

“Сфер”

ТӨСӨЛ

**Хүмүүнлэгийн
тунхаглал
ба гамшгийн хариу
үйлдлийн минимум
стандартууд**

“Сфер” төсөл

Зохиогчийн эрх © “Сфер” төсөл 2004

Шуудангийн хайрцаг 372, 17 Шэмин дес Кретс СН-1211 Женева хот 19, Швейцарь улс

Утас: +41 22 730 4501 Факс: +41 22 730 4905

Е-мэйл: info@sphereproject.org Вэб хуудас: <http://www.sphereproject.org>

“Сфер” төсөл

“Сфер” төсөл нь Хүмүүнлэгийн Тусламжийн Удирдах Комиссийн (ХТУК) хөтөлбөр бөгөөд VOICE ба ICVA байгууллагуудын хамтын ажиллагаа юм. Тус төсөл хүмүүнлэгийн тусламжийн цөм салбаруудад багц универсал минимум стандартуудыг хөгжүүлэх зорилт тавин 1997 онд анх үүсгэн байгуулагдсан юм. Төслийн зорилго бол гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлэх тусламжийн чанарыг дээшлүүлэх, гамшгийн хариу үйлдэлд үзүүлэх хүмүүнлэгийн системийн хариуцлагыг дээшлүүлэх явдал юм. Хүмүүнлэгийн тунхаг бичиг ба гамшигтай тэмцэх минимум стандартууд бол олон хүмүүс, агентлагуудын цуглуулсан туршлагын нийлбэр бүтээгдэхүүн юм. Иймээс аль нэг агентлагийн санал бодлын илэрхийлэл гэж авч үзэж болохгүй.

Туршилтын анхны хэвлэл 1998

Анхны бүрэн хэвлэл 2000

Энэхүү хэвлэл 2004

ISBN 92-9139-097-6

Их Британы Номын сан ба АНУ-ын Конгрессийн Номын сангаас энэхүү хэвлэлийн каталог бичлэгийг олж авч болно.

Бүх эрх хамгаалагдсан. Энэхүү материал зохиогчийн эрхээр хамгаалагдсан бөгөөд дахин худалдах зорилгоор биш, харин боловсролын зориулалтаар дурын арга, байдлаар хуулбарлагдаж болно. Хэрэглээ болгонд албан ёсны зөвшөөрөл шаардаагдах бөгөөд жирийн нөхцөлд зөвшөөрлийг шуурхай олгодог. Бусад нөхцөл байдалд хуулбарлах, дахин хэвлэх эсвэл орчуулга, нэмэлт залруулга хийх тохиолдолд зохиогчийн эрх эзэмшигчээс бичгээр үйлдсэн зөвшөөрөл урьдчилан авах ёстой ба хураамжийн төлбөр төлөх боломжтой.

Оксфам ГБ (Oxfam GB ~ Oxford Famine Хөнгөлөх GB буюу Оксфорд хотын өлсгөлөнд нэрвэгдэгсдэд туслах комисс) нь энэ гарын авлагыг “Сфер” төсөлд зориулж дэлхий даяар түгээж байгаа болно.

Захиалах газар: Оксфам Пабблишинг, 274 Банбёри гудамж, Оксфорд хот OX2 7DZ, Нэгдсэн Вант улс

Утас: +44 1865 311 311 Факс: +44 1865 312 600

Е-мэйл: publish@oxfam.org.uk Вэб хуудас: www.oxfam.org.uk/publications

ба түүний дэлхий даяар тархсан агентууд, төлөөлөгчдөөс захиалж болно. Оксфам ГБ бол бүртгэгдсэн, № 202918, буяны байгууллага бөгөөд Оксфам Интернешнл группын гишүүн юм.

Дизайн хийсэн: ДС Принт энд Ридизайн, Лондон хот.

Хэвлэсэн: Мусумечи, Аоста хот, Итали улс.

Агуулга

Сфер гэж юу вэ?.....	5
Хүмүүнлэгийн тунхаглал	15
Бүлэг 1:	
Бүх салбарт мөрдөгдөх нийтлэг минимум стандартууд	21
Бүлэг 2:	
Усны хангамж, ариун цэвэр ба эрүүл ахуйг сахих минимум стандартууд	51
Бүлэг 3:	
Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл, хүнсний тусламжийн минимум стандартууд	103
Бүлэг 4:	
Орогнох байр, суурьшил ба хүнсний бус зүйлүүдийн минимум стандартууд	203
Бүлэг 5:	
Эрүүл мэндийн үйлчилгээний минимум стандартууд.....	249
Хавсралтууд	
1. Сфер төслийн гарын авлагыг бататгах хууль ёсны хэрэгслүүд.....	313
2. Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган Сар хөдөлгөөн ба Төрийн бус байгууллагуудын (ТББ) гамшгийн тусламжийн үед баримтлах ёс зүйн хэм хэмжээ	315
3. Талархлын үг.....	325
4. Товчилсон үгс.....	328
Индекс	331
Сфер төслийн талаархи мэдээлэл.....	340
Хариу, санал асуулгын маягт	344

Гарын авлагын ерөнхий бүтэц

Сфер гэж юу вэ? (танилцуулга)

Хүмүүнлэгийн тунхаглал

Бүх салбарт мөрдөгдөх нийтлэг стандартууд

Ус, ариун цэврийн хангамж ба эрүүл ахуйг сахих

Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл ба хүнсний тусламжийн

Орогнох байр, суурьшил ба хүнсний бус зүйлүүд

Эрүүл мэндийн үйлчилгээ

Ёс зүйн журам

Хавсралтууд

Индекс

Бүлэг болгон дараахь зүйлүүдийг агуулсан:

☐ **Минимум стандартууд**

☐ **Үндсэн үзүүлэлтүүд**

☐ **Заавар тэмдэглэл**

Сфер гэж юу вэ?

Сфер төсөл нь хоёр үндсэн итгэл үнэмшил дээр тулгуурлагдсан: нэгдүүгээрт, байгалийн гамшиг ба зөрчилдөөн тэмцлээс үүссэн хүмүүсийн зовлонг хөнгөлөх бүх боломжит алхмыг авч хэрэгжүүлэх, ба хоёрдугаарт, гамшигт нэрвэгдсэн хүмүүс эрхэмсэг орших ба тусламж авах эрхтэй. Сфер бол гурван зүйлээс бүрддэг: гарын авлага, хамтын ажиллагааны өргөн цар хүрээтэй процесс ба хариуцлага, чанарын амлалтын илрэл.

Тус санаачлага нь 1997 онд хүмүүнлэгийн туслалцааны ТББ-ын бүлэг, Улаан загалмай ба Улаан хагас сар хөдөлгөөнөөр үүсэн байгуулагдсан. Эдгээр байгууллагууд нь Хүмүүнлэгийн тунхаг бичгийг тодорхойлж, гамшигийн тусламжийн үед баримтлах минимум стандартуудыг таван чухал салбар болгонд нь тодорхойлж өгсөн (ус ба ариун цэврийн хангамж, хүнс тэжээлийн тусламж, орон байр ба эрүүл мэндийн үйлчилгээнүүд). Энэхүү процессийн үр дүнд Сфер төслийн эхний гарын авлага 2000 онд хэвлэгдсэн. Бүхэлд нь авч үзвэл, хүмүүнлэгийн тунхаг бичиг ба минимум стандартууд нь гамшигт туслах эрмэлзэл, түүний хариуцлага, үйл ажиллагааны цар хүрээнд нь хувь нэмэр оруулдаг.

Гарын авлагын үндсэн тулгуур бол хүмүүнлэгийн тунхаг бичиг бөгөөд Олон улсын хүмүүнлэгийн хууль, Олон улсын хүний эрхийн тухай хууль, Дүрвэгсдийн тухай хуулийн зарчим, зүйл ангиуд болон *Олон улсын Улаан загалмай, Улаан Хавирган сар хөдөлгөөн ба Төрийн бус байгууллагуудын (ТББ)гамшигийн тусламжийн үед баримтлах ёс зүйн хэм хэмжээн* дээр үндэслэгдсэн юм. Тунхаг бичиг нь хүмүүнлэгийн үйл ажиллагааг удирдаж буй гол зарчим болдог бөгөөд байгалийн болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй (түүний дотор зэвсэгт мөргөлдөөн) гамшигт нэрвэгдсэн хүн амын хамгаалагдах ба туслалцаа авах эрхийг нь дахин баталгаажуулдаг. Энэ нь бас гамшигт нэрвэгдсэн хүн амын эрхэмсэг оршихуйн баталгаа болдог.

Тунхаг бичиг нь хамгаалагдах ба туслалцаа авах эрхийг баталгаажуулахын тулд улс орнууд, дайтаж буй талуудын хууль ёсны хариуцлагуудыг цохон тэмдэглэсэн. Хэрэв тухайн эрх баригчид өөрсдийн хариуцлагаа биелүүлж чадахгүй ба/эсвэл биелүүлэх хүсэлгүй байгаа бол, тэд хүмүүнлэгийн байгууллагуудад хүмүүнлэгийн туслалцаа ба хамгаалалт үзүүлэх зөвшөөрөл олгох үүрэгтэй.

Минимум стандартууд ба үндсэн үзүүлэлтүүдийг салбар тус бүрт бодит практик дээр ажиллаж байгаа хүмүүсийн өргөн хэмжээний сүлжээг ашиглан хөгжүүлэн боловсруулсан юм. Стандартуудын ихэнхи нь, ба тэднийг дагалдах индикаторууд шинэ биш боловч одоогийн мэдлэг ба практикийг нэгтгэж оруулан зохицуулж байдаг. Бүхэлд нь харахад, тэд өргөн спектрын хүрээнд гайхамшигтай санааны нэгдлийг илэрхийлж байгаа, ба хүний эрх, хүмүүнлэгийн зарчмуудын бодит амьдрал дээрхи хэрэгжилтийг баталгаажуулахын тулд үргэлжлэн хийгдэж буй шийдлийг тусгаж байгаа болно.

Өнөөгийн байдлаар, дэлхийн 80 улс орнуудын 400 гаруй байгууллагууд минимум стандартууд ба түлхүүр индикаторуудыг хөгжүүлэхэд тус нэмэр оруулсан. Энэхүү гарын авлагын шинэ хэвлэл (2004 он) нь ач холбогдлоороо дахин шинэчлэгдсэн ба орчин үеийн техникийн дэвшил хөгжил, практик дээр Сферийг хэрэглэж байгаа агентлагуудын санаа бодлыг харгалзан үзэж оруулсан юм. Онцгойлон дурьдвал, зургаа дахь бүлэг болох хүнсний аюулгүй байдлыг нэмэн оруулж хоол тэжээл, хүнсний тусламжийн салбарт уялдуулан оруулсан. Өөр бас нэг шинэ бүлэгт бүх салбарт нийтлэг нэлээд хэдэн процессийн стандартуудыг нарийвчлан авч үзсэн. Үүнд оролцоо, үнэлгээ тооцоолол, хариу үйлдэл ба зорилго тодорхойлох, хянан шалгалт, үнэлгээ хийх, ба албан хаагчдийн эрх мэдэл ба менежмент г.м. зүйлүүд орно. Түүнээс гадна, бүх салбарт ач холбогдол бүхий бүхэлд нь авч үзэх долоон асуудлуудыг (хүүхдүүд, өндөр настай хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүйс, хамгаалалт, Хүний дархлал хомсдолын нян/Дархлалын Олдмол дутагдалт Хам шинжийн өвчин буюу ДОХ өвчин ба хүрээлэн буй орчин) анхааран авч үзсэн.

Энэхүү номыг хэзээ ашиглаж болох вэ?

Сфер төслийн гарын авлага нь гамшгийн хариу үйлдэл үзүүлэх үед хэрэглэхэд зориулагдсан, ба бас гамшгийн бэлэн байдал ба хүмүүнлэгийн үйл ажиллаганы суоталчилгаанд хэрэглэгдэх боломжтой юм. Үүнийг байгалийн гамшиг ба түүнчлэн зэвсэгт мөргөлдөөн г.м. туслалцаа шаардагдах нэлээд хэдэн нөхцөл байдалд ашиглах боломжтой. Тэрээр удаан болон хурдан үүсэх нөхцөл байдалд хоёуланд нь, хөдөө болон хот, суурин газрын орчинд, хөгжиж буй болон өндөр хөгжилтэй орнуудад, дэлхийн аль ч газар нутагт хэрэглэгдэхээр боловсруулагдсан юм. Үүнд бас гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн амьд гарахад нэн шаардагдах зүйлсийг хангахын зэрэгцээ хүний эрхэмсэг оршихуйн үндсэн эрхийг батлахад гол анхаарал тавьсан.

Гарын авлагад агуулагдсан мэдээлэл зүйлүүдийг даган мөрдөх боломжтой боловч заавал даган мөрдөх шаардлагагүй. Түүнийг гамшгийн бэлэн байдал, гамшгийн дараах үе шат руу шилжих үед болон бусад нөхцөл байдалд ч уян хатан хэрэглэж болно. Тэрээр тээвэрлэлт, аж үйлдвэрийн, химийн, биологийн эсвэл цөмийн гэх мэт технологийн гамшгуудад хариу үйлдэл барих зорилгоор боловсруулагдаагүй юм.

Хэдий тийм боловч, тус гарын авлага эдгээр төрлийн гамшигт тусгайлан зориулагдаагүй боловч, эдгээр үйл явцын үр дүнд хүн амын шилжилт хөдөлгөөн эсвэл бусад үр дагаварууд үүсч хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэх шаардлага гарсан тохиолдолд ач холбогдолтой болно.

Хамрах цаг хугацааны хүрээ

Гарын авлагын хамрах цаг хугацааны хүрээ нь ихэвчлэн түүний орчин, нөхцлөөс хамаардаг. Агентлагууд тухайн салбарт тодорхойлох минимум стандартууд ба индикаторуудыг хангахын тулд олон өдөр, сар эсвэл жилийн хугацаа шаардагдаж болно. Зарим тохиолдолд, минимум стандартуудад хөндлөнгийн оролцоогүйгээр хүрэх боломжтой юм. Хэрэгжүүлэлтийн хамрах цаг хугацааны хүрээг тухайн нөхцөл байдал болгонд тус тус тохиролцон тогтоох ёстой. Заавар тэмдэглэл нь стандартууд ба индикаторууд хэрэгжүүлэх боломжтой газарт тэдний бодит цаг хугацааны хэрэглээг энэхүү номноос үзэж болно.

Хүмүүнлэгийн агентлагуудын дунд бодит байдлууд, мандатууд ба хүчин чадлын зөрүүнээс тусламжийн үйл ажиллагаануудыг хэрхэн гүйцэтгэх чиг хандлага өөр өөр байдаг. Эдгээр ялгаа зөрүүнүүд нөхөн дүүргэх концепт руу зааж байгаа бөгөөд энэ нь хүмүүнлэгийн агентлагууд тусламж үзүүлэх өөрийн хариуцлагаа гүйцэтгэхдээ үйл ажиллагаа эсвэл арга барилын өөр өөр хэлбэрийг хэрэглэдэг гэсэн утгатай. Бүх нөхцөлд гамшгийн хариу үйлдлүүд нь тухайн засгийн газрын үйлчилгээ, авч буй арга хэмжээнүүдийг бүтэц, дизайн ба урт хугацааны дэмжлэгийн хувьд нь дэмжих ёстой.

Энэхүү номыг яаж хэрэглэх вэ

Хүмүүнлэгийн ажилтнуудад зориулсан практикийн заавар удирдамж өгдөг олон тооны гарын авлага байдаг. Энэхүү ном бол 'яаж хийх вэ' гэсэн гарын авлага биш юм. Харин хүмүүнлэгийн үйл ажиллагааны бүхий л шат дамжлагын үнэлгээ тооцооллоос анхны зохион байгуулалт, зохицуулалт ба суртал сурталчилгаа хүртэл бүхий л талаар мэдээлдэг багц минимум стандартууд ба түлхүүр индикаторуудыг батгаасан болно. Стандартууд бол тухайн нөхцөлд мөрдөгдөх ёстой минимум түвшинг тодорхойлдог ерөнхий тунхаглал баримтууд юм; мөн индикаторууд нь тухайн стандартад хүрсэн эсэхийг тодорхойлдог 'сигнал' байдаг ба харин заавар санамжууд нь нэмэлт мэдээлэлээр хангаж өгдөг.

Дөрвөн техникийн бүлэг бүр – усны хангамж, ариун цэвэр ба эрүүл ахуйг сахих; хоол тэжээл ба хүнсний тусламж, орон байр, суурьшил ба хүнсний бус зүйлүүд, эрүүл мэндийн үйлчилгээнүүд зэрэг нь өөрийн багц стандартууд ба индикаторуудтай. Нийтлэг стандартуудыг агуулсан эхний бүлэг нь бүх салбарт хэрэглэгдэх хөтөлбөрийн дизайн ба хэрэгжүүлэлтийн заавар удирдамжуудийг тогтоодог. Холбогдох техникийн бүлэг рүү орохоосоо өмнө энэхүү бүлгийг эхлээд унших ёстой.

Бүлэг бүрт заавар тэмдэглэл нь хоорондоо ялгаатай нөхцөл байдалд стандартуудыг хэрэглэхэд анхаарч үзэх ёстой онцгой зүйлийг заадаг. Тэд практикийн хүндрэлүүдийг даван туулахад анхаарах гол асуудлын талаархи зөвлөмж өгдөг бөгөөд яах ч аргагүй байдлууд, маргаан шүүмжлэлүүд эсвэл одоогийн мэдлэгийн дутмаг байдлыг тайлбарлах болно. Заавар тэмдэглэл тусгай түлхүүр индикатор руу тогтмол заадаг бөгөөд түүний заагч нь текстэнд тусгайлан заагдсан. Түлхүүр индикаторууд холбогдох заавар удирдамжийн тэмдэглэлтэй дандаа хамт уншигдах ёстой.

Бүлэг бүр тухайн салбарт ач холбогдолтой гол асуудлуудыг тусгасан товч танилцуулга болон техникийн мэдээлэл, үнэлгээ тооцооллын шалгах жагсаалтууд ба, ач холбогдолтой газарт нь, тайлангийн маягтуудын томъёонууд, хүснэгт ба жишээнүүдийн нэмэлт эх үүсвэрүүдийг нарийвчлан заасан сонголтын жагсаалтуудыг агуулсан хавсралтуудтай байдаг. Бүх бүлэг өөр хоорондоо уялдаа холбоотойн зэрэгцээ тухайн салбарт байнга тайлбарлагдсан стандартууд нөгөө салбарын стандартай хамтдаа хэрэглэгдэхийг мартахгүй байх нь маш чухал юм.

Стандартууд ба үзүүлэлтүүдийн хоорондын ялгаа

Стандартууд нь гамшигт нэрвэгдсэн хүн ам эрхэмсэг амьдрах ёстой гэсэн зарчим дээр тулгуурласан байдаг. Тэдгээр нь мөн төрхөөрөө чанартай ба үйл ажиллагаа явуулж байгаа орчин бүрт нийтлэг, ижил хэрэглэгддэг гэсэн үг юм. Үндсэн үзүүлэлтүүд, стандартуудын хэмжүүрийн хувьд чанарын ба тоон үзүүлэлтийн шинж чанартай байж болно. Тэд ашиглагдаж буй нөлөө процессууд ба хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг хэмжих багаж хэрэгсэл болж хэрэглэгддэг. Түүнгүйгээр, стандартууд сайн санаа зорилгын тунхаглалаас ялимгүй их зүйл байх бөгөөд амьдралд хэрэгжүүлэхэд хэцүү байна.

Хоорондоо ялгаатай салбаруудын стандартууд дангаараа байдаггүй: тэд бүгд хоорондоо уялдаа холбоотой. Хэдий тийм боловч, универсал стандартуудын томъёолол ба тэднийг амьдрал дээр хэрэгжүүлэхийн хооронд үл зайлсхийж болмоор хүндрэл байдаг. Нөхцөл байдал болгон хоорондоо ялгаатай байдаг. Зарим тохиолдолд, орон нутгийн хүчин зүйлүүд бүх стандартууд ба индикаторуудын хэрэгжүүлэлтийг хүрч болзошгүй болгож болно. Хэрэв энэ тохиолдол үүссэн бол, стандартууд ба индикаторуудын хооронд үүссэн зай зөрүүг гарын авлагад тусгах ёстой бөгөөд бодит практикт үүссэн энэхүү зай зөрүүг тодорхойлон бичиж, түүний учир шалтгаан болон өөрчлөх шаардлагыг тайлбарлах ёстой.

Гамшигт нэрвэгдсэн хүн амын эмзэг байдал ба хүчин чадлыг олж таних

Гамшигт нэрвэгдэгсдийн асуудлыг шийдвэрлэн даван туулах стратегиудыг оновчтой боловсруулахын тулд, нэрвэгдсэн бүлгүүдийн хүчин чадал, хэрэгцээ, эмзэг байдлыг зөв тодорхойлох нь хамгийн чухал юм. Нас хүйс, тахир дутуу болон ХДХВ/ДОХ-ын халдвартай эсэх нь тухайн гамшгийн үед хүмүүсийн гамшигт өртөмтгийн байдал, гамшгийг даван туулах, амьд гарах чадвар чадамжид нөлөөлнө. Ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настай хүмүүс ба Хүний дархлал хомсдолын вирус ХДХВ/ДОХ-ын халдвартай хүмүүс гамшгийг даван туулахдаа ихэвчлэн сул талтай байдаг бөгөөд хууль ёсны дагуу авах ёстой үйлчилгээнүүд ба дэмжлэгээ авахдаа бодит биеийн, соёлын ба нийгмийн саад тотгоруудтай тулгарах бэрхшээл гардаг. Яс үндэс, арьс өнгө, нийгмийн гарал, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоос хамааран гамшигт өртөхгүй байсан зарим хүмүүсийг өртөмтгий эмзэг байдалд оруулах эрсдэл рүү түлхэх боломжтой.

Өртөмтгий эмзэг бүлгүүдийн өөр хоорондоо ялгаатай хэрэгцээ ба тэдний ижил хэмжээний зохистой үйлчилгээ ба дэмжлэг авахдаа тулгарч байгаа бэрхшээлийг олж мэдэлгүй алдаа гаргавал тэднийг цаашид тоомсорлохгүй, эсвэл бүүр амин чухал тусламж тэдэнд үзүүлэхээ болиход хүргэж болно. Гамшигт нэрвэгдсэн хүн амд тэдний тусламж авах эрх, өөрөөр хэлбэл энэхүү тусламжинд яаж хандах тухай мэдээлэл олгох нь зайлшгүй шаардлагатай. Өртөмтгий эмзэг бүлгүүдийг ийм мэдээлэлээр хангах нь маш чухал байдаг. Учир нь тэдний өмч хөрөнгө элэгдэл эсвэл алдагдалд ороход бусдыг бодвол тэдний гамшгийг даван туулах ба нөхөн сэргээгдэх чадвар нь бусдыг бодвол дорой байдаг ба илүү их дэмжлэг шаардагддаг. Эдгээр учир шалтгаанаас уялдан, өртөмтгий эмзэг бүлгүүдийг танин мэдэж, хоорондоо ялгаатай гамшгийн нөхцөлд хэрхэн нэрвэгдсэн талаар ойлголт авч, хариу үйлдлийг зөв оновчтой байдлаар шийдвэрлэх нь чухал. Гамшигт нэрвэгдсэн хүмүүсийг ялгаварлалгүйгээр тэдний тус бүрийн хэрэгцээг судлан үзэж, тэдэнд дэмжлэг үзүүлэхдээ онцгойлон анхаарч болгоомжлох ёстой.

Хэдий тийм боловч, гамшигт нэрвэгдсэн хүмүүсийг өөртөө туслах чадамжгүй хохирочид гэж үзэж болохгүй бөгөөд түүнд өртөмтгий эмзэг бүлгүүдийн гишүүд бас хамаардаг. Тэд ур чадвар ба хүчин чадалтайгаас гадна тэдгээрийг олж авдаг бөгөөд танин илрүүлэх ба тусалцаа үзүүлэх шаардлагатай гамшгийн нөхцөл байдлыг даван туулах, хариу үйлдэл хийх бүтэцтэй байдаг.

Гамшиг тулгарах үед хувь хүмүүс, гэр бүл, нэг нутгийн хүмүүс гайхамшигтай авхаалжтай, уян хатан байж чаддаг ба эхний үнэлгээ дүгнэлтүүдэд нэрвэгдсэн хүн амын хүчин чадал, ур чадварыг хэрэгцээ ба хомсдолуудын нэгэн адил харгалзан авч үзэх ёстой. Гамшиг гэнэт тохиолдсон эсвэл аажим аажмаар хөгжсөн эсэхээс үл хамааран, хувь хүмүүс ба нэг нутгийн хүмүүс өөрсдийн ач холбогдол өгсөн хэмжээгээр түүний үр нөлөөг идэвхитэй даван туулж нөхөн сэргээдэг.

Гол өртөмтгий эмзэг бүлгүүдэд эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настай хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ХДХВ/ДОХ-ын халдвартай амвдарч буй хүмүүс ба цөөнх яс үндэстнүүд хамаардаг. Энэ бол өртөмтгий эмзэг бүлгүүдийн бүрэн жагсаалт биш, харин ихэвчлэн олж танигдсан бүлгүүдийг агуулсан юм. Гарын авлагын турш, дотор нь, хэрэв 'өртөмтгий эмзэг бүлгүүд' гэсэн ойлголт хэрэглэгдэж байвал түүнд эдгээр бүх бүлэг хамаарна. Өртөмтгий эмзэг хүмүүсийн ямар нэг бүлэг өөр нэг бүлгийг бодвол илүү эрсдэлтэй байдаг тохиолдлууд байх боломжтой боловч, хэрэв нэг бүлэгт хэзээ нэгэн цагт аюул учирвал нөгөө бүлэг нь бас эрсдэлтэй тулгарах өндөр магадлалтай байдаг. Ерөнхийдөө, гарын авлагад хоорондоо ялгаатай өртөмтгий эмзэг бүлгүүдийг тодорхойлохоос зайлсхийсэн. Хэрэв аливаа нэг бүлэг эрсдэлтэй байвал, энэхүү жагсаалтанд дурьдсан бүх бүлэгийн талаар сайтар бодож тунгаахыг хэрэглэгчдэд зөвлөж байна.

Бүхэлд нь авч үзэх асуудлууд

Бид гарын авлагыг засаж залруулахдаа бүх салбаруудад ач холбогдолтой хэд хэдэн чухал асуудлуудыг авч үзсэн. Эдгээр асуудлууд нь 1) хүүхдүүд, 2) өндөр настай хүмүүс, 3) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, 4) хүйс, 5) хамгаалалт, 6) ХДХВ/ДОХ-ын халдвартай хүмүүс 7) хүрээлэн буй орчин гэх мэтэд хамаарна. Тэднийг зэрэг авч үзээгүй, харин бүлэг бүрийн холбогдох хэсгүүдэд тусгасан. Эдгээр хэсэг асуудлуудыг тэдний өртөмтгий эмзэг байдалтай харьцах харьцаагаар нь сонгосон. Учир нь тэдгээр асуудлууд Сфер төслийн ажлын талбарын хэрэглэгчдийн илгээсэн санал бодолд хамгийн ихээр тавигдсан юм. Гарын авлагад авч үзэх бүх асуудлыг бүхэлд нь авч үзэх боломжгүй боловч тэдний ач холбогдол, чухал байдлыг танин мэдэж оруулсан.

Хүүхдүүд

Бүх хүүхдийг хор хөнөөлөөс хамгаалах ба тэдэнд суурь үйлчилгээнүүдийг шударгаар олгох онцгой арга хэмжээнүүдыг авах ёстой. Хүүхдүүд нэрвэгдсэн хүн амын ихэнхи хэсгийг бүрдүүлдэг болохоор, тэдний санаа бодол ба туршлагаудыг онцгой нөхцөл байдлын үнэлгээ дүгнэлтүүд ба төлөвлөлтийн явцад зөвхөн олж тогтоох биш тэд бас хүмүүнлэгийн үйлчилгээ, хяналт шалгалт, үнэлгээ хийхэд нөлөөлдөг.

Өртөмтгий эмзэг байдын зарим онцлогууд (жишээлбэл: өлөн зэлмүүн байдал, мөлжлөг, хүн хулгайлах, дайчилгаа, сексийн хүчирхийлэл, шийдвэр гаргалтанд оролцох боломжгүй байх) нь хүн амын ихэнхи хэсэгт үйлчилж болох боловч, хамгийн хөнөөл хортой нөлөө нь хүүхдүүд ба залуу хүмүүст илэрдэг.

Хүүхдийн эрхийн конвенцийн дагуу хүүхэд бол 18-аас доош настай хувь хүнийг гэж тооцдог. Соёлын ба нийгмийн хүрээнүүдээс шалтгаалж, хүүхдийг зарим хүн амын бүлгийн дунд өөрөөр тодорхойлсон байж болно. Үйлчлүүлэгч нэг нутгийн хүмүүс нь хүүхдүүдийг яаж тодорхойлж байгаа тухай нарийн нямбай анализ хийж хүүхэд эсвэл залуу хүнийг хүмүүнлэгийн үйлчилгээнүүдээс гаргахгүй байх нь зайлшгүй шаардлагатай байна.

Өндөр настай хүмүүс

Нэгдсэн үндэсний байгууллагын тодорхойлтын дагуу өндөр настай эмэгтэй ба эрэгтэй хүмүүст 60-аас дээш настай хүмүүсийн тооцдог. Хэдий тийм боловч, энэхүү тодорхойлолт нэг хам хүрээнээс өөр хам хүрээ рүү соёлын ба нийгмийн хүчин зүйлүүдээс шалтгаалж өөрчлөгдөг гэсэн утгатай юм. Өндөр настай хүмүүс гамшигт нэрвэгдсэн хүн амын хамгийн эмзэг хэсгийг бүрдүүлдэг боловч тэд амьд үлдэх ба нөхөн сэргээхэд гол тус нэмэр оруулдаг. Гамшгийн нөхцөл байдлуудад нэрвэгдсэн өндөр настай хүмүүсийн хувьд тусгаарлалт тэдний өртөмтгий эмзэг байдал үүсгэдэг хамгийн их ач холбогдолтой хүчин зүйл байдаг. Тусгаарлалт нь амь зуулгын стратегиуд ба гэр бүл, нэг нутгийн хүмүүсийн дэмжлэгийн бүтцүүдийг сүйрүүлэхийн зэрэгцээ, эрүүл мэнд ба хөдөлгөөний архаг өвчин, гарч болзошгүй оюун ухааны хомсдлуудаас уялдан гарах өртөмтгий эмзэг байдлыг хурцатгадаг. Хэдий тийм боловч, өндөр настай хүмүүс туслалцаа хүлээн авагчид биш харин илүүтэйгээр үзүүлэгчид байдаг нь туршлагаас харагдаж байдаг. Хэрэв тэдгийг дэмжвэл, тэд асрагчид, нөөцийн менежерүүд ба орлого нэмэгдүүлэгч гэх мэтээр чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд нэг нутгийн хүмүүсийн асуудлыг давж гарах стратегиудын талаархи тэдний мэдлэг, туршлагыг ашиглаж нэг нутгийн хүмүүсийн соёл, нийгмийн жинхэнэ байдлуудыг хамгаалах ба зөрчилдөөн тэмцлийг зогсоож шийдвэрлэх боломжтой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

Аливаа гамшигт ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс маш эмзэг байдаг бөгөөд энэ хүмүүст гамшгийн үед стандарт дэмжлэг үйлчилгээнүүд авахад хүндрэлтэй тулгардаг, бодит биеийн, мэдрэлийн эсвэл сэтгэлийн сулрал эсвэл сурах хүндрэлүүдтэй хүмүүсийг ойлгодог. Хөдөлгөөн шилжилт ба нүүлгэн шилжүүлэлтийн үеийг даван туулахын тулд тэдний шаардлагуудад нийцсэн стандарт тоног төхөөрөмжүүдээр бололцооны хэмжээгээр тэднийг хангах ёстой. Тэд гол төлөв гэр бүлээр нь дамжуулж олгодог нийгмийн халамжийн сүлжээ байлгахыг шаарддаг.

Хүйс

Эмэгтэй ба эрэгтэй хүмүүс тэгш эрхтэй байна гэсэн заалт хүмүүнлэгийн тунхаглалын үндсийг бүрдүүлдэг хүний эрхийн бичиг баримтуудад тусгайлан тодорхойлсон байдаг. Эмэгтэй ба эрэгтэй хүмүүс, охид ба хөвгүүд хүмүүнлэгийн тусламж авах тэгш эрхтэй байна; тэдний хувь хүний нэр хүндийг хүндэтгэх ёстой; хувь хүний ижил төсөөтэй чадавхи, түүний хийсэн сонголт шийдвэр гаргах чадварыг хүлээн зөвшөөрөх ёстой; Тэд адил боломжоор эдгээр сонголтуудыг хийх эрхтэй; тэд үйл ажиллагаануудынхаа үр дүнг нөлөөлөх адил түвшний эрх мэдэлтэй байх ёстой.

Хүмүүнлэгийн Тусламжууд нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондоо ялгаатай хэрэгцээ шаардлагууд, өртөмтгий эмзэг байдал, сонирхлууд, хүчин чадал, асуудлыг давж гарах стратегиуд ба тэдний өөр өөр гамшгийн нөлөө үйлчлэлүүдийн ойлгоц дээр тулгуурласан бол хамгийн үр дүнтэй байдаг. Эдгээр ялгаа зөрүүнүүд түүнчлэн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг, ажлын ачаалалын тэгш бус байдал, нөөцүүдэд хүрэх ба хянах, шийдвэр гаргах эрх мэдэл, ур чадвараа хөгжүүлэх бололцоонуудын талаархи ойлголтыг хүйсийн тухай анализаар гаргаж авдаг. Хүйсийн асуудал бусад бүх бүхэлд нь авч үзэх асуудлууд дээр тулгардаг. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хооронд шударга ёсонд хүрэхэд, үр дагаварын тэгш байдал баталгаажуулахад анхаарах нь пропорциональ ба шударга байх хүмүүнлэгийн зорилго оршдог.

Хамгаалалт

Тусламж ба хамгаалалт бол хүмүүнлэгийн үйл ажиллагааны хоёр хуваагдашгүй тулгуур юм. Хүмүүнлэгийн агентлагууд ихэвчлэн олон улсын эрх зүйд хүлээн зөвшөөрөгдсөн хүн амын эрхийн зөрчил гэх мэт нэг нутгийн нийт хүмүүс эсвэл хүн амын хэсгүүдийн үндсэн сайн сайхан эсвэл аюулгүй байдалд заналхийж байгаа хүний үйлдлүүд эсвэл саад тотгор гэх мэт нөхцөл байдлуудтай тулгардаг. Энэ нь хүмүүсийн сайн сайхан байдал, амьд үлдэх арга, аюулгүй байдалд нь шууд заналхийлэх хэлбэрт шилжих боломжтой. Зэвсэгт мөргөлдөөн тэмцэл гарахад иймэрхүү заналхийлэлтээс хүмүүсийг хамгаалах нь тэргүүн зэргийн хүмүүнлэгийн зорилго байдаг.

Хөнгөлөлт, тусламж үзүүлэх хэлбэр ба тэдгээрийг үзүүлж байгаа арга зам нь гамшигт нэрвэгдсэн хүн амын аюулгүй байдалд шууд нөлөө (эрэг эсвэл сөрөг) үзүүлэх боломжтой. Энэхүү гарын авлага нь хамгаалалт стратегиуд, механизмууд, агентлагууд өөрийн хариуцлагаа яаж хэрэгжүүлэх талаар нарийвчилсан тайлбарууд агуулаагүй. Хэдий тийм боловч, зарим хэсэгт агентлагууд туслалцаа үзүүлэх үедээ анхаарах ёстой бэлгийн хүчирхийлэл ба дарангуйлал мөлжлөгөөс хамгаалах, хүн амын тохиромжтой бүртгэлтэй байх шаардлага гэх мэт хамгаалалтын аспектиуд болон хүний эрхийн асуудлуудыг энэхүү гарын авлагад тусгасан.

Хүний дархлал хомсдолын вирус/ДОХ өвчин

Хэрэв тэнд Хүний дархлал хомсдолын вирус/ДОХ өвчний тархалт ба үүнээс уялдан гамшгийг багасгахын зэрэгцээ нэг нутгийн хүмүүсийн сэргээн илааршихад шаардагдах цаг хугацааа уртасгадаг гаднах дарамт ачаалалын аюул их байгаа нөхцөлд нэг нутгийн хүмүүсийн давж гарах механизмууд ба уян хатан чанар нь муудах боломжтой. Хүний дархлал хомсдолын вирусын халдвартай (PLWH/A) хүмүүс ялгаварлан гадуурхагддаг учраас тэдний нууцыг чанд хамгаалж шаардлагатай тохиолдолд тэднийг хамгаалах ёстой. Энэхүү өвчин нь зөвхөн хувь хүмүүсийг бус тэдний гэр бүл, нэг нутгийн хүмүүст бас тусдаг бөгөөд залуу хүмүүс өөрсдийн хамгийн өндөр үр бүтээмжтэй жилүүдэд, ялангуяа эмэгтэйчүүд биеийн, сэтгэл санааны болон санхүүгийн хувьд пропорциональ бус хэмжээгээр өвчилсөн байдаг. Тахал өргөн тархаж олон хүмүүс үхэж үрэгдэхээр нэг нутгийн хүмүүсийн хүн ам зүйн шинж тогтолцоо өөрчлөгдөж пропорциональ бус тооны хүүхдүүд, түүний дотор өнчин хүүхдүүд ба өндөр настай хүмүүс үлддэг. Эдгээр өртөмтгий эмзэг бүлгүүдэд онцгой анхаарал тавьж хөнгөлөх хөтөлбөрүүдийг зохих байдлаар өөрчлөх шаардлагатай болно.

Хүрээлэн буй орчин

Хүрээлэн буй орчинд тухайн орон нутгийн хүмүүс амьдарч аж амьдралаа эрхэлж байгаа бодит биеийн, химийн ба биологийн орчин тойронг ойлгодог. Энэ нь хувь хүмүүсийг тэжээдэг байгалийн нөөцүүдээр хангадаг ба тэдний амьдарч байгаа хүрээлэн буй орчинг тодорхойлдог. Эдгээр зайлшгүй шаардлагатай функцүүдийг байлгахын тулд хамгаалах шаардлагатай болдог. Минимум стандартууд орчин тойрны нөхцөл байдлын хэт их ашиглалт, бохирдолт ба доройтолтоос хамгаалах шаардлагуудыг тодорхойлсон. Тэдний зорьсон минималь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанууд хүрээлэн буй орчны амьдралын туслалцаа үзүүлдэг функцүүдыг хамгаалан баталгаажуулахад зориулагдсан бөгөөд нөхөн сэргээх байгалийн системүүдийн зохицон дасах чадварыг дэмждэг механизмуудыг нэвтрүүлэхэд оршдог.

Сфер төслийн гарын авлагын цар хүрээ ба хязгаарлалт

Агентлагуудын минимум стандартуудад хүрэх чадвар нь хэд хэдэн хүчин зүйлүүдээс хамаарах бөгөөд тэдний зарим нь агентлагуудын хяналтан доор байхад улс төрийн ба аюулгүй байдал гэх мэд бусад хүчин зүйлүүд тэдний хяналтын хүрээнээс гарсан байдаг. Агентлагуудаас нэрвэгдсэн хүн амд туслалцаа үзүүлэх хэмжээ нь хариуцсан эрх баригчдын зөвшөөрөл, хамтын ажиллагаа, тэдний найдвартай нөхцөл байдлуудад ажиллаж чадахаас хамааран өөр өөр ач холбогдолтой байна. Хангалттай санхүүгийн, хүний, материал нөөцийн хэмжээ чухал байдаг.

Хүмүүнлэгийн тунхаглал нь хүмүүнлэгийн зарчмуудын ерөнхий илэрхийлэл байхад энэхүү гарын авлага нь бүрэн дүүрэн үнэлгээ хийх удирдамж эсвэл хүмүүнлэгийн үйл ажиллагааны багц шалгууруудыг ганцаараа тодорхойлж чаддаггүй. Нэгдүүгээрт, Минимум стандартууд зохистой хүмүүнлэгийн тусламжийн бүх боломжтой хэлбэрүүдийг хамардаггүй. Хоёрдугаарт, бүх стандартуудыг биелүүлэхэд хүндрэлтэй, заримдаа бүр боломжгүй, үл зайлсхийж болмоор нөхцөл байдлууд үүсэх боломжтой. Энд хүмүүнлэгийн ажлыг гүйцэтгэхэд туйлын хүнд түвэгтэй нөхцөл байдлууд үүсгэдэг олон тооны хүчин зүйлүүд - түүний дотор хандах боломжгүй байх эсвэл найдваргүй байдал, хангалтгүй нөөцүүд, бусад үйлдэгчдийн оролцоо ба олон улсын хууль тогтоомжтой нийцэхгүй байх тохиолдол байдаг.

Жишээлбэл, агентлагууд гамшигт нэрвэгдсэн хүн амын шаардлагуудыг хангахад тэдний эрх мэдэлд байгаа нөөцүүд хангалтгүй байна гэж тогтоох; дараа нь шаардлагатай болох тохиромжтой тусламж ба хамгаалалт үзүүлэхэд саад тотгор болж байгаа зүйлүүдийг зайлуулахад тавих шаардлагуудыг эн тэргүүнд тавих, хариу үйлдэл, хамгаалалт хийх. Минимум стандартууд орон нутгийн хүн амын гамшгийн өртөмтгий эмзэг байдал их байх, мөн их хэмжээний ядуурал, эсвэл урт хугацаанд үргэлжлэх зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдлуудад өдөр тутмын жирийн амьдралын нөхцөл байдлуудаас даван гарсан байдаг. Энэ нь хүмүүсийн дургүйцлийг төрүүлээд зогсохгүй, орон нутгийн нөхцөл байдлуудыг анхааралдаа авч, гамшигт нэрвэгдсэн ба ойролцоо орших хүн амын тэгш байдлыг хангахаар боловсруулагдсан байх ёстой.

Индикаторууд ба стандартуудын зарим нэг хэсэг нь биелэгдэхгүй байх олон тооны тохиолдлуудыг олж тогтоосон - хэдий тийм боловч, энэхүү номын хэрэглэгчид тэдгээрийг биелүүлэхийг эрмэлзэх ёстой бөгөөд тэгэж ч чадна. Хариу үйлдлийн эхний үе шатанд, жишээлбэл, нэрвэгдсэн бүх хүн амыг суурь тоног төхөөрөмжүүдээр хангах нь хүн амын зөвхөн нэг хэсэгт нь минимум стандартууд ба индикаторуудыг биелүүлэхээс илүү чухал байж болно. Энэхүү гарын авлага нь асуулт болгоныг хамрах буюу яах ч аргагүй байдал болгоныг шийдэж чадахгүй. Энэ нь харин олон жилийн туршлага ба сайн практикаас уламжлан гаргаж авсан зохицуулалт; практикийн чиглэл санал болгохоор боловсруулагдсан заавар тэмдэглэл; хамгаалалтын цар хүрээ, үндсийг санал болгодог хүмүүнлэгийн тунхаглал дээр үндэслэсэн стандартууд ба индикаторуудыг хэрэглэж тусламж үзүүлэх гарааны цэг болж чаддаг.

Хүмүүнлэгийн тунхаглал ба минимум стандартууд нь хүмүүнлэгийн тусламжийн бүх асуудлыг шийдэхгүйгээс гадна бүх хүнийг зовлон зүдгүүрээс нь урьдчилан сэргийлж чадахгүй. Тэд хүмүүнлэгийн агентлагуудад тэдний тусламжийн үр бүтээмж ба чанарыг дээшлүүлэх багаж хэрэгсэл өгдөг бөгөөд гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн амьдралд их ач холбогдол бүхий ялгаа авчирдаг.

Хүмүүнлэгийн

Тунхаглал

Хүмүүнлэгийн

Тунхаглал

Энэхүү Тунхаглал ба Минимум стандартуудыг даган мөрддөг Хүмүүнлэгийн агентлагууд байгалийн гамшиг эсвэл зэвсэгт мөргөлдөөнд нэрвэгдсэн хүмүүст үзүүлэх үйлчилгээний тодорхойлсон түвшинд хүрэх, хүмүүнлэгийн үндсэн зарчмуудыг даган мөрдөхийг дэмжих зорилготой байна.

Хүмүүнлэгийн тунхаглал нь эдгээр зарчмууд ба минимум стандартуудад хүрэх агентлагуудын үүрэг даалгаварыг илэрхийлдэг. Энэхүү үүрэг даалгавар нь агентлагуудын өөрийн ёс суртахууны үүрэг хариуцлагуудын үнэлэмж дээр тулгуурлаж улс орнууд ба бусад талууд үүрэг хариуцлагуудаа тогтоосон олон улсын хууль тогтоомжинд тунхагласан эрх, үүргүүдийг тусгадаг.

Тунхаглал нь байгалийн гамшиг ба зэвсэгт мөргөлдөөнд нэрвэгдсэн хүмүүсийн амь нас, нэр хүндийг дэмжих хамгийн суурь хэрэгцээн дээр үндэслэгддэг. Минимум стандартууд нь ус, ариун цэврийн хангамж, хоол тэжээл, хүнс, орон байр ба эрүүл мэндийн хамгаалалт гэх мэт хүмүүсийн хэрэгцээтэй холбоотой эдгээр шаардлагуудыг ихэсгэх зорилготой. Нийтэд нь авч үзвэл, хүмүүнлэгийн тунхаглал ба минимум стандартууд нь хүмүүнлэгийн тусламжийн хүчин чармайлт үзүүлэхэд хариуцлага хүлээх ажиллагааны цар хүрээнд тус нэмэр болдог.

1. Зарчмууд

Бид хүмүүнлэгийн чухал асуудал ба түүний тэргүүн байрын талаархи бидний итгэл үнэмшлийг дахин батлах болно. Үүгээр бид зэвсэгт мөргөлдөөн, байгалийн гамшгаас үүдэлтэй хүний зовлон зүдгүүрийг хөнгөвчлөх бүх боломжтой алхмуудыг авах ёстой. Ингэснээрээ гамшигт нэрвэгдсэн хүмүүс хамгаалагдах ба туслалцаа авах эрхтэй гэсэн итгэл үнэмшлийг ойлгож авдаг.

Бид хүмүүнлэгийн агентлагуудын хувьд олон улсын хүмүүнлэгийн хуульд тусгасан, хүн төрлөхтний зарчим дээр тулгуурласан энэхүү итгэл үнэмшлийг өөрсдийн үйлчилгээнүүдээ санал болгодог.

Бид хүмүүнлэг ба шударга байх зарчмуудын дагуу ажиллах ба Олон Улсын Улаан Загалмай, Улаан Хавирган Сар Хөдөлгөөн, Төрийн бус байгууллагуудын (ТББ) гамшгийн хариу үйлдлийн үед баримтлах ёс зүйн хэм хэмжээн (1994) -д тодорхойлсон бусад зарчмуудын дагуу үйл ажиллагаагаа явуулах болно. Энэхүү ёс зүйн дүрмийн 315-р хуудас дээр дэлгэрэнгүй тайлбарласан.

Хүмүүнлэгийн тунхаглал дараахь зарчмуудын үндсэн, чухал ач холбогдлыг баталдаг:

1.1 Хүний эрхэмсэг оршихуй

Энэхүү эрх нь амьдрах эрх, амьдралын тохиромжтой стандартаар хангагдах эрх, хэрцгий харгис байдал, хүнлэг бус, доромжилсон харьцаа хандлага буюу ял шийтгэлээс ангид байх эрх чөлөөтэй холбоотой хууль ёсны арга хэмжээнүүдэд тусгагдсан. Бид хувь хүний амьдрах эрхэд амь насанд заналхийлсэн газар нь арга хэмжээ авах эрх болон ийм алхмуудыг бусдад авах холбогдох үүргийг дагалдуулдаг эрхийг ойлгодог. Энэ нь шууд бусаар амь нас хамгаалах тусламжийн хангалтыг боох, татгалзах эрх үүрэг агуулсан байдаг. Түүнээс гадна, олон улсын хүмүүнлэгийн хууль нь зэвсэгт мөргөлдөөний явцад энгийн хүн амд тусламж үзүүлэх тусгай заалтыг оруулсан байдаг бөгөөд энгийн хүн ам зайлшгүй шаардлагатай хангамжаар дутаж байхад улс орнууд ба бусад талууд хүмүүнлэгийн аль нэг талыг бариагүй тусламж үзүүлэх үүрэг ноогдуулдаг.¹

1.2 Байлдагчид ба үл байлдагчид хоёрын ялгаа

Энэ нь 1949 онд Женевт батлагдсан Конвенциуд ба тэдний 1977 оны нэмэлт Протоколуудыг баталгаажуулж байгаа ялгаа юм. Энэхүү үндсэн зарчим нь хорьдугаар зууны хоёрдугаар хагаст маш их хэмжээгээр өссөн энгийн золгүй явдлын харьцаанд тусгагдсаны дагуу их хэмжээгээр элэгдэж суларсан. ‘Иргэний дайн’ гэж нэрлэгдэх зэвсэгт мөргөлдөөн, дайн байлдаанд идэвхитэй оролцогчид болон шууд оролцоогүй иргэд, бусад хүмүүс (түүний дотор өвчтэй, шархдсан хүмүүс ба хоригдлууд)–ийн хооронд ялгах шаардлагыг умартуулахгүй байх ёстой. Үл байлдагчид олон улсын хүмүүнлэгийн хуулиар хамгаалагдсан байдаг ба дайралт довтолгооноос хамгаалагдах эрхтэй байдаг.²

1.3 Аюултай тулгарах улс орон руу албадан буцаахгүй байх зарчим

Энэ нь арьсны өнгө, шашин шүтлэг, яс үндэс, нийгмийн аль нэг бүлэгт хамаарах эсвэл улс төрийн үзэл бодлоос нь шалтгаалж түүний амь нас эсвэл эрх чөлөөнд заналхийлж байгаа эсвэл тэрээр эрүү шүүлтэнд орох аюултай тулгарах бодитой үндэслэл байгаа эсэх эсвэл бусад улс орон руу дүрвэгчийг (буцааж) илгээхгүй гэсэн зарчим юм.³

2. Үүрэг ба Хариуцлага

2.1 Бид, нэгдүгээрт, тэдний хувийн хүчин чармайлтуудаар байгалийн гамшиг эсвэл зэвсэгт мөргөлдөөнд нэрвэгдсэн хүмүүсийн суурь хэрэгцээ шаардлага хангагдсан гэж ойлгож байгаа бөгөөд хүмүүсийн даван туулах хүчин чадал хүрэхгүй үед тусламж үзүүлэх төрийн тэргүүн үүрэг, хариуцлагыг хүлээн гэж ойлгож байна.

2.2 Олон улсын хууль тогтоомжинд гамшигт нэрвэгдсэн хүмүүс хамгаалалт ба тусламж авах эрхтэй гэж заасан байдаг. Энэ нь улс орнууд эсвэл дайтаж байгаа талууд тусламж үзүүлэх эсвэл үзүүлэх зөвшөөрөл олгох, ба түүнчлэн хүний үндсэн эрхүүдийг зөрчиж байгаа зан авираас сэргийлэх ба цээрлэх хууль ёсны үүрэг хариуцлагуудыг тодорхойлж өгдөг. Эдгээр эрх, үүрэг хариуцлагууд олон улсын хүний эрхийн тухай хууль, олон улсын хүмүүнлэгийн хууль ба дүрвэгсдийн тухай хууль (доор дурьдсан эх үүсвэрүүдээс харна уу) дотор агуулагдсан байдаг.

2.3 Бид, хүмүүнлэгийн агентлагуудын хувьд, эдгээр тэргүүн үүргүүд ба хариуцлагуудтай холбоотой өөрийн үүргүүдээ тодорхойлдог. Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх бидний үүрэг нь тэргүүн хариуцлагатай тэдгээр талууд тэр болгон энэхүү үүргээ өөрсдөө биелүүлж чадахгүй эсвэл биелүүлэхийг хүсэхгүй байгаа бодит байдлыг харуулдаг. Энэ нь зарим тохиолдолд хүчин чадлын асуудал байдаг юм. Зарим тохиолдолд их хэмжээний хүний зовлон зүдгүүрээс зайлсхийх боломжтой байсан ч эдгээр нь хууль ёсны ба ёс суртахууны үндсэн үүрэг хариуцлагуудыг санаатайгаар үл тоомсорлох байдал бүрддэг.

2.4 Дайтаж байгаа талууд хүмүүнлэгийн зорилго бүхий хөндлөнгөөс оролцохыг хүлээн зөвшөөрснөөр зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдлуудад тусламж үзүүлэх оролдлого нь дайралт довтолгоонд илүү эмзэг иргэдэд туслах, заримдаа нэг эсвэл олон дайтаж байгаа талуудад төлөвлөөгүй давуу тал гаргах боломжтой байнга давтагдах алдаа гаргадаг гэж тогтоогдсон. Бид өөрсдийн хөндлөнгийн оролцлогын ийм хор хөнөөлтэй үр нөлөөг дээр дурьдсан үүрэг хариуцлагуудтай уялдуулан тууштай багасгах ёстой. Дайтаж байгаа талууд ийм хөндлөнгийн оролцоонуудын хүмүүнлэгийн мөн чанарыг хүндлэх үүрэг хариуцлага хүлээх ёстой.

2.5 Дээр тодорхойлсон зарчмууд ба илүү ерөнхий байдлаар авч үзвэл Олон Улсын Улаан Загалмайн Хороо ба Нэгдсэн Үндэсний Байгууллагын Дүрвэгчдийн асуудал эрхэлсэн дээд байгууллагын олон улсын хууль тогтоомжийн доор гаргасан хамгаалалт, тусламж мандатуудыг бид хүлээн зөвшөөрч, дэмжиж байна.

3. Минимум стандартууд

Доор дурьдсан минимум стандартууд нь хүмүүнлэгийн тусламж үзүүлж байгаа агентлагуудын туршлага дээр суурилсан юм. Стандартуудын биелэлт хэд хэдэн хүчин зүйлүүдээс хамаардаг ба тэдний нэлээд хэсэг нь бидний хяналтаас давсан байдаг ч гэсэн бид тэднийг биелүүлэхийн тулд тууштай оролдох ёстой гэсэн үүрэг өмнөө тавьж зохих байдлаар тайлагнах үүрэг хүлээх болно. Бид бусад хүмүүнлэгийн үйлчилгээ үзүүлэгчид, түүний дотор улс орнуудыг, эдгээр стандартууд хүлээн зөвшөөрөгдсөн нормоор сонгон авахыг уриалж байна.

1–5 –р бүлэгүүдэд тодорхойлсон стандартуудыг чанд баримтлан бид гамшигт нэрвэгдсэн хүмүүс эрхэмсэг оршихуйн суурь эрхийг хангах хамгийн наад захын минимум шаардлагуудыг (ус, ариун цэврийн хангамж, хоол, хүнс, орогнох байр ба эрүүл мэндийн хамгаалалт) биелүүлэхэд бүх хуч чадлаа дайчлах үүрэг өмнөө тавьж байна. Энэ хүртэл бид засгийн газрууд ба бусад талууд олон улсын хүний эрхийн тухай хууль, олон улсын хүмүүнлэгийн хууль ба дүрвэгсдийн тухай хуульд заасан үүрэг хариуцлагуудаа биелүүлэхийг нь үргэлжлэн дэмжих болно.

Бид энэхүү үүрэг даалгаварыг хариуцахаас гадна бидний тус тусын агентлагууд, консорциуд ба холбоонуудын дотор хариуцлагын системүүдийг хөгжүүлэх үүрэг хүлээх болно. Бид туслалцаа үзүүлэх гэж байгаа хүмүүсийн өмнө үндсэн хариуцлага хүлээх болно.

Тэмдэглэл

1. Хүний эрхийн универсаль тунхаглал –ын 3 ба, 1948 он; Иргэний ба улс төрийн эрхийн талаархи олон улсын гэрээ хэлэлцээр –ийн 6 ба 7 –р зүйл, 1966 он; Генева хотод 1949 онд байгуулсан дөрвөн конвенциуд –ын нийтлэг 3-р зүйл; Генева хотын дөрөвдүгээр конвенцийн 23, 55 ба 59-р зүйлүүд; 1977 оны Нэмэлт протокол I –ийн 69 – 71 –р зүйлүүд; 1977 оны Нэмэлт протокол II –ын 18-р зүйл ба түүнчлэн олон улсын хүмүүнлэгийн хуулийн бусад холбогдох дүрмүүд; Эрүү шүүлт ба бусад хэрцгий харгис байдал, хүнлэг бус эсвэл доромжилсон харьцаа хандлага эсвэл ял шийтгэлийн эсрэг конвенци, 1984 он; Эдийн засгийн, нийгмийн ба соёлын эрхийн талаархи олон улсын гэрээ хэлэлцээр –ийн 10, 11 ба 12 –р зүйлүүд, 1966 он; Хүүхдийн эрхийн конвенц –ийн 6, 37 ба 24 –р зүйлүүд, 1989 он; ба олон улсын хууль тогтоомжинд заасан бусад зүйлүүд.
2. Байлдагчид ба үл байлдагчдийн хоорондын ялгаа бол олон улсын хүмүүнлэгийн хуулийн үндсэн суурь зарчим юм. Генева хотод 1949 онд байгуулсан дөрвөн конвенциуд –ын нийтлэг 3-р зүйл ба 1977 оны Нэмэлт протокол I –ийн 48-р зүйлийг тусгайлан харна уу. 1989 оны Хүүхдийн эрхийн конвенц –ийн 38-р зүйлийг бас харна уу.
3. Дүрвэгсдийн байдлын талаархи конвенцийн 33-р зүйл, 1951 он; Эрүү шүүлт ба бусад хэрцгий харгис байдал, хүнлэг бус эсвэл доромжилсон харьцаа хандлага эсвэл ял шийтгэлийн эсрэг конвенцийн 3-р зүйл, 1984 он; Хүүхдийн эрхийн конвенцийн 22-р зүйл, 1989 он.

Эх сурвалж

Дараахь баримт бичиг энэхүү Тунхаг бичигт орсон болно:

Хүний эрхийн универсаль тунхаглал 1948 он.

Иргэний ба улс төрийн эрхийн талаархи олон улсын гэрээ хэлэлцээр 1966 он.

Эдийн засгийн, нийгмийн ба соёлын эрхийн талаархи олон улсын гэрээ хэлэлцээр 1966 он.

Арьс өнгөөр ялгаварлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенци 1969 он.

Генева хотод 1949 онд байгуулсан дөрвөн конвенциуд ба 1977 оны тэдний хоёр нэмэлт протоколууд.

Дүрвэгсдийн байдалтай холбоотой 1951 оны конвенци ба Дүрвэгсдийн байдалтай холбоотой 1967 оны протокол.

Эрүү шүүлт ба бусад хэрцгий харгис байдал, хүнлэг бус эсвэл доромжилсон харьцаа хандлага эсвэл ял шийтгэлийн эсрэг конвенци 1984 он.

Геноцидын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба ял шийтгэлийн тухай конвенци 1948 он.

Хүүхдийн эрхийн конвенц 1989 он.

Эмэгтэйчүүдийг ялгаварлах бүх хэлбэрүүдийг устгах тухай конвенци 1979 он.

Харьяалалгүй иргэдийн байдалтай холбоотой конвенци 1960 он.

Дотоод нүүлгэн шилжүүлэлт хийх удирдамж бүхий зарчмууд 1998 он.

Бүлэг 1: Бүх салбарт мөрдөгдөх нийтлэг минимум стандартууд

Энэхүү бүлгийг яаж хэрэглэх вэ?

Энэхүү бүлэгт техникийн салбарууд болгонд ач холбогдол бүхий найман үндсэн ‘процесс ба хүмүүс’ стандартуудыг дэлгэрэнгүй авч үзэх болно. Эдгээр стандартууд бол: 1) оролцоо, 2) анхны үнэлгээ 3) хариу үйлдэл, 4) зорилтот бүлгийг тодорхойлох, 5) хяналт шалгалт, 6) үнэлгээ хийх, 7) тусламжийн ажилтны эрх мэдэл ба хариуцлагууд ба 8) ажилтаны хяналт, менежмент ба дэмжлэг. Тус бүр нь дараахь зүйлийг агуулсан:

- *минимум стандартууд*: эдгээр нь мөн чанарын хувьд чанартай ба хүрэх минимум түвшингүүдийг тодорхойлдог;

- *үндсэн үзүүлэлтүүд*: эдгээр нь стандартанд хүрсэн эсэхийг харуулдаг ‘сигналууд’ юм. Тэд хөтөлбөрүүдийн нөлөө үйлчлэл эсвэл үр дүн, түүнчлэн хэрэглэгдсэн процесс эсвэл аргуудыг хэмжих болон харилцах замыг гаргаж өгдөг. Энд чанарын эсвэл тоо хэмжээний индикаторууд байж болно;

- *заавар тэмдэглэл*: эдгээр нь хоорондоо ялгаатай нөхцөл байдлуудад стандартууд ба индикаторуудыг хэрэглэх үед анхааран авч үзэх тусгай зүйлүүдийг, гарч буй практикийн хүндрэлүүдийн талаархи заавар удирдамж, ба эн тэргүүн асуудлуудын талаархи зөвлөгөөг агуулдаг. Эдгээр санамжуудад стандартууд эсвэл индикаторуудтай холбоотой тулгарч болзошгүй, хүндрэлтэй асуудлуудыг дурьдсан бөгөөд шийдэрлэх аргагүй байдлууд, маргаан шүүмжлэлүүд болон өгөгдсөн мэдээллийн дутагдлын талаар тайлбар багтсан болно.

Энэхүү бүлэгийн эцэст стандартуудтай холбоотой ерөнхий ба тусгай техникийн асуудлуудын талаархи мэдээллийн эх сурвалжийг лавлах ном зүйн жагсаалтыг үзэж болно.

Агуулга

Танилцуулга	24
1. Оролцоо	28
2. Анхны Үнэлгээ	29
3. Хариу үйлдэл	33
4. Зорилтот бүлэгээ тодорхойлох	35
5. Хяналт шалгалт	37
6. Үнэлгээ хийх	39
7. Тусламжийн ажилтаны эрх мэдэл ба хариуцлагууд	40
8. Ажилтаны хяналт, менежмент ба дэмжлэг	41
Хавсралт № 1: Ном зүй	43

Нийтлэг Стандартууд

Стандарт 1 Оролцоо

Стандарт 2 Эхний үнэлгээ

Стандарт 3 Хариу үйлдэл

Стандарт 4 Зорилтот бүлгийг тодорхойлох

Стандарт 5 Хяналт шалгалт

Стандарт 6 Үнэлгээ хийх

Стандарт 7 Тусламжийн ажилтаны эрх мэдэл ба хариуцлагууд

Стандарт 8 Ажилтаны хяналт, менежмент ба дэмжлэг

Хавсралт № 1 Ном зүй

Танилцуулга

Эдгээр нийтлэг стандартууд энэхүү гарын авлагын бүлэг болгонд хамаарах бөгөөд тэднийн салшгүй хэсэг мөн. Энд тайлбарласан стандартуудыг хэрэгжүүлснээр агентлагууд техникийн бүлгүүдэд тодорхойлсон стандартуудын биелэлтийг дэмжих болно.

Олон улсын хууль ёсны баримт бичигтэй холбогдох нь

Хүн болгон эрхээ хүндлүүлэн нэр хүндтэй амьдрах эрхтэй байдаг. Хүмүүнлэгийн агентлагууд олон улсын хүний эрх, хүмүүнлэгийн ба дүрвэгсдийн тухай хууль дотор заасан хүний эрх, түүний дотор оролцох, ялгаварлан гадуурхагдахгүй байх ба мэдээлэл авах эрхийн дагуу тууштай байдлаар тусламж үзүүлэх хариуцлагатай байна. *Олон Улсын Улаан Загалмай ба Улаан Хагас Сар хөдөлгөөн ба гамшигт туслах Төрийн бус байгууллагууд (ТББ)*-ын хүмүүнлэгийн тунхаглал ба ёс журмын дагуу хүмүүнлэгийн агентлагууд туслалцаа үзүүлэх гэж байгаа хүмүүсийн өмнө хариуцлага өөрсдөө хүлээх болно. Нийтлэг стандартууд нь байгууллагууд ба хувь хүмүүсийн хамгаалалт ба тусламж үзүүлэхэд үүрэх хариуцлагуудыг тодорхойлж өгдөг.

Бүх салбарт нийтлэг стандартуудын ач холбогдол

Гамшигт нэрвэгдсэн хүн амын хэрэгцээг хангасан хөтөлбөрүүд тухайн нөхцөл байдлын талаархи бодит ойлголт дээр тулгуурласан байх ёстой. Эхний үнэлгээ дүгнэлтүүд тухайн гамшгийн мөн чанар ба хүн амд үзүүлэх нөлөөг судлах болно. Нэрвэгдсэн хүмүүсийн хүчин чадал ба бэлэн байгаа нөөцүүдийг тэдний хэрэгцээ, өртөмтгий эмзэг байдал, зайлшгүй шаардлагатай үйлчилгээнүүдэд гарсан зай завсрыг үнэлэх яг тэр үед олж тогтоох ёстой. Ямар ч салбарыг бусад хүмүүс, эсвэл эдийн засаг, шашны ба уламжлалт итгэл үнэмшил, нийгмийн заншил, улс төр, аюулгүй байдлын хүчин зүйлүүд, давж гарах механизмууд эсвэл урьдчилан тааварласан ирээдүйн хөгжлүүдээс тусгаарлан авч үзэж болохгүй. Гамшгийн учир шалтгаанууд ба үр нөлөөнд анализ хийх нь чухал байдаг. Хэрэв асуудлыг зөв таньж тодорхойлоогүй ба ойлгоогүй бол зохих байдлаар хариу үйлдэл хийхэд хүнд түвэгтэй, бүр бараг боломжгүй болдог.

Хариу үйлдэл олон тооны хүчин зүйлүүд, түүний дотор байгууллагын хүчин чадал, туршлага цуглуулсан салбар, төсвийн бүтэц, бүс нутаг эсвэл нөхцөл байдлыг мэдэх байдал, ажилтнуудын аюул эрсдэлээс хамаардаг. Энд нарийвчлан заасан хариу үйлдэл стандартууд ‘хэрэв ямар нэг зүйл гарвал хэн юу хийх вэ?’ гэсэн асуултыг тодруулахаар боловсруулагдсан юм. Зохистой хариу үйлдлийг нэгэнт тодорхойлсны дараа зорилго тодорхойлох механизмуудыг тогтоож аль нэг талыг илүүд үзэлгүй, ялгаварлахгүйгээр шаардлагын дагуу тусламж үзүүлэх боломжийг агентлагуудад олгох болно.

Хянан шалгалтын системүүдийг процесст эрт оруулж тавьсан зорилтуудын хэрэгжилтийн дэвшлийг үргэлжлэн хэмжих болон хувьсаж буй нөхцөл байдал доторхи хөтөлбөрийн үргэлжилж буй ач холбогдлыг хянах ёстой. Хариу үйлдэл хийх үед эсвэл эцэст нь хийж болох үнэлгээ нь хөтөлбөрийн нийт үр бүтээмжийг тодорхойлж ирээдүйн төстэй хөтөлбөрүүдийг сайжруулах боломжтой сургамжийг тогтоодог.

Хүмүүнлэгийн тусламжийн чанар хүнд түвэгтэй ба зарим тохиолдолд найдваргүй нөхцөл байдалд ажиллаж байгаа ажилчид ба сайн дурын хүмүүсийн ур чадвар, чадавхи, мэдлэг, үүрэг даалгавраас хамаардаг. Чанга менежмент ба хяналт бол тусламжийн хөтөлбөрийн гол элементүүд бөгөөд хүчин чадал бүрдүүлэхийн зэрэгцээ хүмүүнлэгийн тусламжийн минимум стандартуудыг хүлээн зөвшөөрөхөд тус дэм болдог. Хүйс ба бусад бүхэлд нь авч үзэх асуудлуудад чухал ач холбогдол өгснөөр баг бүрдүүлэхэд хүний нөөцүүдийн олон төрлийг анхааралдаа авах ёстой.

Гамшгийн хариу үйлдэл бүрийн зохистой байдал ба чанарыг хангахын тулд гамшигт нэрвэгдсэн хүмүүс – түүний дотор доор тодорхойлсон өртөмтгий эмзэг бүлгүүдийн – хариу үйлдлүүдийн үнэлгээ тооцоолол, хөгжүүлэлт, хэрэгжилт ба хянан шалгалт оролцоог хамгийн ихээр нэмэх ёстой. Хариу үйлдэлд нэрвэгдсэн хүмүүсийн дунд мэдлэг ба мэдээлэлийг эмх журамтай хуваалцах нь асуудлуудын нийтлэг ойлголтонд хүрэх ба агентлагууд дунд үр ашигтай зохицуулалтанд хүрэхэд маш чухал байдаг.

Бусад бүлгүүдтэй холбогдох нь

Холбогдох техникийн салбарт хандахаас өмнө энэхүү бүлгийг эхлээд унших нь маш чухал юм.

Гамшигт нэрвэгдсэн хүн амын өртөмтгий эмзэг байдал ба хүчин чадал

Гамшигт хамгийн ихээр эрсдэлд ордог бүлгүүд бол ихэвчлэн хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настан ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, Хүний дархлал хомсдолын вирусын халдвартай хүмүүс байдаг. Зарим нөхцөлд, хүмүүс үндэстэн ястны гарал, шашин, улс төрийн хамаарал, нүүлгэн шилжүүлэлтээс шалтгаалан эмзэг байдалд орох боломжтой. Энэ нь бүрэн тоочсон жагсаалт биш, харин хамгийн их магадлал өндөртэй хэсгүүд байгаа юм. Эмзэг өртөмтгий байдал нь гамшигийг даван туулах ба амьд үлдэх хүмүүсийн чадавхид нөлөөлдөг бөгөөд тухайн нөхцөл байдалд байгаа хамгийн их эрсдэлтэй хэсгийг тогтоох ёстой.

Гарын авлагын турш, дотор нь, ‘нэн эмзэг бүлгүүд’ гэсэн нэр томъёо нь бүх эдгээр бүлгүүдэд хамаарч байгаа болно. Хэрэв аливаа нэг бүлэг эрсдэлтэй тулгарсан бол бусад хүмүүс бас аюултай тулгарах магадлалтай. Тиймээс эмзэг бүлгүүдийн тухай дурьдах болгонд хэрэглэгчид бүх энд дурьдсан болгоныг авч үзэх ёстойг анхааруулж байна. Бүх нэрвэгдсэн бүлгүүд ялгаварлан үзэхгүй байдлаар ба тэдний тусгай шаардлагууд дагуу хамгаалах ба хангахын тулд онцгой болгоомж авах ёстой. Хэдий тийм боловч, гамшигт нэрвэгдсэн хүн ам тэдгээрийг даван туулах ур чадвар, хүчин чадалтай байдаг ба өөрсдөө олж авдаг бөгөөд эдгээрийг танин олж, туслах ёстой гэдгийг санах ёстой билээ.

Минимум стандартууд

Нийтлэг стандарт № 1: оролцоо

Гамшигт нэрвэгдсэн хүн ам тусламжийн хөтөлбөрийн үнэлгээ, дизайн, хэрэгжилт, хянан шалгалт ба үнэлгээ хийхэд идэвхитэй оролцдог.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Гамшигт нэрвэгдсэн орон нутгийн хүн ам, бүх насны эмэгтэй ба эрэгтэй хүмүүс, түүний дотор нэн эмзэг бүлгүүд, тусламжийн хөтөлбөрийн талаархи мэдээлэл авч төслийн циклийн бүх үе шатны турш санал бодлоо тусламжийн агентлагт гаргах боломжтой (заавар тэмдэглэл № 1 –г харна уу).
- Бичмэл тусламжийн хөтөлбөрийн зорилтууд ба төлөвлөгөөнүүд гамшигт нэрвэгдсэн хүмүүс, ялангуяа өртөмтгий эмзэг бүлгүүдийн шаардлагууд, сонирхол болон үнэ хүндэтгэлийг тусгах бөгөөд тэднийг хамгаалахад тус нэмэр оруулах ёстой (заавар тэмдэглэл № 1-2 –г харна уу).
- Хөтөлбөр болгон тухайн орон нутгийн ур чадвар ба хүчин чадлыг дээд зэргээр ашиглахыг зорьсон байдаг (заавар тэмдэглэл 3-4 –г харна уу).

Заавар санамжууд

1. Бүх бүлгийн төлөөлөл: Гамшигт нэрвэгдсэн хүмүүс төслийн циклийн турш шийдвэр гаргалтанд (үнэлгээ, дизайн, хэрэгжилт, хянан шалгалт ба үнэлгээ хийх) оролцсноор хөтөлбөрүүд шударга ба үр ашигтай явагдах болно. Хүмүүс, түүний дотор эмзэг ба тусгаарлагдсан бүлгүүд тусламжийн хөтөлбөрт ижил хэмжээгээр оролцоход онцгой зүтгэл чармайлт гаргах ёстой. Гамшигт нэрвэгдсэн хүмүүс сайн дурын хамтын ажиллагааны үндсэн дээр хөтөлбөрт оролцож хувь хүмүүсийн эрхийг дордуулахгүй байдлаар орон нутгийн соёлыг хүндэтгэх ёстой. Тусламжийн хөтөлбөрүүд хувь хүмүүс, гэр бүл, нэг нутгийн хүмүүсийн хоорондын харьцааг тусгаж хамгаалалтын элементүүдыг хаягдуулахгүй байхыг анхаарах ёстой.

2. Харилцаа холбоо ба илэрхий ойлгомжтой байх: Нэрвэгдсэн хүмүүсийн дунд мэдээлэл ба мэдлэгийг хувааж тарааснаар асуудлын талаархи илүү сайн ойлголт олж авах, зохицуулагдсан тусламж үзүүлэхэд чухал байдаг. Бүх холбогдох байгууллага ба хувь хүмүүс үнэлгээ дүгнэлтүүдийн үр дүнгийн талаар идэвхитэй ярилцах ёстой. Хүмүүс хөтөлбөрт санаа бодлоо илэрхийлэх бололцоо олгодог механизмуудыг авч тогтоох ёстой, жишээлбэл: олон нийтийн цуглаан эсвэл нэг нутгийн хүмүүсээс бүрдсэн байгууллагуудаар. Гэрээсээ гарч чаддаггүй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хувь хүмүүст хүрэх тусгай хөтөлбөрүүд шаардлагатай болох боломжтой.

3. Орон нутгийн хүчин чадал: Хүмүүс хөтөлбөрт оролцсоноор хямралын үед тэдний нэр хүнд, итгэл найдвар дээшилдэг бөгөөд хүмүүсийг хөтөлбөрүүдэд өөр өөр замаар оролцохыг дэмжих ёстой. Хөтөлбөрүүдийг орон нутгийн хүчин чадал дээр тулгуурлан боловсруулах бөгөөд асуудлыг давж гарах хүмүүсийн өөрсдийн стратегиудыг муутгахгүй байх ёстой.

4. Удаан хугацааны тогтвортой байдал: Удаан хугацааны турш ашиг тустай ажиллахын тулд гол төлөв гамшигтай тэмцэх орон нутгийн хүчин чадлыг чадваржуулах ёстой байдаг. Гамшгийн хариу үйлдлийн хөтөлбөр нь байгаа үйлчилгээнүүд, орон нутгийн байгууллагуудыг бүтэц ба дизайны хувьд бүрэлдүүлэн дэмжих бөгөөд гаднах тусламж зогссоны дараа тогтвортой байх ёстой. Орон нутгийн ба үндэсний төрийн байгууллагууд хүн амын өмнө маш чухал хариуцлага хүлээх бөгөөд урт удаан хугацааны дизайн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үед нь зөвлөгөө өгөх ёстой.

Нийтлэг стандарт 2: Анхны үнэлгээ

Үнэлгээ дүгнэлтүүд нь холбогдох эрх бүхий хүмүүстэй зөвлөгөөн хийж, гаднаас тусламж дэмжлэг авах шаардлагатай эсэхийг тогтоож, шаардлагатай тохиолдолд хариу үйлдлийн мөн чанарыг гаргаж ирэхийн тулд гамшгийн нөхцөл байдлын талаар тэдэнд ойлголт өгч хүний амь нас, нэр төр, эрүүл мэнд, амь зуулгад заналхийлж байгаа зүйлд анализ хийхэд чухал ач холбогдолтой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Илэрхий ойлгомжтой шийдвэр гаргах боломж олгохын тулд мэдээлэлийг стандартчлагдсан процедуруудыг ашиглан олж авч бэлэн болгодог (заавар тэмдэглэл № 1-6 -с харна уу).

- Үнэлгээ тооцоолол хийхэд бүх техникийн салбарууд (ус ба ариун цэврийн хангамж, хүнс, хоол, орон байр, эрүүл мэнд), болон бодит биеийн, нийгмийн, эдийн засгийн, улс төрийн ба аюулгүй байдал хүрээлэн буй орчинг харгалзан үздэг (заавар тэмдэглэл № 7 -с харна уу).
 - Зөвлөгөө хийсний үндсэн дээр үнэлгээ тооцоолол хийхэд орон нутгийн ба үндэсний эрх бүхий байгууллагууд, бусад үйлчилгээ үзүүлэгчид, агентлагуудын хариу үйлдлүүдийг харгалзан авч үздэг (заавар тэмдэглэл № 7 -с харна уу).
 - Гамшигт нэрвэгдсэн хүн ам ба хүрээлэн амьдарч буй хүн ам хоёулангийн гамшигийг даван туулах орон нутгийн хүчин чадал ба стратегиудыг олж тогтоох (заавар тэмдэглэл № 8-с харна уу).
 - Боломжтой үед нь цуглуулж байгаа мэдээлэлийг хүйс, насаар нь ялгах (заавар тэмдэглэл № 9 -с харна уу).
 - Үнэлгээ тооцоолол нь гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн олон улсын эрх зүйд тодорхойлсон эрхээр баталгаажсан байдаг.
 - Үнэлгээ тооцоолол хийхэд холбогдох эрх баригчдын хяналтан доор байгаа газар нутагт оршин сууж байгаа хүн амыг хамгаалах ба туслах хариуцлагыг болон гамшигт нэрвэгдсэн хүн ам бүрт үйлчлэх олон улсын хууль тогтоомжинд нийцэх үндэсний хууль, стандартууд ба заавар удирдамжууд харгалзан авч үздэг.
 - Үнэлгээ тооцоолол нь үйл ажиллагааны хүрээлэн буй орчин, түүний дотор гамшигт нэрвэгдсэн хүн амын ба хүмүүнлэгийн ажилчдын хувийн найдвартай аюулгүй байдалд нөлөөлдөг хүчин зүйлүүдийн анализийг дотроо агуулдаг (заавар тэмдэглэл № 10 -с харна уу).
 - Хүн амын тооны талаархи урьдчилсан тооцоог бололцоотой тооны эх сурвалжтай харьцуулж баталгаажуулж урьдчилсан тооцооны үндсийг бусдад мэдэгдэх болно.
 - Бусад салбарууд, үндэсний ба орон нутгийн эрх бүхий байгууллагууд ба гамшигт нэрвэгдсэн хүн амын төлөөлөгчид үнэлгээ тооцоололын үр дүнг хүлээж авах боломжтой. Гарах эсвэл шилжилтийн стратегиудтай холбоотой байх гаднах тусламж ба зохистой хариу үйлдлүүдэд зөвлөгөө гаргаж өгдөг (заавар тэмдэглэл № 11-с харна уу).
- Хувь хүн салбаруудын үнэлгээ тооцоолол шалгах жагсаалтуудыг техникийн бүлэг болгоны эцэст байгаа хавсралтуудаас олж болно.

Заавар тэмдэглэл

1. Эхний үнэлгээ дүгнэлтүүд нь шаардагдах боломжтой яаралтай шууд тусламж үзүүлэх үндэс болдог бөгөөд илүү нарийвчилсан үнэлгээ тооцоолол хийх зүйлийг олж илрүүлдэг. Ялангуяа хэрэв нөхцөл байдал хурдан хувьсаж өөрчлөгдөх, хүн амын их хэмжээний шилжилт хөдөлгөөн, гэнэтийн өвчин гарах гэх мэт аюултай хөгжил гарахад эхний үнэлгээ тооцоололыг өөрөө төгсгөл биш, харин хянан шалгалт процессийн нэгэн хэсэг болох тасралтгүй хянан залруулах процесс дахь эхний алхам гэж авч үзэх ёстой. Ихэвчлэн бүх салбарууд эсвэл хүн амын хэсэг бүлгүүдэд зохих хэмжээгээр арга хэмжээ авах эсвэл зөвлөгөө өгөх боломжгүй байдаг. Энэ тохиолдолд орхигдсон бүлгүүдийг тодорхой тэмдэглэж эхний боломж гарахад тэдэнд туслах арга хэмжээ авах ёстой.

2. Шалгах жагсаалтууд: эдгээр нь гол хэсгүүдийг шалгах ба энэхүү гарын авлагын техникийн бүлэг болгоны хавсралтуудад шалгах жагсаалтуудын жишээнүүдийг оруулсан байгааг баталгаажуулах ашигтай арга зам юм. Хавсралт № 1 -т нэмэлт мэдээлэлийг олж болно: 43-р хуудасны ном зүй.

3. Цаг хугацаандаа байх: эхний үнэлгээ тооцоололыг амь насанд заналхийлсэн эсвэл бусад шийдвэрлэх шаардлагуудыг шийдвэрлэн гамшиг гарсны дараа бололцоо гармагц яаралтай гүйцэтгэх ёстой. Ердийн нөхцөл байдалд, тайланг хэдэн өдрийн дотор гаргах ёстой бөгөөд түүний формат, агуулга нь хялбар байдлаар эн тэргүүн зүйлүүдийг олж тогтоох ба зохистой хөтөлбөрийг шуурхай боловсруулахад хангалттай мэдээлэл гаргаж өгөх боломжийг төлөвлөгөө гаргагчдад ба шинжээчдэд олгох ёстой. Тусламжийн завсардлыг олж тогтоох ба суурь мэдээлэлээр хангахын тулд дараа нь илүү гүнзгий үнэлгээ тооцоолол хийх шаардлагатай болно.

4. Үнэлгээ тооцоолол хийх баг: Адил тооны эрэгтэй ба эмэгтэй хүмүүсээс бүрдэх, ил тодорхой эрх мэдэлтэй, өргөн мэдлэгтэй хүмүүс ба холбогдох техникийн мэргэжилтнүүдээс бүрдэх, хүн амыг соёлын хувьд хүлээн зөвшөөрөгдөх идэвхтэй байдлаар оролцуулахыг эрмэлздэг баг үнэлгээ тооцооллын чанарыг сайжруулах болно. Улс орон эсвэл бүс нутагт гарсан гамшгийн талаархи орон нутгийн мэдлэг ба өмнөх туршлага шийдвэрлэх ач холбогдолтой байдаг.

5. Цуглуулсан мэдээлэл: багийн гишүүд ажлын талбар дээр ажил эхлэхээс өмнө үнэлгээ тооцооллын тавьсан зорилго ба аргачлал, тэдний өөрсдийн үүргүүдийн талаар сайн ойлгосон байх ёстой бөгөөд ердийн нөхцөл байдалд тухайн хам хүрээнд зохих тоо хэмжээний чанарын аргуудыг хослон хэрэглэх ёстой. Зарим хувь хүмүүс эсвэл бүлгүүд нээлттэй ярих бололцоогүй байх бөгөөд нарийн эмзэг мэдээлэл цуглуулахын тулд онцгой тохиролцоо хийх шаардлагатай болох боломжтой. Мэдээлэлийг дээд зэргийн болгоомжлолтойгоор авч хэрэглэх ба нууцлалтыг чанд сахих ёстой.

Хувь хүнээс зөвшөөрөл авсны дараа энэхүү мэдээлэлийг зохих үйлчилгээ үзүүлэгчид эсвэл байгууллагуудад шилжүүлэх шийдвэр гаргаж болно. Үйл ажиллагааны зөрчилдөөн тэмцлийн нөхцөл байдалд ажиллаж байгаа ажилчид цуглуулсан мэдээлэл нь нарийн эмзэг, буруу ашиглагдах ба агентлагийн үйл ажиллагаа явуулах чадавхи нь гутаах боломжтой гэдгийг ойлгож сэргийлэх ёстой.

6. Мэдээллийн эх сурвалж: Үнэлгээ тооцоолол, тайлангийн мэдээлэлийг анхдагч эх сурвалж, түүний дотор шууд ажиглалт ба агентлагийн ажилчид, орон нутгийн эрх бүхий байгууллагууд, засаг захиргааны нэгжийн удирдагчид (эрэгтэй ба эмэгтэй хүмүүс), хөгшин хүмүүс, хүүхдүүд, эрүүл мэнд ажилчид, багш нар, наймаачид, бусад холбогдох үйлчилгээ үзүүлэгчид гэх мэт чухал хүмүүстэй хийх яриа хэлэлцүүлгүүд, ном судар ба тайлангууд (хэвлэсэн ба хэвлээгүй хоёулаа), холбогдох түүхийн материал, онцгой нөхцөл байдал үүсэхээс өмнөх мэдээлэл гэх мэт хоёрдогч эх сурвалжаас гаргаж авч болно. Үндэсний эсвэл бүс нутгийн гамшигт бэлэн байх төлөвлөгөөнүүд нь чухал мэдээллийн эх үүсвэр болдог. Хоёрдогч мэдээллийг шууд ажиглалт ба үнэлгээтэй харьцуулах нь гарч болзошгүй хэт нэг талын баримтлалыг бууруулдаг. Үр дүнгээр гарч буй өгөгдлийн цуглуулсан мэдээлэл ба хязгаарлалтуудад хэрэглэсэн аргуудын талаар бодит нөхцөл байдлыг олж тогтоох зорилгоор хоорондоо тодорхой ярилцах ёстой. Үнэлгээний тайланд бүх бүлэг хүмүүс, түүний дотор ялангуяа эмзэг хүмүүсийн илэрхийлсэн тусгай санаа бодол ба зөвлөгөөг тодорхой илтгэсэн байх ёстой.

7. Салбарын үнэлгээ дүгнэлтүүд: олон салбарын үнэлгээ тооцооллыг гамшгийн эхний үе шатанд дандаа хийх боломжгүй байдаг бөгөөд тусгай салбарууд дахь шийдвэрлэх шаардлагуудыг хангахын тулд үйл ажиллагааг зогсоох боломжтой. Хэрэв салбарын хувийн үнэлгээ дүгнэлтүүдийг хийвэл бусад салбаруудтай үүссэн холбоо хамаарал болон өргөн хам хүрээ, хамгаалалтын асуудлуудыг бусад үйлчилгээ үзүүлэгчид ба агентлагуудтай консултаци хийсний үндсэн дээр онцгойлон анхааран авч үзэх ёстой.

8. Хүлээн авч буй хүн амтай харьцах харилцаа: Дүрвэгсдэд үзүүлэх тоног төхөөрөмжийн туслалцаа дэмжлэг нь ялангуяа байгаа нөөцүүд хязгаарлагдмал ба шинэ ирэгсэдтэй хуваалцах ёстой болсон тохиолдолд хүлээн авч байгаа газрын хүмүүсийн дургүйцэл хүргэх боломжтой. Энэхүү хурцадмал байдлыг үүсгэхгүйн тулд хүлээн авч буй хүн амтай энэ тухай ярилцах ёстой ба, зохистой газар нь дэд бүтцийн хөгжил, дүрвэгсдэд үзүүлэх үйлчилгээнүүд нь хүлээн авч буй хүн амын амь зуулгыг сайжруулахад тогтвортой байдлыг үүсгэхэд чиглэгдсэн байх ёстой.

9. Өгөгдлийн хэсэглэн хуваалт олон шалтгаанаар чухал байдаг for various reasons. Энэ нь үнэлгээ тооцооллын хэрэглэгчдэд үр дүнгийн нарийвчлалтыг хянах бололцоотой болгож яг тухайн хэсэгт өмнө нь хийсэн судалгаануудтай харьцуулалт хийх боломж олгодог. Түүнээс гадна нас, хүйс, өртөмтгий эмзэг байдал гэх мэт зүйлүүдэд нэмж гэр бүлийн дундаж хэмжээ ба тоог хэсэглэн хуваасан гол мэдээлэл хэлбэрээр оруулах нь ашигтай байдаг.

Учир нь энэ нь зохистой хариу үйлдэл хийх төлөвлөгөө гаргахад тус нэмэр болно. Гамшгийн эхний үе шатанд өгөгдлийг нас ба хүйсээр нь хэсэглэн хуваахад түвэгтэй, хэцүү байх боломжтой. Хэдий тийм боловч таваас доош настай хүүхдүүдийн үхэл ба өвчлөлтийг эхнээс нь баримтжуулах ёстой. Учир нь хүн амын энэхүү хэсэг гол төлөв онцгой эрсдэлтэй байдаг. Цаг, нөхцөл байдлал боломжтой байгаа үед нас, хүйс ба өртөмтгий эмзэг байдлын бусад ялгаа зөрүүнүүдийг нь олж тогтоох зорилгоор илүү нарийвчилсан хэсэглэн хуваалт хийх талаар бодолцон авч үзэх ёстой.

10. Суурь нөхцөл: Үнэлгээ тооцоолол ба дараачийн анализ хийхдээ суурь бүтцийн, улс төрийн, аюулгүй байдлын, эдийн засгийн, хүн ам зүйн ба орчин тойрны асуудлуудыг авч үзэх ёстой. Түүнтэй нэгэн адил, хүлээн авч буй хүмүүс ба дүрвэгсдийн амьдрах нөхцөл байдлууд ба засаг захиргааны нэгж бүтцүүд дэхь гамшгийн өмнөх үе шатанд гарах аливаа өөрчлөлтүүдийг харгалзан авч үзэх ёстой.

11. Нөхөн сэргээлт: Гамшгийн дараахь нөхөн сэргээлтийн үеийн анализ ба төлөвлөлт эхний үнэлгээ тооцооллын нэгэн хэсэг байх ёстой. Учир нь, хэрэв орон нутгийн хүн амын өөрсдийн амьд үлдэх механизмуудыг дэмжих замаар хийгдээгүй бол гаднах туслалцаа нөхөн сэргээлтийг удаашруулах боломжтой.

Нийтлэг стандарт 3: Хариу үйлдэл

Холбогдох эрх бүхий хүмүүс өөрсдийн хяналт доорхи газар нутгийн хүн амыг хамгаалах ба тусламжийн шаардлагуудад хариу үйлдэл хийх чадваргүй буюу хийхийг хүсэхгүй байгаа нөхцөлд үнэлгээ тооцоолол ба анализын үр дүнгээр эдгээр шаардлагууд биелэгдээгүй тохиолдолд хүмүүнлэгийн тусламж шаардлагатай болно.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Гамшгийн уршгаар хүмүүсийн амь нас эрсдэлтэй тулгарсан үед хөтөлбөрүүд амь нас хамгаалах шаардлагуудыг чухалчлан авч үзэх болно (заавар тэмдэглэл № 1 -с харна уу).
- Хөтөлбөрүүд ба төслүүд гамшигт автагдсан хүн амыг дэмжин хамгаалах ба Сфер төслийн минимум стандартуудыг түлхүүр индикаторуудад дүрсэлсэн байдлаар биелүүлэх эсвэл даван биелүүлэх хэмжээгээр тэдний амь зуулгыг дэмжихээр боловсруулагдсан (заавар тэмдэглэл № 2 -с харна уу).
- Гамшигт нэрвэгдсэн эсвэл хариу үйлдэлд холбогдсон хүмүүсийн хооронд мэдээллийн үр ашигтай зохицуулалт ба солилцоо явагддаг.

Хүмүүнлэгийн агентлагууд тэдний туршлага ба хүчин чадал нь нийт тусламжийн хөтөлбөрийн хүрээнд хамгийн их хэмжээгээр нөлөө үзүүлж чадах үйл ажиллагаануудыг шаардлагын дагуу авч хэрэгжүүлдэг (заавар тэмдэглэл № 3 -с харна уу).

- Олж тогтоосон шаардлагуудыг эсвэл минимум стандартуудыг биелүүлж чадахгүй байгууллагууд, хөтөлбөрүүд ба төслүүд завсардал гаргаж болох бөгөөд иймээс бусад хүмүүс туслах боломжтой (заавар тэмдэглэл № 4-5 -с харна уу).
- Зөрчилдөөн тэмцлийн нөхцөл байдалд, тусламжийн хөтөлбөр нь динамик байдал дахь хариу үйлдлийн боломжит нөлөө үйлчлэлийг харгалзан авч үздэг (заавар тэмдэглэл № 6 -с харна уу).

Заавар тэмдэглэл

1. Бодит шаардлагад барих хариу үйлдэл: Хүмүүнлэгийн тусламжийг үнэлэгдсэн хэрэгцээг хангахаар зохион байгуулах ёстой. Зайлшгүй шаардлагатай зүйлүүдийг илгээхэд илүүдэл зүйлүүд саад болохгүй ба илгээмжинд ороогүй байхыг анхаарах ёстой.

2. Минимум стандартуудыг хангах: Хариу үйлдэл хийх хөтөлбөр төслүүд нь бодит амьдрах нөхцөл байдал ба Сфер төслийн минимум стандартуудын хоорондох зөрүүг арилгахаар боловсруулагдсан байх ёстой. Тийм боловч гамшигт нэрвэгдсэн хүн амын онцгой нөхцөл байдал болон урт удаан хугацааны хэрэгцээ шаардлагуудыг хооронд нь ялгах нь чухал. Олон тохиолдолд, засаг захиргааны нэгж, хэсэг, бүс нутаг эсвэл улс орныг ч гэсэн минимум стандартуудыг хангадаг болгоход шаардагдах хүмүүнлэгийн шаардлагууд ба нөөцүүд бэлэн байгаа нөөцүүдээс хавьгүй илүү байдаг. Агентлаг өөрөө ганцаарчлан биелүүлж чадахгүй бөгөөд засаг захиргааны нэгж, тэдний хөршүүд, хүлээн авч буй засгийн газрууд, донорууд, бусад орон нутгийн болон олон улсын байгууллагууд бүгдээрээ чухал үүрэг гүйцэтгэх болно. Гамшгийн нөхцөл байдалд хариу үйлдэл хийж байгаа хүмүүс, байгууллагын хоорондын зохицуулалт чухал ач холбогдолтой завсардлыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай.

3. Хүчин чадал ба туршлага: Тухайн байгууллага өндөр нарийвчлалтай мэргэшсэн эсвэл нэг хэсэг хэрэгцээ шаардлагуудыг (эсвэл бүлэг шаардлагууд) биелүүлэх мандат авсан тохиолдолд өөрсдийн нөөцүүд ба үндсэн ур чадварыг ашиглан боломжоороо хүмүүнлэгийн хамгийн их нөлөө үйлчлэл үзүүлэх зорилт өмнөө тавих ёстой. Агентлагийн туршлага эсвэл мандат үнэхээр хязгаарлагдмал байсан ч нийт хүмүүнлэгийн шаардлага түүний зохион байгуулалтын нөөцүүдийг даван гарах өндөр магадлалтай. Хэрэв агентлаг өөрөө нэмэлт хүчин чадалтай байвал энэ тухайгаа хүмүүнлэгийн тусламжийн өргөн олон нийтэд мэдэгдэж шаардлагатай газар ба цагт нь тус нэмэр оруулах ёстой.

4. Завсардлыг мэдэгдэх: Хүмүүнлэгийн агентлагууд ирээдүйн хөтөлбөрүүдийг явуулах хүсэлтэй байдаг болохоороо явагдаж байгаа санаачлагуудын хөтөлбөр амжилтууд ба эерэг үнэлгээнүүдийг үзүүлэхийг илүүд үздэг ч гэсэн суурь шаардлагуудыг биелүүлэхийн тулд тэд хүчин чадалд нь гарсан завсардлыг нэн даруй мэдэгдэхэд бэлэн байх ёстой.

5. Мэдээлэл хуваалцах: шийдвэрлэх шаардлагуудыг олж тогтоосон байгууллагууд өргөн олон нийтэд аль болвол түргэн шуурхай мэдэгдэж тэдгээр агентлагуудыг хариу үйлдэл хийх хамгийн зохистой нөөцүүд ба хүчин чадалтай болгох болно. Бусад хүмүүс хариу үйлдлүүдээ илүү хурдан ба илүү үр дүнтэй бэлтгэн авахад туслахад олж танисан нэр томъёо, стандартууд ба процедуруудыг боломжтой үе болгонд хэрэглэх ёстой. Хүлээн авч буй засаг захиргаа ба агентлагуудаар улсын түвшин хүлээн зөвшөөрөгдсөн стандарт судалгааны форматууд ба холбогдох заавар удирдамжуудын хэрэглээ нь энэ тал дээр ач холбогдол бүхий хэмжээгээр тусалж чадна.

6. Эерэг нөлөө үйлчлэлийг нэмэгдүүлж, хор хөнөөлийг хязгаарлах: Хомсдмол нөөцүүдийн төлөө зөрчилдөөн тэмцэл ба өрсөлдөөн ихэнхдээ аюултай байдлыг ихэсгэж, тусламжийг буруу хэрэглэх эсвэл шамшигдуулах, шударга бус хуваарилалт эсвэл туслалцааг өөр зүйлд ашиглахад хүргэдэг. Зөрчилдөөн тэмцлийн эх үүсвэр болон мөн чанарыг ойлгосноор туслалцааг аль нэг талыг бариагүй байдлаар хуваарилахад эсвэл сөрөг нөлөө үйлчлэлийг гаргахгүй байдлыг хангахад тус дэм болдог. Зөрчилдөөн тэмцэл үүссэн байдалд оролцогчид, механизмууд, асуудлууд ба зөрчилдөөн тэмцлийн хам хүрээний анализыг хөтөлбөрийн төлөвлөлтийн өмнө гүйцэтгэх ёстой.

Нийтлэг стандарт 4: Зорилтот бүлгийг тодорхойлох

Хүмүүнлэгийн тусламж эсвэл үйлчилгээнүүдийг гамшигт нэрвэгдсэн хувь хүмүүс, бүлгүүдийн өртөмтгий эмзэг байдал, хэрэгцээг харгалзан авч үзсэн үндсэн дээр шударгаар аль нэг талыг илүүд үзэхгүйгээр үзүүлэх ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Зорилтот бүлгийг тодорхойлох шалгуурыг өртөмтгий эмзэг байдлын нарийн анализ дээр үндэслэсэн байх ёстой (заавар тэмдэглэл № 1-с харна уу).
- Зорилтот бүлгийг тодорхойлох механизмуудыг гамшигт нэрвэгдсэн хүн ам (түүний дотор өртөмтгий эмзэг бүлгүүдийн төлөөлөгчид) ба бусад зохистой үйлчилгээ үзүүлэгчдийн дунд хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой. Зорилтот бүлгийг тодорхойлох шалгуурыг ил тодорхой тодорхойлж өргөн тарааж дэлгэрүүлсэн байдаг (заавар тэмдэглэл № 2-3 -с харна уу).

- Зорилтот бүлгийг тодорхойлох механизмууд ба шалгуур хувь хүмүүсийн нэр хүнд ба аюулгүй байдалд халдахгүй эсвэл мөлжлөгт автагдах өртөмтгий эмзэг байдлыг нь ихэсгэхгүй байх ёстой (заавар тэмдэглэл № 2-3 -с харна уу).
- Хуваарилалтын системүүдийг зорилго тодорхойлох шалгуурыг хүлээн зөвшөөрөх ба шаардлагатай үед цаг хугацааны залруулах үйл ажиллагаа авахын тулд хянах ёстой байдаг. (заавар тэмдэглэл № 4-5 -с харна уу).

Заавар тэмдэглэл

1. Зорилтот бүлгийг тодорхойлохын зорилго нь тусламж үр дүнтэй байх ба хамааралыг минимум түвшинд авчрах замаар үзүүлэхийн зэрэгцээ хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг хангахад зориулагдсан байна.

2. Зорилтот бүлгийг тодорхойлох механизмууд аль нэг талыг илүүд ба ялгаварлан үзэхгүйгээр шаардлагын дагуу тусламж үзүүлэх арга зам юм. Үүнд олон нийтэд суурилан зорилтот бүлгийг тодорхойлох, удирдлагын болон хувийн зорилгоо тодорхойлох, эдгээр аргуудын комбинаци ордог. Агентлагийн ажилтнууд зарим тохиолдолд өөрсдөө зорилтот бүлгээ тодорхойлоход зарим нэг өртөмтгий эмзэг бүлгүүдийг орхигдуулах магадлал байдаг. Гамшигт нэрвэгдсэн хүн амтай ярилцсан зорилго тодорхойлох шийдвэрүүдтэй нийцсэн байхын тулд эрэгтэй, эмэгтэй хүмүүс, охид хөвгүүд, өртөмтгий эмзэг бүлэгт хамаарах хүмүүсийг төлөөлөх хэсэг хүмүүсийг консулацийн процесст оролцуулах ёстой. Зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд зэвсэгт мөргөлдөөний эх үүсвэр, мөн чанар болон энэ нь зорилго тодорхойлох тусламжийн тухай удирдлагын ба олон нийт шийдвэрүүдэд яаж нөлөөлөхийг ойлгох нь зайлшгүй шаардлагатай.

3. Зорилтот бүлгийг тодорхойлох шалгуур нь гол төлөв олон нийт, гэр бүл, хувь хүмүүсийн гамшигт өртөмтгий эмзэг байдлын түвшинтэй холбоотой байдаг бөгөөд энэ нь гамшгаас гарах эрсдэлүүд, хүлээн авагчдын давж гарах хүчин чадлаар тодорхойлогддог. Зорилгын шалгуураа буруу тодорхойлсноор хувь хүний нэр төрийг санаандгүй унагаах боломжтой бөгөөд үүнийг гаргахгүй байх механизмууд ба зохистой арга хэмжээнүүдийг авах ёстой. Зарим нэг жишээнүүд:

- Удирдлагын ба олон нийтэд тулгуурласан зорилтот бүлгийг тодорхойлох механизмууд тухай хувь хүний өмч хөрөнгийн талаар мэдээлэл авах асуулт тавьж болох юм. Ийм асуултууд хувь хүний хэрэгт орсон мэтээр ойлгогдох боломжтой бөгөөд нийгмийн бүтцийг сулруулах магадлалтай.

- Хагас өлсгөлөн хүүхдүүдтэй гэр бүлийг ихэвчлэн хоол тусламжинд сонгон хамруулдаг. Энэ нь эцэг эхчүүд тэдний хүүхдүүдээ өлсгөлөн байлгаж хоолны тусламж авахыг урамшуулдаг болохоор хүмүүсийн нэр хүндэнд муугаар нөлөөлөх боломжтой. Энэ нь бас ерөнхий хоолны тусламж авахад тохиолдох боломжтой.

- Орон нутгийн омгийн системээр дамжин тусламжийг хэрэгжүүлэхэд ийм системээс гадна байгаа хүмүүс (жишээлбэл: дүрвэсэн хүмүүс) тусламжаас хасагдсан байх магадлалтай.
- Дүрвэсэн эмэгтэйчүүд, охид хөвгүүд бэлгийн хүчирхийлэлтэнд орох магадлалтай.
- Хүний дархлал хомсдолын вирусын халдвартай хүмүүс доромжлолд өртөх боломжтой.

4. Тоног төхөөрөмж ба үйлчилгээ авах, хэрэглэх боломж: Хүмүүст олгосон тоног төхөөрөмж ба барааны хэрэглээ нь туслалцаа авах боломж, аюулгүй байдал, тав тух, чанар, хэрэгцээ шаардлага, зан заншилд зохистой эсэх гэх мэт олон тооны хүчин зүйлүүдээс хамаардаг. Туслалцаа авах боломж зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд болон хээл хахууль, сүрдүүлэлт ба мөлжлөг (түүний дотор хүйсийн ялгаа) гэх мэт хүчин зүйлүүдээс шалтгаалж зарим талаар шаардлагатай байх боломжтой. Тоног төхөөрөмжүүдийн хэрэглээг хязгаарладаг хүчин зүйлүүдийг бололцоогоор олон нийтийн дайчилгаа эсвэл хөтөлбөрийг дахин хянаж шийдвэрлэх ёстой. Хөтөлбөр хэрэгжилтийн өмнө ба хөтөлбөр хэрэгжилтийн үед хийсэн консултацид эмэгтэйчүүд, хүүхдүүд, бусад өртөмтгий эмзэг бүлгүүдтэй хийх зохих хэмжээний яриа хэлэлцүүлэг орох нь зайлшгүй шаардлагатай бөгөөд тэдний хувьд тавьсан шаардлагууд хамгийн өндөр байх болно.

5. Хянан шалгалтанд оруулах ба оруулахгүй байх алдаанууд: хэрэв зорилго тодорхойлох систем бүх өртөмтгий эмзэг хүмүүсийн гамшгийн дараахь шаардлагыг биелүүлж чадахгүй бол хувь хүмүүс эсвэл бүлгүүд шийдвэрлэх шаардлагуудыг хурдан хөгжүүлж чадна. Хүмүүсийг илүү үр ашигтай хамруулахын тулд зорилго тодорхойлох ба хуваарилалт системүүдийг шинэчлэх ба нарийвчлах бэлтгэх ажлыг хийх ёстой.

Нийтлэг стандарт 5: Хянан шалгалт

Хөтөлбөрийг сайжруулах эсвэл шаардлагатай тохиолдолд түүнийг хэд хэдэн үе шатанд хуваан хэрэгжүүлэх зорилгоор гарсан асуудлуудыг шийдвэрлэх хөтөлбөрийн үр бүтээмжийг олж тогтоож өргөн хам хүрээний өөрчлөлтүүдийг байнга хянан шалгадаг.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Хянан шалгалт хийхэд цуглуулсан мэдээлэл нь цаг хугацаандаа хийгдсэн ба ашиг тустай байх бөгөөд нарийн нямбай, авцалдаатай, тууштай, жигд ба илэрхий ойлгомжтой байдлаар хураан бичигдэн шинжлэгдэж хэрэгжиж байгаа хөтөлбөрт нэмэлт мэдээлэл оруулдаг (заавар тэмдэглэл № 1-2 -с харна уу).

- Техникийн салбар болгоны мэдээллийг тогмол цуглуулалдаг ба стандарт болгоны индикаторуудыг биелэгдсэн эсэхийг олж тогтоодог системүүд байдаг.
- Бүх гамшигт нэрвэгдсэн бүлгийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхдүүдтэй байнга консултаци хийдэг бөгөөд хянан шалгалт үйл ажилгаанд орулцуулдаг (заавар тэмдэглэл № 3 -с харна уу).
- Хөтөлбөр, бусад салбарууд, хүн амын гамшигт нэрвэгдсэн бүлгүүд, холбогдох орон нутгийн эрх бүхий байгууллагууд, донорууд, бусад үйлчилгээ үзүүлэгчдийн хооронд шаардлагатай тохиолдолд мэдээллийн солилцоо явуулдаг системүүд байдаг (заавар тэмдэглэл № 4 -с харна уу).

Заавар тэмдэглэл

1. Хянан шалгалтын мэдээллийн хэрэглээ: Гамшгийн нөхцөл байдлууд хувирамтгай ба динамик байдаг. Тийм учраас байнга шинэчлэгдсэн мэдээлэл хөтөлбөрүүд үргэлж ач холбогдолтой ба үр ашигтай байхыг баталгаажуулахад амин чухал байдаг. Тогмол хяналт шалгалт нь эн тэргүүн зүйлүүдийг тодорхойлох, илэрсэн асуудлуудыг олж тогтоох, чиг хандлагуудыг дагах, авсан хариу үйлдлүүдийн үр нөлөөг тодорхойлох, хөтөлбөрүүдээ засаж, залруулах боломж менежерт олгодог. Хөтөлбөрүүдийн үргэлжилсэн хяналт шалгалтаар гаргаж авсан мэдээллийг шүүмжлэл, үнэлгээнүүд ба бусад зорилгоор ашиглаж болно. Зарим нөхцөл байдалд шаардлагууд эсвэл хам хүрэн дэх үндсэн өөрчлөлтүүдэд хариу үйлдэл хийхэд стратегийн өөрчлөлт шаардлагатай болох боломжтой.

2. Мэдээлэл хэрэглэх ба тарааж түгээх: Цуглуулсан мэдээлэл нь хөтөлбөрт шууд ач холбогдолтой байх ёстой – өөрөөр хэлбэл, ашигтай ба түүний дагуу үйл ажиллагаагаа явуулах ёстой. Түүнийг баримтжуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд бусад салбарууд, агентлагууд ба гамшигт нэрвэгдсэн хүн амд идэвхтэй байдлаар бэлдэж өгөх шаардлагатай. Хэрэглэгдэж байгаа харилцаа холбооны арга зам (түгээн тараах аргууд, хэл, гэх мэт) нь зохистой ба зориулсан бүлэг хүмүүс авах боломжтой байх ёстой.

3. Хянан шалгалтанд холбогдох хүмүүс: Гамшигт нэрвэгдсэн хүн амын бүх бүлгээс соёлын хувьд хүлээн зөвшөөрөгдөх байдлаар мэдээлэл цуглуулж чадах хүмүүсийг, ялангуяа хүйс ба хэлний ур чадварыг нь харгалзан оролцуулах ёстой. Орон нутгийн соёлын уламжлал, практикаас харахад эмэгтэйчүүд эсвэл цөөнх бүлгүүдийг соёлын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн хувь хүмүүсээс консултаци тусдаа авах шаардлагатай байдаг.

4. Мэдээлэл солилцох: хяналт шалгалт ба үнэлгээ хийх үйл ажилгаанууд нягт консултаци ба салбарууд хамтын ажиллагааг шаарддаг. Жишээлбэл : булчин задрах тахал гарах үед ус ба ариун цэврийн хангамжийн агентлагууд ба эрүүл мэндийн агентлагуудын хооронд мэдээллийг үргэлжлэн солилцох ёстой. Тогмол явагдах хурал уулзалт ба мэдээллийн самбарыг хэрэглэх гэх мэт зохицуулалтын механизмууд энэхүү мэдээллийн солилцоог хялбарчилдаг.

Нийтлэг стандарт 6: Үнэлгээ хийх

Сургамж авах, практик ба бодлогыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх зориулалттай хүмүүнлэгийн үйл ажиллагаанд байнгын ба шударга үнэлгээ хийх явдал юм.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Нийт хөтөлбөрийн зохистой байдал, үр ашиг, хамруулалт, уялдаа холбоо гамшигт нэрвэгсдэн хүн амд үзүүлэх нөлөө үйлчлэлийг хэмжих зорилгоор тавьсан зорилго ба тохиролцсон минимум стандартуудыг харгалзан хөтөлбөрт үнэлгээ хийдэг (заавар тэмдэглэл № 1 -с харна уу).
- Үнэлгээнд гамшигт нэрвэгсдэн хүн амын болон хоорондоо ялгаатай тохиолдолд түүнчлэн хүлээн авч буй олон нийтийн үзэл, санаа бодлыг анхааран авч үздэг.
- Үнэлгээ хийх зорилгоор мэдээлэл цуглуулахдаа чөлөөтэй ба аль нэг талыг баримтлаагүй байдлаар хийдэг.
- Үнэлгээ болгоны үр дүнг ирээдүйн практикийг сайжруулахад хэрэглэдэг (заавар тэмдэглэл № 2 -с харна уу).

Заавар тэмдэглэл

1. Шалгуур тогтоох: Хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрүүдэд үнэлгээ хийх нь хялбар ажил биш юм. Учир нь гамшиг огцом өөрчлөлтүүд ба тодорхой биш байдлын хэмжээгээр тодорхойлогддог. Шилдэг аргуудаар гамшгийн хариу үйлдлүүдийн төвөгтэй мөн чанарыг олж тогтоох илүү боломжтой ба ийм хөтөлбөрүүдэд үнэлгээ өгөгчид хүчин төгөлдөр шийдвэр гаргахын тулд хоорондоо янз бүрийн аргууд хэрэглэж, гарах үр дүнгийг нь хооронд нь харьцуулж үнэлгээ хийх ёстой.

2. Мэдээллийн байнгын хэрэглээ: Үнэлгээний үр дүнд илэрхий ойлгомжтой ба хариуцлагатай байдалд тус нэмэр оруулах зорилгоор хуваалцах ба хүмүүнлэгийн тусламжийн бодлого, практикийг дээшлүүлдэг хөтөлбөрүүд ба агентлагууд сургамж авах боломж олгодог бичгээр үйлдсэн тайлангууд гаргах ёстой.

Нийтлэг стандарт 7: Тусламжийн ажилтаны эрх мэдэл ба хариуцлагууд

Тусламжийн ажилтнууд тухайн хөтөлбөрийг төлөвлөх ба үр дүнтэй хэрэгжүүлэхэд зохих хэмжээний мэргэшил, зан төлөв, туршлага эзэмшсэн байна.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Тусламжийн ажилтнууд зохих техникийн мэргэшил, орон нутгийн соёл ба заншлын тухай мэдлэг буюу өмнөх онцгой нөхцөл байдлын талаархи туршлагатай байна. Ажилтнууд хүний эрх ба хүмүүнлэгийн зарчмуудыг сайн мэддэг байна.
- Ажилчид гамшигт нэрвэгдсэн хүн амын дунд ба хүлээн авч буй газрын хүн амтай гарч болзошгүй хүндрэл, зэвсэгт мөргөлдөөний эх үүсвэрийн тухай мэдлэгтэй байна. Тэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд гарах хүндрэлийг тунгаан ойлгож өртөмтгий эмзэг бүлгүүдэд онцгой анхаарал тавих ёстой (заавар тэмдэглэл № 1 -с харна уу).
- Ажилчид доромжилсон, ялгаварлан үзэх эсвэл хууль бус үйл ажилгаануудыг таних чадвартай ба ийм үйл ажилгаануудад оролцохгүй байх ёстой (заавар тэмдэглэл № 2 -с харна уу).

Заавар тэмдэглэл

1. Ажилчид мэдэр ёстой зүйл: Ажилчид хүчирхийлэлийн гэмт хэрэг, түүний дотор хулгай ба эмэгтэйчүүд, охид хөвгүүдийн эсрэг харгис байдлын бусад хэлбэрийн гэмт хэрэг хямралын үед нэмэгдэж болохыг тунгаан ойлгох шаардлагатай. Зовлон амсах ба хулгайгаас айх айдас нь эмэгтэйчүүдийг цэргүүд ба эрх бүхий байгууллагад ажилладаг эрх мэдэлтэй бусад эрэгтэйчүүдтэй холбоо тогтооход хүргэдэг. Залуу эрэгтэй хүмүүс байлдаж байгаа армийн цэрэг татлагад хамрагдах өндөр магадлалтай байдаг. Ажилчид ба ажлын талбарын түншүүд хүний эрхийн зөрчлүүдийн нөхөн төлбөр авахыг хүсэж байгаа эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд ба хүүхдүүдтэй яаж харьцахаа мэдэх бөгөөд хулгай ба бэлгийн хүчирхийлэлд орсон хүмүүст зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн эсвэл жирэмслэлтийн эсрэг арга хэмжээ авах процедуруудтай ойр дотно танилцах ёстой.

2. Ажилчид ойлгох зүйл: Ажилчид гамшигт үзүүлэх хариу үйлдэл хийх хөтөлбөрүүдэд хамаарах үнэ цэнэтэй нөөцүүдийн менежментэнд болон бүрдүүлэлтэнд тавих хяналтын хариуцлага нь тэднийг ба түгээлтэнд оролцогчдыг бусад хүмүүстэй харьцуулвал харьцангуй илүү их эрх мэдэлтай байдалд байдгийг ойлгох ёстой. Ажилчид энэхүү эрх мэдлийг зээл хахууль авч эсвэл хэрүүл маргаантайгаар ашиглах аюулын талаар сонор сэрэмжтэй байх ёстой. Ажилчид эмэгтэйчүүд, хүүхдүүдийг гутаасан, доромжилсон эсвэл мөлжсөн байдалд ихэвчлэн албадан оруулсан байдгийг мэдэж байх ёстой. Бэлгийн харьцаа хүмүүнлэгийн тусламж харилцан үзүүлэхэд шаардлагатай биш байдгаас гадна туслалцаа үзүүлэгч ажилтангууд аливаа ийм хэлбэрийн харилцаанд оролцож үл болно. Албадсан хөдөлмөр ба хориотой эм наркотик хэрэглэх ба худалдаалах гэх мэт үйл ажилгаанууд явуулахыг бас хориглосон.

Нийтлэг стандарт 8: Хүний нөөцийн хяналт, менежмент ба дэмжлэг

Тусламжийн ажилтнууд хүмүүнлэгийн тусламжийн хөтөлбөрийн үр ашигтай хэрэгжилтийг хангахын тулд хяналт ба дэмжлэг авдаг.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Менежерүүд гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээх бөгөөд ёс зүйн хэм хэмжээг баталгаажуулах зохих хэмжээний аюулгүй байдал, ёс журамд нийцэх байдлыг хангаж түүнчлэн ажилчидаа дэмжлэг үзүүлэх ёстой (заавар тэмдэглэл № 1 -с харна уу).
- Техникийн ба удиодлагын ажилчид хариуцлагаа биелүүлэхэд шаардагдах сургуулилалт, нөөцүүд ба хангамжийн дэмжлэг авдаг (заавар тэмдэглэл № 2 -с харна уу).
- Хөтөлбөрүүд дээр ажиллаж байгаа ажилчид гүйцэтгэхээр даалгасан үйл ажилгаануудын зорилго ба аргыг ойлгох ба өөрсдийн гүйцэтгэлийн талаар санал шүүмжлэл авдаг.
- Бүх ажилчид ил тодорхой тайлагнах чиг заавартай бичгээр үйлдсэн ажлын тайлбаруудтай ба бичгээр үйлдсэн өөрсдийн гүйцэтгэлийн үнэлгээг тогтмол авдаг.
- Бүх ажилчид ажиллаж буй бүс нутаг ба хүрээлэн буй орчин дахь холбогдох эрүүл мэнд ба аюулгүй байдлын асуудлуудын талаар зааварчилгаа авсан байна (заавар тэмдэглэл № 3 -с харна уу).
- Ажилчид зохих хэмжээний аюулгүй байдлын сургуулилалт авсан байна.

- Ажилчдын хүчин чадал бүрдүүлэх системүүд хийгдэж тэдэнд хянан шалгалт тавих болно (заавар тэмдэглэл № 4-5 -с харна уу).
- Үндэсний ба орон нутгийн байгууллагуудын хүчин чадлыг удаан хугацааны тогтвортой байдлыг хангах зорилгоор хийгдсэн.

Заавар тэмдэглэл

1. Бүх түвшингийн менежерүүд хөтөлбөрүүдийн ба холбогдох бодлогууд хэрэгжилтийг дэмжих системүүдийг бүрдүүлэх буюу ажиллагааг нь хангах ба ёс журмуудыг даган сахиулах хариуцлага хүлээх болно. Зарим хүмүүнлэгийн агентлагууд аль хэдийнэ хүүхэд хамгаалалт, бэлгийн мөлжлөг ба хэрүүл гэх мэт асуудлуудтай холбоотой ажилчдын ба байгууллагын дотоод журамд хамаарах журам дүрэмтэй. As of ийм дүрмүүдийн чухал ач холбогдлыг өргөн хүлээн зөвшөөрөгдсөн тул олон олон хүмүүнлэгийн агентлагууд ёс журам боловруулах шатанд явж байгаа. Ийм журмуудыг дагаж мөрдүүлэх удирдах хүмүүсийн хариуцлага бол түүний биелэлтийг хангах үндсэн чанар болдог.

2. Хүмүүнлэгийн агентлагуудын ажилчид дадлагажсан, чадамгай, зөв сургагдсан ба бэлтгэгдсэн байж онцгой нөхцөл байдал гарах болно. Онцгой нөхцөл байдлын багуудыг тарааж байрлуулахдаа агентлагууд ажилчид ба сайн дурынхны дунд эмэгтэй ба эрэгтэй хүмүүсийн балансыг хангах ёстой. Үргэлжлэн явагдажх дэмжлэг ба сургуулилалт ажилчид өөрсдийн хариуцлагуудаа биелүүлж чадахад шаардлагатай байх боломжтой.

3. Бүх ажилчид аюулгүй байдал ба эрүүл мэнд асуудлуудын талаар зохих зааварыг хуваарилалтаас өмнө ба ажлын талбар дээрээ очих үед авах ёстой. Тэд хуваарилагдахаасаа өмнө вакцин ба хумхаа өвчний эсрэг профилактик эмчилгээ (шаардлагатай тохиолдолд) хийлгүүлэх ёстой. Ажлын талбар дээрээ ирсний дараа тэд аюулгүй байдлын эрсдэлүүдийг минимум түвшинд байлгах зориулалттай мэдээлэл авах ёстой ба хоол ба ус аюулгүй байдал, Хүний дархлал хомсдолын нян/ДОХ өвчин ба бусад эндемик инфекцийн өвчинүүдээс хамгаалах, эмнэлгийн туслалцаа авах боломж, эрүүл мэндийн нүүлгэн шилжүүлэх бодлогууд ба процедурууд, ба ажилтангуудын нөхөн олговорын талаар товч заавар авах ёстой.

4. Байгууллагын өөр өөр түвшингүүдийн дундах ялгааг дэмжих **онцгой хүчин чармайлтууд** гаргах ёстой.

5. Хүчин чадал бүрдүүлэлт гай гамшгийн дараахь сэргээн босголтын үе шатны тодорхой нэг зорилго юм. Үүнийг боломжтой хэмжээгээр нь гай гамшиг/хөнгөлөх үе шатанд, ялангуяа удаширсан, сунжирсан үед авах ёстой.

Хавсралт № 1

Ном зүй

Оксфордын их сургуулийн дэргэдэх Дүрвэгсдийг Судлах Төвийн Албадсан Нүүдэлийн Онлайн хөтөлбөрийн үр дүнд олон тооны эдгээр бичиг баримтууд зохиогчийн эрхийн зөвшөөрөл авсан ба Сфер төслийн тусгай хуудас дээр тавигдсан байгаа: <http://www.forcedmigration.org>

Оролцогчид

ALNAP глобаль судалгаа: Хүмүүнлэгийн Үйл ажиллагаанд оролцох Гамшигт нэрвэгдсэн Хүн амын оролцоо: Практикийн ажилтаны Гарын авлага (удахгүй гарах болно). <http://www.alnap.org>
<http://www.hapgeneva.org>

Үнэлгээ ба хариу үйлдэл

UNHCR, Онцгой байдлын гарын авлага (2000 он). <http://www.unhcr.ch>
Үнэлгээ ба хариу үйлдлийн ажлын талбарын ажиллагааны заавар удирдамжууд (FOG, 1998 он). USAID. <http://www.info.usaid.gov/ofda>
Хүмүүнлэгийн онцгой нөхцөл байдал дахь хүн ам зүйн үнэлгээ тооцооллын арга барилууд: Семинарын хураангуй (2002 он). <http://books.nap.edu/books/0309084970/html>
Хүн төрлөхтний хөгжлийн номын сан: <http://humaninfo.org>
ОСНА Хүмүүнлэгийн мэдээллийн төвүүд: <http://www.humanitarianinfo.org>
ОСНА (1999), Онцгой хэцүү нөхцөл байдалд баримтлах гарын авлага. хүмүүнлэгийн асуудал зохицуулах газар. Нэгдсэн үндэсний байгууллага. Нью-Йорк хот.
Гай гамшигт хөнгөлөх тусламжийн хүмүүнлэгийн сүлжээний номын сан: <http://www.reliefweb.int/library>
Telford, J (1997), Сайн туршилагын тойм 5: Онцгой нөхцөл байдлын Ажиллагаагаар тусламж авсан хүн амыг тоолох ба олж тогтоох: Бүртгэл ба түүний хувилбарууд. Гамшигийн тусламж ба сэргээн болголтын сүлжээ/Далайн чанадын хөгжлийн институт. Лондон хот.

Зорилтот бүлгийг тодорхойлох

Гамшиг ба дайны үеийн хүмүүнлэгийн ёс зүй. IFRC, 2003 он. <http://www.ifrc.org/publicat/wdr2003/chapter1.asp>

Олон улсын хоолны бодлогын судалгааны институтын сургалтын материал, *Зорилго тодорхойлох: Зарчмууд ба Практик.* <http://www.reliefweb.int/training/ti1227.html>

Винсент, М, Рефслунд Соренсен, Б. (хэвлэл) (2001 он), *Хил хязгаарын халдалт, дотоод дүрвэгсдийн хариу үйлдэл стратегиуд.* Норвег улсын дүрвэгсдийн Зөвлөл.

Гамшигийн аюулыг бууруулах, эсрэг арга хэмжээ авах гамшиг, зорилтот эмзэг бүлгийг тодорхойлох олон улсын стратеги. UN/ISDR, 2001. <http://www.unisdr.org>

Хяналт ба үнэлгээ хийх

ALNAP Жилийн Тойм (2001 он), *Хүмүүнлэгийн үйл ажиллагаа: Үнэлгээнээс сурах.* <http://www.alnap.org>

ALNAP Жилийн тойм (2003 он), *Хүмүүнлэгийн үйл ажиллагаа: Хариуцлага дээшлүүлэх ба сургалтыг сайжруулахад тавих хянан шалгалтыг сайжруулах.* <http://www.alnap.org>

Онцгой хэцүү нөхцөл байдалд хүмүүнлэгийн тусламжийн үнэлгээ хийх заавар удирдамж, (1999 он). Далайн чанадын эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагаа (OECD). Парис хот. <http://www.oecd.org/dac>

Хүмүүнлэгийн тусалцааны үнэлгээ хийх гарын авлага. Европын олон нийтийн хүмүүнлэгийн газар, Үнэлгээ хийх хэлтэс, Брюсель хот, 2002 он. <http://europa.eu.int>

Ажилтан

Тусламжийн ажилтныг дэмжих ба удирдах сайн туршлагын журам 2003. Хүмүүс Тусламжинд. <http://peopleinaid.org>

Хүүхдүүд

Хүүхдийн эрхийн төлөө үйл ажиллагаа (ARC). Хүүхдүүдийг хамгаалах холбоо ба UNHCR, 1998.

Хүүхдүүд цэргүүд биш, цэрэгт татагдсан ба байлдаж байгаа хүчинд хамаарах хүүхдүүдтэй ажиллах заавар удирдамжууд. Хүүхдүүдийг хамгаалах.

Гослинг, Л ба Эдвардс, М, *Арга хэрэгслүүд –Төлөвлөлт, хянан шалгалт, үнэлгээ ба нөлөө үйлчлэлийн үнэлгээ хийх практикийн удирдамж.* Хүүхдүүдийг хамгаалах.

Ганцаардсан ба тусгаарлагдсан хүүхдүүдийн асуудал дээр ажилладаг ажлын групп, Ганцаардсан ба тусгаарлагдсан хүүхдүүдийн асуудлыг шийдвэрлэх агентлаг дундын удирдамж болох зарчмууд (удахгүй хэвлэгдэн гарна).

Хөгжлийн бэрхшээл

<http://www.annenberg.nwu.edu/pubs/disada/>

<http://www.fema.gov/rrr/assistf.shtm>

<http://www.redcross.org/services/disaster/beprepared/disability.pdf>

Хүрээлэн буй орчин

<http://www.benfieldhrc.org/disastersstudies/projects/REA>

Бичил үйл ажилгаануудыг хүрээлэн буй орчин тойрны нөөцийн үнэлгээ:

<http://www.encapafrika.org>

www.reliefweb.int/ochaunep

Хүйс

Бек, Т ба Стелкнер, М (1996 он), *Хүйсийг нарийн харгалздаг индикаторуудын удирдамж.* Канад улсын олон улсын хөгжлийн агентлаг (CIDA). Кьюбек хот.

Дуган, Ж, *Дүрвэгсдийн баазууд дахь эмэгтэйчүүд ба хүүхдүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл хийх боломжийн үнэлгээ.* Хүмүүнлэгийн тусламжийн сэтгүүл, 08-р сар 2000 он. <http://www.jha.ac/articles>

Энарсон, Е (2000 он), *Хүйс ба Байгалийн гай гамшигууд*, Ажлын тэмдэглэл, Хямралын үед хариу үйлдэл авах ба сэргээн байгуулалтыг төвлөрүүлэн хэрэгжүүлэх хөтөлбөр. ILO.

FAO, *Онцгой байдлын үеийн хүйсийн асуудлын хавсралтууд*: гарын авлагууд, заавар удирдамжууд, гол бичиг баримтууд: <http://www.fao.org>

FAO/WFP (2003), *Онцгой байдлын үеийн хүйсийн асуудлын ирээдүйг тодорхойлох гол арга замууд*.

Хүйс ба гамшгийн сүлжээ: <http://www.anglia.ac.uk>

Хүйс ба хүмүүнлэгийн тусламжийн багц нөөц: <http://www.reliefweb.int/library/GHARkit>

UNHCR, *Эмэгтэй дүрвэгсдийн хамгаалах заавар удирдамжууд*.

UNICEF (1999), *Тогтворгүй хүрээлэн буй орчинд хүйсийн асуудлыг чухалчлан авч шийдэх*. <http://www.reliefweb.int/library>

Хүний дархлал хомсдолын нян/ДОХ өвчин

Холмес В (2003 он), *Ирээдүйн хамгаалалт: Дүрвэсэн ба дайн-гамшигт нэрвэгдсэн хүн амыг хүний дархлал хомсдолын нянгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ба дэмжлэг үзүүлэх*. Олон улсын аврах комисс. Кумариан Хэвлэл, Нью-Йорк хот.

Агентлаг дундын ажлын талбарын гарын авлага. Дүрвэгсдийн эрүүл мэндийн байдлыг нөхөн сэргээх. UNHCR/WHO/UNFPA. Генева хот, 1999.

Хүний дархлал хомсдолын нян/ДОХ өвчин бүхий онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах агентлаг дундын байнгын комисс (IASC). *Хүний дархлал хомсдолын нян/ДОХ өвчин бүхий онцгой нөхцөл байдал үүссэн үед гаднаас авах арга хэмжээнүүдийн заавар удирдамжууд* (төсөл). IASC, 2003: 85. Генева хот.

Олон улсын гэр бүлийн эрүүл мэндийн байгууллага (FHI) (2001 он), *Хангалтгүй нөөцтэй үед хүний дархлал хомсдолын нян/ДОХ өвчингөөс урьдчилан сэргийлэх ба хамгаалах: Хөтөлбөр боловсруулах ба менежмент хийх гарын авлага*. Виржиния хот.

Өндөр настай хүмүүс

ХелпЭйж олон улсын байгууллага, *Өндөр настай хүмүүс гамшиг ба хүмүүнлэгийн хямралын үед: Хамгийн сайн практикийн заавар удирдамжууд*. Англи, франц, испани ба португаль хэлээр бэлэн байгаа. <http://www.helpage.org>

Хөгшрөлтийн эсрэг авах үйл ажиллагааны Мадрид хотод гаргасан олон улсын төлөвлөгөө, Хөгшрөлтийн асуудлыг хэлэлцсэн хоёрдогч орнуудын ассемблейн тайлан, Мадрид хот, 2002 оны 04-р сарын 8-12 -нд, A/CONF.197/9, 54-56 –р зүйлүүд. <http://www.un.org>

UNHCR, *Өндөр настай дүрвэгсдэд авч хэрэгжүүлэх бодлого* (2000 оны 02/03-р сард зохион байгуулагдсан Байнгын комиссын 17-р цуглаан дээр баталгаажуулсны дагуу). EC/50/SC/CRP.13

Нэгдсэн үндэсний байгууллагаас өндөр настай хүмүүст авч хэрэгжүүлэх зарчмууд. <http://www.un.org>

Хамгаалал

Хамгааллын асуудлын хэлэлцүүлэг. UNHCR. Генева хот, 2002.

Фрохардт, М, Паул, Д ба Минеар, Л (1999 он), *Хүний эрхийн хамгаалал: Хүмүүнлэгийн байгууллагууд хүлээн авах уриа дуудлага*. Тогтмол бус тэмдэгдэл 35, Томас Ж. Ватсон жуниор. Олон улсын судалгааны институт, Брауны Их сургууль.

Орогнуулах байр нэмэгдүүлэх: Хүмүүнлэгийн үйл ажиллагаа, хөтөлбөрүүд ба ажлын талбараас олж авсан практик туршлагаар эрх хэмгаалах. Агентлаг дундын байнгын комисс, Генева хот.

Дүрвэгсдийг хамгаалах: Төрийн бус байгууллагуудын ажлын талбарын удирдамж. UNHCR. Генева хот, 1999

Дайны үед хамгаалалтыг чангатгах: Мэргэжлийн стандартуудыг олж тогтоох. ICRC. Генева хот, 2001.

ООНА, *Зэвсэгт зөрчилдөөн тэмцлийн үед иргэдийг хамгаалах.* http://www.reliefweb.int/ocha_ol/civilians/

Хүмүүнлэгийн тунхаг бичиг ба Минимум стандартууд

Тэмдэглэл

48

Бүх салбаруудад мөрдөгдөх нийтлэг минимум стандартууд

Тэмдэглэл

49

Хүмүүнлэгийн тунхаг бичиг ба Минимум стандартууд

Тэмдэглэл

50

Хоёрдугаар Бүлэг: Усан Хангамжинд Тавигдах

үндсэн Шаардлагууд Ба Эрүүл Ахуйг Таниулан Сурталчлах

51

Энэхүү бүлгийг хэрхэн ашиглах тухай

Уг бүлгийг дараах үндсэн зургаан гарчиг буюу сэдэвт хуваасан болно. Үүнд: Эрүүл Ахуйг Таниулан Сурталчлах, Усан хангамж, Ялгадасыг Хаях, Халдвар Тээгчийг Устгах, Хатуу Хог хаягдлын Менежемент ба Бохирын Шугам. Сэдэв болгон дараах хэсгүүдийг багтаасан болно:

- *Наад захын шаардлага буюу минимум стандартууд:* Энэ нь ус болон ариутгалын ажлыг гүйцэтгэх хамгийн наад захын түвшинг тогтоож өгдөг.
- *Гол үзүүлэлтүүд буюу түлхүүр индикаторууд:* Энэ нь зохих стандартууд биелэгдсэн буюу хангагдсан эсэхийг заах нэг ёсны “дохио” юм.
- *Заавар тэмдэглэл:* Үүнд стандарт болон үзүүлэлтүүдийг янз бүрийн нөхцөлд ашиглах үед авч үзэх тодорхой санаа, бодитой хүндрэл бэрхшээлийг шийдэх заавар мөн эн тэргүүнд тавигдах асуудлын тухай зөвлөгөө зэрэг багтана. Тэдгээр санамжуудад мөн стандарт, үзүүлэлтүүдтэй холбоотой шүүмжлэлтэй асуудлууд багтах ба одоо байгаа мэдлэгийн зөрчил зэргийг тайлбарласан болно.

Хавсралтуудад ашигласан ном бүтээлийн жагсаалтыг харуулсан ба энэхүү бүлэгтэй холбоотой ерөнхий болон тодорхой чиглэлийн асуудлын талаарх мэдээллийн эх сурвалжыг зааж өгсөн болно.

52

АГУУЛГА

Удиртгал	54
1. Эрүүл Ахуйг Таниулан Сурталчлах.....	59
2. Усны хангамж.....	63
3. Ялгадасыг Хаях.....	71
4. Халдвар Тээгчийг Устгах.....	76
5. Хатуу Хог хаягдлын Менежемент.....	83
6. Бохирын шугам.....	86
Хавсралт 1: Усны Хангамж болон Эрүүл Ахуйн Шаардлагыг Үнэлэх асуулга.....	89
Хавсралт 2: Байгууллагуудын Усны Хэрэгцээний Наад Захын Хэмжээ ба бусад хэрэглээ.....	93
Хавсралт 3: Гамшгийн Нөхцөлд Олон Нийтийн Газар болон Байгууллагуудад Байх ёстой Жорлонгийн доод талын тоо.....	94
Хавсралт 4: Ус болон Ялгадастай Холбоотой Өвчин ба Дамжих Арга Механизм.....	95
Хавсралт 5: Ашигласан ном бүтээл.....	96

УДИРТГАЛ

Олон улсын хууль эрх зүйтэй холбогдох нь

Усны хангамжид тавигдах үндсэн шаардлагууд ба эрүүл ахуйч байдлыг дэлгэрүүлэх тухай асуудал нь Хүмүүнлэгийн Тухай Бүлэгт тусгасан зарчим болон эрхүүдийн бодит илэрхийлэл юм. Хүмүүнлэгийн Тухай Бүлэг нь олон улсын хүний эрхийн акт болон хүмүүнлэгийн ба дүрвэгсдийн тухай хуульд заасны дагуу гамшиг буюу зэвсэгт мөргөлдөөнд өртсөн хүн амын ахуй амьдралыг хангах буюу тэтгэхэд тавигдах үндсэн шаардлагуудыг агуулсан юм.

Хүн бүр ус хэрэглэх эрхтэй. Уг эрх нь олон улсын хууль эрх зүйн актуудад хүлээн зөвшөөрөгдөж баталгаажсан ба хувийн болон айл өрхийн хэрэгцээнд хангалттай хэмжээний, аюулгүй, хүртээмжтэй бөгөөд хямд хялбар усыг хувийн болон өрхийн хэрэгцээнд зориулан хэрэглэх эрхтэй байна. Аюулгүй усыг тохирох хэмжээнд хэрэглэснээр цангаж ангахаас үүдэх үхэлээс сэргийлж, устай холбоотой аливаа өвчин эмгэгт өртөх эрсдлийг багасгаж, хэрэглэх, хоол хийх болон хувийн бөгөөд өрхийн эрүүл ахуйн шаардлагыг хангах боломжтой болох юм.

Ус хэрэглэх эрх нь эрүүл байх эрх, орон сууцтай байх эрх мөн тохирох хоол хүнс хэрэглэх эрх зэрэг хүний бусад эрхтэй салшгүй холбоотой асуудал юм. Тийм болохоор энэ нь хүний амьдрах, амьд байхад зайлшгүй шаардагдах баталгааны нэг хэсэг юм. Төрийн болон төрийн бус байгууллагын ажилтанууд ус хэрэглэх энэхүү эрхийг хэрэгжүүлэх хариуцлагыг хүлээнэ. Тухайлбал зэвсэгт мөргөлдөөний үед ундны усны байгууламж болон асжуулалтын газруудыг довтлон сүйтгэх буюу эвдэн нураахийг хориглосон байдаг.

Уг бүлэгт тайлбарласан наад захын шаардлага нь Ус Эдлэх Эрхийн тухай бүрэн гүйцэд ойлголт өгч чадахгүй юм. Гэсэн хэдий ч Сфер стандартууд нь Ус Хэрэглэх Эрхийн гол агуулгын илэрхийлэл болж байгаа ба энэхүү эрхийг дэлхий дахинд хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байдаг юм.

Онцгой нөхцөл байдлын үе дэх усны хангамж, эрүүл ахуйг таниулах сурталчлахын ач холбогдол.

Аливаа нэг гамшигт нөхцөл байдал бий болсон эхний үед ус болоод ариутгалын асуудал маш хурцаар тавигддаг хүчин зүйлүүд юм. Гамшигт өртсөн хүмүүс дутуу дулимаг ариутгал, усны хангамж дутагдалтайгаас болон муу эрүүл ахуйн шаардлага хангаагүйгээс ямар нэг өвчин эмгэг тусах, түүнээс үүдсэн үхэлд хүрэх тохиолдол маш их элбэг тохиолддог. Хамгийн их элбэг тохиолддог нь суулгах буюу гүйлгэх өвчин, мөн бохир гараар дамжин халдварладаг өвчнүүд байдаг (Хавсралт 4-ийг үзнэ үү). Ус болон ариутгалтай холбоотой бусад өвчинд хатуу хог хог хаягдал болон бохир устай холбоотой халдвар тээгчийн тээж явдаг өвчингүүд мөн багтана.

Гамшгийн үеийн усан хангамж, ариутгалын хөтөлбөрийн гол зорилго бол эрүүл ахуйн зөв дадал хэвшлийг таниулан сурталчлах, аюулгүй ундны усаар хангах, байгаль орчноос хамаарах эрүүл мэндийн эрсдлийг бууруулах, хүмүүст эрүүл энх, тав тухтай аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүлэх замаар өвчний халдвар тээгчүүдийг ил болгож, бохир гараар дамжин халдварладаг өвчнүүдийн халдварыг бууруулах явдал юм. “Ариутгал” гэдэг нь бүхэлдээ ялгадасыг хаях, халдвар тээгчийг устгах, хатуу хог хаягдлыг хаях мөн бохирын шугам гэсэн утгуудыг мөн илэрхийлсэн болно.

Хүмүүсийг хангалттай хэмжээнд усаар хангаж, ариутгалын байгууламж бий болгосноор зөвхөн олон нийтийн эрүүл мэндийг найдвартай хамгаалахад нөлөөлж чадна хэмээн үзэж болохгүй. Үр дүнг байж болох дээд хэмжээнд хүргэхийн тулд юуны өмнө гамшигт өртсөн хүмүүст ус болон ариутгалтай холбоотой өвчин эмгэгээс өөрсдийгөө сэргийлж, гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хангалттай мэдлэг мэдээлэл, ойлголтыг өгсөн байх шаардлагатай.

Гамшгийн ихэнхи тохиолдолд ус зөөх үүрэг хариуцлага ихэнхидээ эмэгтэйчүүд, хүүхдүүдэд ноогддог. Тухайлбал дүрвэгсэд буюу нүүлгэн шилжүүлэх үед нийтийн усны болоод ариутгалын байгууламжыг ашиглах тохиолдолд эмэгтэйчүүд, өсвөр насны охидууд бэлгийн дарамт, шахалтад өртөх аюул их байдаг. Эдгээр сөрөг эрсдлийг бууруулж, илүү сайн үр дүнд хүрэхийн тулд эмэгтэйчүүдийг ус хангамж, ариутгалын хөтөлбөрүүдэд аль болох байнга түлхүү оролцуулах явдлыг хөхүүлэн дэмжих явдал маш чухал. Эмэгтэй хүмүүсийг төлөвлөгөө боловсруулах, шийдвэр гаргах болон удирдан зохион байгуулах бүхий л шатуудад эрэгтэй хүний адил хэмжээнд оролцуулсанаар гамшигт өртсөн нийт хүн ам аюулгүй усаар хангагдаж, ариутгалын үйлчилгээг найдвартай хүртэх боломж илүү бүрдэнэ.

Бусад бүлэгтэй холбогдох нь

Бусад бүлэгт тусгагдсан стандартуудын ихэнхи нь уг бүлэгтэй салшгүй холбоотой юм. Тухайн нэг салбар дахь стандартыг хангахад гарсан ахиц дэвшил нь бусад салбарын урагшилж сайжрах байдалд нь нөлөөлж байдаг. Илүү сайн үр дүнд хүрэхийн тулд бусад салбар чиглэлтэй нягт холбоотой уялдаж, хамтран ажиллах шаардлагатай. Орон нутгийн засаг захиргаа болон бусад холбогдох эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах явдал нь хэрэгцээ шаардлагыг хангаж, хүч бололцоо, нөөцийг зөв хуваарилахад чухал ач холбогдолтой.

Тухайлбал хүнс тэжээлд тавигдах шаардлагууд биелэгдээгүй тохиолдолд хүмүүсийн өвчин тусах эрсдэл багагүй өссөнөөр ус болон ариутгалтай холбоотой стандартыг сайжруулах шаардлага улам бүр нэмэгдэнэ. Энэ шаардлага мөн БЗХӨ/ДОХ –ийн тархалт хүн амын дунд өндөр байгаа эсвэл настай буюу тахир дутуу хүмүүсийн эзлэх хувь өндөр байгаа тохиолдлуудад мөн хамаарна.

Бүх салбар чиглэлд нийтлэг хамаарах стандартуудтай холбогдох нь.

Хөндлөнгийн оролцоог бий болгож хэрэгжүүлэх тэрхүү процесс нь өөрөө үйл ажиллагааг үр өгөөжтэй байх эсэхэд ихээхэн ач холбогдолтой. Энэ бүлгийг оролцоо, анхан шатны үнэлгээ, удирдах, хянах, үнэлж цэгнэх, тусламжийн ажилчдын ур чадвар ба үүрэг хариуцлага, удирдлага зохицуулалт болон боловсон хүчнийг дэмжих гээд (Хуудас 21-ийн бүлэг 1-ийг үзнэ үү) өргөн хүрээг хамарсан бүхий л салбар чиглэлд нийтлэг хамаарах стандартуудтай нягт уялдуулж авч үзэх ёстой. Ялангуяа доор дурдсан эмзэг бүлэг гэх мэт гамшигт өртсөн хүмүүсийн оролцоог дээд зэргээр ханган бүрдүүлж өгсөнөөр илүү үр дүнд хүрнэ.

Эмзэг байдал ба гамшигт өртсөн хүн амын чадавхи.

Онцгой байдлын үед хамгийн өндөр эрсдэлд байдаг хүмүүс бол эмэгтэйчүүд, хүүхдүүд, настай хүмүүс, тахир дутуу хүмүүс болон БЗХӨ/ДОХ-ын халдвартай хүмүүс байдаг. Зарим талаараа хүмүүс яс үндэс, шашин шүтлэг, улс төрийн бүлэглэлд элсэх буюу түүнээсээ гарах зэрэг шалтгааны улмаас мөн эмзэг бүлэгт орох тохиолдол байдаг.

Энэ бол эцсийн жагсаалт биш боловч хамгийн их элбэг тохиолддогуудыг нь багтаасан байгаа болно. Тодорхой нэг эмзэг байдал нь хүмүүсийн гамшгийн үед түүнийг хэрхэн давж гарч, амьдрах чадвар чадавхид нь нөлөөлж байдаг ба хамгийн их эрсдэлд байгаа хүмүүсийг тал бүрээс нь таньж тодорхойлох шаардлагатай.

Энэхүү гарын авлагад “эмзэг бүлгийнхэн” хэмээх утга нь тэдгээр бүх бүлэг хүмүүсийг илэрхийлж байгаа болно. Аль нэг бүлэг нь эрсдэлд өртөх тохиолдолд үлдсэн бусад бүлгүүд ч мөн аюулд өртөх магадлалтай байдаг. Иймийн тулд эмзэг бүлгийн тухай гарах тохиолдолд хэрэглэгчид энд заасан бүх бүлгийг заавал авч үзвэл зохилтой юм. Гамшигт өртсөн бүх бүлэг хүмүүсийг үл ялгаварлан гадуурхах зарчимд тулгуурлан, хэрэгцээ шаардлагад нь тохирсон тусламжийг үзүүлж, тэднийг өвчин эмгэгээс хамгаалах асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Гэхдээ гамшигт өртсөн хүн ам гамшгийг даван туулах өөрийн гэсэн тодорхой чадвар чадавхитай байдгийг мөн тэр чадвар чадавхийг нь хүлээн зөвшөөрч дэмжиж байх ёстой гэдгийг санах хэрэгтэй.

1 Эрүүл Ахуйг Таниулан Сурталчлах

Ус болон ариутгалын аливаа хөтөлбөрийн гол зорилго нь хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалахын тулд хувийн болон хүрээлэн буй орчинд эрүүл ахуйн шаардлагуудыг сайтар сахин мөрдүүлж, хэрэгжүүлэх явдал байдаг. Эрүүл ахуйг таниулан сурталчлах асуудлыг хүн амын мэдлэг, дадал, нөөц боломж болоод холбогдох агентлагуудын нөөц чадвар хоёрын хослол хэмээн энэ бүлэгт тодорхойлсон ба энэ хоёр нийлээд урьдчилан сэргийлэх буюу зайлсхийвэл зохих эрүүл ахуйн эрсдэлтэй нөхцөл байдлыг тодотгож өгч байгаа юм. Дараах гурван гол хүчин зүйл байна. Үүнд: 1/ Мэдлэг, мэдээллээ харилцан хуваалцах, 2/ Олон нийтийг татан оролцуулах, 3/ Зайлшгүй шаардлагатай материал хэрэгсэлээр хангах зэрэг болно. Эрүүл ахуйг үр дүнтэй таниулан сурталчлахын тулд гамшигт нэрвэгдсэн хүн ам болон холбогдох агентлагийн хооронд мэдээлэл солилцох ажлыг хэрэгжүүлэх хэрэгтэй ба ингэснээр эрүүл ахуйн асуудалд тулгамдсан бэрхшээлүүдийг тодорхойлохын зэрэгцээ байгаа нөөц боломжыг бүрэн дүүрэн ашиглаж, олон нийтийн эрүүл мэндэд дорвитой нөлөө үзүүлэх эрүүл ахуйн тийм дадлыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, хянах бололцоо бүрдэнэ. Хүмүүсийг идэвхигүй байдлаар зүгээр мэдээ тараахаас илүү өөрсдийн эрүүл мэнд, амь насаа хамгаалж, олгосон нөөц хэрэгслийг сайтар ашиглах байдлаар идэвхитэй оролцоог хөхүүлэн дэмжихэд анхаарах ёстой учраас олон нийтийг татан оролцуулах явдал гамшигийн үед маш чухлаар тавигдах ёстой хүчин зүйлийн нэг юм. Эрүүл ахуйг таниулан сурталчлах асуудлыг ямар ч тохиолдолд ариутгал болоод ус хангамжтай хольж хутгаж болохгүй бөгөөд энэ хоёр нь зөвхөн эрүүл ахуйг хангах үндэс суурь нь л болж өгдөг гэдгийг сайтар ойлгох хэрэгтэй.

Эрүүл ахуйг таниулан сурталчлах асуудал нь энэ бүлэг доторхи бүх стандартуудтай салшгүй холбоотой. Уг асуудал нь холбогдох заалтууд бүхий үндсэн чухал стандарт хэмээн энд тодорхойлогдсон болно. Бусад тодорхой заалтууд нь ус хангамж, ялгадасыг хаях, халдвар тээгчийг устгах, хатуу хаягдлын менежемент болон бохир шугамын стандарт бүр дээр өгөгдсөн болно.

Эрүүл ахуйг таниулан сурталчлах стандарт 1:

Хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

Гамшгийг даван туулахад зориулан өгсөн бүх нөөц хэрэгсэл нь түүнд өртсөн хүн амын эмзэг байдал, хэрэгцээ болон хүсч буй зүйлийн тусгал болж байдаг. Хэрэглэгчид эрүүл ахуйн менежмент болон хэрэгжүүлэлтэд шаардлагатай үед оролцох ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх эрүүл ахуйн гол эрсдлүүдийг тодорхойлсон байна (Заавар тэмдэглэл 1-ийг харна уу).
- Хөтөлбөр нь бүх хэрэглэгчийн байгууламжыг анх зохион бүтээх зэрэг ажилд татан оролцуулах үр дүнтэй механизмтай байх ёстой (Заавар тэмдэглэл 2,3,5-ийг харна уу)
- Хүн ам дахь бүх бүлгүүд эрүүл ахуйн дадлыг хангахад шаардлагатай нөөц хэрэгслийг тэгш байдлаар хүртэнэ (Заавар тэмдэглэл 3-ийг харна уу).
- Эрүүл ахуйг таниулан сурталчлах уриа, үйл ажиллагаа нь хүн амын шинж төлөв болон буруу ташаа ойлголттой холбоотой асуудлыг шийдэхэд чиглэгдэх ба нийгмийн бүх бүлгийг хамарна. Нийгмийн эдгээр бүлгийн төлөөлөгчид төлөвлөгө, сургалт, хэрэгжүүлэлт, хяналт ба үнэлгээ гээд бүхий л үйл явцад оролцоно (Заавар тэмдэглэл 1, 3, 4 мөн 28-р хуудсан дах Оролцооны стандартийг харна уу).
- Хэрэглэгчид байгууламжыг удирдах, ажиллуулах үүрэг хариуцлага хүлээх ба хоорондоо ялгаатай нийгмийн бүлгүүд шударгаар хувь нэмрээ оруулах ёстой (Заавар тэмдэглэл 1, 3, 4 мөн 28-р хуудсан дах Оролцооны стандартууд гэсэн хэсгийг харна уу).

Заавар тэмдэглэл

1. **Хэрэгцээг нь үнэлж тогтоох:** Үнэлж тогтоох ажил нь шийдэх ёстой эрүүл ахуйн гол гол асуудлууд мөн эрүүл ахуйг таниулан сурталчлах үйл ажиллагаа ямар амжилтад хүрч болохыг тогтооход ашиг тустай. Гол гол эрсдлүүдийн тоонд ялгадасыг хаях, бие засах газруудыг ашиглах ба ажиллуулах, гараа савангаар угаахгүй байх, усыг зүй бусаар зөөх, хадгалах мөн хүнсийг зүй бусаар хадгалах, бэлтгэх зэрэг багтаж байна. Үнэлж тогтоох үйл явц нь хүн амын гарын дор байгаа нөөц боломжоос гадна орон нутгийн нөхцөл байдал, мэдлэг чадвар буюу дадалд түлхүү анхаарах бөгөөд ингэснээр түүнээс гарах уриа нь нөхцөл байдалдаа яв цав тохирсон буюу бодитой болно.

Үүнээс гадна эмзэг бүлгийн хэрэгцээ шаардлагад онцгой анхаарал хандуулах ёстой. Нийгмийн аль нэг бүлэгтэй зөвлөлдөх боломжгүй байгаа бол үүнийг үнэлгээний тайланд заавал тодорхой тусгаж, богино хугацаанд шийдвэрлэвэл зохино (28-р Хуудсан дах Оролцооны стандарт болон Хавсралт 1 дэх үнэлгээний хуудсыг үзнэ үү).

2. **Үүрэг хариуцлагаа хамтран үүрэх:** Эрүүл ахуйг сахих үүрэг хариуцлага нь гамшигт өртсөн тухайн хүн амын гишүүн болгонд хамаатай. Гамшгийн эсрэг зогсож байгаа бүх хүмүүс мэдлэг болоод материаллаг нөөц боломжыг бүрдүүлэх замаар эрүүл ахуйг хангахын тулд хүчин чармайлт гарган ажиллах ёстойгоос гадна амжилттай болсоныг харуулах чадвартай байвал зохино. Энэ ажлын хүрээнд гамшигт өртсөн хүн амын эмзэг бүлгийнхэн эрсдэлтэй нөхцөл байдлыг тодорхойлоход оролцож, тэрхүү эрсдлүүдийг бодитойгоор бууруулахад тодорхой үүрэг хариуцлага үүрэх ёстой. Үүнийг танин сурталчлах үйл ажиллагаа, сургалт болон хэвшил дадлыг өөрчлөх замаар биелүүлж болно.
3. **Хүн амын бүх хэсэгт хүрч ажиллах:** Эрүүл ахуйг таниулан сурталчлах хөтөлбөрийг хүн амын бүх бүлэгтэй хамтран нийгмийн төрөл бүрийн төлөөлөлтэй ажиллаж чадвартай хүмүүс гардан хэрэгжүүлдэг (тухайлбал зарим соёл иргэншилд эмэгтэйчүүд үл таних эрэгтэй хүнтэй ярилцах нь зохисгүй байдаг). Баримт материалыг хүн амын бичиг үсэгт тайлагдаагүй хэсэгт хүрэхээр бэлдэж боловсруулах шаардлагатай. Тухайн соёл иргэншилд тохируулан сайтар боловсруулсан материал болон арга хэрэгсэл нь нийгмийн бүлгүүд өөрсдийнх нь талд гарч буй эрүүл ахуйн ахиц дэвшилээ төлөвлөж хянах ашигтай боломжыг бүрдүүлж өгдөг. Жишээлбэл бөөнөөр нь суурьшуулах лагерь байлаа гэхэд зорилтот хүн амын 1000 гишүүн бүрт тус бүх хоёр эрүүл ахуйн зааварлагч, олон нийтийг ухуулагч байх шаардлагатай. Эрүүл ахуйн төрөл зүйлийн талаарх мэдээллийг 232-р хуудсан дах Хүнсний бус зүйлийн стандарт 2-ийг үзнэ үү.
4. **Эрүүл ахуйн эн тэргүүний эрсдэл болон хэвшилд чиглэх:** Эрүүл ахуйг таниулан сурталчлах ба харилцан холбох стратегийн зорилтуудыг нарийн зөв тодорхойлж, ач холбогдолынх эрэмбээр ялгах хэрэгтэй. Эрүүл ахуйн эрсдэлийг үнэлэх замаар олж авсан мэдлэг ойлголт мөн нийгмийн янз бүрийн бүлэгийн зорилго ба үүрэг хариуцлага зэргийг шаардлагатай тусламж дэмжлэгийг төлөвлөж, ач холбогдолоор нь жагсаахад ашиглах хэрэгтэй ба ингэснээр хүн ам доторх буруу ташаа ойлголтыг (тухайлбал БЗХӨ/ДОХ хэрхэн халдварладаг тухай) өөрчлөн засахын хажуугаар хүмүүнлэгийн байгууллага болон гамшигт өртсөн хүн амын хоорондох мэдээллийн урсгал зөв гольдрилоор явна.

5. **Нөөц боломжыг зохицуулах:** Хэрвээ боломжтой бол хагас нь эмэгтэйчүүдийн төлөөлөл бүхий хэрэглэгчидийн янз бүрийн бүлэглэлээс бүрдсэн ус ба/буюу ариутгалын хороог

байгуулах нь үр дүнтэй байдаг. Эдгээр хороодын үүрэг нь усны цэг, нийтийн бие засах газар, угаалгын газар зэрэг нийтийн үйлчилгээний газруудыг зохицуулж эрүүл ахуйг таниулан сурталчлах үйл ажиллагаанд оролцож, тогтвортой байдлыг хангах механизмын үүргийг гүйцэтгэх явдал байдаг.

6. **Хэт ачаалал өгөх:** Эрүүл ахуйг таниулан сурталчлах үйл хэрэг болон нөөц хэрэгслийн менежментийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаар нь далайлган нийгмийн аль ч бүлэгт хэт ачаалал өгөхгүй байх явдал их чухал бөгөөд нийгмийн бүлэг болгоны үзүүлэх нөлөөлөл болон түүний хүртэх ашиг (сургалт гэх мэт) нь тэгш байх ёстой. Нийгмийн бүх бүлэг болон эмэгтэй эрэгтэй хүмүүс ижил хэрэгцээтэй байна гэж байхгүй ба эмэгтэйчүүдийн оролцоо нь үүрэг хариуцлага хүлээхгүйгээр эрэгтэйчүүд болон хүн ам доторхи бусад бүлэгийг үгүйсгэнэ гэсэн утга огт биш юм.

2. Усны хангамж

Ус бол амь амьдрал, эрүүл мэндэд чухал чандмань эрдэнэ мөн. Онцгой хүнд нөхцөлд, амьдралын наад захын шаардлагуудыг хангахад хүрэлцээтэй усгүй байх нөхцөл байж болох ба тийм тохиолдолд аюулгүй ундны усыг амь зогоох хэмжээнд хүргэх асуудал онц чухал асуудал юм. Ихэнхи тохиолдолд, эрүүл мэндтэй холбоотой бэрхшээлүүд нь ус

хүрэлцэхгүйгээс үүдсэн чанаргүй эрүүл ахуй мөн бохир ус хэрэглэснээс шалтгаалан үүсдэг.

Ус хангамжын стандарт 1: Хүрэлцээ ба усны хэмжээ.

Бүх хүн уух, хоол хийх болон хувийн ба гэр ахуй зэрэгтээ эрүүл ахуйдаа аюулгүй бөгөөд тэгш хүртээмжтэй усыг хэрэглэх эрхтэй. Нийтийн усны цэгүүдийг усанд тавигдах наад захын шаардлагыг хангах хэмжээнд айл өрхүүдэд аль болох ойр байх ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Нэг хүн өдөрт уух, хоол хийх болон хувийн буюу гэрийнхээ ариун цэвэр, эрүүл ахуйг сахих зэрэгт хамгийн багаар дунджаар 15 литр ус хэрэглэх ёстой (заавар тэмдэглэл 1-8 – ийг үзнэ үү).
- Айл өрхөөс хамгийн ойрын усны цэгт хүрэх зай хамгийн дээд тал нь 500 метр байна (заавар тэмдэглэл 1, 2, 5, 8 – ийг үзнэ үү).
- Ус түгээх газар буюу худагт дараалалд зогсох дээд хугацаа нь 15 минут байна (заавар тэмдэглэл 7 – ийг үзнэ үү).
- 20 литрийн усны савыг дүүргэхэд дээд тал нь гурван минут болох ёстой (заавар тэмдэглэл 7-8 – ийг үзнэ үү).
- Худгийг хангалттай хэмжээний устай байгаа тохиолдолд эсвэл байнгын ажиллагаатай ажилуулна (заавар тэмдэглэл 2 ба 8 – ийг үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **Хэрэгцээ:** Гэрийн хэрэгцээнд шаардлагатай усны хэмжээ нь уур амьсгал, ажиллаж байгаа ариутгалын байгууламж, хүмүүсийн өөрсдийнх нь энгийн хэв дадал, тэдний шашны болоод соёлын хандлага, хийж иддэг хоол хүнс, өмсөж байгаа хувцас гэх зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж янз бүр байдаг. Усны эх үүсвэр

буюу худаг амьдардаг газартай нь ойр байх тусам усны хэрэглээ нь ерөнхийдөө ихэсдэг.

Амьжиргааны наад захын усны хэрэгцээг хялбарчлан харуулсан хүснэгт		
Амьжиргааны хэрэгцээ: ус /уух ба хүнс/	Өдөрт 2.5-3 литр	Уур амьсгал болон хувь хүний биеийн онцлогоос хамаарна.
Эрүүл ахуйн үндсэн хэвшил	Өдөрт 2-6 литр	Нийгмийн болон соёлын хэв нормоос шалтгаална.
Хоол хийх үндсэн хэрэгцээ	Өдөрт 3-6 литр	Хүнсний төрөл, мөн нийгмийн ба соёлын хэв нормоос шалтгаална.
Усны нийт хэрэгцээ	Өдөрт 7.5-15 литр	

Байгууллагын болон бусад хэрэгцээнд шаардлагатай усны хамгийн баг хэмжээний тухай удирдамжыг Хавсралт 2-оос үзнэ үү.

2. **Усны эх үүсвэрийг хэрхэн сонгох:** Анхаарвал зохих хүчин зүйлүүд бол хангалттай усны хэмжээ байгаа эсэх мөн тэр нь хэр тогтвортой байх эсэх; усыг цэвэршүүлэх шаардлагатай эсэх, хэрвээ тийм бол үүнийг хийх боломжтой эсэх; усны эх үүсвэр гаргаж авахад шаардлагатай цаг хугацаа, техник технологи эсвэл санхүүжилт байгаа эсэх; гамшигт өртсөн хүн амд усны эх үүсвэр нь ойр байгаа эсэх; мөн усны эх үүсвэртэй холбоотой нийгэм, улстөр болон хууль эрхзүйн хүчин зүйлүүд байгаа эсэх тухай асуудлууд юм. Ерөнхийдөө газар доорхи усны эх үүсвэр нь түүнийг цэвэршүүлэхэд бага зардал гардагаас гадна ялангуяа инерцийн хуулиар урсдаг учраас ямар нэг насос шаардлагагүй байдаг зэрэг чанартай учраас усны энэ эх үүсвэрийг илүүд авч үзвэл зохино. Гамшгийн эхний үед түүнийг давах арга техник болон нөөц боломж хоёрыг хослуулах шаардлагатай байдаг. Бүх нөөц боломжыг хэтрүүлэн хэрэглэхээс сэргийлэхийн тулд байнга хянаж шалгаж байх хэрэгтэй.
3. **Хэмжих:** Зөвхөн шүүлтүүрийн систем руу шахсан усны эзлэхүүн эсвэл гар насосын асаалттай байсан хугацааг хэмжиснээр усны хэрэглээг нарийн зөв тогтоож чадахгүй юм. Усны хэрэглээний талаар үнэн зөв мэдээ баримт цуглуулах хамгийн үр дүнтэй арга бол айл өрхөд судалгаа ажиглалт явуулж, олон нийтийн зөвлөлдөх бүлгүүдийг ажиллуулах явдал байдаг.

4. **Чанар ба хэмжээ:** Ихэнхи онцгой нөхцөл байдлын үед устай холбоотой өвчин эмгэг дамжих нөхцөл нь хувийн болон гэрийн ариун цэвэр, эрүүл ахуйг хангахад ус хүрэлцэхгүй байх мөн бохирдсон усаар хангах зэрэг хүчин зүйлээс үүдэн гардаг байна. Тоо хэмжээ болон чанарын наад захын шаардлага хангагдах хүртэл чанарын наад захын шаардлагыг хангасан усыг хүрэлцээгүй хэмжээгээр өгснөөс дунд зэргийн чанартай байлаа ч хүрэлцээтэй хэмжээний усыг тэгш байдлаар түгээх явдлыг эн тэргүүнд тавивал зохино. БЗХӨ/ДОХ-той хүмүүс унд болон хувийн ариун цэвэртээ бусдаас илүү их ус хэрэглэх шаардлагатай байдаг

гэдгийг анхаарах хэрэгтэй. Хүмүүсийн амь амьжиргаа мал аж ахуй болон газар тариалангаас хамаардаг бол ган болж байгаа нөхцөлд мал болон үр тарианд хэрэглэж байгаа усанд тавигдах шаардлагыг хангахад онцгой анхаарал тавих нь зүйтэй /Хавсралт 2-ыг үзнэ үү/.

5. **Хамрах хүрээ:** Гамшгийн эсрэг ажиллагааны эхний шатанд түүнд өртсөн нийт хүн амын нэн түрүүнд шаардлагатай хэрэгцээг хангах нь эн түрүүнд тавигдах ёстой юм. Гамшигт өртсөн хүмүүс өвчин эмгэгт илүү их өртөмтгий болсон байдаг учраас үзүүлэлтүүд гамшигт өртсөн эсвэл уугуул хүн амын хэвийн нормоос давсан байлаа ч тэдгээр үзүүлэлтүүдийг зайлшгүй биелүүлэх хэрэгтэй. Ийм тохиолдолд холбогдох агентлагууд уугуул хүн амын ус болон ариутгалын байгууламжуудын түвшинг сайжруулж, өдөөн хатгасан байдлаас зайлсхийхийн тулд тусгай хөтөлбөр боловсруулах нь зүйтэй.
6. **Усны нэг эх үүсвэрт ногдох хүний дээд тоо:** Усны нэг эх үүсвэрт ногдох хүний тоо хэд байх нь эх үүсвэр тус бүр дэх усны гарцаас хамаарна. Тухайлбал, цорго нь зөвхөн өдрийн тодорхой цагуудад голдуу ажилладаг ба гар насос болон худгууд цэнэг муу авч байгаа бол усны гарц нь тоштомол байж чадахгүй. Хар тооцоогоор бол:

250 хүн тутамд нэг цорго	Минутагд 7.5 литр гоожих тохиолдолд
500 хүн тутамд нэг гар насос	Минутагд 16.6 литр гоожих тохиолдолд
400 хүн тутамд нэг ил худаг	Минутагд 12.5 литр урсах тохиолдолд

Дээрх хар тооцооны дагуу бол усны цэг өдрийн зөвхөн найман цаг л ажилладаг байна. Хэрвээ үүнээс олон цаг ажиллавал хүмүүс хамгийн наад захын шаардлага болох 15 литрээс илүү усыг авч чадна. Эдгээр зорилтыг маш болгомжтой ашиглах ёстой учир нь түүнд хүрсэнээр хамгийн бага усны хэмжээ эсвэл тэгш хэрэглээг найдвартай хангана гэсэн баталгаа байхгүй юм.

7. **Дараалалд зогсох хугацаа:** Усны дараалалд хэт удаан зогсох нь усны хангамж хүрэлцээ муу байгаагийг тод илрэл юм (Усны цэг хүрэлцээгүй эсвэл усны цэгийн гарц муу). Усны дараалалд хэт удаан зогсохоос үүдэн гарч болох сөрөг үр дагаваруудыг дурдвал 1/ Нэг хүн тутамд ногдох усны хэрэглээ багасна 2/ Газрын гадарга дээрхи найдваргүй ил эх үүсвэрээс ус хэрэглэх явдал ихэснэ 3/ Хүмүүс амьдралын бусад чухал зүйлдээ зарцуулах цаг нь багасах зэрэг болно.

8. *Ус авах боломж ба тэгш байдал:* Амьдралын наад захын шаардлагыг хангахад хүрэлцэхүйц ус байлаа ч ус хэрэглэх боломж нийгмийн бүхий л бүлэгт тэгш байх нөхцлийг хангахын тулд нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай байж болно. Усны цэгүүдийг хүйс, яс угсаа зэргээс үл хамааран бүгдэд боломжтой газар байрлуулах ёстой. Шинэ төрлийн гар насос болон ус зөөх савуудыг зохион бүтээх эсвэл БЗХӨ/ДОХ-той хүмүүс, настай бөгөөд тахир дутуу хүмүүс, хүүхэд багачуудад хэрэглэхэд тохируулан өөрчлөх шаардлагатай байж болно. Хот суурин газрын нөхцөлд усыг байшин тус бүрт нь өгөх замаар бие засах өрөөг тасралтгүй ажиллуулж байх нөхцлийг хангах шаардлагатай байж болно. Усыг тодорхой тогтоосон цагт хуваарилж шахах тохиолдолд үүнийг хэрэглэгч нартай зөвлөлдсөний үндсэн дээр төлөвлөх хэрэгтэй. Ус түгээх цагийг ус авах үүргийг гүйцэтгэдэг эмэгтэйчүүд болон бусад хүмүүст тохиромжтой бөгөөд аюулгүй цагт тогтоох хэрэгтэй бөгөөд хэрэглэгчдэд усаа хэзээ хаанаас авч болох тухай бүрэн мэдээллийг өгсөн байх ёстой.

Ус хангамжид тавигдах шаардлага 2: Усны чанар

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Ариутгалын шинжилгээгээр ялгадасны нянгийн түвшин бага гарч байх (заавар тэмдэглэл 1-ийг үзнэ үү).
- Ус хүргэх цэг дээр 100 мл тутамд ямар ч ялгадасны нян байхгүй ёсгүй (заавар тэмдэглэл 2-ийг үзнэ үү).

- Хүмүүс бэлэн байгаа усны бусад эх үүсвэрээс ус уухаасаа илүү цэвэршүүлсэн аюулгүй эх үүсвэрээс усаа хэрэглэх (заавар тэмдэглэл 3-ийг үзнэ үү).
- Усыг түгээснээс хойшхи бохирдолтыг багасгах арга хэмжээг авсан байна (заавар тэмдэглэл 4-ийг үзнэ үү).
- Усыг тусгай шугам хоолойгоор түгээж байгаа тохиолдолд эсвэл ус хангамж аюулд өртсөн эсвэл суулгах буюу гүйлгэх өвчний аюул нүүрлэсэн тохиолдолд усыг тусгай ариутгалын бодисоор ариутган цэвэршүүлэх замаар гоожуурын № литр усанд 0.5 мг ихгүй хлорын үлдэгдэлтэй байх ба усны булингар 5NTU нэгжээсбайга байх ёстой (заавар тэмдэглэл 5, 7, 8 -ийг үзнэ үү).

- Химийн болон цацраг идэвхит бодисоор бохирдсон усыг богинохон хугацаанд хэрэглэсэн боловч эрүүл мэндэд ямар нэг сөрөг нөлөөлөл илрээгүй мөн шинжилгээгээр цаашид сөрөг нөлөө үүсэх магадлал байхгүй байгаа (заавар тэмдэглэл 6-ийг үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **Ариутгалын шинжилгээ** нь хүн амын эрүүл мэндэд эрсдэл учруулж болох нөхцөл байдал, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхийг хэлнэ. Уг шинжилгээ нь усыг бохирдуулж болох эх үүсвэрийг усных нь эх үүсвэр дээр, тээвэрлэх үед нь мөн гэрт нь шинжлэхээс гадна бохир ус болон хатуу хог хог хаягдалын менежмент зэрэг мөн үүнд хамаарна. Ялангуяа хүн амыг mapping нь чухам хаана эрүүл мэндийн эрсдэл байгааг тогтоож, тэдгээр эрсдлийг бууруулах арга замыг олоход олон нийтийг татан оролцуулах үр дүнтэй аргын нэг юм. Хэдийгээр амьтан малын ялгадас хүнийх шиг хортой биш байж болох боловч мал амьтаны ялгадас нь бүдүүн гэдэсний спор үүсгэгч нян, гиарди, салмонелл, кампило бактери, калиси вирус зэрэг хүний суулгах буюу гүйлгэх бусад түгээмэл шалтгааныг агуулж байж болох тул эрүүл мэндэд багагүй сөрөг нөлөө үзүүлж болох талтай.
2. **Усны микробиологийн чанар:** ялгадасны нян нь (түүний 99 хувь нь *E. coli* байдаг) хүн ба мал амьтаны ялгадасаас үүссэн усан дах бохирдолын хэмжээ болоод хортой эмгэг үүсгэгчүүд байж болохыг боломжыг харуулах үзүүлэлт юм. Хэрвээ усанд ямар нэг ялгадасны нян агуулагдаж байгаа тохиолдолд усыг ариутгаж цэвэршүүлэх хэрэгтэй. Гэхдээ аливаа гамшигт нөхцөл байдал үүссэн эхний үед чанараас илүү тоо хэмжээ илүү чухал байдаг (Усанд тавигдах шаардлага 1-ийн заавар тэмдэглэл 4-ийг үзнэ үү).
3. **Усны эх үүсвэр аюулгүй байхын ач холбогдлыг сурталчилан таниулах:** Хүмүүс ариутгаж цэвэршүүлсэн усны эрүүлмэндэд хамаатай ач холбогдол буюу үр ашгийг бүрэн ухан таниж, түүнийг хэрэглээгүй цагт зөвхөн усны аюулгүй эх үүсвэр буюу ариутгасан усаар хүмүүсийг хангаснаар сайн үр дүнд хүрнэ гэвэл эндүүрэл болно. Хүмүүс усыг амт, амьдардаг газартай нь ойр байх мөн нийгмийн ая тух зэрэг шалтгааны улмаас гол мөрөн, ариутгаагүй худаг гэх мэт усны эсрдэлтэй эх үүсвэрээс усаа хэрэглэхийг илүүд үзэж болох юм.

Ийм тохиолдолд инженер техникийн ажилтнууд, эрүүл ахуйн ухуулагч болон олон нийтийг ухуулагч нар хүмүүсийн энэ хүслийн талаар ойлгох хэрэгтэй ба ингэснээр таниулан сурталчлах уриа, хэлэлцүүлэгт оруулах боломж бүрдэнэ.

4. **Усыг түгээсний дараа тохиолдох бохирдол:** Түгээх үед аюулгүй байсан ус нь авах, хадгалах болон гоожуулах үед дахин бохирдсоны улмаас эрүүл мэндэд ноцтой аюул эрсдэл учруулж болно. Ийм төрлийн аюул эрсдэлийг бууруулахын тулд авч хэрэгжүүлж болох арга хэмжээний тоонд усыг авах болон хадгалах хэвшилийг сайжруулах, ус зөөх болон хадгалахад тохирсон цэвэр савыг (Усанд тавигдах шаардлага 3-ийг үзнэ үү) нийлүүлэх, тусгай ариутгагч бодисоор ариутгаж цэвэршүүлэх эсвэл хэрэглээнийх нь шатанд ариутгаж цэвэрлэх зэрэг арга хэмжээ

багтана. Усны дээжийг тогтсон тогтмол хугацаанд хэрэглээнийх нь шатанд байнга авч, түгээсний дараа ямар нэг бохирдол байгаа эсэхийг шалгаж нягталж байх шаардлагатай.

5. **Усыг халдваргүйжүүлэх:** Хэрвээ усны эх үүсвэрт эрүүл мэндэд хортой эрсдэл эсвэл түгээсний дараа бохирдол үүссэн бол усыг хлоринамин гэх мэт ариутгагч бодисоор ариутгаж цэвэршүүлж байх ёстой. Уг эрсдэлийг хүн амын нягтаршил, ялгадасыг хаях зохицуулалт, эрүүл ахуйн хэвшил болон суулгах өвчний тархалт гэх мэт нийгэм дэх нөхцөл байдлаар тодорхойлно. Эрсдэлийг үнэлэх ажилд хүн амын амтны талаарх ухамсар гэх мэт хүчин зүйлтэй холбоотой хүн амын талаарх чанартай мэдээлэл мөн багтаж байх ёстой (заавар тэмдэглэл 6-ийг үзнэ үү). Их хэмжээний буюу төвлөрсөн хүн амыг шугам хоолой ашиглан усаар хангахдаа усыг ариутгагч бодисоор цэвэршүүлж байх ёстой бөгөөд суулгах өвчний бодит эрсдэл бий болсон эсвэл тийм нөхцөл байдал хэдийнэ үүссэн тохиолдолд ундны бүх усыг айл өрхөд хүрэхээс нь өмнө ариутган цэвэршүүлж байх шаардлагатай. Усыг зохих ёсны дагуу халдваргүйжүүлэхийн тулд булингарын хэмжээ 5 NTU нэгжээс доогуур байх шаардлагатай.
6. **Химийн ба цацраг идэвхийн бохирдол:** Гидрогеологийн бичлэг эсвэл аж үйлдвэр эсвэл цэргийн үйл ажиллагааны тухай мэдлэгийн дагуу ус хангамж нь химийн болон цацраг идэвхийн хувьд эрүүл мэндэд аюул дагуулж байж болох тохиолдолд даруй химийн дүн шинжилгээ хийж тэрхүү эрсдэлийг судалж тогтоох хэрэгтэй. Дараа нь хүн амын эрүүл мэндийн богино хугацааны эрсдэл болон үр ашгийг тэнцвэржүүлэх шийдвэрийг гаргах нь зүйтэй. Хордсон байж болох усыг арай удаан хугацаагаар хэрэглэх тухай шийдвэрийг илүү нарийн мэргэжлийн судалгаа шинжилгээнд тулгуурлан гаргах ёстой.
7. **Амт чанар:** Хэдийгээр амт нь өөрөө чухам шууд эрүүл мэндийн асуудал биш боловч (нэлээд хужирхаг ус гэх мэт) хэрвээ аюулгүй гэсэн ус нь амт муутай бол хэрэглэгчид найдваргүй эх үүсвэрээс ус ууж, эрүүл мэндээ эрсдэлд учруулж магадгүй юм. Үүнээс гадна хлораминжуулсан ус түгээхэд мөн эрсдэл үүсч болох бөгөөд энэ тохиолдолд таниулан сурталчлах ажлыг хэрэгжүүлэх хэрэгтэй.

68

8. **Эрүүлмэндийн төвүүдийн усны чанар:** Эмнэлэгийн газар, эрүүл мэндийн төвүүд мөн хоолны газруудад хэрэглэж буй бүх усыг хлорамин буюу бусад ариутгалын бодисоор халдваргүйжүүлж, цэвэршүүлж байх ёстой. Ялангуяа ус тасарсан тохиолдолд эрүүл мэндийн төвүүдэд ус нөөцлөх савтай байж, наад захын хэрэглээг тасралтгүй хангаж байх ёстой (Хавсралт 2-ийг үзнэ үү).

Усанд тавигдах шаардлага 3: Ус ашиглалтын хэрэгсэл

Хүмүүс өөрийн унд уух, хоол хийх болон хувийн ариун цэврээ сахихад хүрэлцэхүйц хэмжээний усыг авч, нөөцөлж ашиглахын тулд мөн ундны ус нь хэрэглэж дуусах хүртэл бохирдохгүй аюулгүй байлгахын тулд хангалттай сав, тоног төхөөрөмжтэй байх ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Айл өрх болгон 10-20 литрийн багтаамж бүхий цэвэр ус зөөх сав дор хаяж 2, дээрээс нь гэрээ байнга устай байлгах цэвэр ус хадгалах сав тай байх ёстой (заавар тэмдэглэл 1-ийг үзнэ үү).
- Ус зөөх болон хадгалах савнууд нь нарийхан ам ба/буюу таг эсвэл усыг хадгалах, гоожуулах зэрэг бусад аюулгүй байдлыг хангасан байх ёстой (заавар тэмдэглэл 1-ийг үзнэ үү).
- Нэг хүн нэг сард өөрийн хувийн ариун цэвэртээ зориулж доор хаяж 250 граммын гар нүүрийн саван хэрэглэх ёстой.
- Нийтийн усанд орох газар шаардлагатай бол эмэгтэй, эрэгтэйчүүд нь тусдаа ордог хүрэлцэхүйц тооны тасалгаатай байх ёстойгоос гадна тэдгээр тасалгаануудыг зохих ёстоор нь тэгш байдлаар ашиглаж байх ёстой (заавар тэмдэглэл 2-ийг үзнэ үү).
- Нийтийн угаалгын газар шаардлагатай бол 100 хүн тутамд угаалгын нэг сав заавал байх ёстойгоос гадна эмэгтэйчүүдэд дотуур хувцсаа угаахад нь зориулж тусгай тасалгаа гаргаж өгөх ёстой.
- Эмзэг бүлгийн бүх хүмүүсийг усанд орох газрыг барьж байгуулахад мөн саван үйлдвэрлэж тараах ажилд оролцуулах явдлыг хөхүүлэн дэмжвэл зохино Нийтийн усанд орох газар шаардлагатай бол эмэгтэй, эрэгтэйчүүд нь тусдаа ордог хүрэлцэхүйц тооны угаалгын тасалгаатай байх ёстойгоос гадна тэдгээр тасалгаануудыг зохих ёстоор нь тэгш байдлаар ашиглаж байх ёстой (заавар тэмдэглэл 2-ийг үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **Ус зөөх ба хадгалах:** Хүмүүст усаа зөөж, нөөцлөн хадгалж, юмаа угааж, хоолоо хийж мөн усанд орохын тулд сав суулга зайлшгүй хэрэгтэй байдаг. Тэр сав суулгууд нь цэвэрхэн, бохир биш, зөөхөд хялбар байх ёстойгоос гадна хэмжээ дамжаа, хэлбэр дүрс, загвар хийцийн хувьд тухайн амьдарч буй орчных нь хэрэгцээ шаардлага болон амьдралын хэв маягт нь тохирсон байх шаардлагатай. Хүүхдүүд, өндөр настай, тахир дутуу хүмүүс мөн БЗХӨ/ДОХ-той хүмүүст жижиг авсаархан буюу ус зөөхөд тусгайлан зохион бүтээсэн сав суулга хэрэгтэй нь гарцаагүй. Савны багтаамж нь тухайн айл өрхийн гишүүдийн тоо болон усны хангамж тогтмол эсэхээс хамаарах бөгөөд усаа өдөр болгон аваад зөөгөөд байж болох тийм нөхцөлд нэг хүнд ойролцоогоор 4 литр байхад хангалттай.
2. **Олон нийтийн угаалгын болон усанд орох газар:** Хүмүүст бусдын нүднээс далд чөлөөтэй усанд орох тийм газар хэрэгтэй байж болно. Хэрвээ энэ хүсэл нь гэр дотор нь боломжгүй тохиолдолд нийтийн зориулалттай усанд орох газар хэрэг болно. Саван байхгүй эсвэл байнга хэрэглэдэг бол үнс, цэвэр элс, давс эсвэл бие угаах ба/буюу үрэхэд тохиромжтой төрөл бүрийн ургамалаар

орлуулж болдог. Хувцсаа угаах бол ялангуяа хүүхэд багачуудын хувьд эрүүл ахуй, ариун цэврийн зайлшгүй байх ёстой дадал бөгөөд хоол бэлдэж, иддэг сав суулгыг мөн угааж байх хэрэгтэй. Усанд орох болон угаалгын газрын тоо, байрлал, загвар, аюулгүй байдал, тав тухтай байдал зэргийг шийдэхээсээ өмнө хэрэглэгчид, ялангуяа эмэгтэйчүүд, насанд хүрээгүй өсвөр насны охид болон тахир дутуу хүмүүстэй нэг бүрчлэн зөвлөн ярилцаж, санал бодлыг нь сонсох шаардлагатай. Усанд орох болон угаалгын газруудыг төв болоод ойрхон газарт байрлуулах нь хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангахад чухал нөлөөтэй.

3 Ялгадасыг хаях

Хүнээс гарах ялгадасыг зохих ёсоор хаяж аюулгүй болгох нь ялгадаснаас үүсэх өвчинөөс сэргийлэх анхны алхам бөгөөд ингэснээр шууд болон шууд бус замаар халдварлах эрсдэлийг бууруулхад тустай юм. Тийм учраас ялгадасыг хаяж аюулгүй болгох явдал нь нэн тэргүүнд тавигдах чухал асуудал бөгөөд гамшигийн ихэнхи тохиолдолд уг эрсдэлийг цэвэр аюулгүй усаар хангах асуудлын адил богино хугацаанд хүчин чармайлт гаргаж шийдвэрлэх ёстой юм. Бие засах тохиромжтой газруудыг байгуулах нь гамшигийн үед хүмүүсийн тав тух, аюулгүй байдал, эрүүл мэндэд зайлшгүй шаардлагатай олон олон хүчин зүйлийн нэг нь юм.

Ялгадасыг хаяж аюулгүй болгоход тавигдах шаардлага 1: Бие засах газрын хэрэглээ ба тоо.

Хүмүүс өөрсдийн оршин суудаг газарт нь ойрхон, хүрэлцэхүйц тооны бие засах газартай байх ёстой ба ингэснээр тэд өдөр шөнийн аль ч цагт бие засах газарт хурдан бөгөөд аюулгүй хүрэх боломжтой болох ёстой юм.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Нэг жорлонг дээд тал нь 20 хүн ашиглах ёстой (заавар тэмдэглэл 1-4 - ийг үзнэ үү).
- Бие засах газрын хэрэглээг өрх бүлээр нь зохицуулах ба/буюу хүйсээр нь салгаж тусгаарлах ёстой (заавар тэмдэглэл 3-5-ийг үзнэ үү).
- Олон нийтийн газруудад эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдэд зориулсан салангид бие засах газартай байх ёстой (зах, худалдааны төв, эрүүлмэндийн төв гэх мэт) (заавар тэмдэглэл 3-ийг үзнэ үү).
- Нийтийн зориулалттай бие засах газрыг зориулагдсан бүх хэрэглэгчид ашиглахаар цэвэрлэж ажиллуулж байх ёстой (заавар тэмдэглэл 3-5-ийг үзнэ үү).
- Бие засах газрыг оршин суух байшин барилгаас дор хаяж 50 метрийн цаана барих ёстой (заавар тэмдэглэл 5-ийг үзнэ үү).
- Бие засах газрыг эрүүл ахуйн дээд хэмжээнд ашиглахаас гаднаа хүүхдийн ялгадасыг тэр дор нь хаяж, аюулгүй болгох ёстой (заавар тэмдэглэл 6-ийг үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **Ялгадасыг аюулгүй болгож хаях:** Ялгадасыг аюулгүй болгож хаях тухай хөтөлбөрийн зорилго нь хүрээлэн буй орчинг хүний ялгадасаас үүдсэн бохирдолоос ангид байлгах явдал юм. Гамшигт өртсөн хүн ам доторх аль болох их бүлэг оролцох тусам уг хөтөлбөр тэр хэмжээгээр амжилттай болно. Хүн ам нь өмнө нь бие засах газрыг огт ашиглаж байгаагүй нөхцөлд бие засах газрыг ашиглахын ач холбогдолыг таниулсан ухуулга/сургалтын ажлыг явуулж, илүү олон тооны бие засах газрыг барьж байгуулах хэрэгцээ шаардлагыг бий болгох нь чухал юм. Гамшигын улмаас бохирын шугам хоолой нь гэмтсэн тохиолдолд шугам хоолойн гэмтээгүй ажиллаж байгаа тэр хэсгийг нь тусгаарлаж (шугам хоолойн чиглэл буюу урсгалыг өөрчилж), зөөврийн бие засах газрыг байрлуулж, байнга цэвэрлэж болох газар доорх бохирын бак болон нөөцлөх бакуудыг ашиглах гэх мэт байдлаар асуудлыг шийдвэрлэж болох юм.

2. **Бие засах ил талбай:** Аливаа гамшгийн эхний үед зориулалтын бие засах байр барихаас өмнө бие засах ил талбай эсвэл бие засах шуудуу болгон ашиглах газрыг тусгайлан тэмдэглэж ашиглах шаардлагатай. Ингэхдээ тэдгээр ил бие засах газруудыг зөв зохион байгуулж, зохицуулах хэрэгтэй.
3. **Нийтийн бие засах газар:** Аливаа гамшиг тохиолдсон эхний үед нийтийн зориулалттай бие засах газруудыг барьж байгуулах шаардлагатай нийтийн эзэмшлийн газруудад тэдгээрийг байнгын цэвэрлэж зөв зохистой ажиллуулах тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй. Хүн амын холбогдох тоо баримтыг ашиглан бие засах газарт ногдох эмэгтэй эрэгтэй хүмүүсийн харьцааг төлөвлөж гаргах шаардлагатай (ойролцоогоор 3:1). Хэрвээ боломжтой бол эрэгтэйчүүдэд зориулан босоо хэлбэрийн жорлонг би болговол зохино (Хавсралт 3-ийг үзнэ үү).
4. **Нийтийн бие засах газар:** нүүлгэн шилжүүлсэн хүн амын хувьд ямар нэг бэлэн баригдсан бие засах газар байхгүй бол 20 хүн бүрт зориулж нэг бие засах газрыг богино хугацаанд барьж байгуулах боломж тэр бүр байдаггүй. Ийм тохиолдолд эхний ээлжинд 50 хүний дунд нэг бие засах газар барьж, дараа нь 20 хүнд нэг ногдон хүртэл нь аль болох хурдан нэмж барих шаардлагатай. Аливаа нийтийн зориулалттай бие засах газар нь байнгын цэвэр байлгаж, зөв зохистой ашиглах тогтсон ажиллагаатай байх ёстой. Зарим тохиолдолд зайг багасгаж хэмнэх замаар хорин хүнд нэг бие засах газар ногдох шаардлагыг хангаж болох юм. Энэ тохиолдолд хамгийн гол анхаарах ёстой зүйл бол хүний ялгадасаас ангид орчин бүрдсэн байх ёстойг мардаж болохгүй.
5. **Дундаа хэрэглэдэг газар:** Дөрөв буюу таван өрх айл дундаа нэг жорлон хувааж хэрэглэж байгаа тохиолдолд арчилж, цэвэрлэх үүрэг хариуцлагаа хамтдаа үүрдэг учраас ихэнхдээ цэвэрхэн байдаг.

72

Дундаа хэрэглэх жорлонг чухам хэн хэн ашиглах мөн цэвэрлэгээ арчилгаагаа хэрхэн зохицуулах тухай шийдэхийн тулд зорилтот хэрэглэгчидтэй хамтран ажиллах нь чухал. БЗХӨ/ХДХВ-ийн халдвар авсасн хүмүүс эмгэг суулгалт болон хөдөлгөөний дутагдлаас байнга шаналж байдаг учраас жорлонг тэдэнд эвтэй тухтай байдлаар зохицуулахад анхаарах хэрэгтэй.

6. **Хүүхдийн ялгадас:** Хүүхдийн дунд ялгадастай холбоотой халдвар харьцангуй өндөр байдгаас гадна хүүхдэд эсрэг бие бага байдаг учраас хүүхдийн ялгадас нь том хүмүүсийнхээс илүү хортой аюултай байдаг тул үүнд онцгой анхаарах хандуулах шаардлагатай. Эцэг эхчүүд болон асрагчдыг татан оролцуулах хэрэгтэй. Үүнээс гадна эцэг эх болон асрагч нарт нялх хүүхдийн ялгадсыг хэрхэн зөв арилгаж хаях, мөн өлгий манцуйг нь хэрхэн угааж цэвэрлэх тухай зөвлөгөөг өгвөл зохилтой.

Ялгадасыг аюулгүй болгож хаяхад тавигдах шаардлага 2: Бие засах газрыг зохион бүтээх, барьж байгуулах ба ашиглах

Бие засах газрыг аль болох тав тухтай, эрүүл ахуйг хангасан, хялбар, ашиглахад аюулгүй байхаар зохион бүтээж, барьж байгуулж, ажиллуулах ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Бие засах газрын байрлал болоод хийц загварын талаар хэрэглэгчидтэй /ялангуяа эмэгтэйчүүдтэй/ зөвлөлдөж батлана (заавар тэмдэглэл 1-3-ийг үзнэ үү)
- Бие засах газрыг зохион бүтээж, барвж байгуулж, байрлуулахдаа дараах шаардлагуудыг хангасан байвал зохино. Үүнд:
 - Хүүхэд багачууд, настай хүмүүс, жирэмсэн эхчүүд, тахир дутуу болоод оюунй хомсдолтой хүмүүс гэх мэт хүн амын бүхий л хэсэг хэрэглэж болохоор хийх ёстой (заавар тэмдэглэл 1-3-ийг үзнэ үү).
 - Өдөр шөнийн аль ч цагт хэрэглэгчидэд ялангуяа эмэгтэйчүүд болон охид айх аюулгүй тайван байхаар байрлуулах ёстой (заавар тэмдэглэл 2-ийг үзнэ үү).

73

- Цэвэрлэхэд хавьгүй хялбар бөгөөд эрүүл мэндийн хувьд сөрөг нөлөөгүй байх ёстой.
- Хэрэглэгчид бусдын нүднээс далд тайван бие засах нөхцлөөр хангагдсан байх ёстой.
- Бие засах газар нь эмэгтэйчүүд ариун цэврийн хэрэгслээ хаяхад эсвэл ариун цэврийн зориулалттай хувцсаа угааж хатаах зориулалтын тоноглолтой байх ёстой (заавар тэмдэглэл 4-ийг үзнэ үү)
- Ялаа шумуул үржихээс хамгаалагдсан байх ёстой (заавар тэмдэглэл 7-ийг үзнэ үү)
- Усыг ялгадсаа урсгах зориулалтаар ашигладаг бүх жорлонг усаар тасралтгүй байнга хангаж байх ёстой (заавар тэмдэглэл 1 ба 3-ийг үзнэ үү)
- Нүхэн болон хөрс руу сорогддог бие засах газрууд нь газар доорх гүний усны эх үүсвэрээс наад зах нь 30 метрийн зайтай байх ёстой ба ёроол нь усны түвшингээс дээш дор хаяж 1,5 метр дээш байх ёстой. Ил бие засах газрын бохир нь гадаргын усны ундаргын чиглэлд урсах ёсгүй мөн газар доорхи усны ундаргат юүлэгдэж орох ёсгүй. (заавар тэмдэглэл 5-ийг үзнэ үү)
- Бие зассаныхаа дараа хоол идэх буюу бэлдэхээсээ өмнө хүмүүс заавал гараа угааж байх ёстой (заавар тэмдэглэл 6-ийг үзнэ үү)
- Хэрвээ боломжтой бол хүмүүс өөрсдийн жорлонгоо өөрсдөө барьж, арчилж цэвэрлэх тусгай багаж материалаар хангагдсан байвал зохистой (заавар тэмдэглэл 7-ийг үзнэ үү)

Заавар тэмдэглэл

1. *Хэрэглэх боломжтой бие засах газрууд* Ялгадсыг хаяж аюулгүй болгоход чиглэгдсэн хөтөлбөрийн амжилттай болох эсэх нь хүмүүсийн өөр хоорондоо ялгаатай хэрэгцээний тухай ойлголт мөн

хэрэглэгчдийн оролцооноос ихээхэн шалтгаална. Бүх бие засах газрыг хүн амын бүх бүлэг хэрэглэх боломжтой болгох боломжгүй бол хүүхдүүд, настай хүмүүс, тахир дутуу хүмүүст зориулсан нам суудал, бариул бүхий тусгай бие засах газар байгуулах шаардлага гарч болно. Барьсан бие засах газрын төрөл нь зорилтот хэрэглэгч нарын сонирхол болон соёлын хэвшил, бэлэн байгаа дэд бүтэц, байнгын ус хангамж (зайлах болон бөглөө зэрэгт), хөрсний нөхцөл, мөн барилгын материалын бэлэн байдал зэргээс шалтгаална.

2. **Аюулгүйн нөхцөл:** Бие засах газрыг буруу зохисгүй байрлуулснаар эмэгтэйчүүд, охидууд ялангуяа шөнийн цагт халдлагад өртөх аюул ихэсдэг ба эмэгтэйчүүд бие засах газрыг ашиглах нь аюулгүй байх нөхцлийг бүрдүүлэх арга замыг олж хайх хэрэгтэй. Хэрвээ боломжтой бол нийтийн зориулалттай бие засах газруудыг гэрэлтүүлгээр хангаж айл өрхийг гар чийдэнгээр хангах шаардлагатай.
3. **Бөгсөө цэвэрлэх:** Усыг ашигладаг хүмүүст нь л түгээх хэрэгтэй. Бусад хүмүүсийн хувьд бөгсөө цэвэрлэхэд нь зориулж 0-ийн цаас эсвэл бусад материалаар хангах шаардлагатай байж болно. Хэрэглэгчидэд хамгийн их тохирох боловсон цэвэрлэх материал болон тэдгээрийг хэрхэн хаяж устгах талаар зөвлөгөө өгөх хэрэгтэй.
4. **Сарын тэмдэг:** Сарын тэмдэг нь ирдэг эмэгтэйчүүд, охидыг сарын тэмдгийн цусаа уусгаж цэвэрлэхэд тохиромжтой материалаар хангах ёстой. Эмэгтэйчүүдэд хамгийн их тохирох боловсон материалын талаар зөвлөгөө өгөх хэрэгтэй (232-р хуудсан дах Хүнсний бус зүйлд тавигдах шаардлага 2 гэсэн сэдвийг үзнэ үү).
5. **Бие засах газар болон усны ундарга хоёрын хооронд байх ёстой зай:** Өмнө нь дурдсан бие засах цэг болон усны ундарга хоёрын хооронд байх ёстой зайг ан цав ихтэй хад чулуу болон шохойн чулуутай газарт их болгож харин хөрс сайтай газар ойртуулж болно. Гамшгийн нөхцөлд хэрвээ газар доорхи ус бохирдоогүй бол түүнийг эн тэргүүнд анхаарах шаардлагагүй. Үертэй буюу усны түвшин өндөр болсон үед хүрээлэн буй орчныг бохирдолоос сэргийлэхийн тулд бие засах газрыг газраас хөндийрүүлэн өндөрлөх маягаар барьж, ялгадасыг юулж хадгалах бохирдлын бак байрлуулах шаардлага гарч болно.

6. **Гараа угаах:** Бие зассаны дараа болон хоол идэх, бэлдэхийн өмнө гараа тогтмол угааж өвчинөө урьдчилан сэргийлэхийн ач холбогдолыг хий хоосон өсгөж болохгүй. Хэрэглэгчид бие зассаныхаа дараа саван болон бусад зүйлээр /үнс гэх мэт/ гараа угаах явдлыг ухуулан дэмжих шаардлагатай. Гар угаахад зориулж бие засах газрын хажууд усны эх үүсвэр байнга байж байх ёстой.
7. **Бие засах газрын эрүүл ахуй:** Хэрвээ бие засах газрыг цэвэрхэн байлгахгүй бол өвчин тархах үүр уурхай болж болох ба ингэвэл хүмүүс бие засах газарт орохоос зайлсхийж эхлэнэ. Хэрвээ хэрэглэгчид өмчид өөрийн юм шиг хандвал бие засах газрууд байнга цэвэрхэн байх боломжтой юм. Үүнийг ухуулан таниулах ажил, бие засах газрыг хүмүүсийн унтдаг газартай нь ойр болгох, хэрэглэгчидийг бие засах газрын загвар хийцтэй холбоотой шийдвэр гаргахад оролцуулах, зөв ажиллуулах, арчлах мөн ашиглах тухай заавраар дамжуулан дэмжиж болно. Бие засах газрыг цэвэрхэн байлгах, усны хаалт тавих, Агааржуулалттай Сайжруулсан Жорлон зэрэг аргаар ялаа болон шумуулаас сэргийлж болно.

4. Халдвар Тээгчийг Устгах

Халдвар тээгч гэдэг нь ямар нэг төрлийн өвчин тээж буй зүйлийг хэлэх бөгөөд халдвар тээгчээс үүссэн өвчин нь ихэнхи гамшигийн нөхцөлд өвчин үүсч тарах мөн үхэлд хүргэх гол шалтгаан болдог. Шумуул бол өвчлөл болон нас баралтын гол шалтгааны нэг болох хумхаа буюу чичрэг өвчнийг дамжуулж халдаадаг халдвар тээгч юм. Шумуул мөн шар хумхаа болон халуун хумхаа зэрэг бусад өвчнийг дамжуулж халдаадаг. Гэрийн ялаа, хаздаг ялаа гэх мэт хаздаггүй буюу синантропик ялаанууд нь суулгаа өвчний халдварт ихээхэн чухал үүрэг гүйцэтгэдэг амьтад юм. Хаздаг ялаа, бясаа болон оронд амьдардаг шавьж зэрэг нь зарим тохиолдолд гэдэсний хижиг болон тахалыг дамжуулан халдаах чадалтай байдаг. Хачиг нь байнгын халуурлын өвчинг дамжуулан халдаадаг бол хүний биеийн бөөс нь хижиг болон байнгын халуурлын өвчинг халдаадаг. Хулгана болон оготнууд летоспероз болон салмонелёз зэрэг өвчнийг дамжуулж чадахаас гадна тахал болон бусад халдварыг дамжуулдаг бясаа гэх мэт бусад халдвар тээгч нарын үүр нь байж болдог.

Халдвар тээгчээс үүссэн өвчнийг янз бүрийн арга хэлбэрээр хянаж зохицуулж болох ба үүнд тохирох газрыг сонгох ба байр оромжоор хангах, ус хангамжыг сайн байлгах, ялгадасыг аюулгүй болгож хаях, хатуу хог хаягдлын менежмент ба бохир ус, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх /хүн амыг татан оролцуулах ба эрүүл мэндийг таниулан сурталчлах/, химийн аргыг ашиглах, айл өрх болон хувь хүмүүс өөрсдөө урьдчилан сэргийлэх мөн хүнсний дэлгүүрүүдийг хамгаалах зэрэг багтана. Хэдийгээр халдвар тээгчээс үүссэн өвчний шинж чанар ерөнхийдөө ярвигтай байдаг учраас халдвар тээгчтэй холбоотой бэрхшээлийг

шийдэхийн тулд нарийн мэргэжилтэний оролцоо шаардагдаж болох боловч өвчин, түүнийг тээгч мөн тэдгээрийн хүн амтай хэрхэн харилцан холбогдож байгааг зөв тогтоож чадах юм бол ийм төрлийн өвчний тархалтаас энгийн бөгөөд үр дүнтэй аргаар сэргийлэх ажилд тус болох олон зүйлийг хийж болно.

Халдвар тээгчийг устгахад тавигдах шаардлага 1: Хувь хүн болон айл өрх өөрсдийгөө хамгаалах нь.

Гамшигт өртсөн бүх хүмүүс эрүүл мэнд, амь насанд нь бодитой аюул учруулж болох өвчин эмгэг болон халдвар тээгчээс өөрсдийгөө урьдчилан сэргийлж хамгаалах мэдлэг чадвартай байх ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Халдвар тээгчээс үүссэн өвчинд өртөх эрсдэлтэй байгаа бүх хүн ам халдвар дамжих хэлбэр болон түүнээс урьдчилан сэргийлэх боломжит аргуудыг таньж ойлгосон байх ёстой (заавар тэмдэглэл 1-5-ийг үзнэ үү).
- Нийт хүн ам халдвар тээж буй хүн амаас ангид бөгөөд халдвар тээгчийг хянах зохих аргаар хамгаалагдсан байр сууцтай байх ёстой.
- Хүмүүс шумуулын оргил үед өөрсдийн мэдэх аюулгүй бүхий л аргыг ашиглан шумуулд хазуулахгүй байхыг эрмэлздэг. Жирэмсэн болон хөхүүл эхчүүд, нялх болон нярай хүүхэд, настай хүмүүс болон өвчтэй байгаа хүмүүсийг хамгаалахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай (заавар тэмдэглэл 3-ийг үзнэ үү).
- Тусгайлан цэвэршүүлсэн шумуулын тортой хүмүүс тэдгээрийг үр дүнтэй ашигладаг (заавар тэмдэглэл 3-ийг үзнэ үү).
- Бөөснөөс үүссэн хижиг болон байнгын халуурлын өвчиний эрсдэл нүүрлэсэн тохиолдолд хүний биеийн бөөсийг устгах ажлыг хэрэгжүүлэх ёстой (заавар тэмдэглэл 4-ийг үзнэ үү).
- Хөнжил ор дэвсгэр болон хувцас хунартаа байнга агаар оруулж, тогтмол угааж байх ёстой (заавар тэмдэглэл 4-ийг үзнэ үү).
- Хүнсний ялаа, шавьж, хулгана зэрэг халдвар тээгч нараас байнга хамгаалж байх хэрэгтэй.

Заавар тэмдэглэл

1. **Халдвар тээгчээс үүссэн өвчний эрсдэлийг тогтоох:** Халдвар тээгчийг хянах хөндлөнгийн оролцооны талаархи шийдвэрийг гаргахдаа өвчний байж болох эрсдэлийн үнэлгээ мөн халдвар тээгчээс үүсэн өвчинтэй холбоотой бэрхшээлийн талаарх эмнэлгийн баримт зэрэгт тулгуурлан гаргах хэрэгтэй. Энэхүү эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлүүдийг дурдвал:

77

- Өмнө нь халдвар авч байсан эсэх, хүнс тэжээлийн болон бусад стресс гэх мэт хүн амын дархлалын байдал. Хүмүүсийн гадны халдварт өвчний тархалтаас дотоод руу шилжих хөдөлгөөн (дүрвэгсэд, IPDs гэх мэт) нь тахлын гамшгийн үндсэн шалтгаан;
 - Халдвар тээгч болон хүн дэх эмгэг үүсгэгчийн төрөл ба тархалт;
 - Халдвар тээгчийн төрөл зүйл, зан араншин ба үржлийн орчин;
 - Халдвар тээгчийн тоо (улирал, үржлийн газар гэх мэт);
 - Халдвар тээгчид хазуулах тохиолдол ихсэх: үржлийн газартай нь ойрхон байх, байр сууцны төрөл, хувийн хамгаалалт гэх мэт.
2. **Халдвар тээгчийг хянах хөтөлбөрийн үзүүлэлтүүд:** Халдвар тээгчээс үүссэн өвчний гаралтын түвшин (тахлын гамшигын тоо, олон нийтэд үндэслэсэн тоо гэх мэт) мөн шимэгч хорхойны тооллого (яаралтай шинжилгээний багаж хэрэгсэл болон микроскоп) зэрэг өргөн хэрэглэгддэг үзүүлэлтүүдээр халдвар тээгчийг устгах ажлын үр нөлөөг хэмждэг.
 3. **Хумхаа өвчинөөс хамгаалах хувийн арга хэрэгсэл:** Хэрвээ хамхуу өвчинд өртөх бодит эрсдэл байгаа бол шавьж устгах бодисоор ариутгасан материал, майхан, хөшиг, орны хөшиг гэх мэт хамгаалах арга хэмжээг дэс дараатай, цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай. Орны хөшиг нь их бие болон толгойны бөөс, бясаа, хачиг, жоом зэрэг халдвар тээгчийн эсрэг хамгаалах хамгаалалттай болсон. Урт ханцуйтай хувцас, гэрийн утлага, тор, аэрозол шүршигч, үрэл зэрэг нь шумуулын эсрэг ашиглаж болох бусад төрлийн хамгаалах арга хэрэгсэл болно. Хэрэглэгчид урьдчилан хамгаалахын ач холбогдолыг ухан ойлгож, хамгаалах арга хэрэгсэлийг үр дүнтэй байлгахын тулд хэрхэн зөв ашиглах тухай сайтар мэдэж байх нь маш чухал. Нөөц боломж хомс байгаа тохиолдолд байгаа нөөцөө таван наснаас доош насны хүүхдүүд, дархлаа муутай мөн жирэмсэн эхчүүд гэх мэт хамгийн их эрсдэлд байгаа хүмүүст хамгийн түрүүнд зориулах хэрэгтэй.
 4. **Бусад халдвар тээгч нараас хамгаалах хувийн арга хэрэгсэл:** Хувийн ариун цэврийг сайтар сахиж, хувцас хунар, ор дэвсгэрээ байнга угааж цэвэрлэж байх нь биеийн бөөсний эсрэг хамгийн сайн хамгаалалт болж чадна. Лагерьт шинэ хүмүүс нүүн шилжиж ирэхэд хувийн хамгаалалт, угаалга,

бөөсгүйжүүлэлтийн ажил зэрэг аргаар шавьж болон мэрэгчидийн үржлийг хянах буюу хязгаарлаж болно.

78

Гэртээ цэвэр орчин бүрдүүлж, хог хаягдлаа зөв хаяж, хүнсний зүйлээ зөв хадгалсанаар хулгана болон бусад мэрэгчин амьтдыг байшинд нэвтэрч, үүрлэхээс сэргийлдэг.

5. **Уснаас үрсэх өвчин:** Хүмүүс чистосомасис буюу schistosomiasis, **Guinea өг** эсвэл липтопиросис буюу leptospirosis (ялангуяа эмэгчин хулганы шээсэнд хүрсэнээс дамждаг: хавсралт 4-ийг үзнэ үү) гэх мэт өвчин авах эрсдэл мэдэгдэж байгаа тохиолдолд ус голд орохоос зайлсхийх хэрэгтэй ба ийм төрлийн эрүүл мэндэд учрах эрсдлийн талаар тодорхой мэдэж байх шаардлагатай. Холбогдох агентлагууд олон нийттэй хамтран ажиллаж усны өөр эх үүсвэрийг олох эсвэл хэрэглээний ус найдвартай цэвэрхэн гэдгийг баталгаажуулах шаардлага гарч болно.

Халдвар тээгчийг хянахад тавигдах шаардлага 2: Халдвараас сэргийлэх физикийн, хүрээлэн буй орчны, химийн арга хэрэгсэл

Хүмүүсийн эрүүлмэндэд аюул учруулж байгаа өвчний халдвар тээгчидийн тоог боломжтой хэмжээнд байрж байх ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Нүүлгэн шилжүүлж буй хүн амыг шумуулд хазуулах аюулаас хол газар байршуулах хэрэгтэй (заавар тэмдэглэл 2-ийг үзнэ үү).
- Халдвар тээгчидийн үржиж, амрах газрыг байж болох газарт шилжүүлэх (заавар тэмдэглэл 2-4-ийг үзнэ үү).
- Суулгах өвчний гамшиг нүүрлэх магадлал ихтэй эсвэл байгаа тохиолдолд хүн ам ихээр суурьшсан газарт ялааг устгах арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлэх шаардлагатай.

- Өвчний халдварын түвшинг бага хэмжээнд барьж байхын тулд шумуулын тоог маш бага тоонд барьж байх хэрэгтэй (заавар тэмдэглэл 4-ийг үзнэ үү).
- Хумхаагаар халдварласан хүмүүсийг эрт үед нь шинжлэн тогтоож, эмчилгээ хийж байх хэрэгтэй (заавар тэмдэглэл 5-ийг үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **Газрыг сонгох:** Энэ нь хүн амыг халдвар тээгчээс үүсэх өвчин авах эрсдлээс сэргийлэн хамгаалахад их чухал бөгөөд газрыг сонгохдоо энэ хүчин зүйлийг тусгайлан авч үзэх шаардлагатай. Тухайлбал хумхааг устгах арга хэмжээний хувьд намаг эсвэл нуур гэх мэт халдвар тээгч ихээр байдаг газраас салхины дээр нь 1-2 километрийн зайтай байрлалыг сонгох хэрэгтэй ба тэнд цэвэр усны эх үүсвэрээр хангах боломжтой эсэхийг мөн харгалзаж үзэх хэрэгтэй (211-218-р хуудсууд дах Байр сууц ба суурьших газарт тавигдах шаардлага 1-2-ийг үзнэ үү).
2. **Халдвар тээгчийг хүрээлэн буй орчин болон химийн аргаар устгах:** Халдвар тээгчийг өсч үржих боломжыг нь хязгаарлаж боох хүрээлэн буй орчны техникийн олон олон арга хэрэгсэл байдаг. Үүнд хүний болон мал амьтны ялгадсыг зөв хаяж аюулгүй болгох (Ялгадсыг Хаях гэсэн хэсгийг үзнэ үү), хог хаягдлаа зохих ёсоор хаяж, ялаа болон шимэгч хорхойнуудыг цуглуулахгүй байх (Хатуу хог хаягдлын менежмент гэсэн хэсгийг үзнэ үү), шумуул цуглуулахгүйн тулд тогтмол усыг ширгээж хатаах (Ширгээж Хатаах гэсэн хэсгийг үзнэ үү) гэх зэрэг аргууд багтана. Хүрээлэн буй орчны эрүүл мэндийн эдгээр арга хэрэгслүүдийг нэн тэргүүнд хэрэгжүүлсэнээр зарим нэгхалдвар тээгч нарын тоонд тодорхой нөлөө үзүүлдэг. Нүүлгэн шилжүүлж авчирсан газарт буюу түүнтэй ойролцоо халдвар тээгч нарын үржих, хооллох болон амрах газарт урт хугацааны турш хангалттай нөлөөлөл үзүүлэх боломж байхгүй байж болох болох ба химийн устгалын арга хэрэгсэл эсвэл хувийн хамгаалах арга хэрэгсэл шаардагдаж болох юм. Тухайлбал агаарт цацагч хор нь насанд хүрсэн ялааны тоо толгойг бууруулж суулгах гамшгаас сэргийлж болно мөн эсвэл гамшгийн үед хэрэглэсэн тохиолдолд өвчний дарамтыг зөөлрүүлж өгч болох юм.
3. **Хариу арга хэмжээг боловсруулах:** Халдвар тээгчийг хянах хөтөлбөр нь хэрвээ буруу халдвар тээгчид чиглэсэн, үр дүн муутай аргыг хэрэглэсэн, эсвэл зөв халдвар тээгч нь зөв боловч буруу газарт, буруу цаг мөчид чиглэсэн бол тухайн өвчинд ямар нэг нөлөөлөл үзүүлж чадахгүй байх магадлалтай. Халдвар тээгчийг хянах хөтөлбөр нь юуны түрүүнд дараах гурван зорилтыг шийдвэрлэх ёстой. Үүнд: 1/ Халдвар тээгчийн тоо толгойг цөөрүүлэх, 2/ хүн-халдвар тээгч хоёрын контактыг бууруулах эцэст нь 3/ халдвар тээгч нарын үрждэг газрын тоог цөөрүүлэх зэрэг болно. Хөтөлбөрийг муу чанаргүй хэрэгжүүлвэл үр дүн нь сөрөг гарна. Дотоодын болон олон улсын байгууллагуудаас нарийвчилсан судалгаа, ялангуяа экспертүүдийн зөвлөгөө авах шаардлагатайгаас гадна орон нутгийн өвчний шинж чанар, онцлог, халдвар тээгч нарын үрждэг газар, халдвар тээгч нарын тоонд гарах улирлын чанартай өөрчлөлтүүд, өвчний гаралт зэргийн талаар орон нутгийн зөвлөгөөг авах хэрэгтэй.

4. **Шумуулны хүрээлэн буй орчин дах хяналт:** Хүрээлэн буй орчны хяналт нь ерөнхийдөө шумуулны үрждэг газруудыг устгахад чиглэгдэх ёстой. Өвчнийг дамжуулж халдаадаг шумуулны гурван гол төрөл зүйл бол кулекс буюу *Culex* (filariasis),

80

Anopheles (хумхаа ба filariasis) эцэст нь *Aedes* (yellow fever and dengue) нар юм. *Culex* төрлийн шумуул нь latrines гэх мэт органик бодисоор дүүрсэн тогтмол усанд байдаг бол *Anopheles* нь шалбааг, зөөлөн урсгалтай гол булаг гэх мэт бохирдоогүй гадаргын усанд голдуу байдаг, харин *Aedes* нь лонх, хувин гэх мэт ус болон шингэн зүйлийн сав суулганд үрждэг байна. Шумуулны хүрээлэн буй орчин дах хяналтын арга хэрэгслийн тоонд сайн бохирын шугам, найдвартай ажиллагаатай VIP жорлон, худгийг байнгын тагтай бйлгах зэрэг багтана.

5. **Хумхааг эмчлэх:** Шумуулны үржлийн газрын тоог цөөрүүлэх, шумуулны өдөр тутмын амьд гарах түвшинг нь бууруулах, хүний шумууланд хазуулах зуршлыг хязгаарлах гэх мэт замаар шумуулны тоо толгойг цөөрүүлэхэд чиглэгдсэн хумхааг хянах стратегийг эрт үед нь оношилж, хумхааны эсрэг эмээр эмчлэх ажилтай нэгэн зэрэг уялдуулан авч хэрэгжүүлэх шаардлагатай. Эрт үед нь оношилж, эмчлэх кампанит ажлыг санаачилж, дэмжих хэрэгтэй. Хумхааг багасгахын тулд тусгайлан бэлтгэгдсэн ажилтаныг газар дээр нь ажиллуулж шинжилгээ хийлгэн хумхааны эсрэг эмээ эмчлэх явдал нь төвлөрсөн эмнэлгийн үйлчилгээнээс илүү үр дүнтэй болдог (281-р хуудсан дах халдварт өвчнийг устгах стандарт 5-ийг үзнэ үү).

Халдвар тээгчийг хянахад тавигдах шаардлага 3: Химийн арга хэрэгслийн аюулгүй ажиллагаа.

Халдвар тээгчийг хянах химийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ гамшигт өртсөн тусламжын ажилтан, энгийн ард иргэд болон хүрээлэн буй орчинг зохих ёсоор хамгаалж, хэрэглэсэн химийн бодисноос хордож бохирдохгүй байх талаас нь юуны түрүүнд анхаарах ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Ажилтнуудад холбогдох сургалт зохион байгуулах, хамгаалалтын хувцас хэрэгслээр хангах, усанд орох газрыг ашиглуулах, химийн бодистой харьцахад зарцуулах цагийн хэмжээг хянах буюу хязгаарлах зэргээр хамгаалах ёстой.
- Халдвар тээгчийг хянахад хэрэглэгдэх химийн бодисыг сонгох, түүний чанар, тээвэрлэлт, хадгалалт, хэрэглэх багаж техник, химийн бодисыг аюулгүй устгах зэрэг нь олон улсын норм нормативын дагуу хийгдэх ёстой (заавар тэмдэглэл 1-ийг үзнэ үү).

- Халдвар тээгчийг устгахад ашиглагдаж байгаа химийн бодисын бодит аюул болон тэдгээрийг ашиглах цагийн хуваарь зэргийн талаарх мэдээллийг хүн амд цаг тухайд нь өгч байх ёстой. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн журмын дагуу хүмүүсийг химийн хор болон шавьж устгагчыг хэрэглэх үед мөн хэрэглэсний дараа бүхий л хугацаанд хамгаалах ёстой (удирдах санамж 1-ийг үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. Үндэсний болон олон улсын протоколууд: Химийн бодисыг халдвар тээгчийг устгахад ашиглах талаар Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас гаргасан олон улсын тодорхой протокол ба норм байдаг бөгөөд тэдгээрийг цаг ямагт хэлбэрэлтгүй дагаж мөрдөж байх ёстой. Халдвар тээгчийг устгах үйл ажиллагаа нь үр дүн ба аюулгүй ажиллагаа гэсэн хоёр л үндсэн асуудал дээр тулгуурлаж хийгдэх ёстой. Хэрвээ химийн бодисыг сонгохтой холбоотой дотоодод мөрдөж байгаа норм нормативууд нь олон улсын стандартад хүрэхгүйгээс шалтгаалан эрүүл мэнд болон аюулгүй байдалд учирж байгаа аюулыг ямар нэг нөлөөлөл үзүүлж чадахгүй байгаа бол холбогдох агентлаг дотоодынхоо эрх бүхий байгууллагатай зөвлөлдсөний үндсэн дээр олон улсад мөрдөж байгаа норм стандартыг дагаж мөрдөх зөвшөөрлийг авах шаардлагатай.

5 Хатуу Хог хаягдлын Менежмент

Хэрвээ органик хатуу хог, хог хаягдалыг зохих ёсоор хаяж устгаагүйгээс шалтгаалан ялаа болон хулгана үржих (Халдвар тээгчийг хянах гэсэн хэсгийг үзнэ үү) мөн гадаргын ус бохирдох аюул үүснэ. Байгалийн гамшиг болон мөргөлдөөний дараа үлдсэн хатуу хог, хог хаягдалыг цуглуулж бөөгнүүлэхгүй бол эмх замбараагүй, хөглөрсөн орчин бий болж, үүний улмаас хүрээлэн буй орчны эрүүлмэндийн бусад асуудлуудыг сайжруулах хүчин чармайлтыг сулруулах сөрөг үр дагавартай. Хатуу хог хог хаягдал нь голдуу бохирын суваг шуудууг бөглөж, тогтмол ба бохирсдон гадаргын устай холбоотой хүрээлэн буй орчны эрүүлмэндийн бэрхшээлийг бий болгоно.

Хатуу хог хаягдлын менежментэд тавигдах шаардлага 1: хатуу хог хаягдлыг цуглуулах хаяж устгах

Хүмүүс эмнэлгийн хог хаягдал гэх мэт хатуу хог хаягдалаар бохирдоогүй хүрээлэн буй орчинд аж төрөх ёстойгоос гадна гэрийн хог хаягдалаа зөв боловсон хаяж устгах арга хэрэгсэлтэй байх ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Гамшигт өртсөн хүмүүс хатуу хог хаягдлын хөтөлбөрийг боловсруулах болон хэрэгжүүлэх үйл хэрэгт оролцох ёстой.
- Гэрийн хог хаягдалыг өдөр болгон саванд хийж тогтмол цуглуулах ба тусгай зориулалтын хогийн саванд шатааж эсвэл булж устгана.
- Бүх айл өрх хогийн савтай байх ёстой ба айл өрх нь нийтийн хогийн савны цэгнээс 100-аас илүүгүй метр ойрхон байх ёстой.
- Гэрийн хог хаягдлыг газар дээр нь шатаах боломжгүй тохиолдолд 10 айлын дунд 100 литрийн багтаамжтай нэг хогийн савыг заавал байрлуулах ёстой.

- Хог хаягдлыг эрүүл мэндэд хортой болж хувирахаас нь өмнө зайдуу гаргаж устгах ёстой. (заавар тэмдэглэл 1, 2, 6-г үзнэ үү).
- Эмнэлгийн хог хаягдлыг ангилж, тусад нь хаяж устгах ёстой ба тусгай зориулалтын хогийн сав буюу үнсний гүн савтай хог шатаах зуухыг эрүүл мэндийн газрын эзэмшил газар болгонд заавал байлгах ёстой. (заавар тэмдэглэл 3, 6-ийг үзнэ үү).
- Ямар ч тохиолдолд орон сууцны хороолол болон олон нийтийн газруудад бохир буюу аюултай эмнэлгийн хог хаягдал (зүү тариур, шил, хувцас, эм гэх мэт) байх ёсгүй (заавар тэмдэглэл 3-ийг үзнэ үү).
- Зах, мал нядалгааны газар гэх мэт нийтийн газруудад гаргацтай тэмдэглэсэн мөн сайн хашаалж хүрээлсэн хогийн савыг байрлуулах ёстой ба хогны машин тогтмол цуглуулах явдлыг хангах шаардлагатай (заавар тэмдэглэл 4-ийг үзнэ үү).
- Хатуу хог хаягдлыг хамгийн сүүлд орон нутгийн болон гамшигт өртсөн хүмүүст эрүүл мэнд болон хүрээлэн буй орчны аюул үүсгэхээргүй газар хаях ёстой (заавар тэмдэглэл 5-6-ийг үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **Хог хаягдлыг булах:** Хэрвээ хог хаягдлыг гэртээ эсвэл нийтийн зориулалттай нүхэнд газар дээр нь булах тохиолдолд ялаа, хулгана гэх мэт халдвар тээгчидийг татаж, үржих газар болохоос нь сэргийлэх зорилгоор долоо хоног болгон шороогоор нимгэн зулж булах хэрэгтэй. Хэрвээ хүүхдийн ялгадас болон бохир даавууг хаях бол тэр дариуд нь шороогоор булах хэрэгтэй. Хог хаяг цэгийг хүүхэд болон мал амьтан орохоос сэргийлж хашаагаас хүрээлэх хэрэгтэй. Мөн хөрсний усыг бохирдуулж байгаа аливаа бохирдлоос сэргийлэхэд анхаарах шаардлагатай.
2. **Хог хаягдлын төрөл ба хэмжээ:** Суурин газруудын хог хаягдал нь эдийн засгийн үйл ажиллагааны цар хүрээ болон төрөл, хэрэглэсэн хүнс болон тухайн орон нутгийн хог хаягдалыг эргэж ашиглах ба/буюу хаях арга хэлбэр зэргээс хамааран бүтэц болоод хэмжээний хувьд нэлээд ялгаатай байдаг. Хатуу хог хаягдлын хүмүүсийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн хэмжээнд үнэлгээ хийж шаардлагатай бол тохирох арга хэмжээг авах хэрэгтэй. Хатуу хог хаягдалыг дахин ашиглах явдал нь эрүүлмэнд хор хөнөөлгүй бол түүнийг хүн амын дунд хөхүүлэн дэмжих нь зүйтэй. Савлагаа болон боловсруулах үйл ажиллагаанаас болон хатуу хог хаягдал их хэмжээгээр бий болгодог бараа таваарыг нийлүүлэх явдлаас зайлсхийх шаардлагатай.

3. **Эмнэлгийн хог хаягдал:** Эрүүл мэндийн ажиллагаатай холбоотой үүссэн хог хаягдалыг менежментийг муу зохион байгуулсаны улмаас хүн ам, эрүүл мэндийн ажилтан болон хог хаягдалтай харьцдаг хүмүүс халдвар авч бэртэх аюулд өртдөг. Гамшгийн нөхцөлд хог хаягдлын хамгийн хортой төрлийн тоонд халдварт үзүүртэй болон үзүүргүй зүйлүүд (шархны боолт, цус боох материал, плацент зэрэг органик бодисууд гэх мэт) зэрэг багтдаг. Хог хаягдалыг төрөл төрлөөр нь ангилж тусгаарлах шаардлагатай. Халдваргүй хог хаягдалыг (цаас, хуванцар боолт, хүнсний хаягдал гэх мэт) хатуу хог хаягдал гэдэг утгаар нь хаяж болно. Бохирдсон үзүүртэй зүйл, ялангуяа хэрэглэсэн зүү, тариур зэргийг хэрэглэснийхээ дараа шууд аюулгүй саванд хийх хэрэгтэй. Аюулгүйн сав болон бусад халдвартай хог хаягдлыг булах, шатаах гэх мэт аюулгүй аргаар газар дээр нь устгаж болно.
4. **Захын хог хаягдал:** Захын ихэнхи хог хаягдлыг гэрийн хог хаягдалтай адил аргаар хаяж болно. Мал нядалгааны газрын хог хаягдлын хувьд бий болсон шингэн хаягдлыг шийдэж, нядалгааны ажлыг эрүүл ахуйн шаардлага болон дотоодын хуулт тогтоомжын дагуу явуулахын тулд тусгай цэвэршүүлэх ажиллагаа мөн тусгай барилга байгууламж шаардлагатай байж болно. Нядалгаанаас гарсан хог хаягдлыг бойны газрын ойролцоох таглаатай том нүхэнд хаяж болно. Цус гэх мэт зүйлийг хавтгай зүйлээр бүтээсэн суваг шуудууг ашиглан бойны газраас нүх рүү урсгаж болно (Ялааг нүхэнд орохоос сэргийлэх зорилгоор). Усыг цэвэрлэгээ хийх зорилгоор байнга бэлэн байлгах хэрэгтэй.
5. **Хяналтын дор хаях/ ариутгалын үүднээс газарт булах:** Их хэмжээний хог хаягдлыг зайдуу гаргаж хяналтын дор ил хаях, эсвэл ариутгалын үүднээс газарт булах шаардлагатай. Энэхүү арга нь хангалттай орон зай буюу газар болон механик төхөөрөмж бэлэн байгаа эсэхээс шалтгаална. Халдвар тээгч үржихээс сэргийлэх зорилгоор ил хаясан хог хаягдлыг хамгийн сүүлд шороогоор булах хэрэгтэй.
6. **Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах:** Хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэж, хаях ажлыг гүйцэтгэж буй хатуу хог хаягдлын менежментийн ажилчдад хамгаалалтын хувцас, бээлий, комбинзон, гутал болон хамгаалалтын багаар хангах шаардлагатай. Гар болон нүүрээ угаахад нь зориулж ус, савангаар мөн хангах хэрэгтэй. Эмнэлгийн хог хаягдалтай ажиллах ажилтанд ийм төрлийн хог хаягдлыг хадгалах, тээвэрлэх болон хаях зөв арга ажиллагааны талаар мөн буруу харьцсанаас үүдэн гарах эрсдэлийн талаар зохих мэдээллийг өгөх хэрэгтэй.

6 Бохирын Систем

Онцгой байдлын лагерь доторх буюу түүнтэй ойролцоохи гадаргын ус нь айл өрх, усны цэгийн хаягдал ус, гэмтэлтэй бие засах газар болон бохирын хоолой, борооны ус, үерийн ус зэргээс үүсч болно. Гадаргын устай холбогдон эрүүлмэндэд үүсч болох гол аюул бол усны хангамж болон амьдрах орчин бохирдох, бие засах газар болон байр сууц гэмтэж эвдрэх, халдвар тээгч үржих гэх зэрэг болно. Борооны болон үерийн ус нь лагерь дах бохирын системийг доройтуулж, бохирдол үүсэх эрсдэлийг нэмэгдүүлнэ. Бохирын системийг зөв төлөвлөх мөн бага оврын талбай дах бохирын системийг ашиглан лагерийн дотоод зохион байгуулалтыг төлөвлөж, хаягдал усыг хаях замаар ширүүн борооны усны шугамыг шийдэх зэрэг ажлыг авч хэрэгжүүлэн хүн амын эрүүлмэндэд учирч болох аюулыг бууруулж болно. Энэхүү бүлэгт бага хэмжээний бохирын системийн бэрхшээл болон үйл ажиллагааны тухай тайлбарласан болно. Том хэмжээний бохирын систем нь голдуу лагерийг сонголт ба хөгжлөөр тодорхойлогдоно (203-р Хуудсан дах Байр Сууц, Суурьших ба Хүнсний Зүйл хэмээх 4-р бүлгийг үзнэ үү).

Бохирын системд тавигдах шаардлага 1: Бохирын ажил

Хүмүүс ширүүн борооны ус, үерийн ус, ахуйн хаягдал ус болон эмнэлгийн хаягдал ус зэргээс үүсэх усны элэгдэл ба тогтмол уснаас шалтгаалах эрүүлмэнд болон бусад аюул багатай орчинд аж төрөх ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Орон сууц болон усны цэгийн ойролцоох газрыг тогтмол хаягдал уснаас хол байх ёстой ба борооны усны шугамыг цэвэрхэн байлгах хэрэгтэй (заавар тэмдэглэл 1,2,4,5-ийг үзнэ үү).
- Байр сууц, зам, ус болон ариутгалын байгууламж нь үер усны аюулд өртөхгүй мөн элэгдэж идэгдэхгүй байх ёстой (заавар тэмдэглэл 2-4-ийг үзнэ үү).

- Усны цэгийн шугамыг сайтар төлөвлөсний үндсэн дээр зөв хийж ажиллуулах хэрэгтэй. Үүнд угаалгын болон усанд орох газраас бохирын шугам татах мөн ус цуглуулах цэг зэрэг багтана. (заавар тэмдэглэл 2-4-ийг үзнэ үү).
- Бохирын шугамын ус гадаргын болон гүний усны эх үүсвэрийг бохирдуулах эсвэл хөрсөнд элэгдэл үүсгэх ёсгүй (заавар тэмдэглэл 5-ийг үзнэ үү).
- Шаардлагатай үед бохирын ажилд зориулж тусгай багаж хэрэгслийг хангалттай тоо хэмжээгээр хангах хэрэгтэй (заавар тэмдэглэл 4-ийг үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **Байрлах газрыг сонгох ба төлөвлөх:** Бохирын асуудлыг хянах буюу зохицуулах хамгийн үр дүнтэй арга бол сайтыг зөв сонгож, зөв зохион байгуулж төлөвлөх явдал байдаг (211-224-р уудсан дах Байр Сууцанд тавигдах шаардлага 1-4-ийг үзнэ үү).
2. **Хаягдал ус:** хөрсний болон ахуйн хаягдал ус хүний ялгадастай холилдсон тохиолдолд түүнийг бохир гэж нэрлэдэг. Бохирын шугамтай газар лагерийг байрлуулах хүртэл ахуйн хаягдал усыг хүний ялгадастай холилдохоос сэргийлж байх хэрэгтэй. Бохирыг цэвэршүүлэхэд ахуйн хаягдал уснаас илүү хэцүү бөгөөд илүү зардал ордог. Усны цэг болон угаалга ба усанд орох газруудад хаягдал усыг ашиглах жижиг цэцэрлэгийг байгуулах явдлыг хөхүүлэн дэмжих шаардлагатай. Угаалга болн усанд ордог газруудаас гарч байгаа хаягдал усыг усны эх үүсвэрийг бохирдуулахаас сэргийлэхэд онцгой анхаарал хандуулах шаардлагатай.
3. **Бохир болон ялгадасыг хаях:** Механик гэмтэл болон гоожилтоос сэргийлэхийн тулд бие засах газар болон сувгийг үерээс хамгаалахад онцгой анхаарал тавих хэрэгтэй.
4. **Таниулан ухуулах:** Гамшигч өртсөн хүмүүс усны байгалийн урсгалын чиглэл болон сувгийг хаагуур татвал болохыг ерөнхийдөө мэдэж байдаг учраас тэднийг бага хэмжээний бохирын системийг татах ажилд татан оролцуулах нь маш чухал. Үүнээс гадна гамшигч өртсөн хүмүүс эрүүлмэнд, бие махбодод учирч болох аюулыг ойлгож, бохирын системийг татах ажилд гар бие оролцсон бол тэд шугамыг татсаны дараа түүнийг цаашид ажиллуулж, арчлах сонирхолтой байдаг (Халдвар тээгчийг устгах гэсэх бүлгийг үзнэ үү). Энэ тохиолдолд техникийн дэмжлэг үзүүлж, багаж хэрэгсэлээр хангах шаардлага гарч болно.
5. **Хог хаягдлыг газар дээр нь хаяж аюулгүй болгох:** Хэрвээ боломжтой бол мөн хөрс сайтай газарт усны цэг болон угаалгын газараас гарч буй бохирыг арчилахад хэцүүгээс гадна байнга бөглөрч байдаг ил сувгаар биш харин газар дээр нь гүйцэтгэвэл зохино. Юүлэгч нүх гэх мэт энгийн бөгөөд хямд арга техникийг хаягдал усыг сайт дотор газар дээр нь хаяж аюулгүй болгоход ашиглаж болно.

Хэрвээ сайтаас гаргаж зайдуу хаяхаас өөр боломж байхгүй бол хоолой татан суваг татсан нь илүү болно. Сувгийг цаг агаарын хуурай хаягдалд зориулсан урсгалын хурдтай байхаас гадна борооны ус гүйхээр хийх ёстой. Налуу 5 хувиас дээш байх тохиолдолд хэт элэгдлээс сэргийлэхийн тулд техникийн арга техникийг ашиглах ёстой. Усыг цэвэршүүлэх ажлаас үлдсэн үлдэгдэлийн бохирын шугамыг хүмүүсийг хэрэглэхээс мөн гадаргын эсвэл гүний усны эх үүсвэрийг бохирдуулахаас сэргийлж сайтар хянаж байх хэрэгтэй.

ХАВСРАЛТ 1

Ус хангамж ба Ариутгалын Наад Захын Хэрэгцээг Үнэлэх Хянах асуултын жагсаалт

Энэхүү асуултын жагсаалт нь ерөнхийдөө хэрэгцээг тогтоож, орон нутгийн нөөц боломжыг тодорхойлж, орон нутгийн нөхцөл байдлыг үнэлэхэд зориулагдсан болно. Үүнд яаралтай буюу орон нутагт байгаа нөөц боломж дээр нэмэлт шаардлагатай гадаад нөөц боломж, эх үүсвэрийг тогтооход чиглэгдсэн асуултууд ороогүй.

1. Ерөнхий асуултууд

- Хэдий тооны хүн гамшигт өртсөн, хаана байгаа болох? Хүний тоог хүйс, нас болон хөдөлмөрийн чадваргүй гэх мэт үзүүлэлтүүдээр аль болох дундажлаж гаргах.
- Хүмүүс хаашаа нүүх хандлагатай байдаг вэ? Гамшигт өртсөн хүмүүс болон тусламжийн ажлын аюулгүй байдлын хүчин зүйл нь юу вэ?
- Ус болон ариутгалтай холбоотой ямар өвчин байгаа болох эсвэл үүсэх магадлалтай байна вэ? Тулгарсан бэрхшээлийн цар хүрээ болон өөрчлөгдөх магадлал ямар байна вэ?
- Зөвлөгөө авч холбоо барих гол хүмүүс хэн бэ?
- Хүн ам доторхи эмзэг бүлгийн хүмүүс гэж хэн бэ яагаад тэгж нэрлэсэн бэ?
- Бэлэн байгаа барилга байгууламж хүн болгонд тэгш хүртээмжтэй байж чадаж байна уу?
- Эмэгтэйчүүд болон охидын хувьд ямар аюул учирч болох вэ?
- Онцгой байдал үүсэхээс өмнө тухайн хүн амын хэвшсэн ус ба ариутгалын ажил нь ямар байсан бэ?

2. Усны хангамж

- Одоо байгаа усны эх үүсвэр нь юу болох мөн одоогийн хэрэглэгчид нь хэн бэ?
- Нэг хүн өдөрт хэдий хэмжээний ус хэрэглэх боломжтой вэ?
- Ус хангамжын өдөр тутмын болон долоо хоног тутмын давтамж ямар байна вэ?
- Ус хангамж нь хүн ам дах бүх бүлгийн богино хугацааны болон урт хугацааны хэрэглээг хангахад хүрэлцээтэй байна уу?

- Ус зөөх цэг хүмүүсийн амьдардаг газартай хангалттай ойрхон байж чадаж байна уу? Тэр нь аюулгүй юу?
- Одоо байгаа ус хангамж хангалттай юу? Хэр удаан байх вэ?
- Хүмүүст тохирсон хэмжээ болон төрлийн хангалттай усны сав байгаа юу?
- Усны эх үүсвэр бохирдсон эсвэл бохирдох аюултай байна уу (микробиологийн эсвэл химийн/радиологийн)?
- Усыг цэвэршүүлэх шаардлагатай юу? Цэвэршүүлэх боломжтой юу? Ямар төрлийн цэвэршүүлэлт шаардлагатай байна вэ?
- Ус бохирдоогүй боловч халдваргүйжүүлэлт шаардлагатай юу?
- Ойр хавьд өөр усны эх үүсвэр байна уу?
- Усыг зөөх, нөөцлөх болон хэрэглэхтэй холбоотой уламжлалт сүсэг бишрэл болон тогтсон заншилтай юу?
- Бэлэн байгаа ус хангах тогтолцоог ашиглахад ямар нэг хүндрэл байна уу?
- Усны эх үүсвэр хүрэлцээгүй тохиолдолд хүн амыг нүүлгэх боломжтой юу?
- Усны эх үүсвэр хангалтгүй бол усыг баканд нөөцлөх боломжтой юу?
- Ус хангамжтай холбоотой хамгийн гол эрүүл ахуйн асуудал юу вэ?
- Хүмүүст усыг аюулгүй хэрэглэх арга хэрэгсэл байгуу юу?

3. Ялгадсыг хаях

- Бие засч байгаа одоогийн арга хэлбэр нь ямар байна вэ? Хэрвээ ил бие засч байгаа бол тусгайлан заасан газар байгаа юу? Тэр газар нь аюулгүй юу?
- Ялгадсыг хаяхтай холбоотой хүйсний гэх мэт сүсэг бишрэл болон тогтсон заншил байна уу?
- Бэлэн барилга байгууламж байна уу? Хэрвээ байгаа бол ашиглаж байгаа эсэх, хүрэлцээтэй эсэх мөн найдвартай ажиллаж байна уу? Нэмж өргөтгөх буюу засаж өөрчлөх боломжтой юу?
- Бие засч байгаа одоогийн арга хэлбэр усны хангамж болон амьдрах орчинд аюул учруулж байна уу?

- Хүмүүс бие зассаныхаа дараа болон хоол идэх буюу бэлдэхийн өмнө гараа угааж байна уу? Саван болон бусад цэвэрлэгээний материалтай байна уу?
- Хүмүүс бие засах газрыг барих болон ашиглах талаар мэдлэг хэр байна вэ?
- Бие засах газрыг барихад орон нутагт ямар материалын нөөц байна вэ?
- Хүмүүс ялгадасны нүх, бие засах ил талбай болон шуудууг ашиглахад бэлэн байна уу?
- Бие засах ил газар, ялгадасны нүх болон жорлонд хангалттай зай байна уу?
- Суваг шуудууны налуу нь ямар байна вэ?
- Гүний усны түвшин ямар байна вэ?
- Ялгадасыг сайт дотор нь хаяхад хөрсний нөхцөл тохирох уу?
- Ялгадасыг хаях одоо мөрдөгдөж байгаа хэвшил халдвар тээгчийг үржих нөхцлийг бүрдүүлж байна уу?
- Бөгсөө угааж цэвэрлэхэд зориулсан ямар нэг материал буюу ус байна уу? Хүмүүс тэр хэрэглэсэн материалаа хэрхэн хаяж байна юэ?
- Эмэгтэйчүүд сарын тэмдэгтэй холбоотой асуудлаа хэрхэн зохицуулж байна вэ? Сарын тэмдэг ирсэн үед хэрэг болох зориулалтын материал байна уу?

4. Халдвар тээгчээс үүсэх өвчин

- Халдвар тээгчээс өвчин халдах магадлал хэр вэ мөн тэр нь хэр аюултай вэ?
- Халдвар тээгч болон халдвар тээгчээс үүсэх өвчинтэй холбоотой ямар нэг сүсэг бишрэл болон тогтсон заншил байна уу? Тэдгээр сүсэг бишрэл болон заншил нь ашигтай буюу ашиггүй эсэх.
- Хэрвээ халдвар тээгчээс өвчин гарах эрсдэл өндөр байвал өртөх магадлалтай хүмүүс өөрийгөө хамгаалах чадвартай юу?
- Халдвар тээгчийн үржлийг зогсоохын тулд тухайн газрын орчинд өөрчлөлт хийх боломжтой юу (бохирын шугам, ялгадасыг зөв хаях, хог хаягдлыг зөв хаях гэх мэт хэлбэрээр)?
- Халдвар тээгчийг химийн аргаар устгах боломжтой юу? Халдвар тээгчийг устгах болон химийн бодисыг ашиглахтай холбоотой ямар нэг хөтөлбөр, зохицуулалт, үйл ажиллагаа байна уу?

- Алий өрхөд ямар төрлийн мэдээлэл болон аюулгүйн анхааруулгыг өгвөл зохих вэ?

5. Хатуу хог хаягдлыг хаях

- Хатуу хог хаягдал асуудал мөн үү?
- Хүмүүс хог хаягдалаа хэрхэн хаяж аюулгүй болгож байна вэ?
- Ямар төрлийн, хэдий хэмжээний хатуу хог хаягдал үүсч байна вэ?
- Хатуу хог хаягдалыг сайт дээр хаяж болох уу эсвэл цуглуулаад сайтаас гадагши гаргаж хаях ёстой юу?
- Гамшигт өртсөн хүмүүс хатуу хог хаягдалаа хэрхэн хаяж байна вэ? (**compost**/хогийн нүх үү? Зөөх тогтолцоотой юу? Хогийн саванд уу?)
- Хог хаягдал үүсгэж байгаа ямар нэг эмнэлгийн байгууллага буюу үйл ажиллагаа байна уу? Хогоо хэрхэн хаяж аюулгүй болгож байна вэ? Хэн хариуцаж байна вэ?

6. Бохирын шугам

- Бохирын шугамтай холбоотой ямар нэг хүндрэл бэрхшээл байна уу (байр сууц эсвэл бие засах газар үерт автах, халдвар тээгч үржих газар, амьдрах орчин болон ус хангамжыг бохирдуулж буй бохирдсон ус)?
- Намгийн ус хөрсөнд нөлөөлж байна уу?
- Хүмүүс үер усны аюулаас өөрсдийн байр сууц болон бие засах газраа хамгаалах боломж байна уу?

ХАВСРАЛТ 2

Байгууллага болон бусад хэрэгцээнд шаардагдах усны доод хэмжээний чиглэлийг төлөвлөх

Эрүүлмэндийн төвүүд ба эмнэлгүүд	5 литр / гэрээр эмчлүүлэгч 40-60 литр/хэвтэж эмчлүүлэгч/өдөр Угаалгын төхөөрөмж, урсдаг жорлон гэх мэтэд нэмэлт ус хэрэгтэй болж болно.
Холерийн Төвүүд	60 литр/өвчтөн/өдөр 15 литр/асрагч/өдөр
Эмчилгээний хоолны төвүүд	30 литр/хэвтэж эмчлүүлэгч/өдөр 15 литр/асрагч/өдөр
Сургууль	3 литр/сурагч/өдөр уух, гараа угаах хэрэгцээнд (жорлонд хэрэглэгдэх усыг тооцоогүй болно: доор үзнэ үү).
Сүм	2-5 литр/хүн/өдөр угаах болон уух хэрэгцээнд
Нийтийн бие засах газар	1-2 литр/хэрэглэгч/өдөр гар угаах хэрэгцээнд 2-8 литр/нэг тасалгаа/өдөр жорлонг цэвэрлэх хэрэгцээнд
Урсдаг бүх жорлон	20-40 литр/хэрэглэгч/өдөр бохирын шугамд холбогдсон урсдаг боловсон жорлонгийн хэрэгцээнд 3-5 литр/хэрэглэгч/өдөр
Бөгсөө угаах	1-2 литр/нэг хүн/өдөр
Мал амьтан	20-30 литр/том ба дунд зэргийн амьтан/өдөр 5 литр/жижиг амьтан/өдөр
Бага хэмжээний усжуулалтын систем	3-6мм/м2/өдөр. Гэхдээ янз бүр байна.

ХАВСРАЛТ 3

Гамшгийн үед Олон нийтийн Газар болон Байгууллагуудад Байх ёстой бие засах газрын хамгийн доод тооны үндсэн чиглэлийг төлөвлөх.

Байгууллага	Богино хугацаа	Урт хугацаа
Зах	50 лангуу тутамд 1 жорлон	20 лангуу тутамд 1 жорлон
Эмнэлэг/эрүүлмэндийн төвүүд	20 ор эсвэл 50 гэрээр эмчлүүлэгч тутамд 1 жорлон	10 ор эсвэл 20 гэрээр эмчлүүлэгч тутамд 1 жорлон
Хоолны төвүүд	Насанд хүрсэн 50 хүн тутамд 1 жорлон 20 хүүхэд тутамд 1 жорлон	Насанд хүрсэн 20 хүн тутамд 1 жорлон 10 хүүхэд тутамд 1 жорлон
Хүлээн авах болон/дамжих төвүүд	50 хүн тутамд 1 жорлон 3:1 эмэгтэй ба эрэгтэй	
Сургууль	30 охинд 1 жорлон 60 хөвгүүнд 1 жорлон	30 охинд 1 жорлон 60 хөвгүүнд 1 жорлон
Албан өрөө	20 ажилтанд 1 жорлон	

ХАВСРАЛТ 4

Ус ба ялгадастай холбоотой өвчин ба түүний халдварлах механизм

Уснаас үүссэн эсвэл усаар угаасан	Холер/Cholera, shigellosis, суулгах, салмонеллёз/ salmonellosis гэх мэт	Бохир гарын бактерийн	Ус бохирдох
	Typhoid, paratyphoid гэх мэт		Ариутгал муу
	Амёбийн дизентери, giardiasis	Бохир гарын бактерийн бус	Хувийн ариун цэвэр муу
	А гепатит, poliomyelitis, rotavirus гүйлгэх		Үр бохирдох
Усаар угаасан эсвэл ус дутагдсанаас	Арьс нүдний халдвар		Усны хүрэлцээ муу
	Бөөснөөс гаралтай хижиг ба халуурлах		Хувийн ариун цэвэр муу
Ялгадастай холбоотой helminthes	Roundworm, hookworm, whipworm	Хөрсөөр дамждаг helminthes	Ил бие засах Хөрс бохирдох
Үхэр болон гахайн махны төрлийн өт	Taeniasis	Хүн-амьтан	Дутуу болгосон мах Хөрс бохирдох
Усан суурьт	Schistosomiasis Guinea өт Clonorchiasis	Бохирдсон усанд удаан зогсох	Ус бохирдох
Устай холбоотой халдвар тээгч шавьж Ялгадастай холбоотой халдвар тээгч шавьж	Malaria, dengue, sleeping sickness, filariasis гэх мэт	Ялаа шумууланд хазуулах	Усны ойрхон
	Гүйлгэх ба дизентери	Ялаа болон жоомоор дамжина	Усанд үрждэг Бохир орчин

ХАВСРАЛТ 5

Ашигласан ном бүтээл

Оксфордын Их Сургуулийн Дүрвэгсдийн Судалгааны Төвийн Албадмал Шилжилт Хөдөлгөөний Онлайн хөтөлбөрийн ачаар эдгээр бичиг баримтын ихэнхи нь зохиогчын эрхийн зөвшөөрөлтэй болсон ба тусгай веб хуудсан дээр тавигдсан: <http://www.forcedmigration.org>

Олон улсын хууль эрхзүйн актууд

Ус Хэрэглэх Эрх (Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Олон Улсын Гэрээний 11 ба 12-р зүйл), CESCR Ерөнхий Тайлбар 15, 2002 оны 11 сарын 26, НҮБ Баримт E/C.12/2002/11, Эдийн Засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хороо.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэрээ Хэлэлцээрийн Цуглуулга: <http://untreaty.un.org>

Миннесотагийн Их Сургуулийн Хүний Эрхийн Номын Сан: <http://www1.umn.edu/humanrts>

http://www.who.int/water_sanitation_health/Documents/righttowater/righttowater.htm

Ерөнхий

Adams, J (1999) гамшгийн үеийн усны хангамж ба эрүүл ахуй. Oxfam GB

Cairncross, S ба Feachem, R (1993) Халуун оронд орчны эрүүл ахуйн төлөвлөлт 2 дахь хэвлэлт John Wiley & Sons Ltd, Chichester, UK

Davis, J ба Lambert, R (2002) Гамшгийн үеийн төлөвлөлт: тусламжийн ажилтнуудад гарын авлагав – дахь хэвлэлт RedR/IT Publications, London

Drouarty, E and Vouillamoz, JM (1999) Alimentation en eau des populations menaces. Hermann, Paris

Олон Улсын судалгааны төвийн вэбхуудас (Голланд) <http://www.irc.nl/publications/>

MSF (1994) Гамшгийн үеийн нийтийн эрүүл мэндийн төлөвлөлт. Анхны хэвлэлт. Medecins Sans Frontieres, Paris

UNHCR (1999), Гамшгийн гарын авлага. 2 дахь хэвлэлт. Geneva. <http://www.unhcr.ch>

Ус, техник хөгжлийн төв (WEDEC) Loughborough University, UK. <http://www.lboro.ac.uk>

WHO Гамшгийн эрүүл мэндийн лавлах: <http://www.helid.desastres.net/>

WHO Ус, эрүүл ахуй, эрүүл мэндийн хөтөлбөр: http://www.who.int/water_sanitation_health

Ариун цэврийн судалгаа

ARGOSS гарын авлага: <http://www.bgs.ac.uk>

Хүйс

Хүйс ба усны холбоо: <http://www.genderandwateralliance.org>

Лалын дэлхийн эрүүл мэндийн сүлжээ. Islamic Supercourse Lectures. Эрүүл мэндийн сурталчилгаа, хүүхдийн эрүүл мэнд ба Лалын шашин: <http://www.pitt.edu>

WCRWC/UNICEF (1998), Дотоодын шилжин суурьшилтын хүйсийн хэмжээ. Дүрвэж буй эмэгтэйчүүд хүүхдүүдийн Холбоо, New York

Эрүүл ахуйн суртал сурталчилгаа

Almedom, A, Blumental, U and Manderson, L (1997), Эрүүл ахуйн үнэлгээ хийх журам: ус болон урүүл ахуйн нөхцлүүдийг үнэлэх арга барилууд. Хөгжиж буй орнуудын Олон улсын хүсний тэжээлийн сан. Intermediate Technology Publications, Southampton Row, London WC1, UK.

Benenson, AS, ed.(1995), Халдварт өвчний хяналт гарын авлагав 16 дахь хэвлэлт. American Public Health Association

Ferron, S, Morgan, J and O'Reilly, M (2000), Эрүүл ахуйн суртал сурталчилгаа: Тусламжийн болон хөгжлийн хөтөлбөрт зориулсан гарын авлага. Oxfam GB.

Усны хангамж

FAO: <http://www.fao.org>

House, S and Reed, R(1997), Гамшгийн үеийн усны эх үүсвэр: Сонголт хийх ба цэвэршүүлэлтийн заавар WEDEC, Loughborough University, UK.

Усны чанар

WHO (2003), Ундны усны чанарын талаарх заавар. 3 дахв хэвлэлт. Geneva

Ялгадасын устгал

Harvey, PA, Baghri, S and Reed, RA (2002), Гамшгийн үеийн ариун цэвэр, үнэлгээ ба хөтөлбөр боловсруулах. WEDEC, Loughborough University, UK.

Pickford, J (1995), Хамгийн хямд эрүүл ахуй. Бодит туршлагад үндэслэсэн судалгаа. IT Publications, London.

Халдвар тээгчийн устгал

Hunter, P (1997) Уснаас гаралтай халдварт өвчин: Тахал судлал ба экологи. John Wiley & Sons Ltd, Chinchester, UK.

Lacarin, CJ and Reed, RA (1999), Гамшгийн үед халдвар тээгчийг химийн аргаар устгах нь. WEDEC, Loughborough University, UK.

Thomson, M (1995), Халдвар тээгчийг хянах замаар халдварт өвчнөөс сэргийлэх нь: Тусламжийн байгууллагуудад зориулсан заавар. Oxfam GB

UNHCR (1997), Дүрвэх үед халдварт өвчин тээгч болон шавьж хорхойг хянах нь. UNHCR, Geneva

Warrell, D and Gilles, H, eds. (2002), Ерөнхий хумхаа өвчний судлал. 4 дэх хэвлэлт. Arnold, London

WHO, Халдвар тээгч хортон шавьжийг устгах химийн аргууд. <http://www.who.int>

WHO, Хортон шавьжны хорыг үнэлэх схем (WHOPES), нийгмийн эрүүл мэндэд зориулж хортон шавьж устгах хор худалдан авах заавар. <http://www.who.int>

Хатуу хог хаягдал

Хог хаягдлын цэгийг төлөвлөх: <http://www.lifewater.org>

Олон улсын хатуу хог хаягдлын холбоо: <http://www.iswa.org>

Эмнэлгийн хаягдал

Pruss,A, Giroult,E, Rushbrook,P, eds. (1999), Эмнэлгийн хаягдлын аюулгүй менежмент WHO, Geneva

WHO: <http://www.healthcarewaste.org>

WHO: <http://www.injectionsafety.org>

Бохирын систем

Байгаль орчныг хамгаалах агентлаг (EPA) (1980), Төлөвлөлтийн гарын авлага: Газар дээр нь бохирын ус цэвэршүүлэх ба устгах систем, Report EPA-600/2-78-173. Cincinnati

3-р бүлэг

Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл, хүнсний тусламжийн хамгийн бага үзүүлэлтийн стандарт

103

Энэ бүлгийг хэрхэн ашиглах вэ

Энэхүү бүлэг нь 1. Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн үнэлгээ болон шинжилгээний стандарт. 2. Хүнсний аюулгүй байдлын стандарт. 3. Тэжээлийн стандарт. 4. Хүнсний тусламжийн стандартууд дөрвөн хэсгээс бүрдэнэ. Хүнсний аюулгүй байдал ба хоол тэжээлийн стандарт нь хүнс тэжээл хэрэглэх эрхийн бодит тунхаглал байдаг бол Хүнсний тусламжийн стандартууд нь үйл ажиллагаан тал руу илүү чиглэсэн байдаг. Хүнсний тусламжийн стандартууд нь хүнсний аюулгүй байдал ба тэжээлийн стандартуудыг хангахад тус болно.

Хэсэг болгон нь дараахь мэдээллийг агуулна. Үүнд:

Минимум стандартууд: эдгээр нь үндсэндээ чанарын хэмжүүрүүд бөгөөд хүнсний аюулгүй байдал, тэжээл, хүнсний тусламжийн арга хэмжээг хэрэгжүүлэх үед тавигдах хамгийн бага үзүүлэлтүүд юм.

Үндсэн үзүүлэлтүүд: эдгээр нь стандартын хэмжээнд хүрсэн эсэхийг тодорхойлох “дохионууд” юм. Эдгээр нь хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд, үйл явц, хэрэглэсэн аргын үр нөлөө ба үр дүнг харуулах хэрэгсэл болдог. Үзүүлэлтүүд нь чанарын болон тоон хэмжүүртэй байж болно.

Заавар тэмдэглэл: эдгээр нь янз бүрийн нөхцөл байдалд хэрэглэх стандартууд ба үзүүлэлтүүд, бодит хүндрэлийг шийдэх удирдамж, ач холбогдол бүхий асуудлуудын талаархи зөвлөгөөг ашиглах үед анхаарах зүйлүүдийг зааж өгнө. Эдгээр нь стандартууд болон үзүүлэлтүүдтэй холбоотой чухал асуудлуудад анхаарал хандуулж өнөө үед хуримтлагдсан мэдлэгийн зөрчилтэй асуудлууд, сул талуудыг тодорхойлно.

Энэхүү бүлгийн төгсгөлд байгаа хавсралтуудад үнэлгээнд ашиглах жагсаалт, хүнсний аюулгүй байдлын арга хэмжээний жишээнүүд, хүнсний хурц хомсдлыг хэмжих ба бичил тэжээлийн хомсдол нь нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг тодорхойлох, хүнс тэжээлийн шаардлага болон энэхүү бүлэгтэй холбоотой ерөнхий болон тодорхой мэргэжлийн асуудлуудын талаархи мэдээллийн эх үүсвэрийг багтаасан сонгосон номын жагсаалт орсон байгаа.

Агуулга

Оршил

Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн үнэлгээ ба шинжилгээ

Хүнсний аюулгүй байдал

Тэжээл

i. Хүнс тэжээлийн ерөнхий тусламж

ii. Хүнс тэжээлийн хомсдлыг арилгах арга хэмжээнүүд

4. Хүнсний тусламж

i. Хүнсний тусламжийн төлөвлөлт

ii. Хүнсний тусламжийн менежмент

Хавсралт 1. Хүнсний аюулгүй байдлын аргачлал ба тайлангийн жагсаалт

Хавсралт 2. Хүнсний аюулгүй байдлын үнэлгээний жагсаалт

Хавсралт 3. Хүнсний аюулгүй байдлын арга хэмжээнүүд

Хавсралт 4. Тэжээлийн үнэлгээний жагсаалт

Хавсралт 5. Тэжээлийн хурц хомсдлын хэмжүүрүүд

Хавсралт 6. А витамин ба иодын дутагдлын нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

Хавсралт 7. Тэжээлийн шаардлагууд

Хавсралт 8. Нийлүүлэлтийн сүлжээний хангамжийн жагсаалт

Хавсралт 9. Ном зүй

Хүнсний аюулгүй байдал, тэжээл, хүнсний тусламж

Стандарт 1
Хүнсний аюулгүй байдлын
үнэлгээ ба стандарт

Стандарт 2
Тэжээлийн үнэлгээ ба шинжилгээ

Хүнсний аюулгүй байдал	Тэжээл	Хүнсний тусламж
	Тэжээлийн ерөнхий дэмжлэг	Хүнсний тусламж
	Тэжээлийн хомсдлыг арилгах	Хүнсний тусламжийн менежмент

Стандарт 1 Хүнсний ерөнхий аюулгүй байдал	Стандарт 1 Бүх бүлгийнхэн	Стандарт 1 Бага хэмжээний тэжээлийн хомсдол	Стандарт 1 Төлөвлөлт	Стандарт 1 Түгээлтийн харьцах	Хүнстэй
---	------------------------------	---	-------------------------	-------------------------------------	---------

Стандарт 2 Анхдагч үйлдвэрлэл	Стандарт 2 эрсдэлтэй бүлгийнхэн	Стандарт 2 тэжээлийн хурц хомсдол	Стандарт 2 тохиромжтой байдал ба хүлээн авах боломж	Стандарт 2 сүлжээний менежмент
-------------------------------------	---------------------------------------	---	---	--------------------------------------

Стандарт 3 Орлого ба ажил	Стандарт 3 бичил тэжээлийн хомсдол	Стандарт 3 хүнсний чанар ба аюулгүй байдал	Стандарт 3 Түгээлт
------------------------------	--	--	-----------------------

Стандарт 4
Зах зээлд нэвтрэх боломж

Хавсралт 1

Хүнсний аюулгүй байдлын аргачлал ба тайлан гаргах хуудас

Хавсралт 2

Хүнсний аюулгүй байдлын хуудас

Хавсралт 3

Хүнсний аюулгүй байдлын арга хэмжээнүүд

Хавсралт 4

Тэжээлийн үнэлгээний хуудас

Хавсралт 5

Тэжээлийн хомсдлыг хэмжих

Хавсралт 6

А витамин ба иодын дутагдлын нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

Хавсралт 7

Тэжээлийн шаардлагууд

Хавсралт 8

Нийлүүлэлтийн сүлжээний хангамжийн хуудас

Хавсралт 9

Ашигласан бүтээлүүд

Оршил

Олон улсын хуулийн бичиг баримтуудтай холбогдох нь

Хүнсний аюулгүй байдал, тэжээл, хүнсний тусламжинд тавигдах хамгийн доод үзүүлэлтийн стандартууд нь хүмүүнлэгийн тунхаглалд тусгагдсан зарчмууд ба эрхүүдийн бодит илэрхийлэл юм. Хүмүүнлэгийн тунхаглал нь гачигдал зовлон зэвсэгт мөргөлдөөний улмаас золиослогдсон хүмүүсийн амьдрал ба нэр хүндийг хамгаалах үндсэн шаардлагууд бөгөөд олон улсын хүний эрх, хүмүүнлэг, дүрвэлтийн талаархи хуулиудад тусгагдсан байдаг.

Хүн болгон шаардлагатай хэмжээний хүнс тэжээл хэрэглэх эрхтэй. Энэ эрхийг олон хуулийн бичиг баримтуудад хүлээн зөвшөөрсөн байдаг бөгөөд үүнд өлсөхгүй байх эрх хамаарна. Шаардлагатай хэмжээний хүнс тэжээл хэрэглэх эрхэд дараахи зүйлүүд хамаарна. Үүнд:

- Хүнс тэжээл нь тухайн соёлын орчинд хүлээн авдаггүй бодис оруулахгүйгээр хувь хүмүүсийн хүнсний шаардлагыг чанарын ба тоон үзүүлэлтээр хангах, хангалттай хэмжээний олдоцтой байх ёстой
- эдгээр хүнсний бүтээгдэхүүнүүдийн олдцыг тогтвортой хэмжээнд байлгах ба бусад хүний эрхийг хэрэгжүүлэхэд саад болохгүй байх ёстой

Төрийн болон төрийн бус оролцогч талууд нь хүний хоол хүнс хэрэглэх эрхийг хэрэгжүүлэхэд хариуцлага хүлээнэ. Эдгээр үүрэг болон олон улсын хуулийн заалтын зөрчил жишээ нь дайны тактик хэлбэрээр хүн амыг өлсгөлөнд нэрвүүлэх юм уу тэдний амьдралыг сүйтгэх явдал нь олон тохиолдолд хүнсний аюулгүй байдал, тэжээлийн нөхцөлд маш муу нөлөө үзүүлдэг. Зэвсэгт мөргөлдөөний үед тэмцэлдэж байгаа талууд нь хүнсний зүйл болон үр тариа ургац, мал амьтанд зориулагдсан нутгийг эзлэх, устгахыг хориглосон байдаг. Ийм нөхцөлд хүмүүнлэгийн салбарынхан эрх нь зөрчигдсөн хүн амын эрхийг сэргээх жишээ нь тухайн улсын болон олон улсын хуулийн дагуу хоол хүнсээр хангах арга хэмжээ авч болно.

Энэхүү бүлэгт заасан хамгийн доод үзүүлэлтийн стандартууд нь шаардлагатай хүнс хэрэглэх эрхийн бүрэн илэрхийлэл биш юм. Гэхдээ эдгээр стандартуудад хоол хүнс хэрэглэх эрхийн үндсэн агуулга тусгагдсан ба энэ эрхийг дэлхий дахинд улам хурдацтайгаар хэрэгжүүлэхэд тус болдог.

Гамшгийн үеийн хүнсний аюулгүй байдал, тэжээл, хүнсний тусламжийн ач холбогдол

Хоол хүнсийг олдоцтой байлгах ба тэжээлийн түвшнийг шаардлагатай хэмжээнд барих нь гамшгийн үед хүмүүс амьд үлдэх гол хүчин зүйл болдог. Хүнсний хомсдол нь нийгмийн эрүүл мэндийн хамгийн чухал асуудал учраас нас баралтын шууд болон шууд бус үндсэн шалтгаан байж болно. Амьжиргааны уян хатан байдал ба хүмүүсийн хэрэглээний хүнсний аюулгүй байдал нь хүний эрүүл мэнд, хоол тэжээлийн нөхцөл байдал, амьд гарах боломж, сайн сайхан байдлыг тодорхойлно. Хүнсний тусламж нь цогц арга хэмжээний нэг хэсгийн хувьд хүнсний аюулгүй байдал ба тэжээлийн нөхцөл байдлыг хамгаалахад чухал үүрэгтэй байж болно.

Хүнсний аюулгүй байдлын стандарт нь тэжээлийн болон хүнсний тусламжийн стандартуудаас илүү ерөнхий агуулгатай байдаг нь хүнсний аюулгүй байдал олон талыг хамарсан нарийн түвэгтэй салбар боловч гамшгийн нөхцөлд ажиллах туршлагатай байгууллага цөөхөн байдагтай ихээхэн холбоотой.

Энэ бүлэгт дараахи нэр томъёонуудыг ашигласан болно . Үүнд:

- **Хүнсний аюулгүй байдал** нь бүх хүмүүс эрүүл бөгөөд идэвхтэй амьдрахын тулд үргэлж хангалттай, аюулгүй, тэжээллэг хоол хүнс хэрэглэх бодит ба эдийн засгийн боломжтой байх үед бий болдог (1996 оны Дэлхийн хүнсний дээд хэмжээний уулзалтын Үйл ажиллагааны төлөвлөгөөний 1-р хэсэг)
- **Амьжиргаа** гэдэгт амьд үлдэх ба ирээдүйн сайн сайхан амьдралаа хангахтай холбоотой амьдрах хэрэгслийг хангахад шаардлагатай чадвар, эд хөрөнгө (материаллаг болон нийгмийн баялгууд) ба үйл ажиллагаанууд хамаарна. *Амьжиргааны стратеги* гэдэг нь хүмүүс хоол хүнс юм уу хоол хүнс худалдаж авах орлого олохын тулд ашигладаг практик арга, үйл ажиллагаа бол *зохицох стратеги* гэдэг нь хүнсний аюулгүй байдлыг шийдэх түр зуурын арга хэмжээ юм.
- **Хүнс тэжээлийн хомсдол** гэдэгт хурц болон архаг хүнсний хомсдол мөн бичил тэжээлийн хомсдол зэрэг олон янзын нөхцөл байдлууд хамаарна. Тэжээлийн хурц хомсдол гэдэг нь тураал ба тэжээлийн доройтлыг хэлдэг ба архаг хүнсний хомсдол гэдэг нь давжаарлыг хэлнэ. Давжаарал ба тураал нь өсөлтийн гажуудлын хоёр өөр хэлбэр юм. Энэ бүлэгт бид зөвхөн хүнсний хурц хомсдол ба бичил тэжээлийн хомсдлын талаар өгүүлэх болно.

Эмэгтэйчүүд өрх гэрийн хоол хүнсийг ерөнхийд нь хариуцдаг бөгөөд тэд хүнсний тусламжийг авдаг гол хүмүүс байдаг учраас боломжтой бол тэдгээрийг хөтөлбөрийг боловсруулах ба хэрэгжүүлэхэд оролцуулах нь зүйтэй.

Бусад бүлгүүдтэй холбогдох нь

Бусад бүлгүүдэд тайлбарлах стандартууд нь энэ бүлэгтэй холбоотой. Нэг салбарт стандартыг хэрэгжүүлэх нь бусад салбаруудад нөлөөлдөг ба тэр байтугай тэдгээр салбаруудад гарах ахиц дэвшлийг тодорхойлдог. Үйл ажиллагааг үр дүнтэй болгохын бусад салбаруудтай нягт хамтран ажиллаж харилцан зохицуулалт хийх шаардлагатай. Орон нутгийн удирдлага болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажилласнаар хэрэгцээ шаардлагыг хангах, үйл ажиллагаагаа давхцуулахгүй байх, хүнсний аюулгүй байдал, тэжээл, хүнсний тусламжийн ажиллагааны чанарыг дээд зэрэгт хүргэхэд зайлшгүй шаардлагатай. Жишээ нь: гал тогооны хэрэгсэл, хүнсний хэрэглээний түлш ба усанд тавигдах шаардлага, нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад тавигдах шаардлага нь Ус, Эрүүл ахуй, Ариун цэвэр, Эрүүл мэндийн үйлчилгээ, Орон гэр, Байршил, Хүнсний бус зүйлүүдийн хэрэгцээ шаардлагад заагдсан байгаа. Эдгээр шаардлагууд нь өрх гэрүүд хоол хүнсээ олж тэжээлийн хэмжээг зохих түвшинд байлгахад шууд нөлөөтэй. Тодорхой стандартууд ба удирдамжийн тайлбарыг шаардлагатай үед бусад бүлгүүдэд иш татсан байгаа.

Бүх салбаруудад хамаарах ерөнхий стандартууд

Аливаа үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх үйл явц нь түүний үр дүнд чухал нөлөөтэй. Энэ бүлгийг оролцоо, анхны үнэлгээ, хариу арга хэмжээ, зорилго, хяналт, дүгнэлт, ажилтнуудын чадвар ба хариуцлага, ажилтнуудын хянах, удирдах, дэмжихэд хамаарах бүх салбаруудын ерөнхий стандартуудтай хамт ашиглах ёстой /21-р хуудасны 1-р бүлгийг үзнэ үү/. Ялангуяа гамшигт нэрвэгдсэн хүмүүс, тэр дундаа дор дурьдсан эмзэг бүлгийн оролцоог дээд хэмжээгээр нэмэгдүүлснээр тухайн ажиллагааны тохиромжтой байдал ба чанарыг баталгаажуулахад зайлшгүй шаардлагатай.

Гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн эмзэг байдал ба давуу талууд

Гэнэтийн нөхцөлд хамгийн их эрсдэлд өртдөг бүлгүүд бол эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настнууд, тахир дутуу хүмүүс, ХДХВ-ийн халдвартай хүмүүс юм. Тодорхой нөхцөл байдалд хүмүүс гарал угсаа, шашны болон улс төрийн харьяалал, шилжих хөдөлгөөн зэргээс шалтгаалж эмзэг байдалд орж болно. Эдгээр нь бүгдийг хамруулсан жагсаалт биш боловч хамгийн түгээмэл тохиолддог хэлбэрүүд юм. Тодорхой эмзэг байдал нь хүмүүсийн зохицох чадвар ба гамшгийн үед амьд үлдэх чадварт нөлөөлдөг бөгөөд тухайн нөхцөл байдал бүрт хамгийн их эрсдэлд өртөж байгаа хүмүүсийг тогтоох ёстой.

Гарын авлагын бүх хэсэгт гарч байгаа “эмзэг бүлэг” гэсэн нэр томъёо нь тэдгээр бүх бүлгүүдэд хамаарна. Аливаа нэг бүлэг эрсдэлд өртсөн үед бусад бүлгүүд ч гэсэн аюулд өртөх магадлалтай байдаг. Тийм учраас эмзэг бүлгийн талаар дурьдах бүрт уншигчид энд нэр дурьдсан бүх хүмүүсийг ойлгох ёстой. Гамшигт өртсөн бүх бүлгүүдийг ялгаварлалгүйгээр тэдгээрийн өөрсдийн хэрэгцээ шаардлагад нь нийцүүлэн хамгаалж хүнсээр хангахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Гэхдээ гамшигт нэрвэгдсэн хүмүүс нь өөрсдөө зохицох чадварыг эзэмших боломжтой байдаг гэдгийг санаж түүнийг нь хүлээн зөвшөөрч дэмжих ёстой.

Хамгийн доод үзүүлэлтийн стандартууд

Хүнсний аюулгүй байдал болон тэжээлийн үнэлгээ ба шинжилгээ

Энэ хоёр стандарт нь анхны үнэлгээ (29-р хуудсыг үзнэ үү) ба оролцооны стандартаас (28-р хуудсыг үзнэ үү) гаралтай бөгөөд энэ хоёрыг тэжээлийн болон хүнсний аюулгүй байдлын арга хэмжээ авах төлөвлөгөө гаргах юм уу түүнийг дэмжихэд хэрэглэнэ. Хурц хямралын үед яаралтай арга хэмжээ авахын тулд яаралтай тусламж шаардлагатай эсэхийг тогтоох түргэвчилсэн үнэлгээ явуулахад хангалттай бөгөөд энэ тохиолдолд шаардлагатай заалтуудыг өгнө. Үнэлгээний жагсаалтыг 172-179-р хуудсан дээрх 1-3-р хавсралтан дээр өгөв.

Үнэлгээ ба шинжилгээний стандарт 1:

Хүнсний аюулгүй байдал

Хүмүүс хүнсний аюулгүй байдлын эрсдэлд өртсөн үед хөтөлбөртэй холбоотой шийдвэрийг гаргахдаа тэдгээр хүмүүсийн хоол хүнсний олдоц, тухайн гамшгийн одоогийн болон ирээдүйн хүнсний аюулгүй байдалд үзүүлэх нөлөөг бүрэн ойлгосны үндсэн дээр гаргах ёстой ба үүний дагуу хамгийн тохиромжтой арга хэмжээг авна.

Үндсэн үзүүлэлтүүд: /Заавар тэмдэглэлтэй хамт уншина/

- Үнэлгээ ба шинжилгээ, газарзүйн байрлал ба амжиргааны түвшний янз бүрийн бүлгүүдийн хүнсний аюулгүй байдлыг улирал бүр цаг хугацааны явцад тодорхойлж чухал ач холбогдолтой шаардлагуудыг олж тогтооно. /Заавар тэмдэглэл 1-г үзнэ үү/

- Үнэлгээ нь хүнсний аюулгүй байдалд нөлөөлдөг илүү өргөн хүрээний нийгмийн, эдийн засгийн болон улс төрийн бодлого, институцууд, үйл явцын талаарх ойлголтууд дээр үндэслэх ёстой. /Заавар тэмдэглэл 2-г үзнэ үү/
- Үнэлгээнд зохицох стратегийн судалгаа болон шинжилгээ хамаарна. /Заавар тэмдэглэл 3-г үзнэ үү/
- Боломжтой бол үнэлгээг орон нутгийн чадавхи, тэр дундаа албан ёсны болон албан бус институцуудын чадавхийг харгалзан тооцно. /Заавар тэмдэглэл 4-г үзнэ үү/
- Ашигласан аргачлалыг үнэлгээний тайланд дэлгэрэнгүй тайлбарлах ёстой ба эдгээр нь нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудыг баримталсан гэдгийг харуулах ёстой. /Заавар тэмдэглэл 5-г үзнэ үү/
- Олдож байгаа хоёрдогч мэдээллүүдийг ашиглах ба тухайн салбарт хамаарах анхдагч шинэ мэдээллийг цуглуулах ажиллагаа нь шийдвэр гаргахад чухал шаардлагатай нэмэлт мэдээлэл дээр төвлөрнө. /Заавар тэмдэглэл 6-г үзнэ үү/
- Хүнсний аюулгүй байдлын талаар авах шаардлагатай арга хэмжээнүүд нь амжиргааны түвшинг дээшлүүлэх стратегийг дэмжиж хамгаалахын хамтаар зайлшгүй тулгарсан хэрэгцээг хангахад чиглэнэ. /Заавар тэмдэглэл 7-г үзнэ үү/
- Хүнсний аюулгүй байдлын эрсдэл нь хүн амын тэжээлийн нөхцөл байдалд үзүүлэх нөлөөг тооцно. /Заавар тэмдэглэл 8-г үзнэ үү/

Заавар тэмдэглэл

1. **Шинжилгээний хүрээ:** Хүнсний аюулгүй байдал нь хүмүүсийн амжиргаа, тэдний амьдарч байгаа газар ба нийгмийн байр суурь, цаг хугацаа, гамшгийн шинж чанар, хариу арга хэмжээнээс шалтгаалж янз бүр байж болно. Үнэлгээ хийхдээ гамшигт өртсөн хүн амын гамшиг тохиолдохоос өмнө хоол хүнс ба орлогын байдалд ямар өөрчлөлт орсон гэдэг дээр анхаарлаа төвлөрүүлэх ёстой. Жишээ нь: хот болон хотын орчмын газрууд хоол хүнсний зах зээлийн нийлүүлэлтэд анхаарал хандуулах ёстой бол хөдөөгийн хүмүүсийн хувьд хоол хүнсний үйлдвэрлэл дээр голдуу анхаарал төвлөрүүлдэг. Хүмүүс оршин сууж буй газраасаа шилжин нүүсэн тохиолдолд тэднийг хүлээн авч байгаа улсын хүнсний аюулгүй байдлыг тооцож үзэх ёстой. Хүнсний аюулгүй байдлын үнэлгээг хөтөлбөрийг дуусгахаас эсвэл эхлүүлэхээс өмнө гүйцэтгэж болно. Аль ч тохиолдолд үйл ажиллагааны давхцалыг аль болох бага хэмжээнд байлгахын тулд холбогдох талуудын үйл ажиллагааг зохицуулах шаардлагатай. Шинэ мэдээлэл нь одоо байгаа мэдээллүүдийн эх үүсвэрүүдээс авсан хоёрдогч мэдээллийг нөхөх байж ёстой.

2. Орчны нөхцөл: хүнсний аюулгүй байдлын эрсдэл нь үндэсний ба олон улсын бодлого, хүмүүс шаардлагатай хэмжээний тэжээллэг хоол хүнс хэрэглэх боломжид нөлөөлдөг үйл явц юм уу институцүүд зэрэг илүү өргөн хүрээний макро эдийн засгийн ба нийгэм улс төрийн бүтцийн хүчин зүйлүүдээс шалтгаалж үүсч болно. Үүнийг голдуу хүнс тэжээлийн аюулгүй байдлын архаг эрсдэл гэж тодорхойлдог бөгөөд энэ нь бүтцийн тогтворгүй байдлаас шалтгаалж бий болдог удаан хугацааны үйл явц боловч гамшгийн нөлөөгөөр улам хурцдаж болно.

3. Зохицох стратеги: үнэлгээ ба шинжилгээг хийхдээ зохицох олон хувилбар стратегиуд болон хэн түүнийг хэрэглэж байгаа, ямар үр дүнтэй байгаа гэдгийг бодолцох ёстой. Стратеги нь олон янз байж болох боловч зохицох үйл явц нь харилцан адилгүй үе шатуудаас тогтоно. Эхэн үеийн стратеги нь заавал онцгой байх албагүй бөгөөд үүнийг буцаан цуцлах боломжтойгоос гадна түүний үр дагавар удаан хугацаагаар үргэлжилдэггүй. Жишээ нь, байгалын гаралтай хүнс цуглуулах, зайлшгүй шаардлагатай бус хөрөнгийг борлуулах, гэр бүлийн нэг гишүүнийг өөр газар ажиллуулахаар явуулах гэх мэт. Зарим үед хямралын стратеги гэж нэрлэгддэг дараагийн шатны стратегиуд нь газар худалдах, гэр бүлээрээ зовлон гачаалын улмаас нүүн шилжих, ойг устгах гэх мэтээр хүнсний ирээдүйн аюулгүй байдалд муугаар нөлөөлж болно. Эмэгтэйчүүд ба охидуудын хэрэглэдэг зарим стратеги нь тэднийг янхандалт, нууц харилцаа, аюулгүй байдал хангагдаагүй газраар аялах үед бэлгийн хүчирхийлэлд өртөх гэх мэтээр ДОХ-ын халдвар авах илүү өндөр эрсдлийг дагуулдаг. Шилжих хөдөлгөөн ихсэх тусам ДОХ тархах магадлал ихэсч болно. Зохицох стратегиуд нь нийтийн эзэмшлийн байгалын баялгийг хэтрүүлэн ашиглах гэх мэтээр байгал орчинд нөлөөлж болно. Хүнсний аюулгүй байдлыг бүх хохиролгүй хувилбаруудыг ашиглаж дуусахаас өмнө хамгаалах ёстой.

4. Орон нутгийн чадавх: үнэлгээ ба төлөвлөлтийн бүх үе шатуудад орон нутгийн оршин суугчид ба байгууллагууд оролцох нь маш чухал юм. Хөтөлбөрүүд нь хэрэгцээ шаардлага дээр үндэслэсэн байдаг ба тухайн орон нутгийн нөхцөл байдалд тохирсон байх ёстой. Өмнө нь ган юм уу үерт өртсөн орон нутгийн оршин суугчид нь өөрсдийн гэсэн гэнэтийн нөхцөл байдлын төлөвлөгөөтэй байж болно. Орон нутгийн ийм чадавхийг дэмжих нь маш чухал юм.

5. Арга зүй: үнэлгээ ба дээжлэлтийн журам нь албан ёсны бус байсан ч гэсэн хамрах хүрээг нь болгоомжтой тооцож үзэх шаардлагатай. Тайланд тусгасан үйл явц нь логиктой бөгөөд ил тод байх ёстой ба хүнсний аюулгүй байдлыг үнэлэх хүлээн зөвшөөрөгдсөн журмыг мөрдсөн байх ёстой.

Мэдээлэл ба шинжилгээг нь харилцан биенээ нөхсөн, уялдаатай байлгахын тулд мэдээллийг цаг хугацааны явцад харьцуулах боломжтой байхын тулд байгууллагууд нь хоорондоо болон засгийн газартай үйл ажиллагааны аргачлалаа зохицуулах шаардлагатай. Ургацын үнэлгээ, хиймэл дагуулын зураг, айл өрхийн үнэлгээ зэрэг янз бүрийн эх үүсвэрүүдээс авсан мэдээллээс харилцан уялдаатай дүгнэлт гаргаж авахын тулд янз бүрийн эх үүсвэрүүд ба хүнсний аюулгүй байдлын талаархи мэдээллийн төрлүүдийн дотроос сонголт хийх нь маш чухал юм. Үнэлгээнд тооцох ёстой зүйлүүдийн жагсаалт 1-р хавсралтад орсон. Аргачлалыг шалгах жагсаалт 2-р хавсралтад орсон.

6. Мэдээллийн эх үүсвэрүүд: нь хоол хүнсний хэвийн хангамж, янз бүрийн бүлгүүдийн хүнс тэжээл олох боломж, хүнс тэжээлийн аюулгүй байдлын хамгийн их эрсдэлд өртсөн бүлэг, өмнө нь тохиолдож байсан хоол хүнсний хомсдол ба янз бүрийн бүлгүүдийн хоол хүнс авах боломж зэрэг гамшгийн өмнөх нөхцөл байдлын талаархи хоёрдогч мэдээллийг хангалттай авах боломжтой олон эх үүсвэрүүдэд хамаарна. Хоёрдогч мэдээллийг үр дүнтэйгээр ашигласнаар шинэ нөхцөл байдалд хамгийн чухал зүйл дээр анхаарлаа төвлөрүүлэхийн тулд үнэлгээний үед анхдагч мэдээллийг цуглуулах боломж олгодог.

7. Удаан хугацааны төлөвлөлт: хямралын анхны үе шатанд зайлшгүй хэрэгцээгээ хангах ба үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг эд хөрөнгөө хадгалж үлдэх нь чухал байдгаас гадна удаан хугацаанд авах хэмжээг дотроо төлөвлөж байх нь зүйтэй. Үүний тулд олон салбарын мэргэжлийн мэдлэг ба оршин суугчид тэр дундаа бүх бүлгүүдийн төлөөлөгчидтэй нягт хамтран ажиллах чадвартай байх ёстой. Үнэлгээ ба хөтөлбөрийн төлөвлөлтийн бүх үе шатанд оршин суугчид оролцох нь чухал бөгөөд энэ нь хэтийн боломж ба эрсдэлд нөлөөтэй. Зөвлөмжийг зохих боловсрол эзэмшсэн туршлагатай ажилтнууд асуудлыг сайтар ойлгосны үндсэн дээр өгнө. Үнэлгээний багт холбогдох салбарын мэргэжилтнүүд тэр дундаа газар тариалангийн мэргэжилтнүүд, эдийн засагчид, малын эмч нар, нийгмийн шинжлэх ухааны ажилтнууд, ус ба ариун цэвэр болон бусад холбогдох салбарын хүмүүс оролцоно (багт ажиллахад тавигдах шаардлагыг 28-р хуудаснаас үзнэ үү).

8. Хүнсний аюулгүй байдлын эрсдэл ба тэжээллэг байдал: хүнсний аюулгүй байдлын эрсдэл нь тэжээлийн хомсдлын гурван шалтгааны нэг бөгөөд хүнсний аюулгүй байдлын эрсдэл байгаа газар хүнс тэжээлийн хомсдол тэр дундаа бичил тэжээлийн хомсдол заавал байдаг. Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн хүнс тэжээлийн байдалд үзүүлэх нөлөө нь хүнсний аюулгүй байдлыг үнэлэх нэг үндсэн шалгуур юм. Гэхдээ эрүүл мэндийн болон халамж анхаарлаас шалтгаалсан хүчин зүйлүүдийг үгүйсгэж хүнсний аюулгүй байдлын эрсдэл нь хүнс тэжээлийн хомсдлын цорын ганц шалтгаан гэж үзэж болохгүй.

Үнэлгээ ба шинжилгээний стандарт 2: Хүнс тэжээл

Хүмүүс хүнсний хомсдолд орох эрсдэлд орсон үед хөтөлбөрүүд нь тэдгээрийн шалтгаан, түвшин, тэжээлийн хомсдолын зэрэг болон хамгийн тохиромжтой хариу арга хэмжээн дээр үндэслэн боловсруулагддаг.

Үндсэн үзүүлэлтүүд /Заавар тэмдэглэлтэй хамт уншина/

- хүний биеийн хэмжилт явуулахын өмнө тэжээлийн дутагдлын цаад шалтгааны талаархи мэдээллийг шинжилж, тайлан тавих ёстой бөгөөд ингэхдээ асуудлын шинж чанар, асуудлын хүндрэлтэй байдал, хүнс тэжээл ба дэмжлэг хамгийн их шаардлагатай байгаа бүлгүүдийг тодруулах ёстой. /140-р хуудсанд байгаа Заавар тэмдэглэл 1 ба хүнс тэжээлийн тусламжийн ерөнхий стандарт 2-ыг үзнэ үү./
- Тухайн орон нутгийн хүмүүс болон бусад орон нутгийн холбогдох хүмүүсийн хүнс тэжээлийн хомсдолын талаархи санаа бодлыг харгалзан үзнэ. /Заавар тэмдэглэл 1-р тайлбарыг үзнэ үү./
- хүний биеийн хэмжилтийг зөвхөн хөтөлбөрийн шийдвэр гаргах шатанд мэдээлэл ба дүн шинжилгээ шаардлагатай үед л явуулна. /Заавар тэмдэглэл 2-р тайлбарыг үзнэ үү./
- Олон улсын хүний хүний биеийн хэмжилтын удирдамж ба тэдгээртэй нийцсэн үндэстний удирдамжууд нь хүнс тэжээлийн хомсдолын төрөл, түвшин, зэргийг тодорхойлоход зориулагдсан байдаг. /Заавар тэмдэглэл 3-р тайлбарыг үзнэ үү./
- хүний биеийн хэмжилтийг 5-аас доош насны хүүхдүүдийн дунд явуулах үед тэжээлийн хомсдолыг Z оноо ба дундаж хувийг төлөвлөхөд олон улсад ашиглагддаг жин ба өндрийн харьцааг ашигладаг. /Заавар тэмдэглэл 3-р тайлбарыг үзнэ үү./
- Хүн амын бичил тэжээлийн хомсдолд орох эрсдлийг тогтооно. /Заавар тэмдэглэл 4-р тайлбарыг үзнэ үү./
- Хүнс тэжээлийн үнэлгээг хийсний дараа авах арга хэмжээг зөвлөж, орон нутгийн чадварыг зохицуулалтын аргаар нэмэгдүүлнэ.

1. Үндсэн шалтгаанууд: Хүнс тэжээлийн хомсдлын шууд шалтгаанууд нь өвчин, хүнсний хангалтгүй хэрэглээ /хүнсний аюулгүй байдлаас шалтгаална/, нийгмийн эрүүл мэнд, нийгмийн халамжийн хангалтгүй түвшин, гэр бүлийн болон бүлгийн түвшинд эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй байдал зэрэг болно. Эдгээр шалтгаанууд нь хүний, бүтцийн, байгалийн хүчин зүйлүүд, эдийн засгийн нөөц бололцоо, улс төр соёл, аюулгүй байдлын нөхцөл байдал, албан болон албан бус дэд бүтэц, хүн амын хөдөлгөөн /албадлагын болон сайн дурын/, шилжилт хөдөлгөөнд тавих хязгаарлалтаас шалтгаална. Тухайн нөхцөл байдал бүрт хамаарах хүнс тэжээлийн хомсдлын шалтгааныг ойлгох нь хүнс тэжээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болдог. Хүнс тэжээлийн хомсдлын шалтгааны талаархи мэдээллийг анхдагч болон хоёрдогч эх үүсвэр, тэр дундаа эрүүл мэнд ба хүнс тэжээлийн талаархи мэдээллэл, судалгааны тайлан, урьдчилсан сануулга, эрүүл мэндийн төвүүдийн тайлан, хүнсний аюулгүй байдлын мэдээлэл, хүн амын төлөө ажилладаг бүлгүүд орох ба энэ нь чанарын болон тоон мэдээлэл байж болно. Хүнс тэжээлийн үнэлгээний шалгалтын хуудсыг 4-р хавсралтаас харж болно.

2.Шийдвэр гаргах үйл явц: нь хүнс тэжээлийн хомсдолын боломжит 3 шалтгааны талаархи ойлголт ба хүний биеийн хэмжилтийн үр дүн дээр үндэслэгдэнэ. Гэхдээ хурц хямралын үед хүнс тэжээл түгээх ерөнхий ажиллагааг хэрэгжүүлэх шийдвэрийг гаргахад хүний биеийн хэмжилтийн үр дүнг хүлээх шаардлагагүй. Учир нь үүнд 3 долоо хоног хүртэл хугацаа шаардагдаж болно. Харин энэ нь хүнс тэжээлийн хомсдолыг засч арилгахад чиглэсэн шийдвэрүүдийн талаар мэдээлэхдээ хүний биеийн хэмжилтийн үр дүнг ашиглах боломжтой байх ёстой.

3.Хүний биеийн хэмжилт нь: хүнс тэжээлийн хомсдлын тархацыг үнэлэх үнэлгээ юм. Хүнс тэжээлийн хомсдлын түвшинг үнэлэх хамгийн түгээмэл арга бол хүн амыг төлөөлүүлэн 6-59 сартай хүүхдүүдийг судлах арга юм. Гэхдээ энэ насны хүүхдүүд нь хүнс тэжээлийн хомсдлын эрсдэлд илүү их өртөх боломжтой. Энэ тохиолдолд судалгааны дүн зөрүүтэй байсан ч энэ насны хүүхдүүдийн хүнс тэжээлийн хомсдолыг зайлшгүй судлах ёстой. /5-р хавсралтыг үзнэ үү/ Олон улсын удирдамжуудын дагуу судалгаанд төлөөлөх дээжийг хэрэглэх бөгөөд тухайн улсаас гаргасан удирдамжийг дагаснаар мэдээллийг зохицуулах ба харьцуулах илүү их боломжтой. Тэжээлийн хандлагын талаархи төлөөлүүлэн авсан мэдээлэл байгаа тохиолдолд цорын ганц давамгайлсан мэдээлэлд илүү ач холбогдол өгөх ёсгүй. Дархлаажуулалтын хамрах хүрээний талаархи мэдээллийг нас баралтын талаархи мэдээллийн нэг адил хүний биеийн хэмжилтийн судалгаанд үед ашиглаж болно.

Тайлан нь тэжээлийн хомсдлын боломжит шалтгааныг заавал дурьдаж тэжээлийн хурц хомсдолын талаар тусад нь мэдээлэх ёстой.

4.Бичил тэжээлийн хомсдол: хүн ам нь гамшгийн өмнө А витамин, иод, төмрийн дутагдалд орсон нь мэдэгдэж байгаа бол энэ нь гамшгийн туршид хэвээр үргэлжилнэ гэж тооцож болно. Эрүүл мэнд ба хүнсний аюулгүй байдлын нөхцлийн шинжилгээгээр бичил тэжээлийн хомсдолын эрсдэл байгаа шинж тэмдэг илэрвэл тухайн хомсдолын тоон үзүүлэлтүүдийг сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай. (137-р хуудасны тэжээлийн туслалцааны ерөнхий стандарт 1 ба 152-р хуудасны тэжээлийн хомсдолыг залруулах стандарт 3-ыг үзнэ үү)

Хүнсний аюулгүй байдлын үнэлгээ ба шинжилгээний стандарт 111-р хуудсыг үз

Стандарт 1

Хүнсний ерөнхий аюулгүй байдал

Стандарт 2

Анхдагч үйлдвэрлэл

Стандарт 3

Орлого ба ажил

Стандарт 4

Зах зээлд нэвтрэх боломж

Хавсралт 1

Хүнсний аюулгүй байдлын аргачлалын ба тайлангийн хуудас

Хавсралт 2

Хүнсний аюулгүй байдлын үнэлгээний хуудас

Хавсралт 3

Хүнсний аюулгүй байдлын арга хэмжээнүүд

Хавсралт 9

Ном зүй

2. Хүнсний аюулгүй байдалд тавигдах минимум стандарт

Хүнсний аюулгүй байдлын асуудалд хоол хүнсээ олж авах боломж (тэр дундаа худалдах авах боломжийн үнэ), хүнсний хангамж ба олдоц, цаг хугацааны явц дахь нийлүүлэлтийн тогтвортой байдал ба түүнийг олж авах боломж орно. Үүнд мөн хүнсний чанар, нэр төрөл, аюулгүй байдал ба хүнсний хэрэглээ болон биологийн ашгийн асуудал хамаарна.

Хүмүүсийн зовлонг давах чадвар болон хүнсний аюулгүй байдлын эрсдэлд өртөмтгий байдал нь тэдэнд байгаа баялаг ба үүнд нь гамшиг хэрхэн нөлөөлснөөс ихээхэн хэмжээгээр хамаардаг. Эдгээр баялагт эдийн засгийн ба санхүүгийн (бэлэн мөнгө, зээл, хадгаламж, хөрөнгө оруулалт гэх мэт) эд хөрөнгөөс гадна биет, байгалын, хүний болон нийгмийн баялаг багтана. Гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн хувьд өөрсдийн ирээдүйн хүнсний аюулгүй байдал ба амьжиргааг хангах үүднээс баялгийг хадгалж хамгаалах, нөхөн сэргээх, бүтээх нь хамгийн чухал асуудал юм.

Зөрчил үүссэн нөхцөлд аюулгүй байдал ба мөргөлдөөний аюул нь хүмүүсийн амьдрал ахуй ба зах зээлд нэвтрэх боломжид хүчтэй нөлөөлдөг. Айл өрхүүд нь эд хөрөнгөө шууд алдах, зугтахдаа орхин явах, эсвэл түүнийг байлдаж байгаа талууд устгах юм уу булааж авч болно.

111-р хуудсан дээрхи хүнсний аюулгүй байдлын үнэлгээ ба шинжилгээнээс эхэлж байгаа хүнсний аюулгүй байдлын эхний стандарт нь гамшгийн үед хүнсний аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийн бүхий л талууд тэр дундаа эд хөрөнгийг аварч хадгалахтай холбоотой асуудалд хамаарсан ерөнхий стандарт юм. Үлдэж байгаа гурван стандарт нь анхдагч үйлдвэрлэл, орлогын эх үүсвэр ба ажил эрхлэлт, зах зээлд нэвтрэх ба бараа үйлчилгээ авах боломжид хамаарна. Хавсралт 3-т хүнсний аюулгүй байдалтай холбоотой олон арга хэмжээний талаар тайлбарласан байгаа.

Хүнсний аюулгүй байдлын ажиллагаа нь хүнсний аюулгүй байдлын асуудлын олон талыг хамардаг бөгөөд олон зорилготой байдаг учраас зөвхөн ганц стандартаар (үүнд ус, эрүүл мэнд, орон сууцны салбаруудад хамаарах стандартууд орно) зохицуулагддаггүй болохоор хүнсний аюулгүй байдлын стандартууд нь зарим зүйл дээр илэрхий давхацсан байдаг. Үүнээс гадна хүнсний аюулгүй байдлын бүх стандартуудын шаардлагыг хангахын тулд хөтөлбөрүүдийн хооронд тэнцвэртэй байдал бий болгох ёстой.

Гамшгийн эсрэг арга хэмжээ нь төрийн зүгээс бий болгосон бүтэц, зохион байгуулалт, удаан хугацааны тогтвортой байдлыг дэмжих юм уу нөхөх зориулалттай байх ёстой.

Хүнсний аюулгүй байдлын стандарт 1: хүнсний ерөнхий аюулгүй байдал

Хүмүүс амьд үлдэж эд хөрөнгө, өөрсдийн нэр төрийг алдахгүйгээр хангалттай хэмжээний шаардлага хангасан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүнийг хэрэглэх боломжтой байх ёстой.

үндсэн үзүүлэлтүүд /Заавар тэмдэглэлтэй хамт уншина/

- Хүнсний хомсдол үүссэний улмаас хүмүүсийн амьдрал эрсдэлд орсон нөхцөлд авах хариу арга хэмжээний хамгийн чухал асуудал нь тэдгээрийн хүнсний шууд хэрэглээг хангах явдал юм (Заавар тэмдэглэл 1-г үзнэ үү).
- Гамшгийн бүх л нөхцөлд хүнсний аюулгүй байдлыг дэмжих, хамгаалах, сайжруулах арга хэмжээг авах ёстой. Үүнд үйлдвэрлэлийн эд хөрөнгийг хадгалж үлдэх ба гамшгийн улмаас алдсан эд хөрөнгийг эргүүлэн олж авах асуудал хамаарна (Заавар тэмдэглэл 2-г үзнэ үү).
- Хүнсний аюулгүй байдлыг хамгаалах ба дэмжих арга хэмжээнүүдийг нарийн шинжилгээн дээр үндэслэн гамшигт нэрвэгдсэн хүн амтай зөвлөлдсөний дагуу явуулна.
- Хариу арга хэмжээг авахдаа хүмүүсийн зохицох стратеги, тэдний хүртэх үр ашиг болон холбогдох аливаа эрсдэл ба зардлыг тооцох ёстой (Заавар тэмдэглэл 3-г үзнэ үү)..
- Гамшгийн үед хүнсний аюулгүй байдлыг хамгаалах бүхий л арга хэмжээ авах үед хөтөлбөрөөс гаргах юм уу дараагийн шатанд шилжүүлэх стратегийг боловсруулж нийтэд мэдээлсний дагуу хэрэгжүүлнэ (Заавар тэмдэглэл 4-г үзнэ үү).
- Хариу арга хэмжээ нь шинэ юм уу амьжиргааг дэмжих өөр стратегийн дагуу явагдаж байгаа үед зохих дэмжлэг тэр дундаа шаардлагатай мэдлэг, ур чадвар, үйлчилгээг бүх бүлгийн хүмүүст хүртээх ёстой (Заавар тэмдэглэл 5-г үзнэ үү).
- Хүнсний аюулгүй байдлын арга хэмжээний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө нь хамгийн бага хэмжээнд байх ёстой (Заавар тэмдэглэл 6-г үзнэ үү).

- Хүн амын дундах янз бүрийн бүлгүүд хэрэгжүүлж байгаа арга хэмжээг хүлээн авах ба оролцох боломжоор нь оролцох түвшнийг тодорхойлж гамшигт нэрвэгдсэн хүн амыг ялгарлахгүйгээр нийтэд нь хамруулахын тулд тусламж хүлээн авч байгаа хүмүүсийг тоог хянах ёстой (заавар тэмдэглэл 7-г үзнэ үү).
- Хөтөлбөрийн зорилгын дагуу тогтмол хийгдэх ажиглалтаас гадна хариу арга хэмжээний орон нутгийн эдийн засаг, нийгмийн сүлжээнүүд, хүмүүсийн амьжиргаа, байгал орчинд үзүүлэх нөлөөг ажиглах ёстой (заавар тэмдэглэл 8-г үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. Аврах ажиллагааг ач холбогдлоор нь ангилах: хэдийгээр гамшгийн үед хүнсний хурц хомсдолын эсрэг авдаг хамгийн түгээмэл арга хэмжээ нь хоол хүнсний түгээлт байдаг боловч бусад төрлийн арга хэмжээнүүд ч гэсэн хүмүүст өөрсдийн шууд хэрэгцээг хангахад тусалж болно. Үүний жишээ бол хямдруулсан үнээр хүнсний бүтээгдэхүүн борлуулах (хүмүүс ямар нэг хэмжээний худалдан авах чадвартай байгаа боловч хүнсний хангамж муу байгаа нөхцөлд), ажил эрхлэлтийн хөтөлбөрөөр дамжуулж хүмүүсийн худалдан авах чадварыг нэмэгдүүлэх (тэр дундаа ажлын хөлсөнд хүнс олгох хөтөлбөр), мал нядалгаа юм уу бэлэн мөнгө тараах зэрэг арга хэмжээнүүд орно. Ялангуяа хот суурин газар зах зээлийн хэвийн ажиллагааг сэргээж эдийн засгийн үйл ажиллагааг эрчимжүүлснээр ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь чухал ач холбогдолтой байж болно. Ийм стратегиуд нь хүмүүсийн нэр төрд сэвгүй, амьжиргааг нь дэмжсэнээр ирээдүйд эмзэг байдалд орох магадлалыг бууруулдаг учраас хүнс тараах хөтөлбөрөөс илүү тохиромжтой байж болно. Байгууллагууд нь хамтарч ажилласан тохиолдолд нэгнийхээ үйл ажиллагааг нөхөхийн тулд бусдын хийж байгаа зүйлийг харгалзан үзэх хариуцлага хүлээнэ. Хүнсний ерөнхий түгээлтийг зөвхөн зайлшгүй шаардлагатай нөхцөлд л хэрэгжүүлж аль болох түргэн хугацаанд зогсоох ёстой. Дараахь тохиолдлуудад хүнсний ерөнхий түгээлт нь тохиромжгүй байж болно. Үүнд:

- хүнсний хангалттай нөөц тухайн нутагт байгаа (тэднийг хэрэглэх боломжид учирч байгаа саадыг арилгах шаардлагатай байж болно)
- тухайн нутагт хүнсний олдоц муудсан нөхцөлд зах зээлийн системийг сайжруулах замаар асуудлыг шийдэж болно.
- орон нутгийн хандлага юм уу бодлого нь хүнсний бүтээгдэхүүнийг үнэгүй тараахын эсрэг байгаа.

2. хүнсний аюулгүй байдлыг дэмжих, хамгаалах, сайжруулах: хүнсний аюулгүй байдлыг дэмжихэд тохиромжтой олон арга хэмжээ ба дэмжлэг байж болно

(Хавсралт 3-г үзнэ үү). Богино хугацаанд хүнсний аюулгүй байдлыг зөвхөн хүмүүсийн амьжиргааны стратеги дээр үндэслэн хэрэгжүүлэх боломжгүй байж болох боловч айл өрхийн хүнсний аюулгүй байдалд хувь нэмэр оруулж нэр төрийг хамгаалдаг стратегийг аль болох хамгаалж дэмжих ёстой. Хүнсний аюулгүй байдлын арга хэмжээ нь гамшгийн үр дүнд алдагдсан эд хөрөнгийг заавал бүрэн

хэмжээгээр олж авах зорилгогүй байж болох боловч цаашид алдагдах явдлаас урьдчилан сэргийлэх, буцаан олж авах ажиллагааг үргэлжлүүлэн явуулах ёстой.

3. зохицох стратегитай холбоотой эрсдэлүүд: олон зохицох стратегиуд нь хүмүүсийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх боломжтой эрсдэл дагуулдаг. Жишээ нь:

- хэрэглэсэн хүнсний хэмжээ ба чанар буурснаар эрүүл мэнд тэжээлийн үзүүлэлт мууддаг.
- сургуулийн төлбөр ба эрүүл мэндийн зардлыг бууруулах нь хүний баялагт муугаар нөлөөлдөг.
- хоол хүнс олж авахын тулд биеэ үнэлэх ба бусадтай харьцаа тогтоох нь хүний нэр төрд муугаар нөлөөлж нийгмээс гадуурхагдах, ДОХ болон бусад бэлгийн замын өвчний халдвар авах эрсдлийг бий болгодог.
- гэрийнхээ эд хөрөнгийг зарснаар өрхийн ирээдүйн үйлдвэрлэлийн хүчин чадал буурдаг.
- зээлээ эргүүлэн төлөх боломжгүй болсноор дахин зээл авах боломж хаагдах эрсдэлтэй байдаг.
- байгалын баялгийг хэтрүүлэн ашигласнаар (хэт их загасчлах, түлээний мод цуглуулах гэх мэт) байгалын баялгийн олдоц муудна.
- ажил хийх, түлээ цуглуулах зорилгоор аюултай газраар явах нь хүмүүсийг (ялангуяа хүүхэд эмэгтэйчүүд) халдлагад өртөх эрсдэлийг бий болгодог.
- хууль бус бараа үйлдвэрлэх юм уу худалдаалах нь баривчлагдах ба шоронд хоригдох эрсдэлийг бий болгоно.
- гэр бүл ба эхчүүдийг хүүхдүүдээс нь салгаснаар хүүхдийн төлөө тавих анхаарал халамж сулрах ба хүнсний хомсдол үүсэх эрсдэлийг үүсгэнэ.

Эдгээр улам өсөн нэмэгддэг сөрөг нөлөөнүүдийг ойлгож эдгээр зохицох стратегийг аль болохоор таслан зогсоохын хамт эд хөрөнгө алдагдахаас урьдчилан сэргийлэхийн тулд аль болох түргэн шуурхай хөндлөнгийн оролцоог бий болгох ёстой. Тодорхой зохицох стратегиуд нь хүмүүсийг нэр хүнд муутай юм уу хүлээн зөвшөөрч боломгүй ажиллагаанд татан оруулснаар хүний нэр төрд сэв суулгах боломжтой. Гэхдээ олон нийгэмд тодорхой стратегиуд нь (хүнд хэцүү үед гэр бүлийн нэг гишүүнийг өөр газар ажиллуулахаар явуулах гэх мэт) хэвшсэн уламжлал болсон байдаг.

4. хөтөлбөрөөс гаргах ба шинэ шатанд гаргах стратеги: ийм стратегийг ялангуяа хариу арга хэмжээ нь зээл ба мал эмнэлгийн зэрэг голдуу төлбөртэй үйлчилгээгээр хангах удаан хугацааны явцад хэрэгжих тохиолдолд хөтөлбөрийн эхнээс нь бодолцох ёстой. Хөтөлбөрийг дуусгах юм уу шинэ шатанд гаргахын өмнө нөхцөл байдал сайжирсан гэдгийг баримтаар баталгаажуулах ёстой.

5. мэдлэг, ур чадвар, үйлчилгээ авах боломж: холбогдох үйлчилгээгээр хангаж байгаа бүтцийг хэрэглэгчидтэй хамт боловсруулж төлөвлөснөөр тэдгээрийг зохих хэмжээнд хөтөлбөрийн хугацаа дуустал эсвэл шаардлагатай бол цааш нь үргэлжлүүлэх явцад хэрэгжүүлэх боломжтой болно. Зарим бүлгийн хүмүүс нь онцгой хэрэгцээ шаардлагатай байдаг. Жишээ нь, ДОХ-ын улмаас өнчирч үлдсэн хүүхдэд гэр бүлийн гишүүдийн дунд байдаг мэдээлэл солилцох, ур чадвараа өвлүүлэх гэх мэт боломж байхгүй болдог.

6. Байгал орчинд үзүүлэх нөлөө: гамшигт нэрвэгдсэн хүн ам эсвэл хүлээн авагч хүн амын үйлдвэрлэлийн ба амьжиргааны хэрэгцээнд ашиглагддаг байгалын нөөц баялгийг аль болохоор хадгалж үлдэх ёстой. Байгаль орчинд үзүүлэх нөлөөг үнэлэх ба аливаа хариу арга хэмжээг төлөвлөх явцад тооцох шаардлагатай. Жишээ нь, хуаранд амьдарч байгаа хүмүүс хоол хүнсээ бэлдэхийн тулд түлш хэрэгтэй болсноор тухай орон нутгийн ой түргэн хугацаанд устах аюултай. Зарим нэг төрлийн шош гэх мэт удаан болдог хүнсний бүтээгдэхүүнийг болгоход илүү их түлш шаардлагатай болдог бөгөөд энэ нь байгаль орчинд нөлөөлөх боломжтой байдаг (158-р хуудсанд байгаа хүнсний тусламжийн стандарт 2-г үзнэ үү). Боломжтой бол хариу арга хэмжээ нь байгал орчныг улам илүү бохирдохоос сэргийлэхэд чиглэсэн байх ёстой. Жишээ нь, мал нядлах хөтөлбөр нь гангийн үед бэлчээрийн ачааллыг бууруулж амьд үлдэх боломжтой малд илүү хэмжээний тэжээл өгөх боломж олгодог.

7. Хамрах хүрээ, оролцох боломж, хүлээн авах боломжтой байдал: тусламж авч байгаа хүмүүс ба тэдгээрийн шинж чанарыг дүрслэн бичихээс гадна янз бүрийн бүлгүүдийн (эмзэг бүлгийнхэнд онцгой анхаарал хандуулна) оролцооны түвшинг тогтоохын өмнө тэдний тоог гаргах ёстой. Хүмүүсийн оролцоо нь зарим талаар тэдний оролцох ба ажиллагааг хүлээн зөвшөөрөх боломжтой байдлаар тодорхойлогддог. Хүнсний аюулгүй байдлын зарим арга хэмжээ нь эдийн засгийн идэвхтэй хэсэг рүү чиглэдэг боловч тэдгээрийг ялгаварлан гадуурхахгүйгээр эмзэг бүлгийн хүмүүст оролцох бололцоо олгож бусдаас хамааралтай хүмүүс тэр дундаа хүүхдүүдийг хамгаалахыг хичээх ёстой. Ажлын чадвар, гэрийн ажлын ачаалал, хүүхэд асрах үүрэг хариуцлага, архаг хууч өвчин юм уу бие эрхтний доголдол, биеэр оролцох боломжгүй байдал зэрэг олон янзын саад тотгор нь эмэгтэйчүүд, тахир дутуу хүмүүс, өндөр настай хүмүүсийн оролцох боломжийг хязгаарладаг.

Эдгээр саад тотгорыг даван гарахын тулд тэдгээр хүмүүсийн чадварын хүрээнд ямар үйл ажиллагаа явуулах боломжтойг тогтоох юм уу зохих дэмжлэг үзүүлэх бүтцийг бий болгох ёстой. Өөрөө сонголт хийх зарчим дээр үндэслэсэн оролцогчдыг сонгох механизмыг тухайн оршин суугчдын дундах бүх бүлгийнхэнтэй зөвлөлдсөний дагуу бий болгох ёстой (36-р хуудсанд байгаа оролцогчдыг сонгох

стандартыг үзнэ үү).

8. Хяналт: байнгын хяналт (37-40-р хуудсанд байгаа хяналт ба үнэлгээний стандартыг үзнэ үү) хийхээс гадна хөтөлбөрийн тохиромжтой байдлыг үнэлэх, тодорхой үйл ажиллагааг хэзээ зогсоох, шаардлагатай өөрчлөлт хийх, шинэ төслийг хэрэгжүүлж болохыг тогтоох, эсвэл дэмжлэг шаардлагатай байгаа эсэхийг тодорхойлохын тулд хүнсний аюулгүй байдлын илүү өргөн хүрээний хяналтыг явуулах шаардлагатай. Орон нутгийн ба бүс нутгийн хүнсний аюулгүй байдлын мэдээллийн системүүд тэр дундаа өлсгөлөнгийн эхэн үеийн анхааруулгын системүүд нь мэдээллийн чухал эх үүсвэрүүд юм.

Хүнсний аюулгүй байдлын стандарт 2: анхдагч үйлдвэрлэл

Анхдагч үйлдвэрлэлийн механизмуудыг хамгаалж дэмжих ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд: /Заавар тэмдэглэлтэй хамт уншина/

- Үйлдвэрлэлийг дэмжих хөндлөнгийн оролцоо нь үйлдвэрлэлийн системийн амьдрах чадвар тэр дундаа шаардлагатай баялаг ба үйлчилгээг олж авах боломж болон олдоцын талаархи гүнзгий ойлголт дээр үндэслэсэн байх ёстой (Заавар тэмдэглэл 1-г үзнэ үү).
- Шинэ технологийг нэвтрүүлэхдээ зөвхөн түүний орон нутгийн үйлдвэрлэлийн систем, соёлын хэвшил, байгал орчинд үзүүлэх нөлөөг нь ойлгож хүнсний үйлдвэрлэгчид хүлээн зөвшөөрсний дараа нэвтрүүлнэ. (Заавар тэмдэглэл 2-г үзнэ үү).
- Боломжтой үед үйлдвэрлэл, боловсруулалт, түгээлтийг илүү уян хатан байдлаар зохион байгуулж эрсдэлийг бууруулахын тулд янз бүрийн үйлдвэрлэлд шаардлага зүйлүүдээр хангадаг (Заавар тэмдэглэл 3-г үзнэ үү).
- Үйлдвэр, амьтан, загасны аж ахуйд хэрэгцээтэй зүйлүүдийг цагт нь нийлүүлэх шаардлагатай бөгөөд эдгээр нь орон нутагт хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд холбогдох чанарын шаардлагад нийцсэн байх ёстой (Заавар тэмдэглэл 4-5-г үзнэ үү).
- Үйлдвэрлэлд шаардлагатай зүйлс ба үйлчилгээ нь байгалын ховор баялгийг олж авах өрсөлдөөнийг нэмэгдүүлэх юм уу оршин тогтнож байгаа нийгмийн сүлжээнүүдэд хохирол учруулах мэтээр эмзэг байдал ба эрсдэлийг нэмэгдүүлэхгүй байх ёстой (Заавар тэмдэглэл 6-г үзнэ үү).

- Орон нутгийн үйлдвэрлэгчид, зах зээлүүд юм уу хэрэглэгчдэд сөрөг нөлөө үзүүлэхгүй тохиолдолд үйлдвэрлэлд шаардлагатай зүйлс ба үйлчилгээг аль болохоор орон нутгаас нь авах ёстой (Заавар тэмдэглэл 7-г үзнэ үү).
- Төслийн хүрээнд үйлдвэрлэлд шаардлагатай зүйлс хүлээн авч байгаа хүнсний үйлдвэрлэгчид, боловсруулагчид, түгээгчид нь тэдгээрийг зөв зохистой ашиглах ёстой (Заавар тэмдэглэл 8-9-г үзнэ үү).

- Хариу арга хэмжээ авахдаа харилцан нөхөн үйлдвэрлэлд шаардлагатай зүйлсийг мэдсэний үндсэн дээр тэдгээрийг хангах ёстой.

Заавар тэмдэглэл

1. Анхдагч үйлдвэрлэлийн амьдрах чадвар: амьдрах чадвартай байхын тулд хүнсний үйлдвэрлэлийн стратеги нь зохих түвшинд боловсруулагдаж амжилттай хэрэгжүүлэх боломжтой байх ёстой. Үүнд дараахи болон бусад олон хүчин үйлчилнэ. Үүнд:

- хангалттай хэмжээний байгалийн нөөцийг (тариалангийн газар, бэлчээр, ус, гол нуур, эргийн ус гэх мэт) ашиглах боломж. Газрын ашиглалтын даацыг хэтрүүлэх, хэт их загасчлах, усыг ялангуяа хотын ойролцоо газруудын усыг бохирдуулах гэх мэтээр экологийн тэнцвэрт байдалд аюул учруулах ёсгүй.
- Хүн ам хүнд өвчинд нэрвэгдсэн юм уу боловсрол эзэмшиж сургалтанд хамрагдах боломжийг зарим бүлгийн хүмүүст олгодгүйн улмаас ур чадварын ба хүчин чадал хязгаарлагдах ёсгүй.
- Тогтсон үйлдвэрлэлийг хадгалахын тулд шаардлагатай ажиллах хүчний олдоц ба хөдөө аж ахуйн үндсэн үйл ажиллагаануудын цагийн зохицуулалт. Үйлдвэрлэлийн хүчин зүйлийн олдоц ба төрийн байгууллага юм уу бусад байгууллагын зүгээс хангаж болох үйлчилгээний (санхүүгийн, мал эмнэлгийн, газар тариалангийн өргөтгөлийн) шинж чанар ба хүртээмж.
- Тодорхой үйл ажиллагааны хуульд нийцсэн байдал, түлш цуглуулахад тавих хяналт юм уу дүрвэгсдийн цалинтай ажил хийх эрхийн хязгаарлалт зэрэг нэрвэгдсэн бүлгийнхний ажиллах эрхийн хязгаарлалт.
- Зэвсэгт мөргөлдөөний улмаас шаардлагатай болсон хамгаалал, тээврийн дэд бүтцийн эвдрэл, газрын мина, халдлага хийх эсвэл дээрэмдэх заналхийлэл.

Үйлдвэрлэл нь бусад бүлгийн хүмүүсийн ус гэх мэтийн амьдрал тэтгэгч байгалын нөөцийг ашиглах боломжийг хязгаарлах ёсгүй.

2. Технологийн хөгжил: шинэ технологид сайжруулсан ургац ба амьтны төрлүүд, шинэ багаж хэрэгсэл, бордоо багтана. Хүнсний үйлдвэрлэлийн ажиллагаа нь аль болох тогтсон хэвшлийн дагуу юм уу үндэсний хөгжлийн төлөвлөгөөний дагуу явагдах ёстой. Гамшгийн үед шинэ технологийг зөвхөн тухайн орон нутагт түүнийг урьдчилан туршиж тохиромжтой гэдгийг баталсан нөхцөлд л нэвтрүүлэх ёстой. Нэвтрүүлсэн тохиолдолд шаардлагын дагуу оршин суугчидтай зөвлөлдөх, мэдээллээр хангах, сургалт болон бусад дэмжлэгийг үзүүлэх ёстой. Ингэхдээ туслалцаа үзүүлэх ёстой орон нутгийн төрийн байгууллагууд, төрийн бус

байгууллагууд, болон бусад байгууллагуудын нэмэлт үйлчилгээ үзүүлэх хүчин чадлыг тооцож шаардлагатай бол хэрэгжүүлэх ёстой.

3. **Сонголтыг сайжруулах:** үйлдвэрлэгчдийн сонголтыг өргөжүүлэх хөндлөнгийн оролцооны жишээнүүд бол үйлдвэрлэлийн хүчин зүйлийн оронд эсвэл хамт бэлэн мөнгө төлөх юм уу зээл өгөх ба газар тариаланчдад өөрсдийн сонгосон үр тариа авах боломж олгох, үр тарианы үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэрэг болно. Үйлдвэрлэл нь хүнсний бүтээгдэхүүнийг бусад ашигтай зүйлээр солих гэх мэт тэжээлийн үзүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлэх ёсгүй. Ган болсон үед амьтны тэжээл нийлүүлэх нь малчдад хүнсний тусламж үзүүлснээс илүү үр дүнтэйгээр хүнсний тэжээлийн хувьд үр ашиг өгч болно.
4. **Цаг хугацаа ба хүлээн авах боломж:** үйлдвэрлэлийн хүчин зүйлүүд гэдэгт үр тариа, багаж хэрэгсэл, бордоо, мал, загасчлах хэрэгсэл, ангийн хэрэгсэл, зээлийн төрлүүд, зах зээлийн мэдээлэл, тээврийн хэрэгслүүд гэх мэт орно. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүчин зүйлс ба мал эмнэлгийн үйлчилгээгээр хангахдаа жишээ нь үр тариа ба багаж хэрэгслийг тариалангийн өмнө нийлүүлэх гэх мэт хөдөө аж ахуйн ба мал аж ахуйн хувьд тохиромжтой улиралтай давхцуулах байдлаар хугацааг тохируулах ёстой. Ган болсон үед малыг яаралтай нядлахдаа малын үхэл ихсэхээс өмнө хэрэгжүүлэх ёстой ба дахин малжуулах ажиллагааг дараагийн бороо орсны дараа гэх мэтээр сэргэх баталгаатай болсон үед хэрэгжүүлнэ.
5. **Үр:** тариаланчид өөрсдийн чанарын хэмжүүрийг ашиглах боломж олгохын тулд аль орон нутгийн үр тарианд давуу эрх олгох ёстой. Орон нутагт тариалдаг үрийн төрлүүдийг тариаланчид ба орон нутгийн газар тариалангийн ажилтнууд баталгаажуулах ёстой. Үр нь орон нутгийн нөхцөлд зохицох чадвартайгаас гадна өвчнийг эсэргүүцэх чадвартай байх шаардлагатай. Тухайн бүс нутгаас өөр газраас олж авсан үрийг зохих шаардлагын дагуу гэрчилгээжүүлж орон нутгийн нөхцөлд тохиромжтой эсжхийг нь шалгах шаардлагатай. Тариаланчид урьд нь мэддэг бөгөөд тарьж байсан туршлагатай тохиолдолд эрлийз үрийг хэрэглэх боломжтой. Энэ асуудлыг оршин суугчидтай зөвлөлдөж шийдэх боломжтой. Үрийг төлбөргүй нийлүүлсэн тохиолдолд тариаланчид нь илүү өндөр үнэтэй орон нутгийн үрээс эрлийз үрийг хэрэглэхээр сонголт хийж болно.

Үрийг тараахын өмнө мөн эрлийз үрийн талаар төрөөс баримтлах бодлогыг баримтлах ёстой. Генетикийн хувьд өөрчилсөн үрийг улсын болон бусад эрх бүхий байгууллагуудын зөвшөөрөлгүйгээр түгээж болохгүй.

6.Хөдөөгийн амьдралд үзүүлэх нөлөө: хүнсний анхдагч үйлдвэрлэл нь зайлшгүй шаардлагатай байгалийн баялаг байхгүй нөхцөлд удаан амьдрах чадваргүй байж болно. Орон нутгаас олддог байгалын баялгийн ашиглалтыг нэмэгдүүлэх юм уу өөрчлөх шаардлагатай үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь орон нутгийн хүн амтай зөрчил үүсгэх цаашлаад ус болон бусад зайлшгүй шаардлагатай хэрэгцээг хангах боломжийг хязгаарлахад хүргэж болно. Тусламж юм уу зээл хэлбэрийн санхүүгийн бүтээгдэхүүнээр хангахдаа болгоомжтой хандах шаардлагатай. Учир нь энэ нь орон нутгийн аюулгүй байдлын эрсдэлийг улам нэмэгдүүлж болно (130-р хуудсанд байгаа хүнсний аюулгүй байдлын стандарт 3, удирдамжийн тайлбар 5-г үзнэ үү). Үүнээс гадна шаардлагатай зүйлсийг үнэгүй нийлүүлснээр нийгмийн дэмжлэгийн ба дахин хуваарилалтын уламжлалт механизмыг эвдэж болно.

7. шаардлагатай зүйлсийг орон нутгаас худалдан авах: малын эрүүл мэндийн үйлчилгээ, үр гэх мэт хүнсний үйлдвэрлэлд шаардлагатай зүйлс ба үйлчилгээг боломжтой бол тухайн улсын дотоодын хангамжийн системээр дамжуулж олж авах нь зүйтэй. Гэхдээ орон нутгаас худалдан авалт хийж эхлэхийн өмнө төслийн дагуух худалдан авалт нь ховор бүтээгдэхүүний үнийг хөөрөгдөх гэх мэт зах зээлийг гажуудуулах эрсдэлийг тооцож үзэх ёстой.

8. хэрэглээг ажиглах: үйл явцын үзүүлэлтүүд ба хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, түгээлтийн үр дүнг хэмжиж болно. Жишээ нь, тариалангийн газар, нэг га газарт суулгасан үрийн тоо, гарц, соёолсон үрийн тоо гэх мэт. Үйлдвэрлэгчид төслийн хүрээнд нийлүүлсэн зүйлүүдийг хэрхэн ашиглаж байгаа тухайлбал үрийг үнэхээр суулгасан эсэх, багаж хэрэгсэл, бордоо, тор, загасны хэрэгслийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах нь чухал юм. Нийлүүлсэн зүйлүүдийн чанарыг хүлээн авах боломжтой байдал ба үйлдвэрлэгчдийн сонголтын дагуу үнэлэх ёстой. Үнэлгээ хийхдээ төсөл нь айл өрхийн хүнсний хангамжид хэрхэн нөлөөлсөн, хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний хэмжээ ба чанар, худалдсан юм уу бусдад өгсөн хүнсний бүтээгдэхүүний хэмжээ зэргийг тооцох шаардлагатай. Төсөл нь амьтан ба загасны гаралтай бүтээгдэхүүн эсвэл уургаар баялаг хүнсний ногоо зэрэг тодорхой бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилготой тохиолдолд эдгээр бүтээгдэхүүний айл өрхийн хэрэглээг тооцно. Ийм төрлийн шинжилгээний үр дүнг тэжээлийн үзүүлэлтийн судалгааны дүнтэй харьцуулж баталгаажуулж болно (тэжээлийн үзүүлэлтийг тодорхойлох эрүүл мэндийн ба асаргааны хүчин зүйлүүд өгөгдсөн тохиолдолд).

9. Урьдчилан таамаглашгүй ба сөрөг нөлөө: жишээ нь, хөдөө аж ахуйн хөдөлмөр улирлаас шалтгаалж өөрчлөгдөж байгаа тохиолдолд төслийн үйл ажиллагааны хувилбар ба хэрэгжүүлж байгаа зохицох стратегийн нөлөө (жишээ нь, ажиллах хүчийг өөр газар шилжүүлэх гэх мэт), эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зохион байгуулалт ба хүүхдийн асаргаанд нөлөөлөх нь, хичээлийн ирц болон боловсролд нөлөөлөх нь, газар болон бусад зайлшгүй шаардлагатай нөөцүүдийг ашиглах үед хүлээх эрсдэл зэрэгт ямар нөлөө үзүүлснийг тооцох ёстой.

Хүнсний аюулгүй байдлын стандарт 3: орлого ба ажил эрхлэлт

Орлого ба ажил эрхлэлт нь хэрэгжих боломжтой стратеги болж байгаа үед хүмүүс зохих хэмжээний орлого олох боломжийг ашиглаж амьжиргааны тулгуур болсон баялгийг аюулд учруулахгүйгээр хүнсний аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулах боломжтой болдог.

Үндсэн үзүүлэлтүүд /Заавар тэмдэглэлтэй хамт уншина/

- Цаг хугацаа, үйл ажиллагаа, төлбөрийн хэлбэр, төслийн техникийн тооцоо зэрэгтэй холбоотой төслийн шийдвэрүүд нь орон нутгийн хүний нөөц, зах зээл ба эдийн засгийн шинжилгээ, холбогдох ур чадварын эрэлт ба нийлүүлэлт, сургалтын хэрэгцээ зэргийн талаархи гүнзгий ойлголт дээр үндэслэгдсэн байх ёстой (Заавар тэмдэглэл 1-2-г үзнэ үү).
- Ажил ба орлогын эх үүсвэрээр хангах арга хэмжээ нь техникийн хувьд хэрэгжих боломжтой бөгөөд шаардлагатай бүх хүчин зүйлүүдийг цаг тухайд хангах шаардлагатай. Боломжтой бол эдгээр арга хэмжээнүүд нь бусад хүмүүсийн хүнсний аюулгүй байдлыг хангах ба байгаль орчныг хамгаалахад хувь нэмэр оруулах ёстой.
- Хөлсний хэмжээ зохих түвшинд байх ба хөлсний ажлын хөлсийг тогтмол, цаг тухайд нь түргэн шуурхай төлөх ёстой. Хүнсний аюулгүй байдал ноцтой эрсдэлд орсон нөхцөлд төлбөрийг урьдчилан хийнэ (заавар тэмдэглэл 3-г үзнэ үү).
- Аюулгүй ажлын орчин бүрдүүлэхийн тулд журам боловсруулж хэрэгжүүлнэ (Заавар тэмдэглэл 4-г үзнэ үү).
- Ихээхэн хэмжээний бэлэн мөнгө шаардлагатай төсөл хэрэгжүүлэхэд мөнгө алдагдах ба өөр зорилгоор ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна (Заавар тэмдэглэл 5-г үзнэ үү).

- Ажил эрхлэх боломж олгох арга хэмжээ нь гэр бүлийн хүрээнд анхаарал халамж үзүүлэх үүргийг хамгаалж дэмжих ба орон нутгийн хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэх юм уу амьдралын хэвийн үйл явцад хутгалдахгүй байх ёстой (Заавар тэмдэглэл 6-г үзнэ үү).
- Өрх гэрийн менежмент ба цалин хөлс (бэлэн мөнгө юм уу хоол хүнс), тусламж, зээлийн хэрэглээг сайтар ойлгох шаардлагатай ба тэдгээр нь бүх өрхийн гишүүдийн хүнсний аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулах ёстой (Заавар тэмдэглэл 7-г үзнэ үү).

1. Зөв санаачлага гаргах: төслийн үйл ажиллагааг явуулахдаа төслийг боловсруулах ба шаардлагатай үйл ажиллагааг олж тогтоохдоо орон нутгийн хүний нөөцийг бүрэн ашиглах ёстой. Ажлын хөлсөнд хоол хүнс өгөх эсвэл бэлэн мөнгө өгөхийг аль болох төсөлд оролцож байгаа бүлгүүдтэй хамтран шийдэж төлөвлөх ёстой. Олон тооны орон гэргүй болсон хүмүүс байгаа тохиолдолд ажлын байр бий болгохдоо хүлээн авсан нутгийн хүн амд хохиролгүйгээр хэрэгжүүлэх ёстой. Зарим нөхцөлд ажил эрхлэх боломжийг аль алинд нь олгох ёстой. Хүнсний аюулгүй байдлыг дэмжихийн тулд бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай юу, үзүүлвэл ямар хэлбэрээр үзүүлэх гэдгийг шийдэхэд өрх гэрийн менежмент ба бэлэн мөнгөний хэрэглээг сайтар ойлгох шаардлагатай (хүнсний аюулгүй байдлын стандарт 2-г үзнэ үү).

2. төлбөрийн хэлбэр: төлбөрийг бэлэн мөнгөөр юм уу хүнсний бүтээгдэхүүнээр эсвэл энэ хоёрыг хослуулсан байдлаар хийж болох энэ нь хүнсний аюулгүй байдлын эрсдэлд орсон айл өрхүүдэд өөрсдийн үндсэн хэрэгцээгээ хангах боломж олгох ёстой. Бэлэн мөнгөнөөс илүү хүмүүст өөрсдөд нь ашигтай үүрэг даалгавраа гүйцэтгэхэд нь туслах урамшууллын хэлбэртэй төлбөр байх нь олонтоо. Зах зээл идэвхгүй юм уу зохицуулалт муутай эсвэл хүнсний олдоц муу үед ажлын хөлсийг бэлэн мөнгөөр биш хүнсний бүтээгдэхүүнээр өгөх нь илүү тохиромжтой байж болно. Эмэгтэйчүүд бэлэн мөнгөнөөс илүү хүнсний бүтээгдэхүүнийг хянах боломжтой үед ажлын хөлсийг хүнсний бүтээгдэхүүнээр өгч болно. Ажлын хөлсийг бэлэн мөнгөөр төлөх арга нь орон нутгийн зах зээл дээр хүнсний бүтээгдэхүүний олдоц сайтай бөгөөд бэлэн мөнгөөр төлбөр хийх найдвартай систем байгаа үед хэрэглэх нь зүйтэй. Хүмүүсийн худалдан авах хэрэгцээ ба бэлэн мөнгө юм уу хүнсний бүтээгдэхүүнээр төлбөр хийх арга нь бусад үндсэн хэрэгцээнд (хичээлдээ явах, эрүүл мэндийн үйлчилгээ авах, нийгмийн үүргээ гүйцэтгэх) ямар нөлөө үзүүлж байгааг тооцох ёстой. Төлбөрийн хэлбэр ба хэмжээг тухайн нөхцөл байдлаас хамааран шийдэх бөгөөд ингэхдээ дээрхи хүчин зүйл ба бэлэн мөнгө, хоол хүнсний олдоцыг тооцох ёстой.

3. төлбөрүүд: төлбөрийн түвшинг тогтоохдоо хүнсний аюулгүй байдал хангагдаагүй айл өрхүүдийн хэрэгцээ ба орон нутгийн хөдөлмөрийн хөлсний хэмжээг тооцох ёстой. Төлбөрийн хэмжээг тогтоох бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зааварчилгаа байдаггүй боловч төлбөрийг биет зүйлээр юм уу орлогын шилжүүлэг хэлбэрээр хийж байгаа үед хүнсний бүтээгдэхүүнийг орон нутгийн зах зээл дээр дамжуулан худалдаж байгаа үнийг тооцох ёстой. Хувь хүмүүсийн хувьд хөтөлбөрт оролцох замаар орлогоо нэмэгдүүлсэн цэвэр хэмжээ нь бусад үйл ажиллагаанд оролцсон бол олох боломжтой байсан орлогоос их байх ёстой. Энэ нь хүнсний бүтээгдэхүүн юм уу бэлэн мөнгөөр хийх төлбөр, мөн зээл, шинээр эхлүүлсэн бизнес гэх мэтэд хамаатай. Орлого олж байгаа үйл ажиллагаанууд нь орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхээс биш одоогийн орлогын эх үүсвэрийг орлох ёсгүй. Төлбөр нь цалин

хөлсний ханшийг бууруулах, ажиллах хүчийг бусад үйл ажиллагаанаас хөндийрүүлэх, олон нийтийн гол үйлчилгээнүүдэд муугаар нөлөөлөх гэх мэтээр орон нутгийн хөдөлмөрийн зах зээлд сөрөг нөлөө үзүүлэх ёсгүй.

4. ажлын орчин дахь эрсдэл: мэдээлэл, анхны тусламжийн хэрэгсэл, хамгаалалтын хувцас гэх мэтийг шаардлагатай үед хэрэглэж эрсдэлийг хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулах юм уу гэмтэлтэй хүнтэй ажиллах амьдралд нийцтэй журмыг хэрэгжүүлэх замаар өндөр эрсдэлтэй ажлын орчноос зайлсхийх шаардлагатай. Үүнд ДОХ-ын халдвар авах эрсдэл багтах бөгөөд түүнийг аль болохоор багасгахын тулд шаардлагатай арга хэмжээг авна.

5. баталгаагүй байдал ба мөнгийг өөр зүйлд зарцуулах эрсдэл: зээл тараах ба гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөх үед мөнгийг бэлнээр олгох нь хөтөлбөрийн ажилтнууд ба хүлээн авагчдад аль алинд нь баталгаагүй байдлын асуудал үүсгэдэг. Энэ хоёр талын баталгаагүй байдлын эрсдэлийг тэнцвэртэй байлгах ёстой үүний тулд хэд хэдэн хувилбар аргыг бодолцох ёстой. Мөнгө хүлээн авагчдын хувьд хүрэхэд хялбар байдал болоод аюулгүй байдлыг бодолцон мөнгийг түгээж байгаа газрыг аль болох тэдний гэрт ойрхон байлгах буюу өөрөөр хэлвэл төвлөрлийг задлах ёстой боловч энэ нь хөтөлбөрийн ажилтнуудын аюулгүй байдалд эрсдэл учруулж болно. Авилгал юм уу хөрөнгийг өөр зүйлд зарцуулах магадлал өндөр байгаа тохиолдолд хөдөлмөрийн хөлсийг бэлэн мөнгөөр өгснөөс илүү хүнсээр төлөх нь зүйтэй.

6. халамж анхаарал тавих хариуцлага ба амьжиргаа: хүмүүс орлого олох боломжийг ашиглаж байгаа нь тэдний хүүхдээ асрах болон бусдад анхаарал халамж тавих үүрэг хариуцлагад нь сөргөөр нөлөөлөх ёсгүй. Учир нь энэ нь тэжээлийн хомсдолын эрсдэлийг нэмэгдүүлдэг. Хөтөлбөрүүдэд асрах ажилтнуудыг ажилд авах юм уу асрах байгууламжуудыг байгуулах хэрэгцээ байгаа эсэхийг тооцож үзэж болно (140-р хуудсан дээр байгаа тэжээлийн дэмжлэгийн ерөнхий стандарт 2-г үзнэ үү). Хариу арга хэмжээ нь өөр ажил хийх, боловсрол олох зэрэг бусад боломжуудыг ашиглахад саад болох юм уу айл өрхийн эх үүсвэрийг тэдний үйлдвэрлэлийн ажиллагаанаас хөндийрүүлэх ёсгүй.

7. ажлын хөлсний зарцуулалт: зохих хэмжээний цалин хөлс нь олж байгаа орлого хүнсний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай эх үүсвэрийн ихээхэн хэсгийг бүрдүүлнэ гэсэн үг юм. Айл өрхүүдийн бэлэн мөнгө ба хүнсний (тэр дундаа айл өрхийн доторхи хуваарилалт ба эцсийн хэрэглээ) зүйлийн менежментийг сайтар ойлгох шаардлагатай. Орлого олж байгаа үйл ажиллагаа ба ажил нь хүнсний аюулгүй байдлын олон зорилго агуулдаг бөгөөд тэр дунд хүнсний аюулгүй байдалд нөлөөлдөг бүлгийн түвшний эх үүсвэрүүд ордог. Жишээ нь, зам зассанаар зах зээлд хүрэх ба эрүүл мэндийн халамж үйлчилгээ авах боломжийг сайжруулдаг бол ургац хураах эсвэл усалгааны системийг засах юм уу байгуулснаар бүтээмж нэмэгддэг.

Хүнсний аюулгүй байдлын стандарт 4: зах зээлд нэвтрэх боломж

Үйлдвэрлэгч, хэрэглэгч, худалдаачин хүмүүсийн зах зээлийн бараа үйлчилгээг найдвартай авах боломжийг хамгаалж сайжруулах ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Хүнсний аюулгүй байдлын арга хэмжээнүүд нь орон нутгийн зах зээл ба эдийн засгийн системүүдийн талаархи гүнзгий ойлголт дээр үндэслэх ба авах арга хэмжээнүүдийг тэдгээрийн дагуу төлөвлөх бөгөөд шаардлагатай бол үүний тулд системийг сайжруулах эсвэл бодлогыг өөрчилж болно (Заавар тэмдэглэл 1-2-г уншина уу).
- Үйлдвэрлэгчид ба хэрэглэгчид нь үндсэн хэрэглээний бүтээгдэхүүнүүд тэр дундаа хүнсний бүтээгдэхүүнийг боломжийн үнээр тогтмол хангах үйл ажиллагаа явуулж байгаа зах зээлүүдэд эдийн засгийн хувьд болон өөрийн биеэр нэвтрэх боломжтой байх ёстой (Заавар тэмдэглэл 3-г уншина уу).
- Хүнсний аюулгүй байдлын хариу арга хэмжээ тэр дундаа хүнсний худалдан авалт ба түгээлтийг хэрэгжүүлэхдээ тэдгээр нь орон нутгийн зах зээлүүд ба зах зээлийн нийлүүлэгчдэд үзүүлэх сөрөг үр дагавруудыг аль болохоор хамгийн бага хэмжээнд байлгана (Заавар тэмдэглэл 4-г уншина уу).
- Зах зээлийн үнэ ба олдоц, зах зээл хэрхэн ажилладаг болон тэдгээрт хамаарах бодлогуудын талаархи мэдээллийг нэмэгдүүлж орон нутгийн оршин суугчдын тэдгээрийн талаархи ойлголтыг сайжруулна (Заавар тэмдэглэл 5-г уншина уу).
- Үндсэн хүнсний бүтээгдэхүүнүүд ба бусад хэрэглээний үндсэн бүтээгдэхүүнүүдийн олдоц сайн байх ёстой (Заавар тэмдэглэл 6-г уншина уу).

131

- Улирлын чанартай үнийн огцом өөрчлөлт юм уу бусад хэвийн бус үнийн хэлбэлзлийн сөрөг нөлөөг хамгийн бага хэмжээнд байлгана (Заавар тэмдэглэл 7-г уншина уу).

Заавар тэмдэглэл

1. **Зах зээлийн шинжилгээ:** нь орон нутгийн, бүсийн, улсын гэх мэт зах зээлийн төрлүүд ба тэдгээр нь хоорондоо ямар холбоотой болохыг судлах ёстой. Ингэхдээ гамшигт өртсөн бүх бүлгийн хүмүүс тэр дундаа эмзэг бүлгийн хүмүүсийн зах зээлд нэвтрэх боломжийг бодолцох ёстой. Хүнсний бүтээгдэхүүн юм уу үр тариа, хөдөө аж ахуйн багаж хэрэгсэл, орон сууцны материал зэрэг үйлдвэрлэлд хэрэглэгдэх зүйлүүдээр хийж байгаа төлбөрийг хийхийн өмнө нийлүүлж байгаа бүтээгдэхүүнтэй холбоотой зах зээлийн шинжилгээ хийх ёстой. Илүүдэл бүтээгдэхүүнийг худалдаж авах нь орон нутгийн зах зээлд тустай байдаг. Үр тариа гэх мэт үйлдвэрлэлийн хүчин зүйлүүд нь нээлттэй зах зээл дээр байхгүй боловч үр тарианы

- хангамжийн сүлжээгээр дамжуулж тариаланчидтай харьцах боломжтой үед эдгээр сүлжээнүүдэд гаднаас авдаг үйлдвэрлэлийн хүчин зүйл ямар үүрэгтэй болохыг тооцох ёстой.
2. **Дэмжлэг:** зах зээлүүд нь орон нутгийн зах зээлийн нөхцөл байдалд нөлөө үзүүлдэг илүү өргөн хүрээний улсын болон дэлхийн эдийн засгийн орчинд ажилладаг. Жишээ нь төрийн бодлого тэр дундаа үнийн ба худалдааны бодлогууд нь зах зээлд нэвтрэх боломж ба бүтээгдэхүүний олдцод нөлөөлдөг. Энэ түвшинд хэрэгжиж байгаа арга хэмжээ нь гамшгийн эсрэг арга хэмжээний хүрээнд багтахгүй боловч эдгээр хүчин зүйлүүд нь хамтран ажиллах боломж юм уу нөхцөл байдлыг сайжруулахад төрийн ба бусад байгууллагад дэмжлэг боломж олгож болох учраас тэдгээрийг шинжлэн судлах ёстой.
 3. **Зах зээлийн эрэлт ба нийлүүлэлт:** зах зээлд нэвтрэх эдийн засгийн боломжид худалдан авах чадвар, зах зээлийн үнэ ба олдоц ордог. Үнийн боломжийн байдал нь үндсэн хэрэгцээ (тэр дундаа хүнс, үр тариа, багаж хэрэгсэл, эрүүл мэндийн халамж зэрэг амин чухал хүчин зүйлүүд) ба орлогын эх үүсвэрүүдийн (бэлэн мөнгө, ургац, мал, цалин гэх мэт) худалдааны нөхцлөөс хамаардаг. Худалдааны нөхцөл муудсанаар хүмүүс үндсэн хэрэгцээгээ хангахын тулд (хөөрөгдсөн үнээр) эд хөрөнгөө зарахад хүрснээр (ихэнхдээ бага үнээр) эд хөрөнгөө алдана. Зах зээлд нэвтрэх боломжид мөн улс төрийн болон аюулгүй байдлын орчин, тодорхой бүлгийн хүмүүсийн (жишээ нь цөөнх) зах зээлд нэвтрэх боломжийг хязгаарлах соёлын юм уу шашны хүчин зүйл нөлөөлж болно.
 4. **хөндлөнгийн оролцооны нөлөө:** орон нутагт үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүн, үр тариа болон бусад хэрэглээний бүтээгдэхүүнүүдийн хангамж нь орон нутагт инфляци үүсгэж болох ба энэ нь хэрэглэгчдэд ашиггүй боловч орон нутгийн үйлдвэрлэгчдэд ашигтай байдаг. Үүний эсрэгээр гаднаас өгсөн хүнсний тусламж нь бүтээгдэхүүний

үнийг унахад хүргэснээр орон нутгийн хүнсний үйлдвэрлэгчдийн сонирхлыг бууруулж хүнсний аюулгүй байдлын эрсдэлд өртөх хүмүүсийн тоог нэмэгдүүлдэг. Хангамж хариуцсан хүмүүс нь эдгээр нөлөөг ажиглан тооцож байх ёстой. Хүнсний түгээлт нь орлогын шилжилтийн нэг хэлбэр учраас хүлээн авч байгаа хүмүүсийн төлбөрийн чадварт муугаар нөлөөлдөг. Жишээ нь тос ба холимог хүнсний бүтээгдэхүүн гэх мэт зарим бүтээгдэхүүн нь нөгөөдөхөөсөө илүү хялбархан борлуулагддаг. Ямар нэг хүнсний бүтээгдэхүүн юм уу багц бүтээгдэхүүнийг худалдан авах хүмүүсийн чадвар нь тухайн бүтээгдэхүүнийг хүлээн авч байгаа хүмүүс түүнийг идэж байна уу дамжуулан зарж байна уу гэдгээс хамаардаг. Хүнсний түгээлтийн хөтөлбөрүүдийн илүү өргөн хүрээний нөлөөг тодорхойлохын тулд айл өрхийн худалдан авах ба худалдах үйл ажиллагааг ойлгох шаардлагатай (мөн хүнсний тусламжийн менежментийн стандарт 3-г үзнэ үү).

5. **Зах зээлийн ил тод бодлого:** орон нутгийн үйлдвэрлэгчид ба хэрэглэгчид зах зээлийн үнийн хяналт ба эрэлт, нийлүүлэлтэнд нөлөөлөх бусад бодлогуудын талаар мэдэх ёстой. Эдгээрт төрийн мөнгөний ба татварын бодлогууд, бүтээгдэхүүнүүдийн бүс нутгийн дотор хил дамнах

хөдөлгөөнд нөлөөлөх бодлогууд, хөрш нутгуудын хоорондох худалдааг дэмжих зорилготой орон нутгийн төлөвлөгөөнүүд (зөрчил үүссэн олон тохиолдолд эдгээр асуудлуудын талаар ил тод бодлого барих зайлшгүй шаардлагагүй байж болно)

6. **хүнсний гол бүтээгдэхүүнүүд:** зах зээлийн ажиглалтад хамруулах хүнсний бүтээгдэхүүний сонголт нь орон нутгийн хүнсний хэрэглээний зуршлаас шалтгаалдаг учраас үүнийг орон нутгийн хэмжээнд хийх ёстой. Тухайн нөхцөлд ямар хүнсний бүтээгдэхүүнүүд зайлшгүй шаардлагатай болохыг тогтоохын тулд тэжээллэг чанараараа тохиромжтой бүтээгдэхүүнүүдийг төлөвлөх зарчмыг баримтлах ёстой (137-р хуудсан дээр байгаа тэжээлийн дэмжлэгийн ерөнхий стандарт 1 ба 157-р хуудсан дээр байгаа хүнсний тусламжийн төлөвлөлтийн стандарт 1-г үзнэ үү).
7. **Улирлын чанартай үнийн хэт их хэлбэлзэл:** нь орлого багатай хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчдэд өөрсдийн бүтээгдэхүүнүүдийг үнэ хамгийн бага байгаа үед (ургацын дараа гэх мэт) борлуулахад хүргэснээр тэдэнд сөрөг үр дагавартай байж болно. Нөгөө талаас хүнсний бүтээгдэхүүн нөөцлөх боломжгүй бага орлоготой бөгөөд худалдан авалтыг бага багаар нь хийдэг хэрэглэгчид нь үнэ хамгийн их байгаа үед (жишээ нь, ган болсон үед) худалдаж авах шаардлагатай болдог. Ийм сөрөг үр дагаврыг багасгах боломжтой хөндлөнгийн оролцооны жишээнд тээврийн системийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, хүндрэлтэй үед бэлэн мөнгө юм уу хүнсний бүтээгдэхүүн шилжүүлэх ажиллагаанууд орно.

Тэжээл

Тэжээлийн үнэлгээ ба шинжилгээний стандарт 115-р хуудсыг үзнэ үү

Тэжээлийн ерөнхий нэмэлт

Тэжээлийн хомсдолыг арилгах

Стандарт 1

Бүх бүлгийн хүмүүс

Стандарт 1

Бага хэмжээний тэжээлийн хомсдол

Стандарт 2

Эрсдэлд орсон бүлгийн хүмүүс

Стандарт 2

Тэжээлийн хурц хомсдол

Стандарт 3

Бичил тэжээлийн хомсдол

Хавсралт 4

Тэжээлийн үнэлгээний хуудас

Хавсралт 5

Тэжээлийн хурц хомсдолын хэмжилт

Хавсралт 6

А витамин ба иодын дутагдал нь олон нийтийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

Хавсралт 7

Тэжээлд тавигдах шаардлагууд

Хавсралт 9

Ном зүй

3.Тэжээлийн минимум стандартууд

Хүнсний хомсдолын шууд шалтгаан нь өвчин ба хүнсний хангалтгүй хэрэглээ байдаг бөгөөд энэ нь эргээд айл өрхийн ба бүлгийн түвшинд хүнс, эрүүл мэнд, асаргаа сувилгааны нөхцлийн хангалтгүй байдлаас шалтгаалдаг.

Урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн зорилго нь үнэлгээний үед тогтоосон хүнсний хомсдолын шалтгаануудыг арилгах явдал юм. Үүнд хүмүүс хангалттай хэмжээний чанартай хоол хүнс хэрэглэх боломжтой байхаас гадна хоол хүнсийг аюулгүй байдлаар бэлтгэж хэрэглэх боломжийг баталгаажуулах, хүмүүсийн амьдралын орчныг баталгаажуулах, хүмүүс чанартай эрүүл мэндийн үйлчилгээнд (урьдчилан сэргийлэх ба эмчлэх) хамрагдах боломжийг бүрдүүлж өвчин тусах магадлалыг бууруулах, хүн амын тэжээлийн хомсдолд өртөмтгий хэсэгт анхаарал халамж тавих орчныг бүрдүүлэх явдлыг баталгаажуулах зорилго багтана. Анхаарал халамж гэдэгт айл өрхийн

болон бүлгийн хүрээнд гэр бүлийн гишүүдийн биеийн, оюун санааны болон нийгмийн хэрэгцээгээ хангахын тулд цаг хугацаа, анхаарал, дэмжлэгээ зориулах асуудал орно. Нийгмийн анхаарал халамж бүхий орчин нь хүнсний тусламж ба хүнсний аюулгүй байдлын стандартын дагуу хамгаалагддаг бол хүн амын хамгийн их эрсдэлд өртсөн хэсэгт тавих анхаарал халамж ба дэмжлэгийн асуудлыг хүнс тэжээлийн стандартад тавьсан байдаг.

Хүнсний хомсдолын асуудлыг арилгах зорилготой хөтөлбөрүүд нь тусгай хооллолтын хөтөлбөрүүд, тэжээлийн хомсдолд орсон хүмүүсийн эмчилгээ ба дэмжлэгийн хөтөлбөрүүдээс бүрдэж болно. Хооллолтын хөтөлбөрүүдийг зөвхөн хүний хэмжилтийн судалгааг явуулсан юм уу төлөвлөсөн үед л хэрэгжүүлнэ. Тэдгээрийг үргэлж урьдчилан сэргийлэх арга хэмжээний хамт хэрэгжүүлэх ёстой. Энэ хэсэгт танилцуулсан эхний хоёр стандарт нь тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдтэй холбоотой хүнс тэжээлийн асуудлын талаар өгүүлж байгаа бөгөөд тэдгээрийг хүнсний тусламж ба хүнсний аюулгүй байдлын стандарттай хамт хэрэглэх ёстой. Сүүлийн гурван стандарт нь тэжээлийн хомсдолыг арилгах зорилготой хөтөлбөрүүдэд хамаарна.

135

Тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх ба арилгах арга хэмжээнүүд нь энэ бүлэг ба бусад бүлгүүдэд байгаа эрүүл мэндийн үйлчилгээ, усны хангамж, ариун цэвэр, орон байрны стандартуудын шаардлагыг хангах ёстой. Тэдгээр нь мөн 1-р бүлэгт байгаа (21-р хуудсыг үзнэ үү) ерөнхий стандартуудыг хангах ёстой. Өөрөөр хэлвэл бүх бүлгийн хүмүүсийн хүнс тэжээлийн зохих нөхцлийг тэдгээрийн амьд үлдэх боломж ба нэр төрд хохирол учруулахгүй байдлаар хамгаалж дэмжлэг үзүүлэхэд зөвхөн энэ хэсэгт бичигдсэн стандартуудын шаардлагыг хангах нь хангалтгүй юм.

Тэжээлийн хомсдол ба нас баралт

Хүнсний хангалтгүй хэрэглээ

Өвчин

Айл өрхийн хүнсний аюулгүй байдлын хангалтгүй нөхцөл

Эхчүүд, хүүхдүүдэд тавих анхаарал халамжийн

Хангалтгүй үйлчилгээ ба эрүүл бус орчин

хангалтгүй нөхцөл

албан ба албан бус байгууллагууд, улс төр ба үзэл суртлын
бүтцүүд, эдийн засгийн бүтэц, боломжит нөөц

тэжээлийн хомсдолын шалтгааныг харуулсан схем

136

Хүнс тэжээлийн ерөнхий нөхцөл

Энэ хэсэгт олон нийт ба тэжээлийн хомсдолд орох эрсдэлд илүү өртсөн тодорхой бүлгүүдийн хэрэгцээг хангахад шаардлагатай хүнс тэжээлийн нөөц ба үйлчилгээний асуудлыг хөндөнө. Эдгээр хэрэгцээг хангах хүртэл тэжээлийн хомсдолыг арилгах зорилготой аливаа арга хэмжээний үр нөлөө хязгаарлагдмал байх магадлалтай. Учир нь тэжээлийн хомсдолоо нөхсөн хүмүүс эргээд тэжээлийн нөхцөл хангалтгүй орчинд буцаж орсноор дахин тэжээлийн хомсдол үүсэх магадлалтай.

Хүн ам нь өөрсдийн хүнс тэжээлийн хэрэгцээний зарим хэсгийг юм уу бүрэн хангахын тулд хүнсний тусламж авах шаардлагатай тохиолдолд хүнс тэжээлийн нөхцлийн ерөнхий стандарт 1-г 157-160-р хуудсанд байгаа хүнсний тусламжийг төлөвлөх стандарт 1-2 ба 233-236-р хуудсанд байгаа хүнсний бус зүйлүүдийн стандарт 3-4-ийн хамт ашиглана. Гэхдээ нөхцөл байдлаас шалтгаалж гамшигт өртөмтгий хүмүүс нь янз бүр байдаг учраас тухайн тохиолдол бүрт эрсдэлд орсон бүлгүүдийг олж тогтоох ёстой.

Тэжээлийн ерөнхий нөхцлийн стандарт 1. бүх бүлгүүд

Хүн ам бүрийн тэжээлийн хэрэгцээг хангах ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Тэжээлийн үзүүлэлтийн шаардлагыг хангасан үндсэн, ургамлын ба малын гаралтай, өөх тос бүхий олон тооны хүнсний бүтээгдэхүүн олдоцтой байх ёстой (Заавар тэмдэглэл 1-г үзнэ үү)
- А, С, витамин болон төмрөөр баялаг юм уу хүчирхэгжүүлсэн тэжээл эсвэл тохирох нэмэлт тэжээл олдоцтой байх ёстой (Заавар тэмдэглэл 2, 3, 5, 6-г үзнэ үү).
- Айл өрхүүдийн ихэнх хэсэг нь (90%-ээс дээш) иоджуулсан давс хэрэглэх боломжтой байх ёстой (Заавар тэмдэглэл 2, 3, 6-г үзнэ үү).
- Ниацины нэмэлт эх үүсвэр хэрэглэх боломжтой байх ёстой (Заавар тэмдэглэл 2, 3-г үзнэ үү).
- Тиамины нэмэлт эх үүсвэр олдоцтой байх ёстой (Заавар тэмдэглэл 2, 3-г үзнэ үү).

137

- Хүмүүс маш хязгаарлагдмал хүнсний нөөцтэй байгаа үед рибофлавин буюу riboflavin-ы зохих эх үүсвэр олдоцтой байх ёстой (Заавар тэмдэглэл 2, 3-г үзнэ үү).
- Тэжээлийн бага зэргийн ба хурц хомсдол нь тогтмол байдлаар юм уу хүлээн зөвшөөрөхүйц түвшинд хүртэл буурсан байх ёстой (Заавар тэмдэглэл 4-г үзнэ үү)
- Чийг бам, ходоо гэдэсний эмгэг, бери бери, рибофлавины хомсдол г.м. өвчнүүд байх ёсгүй (Заавар тэмдэглэл 5-г үзнэ үү)
- Нүдний эмгэг ба иодын дутагдал нь нийгмийн эрүүл мэндэд хохирол учруулахгүй хэмжээнд байна (Заавар тэмдэглэл 6-г үзнэ үү)

Заавар тэмдэглэл

1. Хүнс тэжээлийн үзүүлэлтийн шаардлага: хүн амын хүнс тэжээлийн үзүүлэлтэд тавигдах дараахи дундаж шаардлагыг Хавсралт 7-д тайлбарласны дагуу хүн ам тус бүрт нь тохируулж хэрэглэнэ. Үүнд:

- нэг хүн өдөрт 2,100 ккал энерги авна
- нийт энергийн 10-12%-ийг уурагнаас авна
- нийт энергийн 17%-ийг өөх тосноос авна

- шинэ юм уу хүчирхэгжүүлсэн хүнснээс зохих хэмжээний бичил тэжээл авна.

Эдгээр шаардлага нь хүн амын хүнсний тэжээлийн хэрэгцээг хангахын тулд хүн ам бүхэлдээ хүнсний тусламжаас хамааралтай тохиолдолд л тавигддаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Хүмүүс хүнс тэжээлийн хэрэгцээнийхээ зарим хэсгийг өөрсдөө хангах боломжтой тохиолдолд үнэлгээн дээр үндэслэн хүнсний тусламжийг зохицуулдаг. Хүнсний түгээлтийг төлөвлөхдөө 157-р хуудсанд байгаа хүнсний тусламжийн төлөвлөлтийн стандарт 1-г үзнэ үү.

2. Бичил тэжээлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх: Хэрвээ улаан бурхан, хумхаа, паразитын халдвар гэх мэт өвчнөөс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зохих арга хэмжээг авсан бол дээрх шаардлагуудыг хангасан тохиолдолд хүн амын бичил тэжээлийн нөхцөл цаашид муудах ёсгүй (273-р хуудсанд байгаа халдварт өвчний хяналтын стандартуудыг үзнэ үү). Бичил тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх боломжит хувилбарууд бол тэжээллэг хүнс хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээнүүд авах (124-131-р хуудсанд байгаа хүнсний аюулгүй байдлын стандарт 2-3-г үзнэ үү), хоол хүнсийг хүчирхэгжүүлэх юм уу холимог хоол нэмэх замаар сайжруулах, эсвэл орон нутгаас худалдан авсан бүтээгдэхүүнээр дутагдаж байгаа тэжээлийг нөхөх, эм орцонд нь оруулах аргууд юм.

138

Хоол хүнсний тээвэрлэлт, хадгалалт, боловсруулалт, болголтын үед бичил тэжээл алдагдах хэмжээг тооцох нь зүйтэй. Тэжээллэг хүнсийг орон нутгаас авах боломжтой үед хоол хүнсний солилцоог нэмэгдүүлэх үүднээс хүнсний хэмжээг нэмэгдүүлэх хувилбарыг хэрэглэж болох боловч гарах зардал ба зах зээлд үзүүлэх нөлөөг бодолцох ёстой.

3. бичил тэжээл хэрэглэх боломжийг хянах: дээрх үзүүлэлтүүд нь хүнсний чанарыг илэрхийлэх боловч хүнс тэжээлийн олдоцыг илэрхийлж чадахгүй. Хүнс тэжээлийн хэрэглээг тоон үзүүлэлтээр илэрхийлэхийн тулд хэрэгжүүлэх боломжгүй их хэмжээний мэдээлэл цуглуулах шаардлагатай болно. Үзүүлэлтүүдийг янз бүрийн эх үүсвэрүүдээс өөр өөр аргаар цуглуулсан мэдээллийг ашиглан хэмжиж болно. Үүний тулд өрх айлын түвшин дэх хоолны олдоц ба хэрэглээг ажиглах, зах зээл дээрх хүнсний үнэ ба олдоцыг үнэлэх, түгээсэн хүнсний тэжээлийн агуулгыг хэмжих, хүнсний тусламжийн түгээлтийн төлөвлөгөө ба бүртгэлийг шалгах, байгалийн зэрлэг хүнсний эзлэх хувь хэмжээг тооцох, хүнсний аюулгүй байдлын үнэлгээ хийх шаардлага гарч болно. Өрх айлын түвшин дэх шинжилгээ нь хувь хүний хоол хүнсний хэрэглээг харуулахгүй. Гэр бүл доторхи хоол хүнсний хуваарилалт заавал тэгш байх албагүй ба эмзэг бүлгийнхэн илүү эрсдэлд орох магадлалтай бөгөөд үүнийг амьдрал дээр судалж тогтоох боломжгүй юм. Түгээлтийн механизмууд (168-р хуудсанд байгаа хүнсний тусламжийн менежментийн стандарт 3-г үзнэ үү), хүнсний тусламжийн бүтээгдэхүүний сонголт, гамшигт өртсөн хүн амтай хийх яриа нь гэр бүлийн доторхи хоол хүнсний хуваарилалтыг сайжруулахад тусалж болно.

4. Хүнсний хомсдолын зэргийг тайлбарлах: хүнсний хомсдолын хандлагыг эрүүл мэндийн төвийн бүртгэл мэдээ, олон давтан явуулсан хүний хэмжилт, хүнс тэжээлийн тандалт, үзлэг, хүн амын дундаас авсан мэдээнээс харж болно. Томоохон газар нутгийг хамарсан юм уу удаан хугацааны

туршид хүнс тэжээлийн хомсдолын ажиглалт явуулах байгууламж байгуулах нь зардал ихтэйгээс гадна мэргэжлийн нарийн мэдлэг шаардаж болно. Ийм байгууламж байгуулах харьцангуй зардлыг нөөц боломжтой харьцуулж дүгнэх ёстой. Тандалт ба тодорхой хугацаанд давтан явагдах ажиглалтыг хоёуланг нь хэрэглэх гэх мэтээр бие биенээ харилцан нөхсөн мэдээллийн системийг хослуулан хэрэглэх нь нөөц боломжийг ашиглах хамгийн үр дүнтэй арга байж болно. Орон нутгийн байгууллагууд ба оршин суугчид нь аль болохоор ажиглалт явуулах, олсон мэдээллийг тайлбарлах, хариу арга хэмжээг төлөвлөхөд оролцох ёстой. Тэжээлийн хомсдолын түвшин нь хүлээн зөвшөөрч болох эсэхийг тогтоохын тулд нөхцөл байдлыг харьцуулахдаа хүн ам, нас баралт ба өвчлөлтийн зэрэг (260-р хуудсанд байгаа эрүүл мэндийн системүүд ба дэд бүтцийн стандарт 1, удирдамжийн тайлбар 3-г үзнэ үү), улирлын чанартай хэлбэлзлүүд, хүнс тэжээлийн хомсдолын онцгой байдлын өмнөх түвшин, тэжээлийн хомсдолын цаадах шалтгаан зэргийг шинжлэх шаардлагатай.

5. өргөн хүрээний бичил тэжээлийн хомсдол: чийг бам буюу scurvy (vitamin C), гэдэс ходоодны эмгэг буюу pellagra (niacin), бери-бери буюу beri-beri (thiamine), рибофлавин буюу riboflavin гэсэн дөрвөн бичил тэжээлийн хомсдолын хэлбэр нь тусламжаас хамааралтай хүн амын хоол хүнсэнд бичил тэжээл дутагдсанаас шалтгаалж үүсдэг хамгийн түгээмэл ажиглагддаг хэлбэрүүд бөгөөд гамшгийн нөхцөлд тэднээс зайлсхийх боломжтой учраас тэднийг энд онцлон авч үзсэн болно. Жишээ нь, хэрвээ эдгээр хомсдолын аль нэгэнд өртсөн хувь хүмүүс эрүүл мэндийн төвд ирвэл энэ нь хүн амын дунд тодорхой төрлийн хоол хүнсийг хэрэглэх боломж ихээхэн хязгаарлагдмал байгаа бөгөөд энэ нь хүн амын дунд нийтлэг тархсан байж болно гэдгийг харуулж байгаа хэрэг юм. Үүнтэй нэг адилаар хүнсний хомсдолын асуудлыг хүн амыг бүхэлд нь хамарсан хөндлөнгийн оролцоо ба хувь хүний эмчилгээний тусламжтай шийдэх ёстой (152-р хуудсанд байгаа тэжээлийн хомсдолыг залруулах стандарт 3-г үзнэ үү). Ямар ч нөхцөлд эдгээр бичил тэжээлийн хомсдол нь өргөн тархсныг батлах тодорхой баримт байвал тэдгээрийн тархалтын түвшинг ядаж гамшгийн өмнөх хэмжээнд хүртэл бууруулах ёстой.

8. хязгаарлагдмал хүрээний бичил тэжээлийн хомсдол: бичил тэжээлийн хомсдолыг олж тогтоох нь хүндрэлтэй байдаг нь гамшгийн эхэн үед бичил тэжээлийн хомсдолыг арилгахад бэрхшээл учруулдаг. Харин А витамин ба иодын дутагдлыг хээрийн нөхцөлд олж тогтоох хэмжүүрүүд байдаг. Эдгээр хомсдолуудыг мөн хүн амын түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээ, жишээ нь хүүхдүүд ба төрсөн эмэгтэйчүүдэд өндөр тунгийн нэмэгдэл А витамин өгөх, давсыг иоджуулах, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх кампанит ажил явуулах зэрэг арга хэмжээний тусламжтай шийдэж болно. Тэдгээрийн нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг Хавсралт 6-аас үзнэ үү.

Тэжээлийн ерөнхий нөхцлийн стандарт 2: эрсдэлтэй бүлгүүд

Эрсдэлд орсон бүлгүүдийн тэжээлийн ба дэмжлэгийн хэрэгцээг хангах ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Зургаан сараас бага насны хүүхдүүдийг зөвхөн хөхөөр хооллох шаардлагатай ба зарим онцгой тохиолдолд хөхний сүүг зохих хэмжээнд орлуулах хангалттай тэжээл хэрэглэх ёстой (Заавар тэмдэглэл 1-2-г үзнэ үү).
- 6-24 сартай хүүхдүүд тэжээллэг, энерги ихтэй, харилцан биенээ нөхсөн хоол хүнс хэрэгдэх боломжтой байх ёстой (Заавар тэмдэглэл 3-г үзнэ үү).
- Жирэмсэн болон хөхүүл эхчүүд нэмэлт тэжээл ба дэмжлэг авах боломжтой байх ёстой (Заавар тэмдэглэл 4-г үзнэ үү).

140

- Өсвөр насны охидуудад тавих анхаарал халамж ба тэжээлийг хамгаах, сайжруулах, дэмжихэд онцгой анхаарал тавих ёстой (Заавар тэмдэглэл 4-г үзнэ үү).
- Холбогдох мэргэжилтнүүд, асран хамгаалагчид, хүүхдийн хүнс тэжээлтэй холбоотой үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг хүнс тэжээлтэй холбоотой зохих мэдээлэл, боловсрол, сургалтаар хангах ёстой (Заавар тэмдэглэл 1-4 ба 8-г үзнэ үү).
- Өндөр настай хүмүүсийн тэжээллэг хоол ба хүнс тэжээлийн дэмжлэгийг хамгаалах, сайжруулах, дэмжих ёстой (Заавар тэмдэглэл 5-г үзнэ үү).
- Архаг өвчтэй тэр дундаа ХДХВ/ДОХ-ын халдвартай хүмүүсийн гэр бүлийнхэн ба тахир дутуу хүмүүсийн гэр бүлийнхэн зохих хэмжээний тэжээллэг хоол хүнс ба тэжээлийн дэмжлэгийг авах ёстой (Заавар тэмдэглэл 6-8-г үзнэ үү).
- Эмзэг бүлгийн хувь хүмүүст зохих анхаарал халамж тавихын тулд оршин суугчдад суурилсан системүүдийг бий болгох ёстой (Заавар тэмдэглэл 8-г үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. Нярай хүүхдийн хооллолт: зургаагаас доош сартай хүүхдүүдийг зөвхөн хөхөөр хооллох нь эрүүл мэндэд тустай хамгийн шилдэг арга юм. Зөвхөн хөхөөр хооллодог хүүхдүүд нь уураг, ус, цай, нэмэлт хоол хүнс хэрэглэдэггүй. Зөвхөн хөхөөр хооллодог хүүхдүүдийн эзлэх хувь бага байдаг учраас ялангуяа эрүүл ахуйн ба асаргааны нөхцөл бүрдээгүйн улмаас халдвар авах эрсдэл нэмэгдсэн үед хөхөөр хооллох явдлыг дэмжиж нэмэгдүүлэх нь чухал юм. Хүүхдийг зөвхөн хөхөөр хооллох боломжгүй онцгой тохиолдлууд байдаг (эх нь нас барсан юм уу хүүхдийг аль хэдийн хөхөөр хооллохоо больсон гэх мэт). Энэ тохиолдлуудад Кодекс Алиментариус стандартын дагуу хангалттай хэмжээний тохирох хөхний сүү орлуулагчаар хооллох ба боломжтой үед нь дахин хөхөөр хооллох нь зүйтэй. Хөхний сүүний орлуулагч нь аюулгүй нөхцөлд бэлдэхэд хүндрэлтэй учраас аюултай байж

болно. Эрүүл ахуйн шаардлага хангадаггүй учраас угжийг хэзээ ч хэрэглэж болохгүй. Мэргэжилтнүүдэд хөхөөр хооллох ба буцаан хөхөнд оруулах явдлыг хамгаалах, нэмэгдүүлэх, дэмжих талаар сургалт явуулах шаардлагатай. Хүүхдийн сүүний жорыг түгээсэн тохиолдолд халамж анхаарал үзүүлж байгаа хүмүүст түүнийг аюулгүй байдалд хэрэглэх зөвлөгөө ба дэмжлэгийг үзүүлэх ёстой. Сүү орлуулагчийг нийлүүлэх ба түгээхдээ Хөхний сүү орлуулагчийг борлуулах олон улсын код ба Дэлхийн эрүүл мэндийн ассамблейн шийдвэрүүдийн дагуу гүйцэтгэх ёстой.

2. ХДХВ/ДОХ ба хүүхдийн хооллолт: ДОХ-ын шинжилгээг сайн дураараа бөгөөд нууцыг хадгалах нөхцөлд авах боломжгүй тохиолдолд бүх эхчүүдэд хүүхдээ хөхөөр хооллоход нь дэмжлэг үзүүлэх ёстой. Хэрвээ эх нь шинжилгээнд ороогүй бол хөхний сүү орлуулагч хэрэглэхийг зөвлөх нь хэтэрхий эрсдэлтэй. Хэрвээ эмэгтэй хүн шинжилгээнд орж ДОХ-ын вирустэй гарсан бол хүлээн зөвшөөрөхүйц, хэрэгжүүлэх боломжтой, үнэ багатай, байнга хэрэглэх боломжтой, аюулгүй сүү орлуулах тэжээлийг хэрэглэх нь зүйтэй. Хүүхдээ хөхөөр хооллохоос татгалзсан ДОХ-ын халдвартай эхчүүдэд тодорхой зааварчилгаа өгч ядаж эхний хоёр жилийн хугацаанд хүүхдээ зохих шаардлагын хэмжээнд хооллоход нь дэмжлэг үзүүлэх ёстой.

3. бага насны хүүхдийн хооллолт: хүүхдийг ядаж хоёр нас хүртэл хөхөөр хооллох нь зүйтэй. Зургаан сартайд нь хүүхдэд энергиэр баяжуулсан тэжээлийг хөхний сүүн дээр нэмж өгөх ба тэд энергийн 30% -ыг нь өөх тосноос авах нь зүйтэй. 6-24 сартай хүүхэд хөхөөр хооллох боломжгүй үед тэдний хоол тэжээл нь тэжээлийн бүх шаардлагыг хангах хангалттай хэмжээтэй байх ёстой. Айл өрхүүдийг 24-өөс доош сартай хүүхдүүдэд тохирох нэмэлт хоол хүнс бэлтгэх хэрэгсэл ба чадвараар хангахад хүчин зүтгэл гаргах шаардлагатай. Үүнийг тусгай хүнсний бүтээгдэхүүн, сав суулга, түлш, усаар хангах замаар шийдвэрлэж болно. Улаан бурхны дархлаажуулалт хийгдэж дууссаны дараа 6-59 сартай хүүхдүүдэд нэмэлт А витамин өгөх нь түгээмэл арга юм. Бага жинтэй төрсөн хүүхэд ба бага насны хүүхдүүдэд ч гэсэн төмрийн нэмэгдэл тустай боловч ингэхдээ холбогдох протоколыг мөрдөх нь хүндрэлтэй байдаг.

4. Жирэмсэн ба хөхүүл эмэгтэйчүүд: жирэмсэн ба хөхүүл эмэгтэйчүүд хангалттай хэмжээний хүнс тэжээл хэрэглээгүйтэй холбоотой эрсдэлд жирэмсний хүндрэл, эхийн эндэгдэл, дутуу төрөлт, хөхөөр хооллох боломжгүй болох явдал ордог. Ерөнхий хоол хүнсний хангамжийн төлөвлөгөөнд жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдийн нэмэгдэл тэжээлийн хэрэгцээг тооцох ёстой. Хүнсний ерөнхий хангамж шаардлага хангахгүй байгаа үед тэжээлийн хомсдолоос сэргийлэхийн тулд нэмэлт хүнс

шаардлагатай болж болно. Жирэмсэн болох үеийн дутуу жин нь төрсөн хүүхдийн дутуу жинтэй шууд холбоотой байгаа нь өсвөр насны охидуудад тэжээлийн дэмжлэг үзүүлэх механизм шаардлагатай байдаг гэдгийг харуулж байна. Жирэмсэн ба хөхүүл эмэгтэйчүүд нь төмөр ба фолийн хүчлийн нэмэлт хэрэглэх шаардлагатай боловч хүүхдүүдийн нэг адил түүнийг яг таг мөрдөх нь хүндрэлтэй байдаг. Тийм учраас олон төрлийн хүнс хэрэглэх замаар төмрийн дутагдлыг багасгах арга хэмжээ авах нь зүйтэй юм (Тэжээлийн ерөнхий дэмжлэгийн стандарт 1-г үзнэ үү). Төрсөн эмэгтэйчүүд төрснөөс хойш 6 сарын хугацаанд А витамин хэрэглэх ёстой.

5. Өндөр настай хүмүүс: нь гамшигт илүү өртөх магадлалтай байдаг. Хоол хүнс хэрэглэх боломжийг бууруулж тэжээлийн шаардлагыг нэмэгдүүлэх тэжээлийн эрсдэлийн хүчин зүйлүүдэд өвчин ба биеийн махбодийн доголдлууд, сэтгэл зүйн ба нийгмийн стресс, хүйтрэл ба ядуурал ордог. Эдгээр хүчин зүйлүүд нь албан болон албан бус ердийн дэмжлэг байхгүй болсон үед улам ноцтой болдог. Хүнсний ерөнхий хангамжийн төлөвлөлтөнд настай хүмүүсийн хүнс тэжээлийн шаардлагыг тооцох ба тэдний тэжээлийн болон анхаарал халамжийн хэрэгцээнд онцгой анхаарал хандуулах ёстой. Тухайлбал:

- өндөр настай хүмүүс хоол хүнсээ хялбархнаар олж авах боломжтой байх ёстой (тэр дундаа тусламжийн хүнс)
- хоол хүнс нь бэлтгэж хэрэглэхэд хялбар байх ёстой
- хоол хүнс нь өндөр настай хүмүүсийн нэмэлт уураг ба бичил тэжээлийн шаардлагыг хангасан байх ёстой.

Өндөр настай хүмүүс бусад өрхийн гишүүдийн хувьд анхаарал халамж тавьдаг хүмүүс байх нь олонтоо байдаг бөгөөд тэд өөрсдийн үүргийг гүйцэтгэхэд онцгой туслалцаа шаардаж болно.

6. ХДХВ/ДОХ-ын халдвартай хүмүүс: нь хэд хэдэн хүчин зүйлийн улмаас тэжээлийн хомсдолд орох магадлал ихтэй байдаг. Эдгээр хүчин зүйлүүдэд хоолны дуршил байхгүй болох юм уу хоол идэх үеийн хүндрэлийн улмаас хоолны хэрэглээ багасах, гүйлгэлтийн улмаас тэжээлийн шингээлт муудах, паразит үүсэх юм уу ходоод гэдэсний эс гэмтэх, бодисын солилцоо өөрчлөгдөх, архаг халдвар ба өвчин үүсэх зэрэг болно. ДОХ-ын халдвартай хүмүүсийн энергийн хэрэгцээ халдварын үе шатаас хамааран нэмэгддэг болох нь батлагдсан. Дархлааны системийг хадгалж амьд явах боломжийг нэмэгдүүлэхийн тулд бичил тэжээл маш чухал байдаг. ДОХ-ын халдвартай хүмүүс нь ДОХ-ын вирусн дайралтыг удаашруулахын тулд сайн хоол хэрэглэхээс гадна эрүүл байх шаардлагатай. Тэд шаардлага хангасан хоол хүнс хэрэглэх боломжтой байхын тулд тусламжийн хүнсийг нунтаглаж

хүчирхэгжүүлэх юм уу хүчирхэгжүүлсэн ба холимог хүнсээр хангагдах нь боломжит стратеги бөгөөд зарим тохиолдолд нийт хоол хүнсний хангамжийн хэмжээг нэмэгдүүлэх нь тохиромжтой байж болно (35-р хуудсанд байгаа сонголтын стандартыг үзнэ үү).

7. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс: нь хэд хэдэн янзын тэжээлийн эрсдэлд өртөх магадлалтай бөгөөд энэ нь тэдний амьдарч байгаа орчны улмаас улам ноцтой болж болно. Хүнс тэжээлийн эрсдэлд эцэстээ хэрэглэх хүнсний хэмжээг бууруулж хахаж цацах, хоол зажлах ба залгих үеийн хүндрэл, хооллох үеийн биеийн буруу байрлал, хоол шингээх ба наранд гарах боломжийг (Д витаминд нөлөөлнө) бууруулаш хөдөлгөөний хомсдол, хоол хүнсээ олж авахад үеийн ялгаварлан гадуурхах хандлага, түгжрэл тэр дундаа тархины сааны шалтгаан болдог түгжрэл зэрэг орно.

143

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гамшгийн үед гэр бүлийн гишүүдээсээ (голдуу анхаарал халамж тавьдаг хүмүүс) тусгаарлагдах эрсдэлтэй байдаг. Хоол хүнсээ олж авах боломжийг баталгаажуулах (тэр дундаа тусламжийн хүнс), хооллох үеийн дэмжлэг үзүүлэх механизмыг бий болгох (халбага ба соруулаар хангах, гэрт нь юм уу байгаа газар нь хүрч очиж туслах системийг бий болгох), энерги ихтэй хүнс хэрэглэх боломж олгох зэргээр эдгээр эрсдэлүүдийг бууруулах хүчин чармайлт гаргах ёстой.

8. Нийгэмд тулгуурласан халамж: Бусдыг асран хамгаалж байгаа хүмүүс ба асран хамгаалуулж байгаа хүмүүст хүнс тэжээлийн онцгой хэрэгцээ байж болно. Жишээ нь, тэд өөрсдөө өвчтэй юм уу өвчтэй хүн асарч байгаа учраас хоол хүнсээ олж авах цаг зав багатай, шаардлага хангахгүй байгаа эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах илүү их шаардлагатай, эмчилгээ ба оршуулгын зардлын улмаас хүнсний бүтээгдэхүүнээр солих эд хөрөнгө багатай, нийгэмд гадуурхагдах боломжтой, нийгмийн дэмжлэгийг хүртэх боломж багатай зэрэг шалтгаанууд байж болно. Асран хамгаалагчдын олдоц нь гэр бүлийн задрал юм уу үхэл хагацал зэрэг гамшгийн улмаас буурч хүүхдүүд ба өндөр настнууд гол асран хамгаалагчид болж болно. Асран хамгаалагчдад дэмжлэг үзүүлэх шаардлагатай ба тэдэнд эмзэг бүлгийг асран хамгаалахад саад болох ёсгүй. Энэ дэмжлэгт хооллолт, эрүүл ахуй, эрүүл мэнд, сэтгэл зүйн дэмжлэг ба хамгаалалт орно. Оршин байгаа нийгмийн сүлжээг ашиглан сонгосон бүлгийн гишүүдийг энэ хариуцлагыг өөртөө хүлээх сургалтанд хамруулах нь зүйтэй.

2. Хүнс тэжээлийн хомсдолыг арилгах

Хүнс тэжээлийн хомсдол тэр дундаа бичил тэжээлийн хомсдол нь гамшигт өртсөн хувь хүмүүсийн нас баралт ба өвчлөлттэй шууд холбоотой. Тийм учраас хүнс тэжээлийн хомсдолын зэрэг өндөр байгаа үед хүнс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх ба арилгах үйлчилгээ авах боломжийг баталгаажуулах ёстой. Хүн амд үзүүлэх ерөнхий дэмжлэг байхгүй бол эдгээр үйлчилгээний үр нөлөө буурч болно. Жишээ нь, хоол хүнс дамжуулах систем доголдсон юм уу хүсний аюулгүй байдал

ноцтой зөрчигдсөн эсвэл аюулгүй байдлын шалтгаанаар ерөнхий дэмжлэг үзүүлэхгүйгээр нэмэлт тэжээлээр хангасан зэрэг тохиолдлууд байж болно. Эдгээр тохиолдлуудад хүнс тэжээлийн дэмжлэгийг олон нийтэд ойлгуулах нь хөтөлбөрийн үндсэн хэсэг болно (33-р хуудсанд байгаа хариу арга хэмжээний стандарт-г үзнэ үү).

144

Бага хэмжээний тэжээлийн хомсдолын асуудлыг шийдэх олон арга зам байдаг бөгөөд үүний жишээ нь хоол хүнсний ерөнхий нийлүүлэлтийг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, эрүүл мэндийн анхаарал халамж, ариун цэврийн шаардлага хангасан нөхцөл, ундны ус хэрэглэх боломжийг сайжруулах явдал юм. Гамшгийн үед сонгосон бүлэгт нэмэгдэл тэжээл өгөх нь бага хэмжээний тэжээлийн хомсдолыг арилгах ба тэжээлийн хурц хомсдолоос сэргийлэх үндсэн стратеги болдог (стандарт 1). Зарим тохиолдолд бага хэмжээний тэжээлийн хомсдолд орсон хүмүүст анхаарал тавих шаардлагагүй бөгөөд эрсдэлийн тодорхой шаардлагыг хангасан хувь хүмүүст (6-59 сартай хүүхдүүд гэх мэт) анхаарал хандуулах шаардлагатай болохоор тэжээлийн хомсдолын зэрэг хурцдаж болно. Тэжээлийн хурц хомсдолыг 24 цагийн эмнэлгийн асаргаа, өдрийн ба гэрийн асаргаа (стандарт 2) зэрэг олон янзын арга замаар дамжуулж эмчилгээний аргаар арилгаж болно. Эмнэлгийн асаргааг эмчилгээний ус ба ариун цэврийн хэрэгслийн хангамж зэрэг бусад стандартууд дээр үндэслэн хийдэг (51-р хуудсанд байгаа ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах гэсэн хэсгийг үзнэ үү). Бичил тэжээлийн хомсдолыг арилгах (стандарт 3) ажиллагааг нь эрүүл мэндийн систем ба дэд бүтцийн стандартын шаардлагыг хангах ба халдварт өвчнийг хянах (249-р хуудсанд байгаа эрүүл мэндийн үйлчилгээ гэсэн хэсгийг үзнэ үү) арга дээр үндэслэнэ.

Тэжээлийн хомсдолыг арилгах стандарт 1: бага хэмжээний тэжээлийн хомсдол

Бага хэмжээний тэжээлийн хомсдолын асуудлыг шийдэх ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Харилцан зөвшөөрсөн зорилгууд ба хөтөлбөрийг эхлүүлэх болон дуусгах шалгууруудыг эхнээс нь тодорхой тавих ёстой (Заавар тэмдэглэл 1-г үзнэ үү).

- Хөтөлбөрийн хамрах хүрээ нь хөдөө орон нутагт 50%, хот суурин газар 70%, хуарангийн нөхцөлд 90%-иас дээш байх ёстой (Заавар тэмдэглэл 1-г үзнэ үү).
- Зорилтот хүн амын 90-ээс дээш хувь нь хуурай хүнсний нэмэгдэл тэжээлийн хөтөлбөрийн түгээлтийн төвөөс 1 өдөр алхах зайнаас бага зайд, газар дээр нь нэмэгдэл тэжээлээр хангах хөтөлбөрийн хувьд 1 цаг алхах зайнаас илүүгүй зайд байх ёстой (Заавар тэмдэглэл 2-г үзнэ үү).

145

- Зорилтот нэмэлт тэжээлийн хөтөлбөрүүдээс гарсан хүмүүсийн харьцаа нь нас барсан < 3%, нөхөн сэргээгдсэн < 75%, орхин явсан 15% байх ёстой (Заавар тэмдэглэл 3-г үзнэ үү).
- Хувь хүмүүсийг хөтөлбөрт хамруулахдаа олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүний хэмжилтийн шалгууруудыг баримтална (Заавар тэмдэглэл 4 ба 5-г үзнэ үү).
- Зорилтот нэмэлт тэжээлийн хөтөлбөрүүд нь оршин байгаа эрүүл мэндийн бүтэцтэй холбоотой бөгөөд эрүүл мэндийн хүндрэлтэй асуудлуудыг илрүүлж зохих зөвлөгөөг өгөхдөө холбогдох протоколуудыг баримтална (Заавар тэмдэглэл 5-г үзнэ үү).
- Газар дээр нь хооллох тодорхой шалтгаан байхгүй тохиолдолд нэмэлт хооллолтыг гэр лүүгээ авч явах хуурай хүнсний түгээлт дээр үндэслэнэ (Заавар тэмдэглэл 6-г үзнэ үү).
- Ажиглалтын систем ажиллаж байх ёстой (Заавар тэмдэглэл 7-г үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **зорилтот нэмэлт тэжээлийн төлөвлөлт:** хөтөлбөрийн төлөвлөлтийг тэжээлийн нөхцөл байдлын нарийн түвэгтэй байдал ба динамикийн талаархи ойлголт дээр үндэслэгдэнэ. Зорилтот нэмэлт тэжээлийн хөтөлбөрүүдийг зөвхөн хүний хэмжилтийн судалгаа явуулсан юм уу төлөвлөсөн тохиолдолд бага хэмжээний тэжээлийн хомсдолын цаад шалтгааныг нэгэн зэрэг арилгасан нөхцөлд хэрэгжүүлнэ. Зорилтот нэмэлт тэжээлийн хөтөлбөрүүдийг тэжээлийн дэмжлэгийн ерөнхий стандарт 1-ийн шаардлагыг хангахын өмнө богино хугацаагаар хэрэгжүүлж болно. Хөтөлбөрийн зорилгыг зорилтот хүн амд тодорхой ойлгуулж харилцан хэлэлцэх ёстой (28-р хуудсанд байгаа оролцооны стандартыг үзнэ үү).
2. **Хамрах хүрээ:** үүнийг хөтөлбөрийн эхэнд тодорхойлсон зорилтот хүн амтай холбоотойгоор тооцох ба хүний хэмжилтийн судалгааны нэг хэсэг гэж үзэж болно. Үүнд хөтөлбөрийг хүлээн авах боломжтой байдал, түгээлтийн цэгүүдийн байрлал, боловсон хүчин ба тусламж

шаардлагатай байгаа хүмүүсийн аюулгүй байдал, хүлээлтийн хугацаа, үйлчилгээний чанар ба гэрээр нь очих шаардлагатай хүмүүсийн хүрээ зэрэг нөлөөлж болно.

146

Түгээлтийн төвүүд нь зорилтот хүн амд ойр байрласнаар бага насны хүүхдүүдтэй хамт хол газар аялахтай холбоотой эрсдэл ба зардлыг бууруулах боломжтой болно. Өртсөн хүн ам нь түгээлтийн төвүүдийг хаана байрлуулах талаар шийдвэр гаргахад оролцох ёстой. Эцсийн шийдвэрийг ялгаварлан гадуурхахгүйгээр харилцан зөвлөлдсөний дараа гаргана.

3. **Хөтөлбөрөөс гаргах шалгуурууд:** хүнс тэжээлийн хөтөлбөрөөс гаргах гэдэг нь бүртгэлээс хасна гэсэн үг юм. Хөтөлбөрөөс гарах хүмүүс нь хөтөлбөрийг орхин явсан хүмүүс, тусламж авсан хүмүүс (тэр дундаа өөр газар шилжүүлсэн хүмүүс), нас барсан хүмүүс багтана.

Хөтөлбөрийг орхин явсан хүмүүсийн эзлэх хувь =
 $\frac{\text{Хөтөлбөрийг орхин явсан хүмүүсийн тоо}}{\text{Хөтөлбөрөөс гарсан хүмүүсийн тоо}} \times 100\%$

Нас барсан хүмүүсийн эзлэх хувь =
 $\frac{\text{Нас барсан хүмүүсийн тоо}}{\text{Хөтөлбөрөөс гарсан хүмүүсийн тоо}} \times 100\%$

Тусламж авсан хүмүүсийн эзлэх хувь =
 $\frac{\text{Тусламж авсан хүмүүсийн тоо}}{\text{Хөтөлбөрөөс гарсан хүмүүсийн тоо}} \times 100\%$

4. **Хөтөлбөрт хамруулах шалгуурууд:** тэжээлийн хомсдолтой холбоотой хүний хэмжилтийн шалгуурыг хангасан хүмүүсээс гадна бусад хүмүүс ч гэсэн нэмэлт тэжээлийн хөтөлбөрт хамрагдаж болно. Жишээ нь ДОХ-ын ба сүрьеэгийн халдвартай хүн бүр тахир дутуу хүмүүсийн хөтөлбөрт хамрагдаж болно. Эдгээр хүмүүсийг хөтөлбөрт хамруулсан бол ажиглалтын системийг ажиллуулах ёстой. Тэжээлийн хөтөлбөрүүдэд эмчилгээ сувилгаа авах шаардлагыг хангасан хүмүүс дийлэнх хувийг эзэлж байвал гамшгийн дараа ч гэсэн эрсдэлд

өртсөн хэвээр үлдэх эдгээр хүмүүсийн хэрэгцээг хангах нь хамгийн зөв арга биш байж болно. Харин илүү удаан хугацааны хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх хувилбар механизмуудыг олж илрүүлэх нь илүү зүйтэй байж болно. Жишээ нь, гэрээр үзүүлэх дэмжлэг юм уу сүрьеэгийн эмчилгээний төвүүд байж болно.

5. **Эрүүл мэндийн хүчин зүйлүүд:** зорилтот нэмэлт тэжээлийн хөтөлбөрүүд нь цагаан хорхойны эсрэг эм, А витамин нэмэлт, дархлаажуулалтын нийлүүлэлт зэрэг эмнэлгийн холбогдох протоколуудыг агуулах ёстой боловч эзгээр үйлчилгээнүүдийг хүргэхдээ оршин байгаа эрүүл мэндийн үйлчилгээний хүчин чадлыг тооцох ёстой. Тодорхой өвчин өргөн тархсан газруудад нэмэлт тэжээлийн чанар ба хэмжээнд онцгой анхаарал хандуулах ёстой.

6. **Газар дээрх хооллолт:** долоо хоног юм уу хоёр долоо хоног бүр түгээдэг гэр лүүгээ авч явах хуурай хүнс нь газар дээр нь хооллох хувилбараас давуу талтай боловч түүний хэмжээг шийдэхдээ айл өрхийн доторхи хуваарилалтыг тооцох ёстой. Газар дээрхи хооллолтыг зөвхөн аюулгүй байдлын асуудал байгаа үед л ашиглах нь зүйтэй. Хүмүүс дүрвэсэн юм уу шилжин нүүж байгаа зэрэг нөхцөлд түлш, ус, гал тогооны хэрэгсэл дутагдалтай байгаа үед уламжлалт хооллолтын хэвшлийг зөрчөөгүй бол бэлэн хоолыг богино хугацаанд түгээх хувилбарыг авч үзэж болно. Гэр лүүгээ авч явж хооллохын тулд нэмэлт хүнсийг эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд хэрхэн бэлтгэх, хэзээ хэрхэн хэрэглэх, 24 сар хүртэл настай хүүхдүүдийг хөхөөр хооллохын ач холбогдол зэрэг асуудлаар тодорхой мэдээлэл өгөх ёстой (168-р хуудсанд байгаа хүнсний тусламжийн менежментийн стандарт 3-г үзнэ үү).
7. **Хяналтын системүүд:** эдгээр системүүд нь хүмүүсийн оролцоо, хөтөлбөрийг хүлээн авах боломж (үүний нэг сайн хэмжүүр бол хөтөлбөрийг орхин явж байгаа хүмүүсийн тоо юм), хөтөлбөрт дахин хамрагдах зэрэг, нийлүүлсэн хүнсний бүтээгдэхүүний чанар ба хэмжээ, хөтөлбөрт хамруулах, хасах зэрэг болон нас баралт ба өвчлөлтийн зүй тогтол, хүн амын дундах тэжээлийн хомсдолын зэрэг, айл өрх ба оршин суугчдын дундах хүнсний аюулгүй байдлын түвшин, оршин тогтнож байгаа үйлчилгээний системүүдийн хүчин чадал зэрэг гадаад хүчин зүйлүүдээс хамаарна. Хүмүүсийн хөтөлбөрт дахин хамрагдах, орхин явах, тусламж авч чадахгүй байх зэрэг шалтгаануудыг тасралтгүйгээр судлах шаардлагатай.

Тэжээлийн хомсдолыг арилгах стандарт 2: тэжээлийн хурц хомсдол

Тэжээлийн хурц хомсдолын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Харилцан зөвшөөрсөн зорилгууд ба хөтөлбөрийг эхлүүлэх болон дуусгах нөхцлүүдийг эхнээс нь тодорхой байлгах ёстой (Заавар тэмдэглэл 1-г үзнэ үү).
- Хамрах хүрээ нь хөдөө орон нутагт 50%, хот суурин газар 70%, хуарангийн нөхцөлд 90%-иас дээш байх ёстой (Заавар тэмдэглэл 2-г үзнэ үү).
- Зорилтот эмчилгээний хөтөлбөрүүдийг орхин гарсан хүмүүсийн харьцаа нь нас барсан < 3%, нөхөн сэргээгдсэн < 75%, орхин явсан 15% байх ёстой (Заавар тэмдэглэл 3-5-г үзнэ үү).

148

- Хөтөлбөрөөс гаргах шалгуурт хоолны дуршил, гүйлгэлт, халууралт, паразит, бусад эмчлэгдээгүй өвчнүүд зэрэг хүний хэмжилтийн бус үзүүлэлтүүд орно (Заавар тэмдэглэл 4-г үзнэ үү).
- Хүний жингийн кг тутамд нэг өдөрт нэмэгдэх хэмжээ нь < 8 г байх ёстой (Заавар тэмдэглэл 6-г үзнэ үү).
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эмчилгээний асаргааны протоколын дагуу эмнэлгийн асаргаа үзүүлнэ (Заавар тэмдэглэл 7-г үзнэ үү).
- Клиникийн асаргаатай нэг адил хөхөөр хооллолт, сэтгэл зүйн дэмжлэг, эрүүл ахуй ба хүн амд хүрч үйлчлэх хүрээнд чухал анхаарал хандуулах ёстой (Заавар тэмдэглэл 8-г үзнэ үү).
- Хамгийн бага нь 10 өвчтөнд хооллоход нь нэг туслах ажилтан байх ёстой
- Тэжээлийн хомсдолд орсон хувь хүмүүс ба гамшигт өртсөн гэр бүлийн гишүүдийг асарч хамгаалахад учрах саад тотгорыг олж илрүүлэн арилгах ёстой (Заавар тэмдэглэл 9-г үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **эмчилгээний асаргаа хийж эхлэх:** тэжээлийн хурц хомсдолыг эмчлэх зориулалттай төвүүдийг нээж ажиллуулахдаа тооцох ёстой хүчин зүйлүүд бол гамшигт өртсөн хувь хүмүүсийн тоо ба газар зүйн тархац, аюулгүй байдлын нөхцөл, төвүүдийг нээх ба хаахад баримтлах шалгуурууд, оршин байгаа эрүүл мэндийн бүтцийн хүчин чадал болно. Эмчилгээний тэжээлийн хөтөлбөрүүд нь эрүүл мэндийн системийн хүчин чадлыг бууруулах юм уу төрийг нийгмийн үйлчилгээ үзүүлэх хариуцлагаас нь чөлөөлөх ёсгүй. Боломжтой бол хөтөлбөрүүд нь улам өргөжиж тэжээлийн хурц хомсдолыг арилгах хүчин чадлаа нэмэгдүүлж байх ёстой. Хөтөлбөрийн зорилгыг тодорхой ойлгуулж түүнийг зорилтот хүн амтай харилцан хэлэлцэх ёстой (28-р хуудсанд байгаа оролцооны стандартыг үзнэ үү). Эмчилгээний асаргааны хөтөлбөрийг зөвхөн үлдэж байгаа өвчтөнүүдийн эмчилгээг хөтөлбөрийн төгсгөлд бүрэн дуусгах төлөвлөгөө гаргасан нөхцөлд л хэрэгжүүлнэ.

2. **Хамрах хүрээ:** үүнийг зорилтот хүн амаас хамаарч тооцох ба энэ нь хүний хэмжилтийн судалгааны нэг хэсэг болно. Үүнд хөтөлбөрийн хүлээн авах боломжтой байдал, эмчилгээний төвүүдийн байрлал, боловсон хүчин ба эмчилгээ шаардлагатай байгаа хүмүүсийн аюулгүй байдал, хүлээлтийн хугацаа, үйлчилгээний чанар нөлөөлнө.

149

3. **Хөтөлбөрөөс гаргах шалгуурууд:** эмчилгээний тэжээлийн хөтөлбөрөөс гарах шалгуурт тэнцэхэд шаардлагатай хугацаа нь 1-2 сар байна. Тэжээлийн хөтөлбөрөөс гарна гэдэг нь бүртгэлгүй болно гэсэн үг юм. Хөтөлбөрөөс гарсан хүмүүс нь хөтөлбөрийг орхин явсан хүмүүс, тусламж авсан хүмүүс (тэр дундаа өөр газар шилжүүлсэн хүмүүс), нас барсан хүмүүс багтана (хөтөлбөрөөс гарах шалгуурыг хэрхэн тооцох тухай өмнөх стандартын удирдамжийн тайлбар 3-аас үзнэ үү). Нас баралтын зэргийг хөтөлбөрийн хамрах хүрээ ба эмчилж байгаа тэжээлийн дутагдлын түвшинтэй харьцуулж тооцох ёстой. Хөтөлбөрт хамрагдаж байгаа хүмүүсийн дундах ХДХВ/ДОХ-ын халдвартай хүний эзлэх хувь өндөр байгаа нөхцөлд нас баралтын зэрэгт нөлөөлөх хэмжээ мэдэгдэхгүй учраас эдгээр нөхцөлд тохируулж хэмжүүрийг өөрчлөөгүй болно.
4. **Нөхөн сэргэлтийн зэрэг:** хөтөлбөрөөс гарч байгаа хүн нь аливаа эрүүл мэндийн хүндрэлээс чөлөөтэй байх ёстой ба тодорхой хэмжээгээр жин нь нэмэгдэж түүнийгээ хадгалах ёстой (жишээ нь хоёр дараалсан хэмжилтийн үед). Хэвшсэн протоколуудад хөтөлбөрөөс хэт эрт гарахтай холбоотой эрсдэлүүдээс зайлсхийхийн тулд мөрдөх ёстой шалгууруудыг санал болгосон байдаг. Протоколууд нь мөн сэргэлтийн хугацааг уртасгахгүйн тулд (ердийн үргэлжлэх хугацаа 30-40 өдөр байж болно) өвчтөнүүд эмчилгээний тэжээлийн хөтөлбөрт хамрагдах ёстой дундаж хугацааны хязгаарыг заасан байдаг. Сэргэхгүй удсаны улмаас тэжээлийн хомсдолд орсон хувь хүмүүс нь ХДХВ/ДОХ юм уу сүрьеэгийн халдвар авч болно. Удаан хугацааны эмчилгээ юм уу асаргааны сонголтгүй эрүүл мэндийн үйлчилгээ болон бусад нийгмийн ба бүлгийн түвшний дэмжлэгтэй хамт хэрэгжүүлэх нь зүйтэй (277 ба 283-р хуудсанд байгаа халдварт өвчний хяналтын стандарт 3 ба 6-г үзнэ үү). Хөтөлбөрт дахин хамрагдах, орхин гарах, хариу арга хэмжээ авч чадахгүй байх шалтгааныг тасралтгүй судалж баримтжуулах ёстой. Хөтөлбөрөөс гарсны дараа хувь хүмүүсийг боломжийн хэрээр ажиглаж нэмэлт тэжээлийн хөтөлбөрт хамруулах ёстой.
5. **Үндсэн зэрэг:** хөтөлбөр хүн амд хүртээмжгүй байгаа бол энэ зэрэг өндөр байх магадлалтай. Хүртээмж нь эмчилгээний цэг хүн амаас хэр алслагдсан, үргэлжлэн явагдаж байгаа зэвсэгт тэмцэл, аюулгүй байдлын хангалтгүй байдал, эмчилгээ хийлгэж хувь хүний асран

хамгаалагчид үзүүлж байгаа дэмжлэгийн түвшин, өөрөөс хамааралтай хүмүүсийг асрахаар гэртээ үлдсэн асран хамгаалагчдын тоо (энэ нь ДОХ-ын халдвартай хүмүүсийн эзлэх хувь өндөр байгаа тохиолдолд маш цөөн байж болно), үзүүлж байгаа асаргааны чанар зэргээс шалтгаална. Эмчилгээний тэжээлийн хөтөлбөрийг орхин гарсан хүн гэдэг нь тодорхой хугацааны туршид хөтөлбөрт оролцоогүй хүнийг хэлнэ (жишээ нь, эмнэлгээр эмчлүүлж байгаа өвчтөний хувьд 48 цаг).

6. **Жингийн өсөлт:** насанд хүрсэн хүн ба хүүхдэд ижил төрлийн хоол хүнс өгөхөд тэдний жин ойролцоо хэмжээгээр нэмэгддэг. Гэхдээ жингийн өсөлтийн дундаж хэмжээ нь өвчтөний биеийн байдал сайжрахгүй байгаа нөхцөл бодит байдлыг харуулахгүй байж болно.

150

Эмнэлгээс гадуур хэрэгжүүлэх хөтөлбөрийн хувьд жишээ нь цаг хугацаа зэрэг хүн амын хүлээх эрсдэл ба шаардлага нь хамаагүй бага байдаг учраас жингийн өсөлтийн илүү бага хэмжээг хүлээн зөвшөөрч болно. Дундаж жингийн өсөлтийг дараахь байдлаар тооцно: хөтөлбөрөөс гарах үеийн жин – хөтөлбөрт хамрагдах үеийн жин / хөтөлбөрт хамрагдах үеийн жин х эмчилгээний үргэлжилсэн хугацаа (өдрөөр).

7. **Протоколууд:** олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн протоколууд тэр дундаа хариу арга хэмжээ аваагүй алдааны тодорхойлолтыг Хавсралт 9-д байгаа. Эмчилгээний протоколуудыг хэрэгжүүлэхийн тулд клиникийн ажилтнууд тусгай сургалтанд хамрагдах ёстой (258-р хуудсанд байгаа эрүүл мэндийн системүүд ба дэд бүтцийн стандартуудыг үзнэ үү). Эмчилгээнд хамрагдсан ДОХ-ын халдвартай нь батлагдсан юм уу сэжигтэй хувь хүмүүс нь хөтөлбөрт хамруулах шаардлагыг хангасан бол ижил хэмжээний асаргаа авах ёстой. Энэ нь сүрьеэнд ч гэсэн хамаарна. Хөтөлбөрт хамрагдах шаардлагыг хангаагүй ДОХ-ын халдвартай хүмүүст тэжээлийн дэмжлэг үзүүлэх ёстой боловч энэ нь гамшгийн үед тэжээлийн хурц хомсдолыг эмчлэх нөхцөлд хамгийн тохиромжтой шийдэл биш юм. Эдгээр хувь хүмүүс ба тэдгээрийн гэр бүлийг гэрээр үзүүлэх асаргаа сувилгаа, сүрьеэгийн эмчилгээний төвүүд, эхээс хүүхдэд өвчин халдварлахаас сэргийлсэн хөтөлбөрүүд зэрэг олон арга хэмжээгээр дамжуулан дэмжлэг үзүүлэх ёстой.
8. **хөхөөр хооллолт ба сэтгэл зүй, нийгмийн дэмжлэг:** хүүхдээ хөхөөр хооллодог эхчүүдийн сүүний гаралтыг сайжруулж хүүхдийг дээд зэргээр сайн тэжээхийн тулд тэдэнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Үүний тулд хүүхдээ хөхүүлэх булан байгуулж болно. Нөхөн сэргээлтийн үед тэжээлийн хомсдолд орсон хүүхдүүдэд тоглоомоор дамжуулж сэтгэл хөдлөлийн ба биеийн хөдөлгөөний дасгал хийлгэж болно. Тэжээлийн хурц хомсдолд орсон хүүхдийг асран хамгаалж байгаа хүмүүст хүүхдүүдээ эмчилгээнд авчрахын тулд нийгмийн ба сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ёстой. Үүнийг хүртээмж ба оролцоог сайжруулах хөтөлбөрүүдээр дамжуулж хэрэгжүүлж болно (тэжээлийн дэмжлэгийн ерөнхий стандарт 2-г үзнэ үү).
9. **асран хамгаалагчид:** тэжээлийн хурц хомсдолд орсон хүүхдүүдийг асран хамгаалж байгаа хүмүүст эмчилгээний үед зөвлөгөө өгөх, үзүүлэн таниулах материал үзүүлэх, эрүүл мэндийн ба хүнс тэжээлийн мэдээллээр хангах замаар хүүхдүүдээ асарч хамгаалах боломж олгох

ёстой. Хөтөлбөрийн ажилтнууд нь асран хамгаалагчидтай хэлэлцсэнээр хүний эрхийг ноцтой зөрчих байдалд (дайнд оролцож байгаа талууд хүн амыг зориуд өлсгөлөнд нэрвүүлэх гэх мэт) хүргэж болно гэдгийг ойлгож энэ нөхцөл байдалд ажиллах журамд суралцах ёстой.

Тэжээлийн хомсдолыг арилгах стандарт 3: бичил тэжээлийн хомсдол

Бичил тэжээлийн хомсдолын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Хүнсний дутагдлын өвчний бүх тохиолдлуудыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын нэмэлт тэжээлийн протоколын дагуу эмчилнэ (Заавар тэмдэглэл 1-г үзнэ үү).
- Хүн ам нь бичил тэжээлийн хомсдолд орох эрсдэлтэй үр дүнтэйгээр тэмцэхийн тулд тусгай журмыг боловсруулсан байх ёстой (Заавар тэмдэглэл 2-г үзнэ үү).
- Эрүүл мэндийн салбарын ажилтнууд нь хүн ам бичил тэжээлийн хомсдолд орох хамгийн эрсдэлтэй үеийг олжу тогтоон эмчилгээний сургалтанд хамрагдсан байх ёстой (Заавар тэмдэглэл 2-г үзнэ үү).

Заавар тэмдэглэл

Оношлогоо ба эмчилгээ: зарим төрлийн бичил тэжээлийн хомсдолыг энгийн клиникийн шинжилгээний тусламжтай оношилж болно. Хэдийгээр үнэлгээг нарийн зөв хийхийн тулд боловсон хүчний сургалтанд нухацтай хандах шаардлагатай боловч эдгээр үзүүлэлтүүдийг эрүүл мэндийн ба хүнс тэжээлийн тандалтын системд нэгтгэж болно. Зарим төрлийн бичил тэжээлийн хомсдолыг биохимийн шинжилгээгүйгээр илрүүлэх боломжгүй байдаг. Энэ тохиолдолд тухайн өвчнийг тодорхойлох нь бэрхшээлтэй байдаг бөгөөд яаралтай үед зөвхөн эмнэлэгт үзүүлсэн хувь хүмүүсийн нэмэлт тэжээлтэй холбоотойгоор ямар хариу үйлдэл үзүүлж байгаагаас хамааран тодорхойлох боломжтой. Ингэхдээ бичил тэжээлийн хомсдол ба хомсдолд орох эрсдэлтэй хүмүүсийг эмчлэх эрүүл мэндийн систем ба тэжээлийн хөтөлбөрийн хүрээнд явуулах ёстой.

Бэлэн байдал: бичил тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх стратегийг тэжээлийн дэмжлэгийн ерөнхий стандарт 1-ээс үзнэ үү. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг мөн амьсгалын замын хурц үрэвсэл, улаан бурхан, паразитын халдвар, хумхаа, гүйлгэлт зэрэг

бичил тэжээлийн нөөцийг устгадаг өвчнүүдийн тохиолдлыг бууруулах замаар хэрэгжүүлж болно (273-р хуудсанд байгаа халдварт өвчний хяналтын стандартыг үзнэ үү). Хүнсний дутагдлын эмчилгээний хүрээнд өвчний тохиолдлуудыг илрүүлж тодорхойлох ажиллагаа болон эмчилгээний протокол багтана.

152

Хүнсний тусламж

Хүнсний тусламжийн төлөвлөлт

Стандарт 1
Түгээлтийн төлөвлөлт

Стандарт 2
Тохиромжтой байдал ба
хүлээн авах боломж

Стандарт 3
Хүнсний чанар ба аюулгүй байдал

Хүнсний тусламжийн менежмент

Стандарт 1
Хүнсний бүтээгдэхүүнтэй харьцах

Стандарт 2
Нийлүүлэлтийн сүлжээний
менежмент

Стандарт 3
Түгээлт

Хавсралт 8

Нийлүүлэлтийн сүлжээний менежментийн хангамжийн жагсаалт

Хавсралт 9
Ном зүй

4. Хүнсний тусламжийн ажиллагаанд тавигдах минимум стандартууд

Хүмүүсийн хоол хүнс олж авах ердийн арга нь гамшгаас шалтгаалж (жишээ нь, байгалын гамшиг, ургац алдсаны улмаас зэвсэгт мөргөлдөөний улмаас хүмүүс өлсгөлөнд нэрвэгдэх, цэргүүд хоол хүнсийг булаан эзэмших, хүмүүсийг хүчээр юм уу хүч хэрэглэхгүйгээр нүүлгэн шилжүүлэх гэх мэт) хязгаарлагдсан үед хүмүүсийн амь насыг хамгаалах, тэдний өөртөө итгэх итгэлийг хамгаалах, сэргээх, өөрсдөдөө хор хохирол учруулж болох зохицох стратегийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагыг бууруулахын тулд хүнсний тусламжийн ажиллагааг явуулах шаардлагатай болдог.

Шинжилгээний үр дүнд хүнсний тусламжийн арга хэмжээ авах нь зүйтэй гэсэн дүгнэлт гарсан бол хүмүүсийн шууд хэрэгцээг хангахын хамт аль болохоор удаан хугацааны турш хүнсний аюулгүй байдлыг хангах байдлаар хэрэгжүүлэх ёстой. Ингэхдээ дараахи зүйлүүдийг анхаарах ёстой. Үүнд:

- Ерөнхий (үнэгүй) түгээлтийг зөвхөн зайлшгүй шаардлагатай нөхцөлд хоол хүнс хамгийн их шаардлагатай байгаа хүмүүст чиглүүлж хэрэгжүүлэх ёстой бөгөөд аль болохоор түргэн хугацаанд зогсоох шаардлагатай.
- Аль болохоор гэрийн нөхцөлд бэлдсэн хуурай хүнсээр хүмүүсийг хангах ёстой. Олон хүнийг хооллох (газар дээр нь чанасан хоол түгээх) ажиллагааг гэнэтийн томоохон гамшиг тохиолдсоны дараа юм уу хүн ам шилжилт хөдөлгөөний улмаас өөрсдийн хоол хүнсийг бэлдэх боломжгүй болсон, хуурай хоол түгээлт нь хүмүүсийг эрсдэлд оруулах боломжтой аюултай нөхцөл байдал үүссэн тохиолдолд эхний үед нь богинохон хугацаанд зохион байгуулах ёстой.
- Дүрвэгсэд болон гамшигт нэрвэгдсэн хүмүүст зориулсан хүнсний тусламж нь дүрвэгсэд болон гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн байр суурь биш харин тэдний нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагын үнэлгээн дээр үндэслэх ёстой.
- Аль нэг улс оронд хүнсний хомсдол үүссэн юм уу илүүдэл хүнсийг гамшигт өртсөн газар нутаг руу зөөх боломжгүй тохиолдолд л хүнсний бүтээгдэхүүнүүдийг импортолно.

- Хүнсний тусламжийг зэвсэгт мөргөлдөөнд оролцож байгаа талууд удирдах юм уу хэрэглэх эрсдэлтэй нөхцөлд энэ арга хэмжээг зөрчилдөөнийг хурцатгахгүй байдлаар зохион байгуулах ёстой.

Ихэнх гамшгийн үеийн тусламжийн хөтөлбөрүүд нь ихээхэн зардал ба үйл ажиллагаа шаарддаг учраас хүнсний тусламжийн түгээлтийн ажиллагааг ихээхэн хатуу хяналтын дор хариуцлагатай байдлаар зохион байгуулах шаардлагатай. Хүнсний хүргэлт ба түгээлтийн бүх үе шатуудад тэр дундаа бүлгийн түвшинд хяналт тавих ёстой. Хөтөлбөрийн үнэлгээг тогтмол явуулж холбогдох мэдээллийг хамааралтай талууд тэр дундаа гамшигт өртсөн хүн амд түгээж харилцан санал солилцох ёстой.

Хүнсний тусламжийн стандарт 6 нь 2 дэд бүлэгт хуваагдана. Хүнсний тусламжийн төлөвлөлтийг хүнсний түгээлтийн төлөвлөлт, хоол хүнсний тохиромжтой бөгөөд хэрэглэх боломжтой байдал, хүнсний чанар ба аюулгүй байдлын асуудлуудыг тусгах ёстой. Энэ бүлгийн төгсгөлд байгаа 8-р хавсралтад нийлүүлэлтийн сүлжээний менежментийн зорилгоор хэрэглэх хангамжийн жагсаалтыг өгсөн.

а. Хүнсний тусламжийн төлөвлөлт

Онцгой нөхцөл байдлын үед анхны үнэлгээ ба шинжилгээг хийхдээ хүмүүсийн хүнсний болон орлогын эх үүсвэрүүд, тэдгээрт учирч байгаа эрсдлийг тодорхойлох ёстой. Үүгээр хүнсний тусламж шаардлагатай эсэхийг тогтоож шаардлагатай бол хүмүүсийн хоол тэжээлийн нөхцөл байдлыг зохих түвшинд байлгахад шаардлагатай хүнсний төрөл ба хэмжээг тогтооно. Хүнсний бүтээгдэхүүнийг үнэгүй түгээх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд айл өрхүүд нь өөрөө өөрсдийгөө хангах боломжтой хоол хүнсийг тооцон өөрсөддөө хор уршиг бүхий зохицох стратегийг (113-р хуудсан дээр байгаа хүнсний аюулгүй байдлын шинжилгээний стандарт 1, заавар тэмдэглэл 3 ба 122-р хуудсан дээр байгаа хүнсний аюулгүй байдлын стандарт 1, заавар тэмдэглэл 3-ыг үзнэ үү) хэрэглэхгүйгээр хоол хүнсний хэрэглээгээ хангах боломж олгох байдлаар зохион байгуулах ёстой.

Нэмэлт тэжээлийн хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд зохих нэмэлт түгээлтийг хэрэгжүүлэх ёстой. Энэ тохиолдолд нэмэлт тэжээлийн хөтөлбөрийг хувь хүмүүс авах эрхтэй (147-р хуудсан дээр байгаа хүнсний хомсдолын стандарт 1, заавар тэмдэглэл 1-ийг үзнэ үү) ерөнхий хангамжин дээр нэмж олгох ёстой.

Бүх тохиолдолд гамшигт өртсөн хүн амтай зөвлөлдсөний үндсэн дээр нийлүүлэх бүтээгдэхүүнүүдийг болгоомжтой сонгох шаардлагатай. Тэдгээр нь чанартай, хэрэглэхэд аюулгүй, хэрэглэж байгаа хүмүүст тохиромжтой бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой.

Хүнсний тусламжийн стандарт 1: Хүнсний төлөвлөлтийн хувь хэмжээ

Хүнсний бүтээгдэхүүний ерөнхий түгээлт нь гамшигт өртсөн хүн амын хэрэгцээ шаардлага ба тэдний хүнсний нөөцийн хоорондох зөрүүг арилгахад оршино.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэлтэй хамт уншина)

- Ерөнхий зорилгоор түгээгдэж байгаа хоол хүнсний хэмжээ эрчим хүч, уураг, өөх тос, бичил тэжээлийн талаархи анхны төлөвлөгөөнд тусгагдсан стандартын шаардлагууд дээр үндэслэж шаардлагатай хэмжээгээр орон нутгийн нөхцөл байдалд тохируулан зохион байгуулна (137-144-р хуудсанд байгаа тэжээлийн дэмжлэгийн ерөнхий стандарт ба 7-р хавсралтыг үзнэ үү)
- Түгээсэн хоол хүнсний хэмжээ нь гамшигт нэрвэгдсэн хүн ам өөрсөдөө хор хохиролтой зохицох стратеги хэрэглэх шаардлагыг бууруулах юм уу байхгүй болгох ёстой.
- Шаардлагатай үед түгээсэн хоол хүнсний эдийн тооцоог хийж орон нутгийн нөхцөл байдалд тохируулах ёстой (Заавар тэмдэглэл 2-г үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. *Хүнс тэжээлд тавигдах шаардлага* : хүмүүс орон нутгаасаа дайжиж хоолн хүнс олох боломжгүй болсон тохиолдолд түгээж байгаа хоол хүнс нь тэдгээрийн хүнс тэжээлийн нийт хэрэгцээг хангах ёстой. Гэхдээ гамшигт нэрвэгдсэн ихэнх хүн ам нь өөрсдөө ямар нэг хэмжээгээр хоол хүнсээ болгох боломжтой байдаг. Энэ үед хоол хүнсийг түгээхдээ тэдгээр хүмүүсийн хүнс тэжээлийн хэрэгцээ шаардлага ба тэдгээрийн өөрсдөө олж чадах хоол хүнсний зөрүүг нөхөх байдлаар төлөвлөх ёстой. Ийм байдлаар хүн өдөрт 2,100 ккал-ын хүнс хэрэглэх шаардлагатай бол зорилтот хүн амд хамаарах хүн дунджаар өдөрт 500 ккал-тай тэнцэх хэмжээний хүнсийг өөрсдөө олох боломжтой байгаа бол түгээх хүнсний хэмжээг $2,100 - 500 = 1,600$ ккал байхаар төлөвлөх ёстой. Өөх тос ба уургийн хэмжээг ч гэсэн ийм аргаар тооцох нь зүйтэй.

Хүмүүсийн олж авах боломжтой хоол хүнсний дундаж хэмжээний хэмжээний талаар харилцан тохиролцох шаардлагатай (111-р хуудсанд байгаа хүнсний аюулгүй байдлын үнэлгээг үзнэ үү).

2. **Эдийн засгийн нөхцөл байдал:** бага хэмжээний хүнс олдож байгаа юм уу огт хүнс олдохгүй байгаа бөгөөд хүмүүс түгээсэн бүх хүнсийг хэрэглэх боломжтой нөхцөлд түгээх хоол хүнсийг тэжээлийн үзүүлэлтийг хатуу баримтлан сонгох ёстой бөгөөд ингэхдээ хоол хүнсний хүлээн авах боломжтой байдал ба өртөг зардлыг тооцох ёстой. Бусад хүнсний эх үүсвэрүүд байгаа бөгөөд хүлээн авч байгаа хүмүүс нь түүнийг олж авахын тулд тэдгээрийн зарим хэсгийг худалдах боломжтой байгаа үед хүнсийг дамжуулан худалдах үнийг тооцох ёстой. Дамжуулан худалдах үнэ нь хоол хүнсний орон нутгийн зах зээлийн үнэ буюу орон нутгийн зах зээл дээр ижил хэмжээний ижил төрлийн бүтээгдэхүүнийг худалдан авахад зарцуулах үнэ юм.

Хүнсний тусламжийн стандарт 2: тохиромжтой байдал ба хүлээн авах тохиромжтой байдал

Түгээж байгаа хоол хүнс нь хүлээн авч байгаа хүмүүст тохиромжтой бөгөөд хүлээн авах боломжтой байх ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэлтэй хамт уншина)

- Түгээх хүнсний бүтээгдэхүүний хүлээн авах боломжтой, байдал, хэрэглэхэд тохиромжтой байдлыг үнлэх ба төлөвлөхдөө хүмүүстэй зөвлөлдөх шаардлагатай ба түүний үр дүнг түгээх хоол хүнсийг сонгох шийдвэр гаргахдаа тооцох ёстой (Заавар тэмдэглэл 1-г үзнэ үү).
- Танил бус хоол хүнсийг түгээх үед түүнийг орон нутгийн хувьд тохиромжтой байдлаар тэжээллэг чанарыг нь хамгийн бага хэмжээгээр алдагдуулж бэлтгэх зааварчилгааг боломжтой бол тухайн орон нутгийн хэлээр эмэгтэйчүүд болон хоол хүнс бэлтгэдэг бусад хүмүүст өгөх ёстой (Заавар тэмдэглэл 1-г үзнэ үү).
- Хүмүүсийн хоол хүнс бэлтгэхэд шаардлагатай түлш ба ус олж авах боломж, хоол хүнс бэлтгэхэд шаардлагатай хугацаа, шингээхэд тавигдах шаардлагыг түгээх хүнсний бүтээгдэхүүнийг сонгохдоо бодолцох ёстой (Заавар тэмдэглэл 2-г үзнэ үү).
- Үр тариаг бүхлээр түгээх үед хүлээн авагчид нь тэдгээрийг тээрэмдэх юм уу уламжлалт гэрийн аргаар боловсруулах эсвэл өөрсдийн оршин суугаа газарт ойрхон тээрэмдэх юм уу боловсруулах байгууламжийг ашиглах боломжтой байх ёстой (Заавар тэмдэглэл 3-г үзнэ үү).

- Хүмүүс соёлын хувьд чухал зүйлүүд тэр дундаа хоол амтлагч олж авах боломжтой байх ёстой (Заавар тэмдэглэл 4-г үзнэ үү).
- Үнэгүй юм уу тусламжийн хуурай ба шингэн сүүг дангаар нь түгээхгүй (Заавар тэмдэглэл 5-г үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **Танил байдал ба хүлээн авах боломжтой байдал:** хүнсний багцад орох хүнсний бүтээгдэхүүнүүдийг сонгоход тэжээлийн үзүүлэлтүүд гол боловч түгээж байгаа хүнсний бүтээгдэхүүн нь хүлээн авч байгаа хүмүүст танил бөгөөд тэдний шашин ба соёлын уламжлалд нийцсэн байх ёстой. Үүнд жирэмсэн ба хөхүүл эхчүүдэд хориглосон бүтээгдэхүүн багтана. Үнэлгээний тайлан ба хандивлагчдад гаргах хүсэлтэд тухайн хүнсний бүтээгдэхүүнийг сонгосон ба бусад бүтээгдэхүүнүүдийг сонгоогүй шалтгааныг тодорхой заасан байх ёстой. Аминд тулгарсан онцгой нөхцөл байдалд хүмүүс хоол хүнсээ бэлдэх боломжгүй байгаа нөхцөлд идэхэд бэлэн хоол түгээх шаардлагатай. Ийм нөхцөлд таньж мэдэхгүй бүтээгдэхүүнийг түгээх хувилбарыг авч үзэж болно. Зөвхөн ийм тохиолдолд л онцгой байдлын хүнсний түгээлтийг хэрэгжүүлж болно.
2. **Хүнсний бүтээгдэхүүнд тавигдах шаардлага:** хүнсний бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг үнэлэх үед хүлээн авч байгаа хүмүүс нь хэт их түлш хэрэглэснээр өөрсдийн эрүүл мэнд ба хүрээлэн байгаа орчинд ямар нэг хохирол учруулахгүйгээр хоол хүнсээ болгож идэх боломжийг тооцох ёстой. Шаардлагатай үед шаардлагатай түлшээр хангах юм уу түлш цуглуулах гол хүмүүс болох эмэгтэйчүүд ба хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах нөхцлийн дагуу зохион байгуулсан түлээ түүх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой. Ерөнхийдөө чанаж болгоход удаан хугацаа юм уу ихээхэн хэмжээний ус шаардлагагүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах ёстой. Нунтагласан тариа нь хоол чанаж болгох хугацаа ба шаардлагатай түлшний хэмжээг бууруулахад тусална.
3. **Тариа буудай боловсруулалт:** бүхэл эрдэнэ шиш нь 6 сарын хадгалах хугацаатай байдаг учраас түүнийг нунтаглах нь чухал асуудал юм. Тийм учраас эрдэнэ шишийг хэрэглэхээс өмнөхөн нунтаглах нь зүйтэй. Эрдэнэ шишийг нунтаглах нь айл өрхийн хувьд уламжлал болсон ажиллагаа учраас бүхэл эрдэнэ шиш түгээж болно. Бүхэл эрдэнэшиш нь хадгалах хугацаа удаанаас гадна хүлээн авч байгаа хүмүүсийн хувьд эдийн засгийн илүү үнэ цэнэтэй байж болно. Үүнээс гадна бага гарцтай нунтаглах төхөөрөмжүүдийг нийлүүлснээр хурших үйл явцыг хурдасгадаг микроб, тос, энзимийг устгадаг учраас үр тарианы хадгалах хугацааг

ихээхэн нэмэгдүүлдэг боловч уургийн хэмжээг бууруулдаг. Ингэхдээ бүхэл үр тариа импортлох ба түгээхтэй холбоотой тухайн улсын хууль журмыг мөрдөх ёстой.

4. **Соёлын ач холбогдол бүхий зүйлүүд:** үнэлгээ нь 1. соёлын хувьд ач холбогдол бүхий хоол амтлагч ба өдөр тутмын хүнсний хэрэглээнд чухал бусад хүнсний зүйлүүд 2. хүмүүс эдгээр хүнсний зүйлүүдийг олж авах боломжийг үнэлэх ёстой. Хүнсний багц бүтээгдэхүүнийг ялангуяа удаан -хугацааны туршид түгээсэн хүнсний бүтээгдэхүүнээс хамааралтай байгаа үед зохих шаардлагын дагуу сонгох ёстой.
5. **Сүү:** дангаар нь түгээх хуурай ба шингэн сүүг (үүнд цайтай хольж уух зориулалттай сүү багтана) хүнсний ерөнхий түгээлт ба гэр лүүгээ авч явах зориулалттай нэмэгдэл хооллолтын хөтөлбөрүүдэд оруулах ёсгүй. Учир нь түүнийг буруу хэрэглэснээр эрүүл мэндэд ноцтой аюул учруулж болно. Сүү нь тохиромжгүй хэмжээгээр шингэрүүлэх юм уу бактериар бохирдсон бол ялангуяа бага насны хүүхдүүдэд ихээхэн хохирол учруулж болно (140-р хуудсанд байгаа хүнс тэжээлийн ерөнхий дэмжлэгийн стандарт 2-г үзнэ үү).

Хүнсний тусламжийг төлөвлөх стандарт 3: хүнсний чанар ба аюулгүй байдал

Түгээсэн хүнс нь сайн чанартай бөгөөд хүн хэрэглэхэд тохиромжтой байх ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Хүнсний бүтээгдэхүүнүүд нь улсын болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудын шаардлагыг хангасан байх ёстой (Заавар тэмдэглэл 1-2-г үзнэ үү).
- Импортоор оруулсан бүх савлагаа бүхий хүнсний бүтээгдэхүүн нь тухайн улсад ирснээс хойш дор хаяж 6 сар лангуун дээр хадгалагдсаны дараа хугацаа нь дуусахаас өмнө эсвэл дуусахаас нилээд хугацааны өмнө түгээгдсэн байхаар тооцоологдох ёстой (Заавар тэмдэглэл 1-г үзнэ үү).
- Хүнсний бүтээгдэхүүний чанарын талаар батлагдсан гомдол гарах ёсгүй (Заавар тэмдэглэл 3-г үзнэ үү).
- Хүнсний бүтээгдэхүүний баглаа боодол нь бөх бат бөгөөд ачих буулгах, хадгалах, түгээхэд тохиромжтой байхаас гадна байгал орчинд аюул учруулах ёсгүй (Заавар тэмдэглэл 4-г үзнэ үү).

- Хүнсний бүтээгдэхүүний баглаа боодол нь тохирох хэлээр бичигдэж үйлдвэрлэсэн болон хэрэглэх хугацаа, тэжээлийн агуулгын талаархи мэдээллийг харуулсан байх ёстой.
- Хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах нөхцөл нь шаардлага хангасан байх ёстой ба агуулахуудыг зохих ёсоор зохион байгуулж хүнсний бүтээгдэхүүний чанарыг бүх газар нутагт тогтмол явуулна. (Заавар тэмдэглэл 5-ыг үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **Хүнсний бүтээгдэхүүний чанар:** Хүнсний бүтээгдэхүүн нь хүлээн авч байгаа улсын хүнсний бүтээгдэхүүний стандарт ба Кодекс Элиментариус стандартыг чанар, баглаа боодол, хаяг шошго, хадгалах хугацаа гэх мэт үзүүлэлтээрээ хангах ёстой. Хүнсний бүтээгдэхүүний дээжний чанар нь шаардлага хангаж байгаа гэдгийг баталгаажуулах юм бол нийлүүлэгч нь хүргэж ирсэн цэг дээр системтэйгээр шалгах ёстой. Худалдаж авсан хүнсний бүтээгдэхүүнийг /орон нутгаас юм уу, импортолсон/ аль болохоор хүний хэрэглээнд тохирно гэдгийг батлахын тулд ургамал, ариун цэврийн гэрчилгээ ба бусад гэрчилгээг дагалдуулах ёстой. Тэдгээр нь хүнсний хэрэглээнд тохиромжтой хэвээр байгаа гэдгийг батлахын тулд улс дотроо сонгосон дээжинд тогтмол шинжилгээ хийх ёстой. Их хэмжээний хүнсний бүтээгдэхүүн байгаа бөгөөд тэдгээрийн чанарын талаар эргэлзээ, маргаан байгаа тохиолдолд хөндлөнгийн чанар шалгагчид бүтээгдэхүүнийг шалгах ёстой. Тухайн хүнсний бүтээгдэхүүний хадгалсан хугацаа ба чанарын талаархи мэдээллийг нийлүүлэгчийн зүгээс бүрдүүлсэн гэрчилгээ, чанарын хяналтын тайлангууд, баглаа боодлын шошго, агуулахын мэдээлэл зэргээс авч болно.
2. **Генетикийн хувьд өөрчилсөн бүтээгдэхүүнүүд:** Генетикийн хувьд өөрчилсөн хүнсний бүтээгдэхүүнийг хүлээн авах ба хэрэглэхтэй холбоотой тухайн улсын дүрэм журмыг ойлгож мөрдөх ёстой. Аливаа хүнсний тусламжын өдрийг төлөвлөхдөө эдгээр дүрэм журмыг анхаарах ёстой.
3. **Санал гомдол:** Хүнсний бүтээгдэхүүний чанартай холбоотой хүлээн авагчдын зүгээс гарсан санал гомдлын дагуу шуурхай арга хэмжээ авч ил тод бөгөөд шударга байдлаар асуулыг шийдэх ёстой.
4. **Баглаа боодол:** Боломжтой бол хүнсний бүтээгдэхүүний баглаа боодол нь дахин баглах шаардлагагүйгээр шууд түгээх боломжтой байх ёстой.
5. **Хадгалах газар:** нь хуурай, эрүүл ахуйн шаардлага хангасан, цаг агаарын нөхцлөөс хамгаалагдсан, химийн болон бусад үлдэгдлээр бохирдоогүй байх ёстой. Тэдгээр нь аль болохоор хорхой шавьж ба мэрэгчдээс хамгаалагдсан байх ёстой. Мөн 165-р хуудсан байгаад хүнсний тусламжийн менежментийн стандарт 2-ыг үзнэ үү.

ii/ Хүнсний тусламжийн менежмент

Хүнсний тусламжийн менежментийн зорилго нь хоол хүнс хамгийн их шаардлагатай байгаа хүмүүст хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэхэд оршино. Үүнд зөв бүтээгдэхүүнийг зөв газарт, зөв нөхцлийн дагуу, цаг хугацаанд нь, тохиромжтой үнээр хамгийн бага алдагдалтайгаар хүргэх асуудал орно.

Гамшигт илүү өртсөн олон тооны хүн амыг хамгаалахад шаардлагатай хүнсний тусламжийн хэмжээ нь хэдэн мянган тоннд хүрч болно. Хүнсний бүтээгдэхүүнийг түгээлтийн цэг хүртэл шилжүүлэхэд худалдан авагчид, зуучлагчид, тээвэрлэгчид ба хүлээн авагчдын томоохон сүлжээ ба 1 тээврийн хэрэгслээс нөгөө рүү дамжуулах ачих буулгах ихээхэн хэмжээний ажиллагаа шаардаж болно. Эдгээр сүлжээнүүд буюу нийлүүлэлтийн сувгуудыг гэрээнд оролцогч талуудын үүрэг хариуцлага ба эрхийг тодорхойлсон цуврал гэрээний дагуу нэгтгэдэг. Энэ бүхэн нь хариуцлагатай байдлыг тогтооход шаардлагатай зохих шаардлага хангасан ба ил тод журам мөрдөхийг шаарддаг.

Нийлүүлэлтийн сувгийг байгуулж зохион байгуулахын тулд хандивлагчид, хүлээн авч байгаа засгийн газар, хүмүүнлэгийн ажилтнууд, орон нутгийн эрх бүхий байгууллагууд, төрөл бүрийн үйлчилгээ эрхлэгч болон орон нутгийн байгууллагууд хамтран хүнсний тусламжийн хөтөлбөрт оролцох шаардлагатай. Нийлүүлэлтийн сүлжээнд оролцож байгаа бүх талууд нь сүлжээний аль нэг хэсэгт өөрийн гэсэн үүрэг хариуцлага хүлээнэ. Нийлүүлэлтийн сүлжээний найдвартай байдал нь түүний хамгийн сул хэсгийн найдвартай байдалтай ижил байдаг учраас хүнсний тусламжийн хөтөлбөрт оролцож байгаа бүх талууд түгээлтийн зорилго ба төлөвлөгөөний шаардлагыг хангахын тулд бүтээгдэхүүний эргэлтийг хангах хариуцлагыг хамтран хүлээдэг.

Түгээлтийн үйл явцад эрх тэгш байдлаар оролцох хамгийн чухал зүйл бөгөөд гамшигт нэрвэгдсэн хүн амын дундаас шийдвэр гаргалт ба хэрэгжүүлэлтэнд оролцуулах нь зайлшгүй зүйл юм. Хүмүүст түгээх хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээ төрлийн талаар мэдээлэх шаардлагатай ба тэдгээр нь хүнсний түгээлтийн үйл явц шударга явагдаж байгаа эсэх өөрсдөө амласан зүйлийг авч байгаа гэдэгт итгэлтэй байх ёстой. Янз бүрийн бүлгүүдэд түгээж байгаа хүнсний бүтээгдэхүүний ялгааны талаар тэдэнд тайлбарлаж ойлгуулсан байх ёстой.

Хүнсний тусламжийн менежментийн стандарт 1: хүнсний бүтээгдэхүүнтэй харьцах

Хүнсний бүтээгдэхүүнийг айл өрхийн болон бүлгийн түвшинд аюулгүй бөгөөд тохиромжтой байдлаар хадгалах, бэлтгэх, хэрэглэх шаардлагатай.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэлтэй хамт уншина)

- Түгээлтийн цэгт хүнсний бүтээгдэхүүнтэй зохих шаардлага хангаагүй нөхцөлд харьцах юм уу бэлтгэсний улмаас эрүүл мэндэд сөрөг гарах ёсгүй (Заавар тэмдэглэл 1-г үзнэ үү).
- Хүнсний бүтээгдэхүүн хүлээн авч байгаа хүмүүст хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуйн талаар мэдээлж ойлгуулах ёстой (Заавар тэмдэглэл р 1-г үзнэ үү).
- Түгээсэн хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах, бэлтгэх, чанаж болгох, хэрэглэх үед учирсан хүндрэлийн талаар санал гомдол гарах ёсгүй (Заавар тэмдэглэл 2-г үзнэ үү).
- Айл өрх бүр зохих шаардлага хангасан хоол бэлтгэх сав суулга, түлш, эрүүл ахуйн бүтээгдэхүүн олж авах боломжтой байх ёстой (Заавар тэмдэглэл 3-4-г үзнэ үү).
- Хоол хүнсээ бэлтгэх юм уу өөрсдийгөө хоолох чадваргүй хүмүүс зохих цаг хугацаанд хоол хүнсийг бэлтгэж шаардлагатай үед хооллох боломжтой асран хамгаалагч олох боломжтой байх ёстой (Заавар тэмдэглэл 4-5-г үзнэ үү).
- Хүнсний бүтээгдэхүүнийг чанаж болгосон байдлаар түгээж байгаа нөхцөлд ажилтнууд нь хүнсний бүтээгдэхүүнийг аюулгүй хадгалах ба харьцах, хоол хүнсийг чанаж болгох, буруу үйлдлээс эрүүл мэндэд учирч болох аюулын талаар сургалтанд хамрагдсан байх ёстой.

Заавар тэмдэглэл

1. ***Хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй:*** нөхцөл байдал өөрчлөгдсөнөөр хүмүүсийн эрүүл ахуйн ердийн хэвшил алдагдаж болно. Ийм учраас хүнсний эрүүл ахуйг сайжруулж орон нутгийн нөхцөл байдал ба өвчний зүй тогтолтой нийцүүлэн хоол идэхийн өмнө гараа угаахын ач холбогдлыг онцлох, усны бохирдлоос урьдчилан сэргийлэх, бактерийн хяналтын арга хэмжээ авах гэх мэт арга хэмжээг идэвхтэй дэмжих ёстой.

Хүмүүст гэрийн нөхцөлд хүнсний бүтээгдэхүүнийг хэрхэн аюулгүй хадгалах талаар мэдээлэл өгч асран хамгаалагчдад хүүхдээ тэжээх хоол хүнсээ бэлтгэх аюулгүй аргыг хэрэгжүүлэхэд өрх гэрийн нөөцийг хэрхэн дээд зэргээр ашиглах талаар мэдээлэл өгөх ёстой (59-р хуудсанд байгаа эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах стандартыг үзнэ үү).

2. **мэдээллийн эх үүсвэрүүд:** үүнд хөтөлбөрийн ажиглалтын системүүд, хүлээн авагчидтай хийх ажлын бүлгийн хэлэлцүүлэг, айл өрхийн түргэвчилсэн судалгаа орж болно.
3. **айл өрхийн хэрэгцээт зүйлүүд ба түлш:** айл өр бүр ядаж нэг тогоо, 40 л-ийн багтаамжтай ус хадгалах сав, нэг хүнд сард 250 г-ийн хэмжээтэй саван, хоол хүнсээ бэлтгэхэд хангалттай түлш зэргийг авах боломжтой байх ёстой. Хоол хүнсээ бэлтгэхэд шаардлагатай түлш олдоцгүй бол богино хугацаанд болдог хүнсний бүтээгдэхүүн түгээх ёстой. Хэрвээ энэ нь боломжгүй бол зөрүүг нөхөхийн тулд түлшээр хангах гадны эх үүсвэрийг олж тогтоох ёстой (69-р хуудсанд байгаа усны хангамжийн стандарт 3 ба 232-236-р хуудсанд байгаа хүнсний бус зүйлүүдийн стандарт 2-4-г үзнэ үү).
4. **тээрэм:** болон бусад боловсруулах байгууламжууд ашиглах ба цэвэр усны одоо нь хүмүүст өөрсдийн сонгосон аргаар хоол хүнсийг дээд зэргээр бэлтгэх боломж олгодог ба бусад үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд зарцуулах цаг хугацааг нэмэгдүүлдэг учраас маш чухал ач холбогдолтой. Эдгээр үйлчилгээг хүлээн ихээхэн хэмжээний цаг хугацаа зарцуулж байгаа асран хамгаалагчид нь энэ цагийг хоол хүнс бэлтгэх, хүүхдүүдийг хооллох болон хүнс тэжээлийн байдал ба удаан хугацааны бие даасан байдалд сайнаар нөлөөлөх боломжтой бусад үйл ажиллагаануудад зарцуулж болно. Өрхийн түвшинд хоол боловсруулах (үүнд тээрэмдэх ажиллагаа орно) боломж нь хоол хүнсээ бэлтгэхэд зарцуулах цагийг (мөн ус ба түлшний хэмжээ) хэмнэж болно.
5. **тусгай хэрэгцээ:** хооллолтын үед туслалцаа авах шаардлагатай хүмүүсийн тоонд бага насны хүүхдүүд, өндөр настнууд, тахир дутуу хүмүүс, ДОХ-ын халдавртай хүмүүс орох боловч энэ нь бүх хүмүүсийг хамруулсан жагсаалт биш юм. 140-р хуудсанд байгаа хүнс тэжээлийн ерөнхий дэмжлэгийн стандарт 2-г үзнэ үү.

Хүнсний тусламжийн менежментийн стандарт 2: нийлүүлэлтийн сүлжээний менежмент

Хүнсний тусламжийн нөөцүүдийг (бүтээгдэхүүнүүд ба тусламжийн сан) ил тод бөгөөд өндөр мэдрэмжтэй байдлаар сайтар зохион байгуулах ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Хүнсний тусламжийн нөөцүүд нь зориулагдсан хүмүүстээ хүрэх ёстой
- Орон нутгийн нийлүүлэлтийн сүлжээний менежментийн хүчин чадал ба хангамжийн албаны бүтцийг үнэлж боломжтой үед орон нутгийн хүчин чадлыг ашиглан уялдаа холбоо бүхий үр ашигтай менежментийн системийг бүрдүүлэх ёстой (Заавар тэмдэглэл 1-2-г үзнэ үү).
- Үнэлгээ хийхдээ орон нутгаас олж авсан хүнсний бүтээгдэхүүний олдцыг тооцох ёстой (Заавар тэмдэглэл 3-ийг үзнэ үү).
- Нийлүүлэлтийн сүлжээний менежментийн үйлчилгээг авах гэрээг ил тод, шударга, нээлттэй байдлаар байгуулна (Заавар тэмдэглэл 4-г үзнэ үү).
- Нийлүүлэлтийн сүлжээний менежментийн бүх түвшний боловсон хүчин нь зохих хэмжээнд сургагдсан бөгөөд хүнсний аюулгүй байдал ба чанартай холбоотой журмыг мөрдөж ажиллах ёстой (Заавар тэмдэглэл 5-г үзнэ үү).
- Нийлүүлэлтийн сүлжээний менежментийн системийн бүх түвшинд хариуцлагатай байдлыг баталгаажуулахын тулд зохих шаардлага хангасан нягтлан бодох бүртгэл, тайлан, санхүүгийн системийг ажиллуулах ёстой (Заавар тэмдэглэл 6-7-г үзнэ үү).
- Алдагдал тэр дундаа хулгайн алдагдлыг болгоомжтой тайлагнах шаардлагатай (Заавар тэмдэглэл 8-10-г үзнэ үү).
- Хүнсний түгээлтийн сүлжээг хянаж түгээлтэд саад учруулахгүйгээр ажиллуулах ёстой (Заавар тэмдэглэл 11-г үзнэ үү).
- Нийлүүлэлтийн сүлжээний гүйцэтгэлийн үзүүлэлтийн талаархи мэдээллийг бүх сонирхогч талуудад тогтмол өгнө (Заавар тэмдэглэл 12-г үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **Нийлүүлэлтийн сүлжээний менежмент** нь хүнсний тусламжийн нэгдмэл ажиллагаа юм. Үүнд бүтээгдэхүүнийг сонгохоос эхлээд олж авах, хангах,

чанарыг баталгаажуулах, баглаж боох, тээвэрлэх, агуулахад хадгалах, бараа материалыг зохион байгуулах, даатгалд хамруулах зэрэг ажиллагаанууд хамаарна. Сүлжээнд олон талууд оролцдог бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг харилцан уялдуулах нь чухал юм. Хүнсний бүтээгдэхүүнүүдийг хүлээн авагчдад хүлээлгэн өгөх хүртэл хамгаалахын тулд зохих шаардлагын дагуу менежментийн ба хяналтын журмууд боловсруулах шаардлагатай.

2. **Орон нутгийн үйлчилгээг ашиглах:** гаднаас эх үүсвэр олохын өмнө орон нутгийн хүчин чадлын олдоцтой байдал ба найдвартай байдлыг үнэлгээг хийх ёстой. Хангамжийн үйлчилгээгээр хангах гэрээ байгуулахын тулд нэр хүнд бүхий орон нутгийн ба бүс нутгийн тээвэрлэгчид, тээвэр зуучидтай байгуулж болно. Эдгээр байгууллагууд нь орон нутгийн дүрэм журам ба байгууламжуудын талаар үнэтэй мэдлэгтэй байдаг бөгөөд хүлээн авч байгаа улс орны хууль журмыг мөрдөж хүргэлтийн ажиллагааг түргэвчлүүлэхэд тус болох ёстой.
3. **Орон нутгийн нийлүүлэлт ба импорт:** хүнсний бүтээгдэхүүний орон нутгийн олдоц ба хүнсний бүтээгдэхүүнийг орон нутгаас олсон юм уу импортолсон эсэх нь орон нутгийн үйлдвэрлэлийн, зах зээлийн системд үзүүлэх нөлөөг үнэлэх ёстой (111-р хуудсанд байгаа хүнсний аюулгүй байдлын үнэлгээ ба шинжилгээний стандарт, 124-р хуудсанд байгаа хүнсний аюулгүй байдлын стандарт 2, 131-р хуудсанд байгаа хүнсний аюулгүй байдлын стандарт 4-г үзнэ үү). Хүнсний нийлүүлэлтэнд олон тооны байгууллагууд оролцож байгаа нөхцөлд орон нутгаас тэр дундаа хүнсний бүтээгдэхүүнийг худалдаж авах ажиллагааг аль болох харилцан уялдуулах ёстой. Хүнсний бүтээгдэхүүнийг олж авах дотоодын бусад эх үүсвэрүүдэд хэрэгжүүлж байгаа хүнсний тусламжийн хөтөлбөрүүдээс авах зээл, дахин хуваарилалт, арилжааны нийлүүлэгчдээс авах зээл, солилцоо орно.
4. **шударга байдал:** хэн нэгэнд давуу эрх өгөх юм уу авлигатай холбоотой эргэлзээ төрүүлэхгүйн тулд шударга бөгөөд ил тод гэрээний журам маш чухал байдаг. Тусламжийн хүнсний баглаа боодол нь улс төр юм уу шашны утга агуулга эсвэл ялган хуваасан шинж чанартай байдлыг агуулах ёсгүй.
5. **Ур чадвар ба сургалт:** нийлүүлэлтийн сүлжээний менежментийн системийг бий болгохын тулд нийлүүлэлтийн сүлжээний менежментийн туршлагатай ажилтнууд ба хүнсний тусламжийн хөтөлбөрийн менежерүүдийг элсүүлж ажилтнуудыг сургалтанд хамруулах ёстой. Үүнд хамаарах тодорхой мэргэжлийн чадварт гэрээний менежмент, тээврийн ба агуулахын менежмент, бараа материалын менежмент, дамжуулах системийн шинжилгээ ба мэдээллийн менежмент, тээвэрлэлтийг хянах явц, импортын менежмент гэх мэт орно. Сургалтыг явуулахдаа түнш байгууллагуудын боловсон хүчнийг оролцуулах ёстой.

6. **Тайлан мэдээ:** ихэнх хүнсний тусламжийн хандивлагчид нь тайлан мэдээ гаргах тодорхой шаардлагуудыг тавьдаг бөгөөд нийлүүлэлтийн сүлжээний менежерүүд нь эдгээр шаардлагуудын талаар мэдлэгтэй байж, тэдгээр шаардлагууд ба өдөр тутмын менежментийн шаардлагуудыг хангасан системийг байгуулах ёстой. Энэ шаардлагуудад нийлүүлэлтийн сүлжээнд гарсан саатал ба зөрчлийн талаар түргэн шуурхай мэдээ өгөх асуудал орно.
7. **Бичиг баримт:** гүйлгээнүүдтэй холбоотой баримтжуулсан аудитыг хэрэгжүүлэхийн тулд хүнсний бүтээгдэхүүн хүлээж авах, хадгалах, илгээж байгаа бүх газруудад бичиг баримт ба маягтийн хангалттай нөөцийг (замын хуудас, нөөцийн бүртгэл, тайлан мэдээний маягт гэх мэт) бэлэн байлгах ёстой.
8. **Агуулах:** тухайн зорилгод зориулагдсан (хүнс) агуулах нь хувааж ашигладаг байгууламжуудаас илүү тохиромжтой байдаг. Агуулахыг сонгохдоо тэнд өмнө нь аюултай бүтээгдэхүүн хадгалж байгаагүй ба бохирдол үүсэх аюулгүй байдлыг харгалзах ёстой. Үүнд тооцох ёстой бусад хүчин зүйлүүдэд аюулгүй байдал, хүчин чадал, очиход хялбар байдал, найдвартай байдал (дээвэр, хана, хаалга, шал) бологн үерт автахгүй байх баталгаа орно.
9. **Хүний хэрэглээнд тохиромжгүй бүтээгдэхүүнүүдийг устгах:** гэмтсэн бүтээгдэхүүнүүдийг эмч, нийгмийн эрүүл мэндийн лаборатори зэрэг өндөр мэргэжлийн байцаагчид хянаж хүний хэрэглээнд тохиромжтой эсэхийг тогтоох ёстой. Хүний хэрэглээнд тохиромжгүй бүтээгдэхүүнийг устгах аргад мал амьтын тэжээлийн зориулалтаар худалдах, булах, шатаах зэрэг аргууд орно. Амьтны тэжээл хэлбэрээр ашигласан тохиолдолд бүтээгдэхүүнийг тухайн зорилгоор ашиглах боломжтой гэсэн гэрчилгээ авсан байх шаардлагатай. Бүх тохиолдлуудад хэрэглээнд тохиромжгүй бүтээгдэхүүнүүд нь хүн ба амьтны хүнс тэжээлийн нийлүүлэлтийн сүлжээнд буцан орохгүй бөгөөд тэдгээрийг устгаснаар орчин тойрны байгал, усыг бохирдуулахгүй байх явдлыг баталгаажуулах ёстой.
10. **Нийлүүлэлтийн сүлжээнд учрах аюул:** зэвсэгт мөргөлдөөний үед тусламжийн хүнсийг дайтаж байгаа талууд дээрэмдэх юм уу өгөхийг шаардах аюултай байдаг бөгөөд тээврийн зам ба агуулахуудын аюулгүй байдлыг мөн тооцох ёстой. Гамшгийн бүх нөхцлүүдэд нийлүүлэлтийн сүлжээний бүх түвшинд хүнсний бүтээгдэхүүн хулгайд алдагдах магадлалтай байдаг ба тэдгээрийг хадгалах, шилжүүлэх, түгээх цэгүүдэд дээрхи эрсдлийг бууруулахын тулд хяналтын системийг байгуулах ёстой. Дотоодын хяналтын системийг тогтоохдоо хуйвалдах боломжийг бууруулахын тулд үүрэг хариуцлагын хуваарилалтыг баталгаажуулах ёстой. Хүнсний бүтээгдэхүүнийг өөр зүйлд зориулах явдлыг илрүүлэхийн тулд нөөц материалыг тогтмол шалгах ёстой.

Хэрвээ өөр зүйлд зарцуулсан нь илэрвэл зөвхөн нийлүүлэлтийн сүлжээний халдашгүй байдлыг баталгаажуулахаас гадна илүү өргөн хүрээний улс төрийн ба аюулгүй байдлын үр дагавруудыг (хүнсний бүтээгдэхүүнийг зэвсэгт тэмцлийн зорилгоор ашиглах гэх мэт) шинжилж асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах ёстой.

11. **Дамжуулах системийн шинжилгээ:** дамжуулах системийн шинжилгээг тогтмол явуулж нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч бүх талууд нь нөөцийн хэмжээ, хүлээгдэж байгаа бүтээгдэхүүн, түгээлт зэргийн талаархи мэдээллийг харилцан солилцох ёстой. Нийлүүлэлтийн сүлжээний дагуух нөөцийн түвшинг тогтмол хянаж урьдчилан таамаглахдаа шийдлийг олох үед урьдчилан таамагласан нийлүүлэлтийн доголдол ба хүндрэлтэй асуудлуудад онцгой анхаарах шаардлагатай.
12. **Мэдээллээр хангах:** орон нутгийн мэдээллийн хэрэгсэл юм уу мэдээг түгээх уламжлалт аргуудыг ашиглах нь хүмүүст хүнсний хангамж ба үйл ажиллагааны талаархи мэдээллээр хангах нэг арга байх ёстой. Энэ нь ил тод байдлыг нэмгдүүлэхэд тустай. Хүнсний тусламжийн хөтөлбөрийн талаархи мэдээллийг олон нийтэд түгээхэд эмэгтэйчүүдийн тусламжийг авч болно.

Хүнсний тусламжийн менежментийн стандарт 3: түгээлт

Хүнсний түгээлтийн ажиллагаа нь өндөр мэдрэмжтэй, ил тод, эрх тэгш бөгөөд орон нутгийн нөхцөл байдалд тохирсон байх ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Хүнсний тусламжийг хүлээн авах хүмүүсийг тогтоохдоо хамааралтай хүмүүс тэр дундаа бүлгүүдтэй харилцан зөвлөлдсөний үндсэн дээр явуулсан үнэлгээгээр тогтоосон хэрэгцээ шаардлагыг баримтална (Заавар тэмдэглэл 1-2-г үзнэ үү).
- Үр ашигтай бөгөөд эрх тэгш түгээлтийн аргыг орон нутгийн бүлгүүд ба түнш байгуулалгуудтай харилцан зөвлөлдсөний үндсэн дээр бий болгох ба үүнд янз бүрийн тусламж хүлээн авагч бүлгүүдийг оролцуулна (Заавар тэмдэглэл 1-3-г үзнэ үү).
- Тусламж хүлээн авч байгаа хүмүүс очиход хялбар байдал аюулгүй байдлыг бодолцон түгээлтийн цэгийг аль болохоор тэдний гэр ойрхон байрлуулна (Заавар тэмдэглэл 4-5-г үзнэ үү).
- Тусламж хүлээн авагчдад түгээж байгаа хүнсний бүтээгдэхүүний чанар ба тоо хэмжээ мөн түгээлтийн төлөвлөгөөний талаархи мэдээллийг хүнсний бүтээгдэхүүнийг түгээхээс нилээд өмнө өгнө (Заавар тэмдэглэл 6-7-г үзнэ үү).
- Хүнсний тусламжийн хөтөлбөрийн гүйцэтгэл ба үр дүнтэй байдлыг зохих шаардлагын дагуу хянаж үнэлнэ (Заавар тэмдэглэл 8-г үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **зорилго:** хүнсний тусламж нь оршин суугчдын хамгийн эмзэг хэсгийн хэрэгцээ шаардлагыг хүйс, бие махбодийн доголдол, шашны болон угсаатан зүйн гарал үүсэл гэх мэт шалтгаанаар ялгаварлан гадуурхахгүй байх зарчмаар үйлчилдэг. Түгээлтийн агентуудыг сонгохдоо тэдгээрийн шударга байдал, хүчин чадвар, хариуцлагатай байдал дээр үндэслэнэ. Түгээлтийн агентуудад орон нутгийн өндөр настнууд, орон нутгийн сонгуульт тусламжийн хороод, орон нутгийн байгууллагууд, орон нутгийн төрийн бус байгууллагууд, төрийн юм уу олон улсын төрийн бус байгууллагууд зэрэг орно (28-33-р хуудсанд байгаа оролцоо ба анхны үнэлгээний стандартууд ба 35-р хуудсанд байгаа зорилгын стандартыг үзнэ үү)
2. **Бүртгэл:** хүнсний тусламж авч байгаа айл өрхийн албан ёсны бүртгэлийг аль болохоор түргэн хугацаанд явуулж шаардлагатай үед шинэчилнэ. Орон нутгийн удирдлагын гаргасан жагсаалт ба оршин суугчдын гаргасан айл өрхийн жагсаалтыг ашиглаж болох ба энэ үйл явцад гамшигт өртсөн хүн амд хамаарах эмэгтэйчүүдийг оролцуулах нь зүйтэй. Эмэгтэйчүүд өөрсдөө хүсэх юм бол өөрсдийн нэрээрээ бүртгүүлж болно. Өрх гэр толгойлсон эмэгтэйчүүд ба өсвөр насныхныг түгээлтийн жагсаалтад оруулахгүй орхихгүй байхад онцгой анхаарал хандуулах ёстой. Онцгой байдал үүссэн эхнийн үед бүртгэлийг явуулах боломжгүй бол нөхцөл байдал тогтворжсон даруй түүнийг нэн даруй хэрэгжүүлэх ёстой. Энэ нь ялангуяа хүнсний тусламж удаан хугацааны туршид шаардлагатай байгаа бол онцгой чухал юм.
3. **Түгээлтийн аргууд:** ихэнх түгээлтийн аргууд цаг хугацааны явцад хөгждөг. Эхний үе шатанд айл өрхийн жагсаалт юм уу орон нутгийн оршин суугчдын гаргасан баримжаа тооцоон дээр үндэслэн хүнсний бүтээгдэхүүний түгээлтийг явуулах нь цорын ганц боломжтой арга байж болно. Хүнсний бүтээгдэхүүн нь зориулагдсан эзэндээ хүрч байгаа эсэхийг баталгаажуулах ба түгээлтийн системийн шударга бөгөөд эрх тэгш байдлыг баталгаажуулахын тулд аливаа системийг нягт ажиглах шаардлагатай. Ялангуяа хөтөлбөр нь эмзэг бүлгийнхэнд хүртээмжтэй байдалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Гэхдээ эмзэг бүлгийнхэнд үйл ажиллагаагаа чиглүүлэх оролдлого хийхдээ тэдгээр бүлгүүдийн хувьд аль хэдийн бий болсон гадуурхагдах байдлыг хүндрүүлэх ёсгүй. Энэ нь ялангуяа ДОХ-ын халдвартай хүмүүс олноороо хүн амын хувьд онцгой чухал асуудал юм (оролцоо, зорилго, хяналт, үнэлгээний стандарт 1-г үзнэ үү).
4. **Түгээлтийн цэгүүд:** аюулгүй бөгөөд тусалж хүлээн авагчдын хувьд хамгийн тохиромжтой газар байгуулах бөгөөд зөвхөн түгээгч агентын хангамжийн ажиллагаанд тохиромжтой байдлыг тооцох ёсгүй. Түгээлтийн давтамж ба түгээлтийн цэгийн тоог шийдэхдээ тусламж хүлээн авч байгаа хүмүүс төвөөс ирэх болон буцах аялалд зарцуулах хугацаа, тээврийн хэрэгслийг ашиглахад тохиромжтой байдал ба зардлыг тооцох ёстой.

Тусламж хүлээн авагчид нь хүнсээ авахын тулд хол зам туулахгүй байх ёстой ба өдөр тутмын амьдрал үйл ажиллагаанд нь саад болохгүйн байхаар түгээлтийг тохиромжтой хугацаанд төлөвлөх ёстой. Түгээлтийн цэгт хүлээлтийн хэсэг ба ундны ус байлгах ёстой (145-152-р хуудсанд байгаа тэжээлийн хомсдолыг арилгах стандарт 1-2-г үзнэ үү).

5. **Аюулгүй байдлын эрсдэлийг хамгийн бага хэмжээнд хүргэх:** хүнс нь үнэ цэнэтэй бүтээгдэхүүн бөгөөд түүний түгээлт нь аюулгүй байдлын эрсдэл тэр дундаа хүнсний бүтээгдэхүүнийг өөр зүйлд зарцуулах ба хүчирхийлэл гарах эрсдэлийг үүсгэвэр болох магадлалтай. Хүнсний хангамж доголдсон үед хүнс түгээхэд хурцадмал байдал үүсч болно. Эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настнууд болон тахир дутуу хүмүүс нь өөрсдийнхөө хоногдох хувь хэмжээг авах боломжгүй юм уу түүнийг нь тэднээс хүчээр булаан авсан байж болно. Эдгээр эрсдэлийг урьдчилан тооцох ёстой бөгөөд тэдгээрийг аль болох бууруулах арга хэмжээ авах ёстой. Үүнд түгээлтийг зохих шаардлагын дагуу ажиглах ба түгээлтийн цэгүүдийг хамгаалах тэр дундаа шаардлагатай үед орон нутгийн цагдааг татан оролцуулах явдал орно. Хүнсний бүтээгдэхүүний түгээлттэй холбоотой бэлгийн хүчирхийлэл юм уу боолчлолоос урьдчилан сэргийлэх, хянах, хариу арга хэмжээ арга хэмжээнүүд авах шаардлагатай байж болно.
6. **мэдээллийг түгээх:** тусламж авагсад нь дараахи мэдээллийг авсан байх ёстой. Үүнд:
 - түгээх хүнсний тоо хэмжээ ба төрөл, тогтсон хэм хэмжээнээс зөрсөн шалтгаан
 - түгээлтийн төлөвлөгөө (өдөр, цаг, газар, давтамж) ба хэрэв төлөвлөгөө өөрчлөгдсөн бол ямар гадаад нөхцөл байдлын улмаас үүссэн
 - хүнсний тэжээллэг чанар ба хэрэв шаардлагатай бол тэжээллэг чанарыг хадгалж хамгаалахад онцгой анхаарал тавина
 - хүнсний бүтээгдэхүүнтэй аюулгүй байдлаар зөөвөрлөх ба хэрэглэх шаардлага заавар, зөвлөлгөө
7. **хөтөлбөрт орох өөрчлөлт:** хүнсний багц бүтээгдэхүүний юм уу хүнсний хангалтгүй нийлүүлэлтээс шалтгаалсан хүнсний түгээлтэд өөрчлөлтийн хийх талаар түгээлтийн хороод юм уу орон нутгийн удирдагчдаар дамжуулж хүнсний тусламж хүлээн авч байгаа талуудтай харилцан зөвлөлдөж хамтран авах ёстой арга хэмжээнүүдийг боловсруулах ёстой. Түгээлтийн хороо нь хүн амд гарсан өөрчлөлт ба тэдгээрийн шалтгаан, өөрчлөлтийн үргэлжлэх хугацаа, хэвийн түгээлтийг сэргээх хугацаа зэргийн талаар мэдээлэх ёстой. Хүмүүс юу хүлээж авах ёстой талаар тодорхой мэдээлэл өгөх ёстой. Жишээ нь, хүмүүс өөрсдийн авах эрхтэй зүйлийн талаар мэдэж байхын тулд түгээх хүнсний бүтээгдэхүүний хэмжээг орон нутгийн хэлээр бичсэн юм уу зурсан байдлаар түгээлтийн цэгүүдэд тодорхой харуулах ёстой.

8. **Хяналт ба үнэлгээ:** хүнсний тусламжийн түгээлтийн хяналт үнэлгээг нийлүүлэлтийн сүлжээний бүх түвшинд явуулах ёстой. Тусламж тараалтын цэгүүдэд түгээлтийн нарийн хэмжилт ба шударга байдлыг хангахын тулд айл өрхүүдийн хүлээн авсан хүнсний бүтээгдэхүүнийг таамгаар сонгож үе үе жигнэж үзэх ёстой ба хөтөлбөрөөс гарч байгаа хүмүүсээс ярилцлага авна. Тухайн нийгмийн бүлэгт хүнсний тусламж хүлээн авч байгаа айл өрхүүдээр гэнэт зочилж тарааж буй хүнсний хэмжээ нь хүрэлцээтэй ба хэрэгцээтэй эсэхийг олж мэдэх ба сонгон шалгаруулалтын шаардлагыг хангаж байгаа боловч хүнсний тусламж аваагүй байгаа хүмүүсийг олж тогтоох нь чухал юм. Мөн ийнхүү айлчлалууд нь тухайн өрхөд нэмэлт хүнс ирж байгаа эсэх, авч байгаа бол хаанаас ирж байгаа (жишээ нь, дарангуйлал, элсүүлэлт, дарлал, бэлгийн гэх мэт). Хүнсний түгээлтийн системд үзүүлж байгаа илүү өргөн хүрээний нөлөөг ч гэсэн тооцох ёстой. Үүнд хөдөө аж ахуйн цикл, хөдөө аж ахуйн үйл ажиллагаа, зах зээлийн нөхцөл байдал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хүчин зүйлүүдийн олдоц зэрэг хамаарч болно.

Хавсралт 1

Хүнсний аюулгүй байдлын аргазүй болон мэдээлэл

Хүнсний аюулгүй байдлын үнэлгээ нь

1. түүнд хэрэглэх аргазүйг ойлгомжтой тодорхойлсон байх

- ерөнхий төлөвлөлт болон зорилтууд
- үнэлгээ хийх хүмүүсийн тоо, тэдний боловсрол мэдлэгийн түвшин /тус тусдаа эсвэл хосоороо ажиллах/
- гол мэдээллэгчийг сонгох /тэд бүх хэсгүүдийг төлөөлж чадаж байна уу/
- ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүн
- мэдээллэгчийг сонгох шалгуур үзүүлэлтүүд
- үнэлгээний хамрах цаг хугацаа
- Задлан шинжлэх болон аргазүйн хэрэгслүүд үүнд Participatory rural appraisal (PRA) – гийн техник, хэрэгсэл багтана

2. чанарын арга барилд үндэслэсэн байх ба үүнд хоёрдогч мэдээллийн эх үүсвэрийг харгалзан үзэх

3. нэр томъёог зөв хэрэглэх, жишээ нь зорилтот сорьц, үндсэн мэдээлэгч, үндсэн ажлын хэсэг, тусгай арга техникийн нэр томъёонууд гэх мэт

4. тохиромжгүй нөхцөл байдал жишээ нь зарим нэг зөрчил тэмцэл үүсээгүй бол орон нутгийн байгууллагуудыг үнэлгээний процесст оролцуулах

5. PRA –ийн арга барил техник хэрэгслийг ашиглах /олсон мэдээ мэдээллийг задлан шинжилж үнэлгээ өгөхөд хэрэглэнэ/

6. гамшигт нэрвэгдсэн хүн ам болон ажлын хэсгүүдийн төлөөллийг оролцуулах

7. үнэлгээний хязгаарлалт практик хүрээг тодорхойлох

8. үнэлгээний хүрээг тодорхойлж газарзүйн тархалт, ажлын хэсгүүдийн цар хүрээ болон бусад холбогдох хүн амын давхаргыг багтаах /жишээ нь хүйс, яс үндэс, овог аймаг гэх мэт/

9. холбогдох засгийн газрын яамдууд, олон нийтийн үйлчилгээний байгууллагууд, уламжлалт лидерүүд, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөгчид /шашны бүлэг, орон нутгийн төрийн бус байгууллагууд, өмгөөлөлийн болон хүчний байгууллагууд, фермер буюу хөдөө аж ахуйн ажилчдын холбоод, эмэгтэйчүүдийн бүлгүүд/ болон ажлын хэсгүүдийн төлөөлөгчидтэй уулзсан уулзалтуудыг багтаах

Үнэлгээний тайланд заавал тусгах зүйлс:

1. тухайн нөхцөл байдлаас өмнөх үеийн хүнсний аюулгүй байдал болон холбогдох бодлогуудын түүхэн цаг үеүдийг тусгах
2. хүн амын янз бүрийн түвшний бүлгүүд болон тэдний гамшигт нэрвэгдэхээс өмнөх үеийн хүнсний аюулгүй байдал ямар байсан
3. амьжиргааны янз бүрийн түвшний хүмүүсийн гамшигаас өмнөх хүнсний аюулгүй байдал
4. Амьжиргааны янз бүрийн түвшний хүмүүсийн хүнсний аюулгүй байдал болон хүнсний системд үзүүлсэн гамшигийн цар хүрээ
5. эмзэг амьжиргааны түвшинд байгаа хүн амын бүлэг буюу тухайн үеийн хүнсний аюулгүй байдлын алдагдалд илүү ихээр өртөх магадлалтай хүн амын хэсэг
6. санал болгож байгаа арга хэмжээ, хэрэгжүүлэх арга хэрэгсэл, өмгөөлөл болон нэмэлт үнэлгээ шаардлагатай.
7. хэрэв хүнсний тусламж үр дүнгээ өгсөн бол хүнсний тусламжийн зорилго, үргэлжлэх хугацаа зэргийг нарийвчлан зааж өгөх, хүнсний тусалцааны үр дүн дээр дурьдсан өгөгдөл болон анализ дээр үндэслэгдсэн байх ёстой

Хавсралт 2

Хүнсний аюулгүй байдлын үнэлгээний асуултууд

Хүнсний аюулгүй байдлын үнэлгээ нь гол төлөв тухайн нэрвэгдсэн хүн амыг хүнс, орлого олж байгаа байдал, эх үүсвэр дээр нь үндэслэн амьжиргааны түвшнээр нь категорчилдог. Энэ нь мөн хүн амын чинээлэг хэсэг буюу давхаргыг багтаасан байж болно. Тухайн үеийн нөхцөл байдлыг гамшгийн өмнөх хүнсний аюулгүй байдалтай харьцуулж үзэх нь чухал байдаг. Үүнд “дундаж жилүүд” ийг үндсэн үзүүлэлт гэж үзэж болно. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн үүрэг роль, эмзэг өртөмтий байдал мөн өрхийн хүнсний аюулгүй байдлын нөлөөллийг харгалзан үзэх шаардлагатай байдаг. Өрхийн доторх хүнсний аюулгүй байдлын ялгаануудыг харгалзан үзэх нь мөн адил чухал байж болох талтай.

Энд хүнсний аюулгүй байдлын үнэлгээнд харгалзан үздэг салбар ухагдхуунуудыг авч үзсэн бөгөөд нэмэлт мэдээллийг гамшигийн илүү өргөн цар хүрээг хамруулан олж авах ба /жишээ нь улс төрийн нөхцөл байдал, хүн амын тоо, шилжилт хөдөлгөөн гэх мэт/ мөн бусад салбаруудын харилцан хамааралд нь авч үзэх /хоол тэжээл, эрүүл мэнд, усны хангамж, орох орон гэх мэт/ хэрэгтэй болдог.

Энэхүү жагсаалт нь тухайн орон нутгийн нөхцөл байдал болон үнэлгээний зорилготой нийцэж байхаар таарсан байх ёстой. Илүү дэлгэрэнгүй жагсаалтыг жишээ нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг –ийн “Талбайн үйл ажиллагааны заавар” /1998/-аас авах боломжтой.

Амьжиргааны түвшний бүлгүүдийн хүнсний аюулгүй байдал

1. Амьжиргааны адил стратегитай хэсэг/бүлэг хүмүүс байна уу?
Тэднийг хүнс эсвэл орлогын эх үүсвэрээр нь хэрхэн ангилан хуваах вэ?

Гамшгийн өмнөх хүнсний аюулгүй байдал

2. Гамшгаас өмнө тухайн өөр хоорондоо адилгүй бүлэг, давхарга хэрхэн хүнс буюу орлогоо олдог байсан бэ? Хамгийн сүүлийн жилийн дундаж байдлаар тэдний хүнс орлогын эх үүсвэр нь юу байв?
3. Энгийн нэг жилд хүнс орлогын эх үүсвэр улирлын чанартай хэрхэн өөрчлөгдөн хувирч байсан байна? /улирлын календарь хөтлөх нь илүү үр дүнтэй байж болно/

4. Өнгөрсөн 5-10 жилийн хугацаанд хүнсний аюулгүй байдал жилээс жилд хэрхэн өөрчлөгдөж байсныг тодруулах /Сайн тааруу жилүүдийг графикаар харах нь үр дүнтэй байж болох талтай/
5. Тухайн давхаргын хүмүүсийн эзэмшиж байгаа хөрөнгө хадгаламж болон бусад нөөц юу байна /жишээ нь хүнсний нөөц, бэлэн мөнгөний хадгаламж, мал хөрөнгө, хөрөнгө оруулалт, кредит, авлага гэх мэт/
6. Долоо хоног эсвэл сарын хугацаанд өрхийн зарлага юу юу байв, юунд ямар хэмжээгээр зарлагдсаныг тодруулах
7. Өрхийн мөнгийг хэн захиран зарцуулж байна, юунд бэлэн мөнгө зарцуулж байна?
8. Өргөн хэрэглээний бараа бүтээгдхүүнээ авах ойрын зах зээл хаана байна /алслагдсан байдал, аюулгүй байдал, тээвэр, тухайн зах зээлийн газрын талаар мэдээлэл авах боломж бололцоо/
9. Зайлшгүй шаардлагатай бараа бүтээгдхүүн /хүнсийг оролцуулаад/-ийн хүрэлцээ, үнэ
10. Гамшигаас өмнөх хүнс орлогын харьцаа, жишээ нь цалин -хүнс, мал- хүнс, ямар байсан бэ?

Гамшгийн үеийн хүнсний аюулгүй байдал

11. Тухайн давхаргын хүмүүсийн орлого, хүнсний янз бүрийн эх үүсвэрүүдэд гамшиг хэрхэн нөлөөлөв?
12. Улирлын чанартай хүнсний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөв?
13. Зах зээлд хүрэх боломж, зах зээлийн боломж үндсэн нэрийн бараа бүтээгдхүүний үнэнд хэрхэн нөлөөлөв?
14. Янз бүрийн давхаргын бүлгүүдийн асуудлыг шийдэх стратеги нь юу байна, түүнд хир олон хүн хамрагдаж байна?
15. Энэ нь гамшгийн өмнөх байдалтай харьцуулахад хэрхэн өөрчлөгдөв?
16. Аль бүлгийн хүмүүс буюу хүн ам илүү ихээр өртөв?
17. Хүмүүсийн санхүү болон бусад хөрөнгөнд тухайн стратеги нь богино болон дунд хугацаанд нөлөөлөх нөлөө нь хир далайцтай байна?

18. Тухайн стратеги тэдгээр хүмүүсийн эрүүл мэнд, сайн сайханд хэрхэн тусгалаа болов, түүнтэй холбоотой ямар нэг эрсдэл байна уу?

Хавсралт 3

Хүнсний аюулгүй байдлын тусламж

Гамшгийн үед хүнсний аюулгүй байдлыг хамгаалах, дэмжих болон түлхэц өгөх зүйлс нь өргөн хүрээгээр тодорхойлогддог. Доорх жагсаалт нь түүний зөвхөн нэг хэсэг нь юм. Нөлөөлөл бүхэн тухайн орон нутгийн нөхцөл байдал болон хүнсний аюулгүй байдлыг тэтгэх стратеги бодлоготой уялдсан байхаар төлөвлөсөн байх ёстой бөгөөд тиймээс төлөвлөлт болон зорилгоороо дахин давташгүй өвөрмөц байдаг. Эрэлт хэрэгцээг харгалзан үзэж задлан шинжилгээ хийсны үндсэн дээр хөтөлбөрийн сонголт болон нөлөөлөх хүчин зүйлүүдийг тодорхойлох нь чухал. Нөлөөллийг Хүнсний Аюулгүй Байдлын Стандарт 2-4 хамаарах 3 бүлэгт хуваан авч үзэж болно.

- Үндсэн үйлдвэрлэл
- Орлого болон ажил эрхлэлт
- Зах зээлийн бараа бүтээгдхүүн үйлчилгээнд хамрагдах боломж

Хүнсний ерөнхий түгээлт нь өрхүүдэд хүнсний тусламж болон шууд хүрдэг тул богино хугацааны хүнсний аюулгүй байдалыг хангахад маш чухал зүйл болдог.

Үндсэн үйлдвэрлэл

- Үр, багаж хэрэгсэл, бордоо түгээх: нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмждэг, гол төлөв хөдөө аж ахуйн бусад ажил үйлчилгээ болон техник сургалттай хосолсон байдаг.
- Үрийн ваучер болон үзэсгэлэн худалдаа: худалдан авагчдад зориулсан үрийн ваучер дээр үндэслэх бөгөөд үрийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулах нь худалдаачдыг нэг дор цуглуулж тухайн орон нутгийн үрийн хангамжыг сайжруулахын зэрэгцээ худалдан авагчид төрөл бүрийн үр авах боломж бололцоо бүрдэх юм.
- Орон нутгийн хөдөө аж ахуйн өргөтгөсөн ажил үйлчилгээ
- Үр чадвар, мэдлэг мэргэжил олгох сургалтууд

- Мал аж ахуйн нөлөөлөл: үүнд мал амьтдын эрүүл ахуйн арга хэмжээ, гамшгийн үеийн малыг тусгаарлан салгах болон буцаан нийлүүлэх арга хэмжээ, малын тэжээл хувиарлах, нэмэлт тэжээлээр хангах, малын байр бэлдэх нэмэлт усны эх үүсвэрээр хангах гэх мэт
- Загасны тор, загас барих хэрэгсэл, ан агнуурын хэрэгслээр хангах
- Хоол боловсруулалтыг дэмжих

Орлого болон хөдөлмөр эрхлэлт

- Бэлэн мөнгөөр ажил хийх буюу cash-for-work (CFW) нь хүнсний хангамж дутагдалтай өрхүүдийг хөлсний ажил эрхлэх боломжоор хангана.
- Хүнсээр ажил хийх буюу food-for-work (FFW) нь боломж муутай өрхүүдийг хөлсний ажлаар хангах боломж олгохын зэрэгцээ өөрт болон нийгэмд хэрэгтэй эд баялгийг үйлдвэрлэх боломж олгоно.
- Хүнсээр нөхөн сэргээлт хийх буюу food-for-recovery (FFR) нь хүнсээр ажил хийхийн бас нэг хялбар хэлбэр бөгөөд анхан шатны сэргээлтэнд туслалцаа дэмлэг үзүүлэх ба гадны техникийн хяналт шаардлаггүй байдаг.
- Орлого бий болгох загвар нь хүмүүс орлогын эх үүсвэрээ олон төрөл болгох боломж олгоно, үүнд жижиг, цар хүрээтэй хувиараа хөдөлмөр эрхлэлт багтана. Тэдний бизнест менежментийн, хяналт гүйцэтгэлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх арга хэмжээ орно.

Зах зээлийн бараа бүтээгдхүүн ажил үйлчилгээнд хамрагдах

- *Зах зээлийн болон дэд бүтцийн тал дээр дэмжлэг туслалцаа үзүүлэх* –д үйлдвэрлэгчдийг холын зах зээлд нэвтрэх боломж гаргах тээвэрлэлт орно.
- *Малыг худалдах*: нь ган гачиг, усны хомсдол үүссэн бэлчээрийн гарц муудсан болон малын зах зээлийн үнэ ханш унаж байгаа цаг үед боломжийн сайн үнээр худалдах боломж олгоно.
- *Үзэсгэлэн худалдааны газрууд*: үндсэн нэр төрлийн бүтээгдхүүнүүдийг төрөөс барьж байгаа буюу төрийн санхүүжүүлэлт, татаасын үнээр худалдаалах эсвэл ваучер болон бараа бүтээгдхүүнээр солих
- *Хүнс эсвэл/буюу бэлэн мөнгөний ваучер*: нь дэлгүүрт хүнсээр болон өөр бараа бүтээгдхүүнээр солих

- *Засгийн газрын ажил үйлчилгээнд дэмжлэг болохуйц техникийн туслалцаа:* хөдөө аж ахуйн өргөтгөсөн ажил үйлчилгээ болон мал эмнэлгийн үйлчилгээ
- *Микро санхүүжүүлэлтийн төслүүд:* үүнд жишээ нь, зээл олгох, хадгаламжийн аргууд, жишээ нь зээл, төрөөс олгох зээл, малын сан, нөхөрлөлийн сан байгуулах гэх мэт

Хүнсний аюулгүй байдлын тухай хавсралт 9 –ээс бас үзэж болно.

Хавсралт 4

Хоол тэжээлийн үнэлгээний асуултууд

Хоол тэжээлийн дутагдалд хүргэх шалтгаануудыг нягтлан үзэх, эрсдэлийн хэмжээ болон үр дагаварын үнэлгээний жишээ асуулгыг дор үзүүлэв. Тэдгээр асуултууд нь хоол тэжээлийн дутагдалд хүргэх шалтгаануудын хүрээнд тавигдаж байгаа /136-р хуудсыг харна уу/ бөгөөд мэдээллийг янз бүрийн эх сурвалжаас авах боломжтой ба тэдгээр мэдээллийг цуглуулахад үнэлгээний олон янзын хэрэгслүүд шаардлагатай болдог. Үүнд мэдээлэгчтэй хийх ярилцлагууд, хоёрдогч мэдээллийг харгалзан үзэх зэрэг багтана. /28-33-р хуудсанд байгаа Анхан шатны үнэлгээ, стандарт-ыг үзнэ үү./

1. Хоол тэжээллэгийн байдлын талаар ямар мэдээ мэдээлэл байна?

- A. Хоол тэжээлийн талаар ямар нэг санал асуулга явуулсан уу?
- B. Эх нялхсын эрүүл мэндийн клиникээс гаргасан мэдээ мэдээлэл байна уу?
- B. Эмчилгээ сувилгааны төвүүдийн мэдээ мэдээлэлээс авах боломж байна уу?
- C. Гамшигт нэрвэгдсэн хүн амын гамшигаас өмнөх үеийн хоол тэжээлийн нөхцөл байдалын талаарх мэдээ мэдээлэл байна уу? /хүмүүс тухайн газар орондоо байхгүй байсан ч/

2. Эмзэг бүлгийнхний эрүүл мэндтэй холбоотойгоор хоол тэжээлийн дутагдлын эрсдэл юу байна?

- A. Хоол тэжээлийн байдалд нөлөөлөхөөр ямар нэг өвчин дэгдсэн мэдээлэл байна уу, жишээ нь салхин цэцэг, гэдэсний ужиг өвчнүүд, шинээр өвчин гарах эрсдэл байна уу? /273-р хуудсан дахь Халдварт өвчний стандарт хяналт –ыг үзнэ үү/
- B. Улаан бурхын эсрэг тухайн нэрвэгдсэн хүн амын вакцинжуулалтын түвшин ямар байна? /халдварт өвчний хяналтын стандарт 2-ыг 275-р хуудаснаас харна уу/
- B. Улаан бурхны вакцинжуулалтаар витамин А өгсөн үү, Витамин А- жуулалтын түвшин ямар байна?

- С. Нас баралтын түвшинг гаргасан судалгаа байна уу, ямар судалгаа байна, түүндээ ямар арга хэрэглэсэн байна /эрүүл мэндийн систем болон дэд бүтцийн стандарт 1, 259-р хуудас хар/
- Д. Амьсгалын замын халдвар тараах орчны температурын уналт ажиглагдаж байна уу?
- Е. ХДХВ/ДОХ-ын тархалт их, хүмүүс ядуу тарчиг болон эрүүл мэндийн байдлаас шалтгаалан хоол тэжээлийн дутгадалд нэрвэгдэхэд хялбар болсон байна уу?
- Ү. Хүмүүс чийгтэй нойтон нөхцөлд эсвэл усандхэр удаан байсан бэ?

3. Муу халамж үйлчилгээтэй холбоотойгоор үүсэх хоол тэжээлийн дутгадалд орох эрсдэл юу вэ?

- А. Хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдалд өөрчлөлт гарсан уу /жишээ нь дүрвэх, нүүх, зэвсэгт мөргөлдөөн гэх мэтээс шалтгаалан/, өөрөөр хэлбэл өрхийн доторх үүрэг хариуцлагад гарсан өөрчлөлт байгаа эсэх
- Б. Өрхийн энгийн бүтэц алдагдсан уу, салж сарнисан хүүхдийн тоо их байна уу?
- В. Халамж үзүүлэх энгийн орчин бүрдүүлэхэд саад тотгор учирсан уу, /жишээ нь дүрвэх/ хоёрдогч харгалзагчгүй болох, хүүхдийн хоол тэжээлгүй болох, усгүй болох
- Г. Хүүхдийг яаж хооллож байна, эхчүүд угжаар хооллож байна уу эсвэл үйлдвэрийн хүнсний зүйл хэрэглэж байна уу? Хэрэв тийм бол угжаар хооллох нөхцөл бололцоо, орчны дэд бүтэц хир хөгжсөн байна?
- Д. Хүүхдийн хоол тэжээл сүү, угж нийлүүлдэг хандивлагч байна уу, энэ талаар хүсэлт тавьсан явдал гарч байна уу?
- Е. Малчин өрхүүдийн хувьд бага хүүхдүүдээсээ хол удаан хугацаагаар явж байна уу, сүүгээр хооллох байдалд өөрчлөлт гарсан уу?
- Ж. Өрхийн хүрээнд Дох-оор өвчилсдийг асран сувилах практик байна уу?

4. Хүнсний хүрэлцээ муугаас хоол тэжээлийн дутагдалд орох эрсдэл юу вэ?

Хавсралт 2 хүнсний аюулгүй байдлын үнэлгээ үзнэ үү.

5. Тухайн **орон нутгийн** албан болон албан бус **бүтэц** ямар байна, үр дүнд хүргэх ажил явуулах суваг юу байна?

А. Эрүүл Мэндийн Яам, Дох-ын эсрэг тэмцлийг дэмжигч байгууллагууд, хүүхдийн тэжээлээр тусалж дэмжигчид эсвэл тухайн газар урт богино хугацаагаар ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудын хүчин чадал ямар байна?

Б. Ямар төрлийн хүнс хэрэглээнд байна?

В. Хүн ам нь удахгүй нүүдэл суудал хийх гэж байна уу /бэлчээр/тусламж/ажил/?

6. Гамшгаас өмнө **хоол тэжээлийн тусламж дэмжлэг** үзүүлэх орон нутгийн байгууллага, хувь хүн, төр захиргааны байгууллагууд, НҮБ-ын агентлаг, шашны байгууллага гэх мэт байгууллага хувь хүн тухайн **орон нутагт байсан уу**, өмнө нь , гамшигийн улмаас одоо болон ирээдүйд баримтлаж байсан, байгаа, баримтлах ямар хоол тэжээлийн бодлого байна, урт хугацаагаар төлөвлөсөн ажил байна уу, ямар хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байна?

Хавсралт 5

Хоол тэжээлийн хурц дутагдлыг хэмжих

Таваас доош настай хүүхдүүд

6-59 сартай хүүхдүүдийн дунд хоол тэжээлийн дутагдлын янз бүрийн түвшинг харуулах хүчин зүйлсийг доорх хүснэгтэнд үзүүлэв.

Жин -өндөрийн харьцааг Эрүүл мэндийн статистикийн үндэсний төв буюу англиар National Center for Health Statistics (NCHS/CDC)-ийн лавлах өгөгдлөөс авч болно.

Жин-өндрийн Z оноо нь антропометрийн судалгааны үр дүнг мэдээлэхэд чухал үзүүлэлт болдог. Жин-өндрийн дундаж хувь нь бас нэг чухал шалгуур үзүүлэлт болдог бөгөөд гарын шууны тойрог антропометрийн судалгаанд дангаар нь хэрэглэхэд хангалтгүй боловч нас баралтыг тодорхойлоход сайн үзүүлэлтийн нэг болж чаддаг. Тиймээс хооллох хөтөлбөрт хамруулах хоёр шатлалт хяналтын нэг хэсэг болдог. Лимит болгож 12.5 см –ийг авдаг, 11 см-с бага бол 12-59 сартай хүүхдүүдийн дунд хоол тэжээлийн хүнд дутагдалд орсонг илтгэнэ.

	Нийт хоол тэжээлийн дутагдал	Дунд зэргийн дутагдал	Хүнд хэлбэрийн дутагдал
6.0-59.9 сартай хүүхдүүд	Жин-өндрийн $2Z$ оноо буюу дундаж хувь 80 ба буюу тэжээлийн дутагдлаас үүдсэн усан хаван	-3- $2Z$ дундаж хувь 70-80%	-3 Z жин-өндрийн харьцаа 70% -аас бага Тэжээлийн дутагдлаас үүдсэн усан хаван

6 сараас доош сартай хүүхдүүдийн хувьд антропометрийн хэмжилтэнд зориулсан хоол тэжээлийн дутагдлыг тодорхойлох нэгдсэн үзүүлэлт байдаггүй.

Энэ насны хүүхдүүдүүдийн хоол тэжээлийн дутагдлыг тодорхойлоход учир дутагдалтай байдаг.

Бусад насны хүмүүс: хүүхдүүд, өсвөр үеийнхэн, насанд хүрэгсэд, болон настай хүмүүс

Бусад насны хүмүүсийн хувьд архаг хоол тэжээлийн хурц дутагдлын талаар олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт байдаггүй. Үндэстэн ястны өсөлтөн дэх ялгаа 5 нас хүрээд илэрдэг учраас нэг үзүүлэлтийг бүх үндэстэн ястанд авч хэрэглэх нь учир дутагдалтай болдог. Өөр нэг шалтгаан бол дийлэнх нөхцөлд 6-59 сартай хүүхдүүдийн хоол тэжээлийн статусын талаарх мэдээлэл төлөвлөгчдөд шийдвэр гаргахад хангалттай байдаг.

Гэсэн хэдий ч хоол тэжээлийн дутагдлын гамшигийн үед бусад хүүхдүүд, өсвөр үеийнхэн, насанд хүрэгсэд болон өндөр настангуудыг хоол тэжээлийн үнэлгээ болон хөтөлбөрүүдэд хамруулах шаардлагатай болдог. 6-59 сартайгаас бусад насны хүмүүсийн судалгааг зөвхөн доорх тохиолдолд явуулна:

- Тухайн нөхцөл байдалд анализ хийсний дараа. Үүнд хоол тэжээлийн дутагдалд хүгэсэн шалтгаанд задлан шинжилгээ хийх багтана. Анализын үр дүн бага насны хүүхдүүдийн хоол тэжээлийн байдал ерөнхий нийт хүн амын хоол тэжээлийн байдлыг тусгахгүй байгаа тохиолдолд л дараагийн насны хүмүүст судалгаа явуулах үндэс болно.
- Мэдээлэл цуглуулах, таарч тохирох задлан шинжилгээ хийх, үр дүнг зөв харуулах болон тайлбарлах ажлын чанарыг хангахад техникийн экспертиз шаардлагатай
- Судалгаанд хамрагдах бусад насны хүмүүсийг оролцуулаад гарах зардлыг эх үүсвэр, нөөц бололцоог олох
- Судалгааны тодорхой зорилтуудыг дэвшүүлэн тавих

59 сараас дээш насныханд зориулсан хоол тэжээлийн дутагдлыг тодорхойлоход хамгийн тохиромжтой үзүүлэлтүүдийг гаргаж ирэх судалгаа одоо явагдаж байна. Тэр үед энэхүү мэдээлэл өөрчлөгдсөн байх болно.

Бага насны хүүхдүүд /5-9.9 насны/

Бага насны хүүхдүүдийн хоол тэжээлийн дутагдлыг тодорхойлох үзүүлэлтүүд байхгүй байгаа тохиолдолд жин-өндрийн Z оноо болон дундаж хувийг тогтооход NCHS/CDC лавлахыг ашиглахыг зөвлөж байна.

Энэ тохиолдолд түүнээс доош насны хүүхдүүдийн үзүүлэлтийг ашиглаж болно. /дээрх хүснэгтийг харна уу/. Энд мөн тэжээлийн доройтлоос үүдсэн усан хаванд үнэлэлт дүгнэлт хийх шаардалагатай.

Өсвөр үеийнхэн /10-19.9 насныхан/

Өсвөр насныханд зориулсан тодорхой туршсан нэгдмэл нэг хоол тэжээлийн дутагдлын ойлголт байдаггүй. 9-р хавсралтаас үнэлгээний удирдамж талаарх жагсаалтаас үзэж болно.

Насанд хүрэгсэд /20-59.9 насныхан/

Насанд хүрэгсэдийн хоол тэжээлийн архаг дутагдалын талаар нэгдмэл нэг ойлголт байдаггүй боловч хүнд хэлбэрийн хоол тэжээлийн дутагдалын үзүүлэлт нь 16 ийн Биеийн Жингийн Индекс –ээс бага байдаг.

Насанд хүрэгсэдийн хоол тэжээлийн дутагдлын судалгааг биеийн жин, өндөр, сууж байх үеийн өндөр болон хүний бие дэх хүнсний тэжээлийн түвшин буюу Mid-Upper Arm Circumference (MUAC) хэмжилтийн талаарх мэдээллийг олж авах ёстой. Эдгээр мэдээллүүд нь биеийн жингийн индекс буюу Body Mass Index (BMI)–ийг тооцоолоход хэрэглэгддэг. BMI-ийг Cormic /суугаа өндрийг босоо өндөртэй харьцуулсан харьцаа/ - ийн индекстэй тааруулж хүн амын дунд харьцуулалт хийдэг. MUAC ийн хэмжилтийг ямагт хийж байх хэрэгтэй. үзүүлэлт яаралтай шаардлагатай бол эсвэл нөөц боломж хязгаарлагдмал бол судалгааг зөвхөн MUAC-ийн хэмжилтэн дээр үндэслэж болно. Үр дүнг нэмэлт нарийвчилсан орчны мэдээллийг харгалзан үзсэний үндсэн дээр гаргаж авах шаардлагатай. Үнэлгээ хийх талаарх удирдамжийг холбогдох лавлагаануудаас авч болно.

Хувь хүмүүсийг хоол тэжээлийн хөтөлбөрт хамруулах уг хөтөлбөрөөс гаргах, хянах шалгуур үзүүлэлтэнд антропометрийн индексүүд, клиник шинж тэмдэгүүд болон нийгмийн хүчин зүйлүүд /жишээ нь, хоол хүнсний хүрэлцээ, тэжээгч байгаа эсэх, орон байр гэх мэт/-ийг хослуулан авч үзэх шаардлагатай болдог. Усан хаван нь насанд хүрэгсэдийн хувьд хоол тэжээлийн дутагдлаас гадна өөр олон янзын шалтгаантай байж болдог.

MUAC-ийг жирэмсэн эмэгтэйчүүд /жишээ нь хооллолтын хөтөлбөрт хамруулах шалгуур үзүүлэлт/-ийг хянах хэрэгсэл болгон ашиглаж болдог. Нэмэлт тэжээл шаардлагатай байдаг учраас жирэмсэн эхчүүд хүн амын бусад насныханыг бодвол илүү их эрсдэлтэй байдаг. /140-р хуудсанд байгаа Хоол тэжээлийн ерөнхий дэмжлэг туслалцаа стандарт 2-ийг үз/. MUAC нь жирэмсэлтээс шалтгаалан нэг их өөр болдоггүй. MUAC 20.7 см-ээс бага бол урагын өсөлт удаашрах эрсдэл өндөр, 23.0 см-ээс бага бол эрсдэл дунд зэрэг байна.

Өндөр насны хүмүүс

Өндөр настай хүмүүсийн хоол тэжээлийн дутагдалын талаар нэгдмэл нэг ойлголт байдаггүй. Гэвч осолын үед хоол тэжээлийн дутагдалд орох эрсдэлтэй байдаг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага BMI нь 60-69 насны өндөр настангуудад таарах үзүүлэлт гэж үздэг боловч энэ нь бас залуу хүмүүсийн хувьд мөн адил асуудалтай байгаа юм. Нэмж хэлэхэд хэмжилтийг эдгээр насны хүмүүст нарийн явуулах боломжгүй байдаг, учир нь нурууны яс нягтарч нугарсан байдаг. Өндрийн оронд гарын уртыг ашиглах нь үр дүнтэй байдаг боловч өндрийг бодох үржүүлэгч фактор нь хүн амаас шалтгаалан харилцан адилгүй байдаг. MUAC нь настай хүмүүсийн хоол тэжээлийн дутагдлыг хэмжихэд хэрэгтэй хэрэгсэл болдог боловч үзүүлэлтүүдийг тодруулах судалгаа өнөөг хүртэл хийгдсээр байгаа билээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

Бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хэмжих удирдамж одоогоор байхгүй байгаа бөгөөд тэдгээр хүмүүсийг антропометрийн хэмжилтээс гадуур үлддэг. Нүдэн баримжаагаар үнэлэх шаардлагатай. Гарын дээд булчин хөгжсөн суугаа хүмүүсийн хувьд MUAC хэмжилтийн үр дүн буруу гарч болох талтай байдаг. Стандарт хэмжилт болгон өндөр, гарын урт, хөлийн шилбийг авч болно. Стандарт жин, өндөр болон MUAC ын хэмжилт тохиромжгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хэмжилт явуулах хамгийн тохиромжтой аргыг олохын тулд сүүлийн үеийн судалгааг ашиглаж байх хэрэгтэй.

Хавсралт 6

Витамин А болон Иодын дутагдалаас сэргийлэх арга хэмжээ

6-71 сартай хүүхдүүдийн витамин А-гийн дутагдалын үзүүлэлт

Аль нэг буюу түүнээс олон үзүүлэлт нь давамгайлж байвал эрүүл мэндийн хувьд асуудалтай болж байна гэж үзнэ.

Үзүүлэлт	Доод хязгаар
Шөнийн харалгана /24-71 сартайд/ Битот толбо Нүдний болорын xerosis/кератомаласиа/шархлаа Болорын сорви	1%-аас бага 0.5%-аас бага 0.01%-аас бага 0.05%-аас бага

Иод дутлын үзүүлэлт

Доор хүснэгтэд үзүүлсэн үзүүлэлтүүдийг гамшгийн үед үнэлэлт өгөхөд ашиглаж болох юм. Доод тал нь нэг цаашилбал түүнээс их үзүүлэлт давамгайлж байвал эрүүл мэндийн хувьд асуудалтай болж байна гэж үзэж болно. Эдгээр иод дутлын үзүүлэлтүүд нь өөрөө бас учир дутагдалтай байж болдог, жишээ нь биохимийн үзүүлэлт нь ослын олон нөхцөл байдалд ашиглах боломжгүй болох, клиник үнэлгээний эрсдэлүүд нарийн тодорхойлж чадахгүй байх зэрэг. Ямар ч байсан иодын шээсний шинжилгээгээр иодын статусын талаар бүрэн дүүрэн мэдээлэл авах шаардлагатай байдаг бол 6-12 насны хүүхдүүдээс шээсний клиник шинжилгээ авах замаар хир хүнд хөнгөнийг тодорхойлж болдог.

	Эрүүл мэндийн байдал			
Үзүүлэлтүүд	Хүн ам	Бага зэрэг	Дунд	Хүнд
Нийт иодын дутагдлын хэмжээ /хүн амд эзлэх хувь/	Сургуулийн насны хүүхдүүд*	5-19.9	20-29.9	30.0 тэнцүү буюу түүнээс их
Шээсэн дэх иодын түвшиний дундаж /мг/л/	Ёургуулийн насны хүүхдүүд*	50-99	20-49	20-с бага

*6-12 насны хүүхдүүдэд илүү хамаарна

Хавсралт 7

Хоол тэжээлд тавигдах шаардлага

Гамшигйин эхний шатанд доорх хүснэгтийг зорилго төлөвлөлтөндөө ашиглаж болно.

Тэжээл	Хүн амын дундаж хэрэгцээ
Энерги	2100 ккал
Уураг	10-12% нийтэнерги /52-63гр гэхдээ 15%-аас бага/
Тос	Нийт энергийн 17% /40гр/
Витамин А	1.666 IU /буюу 0.5мгр ретинол эквивалент/
Тиамин /B1/	0.9мг /буюу 0.4 мгр 1000 ккал тутамд/
Рибофлавин /B2/	1.4мг /буюу 1000 ккал тутамд 0.6 мгр/
Фолийн хүчил	160мгр
Ниацин /B3/	12 мгр /буюу 1000 ккал тутамд 6.6 мгр/
Витамин B12	0.9мгр
Витамин С	28 мгр
Витамин Д	3.2-3.8 мгр кальциферол
Төмөр	22 мгр /бага биотой жнь 5-9%/
Иод	150мгр
Манган	201мгр
Цайр	12.3мгр
Силен	27.6мгр
Витамин E*	8мгр альфа ТЕ
Витамин K*	48.2 мгр
Биотин*	25.3мгр
Пантотенат*	4.6мгр

Лавлагаа: яаралтай тусламжийн үед дэх хоол тэжээлийн менежмент, ДЭМБ, 2000

Дээр дурьдсан хэрэгцээний жагсаалтыг ашиглахын өмнө хоёр зүйлийг анхаарах шаардлагатай. Нэгд хүн амын давхаргуудын нэг хүний дундаж хэрэгцээ бүх насныханд болон хүйсэнд хамаатай. Нас хүйсний байдлаар тусгайлан авч үзэх хэрэггүй бөгөөд тухайн хувь хүний тэжээлийн хэрэгцээ болгон ашиглах шаардлагагүй. Хоёрт эдгээр хэрэгцээ нь дор үзүүлсэн тодорхой хүн амын байдал дээр үндэслэн гаргасан.

Хүн амын бүлэг	Хүн амд эзлэх хувь
0-4 насны	12
5-9 насны	12
10-14 насны	11
15-19 насны	10
20-59 насны	49
60+ насны	7
Жирэмсэн:	2.5
Хөхөөр хооллолт	2.5
Эрэгтэй/эмэгтэй	51/49

Хүн амын бүтцийн ялгаатай байдал нь тухайн хүн амын хоол тэжээлийн хэрэгцээнд нөлөөлдөг. Жишээ нь хэрэв дүрвэгсдийн хүн амын 26% 5-аас доош насныхан 50% нь эрэгтэй 50% нь эмэгтэй бол хоол тэжээлийн хэрэгцээ 1.940 ккал-р буурна.

Энерги болон уурагны хэрэгцээг тодорхойлохдоо дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ.

- хүн амын демографын бүтэц ялангуяа тэдгээр 5-аас доош насныханы хувь болон эмэгтэйчүүдийн эзлэх хувь /ДОХын халдвартай хүн амд энэ нь өөр байж болно/
- насанд хүрэгсдийн дундаж жин, бодит, ерөнхий байвал зохих жингийн харьцаа. Насанд хүрсэн эрэгтэй хүний дундаж жин 60 кг-аас давж байвал, насанд хүрсэн эмэгтэйн дундаж жин 52 кг-аас хэтэрч байвал хэрэгцээ өснө.

- Нөхөн үржихүйн идэвхтэй шат. Хэрэв идэвхжилтийн түвшин их байвал хэрэгцээ нэмэгдэнэ /жишээ нь, эрэгтэй хүмүүст 1.55 х үндсэн бодисын солилцооны хурд/хэмжээ/ь эмэгтэй хүнд 1.56 х үндсэн бодисын солилцоо /
- Орчны дундаж температур, байр орон сууц, хувцасны хүрэлцээ. Орчны дундаж температур 20 градус Цельсээс бага болоход хэрэгцээ нэмэгддэг.
- Хүн амын хоол тэжээл, эрүүл мэндийн байдал. Хоол тэжээл дутагдалтай бол хэрэгцээ өсдөг. ДОХын халдвар тухайн хүн амын хэрэгцээнд нөлөөлдөг. /140-р хуудсанд байгаа Хоол тэжээлийг дэмжих ерөнхий стандарт 2-ийг үз/ Эдгээр хэрэгцээг хангахад ерөнхий харьцааг харгалзан үзэх эсэх нь өнөөгийн олон улсын зөвлөмжүүдээс хамаарна.

Хэрэв энэ төрлийн мэдээллийг анхан шатны үнэлгээнд ашиглах боломжгүй бол дээрх хүснэгтэнд дурьдсан тоог хамгийн доод утга гэж авч болно.

Хавсралт 8

Бараа бүтээгдхүүний хангамжийн менежмент

1. Худалдааны гэрээгээр нийлүүлэлтийн төлбөр тооцоо, гэмтэлтэй бараа бүтээгдхүүнийг солих, форс мэйжороос бусад гэрээний биелэлт зөрчигдсөн тохиолдолд торгууль хүлээх зэргийг зохицуулна.
2. Тээвэрлэгч болон бусад агентууд хүнсний бараа бүтээгдхүүнд анхаарал тавьж аливаа гэмтэл алдагдлыг нөхөн олгох ёстой.
3. Хадгалалтын байр сав нь аюулгүй цэвэр байх ба хүнсний зүйлс гэмтэх муудах алдагдахаас хамгаалагдсан байх ёстой.
4. Бараа бүтээгдхүүнийг алдагдахаас сэргийлж бүх түвшинд хэрэгжүүлбэл зохих алхамуудыг авсан байна.
5. Алдагдлыг тодорхойлж тооцоо данс хөтөлнө.
6. Гэмтэлтэй контейнерт байгаа бараа бүтээгдхүүнийг аль болох сэргээж авна.
7. Бараа бүтээгдхүүнийг тодорхой интервалаар шалгаж сэжигтэй барааг шинжилгээнд хамруулна. Тохиромжгүй бараа бүтээгдхүүнийг баримтжуулан холбогдох дүрэм заавар, журмын дагуу устгана. Тэдгээр барааг зах зээлд нийлүүлэхийг хориглоно.
8. Эд хөрөнгийн бүртгэл тооллогыг мэргэжлийн мэдэх хүнээр тодорхой хугацааны давтамжтайгаар хийж бүртгэл тооцоотой тулгаж байх
9. Эд хөрөнгийн нэгдсэн тайланг тодорхой давтамжтайгаар бэлтгэн хөрөнгө эзэмшигчид гаргаж өгч байх
10. Бараа бүтээгдхүүний эргэлтийг баримтжуулах
11. Данс бүртгэл тооцоо хөтөлж баланс тулгаж байх
12. Хангамжийн сүлжээний бүхий л түвшинд менежментийн аудитыг оролцуулаад аудит хийж байх
13. Хүнсний бараа бүтээгдхүүн тээвэрлэж байгаа тээврийн хэрэгсэл зориулалтын техникийн өндөр түвшинд байх, карго барааг ил гаргах зай завсаргүй байх ба энэ нь сав баглаа боодолд гэмтэл учруулж болзошгүй бөгөөд цаг агаарын элдэв нөлөөнөөс сайтар хамгаалагдсан байх шаардлагатай.

14. Тээврийн хэрэгсэл нь хүнсний бараа бүтээгдэхүүн тээвэрлэж байхдаа өөр бараа бүтээгдэхүүн болон буюу аюултай материалыг хамт тээвэрлэж болохгүй.
15. Тухайн тээврийн хэрэгсэлээр урьд нь аюултай бодис, бараа бүтээгдэхүүн тээвэрлэж байгаагүй байх, ямар нэг үлдэгдэл хаягдалгүй байх.

Эх сурвалж: Дэлхийн Хүнсний Хөтөлбөр, талбайн үйл ажиллагаа, 2002
Хүнсний нөөцийн менежмент гарын авлага

Хавсралт 9

Ном зүй

Эдгээр баримт бичгүүдийг хуулбарлах эрх Оксфордын Их Сургуулийн Дүрвэгсдийг Судлах Төвийн Дүрвэгсдийн Онлайн Хөтөлбөрийн ачаар олдсон бөгөөд тусгай сайтан дээр байрлуулсан болно.

Олон улсын эрхзүйн хэрэгсэл

Хангалттай хүнс хэрэглэх эрх (Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын гэрээ), CESCR Ерөнхий тайлбар 12, 1999 оны 5-р сарын 12. НҮБ-ийн Баримт E/C.12/1999/5, НҮБ-ын Эдийн засаг Нийгмийн Зөвлөл /1999/. <http://www.unhchr.ch>

Гамшигийн үед хангалттай хүнсээр хангагдах эрх, Л. Котула, М. Видар, FAO Эрхзүйн судалгаа77, НҮБ-ын Хүнс Хөдөө аж ахуйн Байгууллага, Ром <http://www.fao.org/righttofood>

Зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд хүнс хэрэглэх эрх, Ж. Пейжик /2001/: Эрхзүйн орчин, Улаан загалмайн олон улсын үнэлгээ, 83-р дэвтэр 844, 1097 хуудас, Женев, <http://www.icrc.org>

НҮБ /2002/, Хүний эрхийн тусгай сурвалжлагч Жан Зиглерийн сурвалжлага, Хүний эрхийн комиссийн 2001/25 тогтоолын дагуу бэлдсэн, НҮБ-ийн баримт бичиг, E/CN.4/2002/58 <http://www.righttofood.org>

НҮБ-ын Ерөнхий Ассемблей /2001/, Хүний эрхийн тусгай сурвалжлагч Жан Зиглерийн сурвалжлага. <http://www.righttofood.org>

Хүнснийн аюулгүй байдлын үнэлгээ

CARE /удахгүй гарах/, Өртөмтгий байдалд зориулсан заавар хөтөлбөр, CARE Зүүн/Төв Африкийн Бүс нутгийн Менежментийн хэлтэс, Найроби.

Хүнсний Аюулгүй Байдлын Үнэлгээний Зааварчлагаа, Ж. Фриз, Оксфам, Их Британи, Оксфорд

Тариаланчдад гамшигийг бууруулах үр хэрэгтэй юу? Үрийн тогтолцоог үнэлэх аргазүй, С. Лонгли, С. Домингүз болон ВЖ Леонардо /2002/ Гамшиг, 26 343-355
<http://www.blackwellpublishing.com/journal>

Хоол тэжээлийн байдлыг үнэлэх ба хянах нь, А. Моури 1999, ICRC Женев

Өрхийн эдийн засгийн арга: дадлагжигчдын гарын авлагав Хөгжлийн гарын авлага 6. хүүхдүүдийг аварцгаая, Ж. Сийман, П. Кларк, Т. Бойдро, Ж. Холт 2000, Лондон

Гамшигийн үнэлгээ арга хэмжээ, Үйл ажиллагааны зааварчлагаа Олон Улсын Хөгжлийн Америкийн Нэгдсэн Улсын Агентлаг 1998, Гадаад орны гамшигийн тусламжийн алба, АНУ-ын олон улсын агентлаг

<http://www.info.usaid.gov/ofda>

Хүнс Хоол Тэжээлийн Гарын Авлага, НҮБ-ын Дэлхийн Хүнсний Хөтөлбөр 2002, Ром
Хүнсний Аюулгүй Байдлын Мэдээллийн Систем

Өлсгөлөн Урьдчилан Анхааруулах Систем Сүлжээ FEWS NET:

<http://www.fews.net>

Хүнсний Аюул, Хамгаалалтгүй Байдлын талаарх мэдээлэл төлөвлөлтийн систем FIVIMS: <http://www.fivims.net/index.jsp>

Хүнс ХАА-н Урьдчилан Анхааруулах Глобал Систем (GIEWS), НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага. <http://www.fao.org>

Антропометрийн үнэлгээ

Насанд хүрэгсэд: Гамшигт Нэрвэгдсэн Хүн Амын Хоол Тэжээлийн Байдалд хийх Үнэлгээ, С. Коллинс, А.Дафильд, М. Мят /2000/, Женев

<http://www.unsystem.org/scn/archives/adults/index.htm>

Гамшгийн үед насанд хүрэгсдийн хооол тэжээлийн дутгадалд үнэлгээ хийх нь, SCN ажлын хэсгийн тайлан, НҮБ-ийн АСС хоол Тэжээлийн дэд Зөвлөл 2001, SCN ийн мэдээ 22, 49-51 –р хуудас, Женев

<http://www.unsystem.org/scn/archives/adolescents/index.htm>

Хоол тэжээлийн асуудал, Технологийн нийтлэл, Х. Янг, С. Жаспарс 1995, лондон

Хоол тэжээлийн байдал болон нас барагсдын тоог гаргах аргууд:

<http://www.smartindicators.org>

Хүнсний аюулгүй байдлын нөлөөлөл

Гамшигт нэрвэгсдэд Микро Санхүүжүүлэлт олгох нь, П.Алидр, Ж. Дорн, М. Согби, М. Хотарт, Д. Ларсон, Г. Нагарияан, С. Целиконас 2002, Олон Улсын Хөдөлмөрийн Алба болон НҮБ-ын Дүрвэгсэд хариуцсан алба, Женев, <http://www.ilo.org>

Үрийн үзэсгэлэн худалдаа, ваучер: CRS 2002, Африкийн ХАА-г үрэнд тулгуурлан сэргээх гарын авлага, Католикийн гамшгийн хор хөнөөлийг багасгах Үйлчилгээ, Гадаадын Хөгжлийн Институт болон Олон Улсын Үр Тарианы Судалгааны Институттай хамтарсан

Мөнгө ба ажил хөтөлбөр, Практик гарын авлага, С. Лүмсдэн, Е. Нэйлор, Оксфам, Их Британи, Оксфорд

Мал аж ахуйн нөлөө: Чухал зарчмууд, Гадаад Гамшгийн Туслалцааны Алба, АНУ, Вашингтон, Л. Пауерс 2002

<http://www.usaid.gov>

CRS ийн үрийн ваучер болон үзэсгэлэн худалдаагаар гар аргын үр тариалалтыг халах нь. Т. Ремингтон, Ж. Мароко, С. Вольш, П. Оманга, Е. Чарльз 2002, Гамшиг 26, 316-328

<http://www.blackwellpublishing.com/journal>

Гамшигийн үеийн хоол тэжээлийн ерөнхий гарын авлага

Гамшигийн үеийн хоол тэжээлийн дутагдлын үнэлгээ авах арга хэмжээ, С. Прудон 2002, Парис

Гамшигийн үеийн хүнс хоол тэжээлийн хэрэгцээ ДЭМБ, ДХХ, НҮБ-ын Хүүхдийн Сан, Дүрвэгсдийн Алба 2002, Женев

Хүнс хоол Тэжээлийн Гарын Авлага, Ром, ДХХ 2000

Гамшигийн үеийн хоол тэжээлийн менежмент ДЭМБ 2000, Женев <http://www.who.int>

Эрсдэлтэй бүлгүүд

ХДХВ/ДОХ-той амьдрах, ДОХ-той хүмүүсийг дэмжин асрах хоол тэжээлийн гарын авлага, FAO /ДЭМБ 2002, Ром. <http://www.fao.org>

Африкт гамшигийн нөхцөл байдалд байгаа өндөр настай хүмүүсийн хоол тэжээлийн хэрэгцээ, авч болох арга хэмжээний талаарх санаанууд, Help Age International 2001, Найроби. <http://www.helpage.org/publications>

ДОХ болон Тэжээл: Африкийн Сахарын Хоол тэжээлийн асаргаа сувилгааны зөвлөмжийн тойм, АНУ ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, Вашингтон, <http://www.aed.org>

Идэж уух бэрхшээлтэй хүүхдүүдийн практик менежмент, А. Винсток, 1994, Винслоу Хэвлэл, Бисестэр Их Британи.

Нярай ба бага насны хүүхдийн хооллолт

Гамшигийн үед нялх хүүхдийг хооллох нь, Практик, Бодлого, Стратеги, Ад Хок Групп 1999, <http://www.enonline.net>

Нялх хүүхдийн тэжээлийн стандарт, STAN 72-1981 /1983, 1985, 1987 онд өөрчлөлт оруулсан/ FAO/ДЭМБ, Кодекс Алиментариус 4-р боть: Тусгай хэрэглээний хүнс, 2 дахь хэвлэл, Ром <http://www.codexalimentarius.net>

Нялх хүүхдийг гамшгийн үед хооллох үйл ажиллагааны зааварчлагаа, Гамшгийн үед нялх бага насны хүүхдийг хооллох Агент дундын Ажлын Хэсэг, 2001, Лондон <http://www.enonline.net>

Нялх хүүхдийг гамшиг ослын үед хооллох нь: Ослын хөнөөлийг бууруулах Баг, Модул 1, 2001, ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн Сан, Linkages/ IBFAN/ENN /анхны хэвлэл/ <http://www.enonline.net>

Хөхний сүү орлуулалтын маркетингийн олон улсын код, ДЭМБ 1981 Бүрэн код болон холбогдох Дэлхийн Эрүүл Мэндийн Чуулганы тогтоолыг <http://www.ibfan.org/english/resource/who/fullcode.html> хаягаар орж авч болно.

Эмчилгээний хооллолт

Хоол тэжээлийн хүнд дутагдлын менежмент: Эмч эмнэлгийн ажилтны гарын авлага, ДЭМБ, 1999, Женев <http://www.who.int/nut>

Микро-элементийн дутагдал

Иод дутагдлын үнэлгээ, эмгэг, хяналт, тэмцэх арга зам, Хөтөлбөрийн Менежерүүдийн Лавлах, 2 дахь хэвлэл, ICCIDD/НҮБХС/ДЭМБ Женев, 2001 <http://www.who.int/nut>

Төмрийн дутагдлын эмгэг: Үнэлгээ, Урьдчилан сэргийлэх, Хяналт Хөтөлбөрийн Менежерүүдийн Лавлах, НҮБХС/UNU/ДЭМБ Женев, 2001 <http://www.who.int/nut>

Витамин А-гийн нэмэгдэл: Витамин А болон Xerophthalmia-гийн дутагдалаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн эмчилгээ, ДЭМБ 1997

Гамшиг ослын үед Pellagra-гаас урьдчилан сэргийлэх, хянах, ДЭМБ 2000, Женев, <http://www.who.int/nut>

Гамшиг ослын үед Scurvy-гаас урьдчилан сэргийлэх, хянах, ДЭМБ 1999, Женев, <http://www.who.int/nut>

Гамшиг ослын үед Thiamine-ийн дутагдалаас урьдчилан сэргийлэх, хянах, ДЭМБ 1999, Женев, <http://www.who.int/nut>

Хүнсний тусламж

Гамшиг ослын үед хүнс тараах: Хүнс тэжээлийн хэрэгцээнээс Улс төрийн эрх ашиг хүртэл. Сайн практик 3 дахь хэвлэл, С. Жаспарс Н. Янг 1995, Гамшигийг бууруулах сэргээн босгох сүлжээ, Гадаад Хөгжлийн Институт, Лондон

PL 480 Нэр 11 Бараа бүтээгдхүүнийн микро-элементүүдийн баяжуулалт, хангамж, OMNI 1994
Гамшиг Ослын Үеийн Хүнс, Хоол Тэжээлийн Хэрэгцээ, UNHCR, UNICEF, WFP, WHO, 2002, НҮБ-ын Дүрвэгсэд Хариуцсан Алба, НҮБ-ын Хүүхдийн Сан, Дэлхийн Хүнсний Хөтөлбөр, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Женев

Гамшиг ослын үеийн газар дээрх үйл ажиллагаа, Гарын Авлага, Ром, Дэлхийн Хүнсний Хөтөлбөр 2002

Хүнс Хоол Тэжээлийн Гарын Авлага, 2000, Дэлхийн Хүнсний Хөтөлбөр, Ром

Бүлэг 4:
Хоргодох байр,
суурьшилт ба хүнсний бус зүйлийн
минимум
стандартууд

Энэхүү бүлгийг хэрхэн хэрэглэх вэ?

Энэхүү бүлэг нь хамрах хүрээгээрээ 1. Хоргодох байр ба суурьшилт 2. хүнсний бус зүйлс: хувцас, ор хөнжил болон ахуйн хэрэглээний зүйлс гэж 2 хуваагдана.

Хоёр хэсэг нь хоёулаа гамшигт өртөн сүйрсэн байранд эргэн орж засварлан байрлах, хүлээн авч байгаа айлд хоноглуулах, сүйрээгүй үлдсэн барилга байгууламжинд үй олноор нь байрлуулах, мөн түр зуурын болон өөрсдийн босгосон оромжинд орогнуулахад гэх мэт хэд хэдэн чухал нөхцөл байдалд мөрдөх ерөнхий стандартыг хангадаг юм.

Хоёр хэсэг нь доорхи зүйлийг агуулна:

- **Минимум стандарт:** Хоргодох байр ба нүүлгэн шилжүүлэлт, хүнсний бус зүйлсээр хангах доод түвшинг тодорхойлдог дээд зэргийн чанартайгаар боловсруулагдсан стандартууд юм;
- **Үндсэн үзүүлэлтүүд:** стандартанд хүрсэн эсэхийг харуулдаг ‘сигналууд’ юм. Тэд хөтөлбөрүүдийн нөлөө үйлчлэл эсвэл үр дүн, түүнчлэн хэрэглэгдсэн процесс эсвэл аргуудыг хэмжих болон харилцах замыг гаргаж өгдөг. Энд чанарын эсвэл тоо хэмжээний индикаторууд байж болно;
- **Заавар тэмдэглэгээ:** эдгээр нь хоорондоо ялгаатай нөхцөл байдлуудад стандартууд ба индикаторуудыг хэрэглэх үед анхааран авч үзэх тусгай зүйлүүдийг, гарч буй практикийн хүндрэлүүдийн талаархи заавар удирдамж, ба эн тэргүүн асуудлуудын талаархи зөвлөгөөг агуулдаг. Үүнд стандартууд эсвэл индикаторуудтай холбоотой бэрх түвэгтэй шийдвэрлэх асуудлууд орсон байх бөгөөд яах ч аргагүй байдлууд, маргаан шүүмжлэлүүд эсвэл одоогийн мэдлэгийн дутагдлын талаар тайлбарлах боломжтой.

Энэхүү бүлэг нь хойноо стандартуудтай холбоотой ерөнхий ба тусгай техникийн асуудлуудын талаархи мэдээллийн эх сурвалжийг лавлах ном зүйн жагсаалтыг агуулсан.

Танилцуулга.....206


1. Хоргодох байр ба суурьшилт211

2. Хүнсний бус зүйлс: хувцас, ор хөнжил болон ахуйн хэрэглээний зүйлс.....230

Хавсралт 1: Хоргодох байр ба суурьшилт болон хүнсний бус зүйлс

Анхны ба үндсэн хэрэгцээг үнэлж тогтоох нь..... 238

Хавсралт № 2: Ном зүй 244



Appendix 1

Байр, суурьшилт, хүнсний бүс зүйлийн үндсэн хэрэгцээг тогтоох нь

Appendix 2 References

Олон улсын хууль ёсны хэрэгслэлүүдийн харилцаа

Хоргодох байр, суурьшилт ба хүнсний бус зүйлүүдийн минимум стандартууд нь хүмүүнлэгийн тунхаг бичгийн зарчмууд ба эрх зүй нь биелэлээ олсны практикийн илрэл юм.

Хүмүүнлэгийн тунхаг бичгийн хамгийн үндсэн шаардлагууд бол аюул гамшигт нэрвэгдсэн, олон улсын хүний эрх, хүмүүнлэгийн ба дүрвэгчдийн тухай хууль гэх мэт хуулийн зөрчилтэй этгээдийн амьдрал залгуулах болон тэднийг хамгаалан ивээлдээ авах явдал юм. Хүний эрхийн хуульд мөнхөрсөн нэг заалт болох орон гэртэй байх эрхийн цар хүрээнд хүмүүнлэгийн тусламжийн **хоргодох байр**, суурьшилт нь гэр бүлийн байдалтай болдог.

Хүн бүр амьдрах шаардлага хангахуйц орон байртай байх эрхтэй. Энэхүү эрх нь олон улсын хууль ёсны хэрэгслүүдээр илэрч байдаг бөгөөд тайван, найдвартай аюулгүй байдалд мөн аюулгүйгээр өөрийн эзэмшилдээ амьдрах эрхийг агуулна. Амьдрах эрхийн гол хүчин зүйл нь үйлчилгээтэй, техник тоног төхөөрөмжийн боломжтой, материалын болон дэд бүтэцтэй, санхүүгийн боломжтой, хүн сууж болмоор, хялбар дөхөм байршилтай мөн соёлын зохистой байдлаар хангагдсан орон байртай байх явдал юм. Амьдрах эрх нь байгалийн болон элбэг эх үүсвэртэй бараа таваар болон үйлчилгээнүүд, аюулгүй ундны ус, хоол хийх болон халаах, гэрэлтүүлэх цахилгаан энергитэй, цэвэр ба бохирын сүлжээтэй, угаалга, хүнс хадгалах боломжтой, хоггүй цэвэр, усны нийтийн холболттой мөн яаралтай тусламжийн үйлчилгээтэй болох гэхчилэн өргөжин тэлж байна. Хүмүүс шаардлага хангахуйц орон зайтай мөн хүйтэн, чийг, халуун, бороо салхи болон бусад эрүүл мэндийн аюул заналхийлэл, барилгын аюул осол болон өвчин зөөгчөөс хамгаалагдсан байх ёстой. Суурьшилтын болон барилгажуулалтын талбайг төлөвлөхдөө эрүүл ахуйн үйлчилгээ, сургууль, хүүхэд асрах төв ба бусад нийгмийн болон амь зуулгын боломжуудаар хангасан байх ёстой. Энэ маягийн орон байржилт нь зохион бүтээж, барилгын материалыг ашиглах ба эдгээрийг хангах бодлого нь соёлын бодит байдал ба барилгажилтын төрөлжүүлэлтийн дүр төрхийг зохистой болгох ёстой юм.

Орон байржилтийн эрх нь хүмүүнлэгийн бусад хуулиудтай нягт холбоотой бөгөөд хүчээр хөөж гаргахын, тайван амгалан байлгахгүй байхын болон биеийн аюулгүй байдалын болон бусад заналхийлэхийн эсрэг сэргийлсэн мөн сайхан амьдрах, хүн бүр өөрийн орон байрнаас болон идээшсэн өргөөнөөс захиргаадалтаар нүүхийн эсрэг, иргэний байгууламжийг зэвсэглэсэн хүчээр халдахыг хориглох эрхээр ялгаваргүйгээр хамгаалагдана .

Энэхүү бүлгийн минимум стандарт нь орон байртай байх эрхийн бүрэн илрэл биш юм. Хэдийгээр Сфер стандарт нь орон байртай байх эрхийн гол агуулгыг үзүүлэх боловч мөн энэ хуулийн либерал биелэлд ерөнхийд нь нэмэр хандив болдог байна.

Гамшгийн үеийн хоргодох байр, суурьшилт болон хүнсний бус зүйлсийн чухал ач холбогдол

Гамшгийн үеийн эхний шатанд хоргодох байр амьд үлдэгсдэд чухал шийдвэрлэх зүйл болно. Нөгөөтэйгүүр хоргодох байр нь амьд үлдэгсдэд амьд үлдсэнээс илүү биеийн аюулгүй байдал, цаг уурын нөлөөлөл болон өвчин эмгэгээс тэсвэрлэн давах хамгаалал ба баталгаа болдог байна. Мөн гэр бүл болон тосгон суурингийнханд хүнд нөхцөл байдлаас аль болох хол газарт гарган хүмүүнлэгийн тусламж үзүүлэх нь чухал юм. Хоргодох байр, суурьшилт ба хүнсний бус зүйлсийн холбогдолтойгоор үүсч буй процессийн үед олон нийтийн стратегийг дэмжиж мөн боломжоороо өөрсдийгөө хангах, өөрсдийнх нь менежментийг боломжоор нь дэмжих ёстой. Ийм төрлийн хариу үйлдэл нь нэрвэгдсэн олон түмнийг амь зуулгаар нь таслахгүй мөн шинээр тэтгэн хангаж байх үйл ажиллагааны боломжуудыг өсгөж байх үед урт хугацааны байгальд сөрөг нөлөөллийн үйлчлэлийг багасгах ёстой юм. Хариу үйлдлийн хамгийн онцгой түвшиний шаардах хоргодох байр ба эрүүл ахуй, хувийн амьдрал болон нэр хүндийн хувьд тусламж тэтгэмж нь хувцас, хөнжил болон орны хэрэгслэлийн хангамж болно. Хүмүүс мөн хувийн эрүүл ахуйнхаа хэрэгцээгээ хангах, хоол хүнсээ бэлдэх болон идэх, мөн шаардлагатай дулааны түвшингөөр хангагдахын тулд үндсэн бараагаар хангагдахыг шаарддаг. Сүйрэлд нэрвэгдсэн гэр ахуйн бараа болон өөрсдийн орон гэрээсээ зөөн авч гарсан зүйлс мөн таарч тохирох хүнсний бус зүйлсээр гол хэрэгцээгээ хангахад шаардагдана. Хариу үйлдлийн төрөл нь сүйрэлд нэрвэгдсэн гэр бүл болон хүмүүсийн хэрэгцээг хангахад орших бөгөөд энэхүү байгалийн гамшигийн болон сүйрлийн гол хүчин зүйлс нь орон байргүйжилтийн, цаг агаарын нөхцөлийн болон тухайн орон нутгийн байгаль орчин, улс төр болон хамгаалалтын асуудлууд, хот хөдөөгийн үүссэн нөхцөл байдал мөн эмхэлж цэгцлэх хамтын чадварын нийлбэрийн хэмжээгээр тодорхойлогдоно. Зочин айлууд шиг байдлаар гамшигт далдууг өртөж буй хүмүүсийн эрх болон хэрэгцээнд анхаарал хандуулах ёстой. Сүйрлийн анхны хор уршигт нэрвэгдсэн гэр бүлийнхэний өөрсдөд буй материалаар өөрсдийн хувийн ур чадвараар түр хоргодох байр барих болон урт хугацааны шинэ барилгыг эхлүүлэх ажлын тухай алхам бүрээр мэдэгдэж байх ёстой. Нэрвэгдсэн гэр бүлийнхэнд маш богино хугацаанд яаралтай байдлаас нь хамааран хоргодох орон байр шийдэн мөн энэ хүрээнд нэмэлт шаардлагатай нөөцийг сайжруулах ёстой. Энэ хоргодох байр, нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөрт эмэгтэйчүүдийг хамааруулсанаар тэдэнд болон гамшигт нэрвэгдсэн хүмүүст хоргодох байр, хувцаслалт, барилгын материал, хүнсний зүйлсийн тоног төхөөрөмж болон бусад гол чухал хангамжаар ижил тэгш найдвартай хангагдахад тусална. Эмэгтэйчүүд хамгаалалт ба хувийн амьдралын хүрээнд, хэр хэмжээний хоол хийх болон халаах зориулалтын түлшний нөөц уурхай байгаа, мөн хэрхэн тэгш эрхтэйгээр хоргодох байр болон хангалт авах тухайд зөвлөлгөө авах ёстой. Ялангуяа жендерийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийллээс хамгаалах мөн хариу үйлдэл хийхэд анхаарах шаардлагатай. Энэхүү хөтөлбөрийг зохиох болон гүйцэтгэхэд эмэгтэйчүүдийг аль болох оролцуулах нь чухал юм.

Энэ бүлэг дэх наад захын стандартууд нь орон байраар хангагдах эрхийн шууд илэрхийлэл юм. Гэхдээ цар хүрээний стандартууд нь орон байраар хангагдах эрхийн үндсэн агуулгыг илэрхийлдэг бөгөөд энэхүү эрхийг дэлхийн хэмжээнд нааштай хэрэгжүүлэхэд тус дөхөм болдог.

Гамшгийн үеийн оромж байр, суурьшилт, хүнсний бус зүйлийн ач холбогдол

Оромж нь гамшгийн эхний үе шатуудад амь гарах асуудлыг тодорхойлох чухал хүчин зүйл юм. Амь гарсны дараа оромж нь аюулгүй байдал, хувь хүний аюулгүй байдлыг хангах, уур амьсгалаас хамгаалах, эрүүл мэнд доройтол, өвчлөлийг эсэргүүцэх арга хэмжээг нэмэгдүүлэхэд шаардлагатай юм. Хүнд нөхцөлд боломжтой бол энэ нь хүний нэр төр, гэр бүл, хүн амын амьдралыг тогтвортой байлгахад чухал юм.

Оромж, суурьшил, хүнсний бус зүйлээр туслах арга хэмжээ нь үйл ажиллагаанд аль болох их өөрийн үр ашиг, өөрийн менежментийг оруулж хүн амын бусад хэсгээс хуулбарлах стратегийг дэмжих хэрэгтэй. Ийм аливаа арга хэмжээ нь гамшигт нэрвэгдсэн хүн амын амжиргаа дэмжих үйл ажиллагааг хадгалах буюу бий болгох боломжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ байгаль орчинд үзүүлэх урт хугацааны сөрөг нөлөөлг бууруулах хэрэгтэй.

Оромжийн хэрэгцээ, эрүүл мэнд, хувийн нууц, нэр төрийг хадгалах арга хэмжээний хамгийн бие даасан арга бол хувцас, хөншил, орны хэрэглэлээр хангах явдал юм. Мөн хүмүүст өөрсдийн эрүүл ахуйн хэрэгцээг хангах, хүнс бэлтгэж хэрэглэх, шаардлагатай дулаан, ая тухтай байдлыг хангах наад захын хэрэгцээний бараа, хангамж шаардлагатай байдаг. Гамшигт нэрвэгдсэн айл өрх, гэр орноосоо шилжүүлэгдсэн айл өрх ер нь өөрсдийн авах буюу зөөж чадах зүйлийг л авдаг бөгөөд зайлшгүй хэрэгцээг хангахад холбогдох хүнсний бус зүйлээр хангах шаардлагатай болж болно.

Гамшигт нэрвэгдсэн хүмүүс, айл өрхийн хэрэгцээг хангахад шаардагдах арга хэмжээний төрлийг гамшгийн мөн чанар, хэмжээ, оромжийн холбогдох гарз, уур амьсгалын нөхцөл байдал, орон нутгийн цаг агаар, улс төр, аюулгүй байдлын төлөв байдал, орчин /орон нутаг буюу хот суурингийн/, хүн амын хариу арга хэмжээ авах чадвар зэрэг үндсэн хүчин зүйлүүдээр тодорхойлогддог. Мөн аливаа хүлээн авагч хүн ам зэрэг гамшигт хоёрдогч байдлаар нэрвэгдсэн хүмүүсийн эрх, хэрэгцээг харгалзан үзэх ёстой.

Аливаа хариу арга хэмжээг гамшиг гарсны дараа гамшигт нэрвэгдсэн хүмүүс түр зуурын оромжоор хангах буюу шинэ, урт хугацааны орон байр барих өөрсдийн чадвар, материалын нөөцийг ашиглан авсан арга хэмжээгээр мэдээлэх хэрэгтэй. Оромжоор хангах арга хэмжээ нь гамшигт нэрвэгдсэн айл өрхөд

шаардлагатай нэмэлт хөрөнгө нөөцийг олж авахад тохиолдох бэрхшээлийн тухайд богино хугацаанд онцгой байдлаас тогтвортой оромжийн шийдэлд аажмаар шилжих боломж олгоно.

Оромж, суурьшилтын хөтөлбөрт эмэгтэйчүүдийг хамруулах нь тэд ба гамшигт нэрвэгдсэн хүм амын бүх гишүүд оромж, хувцас, барилгын материал, хүнс үйлдвэрлэх тоног төхөөрөмж, бусад шаардлагатай хангамжийг шударга, найдвартай байдлаар авах нөхцлийг бүрдүүлэхэд туслана. Аюулгүй байдал, хувийн нууц, хоол бэлтгэх, халаах түлшийг цуглуулах эх сурвалж, арга хэрэгсэл зэрэг асуудал, орон байр, хангамжийн шударга боломжтой байх нөхцлийг бүрдүүлэх талаар эмэгтэйчүүдтэй зөвлөлдөх хэрэгтэй. Хүйсийн хүчирхийлэл, бэлгийн боолчлолоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад тодорхой анхаарал хандуулах хэрэгтэй. Иймээс боломжтой үед нь оромж, суурьшилтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь чухал юм.

Бусад бүлгүүдтэй холбогдох нь

Бусад салбарын бүлгүүд дэх олон стандарт энэ бүлэгтэй холбоотой юм. Нэг салбарт стандартыг хангахад гарч буй дэвшил нь ер нь нөгөө салбаруудад гарч буй дэвшилд нөлөөлж заримдаа бүр тодорхойлдог. Хариу арга хэмжээг үр дүнтэй болгохын тулд бусад салбаруудтай нягт зохицуулалт хийж хамтран ажиллах шаардлагатай. Хэрэгцээг хангах, гаргаж буй хүчин чармайлтыг давхардуулахгүй байх, оромж, суурьшил, хүнсний бус зүйлээр туслах арга хэмжээний чанарыг сайжруулах нөхцлийг бүрдүүлэхийн тулд орон нутгийн төрийн байгууллага, бусад арга хэмжээ авч буй агентлагуудтай зохицуулалт хийх шаардлагатай.

Жишээлбэл, гамшигт нэрвэгдсэн айл өрхийн эрүүл мэнд, нэр төрийг хангахын тулд оромжоор хангах тусламж үзүүлж буй бүс нутагт хангалттай ус, ариун цэврийн байгууламжаар нэмж хангах шаардлагатай. Мөн хүнсний тусламжийг ашиглаж тэжээлийн хэрэгцээг хангах нөхцлийг бүрдүүлэхэд хэрэгцээтэй хоол бэлтгэх, хэрэглэх хэрэгсэл шаардлагатай байхын зэрэгцээ хангалттай оромжоор хангах нь шилжүүлэгдсэн айл өрхийн эрүүл мэнд, сайн сайханд тус дөхөм үзүүлдэг.

Холбогдох газар нь бусад мэргэжлийн бүлгүүд дэх тодорхой стандарт буюу удирдамжийн тэмдэглэлийг тусгасан болно.

Бүх бүлгүүд, нийтлэг стандартуудтай холбогдох нь

Арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх үйл явц нь түүний үр дүнд чухал юм. Энэхүү бүлгийг оролцоо, анхны судалгаа, хариу арга хэмжээ, сонголт, хяналт, үнэлгээ, тусламжийн ажилтнуудын ур чадвар, үүрэг хариуцлага, боловсон хүчний удирдлага, менежмент, дэмжлэг /1-р бүлгийг үзнэ үү. 21-р хуудас/-ийг хамарч буй бүх салбарт түгээмэл стандартуудтай холбож хэрэглэх хэрэгтэй. Ялангуяа, аливаа хариу арга хэмжээнд дор дурьдсан эмзэг бүлгүүдийг оролцуулан гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн оролцоог түүний тохиромжтой байдал, чанарыг хангахын тулд нэмэгдүүлэх хэрэгтэй.

Гамшигт нэрвэгдсэн хүн амын эмзэг байдал ба чадавхи

Гамшгийн үед хамгийн их эрсдэлд ордог бүлгүүд бол эмэгтэйчүүд, хүүхдүүд, настайчууд, тахир дутуу хүмүүс, ДХВ/ДХОХШ-тэй хүмүүс байдаг. Тодорхой нөхцөлд хүмүүс мөн үндэстэн ястны гарал үүсэл, шашин ба улс төрийн харьяалал, шилжилт зэрэг шалтгаанаар эмзэг байдалд ордог. Энэ нь үүгээр хязгаарлагдахгүй боловч хамгийн их тодорхойлогддог хүмүүсийг хамаардаг. Тодорхой эмзэг байдал нь гамшгийг даван туулах, амьд гарах хүмүүсийн чадварт нөлөөлдөг бөгөөд хамгийн их эрсдэлд орсон хүмүүсийг нөхцөл байдал бүрт нь тодорхойлох хэрэгтэй.

Энэхүү гарын авлагад “эмзэг бүлэг” хэмээх нэр томъёо нь энэ бүх бүлгийг хэлдэг. Аль нэг бүлэг нь эрсдэлд орсон үед бусад нь мөн аюул заналд орох хандлагатай байдаг. Тиймээс эмзэг бүлгүүдийг дурьдсан газар бүр үүнийг хэрэглэгч нь энд жагсааж харуулсан бүх бүлгийг авч үзэх хичээнгүйлэн хүсч байна. Бүх гамшигт нэрвэгдсэн бүлгүүдийг ялгаварлан гардуурхалгүй тэдний тодорхой хэрэгцээний дагуу хамгаалах, халамж үзүүлэхэд онцгой анхаарах шаардлагатай. Гэхдээ гамшигт нэрвэгдсэн хүн ам гамшгийг даван туулах ур чадвар, чадавхтай байх, эзэмших, тэдгээрийг хүлээн зөвшөөрч дэмжих хэрэгтэй гэдгийг санах хэрэгтэй.

1 Хоргодох байр болон суурьшил

Хоргодох байрны туслалцаа нь сууц, барилгын засвар хийлгэж буй өрхүүд болон нүүн шилжиж

буй өрхүүдийн түр суурьшихад байрны туслалцаагаар хангадаг. Нүүлгэн шилжүүлэлт боломжгүй үед бүх хүмүүсийн нэг дор байрлуулна. Жишээ нь, агуулах, заал, хуаран гэх мэт нийтийн барилга байгууламжид буюу түр зуурын хүрээ буудалд байлгана. Мөн орогнох байр нь богино буву урт хугацааных байж болно. Энэ нь тухайн тусламжийн түвшин, газрын зөвшөөрөл, газар эзэмших эрх, дэд бүтэц, үндсэн үйлчилгээ авах боломж, байр ороц сууц нэмж барих, тэлэх боломжуудаас ихээхэн хамаарна.

Сууц болон хуарангийн стандарт 1: Стратеги төлөвлөлт

Баригдсан хоргодох түр байр буюу суурьшилт нь гамшигт өртсөн өрхүүдийн аюулгүй байдал, хамгаалал, эрүүл мэнд, амьжиргааны баталгаа г.м. алинд нь чухал ач холбогдол өгч байгаагаар шийдвэрлэнэ.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Өртсөн өрхүүд өөрсдийн уугуул орон сууц нь амьдрах боломжтой болмогц эргэн явах (заавар тэмдэглэл 1-г харах)
- Өөрийн уугуул орон сууцруу эргэн явах боломжгүй өрхүүдийг боломжтой бол тэнд нь тусад нь суурьшуулах (заавар тэмдэглэл 2-г харах)
- Өөрийн уугуул орон сууцруу эргэн явах боломжгүй мөн нүүж ирсэн газраа суурьшиж чадахгүй байгаа өрхүүдийг түр төлөвлөгдсөн буюу өөрөө үүссэн тосгонд байршуулах (заавар тэмдэглэл 3-г харах)

- Өртсөн өрхүүдийн аюулгүй байдалд учрах бодит болон боломжит аюул заналаас сэргийлж гадны нөлөөнөөс хол орших түр сууц болон хуаранд хуваарилах (заавар тэмдэглэл 4-г харах)

- Хөрсний нуралт, газар хөдлөлт, галт уулын идэвхижилт, үер хүчтэй салхи зэрэг байгалийн гамшгаас үүдэх эрсдлийг бууруулах, өвчин халдахааргүй газар (заавар тэмдэглэл 4-5-г харах)
- Оршин байгаа газар нь тоног төхөөрөмж болон материалд учрах аюул, учирсан аюул, хагарч эвдэрсэн газрын аюулгүй байдлыг хангаж хамгаалалтад авах.(заавар тэмдэглэл 4.6.7-г харах)
- Газар болон өмч эзэмших эрх, барилгын эрх, байгуулагдах газрын байршил тогтоох, эзэмшихээс өмнө заавал зөвшөөрлийн дагуу хийгдсэн байх ёстой. (заавар тэмдэглэл 8-г харах)
- Ус, ариун цэврийн үйлчилгээ болон эрүүл мэнд, сургууль, мөргөлийн газар зэрэг нийгмийн нөхцлүүдийг бүрдүүлэх боломжтой бол шаардлага хангасан нөхцлийг бүрдүүлэх (заавар тэмдэглэл 9-г хар)
- Замын дэд бүтэц нь хувийн нүүдэл суудал, хүнсээр хангах зэрэг үйлчилгээг үзүүлэх (заавар тэмдэглэл 10-г хар)
- Хэрэв боломжтой бол өрхүүд газар авах, өөрийн амьжиргааг дээшлүүлэхийн тулд зах зээлийн үйлчилгээгээр хангагдах (заавар тэмдэглэл 11-г хар)

Заавар тэмдэглэл

1. **Эргэн очих:** Өөрсдийн уугуул орон гэртээ харих боломж ба орон сууц бол ихэнхи гамшигт өртөгсдийн хүсэл эрмэлзэл юм. Гамшигт нэрвэгдсэн ихэнхи өрхүүдийн хувьд гэмтэж нурсан байшин ба түүний эргэн тойронх газар нь гол хөрөнгө нь байдаг. Гэвч буцаж нутагтаа очих боломжгүй тохиолдол ч бас бий. Үүнд аюулгүй байдал нөлөөлнө, жишээ нь хөрөнгө ба газар нь эзлэгдсэн, хүчилхийлэл мөргөлдөөн үргэлжилсээр байгаа, ястан буюу шашны элдэв дарангуйллын айдас, ашигт малтмалын олборлолтын тэсэлгээ хийж байгаа явдлууд болно. Орон байрнуудыг засварласнаар тухайн нийгэмд нэмэр болохоос гадна байгуулсан суурьшилтын схемьг хадгалж үлдэх, оршин байгаа дэд бүтцийг ашиглах боломжтой болдог.

2. **Хүлээн авч буй нийгэм:** гамшигт өртсөн хүмүүсийн ихэнхи нь хүлээн авч буй нийгмийн гишүүн болж, түүх соёлд нь нэвтэрч шашинд нь холбогдохыг илүүд үздэг. Энэ тохиолдолд ямар нэг нийгмийн дарамт зөрчил, болзошгүй аюул үүсэх зэрэг байдалтай зөрчилдөхгүй бол хүлээн авч буй нийгэмд орох нь боломжтой. Сууцны туслалцаагаар дэмжихийн тулд нь оршин байгаа айл өрхүүдийн сууцны багтаамжыг өргөжүүлэх болон тусгай нэмэлт өрөө гаргаж байрлахад илүү дээр болгох зорилгоор оршин суугчдад хандах. Хүн амын нягтрал, нийгмийн хэрэгцээ шаардлага, дэд бүтцийн хангамжийн үр дүнд бий болж байгаа өсөлтийг үнэлж дүгнэх хэрэгтэй. Оршин суугаа айл өрхийн сууцыг нэмж сунган барьж сууцаар хангах нь нийтийг дэмжих бодлогын хувьд дэмжигдэж байгаа.
3. **Хамтын суурин:** түр төлөвлөгдсөн лагерь гэхэд буруу хариулт болохгүй. Энэ хоргодох байрны шийдэл нь тусгаарлагдмал аюулын эрсдэлтэй, зайлшгүй үйлчилгээ болох хүнс ус хязгаарлагдмал газар оногдож болох талтай. Хангалттай материалын нөөц байхгүй хоргодох байр болгонд дулаан шаардагдах хэмжээнд хүрэхгүй бол том хэмжээний барилга сууцанд хүйтэн цаг уурын нөхцөлөөс түргэн хугацаанд түр хамгаалж болно. Сургуулийн барилга нь хэдийгээр гамшигт өртсөн хүмүүсийг орогнуулахад ашиглагддаг ч гамшигт өртсөн гэр бүлийн хүүхдүүдийг үргэлжлүүлэн суралцуулахад ашиглахыг чармайх хэрэгтэй. Мөн түүнчлэн тэдгээр сууринг гэнэтийн довтолгооны бай болхоос хамгаалж баталгаа өгөх хэрэгтэй.
4. **Эрсдэл ба эмзэг байдлын үнэлгээ:** Олон талт эрсдэл болон эмзэг байдлын үнэлгээ нь маш чухал асуудал бөгөөд үүнд гамшигт өртсөн хүмүүсийн доторхи нийгмийн бүлгийн ялгаа , бодит ба болзошгүй аюулыг багтаасан (29-р хуудасхны анхны үнэлгээний стандартаас хар).

5. **Байгалийн гамшиг:** Газар хөдлөлт, галт уулын идэвхижил, хөрсний нуралт, үер, шуурга зэрэг байгалийн эрсдлүүдэд өртсөн тухайн газрууд үнэлэгдэх шаардлагатай. Барилгатай ойролцоох газрууд газар хөдлөлтийн дараа газрын хөрс сул болж гулсан газрын тогтоцод өөрчлөлт орж болзошгүй, мөн галт уулын хайлмагт өртөх нам дор, уруу газар байгаа, үерт өртөж болзошгүй голын сав газар, шуурганд өртөж болзошгүй газар зэргийг анхаарах хэрэгтэй. Эдгээр эрсдлийг багасгах.
6. **Найдваргүй бараа материал:** газар хөдлөлт салхи шуурга үер усанд тэсвэргүй муу материал сонгосноос үүдэж болох аюул бий. Уурхайн тэслээгүй тэсрэх бодис нь мөн өмнө дурьдсан шиг аюул учруулах уршигтай. Энэ мэтчилэн учирч болохуйц эрсдлээс туршлагажиж бараа материалыг зөв сонгож шаардлагатай арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй.
7. **Бүтцийн үнэлэмж дүгнэлт:** Оршин суух бүс нутагт нь шаардлагатай боловсон хүчнийг томилон барилгын бүтцийн тогтворжлыг шалгуулах. Байгалийн гамшгийн дараах барилгын чанарт өөрчлөлт орсон эсэхийг хянан дүгнүүлэх хэрэгтэй. Нийт хоргодох байрнуудын хувьд өмнө баригдсан барилгын бүтэц, нэмэлт ачаалал даах чадавхи, дотоод тусгаарлагч хана, дээвэр зэргийг шалгах.
8. **Газар, барилга эзэмшил болон хэрэглээ:** энэ олголт нь нэлээд маргаантай. Тухайн газар барилгын эзэмшигчээс түр эзэмших эрх зөвшөөрлийг хэр боломжтой эсэхийг тодруулах. Эмзэг бүлгийнхний өмч эзэмших эрхийг хангаж өгөх хэрэгтэй. Энэ нь энгийн ойлгомжтой эзэмшлийн эрхүүдийг багтаасан тухайлбал гамшгийн улмаас үхсэн, газаргүй болсон гэх шалтгаанаар эзэмших.
9. **Үйлчилгээ нөхцлүүдийн боломж бололцоо:** баригдсан, дахин засварласан үйлчилгээ, нөхцөл зэргийг дэлгэрэнгүй тодорхойлж, шинэ нөхцөлөөр баригдах барилгын ажил эхлэхийн өмнө хангалттай хүчин чадалтай байх ёстой. (51-р хуудсан дахь “Усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн дэмжлэг” сэдвийг унш).

10. Сууц барих газар орчин: орон нутгийн замын дэд бүтцийн хөгжлийн шаардлагатай нөхцөл байдлын дагуу сууцыг нисэх зурвас, төмөр замын буудал, боомтуудтай ойр байгуулах нь элдэв аюул эрсдлээс үүдэх туслалцаа дэмжлэгээр хангагдахад дөхөм гэдгийг анхааралдаа авах нь зүйтэй. Хоргодох байр, түр төлөвлөгдсөн юм уу өөрөө үүссэн лагерь, зоорь, хүнс түгээх цэгүүд цаг агаарын бүх нөхцөлд тохиромжтой замаар ирэх хүнд ачааны машинаас хангамж авах болоцоотой байх. Бусад хэрэгцээг хөнгөн тэргээр зөөх нөхцөл болоцоог бүрдүүлэх ёстой.

11. Амьжиргааг дэмжих: гамшигт өртсөн хүмүүсийн аюулын өмнөх эдийн засгийн байдлын талаархи ойлголт, гамшгийн дараах байдал зэргийг лавлах шаардлагатай. Энэ нь газар, газар тариалан, бэлчээр зэргийг багтаана. Зах зээл эрхэлэх газар олгох, орон нутгийн үйлчилгээнд эдийн засгийн зайлшгүй үйл ажиллагааг нэвтрүүлэх. Нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу ялангуяа эмзэг бүлгийн болон газаргүй болсон иргэдэд эдгээрийг нэн түрүүнд хүргэх хэрэгтэй.(Хүнсний аюулгүй байдлын стандарт.119-г хар)

Орогнох байр ба суурьшилтын стандарт 2: Бодит төлөвлөлт

Орон нутгийн бодит төлөвлөлт нь аврах боломж орогнох байрны хэрэглээ ба зайлшгүй үйлчилгээ, мөн өрх бүрийг тусгаарлах, амьдрах нөхцлийг хангахад оршино.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй холбогдуулан унших)

- Газрын багц төлөвлөгөө нь айл өрхүүд, зэргэлдээх хөршүүд болон тосгоныхныг оршин буй нийгмийн сүлжээнд оруулах ба гамшигт өртсөн хүн амын аюулгүй байдал ба зохион байгуулалтын чадварыг дэмжихээр төлөвлөгдөнө. (заавар тэмдэглэл 1-г харах)
- Гамшигт өртсөн хүн бүр ус, ариун цэврийн аюулгүй нөхцөл, эрүүл мэнд, хатуу хог хаягдлаас ангижрах, оршуулгын газар, сургууль, мөргөлийн газар, уулзалтын газар, нөхөн сэргээх газруудад аюулгүй хүрч очих нөхцөлөөр хангагдсан байх.

- Түр хугацаанд байрлах буюу угсран барьдаг хотхонуудыг доод тал нь нэг хүнд 45 метр кв байхаар тооцоологдоно
- Гадаргуу нь байр зүйн байрлалын хувьд ус зайлуулах систем мөн ариун цэврийн гол систем болох жорлон байгуулахад тохиромжтой байх хэрэгтэй. /заавар тэмдэглэл 6-г харах/
- Сууц тус бүрт орох аюулгүй найдвартай замуудтай байх хэрэгтэй. /заавар тэмдэглэл 7-г харах/
- Ихэнх байр сууцнууд шардлагатай нүүлгэн шилжүүлэлт хийхэд тохиромжтой хаалга үүдтэй байх хэрэгтэй ба ингэснээрээ оршин суугчдын ясар нэгэн аюулгүйгээр оруулж гаргах боломжтой байх хэрэгтэй.
- Халдвар авах эрсдэлийг багасгах

Заавар тэмдэглэл

1. **Нэг дор барихаар төлөвлөх:** Янз бүрийн байр сууцнуудын хувьд түр хугацаанд байрлах хотхонууд дахь том хэмжээний байр сууцнуудын доторх орон зайн хуваарилалтыг тухайн газар оронд мөрдөгдөж буй арга хэлбэрийн дагуу зохион байгуулж, нийтийн ундны ус ариун цэврийн систем, хоол хүнсээр хангах зэрэг асуудлуудыг сайтар мөрдөх хэрэгтэй. Тухайн байр сууц тус бүрийн гарах хаалгыг шууд задгай талбай руу харуулсан байхаар бодолцож зохион байгуулах хэрэгтэй. Эмзэг бүлгийнхэн болон ганц бие насанд хүрэгчид болон хүүхдүүдийг нэгдсэн буюу төвлөрсөн байр сууцаар хангах. Тархан байрласан байр сууцнуудын хувьд буюу тодорхой нэг газарзүйн бүс нутаг руу буцах гэж буй юм уу айл өрхүүдийг хооронд нь ойролцоо байрлуулан нэг дор байрлуулах зарчмыг мөн мөрдөх хэрэгтэй.
2. **Шаардлагатай үйлчилгээ болон орчинд хамрагдах:** Ундны ус, жорлон, эрүүл мэнд нийгмийн үйлчилгээ зэрэг чухал асуудлуудыг тухайн байр сууцанд байгаа юм уу сэргээн засварласан тоног төхөөрөмж байр байгууламжуудын хэрэглээг ихэсгэх журмаар шийдэх ба хөрш болон тухайн газар нутгийн үдсэн оршин суугчдад сөрөг нөлөө үзүүлэлгүйгээр шийдвэрлэнэ.

Тухайн хотхонд байгаа нийт оршин суугчдад шаардлагатай болсон үед өөр нэмэлт байр байгууламж тоног төхөөрөмж зэргээр хангана. Гамшгийн хор хөнөөлийг амссан олон нийтийн нийгмийн бүтэц болон хүйсийн гүйцэтгэх үүрэг, эмзэг бүлгийнхэнд үзүүлэх үйлчилгээ зэргийг төлөвлөлт болон үйлчилгээгээр хангахдаа харгалзан үзнэ. Хэрэв боломжтой бол хүүхдүүдийг эрүүл цэвэр орчин нөхцөлд байлган аюулгүй тоглоомын талбай, сургууль боловсролын үйлчилгээгээр хангах хэрэгтэй. /51-р хуудсан дахь ундны ус, эрүүл ахуйны талаарх хэсгүүд мөн 267-р хуудсан дахь Эрүүл мэндийн систем, дэд бүтцийн стандарт шаардлагууд 5-ыг хар/

3. **Нас барагсдын цогцсыг зөөвөрлөх:** Нас барагсдын цогцостой харьцахдаа хүндэтгэлтэй харьцах ёстой, ба янз бүрийн соёл заншилтай олон нийт байгаа учраас хэсэг газрыг тэднийг өөр өөрийн ёс заншил хүндлэлийг үзүүлэх зорилгоор бэлтгэн өгөх хэрэгтэй. Оршуулгын газар чандарлах байгууламж зэрэг байхгүй бол өөр ямар нэгэн байгууламж юмуу газар нутаг олгох хэрэгтэй. Оршуулгын газрыг ундны усны эх үүсвэрээс дор хаяж 30 метрийн зайтай гүний усны ундаргаас 1.5 метрийн өндөрт байрлуулах хэрэгтэй. Оршуулгын газраас гарсан гадаргын ус хүмүүс оршин сууж буй газар орж ирэх ёсгүй. Гамшгийн хор хохирол амссан олон нийтэд тэдний өөр өөрсдийн оршуулгын өвөрмөц зан заншлийг гүйцэтгэх материал зэргээр хангаж өгөх хэрэгтэй. / Эрүүл мэндийн систем, дэд бүтцийн стандарт шаардлагууд 5-ыг хар/
4. **Зохион байгуулагчдын байр сууц ба хөл хорио тогтоох газрууд:** зохион байгуулагчид түүний ажилчдад шаардлагатай контор, байр сууц болон агуулах, хөл хорих газар зэргийг хангаж өгөх хэрэгтэй.
5. **Ашиглагдах талбай:** Нэг хүнд оногдох 45 метр квадрат газар нутагт айл өрхүүдэд оногдох талбай, зам харгуй, боловсролын үйлчилгээ ариун цэвэр хадгалах зоорь, мөн айл өрх бүрт зориулсан гал тогоо зэргийг багтаах хэрэгтэй. Газар төлөвлөлтөнд мөн тухайн газар байгаа олон нийтийн өсөлт зэргийг харгалзан үзэх хэрэгтэй. Хэрэв жоохон ч гэсэн газар нутгийг гаргах боломжгүй бол хүн ам олноор шигүү суурьшсанаас үүдэн гарах хор уршгийг багасгах талаар авч үзэх хэрэгтэй. Жишээ нь чухал шаардлагатай үйлчилгээнд зориулж айл өрхүүдийн байр сууцыг хоорондоо зайтай байхаар төлөвлөнө.

6. **Байр зүй буюу топоргаф болон газрын гадаргын нөхцөл:** Түр хугацаагаар байрлах хотхоны хувьд газрыг өөр ямар нэгэн нэмэлт ус зайлуулах арга хэмжээ авахгүй бол 6%-

аас ихгүй газар сонгох буюу 1%-аас бага бол тохиромжтой ус зайлуулах системийг суурилуулах хэрэгтэй. Ус зайлуулах хоолойнуудыг үерийг усыг зайлуулахаар угсарч болно. Барилга сууц барих газрыг борооны улирлын үед усан сангаа 3 метрээс багагүй өндөрт барих хэрэгтэй. Газар нутгийн нөхцөл байдлыг сонгохдоо жорлонгийн байрлал болон бусад байгууламжийн байрлах байрлалыг бодолцох хэрэгтэй. Цууралттай хад чулуу нь жорлонгийн бохирыг илүү ихээр шингээдэг байхад галт уулын чулуулаг нь жорлонгийн бохирыг муу шигээдэг. /Бохир устгах стандарт 2 болон 86-р хуудсан дахь ус зайлуулах стандартыг хар/

7. **Байр сууцанд хүрэх зам:** Урд нь байсан болон шинэ харгуй замууд нь ямар нэгэн тохиолдож болзожгүй аюулаас хол байх хэрэгтэй. Боломжтой бол иймэрхүү замууд нь хувь хүний аюулгүй байдалд ямарнэгэн хор хохирол учруулах ёсгүй. Замуудыг ашигласнаас үүдэн гарах элэгдэл нь бага байх ёстой.
8. **Аюул ослын үед гарах гарц:** Дийлэнх хоргодох байр сууцууд нь аюул осол тулгарсан үед оршин суугчдыг чөлөөтэй орж гарах нөхцлийг хангасан байх ёстой ба тэдэнд ямар нэгэн ноцтой хор хохирол учруулахгүй байх нөхцлийг хангасан байх ёстой. Өөр хоргодох байр сууц руу орох гарах хаалга гарч чөлөөтэй байх ёстой ба бүх шат нь зориулалтын бариултай байх ёстой. Хэрэв боломжтой бол явахад хүндрэлтэй буюу тусламжгүйгээр явж чадахгүй хүмүүст явах чөлөөтэй зай гаргаж өгөх хэрэгтэй. Хоргодох байрны бүх оршин суугчид гарцуудын хооронд хүлээн зөвшөөрөгдсөн хол биш зайд байрлах ба гал гарсан ямар нэгэн аюул тохиолдсон үед аль ч тийшээ зугтан гарах сонголттой байх ёстой ба эдгээр гарцууд нь тодорхой харагдаж байх ёстой юм.
9. **Халдвар авах эрсдэл:** Нам доор газар болон нүх сууц зэрэг нь хүний эрүүл мэндэд хортой мэрэгчдээс хол байрлах ёстой. (Халдварт өвчний хяналтын стандарт 2, хуудас 79)

Хүний амьдрах орон зай хангалттай байх ёстой. Айл гэрийн гол чухал зүйл бол сэтгэл хангалуун байх мөн амьдралыг тэтгэгч нь хэрэгцээ шаардлагыг хангаж чадахуйц байдаг.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэгээний хамт унших)

- Нэг хүнд ногдох шалны хэмжээ дор хаяж 3.5м^2 байх (Заавар тэмдэглэгээ 1-3 хар)
- Ногдож буй газар нь хүйс, нас, шаардлагатай гэж үзвэл гэр бүлийг дотор нь салангид байлгахад хангалттай байх хэрэгтэй. (Заавар тэмдэглэгээ 4-5 хар)
- Айл өрхийн гол чухал ажиллагаа нь орогнох байранд багтахуйц байхаар байна. (Заавар тэмдэглэгээ 6, 8 хар)
- Айл өрхийг хангаж байх түлхүүр үйл ажиллагаанууд нь хаана боломжтой ойр байхаар зохицуулагддаг (Заавар тэмдэглэгээ 7-8 хар)

Заавар тэмдэглэгээ

1. **Цаг уур ба аюултай нөхцөл:** Цаг агаар хүйтэн үед, айл өрхүүд ерөнхийдөө ноогдсон газраа байж аюул гамшигтай учирсан хүмүүс аюулгүй байдлаа хангах үүднээс тухтай дулаан хүрэлцээтэй газар цагаа өнгрөөж болох юм. Хотын хувьд, айл гэрийн үйл явдал нь ерөнийдөө хэрэглэж болохоор хажуугийн гадаах хэсгийг бага ашиглаж ноогдсон газраа өргөтгөдөг. Халуун болон чийгтэй цаг агаарт, эрүүл орчинг хангах үүднээс нэмэлт агаар оруулах газрыг бий болгодог. Ноогдсон шалны талбай нь нэг хүнд 3.5м^2 -ээс их байх ба байнга ийм хэмжээнд байх шаардлагатай. Шалнаас тааз хүртэл зай ч бас түлхүүр хүчин зүйл, халуун болон чийгтэй уур амьсгалтай нөхцөлд агаарын урсгалыг оруулах үүднээс өндөр байвал илүү харин хүйтэн цаг агаарт халуун шаарддаг дотоод эзэлхүүнийг багасгах үүднээс нам байх хэрэгтэй. Дулаан агаарт, орогнох байрны хажуудах сүүдэртэй гадаах хэсэг нь хоол бэлдэж хийх, унтахад зориулагдаж болно.

2. **Үргэлжлэх хугацаа:** Аюул гамшгийн яаралтай үед, ялангуяа цаг агаарын хэцүү нөхцөл буюу орогнох байрны материал амар олддоггүй газар нэг хүнд ноогдох газар 3.5м^2 –с бага байх нь

магадгүй амь аврах болон олон тооны хүний хэрэгцээг богино хугацааны орогнох байраар хангалттай хангаж болох юм. Энэ тохиолдолд, орогнох байр аль болох нэг хүнд 3.5м^2 -т хүрэхээр зохиогдсон байх ба удаан хугацаагаар үргэлжилвэл эрүүл мэнд болон хүмүүсийн зохицолдоонд нөлөөлж болох талтай. Хэрэв нэг хүнд 3.5м^2 –талбай хүрээгүй, эсвэл ердийн хэмжээнээс их талбай өвчтэй хүмүүс ногдож байвал багассан талбай дах халдашгүй байдал, эрүүл мэнд хувийн эрх зэрэгт нөлөөлөх нөлөөллийг хянаж үзэх ёстой. Нэг хүнд 3.5м^2 –с багагүй талбай ногдуулах шийдвэр нь өвчтэй хүмүүст нөлөөлөх ямарч хортой нөлөөллийг багасгах хэмжээний дагуу шийдэгдсэн байх ёстой.

3. **Дээврийн хучилт:** Орогнох байрыг гүйцэд хийхэд материал хангалтгүй газар дээврийн материалын нөөц, барилгын шаардлагатай хангамжийг хамгийн бага талбайтай газрыг эхэлж хийхээр хангагдсан байдаг. Үүний дараа цаг агаар, аюулгүй байдал, хувийн эрх болон халдашгүй байдлаас хамгаалах шаардлагатай хамгаалалт нь шат дараалан аль болох хурдан хийгдэж эхэлнэ.
4. **Соёл заншлын дадлага туршлага:** Ноогдсон газрыг ашиглалтанд суурышуулах заншил жишээ нь унтах зохион байгуулалт, мөн нэмэгдсэн гэр бүлийн гишүүдийн хоргодох байр зэрэг газар шаардаглагатай эсэхийг мэдээлж байх ёстой. Хэлэлцүүлгээр эмзэг хэсгийн хүмүүс буюу бие нь амархан муудах хүмүүсийг багтаасан байх ёстой.
5. **Аюулгүй байдал болон хувийн эрх:** эмэгтэйчүүд, охид хөвгүүд халдлагад өртөхдөө эмдэг байдаг ба тэдний хувийн аюулгүй байдалд хандах тохиромжтой анхаарал халамжийг өгөх ёстой. Айл өрхийн дотор дотоод хувиарлалт байх ёстой. Их хүнтэй орогнох байранд, гэр бүлийг хэсэг бүлэг болгох нь хувийн эрх болох аюулгүй байдалд хангалттай тус дөхөм болохуйц айл өрхийн газар, хувь хүний хамгаалалтанд зориулагдсан барилгын бүтэц, материал зэргийг хэрхэн авахаа сайтар төлөвлөдөг.
6. **Айл өрхийн үйл ажиллагаа:** унтах, усанд орох, хувцаслах; нярай хүүхэд, болон өвчтэй, хөгшин настай хүмүүсийг асрах; хоол хүнс, ус, гэрийн эд хөрөнгө болон бусад гол хөрөнгөө хадгалах газар; шаардлагатай үед хоол хүнсээ хийх болон идэх газар; мөн айл өрх цуглаж байх нийтийн газар нь хангагдсан байх ёстой.

7. **Загвар дизайн ба орон зай:** оноогдсон орон зай нь өдөр, шөнийн турш өөр өөр цагт өөр өөр арга хэмжээнд тохирох боломжтойгоор хангагдсан уян хатан байна. Барилгын хэв загвар, нээх байрлал болон дотоод бүтцийг хувааж өрчлөх боломжууд нь амин хэрэгцээ хангамж шаардагдсан газарт тохирох дотор болон гаднах хажуугийн газартай байх.
8. **Орогнох байрны бусад хүчин зүйлс:** Цаг агаар, хувийн эрх, аюулгүй байдал, гэх мэт хамгаалалтаар хангагдах мөн бусад зорилгоор ашиглах зэрэг боломжийг багтаасан байх ёстой. Үүнд барилга, сэргээн босголтын арил хийх замаар гамшиг сэтгэл зүй, нийгтийн тэтгэмж үзүүлэхэд шаардлагатай зардлыг төлөвлөх, тусламжыг хүлээн авах газар болж үйлчлэх ёстой тодорхой газар нутгийг эзэмших эрхийг авах асуудал багтана.

Орогнох байр ба суурьших стандарт 4: Загвар дизайн

Орогнох байрны загвар нь өвчтэй хүмүүс болон тухтай, дулаан хүрэлцэхүйц, цэвэр агаар, цаг агаарын ширүүн нөхцлөөс хамгаалсан, халдашгүй байдал, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангасан байхаар зохиогдсон байвал илүү тохиромжтой.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэгээний хавсралтыг унших)

- Орогнох байрны загвар болон материал нь тухайн газрын онцлог, соёл, нийгэм зэрэгтэй тохирохуйц байх (Заавар тэмдэглэгээ 1-г хар)
- Гэмтэж нурсан байр болон өвчтэй хүмүүст анхны туслалцаа үзүлэх зэрэг нь эхэлж хийгдэх (Заавар тэмдэглэгээ 2-г хар)
- Түр зуурын байрыг бэлдэхэд шаардагдсан сонгох материал нь өвчтэй хүмүүст тохирохоор бат бөх эдэлгээ сайтай байх (Заавар тэмдэглэгээ 3-г хар)
- Барилгын загвар, материал, хэмжээ, хаалганы байрлал нь тохилог, дулаан агаартай байхаар бэлтгэгдэх (Заавар тэмдэглэгээ 4-7-г хар)

- Ус хангамжын эх үүсвэр, эрүүл ахуйн нөхцөлийг бий болгох борооны усыг хуримтлуулах бэлтгэл, ус хадгалах газар, бохир ус болон хатуу хог хаягдалын зохицуулалт, байр сууцны барилгын гүйцэтгэл (Заавар тэмдэглэгээ 8-г харах).
- Барилгын хэв маяг, материал сонголт нь ч эрүүл ахуйн шаардлагатай уялдаж бэх хэрэгтэй. (Заавар тэмдэглэгээ 8-г харах).

Заавар тэмдэглэгээ

- 1. Оролцогч загвар:** Хоргодох байрны хэв загвар, хэрэглэх материалыг тодорхойлохдоо өрхүүдийг аль болох бүгдийг хамруулж тэдгээрийн багтаамжыг тусгаж өгөх хэрэгтэй. Хоргодох байранд байх шаардлагатай хүн бүрийг хамрагдсан байдлын дагуу дарааллыг өгөх хэрэгтэй. Хоргодох байр бүрийн зүг чиг хамрах газар, гадаргын зай хэмжээ, , цонхны нээлхий хаалганы байрлал нь орж гарахад тохиромжтой байх, гэрэл агааржуулалт болон бусад дотоод салбар ангиуд найдвартай болохыг мэдсэн байх. Энэ нь энгийн орон сууцны үнэлгээгээр мэдээлэгдэх ёстой (28 хуудасны оролцогч стандартыг харах)
- 2. Орон нутгийн хоргодох байрны санаал, эвдэрсэн байрны засвар:** Сүйрэлд өртсөн хүн ам гамшгаас авч үлдсэн материал, мөн орон нутагт хэрэглэж байсан нөөц, сэргээн завсарлаж байсан барилгын техникүүдийг ашиглан хоргодох байрыг засахаар санаачлан зохиодог. Материал техникийн тусламж дэмжлэгээр сүйрэлд өртсөн байрны нэг болон түүнээс дээш өрөөг засварлан тохижуулах. Газар хөдлөлт зэрэг цаашдын байгалийн гамшгаас үүдэж болох эрсдэл, өрхүүдийг уугуул нутагт нь буцаах, дэд бүтцэд учирсан эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан эрсдлийг мэдээлж байх хэрэгтэй.
- 3. Материал болон барилгын ажил:** орон нутагт хэрэгцээтэй материал, дизайныг сонгохдоо яарч сонгож болохгүй хүмүүстэй зөвлөлдөсний үндсэн дээр шийднэ. Гамшигт хариу өгөх үйлдлийн эхний шат болгож найдвартай хуванцар хучлагаар, мод бэлдэхэд хэрэглэх олс, хуванцар хоолойгоор болон цайрдсан гангаар өрх бүрийг хангах. Энэ хучлага олон улсын хүмүүнлэгийн холбооноос олгогдоно.

4. **Дулаан болон чийглэг нөхцөлд:** Орогнох байрнууд агааржуулалт сайтай, нарны шууд тусгалыг бууруулах загвараар хийгдэх ёстой. Хөрш байрнууд оыр баригдсанаас орж гарахад саадтай, агааргүйдэх зэрэг байдлыг анхаарах. Дээвэр борооны усыг тогтоохооргүй ташуу байх. Орогнох байрын байгууламж авсаархан, дулааны хэмжээ бага байх шаардлагатай. Борооны улирлыг тооцоолж үерийн уснаас хамгаалж шалыг өндөрлөх эргэн тойрны орчинд үүсэх бохир усыг тогтхооргүй болгон гадаргыг өөрчлөх. Орчин тойрныг нэмж ургамалжуулан усыг хөрсөнд илүүтэйгээр шингээх арга хэмжээ авч болно.
5. **Хуурай, халуун цаг агаарт:** байрны халаалтыг тохируулж шөнөдөө дулаан өгч, өдөрт нь сэрүүн байхаар зохион байгуулах. Хэрэв зөвхөн хуванцар хучлагатай майхан байвал, давхар хуванцар дээврийн давхаргын завсар агааржуулалт оруулан халаалтыг багасгах. Хаалга цонхыг онгойлгоход халуун салхинаас ангид сүүдэртэй, модорхог орчин зэрэг халууныг бууруулахаар газрыг зөв сонгож байршуулах хэрэгтэй.
6. **Хүйтэн цаг агаарт:** халаалт өндөртэй хүнд хэлбэрийн барилгууд нь өдрийн турш халаалттай байдаг, халаалт багатай хөнгөн хэлбэрийн барилгууд нь зөвхөн шөнөдөө л халдаг. Агааржуулагчаар дотогш орох агаарын урсгалыг багасгах, зууханд гал түлж дулааныг хадгалах, цонх хаалганы завсрыг сайтар дулаалах хэрэгтэй. Мөн шалан дээр унтахад доороосоо даарч хүний биеийн дулаан алдагдах тул гудас матраас зэргийг шалнаас аль болоха өндөрлөж, болж өгвөл орон дээр унтах. (230-р хуудасны Хүнсний бус зүйлсийн стандарт 1, 234-р хуудасны стандарт 4-г хар).

7. **Агааржуулалт:** сууцны загварт тохирсон агааржуулалтаар хангах нь халдварт өвчин тархах нөхцлийг багасгах зэргээр эрүүл мэндэд тустай.
8. **Орон нутгийн усны хангамж, ариун цэвэр, хог хаягдлын зохион байгуулалт:** ундны усны эх үүсвэрийг аюулгүй байдал, цэвэрлэгээний арга, хог хаягдлыг зохицуулах боломжыг хайж тогтооох, мөн бие засах газарь байр сууцны дизайн, хог хаягдлын асуудлыг шийдэхэд заавал нийгмийн шаардлагат нөлөөнд автах ёсгүй.(51-р хуудсан дахь “Усны хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн тусламж”бүлгийг хар).
9. **Халдварын эрсдлийг тодорхойлох:** нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүсд зориулагдсан сууцыг барихад хэрэглэгдэхээр сонгогдсон материал болон байрны бүтэц дизайнаас үүдэх халдвар тараагчын талаархи ойлголтыг мэдээлж байх хэрэгтэй. Үүнд энгийн эрсдлүүд болох шумуул, харх, ялаа, хортон шавьж, могой, хилэнцэт хорхой орно. (76-82-р хуудсан дээрхи “Халдвар хянах стандарт” 1-3-г хар)

Байр сууц ба суурыших стандарт 5: барилгын ажил

Барилгын ажил нь орон нутгийн найдвартай барилгын туршлагатай уялдаатайгаар орон нутгийн амьжиргааны боломжийг нэмэгдүүлэх зорилготой.

Үндсэн үзүүлэлтүүд (Заавар тэмдэглэгээ уялдуулж унших)

- Орон нутгийн эдийн засагт ноцтой төвөг учруулалгүйгээр орон нутгийн материал, хөдөлмөрийн нөөцийг ашиглах (Заавар тэмдэглэгээ 1.2-г хар)
- Орон нутгийн гаралтай ажил материалын стандартыг дээшлүүлэх (Заавар тэмдэглэгээ 3-г хар)
- Барилгын ажил ба материал чанар нь, учрах байгалийн гамшгийн эрсдлийг бууруулах зорилготой (Заавар тэмдэглэгээ 4-г хар)
- Хэрэглэгдэх барилгын материалаар хангаж өгөхөд өрх бүр өөрсдийн багаж хэрэгслээ ашиглан хоргодох байраа сэргээн засварлахад нь тус нэмэр болдог. (Заавар тэмдэглэгээ 5-г хар)

- Барилгажилтын явцад шаардлагатай материал, ажиллах хүч, олон улсын тендер, худалдаа, байгууламжийн удирдлагыг нягт уялдуулж, тендерийн худалдан авалтын, барилгын ажлыг зохион байгуулах олон улсын стандартуудын мөрдөж ажиллах. (заавар тэмдэглэгээ 6-г хар)

Заавар тэмдэглэл

1. Ажиллах хүч ба материалын эх үүсвэр: Амьжиргааг дэмжихэд барилгын материалын хангамж, барилгын мэргэжилтэн, ажиллах хүч дотооддоо хангах хэрэгтэй. Хэв дотоодоос материалаа хангах нь эдийн засгийн болон байгал орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа бол материал сонголт, үйлдвэрлэлийн үйл явц гээд энэ бүх зүйлсийг олон улсын дэмжлэг авах шаардлагатай. Эвдэрсэн барилгын материалыг дахин хэргэхийг дэмжих нь зөв зүйтэй, жишээ нь: тоосго, чулуун өрлөгө, дээврийн мод зэрэг орно. Үүнийг ашиглах эрхийн зөвшөөрөл авсан байх ёстой. (228-р хуудасны зааварчилгаа 3-г хар)

2. Гамшигт өртсөн өрхүүдийн оролцоо: эдгээр хүмүүс барилгын ажлын чадварын хувьд дутагдалтай тул дагалдан сургалт зохион байгуулснаар сайхан боломжууд гарч ирнэ. Биеийнхүчний ажил хийх чавдаргүй эсвэл боломжгүй хүмүүс дашуулах нөөц хариуцуулах, хяналтын ажил хийлгэх, хүүхэд асруулах, түр зуурын байр харуцуулах, барилгын ажилчдад үйлчилгээ дөхүүлэх болон захиргааны бусад ажил өгч болно. Гамшигт нэрвэгдсэн хүн амын бусад хэрэгцээг ажиллах хүчинтэй холбож болно. Жишээ нь ажлын хөлсөнд хүнс өгсөнөөр хүнсний аюулгүй байдлыг хангахаас гадна хүн амыг барилгын ажилд идэвхитэй оролцоход түлхэц болно. Ганц бие өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд өөрсдийн ороц байртай болохын тулд бэлгийн дарамтанд орох магадлал ихтэй байдаг. Тусламж авагчийн оролцоог Сайн дурын идэвхитэн ба хөлс авч ажиллаж буй хэн нь ч бай дэмжиж байх. (28-р хуудасны Оролцогч Стандарт-г хар)

3. Барилгын Стандарт: Сайн ажлын стандарт гэдэг нь мэдээж холбогдох мэргэжилтнүүдээр зөвшөөрөгдсөн байх ёстой. Зэрэглэлийн хувьд, орон нутгийн юм уу үндэсний барилгын стандартад нийцсэн байх ёстой.

4. Гамшгаас сэргийлэх нь: Сууцны загвар нь цаг уурын нөхцөлөөс хамаарч байх хэрэгтэй. Салхинд тэсвэртэй, хүйтэн цаг агаар Газар хөдлөлтөөс хамгаалж суурийг найдвартай хийх. Гамшгаас болж сүйдсэн барилгын стандартыг өөрчлөх, энгийн барилгыг засварлахад орон нутгийн засаг захиргаа, гамшигт нэрвэгдсэн хүн амаас зөвлөлгөө авах хэрэгтэй.

5. Тохижилт засвар үйлчилгээ: Гамшгийн үед үзүүлэх орогнох байр нь зөвхөн бага хэмжээний орон зай болон минимум материалын хангамжтай байдаг учраас гамшигт өртсөн өрхүүд энэ талбайн хэмжээг томсгох нөхцөл байдлыг сайжруулах бусад хувилбаруудыг эрж хайх хэрэгтэй болдог. Барилгын хэлбэр байдал болон ашигласан материалууд нь айл өрхүүд удаан хугацаанд байрлах шаардлагад нь нийцүүлэх зорилгоор байнга сайжруулж байх ёстой. Үүнд орон нутгаас олдох боломжтой багаж хэрэгслийг ашиглан засвар хийж болно.

6. Материал хангамж ба барилгын менежмент: Шуурхай, үр дүнтэй, хариуцлагатай найдвартай нийлүүлэлтийн сүлжээ ба барилгын менежментийн систем, ажилах хүч болон барилга дээр тавих хяналт бий болгох нь чухал. Үүнд эх сурвалж, ханган нийлүүлэлт, тээвэрлэлт, ашиглалт болон захиргааг хамруулан бий болгох ёстой.

Хүрээлэн буй орчны нөлөө

Материалын нөөц, ашиглагдсан барилгын техник, гамшигт өртсөн өрхүүдийг суурьшуулах нь Хүрээлэн буй орчинд үзүүлэх тааламжгүй нөлөөг багасгаж болно.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Гамшигт өртсөн өрхүүдийн түр болон байнгын суурьшил нь олдоцтой байгалийн нөөцийн хэмжээг харгалзан үздэг. (заавар тэмдэглэл 1-2-ийг хар).
- Дүрвэгсэд болон нутгийн уугуул хүн амын хэрэгцээнд байгалийн нөөцийг ашигладаг. (заавар тэмдэглэл 1-2-ийг хар)
- Барилгын материалын нийлүүлэлт ба бүтээгдэхүн мөн барилгын ажлын явц нь удаан хугацаанд оршин байсан байгалийн нөөцийг багасгадаг. (заавар тэмдэглэл 2-3-ийг хар).
- Мод болон бусад ургамал нь усны хомсдол ихсэх буй газар усыг тогтоож, хөрсний элэгдлийг багасгаж, сүүдэртэй үүсгэдэг байна. (заавар тэмдэглэл 4-ийг хар).
- Удаан хугацаагаар аюулгүйн зорилгоор ашиглах шаардлагагүй бол бөөнөөр хоргодох байр болон түр зуурын лагерьуд нь буцаж зориулалтаараа ашиглагддаг.

Заавар тэмдэглэл

1. **Хүрээлэн буй орчны нөөцийн менежмент ба тогтвортой байдал:** Хүрээлэн буй орчны хувьд байгалийн баялаг бүхий газар хязгаарлагдмал байдалд оршин буй хүн төрөлхтний мөн чанарт туслаж, үр дүн нь хүрээлэн буй орчинд туслах удаан хугацааны бус шаардлагыг агуулах хэрэгтэй байдаг. Мөн гаднаас түлшний нийлүүлэлтийг тогтвортой хангах ба малын бэлчээр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, байгалийн нөөцийг түшиглэсэн амьдрал ахуйг дэмжих бүхий л зохицуулалтыг хийх шаардлагатай.

Байгалийн баялаг нөөцтэй орчинд хүний оршин буй тогтвортой байдлыг өсгөж чаддаг. Хэрэв том сууринаас илүү хүрээлэн буй орчинд хор хөнөөл учирч байвал гамшигт өртсөн хүн ам хэд хэдэн жижиг сууринд хуваагдаж тарах хэрэгтэй. Түлш, ус, барилга барихад зориулагдсан модон материал, чулуу зэрэг байгалийн нөөц хүртэх эрх, газар болон модтой нутгийг ашиглах ба сэргээх арга замуудыг тодорхойлсон байх хэрэгтэй.

2. **Байгаль орчны олон жилийн ашиглалтын нөлөөг багасгах:** Гамшигт өртсөн хүн амд хоргодох байр хэрэгтэй газар хүрээлэн буй орчинд орон нутгийн байгалийн нөөцийг багасгах сөрөг нөлөө үзүүлдэг, иймээс байгалт орчны менежмент болон нөхөн сэргээлтийн замаар урт хугацаанд гарах сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээ авах ёстой.
3. **Барилгын материалын нөөц:** Гамшгийн өмнөх болон гамшгийн дараах үеийн хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөг үнэлэх хэрэгтэй. Үүнд ус, барилгын модон материал, элс, хөрс, бэлчээр, дээврийн хавтанцар болон тоосго шатаах түлш зэрэг байгалийн нөөцийн хэрэгцээ багтана. Ердийн хэрэглэгчдэд эдгээр нөөцийн гарал, бүтээн босгох өртөг, хяналт, эзэмшил нь тодорхой байх хэрэгтэй. Зохистой ба нэмэлт нөөцүүд нь орон нутгийн хүрээлэн буй орчинд урт хугацаанд сэргөөр нөлөөлөх аливаа зүйлийг багасгах, орон нутгийн эдийн засгийг дэмжиж болох юм. Эд хогшлын материалын дахин ашиглалт, үйлдвэрлэлийн процессийг тодорхойлох нь дахин тариалалт болон сэргээн босгох хөтөлбөрүүдийн хамт хийгдэх ёстой.
4. **Хөрсний эвдрэл:** Ердийн газар ашиглалтын үнэлгээ, өвс ургамлын тархалт болон гадаргуугийн ус сувгийн үнэлгээ нь шаардагдаж болох газрын гадаргууг чөлөөлөх нөлөөний үнэлгээ хийхэд хэрэгтэй. Хөдөө аж ахуйн болон бэлчээрийн газар нь орон нутгийн байгалийн идээшсэн газарт сэргөөр нөлөөлөх байдлыг бага байлгахаар төлөвлөгдсөн байна. Хоргодох байрны шийдэл нь цаг уурын өөрчлөлтөөс хамгаалах, сүүдрийн гарахыг ихэсгэх, хөрсийг тогтвортой барих зэрэгт зохицож мод, ургамлыг хадгалан үлдээхээр төлөвлөгдсөн байх хэрэгтэй. Зам, гудамж, суваг, шуудууны сүлжээнүүд нь хөрсний эвдрэл ба үерийг багасгах зорилгоор байгалийн шудуу шугамыг ашиглахаар төлөвлөгдсөн байна. Боломжгүй үед энэ нь тохиромжтой арга хэмжээ нь хөрсний элэгдэлд хүргэж ухсан суваг шуудуу, газар доогуурх хоолойн, хөрсөнд ухаж суулгасан далан нь усны урсгалыг багасгана. (86-р хуудсан дээрх суваг шуудууны стандарт 1-ийг хараарай.).

5. Шилжүүлэн өгөх: Бөөнөөр хоргодох байр болон түр зуурын, эсвэл өөрсдөө барьсан лагериудын эргэн тойронх хүрээлэн буй орчны байгаль сэргээлт нь түр зуур оршин суух хугацаанд тухайн орчинг байнга нөхөн сэргээх ажил хийэ сайжруулж байх хэрэгтэй. Иймэрхүү түр оршин суух сууррингуудыг хаах үед дахин ашиглагдахгүй, хүрээлэн буй орчинд тааламжгүй нөлөө үзүүлж болзошгүй бүхий л хог хаягдал, материалуудыг устгаж зайлуулах хэрэгтэй.

2. Хүнсний бус зүйлс:

Хувцас, цагаан хэрэглэл болон ахуйн зүйлс

Хүнсний эрүүл мэнд, хувийн орон зай болон нэр хүнд, цаг уурын өөрчлөлт зэрэг хоргодох

байранд ихэнх хувь хүмүүсийн хэрэгцээнд хувцас, хөнжил, цагаан хэрэглэлийн материалууд шаардагддаг. Хувийн эрүүл ахуй, хоол бэлтгэх ба хооллолт, хоргодох байраа засварлах, хамгаалах, барьж тохижуулах, халаалтаа хангах боломжтой өрхүүдэд үндсэн бараа нөөц шаардагддаг.

Хүнсний бус зүйлсийн стандарт 1: Хувцас ба цагаан хэрэглэл

Гамшигт өртсөн хүмүүс нэр хүнд, аюулгүй байх, сайн сайхан байдлаа хадгалхын тулд хувцас, хөнжил цагаан хэрэгсэл хүрэлцээтэй байх хэрэгтэй.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Охид, эмэгтэйчүүд, хөвгүүд эрэгтэйчүүд цаг уур, улирал, соёлдоо тохиромжтой таарсан хэмжээтэй дор хаяж нэг иж бүрэн хувцастай байх хэрэгтэй. Нялх болон хоёр наснаас доош насны хүүхдүүд хамгийн багадаа 100см*70см хэмжээтэй хөнжилтэй байна. (заавар тэмдэглэл 1-4)
- Хүмүүст, шаардлага ёсоор тусдаа унтах боломж бүрдүүлэх, халуун дулаан тохилог байдлаар хангах унтах ор, хөнжил цагаан хэрэгсэлтэй байна. (заавар тэмдэглэл 2-3)
- Эрсдэлд хамгийн их өртөмтгий хүмүүст нэмэлт хувцас, цагаан хэрэглэл хэрэгтэй. (заавар тэмдэглэл 5)
- Соёлд нь тохирох оршуулгын хувцас хэрэгцээтэй үед олдох боломжтой байна.

1. **Хувцас солих:** Хүмүүс дулаахан, аюулгүй байх үүднээс хувцсаа хангалттай өөрчилж солих боломжтой байх хэрэгтэй. Энэ нь үндсэн хэрэглээний зүйл байх ба жишээ нь, дотуур хувцасны хэд хэдэн ээлж байх ба угаах боломж бүрдүүлэх ёстой.
2. **Тохиромжтой байдал:** Хувцас нь цаг уурын нөхцөл байдал, соёлын хувьд тохиромжтой ялангуяа эмэгтэй, эрэгтэй, охид, хөвгүүдэд насны хувьд тохиромжтой байх хэрэгтэй. Цагаан хэрэгслийн материалууд нь соёлын талыг нь тусгасан өрхийн гишүүд тус тусдаа унтах боломж бүрдүүлсэн тоо ширхэг нь хангалттай байх хэрэгтэй.
3. **Дулаан хувцас, цагаан хэрэгсэл:** Чийглэг уур амьсгалтай нөхцөлд дулаан суух, чийгшлийн үед цагаан хэрэглэл, хувцас, эдлэлийг дулаалахад анхаарлаа хандуулах хэрэгтэй. Хувцас, цагаан хэрэгслийн тохиромжтой зохицол нь дулаан тухтай байдлын сэтгэл ханамжийн түвшинг хангаж байх хэрэгтэй. Газарт дулаанаа алдахаас сэргийлж газраас тусгаарласан орны нөөц хөнжил нэмж хангахаас ч илүү үр дүнтэй байж болох юм.
4. **Бат бөх байдал:** Хувцас, цагаан хэрэглэл ердийн үед өмсөхөд зохицсон бат бөх өвөрмөц зүйлсийн хомсдлын үед хэрэглээг уртасгаж ашиглах хэрэгтэй.
5. **Тусгай хэрэгцээ:** Хувцасны нэмэлт өөрчлөлтүүд нь өтгөн шингэнээ бариж чадахгүй хүмүүс, ДОХ/ХДХВ-тэй амьдарч буй хүмүүс, суулгалттай холбоотой өвчтэй хүмүүс, жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүл, өндөр настай хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, бусад хөдөлгөөн нь хязгаарлагдсан хүмүүст нэмж хувцас өгөх хэрэгтэй. Хүүхэд, нялхас дулаанаа хадгалахдаа насанд хүрэгчдээс муу байдаг ба биеийн дулаанаа ихээр алддаг учир дулаан тухтай байлгах зорилгоор нэмэлт хөнжил шаардаж болох юм. Хөдөлгөөний хомсдолтой хүмүүс, өндөр настай хүмүүс, өвчтэй ДОХ/ХДХВ-тэй дархлаагүй болсон хүмүүст онцгой анхаарал хэрэгтэй. Жишээ нь гудас, өндөрлөсөн ор гэх мэт.

Хүнсний бус зүйлсийн стандарт 2: Хувийн эрүүл ахуй

Гамшигт нэрвэгдсэн өрх бүр хувийн эрүүл ахуй, эрүүл мэнд, нэр төр, сайн сайхан аж байдлаа

хангах хангалттай саван болон бусад зүйлсийг ашигладаг.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Хүн бүр 1 сарын хугацаанд 250 гр биеийн саван ашигладаг. (заавар тэмдэглэл 1-3)
- Хүн бүр 1 сарын хугацаанд 200 гр эдийн саван ашигладаг. (заавар тэмдэглэл 1-3)
- Охид эмэгтэйчүүд сарын тэмдэг ирэх үед ариун цэврийн материалуудыг ашигладаг. (заавар тэмдэглэл 4)
- Нярай болон 2 наснаас доош насны хүүхдүүд 12 ш угааж болдог живх эсвэл ердийн живхийг хэрэглэнэ.
- Хувийн эрүүл ахуй, эрүүл мэнд, нэр төр, сайн сайхан аж байдлаа хангах зайлшгүй хэрэгтэй нэмэлт зүйлсийг хэрэглэнэ.

Заавар тэмдэглэл

1. **Тохиромжтой байдал:** Одоогийн соёлын хувьд хэрэглэгдэж байгаа туршлага болон бүтээгдэхүүний жишгий нийлүүлэх бараа бүтээгдэхүүнийг тодорхойлох үнэлхэд ашиглана. Хэрэглэж мэдэхгүй, ашиглаж чалахгүй тийм бараа бүтээгдэхүүнийг сонгохгүй байх хэрэгтэй. (жишээ нь хүнсний зүйлсийг андуурч хэрэглэх г.м.) Барааны савангийн оронд угаалгын нунтаг, үнс эсвэл цэвэр элсээр соёлын хувьд аль тохиромжтойг сонголтыг нь өгч болно.
2. **Орлуулах:** Шаардлагатай үед орлуулах бүтээгдэхүүнийг хянаж судалж үзэх хэрэгтэй.
3. **Тусгай хэрэгцээ:** Хэрэв боломжтой бол өтгөн шингэнээ барих чадваргүй, ДОХ/ХДХВ-тэй хүмүүс болон суулгалт өвчинтэй болон өндөр настай хүмүүс, хөргжлийн бэрхшээлтэй хүмүүс эсвэл бусад гэмтэлтэй хүмүүсд биеийн болон эдийн савангийн нэмэлт хэрэгцээг нь хангаж өгөх хэрэгтэй.

4. **Ариун цэврийн хэрэглэлийн хамгаалалт:** Охид бүсгүйчүүдийн сарын тэмдэг ирэх үед тохиромжтой материал авах хэрэгтэй. Эмэгтэйчүүд эдгээр материалуудыг сонгоход оролцох нь чухал.
5. **Нэмэлт зүйлс:** Одоогийн нийгэм ба соёл нь хувийн эрүүл ахуйн нэмэлт зүйлсийг шаардаж байна. Эдгээр зүйлс нь нэг хүнд нэг сард 75мл/100г шүдний оо, шүдний сойз 1, шампунь 250 мл, нялхас болон хоёр наснаас дээш насны хүүхдүүдэд 250 мл биеийн тос, 1 ш нэг удаагийн сахлын хутга

зэргээс бүрдэнэ. Нэг өрхөд нэг ширхэг үсний сойзон сам, эсвэл энгийн сам, хумсны хутга байхад болно.

Хүнсний бус зүйлсийн стандарт 3: хоол хийх болон хоол идэх хэрэгслүүд

Гамшигт нэрвэгдсэн өрх бүрт хоол хийх болон хоолоо идэх хэрэгслүүд байдаг.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Гамшигт нэрвэгдсэн өрх бүрт том хэмжээний бариултай тогоо, тагтай хоолны сав, дунд хэмжээний данх бариул, тагтай, хоол бэтгэхэд ашиглах түмпэн, хутга, модон хутгуур халбага хоёр байна. (заавар тэмдэглэл 1).
- Гамшигт нэрвэгдсэн бүр 10-20 литр усны тагтай сав 2, эсвэл (20 литрийн сэнсэн тагтай эсвэл 10 литрийн тагтай хувин) савтай байна. Нэмж ус болон хүнс хадгалах сав суулганууд байна. (заавар тэмдэглэл 1-2).
- Хүн бүр хоол идэх таваг, төмөр халбага, аяга, архи уух хундагатай байна. (заавар тэмдэглэл 1-4)

Заавар тэмдэглэл

1. **Тохиромжтой байдал:** Хангагдаж байгаа зүйлс нь соёлын хувьд тохиромжтой, аюулгүй байх хэрэгтэй. Эмэгтэйчүүд эсвэл хоолны бэлтгэдэг ердийн ус зөөдөг хүнд тухайн зүйлийг хэрэглэх зөвлөлгөө өгөх хэрэгтэй. Хоол хийх болон хоол идэх хэрэгслүүд усны сав нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хүүхдүүдэд тохиромжтой хэмжээтэй байх хэрэгтэй.

2. **Хуванцар бараа:** Бүх хуванцар бараанууд (хувин, түмпэн, хул аяга, лааз, усны сав зэрэг) нь хоол хийх зориулалттай байх хэрэгтэй. (Усны нийлүүлэлэх стандарт 3, заавар тэмдэглэл 1, хуудас 70)
3. **Төмөр эд зүйлс:** Бүх хоолны халбага, сэрээ, хутга, хул аяга, аяга, нь зэвэрдэггүй эсвэл ган төмөр байх хэрэгтэй.
4. **Нялхсын тэжээл:** Нярай хүүхдийн угж нь хөхний сүү орлуулагч хийх, хадгалах шаардлагад бүрэн нийцсэн байх хэрэгтэй. (тэжээлийг өгөх ерөнхий стандарт 2, 141-р хуудасны заавар тэмдэглэл 1).

Хүнсний бус зүйлсийн стандарт 4: Зуух, түлш, гэрэл цахилгаан

Гамшигт нэрвэгдсэн өрх бүр нийтийн хоолны өрөө, зуух, хоол хийх хэрэгсэл ба түлш, дулааны түлш зэргийг ашиглах бололцоогоор хангагдсан байна. Мөн өрх бүр хувийн аюулгүй байдлаа хангахад тогтвортой гэрэл байх хэрэгтэй.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт унших)

- Өрх бүр хоол хийх болон дулаан суухад хэрэгтэй зуух болон түлштэй байх ба хоол бие даасан өрх бүрийн байранд хийгдэнэ. (заавар тэмдэглэл 1-2)
- Гадаад эх үүсвэрээс хангагдсан түлшнээс илүү хүрээлэн буй орчны болон эдийн засгийн хувьд тохиромтой дотоодын түлшний нөөцийг чухалчилна. (Заавар тэмдэглэл 3)

- Түлш нь аюулгүй, баталгаатай байдалтай, түлш тараах үед хүмүүст хор хөнөөл учруулах ёсгүй. (заавар тэмдэглэл 4).
- Түлшийг найдвартай хадгалах агуулах байх ёстой.
- Өрх бүр хиймэл дэн, лаа гэх мэт гэрлээр хангагдана.
- Өрх бүр түлш ноцоох, лаа асаахад хэрэгтэй чүдэнзтэй байна.

1. **Зуух:** Тухайн орон нутгийн практикт хэрэглэгдэж заншсан зуух болон түлшний сонголт хийхэд шаардлага тавих хэрэгтэй байна. Хоол хийх практикт түлээний мод бэлтгэх, галаа түлэх, хоолоо бэлтгэх, нийтийн хол хийх зэрэгт эрчим хүч хэмнэх хэрэгтэй байдаг. Хүнсний тусламжийн хөтөлбөрүүд зэрэг хэмнэл шаарддаг болон түлээгээ бэлтгэх энэ нь бэлтгэж буй хоолны хэлбэрт өөрчлөлт оруулах боломжтой зэрэг болно. Дүрвэгсдийг нэг дор бөөнд нь байрлуулж байгаа тохиолдолд нийтийн эсвэл төвлөрсөн гал тогоотой байлгана, айл бүрийн зуухны хангамжид дулаан байр бэлтгэхийн оронд, байшин дотор тамхи татах, гал гарах эрсдлийг багасгах зорилгоор бөөнөөр нь хорогдох байранд байрлуулдаг.
2. **Агааржуулалт:** Хамарч буй бүсэд ашиглагдсан зуухны хий болон тамхины утаа нь гадагшаа түлштэй хамт яндангаар гарах хэрэгтэй. Мөн зуухны байршил болон хорогдох байрны цаг уурын хамгаалалтын нээлтүүд нь агааржуулалтыг хангалттай байлгах, доторх агаарын бохирдлын, амьсгалын замын эрсдэлт асуудлуудыг багасгахад ач холбогдолтой. Зуух нь галын эрсдэл болон гаднах доторх агаарын бохирдлыг хамгийн бага байлгах аар бүтээгдсэн байх хэрэгтэй.
3. **Түлшний байнгын нөөц:** Түлшний нөөцийг судалсан нөөцийн түлшний байнгын нийлүүлэлтийг хангахын тулд түлшний хэмжээг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх арга хэмжээ авна.
4. **Түлшээ авах:** Хүнс бэлтгэх болон дулааны түлшээ тараах газар болон арга замын талаар эмэгтэйчүүдээс зөвлөлгөө авч, тэдний аюулгүй байдалыг хангах үүднээс зохион байгуулна. Түлш авч буй эмзэг бүлгийн хүмүүсийн ялангуяа өрх толгойлсон эмэгтэйчүүд, ДОХ-ын халдвартай амьдарч буй г.м. хүмүүсийн хэрэгцээг бас авч үзэх хэрэгтэй. Бага ажиллагаатай түлш, түлш бага зарцуулах зуух, түлшний нөөцийн ахиу олдоцтой газар г.м. бүхий л боломжуудыг ашиглах хэрэгтэй.

Хүнсний бүс зүйлсийн стандарт 5: Тоног төхөөрөмж ба хэрэгслүүд

Гамшигт хэрвэгдсэн өрх бүр хорогдох байрныхаа барилгын ажил, засвар, найдвартай ашиглалтыг хариуцдаг ба хэрэгцээтэй тоног төхөөрөмж, хэрэгслээр хангагдах ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтийн хамт унших)

- Барилгын ажлын аль нэг хэсгийг буюу бүхлээр нь хариуцаж буй эсвэл үндсэн засвар хийж буй өрхүүд тухайн ажлыг гүйцэтгэхэд аюулгүй байдлыг хангах бүхий л тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг авч ашиглах эрхтэй. (заавар тэмдэглэл 1-2).
- Хэрэгцээ байвал хоргодох байрны барилга болон засварын ажил болон тоног төхөөрөмж хэрэгслүүдийг ашиглах талаар сургалт, зааварчилгаа өгөх шаардлагатай байдаг. (заавар тэмдэглэл 3).
- Шумуулнаас хамгаалах тор гэх мэт халдварт өвчин тараагч шавьжнаас хамгаалах материалуудыг өрхийн бүх гишүүдэд тарааж өгөх. (76-82-р хуудсан дахь халдварын хяналтын стандартийг хар).

Заавар тэмдэглэл

1. **Ердийн хэрэгслийн иж бүрдэл:** Орон нутгийн практикт ердийн хэрэгслийн иж бүрдэлд алх, цохиур, хусуур, мачет илд, хүрз, малтуур зэрэг багтана. Эдгээр хэрэгслүүд нь газар дээрээ засахад хялбар байх хэрэгтэй. Дүрвэгсэд гадаргын усны суваг ухах, авс булш болон оршуулгын нүх ухах, шарилыг булах, нас барсан хүмүүсийг тээвэрлэх хэрэгслүүдтэй байх хэрэгтэй.

2. **Амьжиргаанд тохируулах:** Эдгээр хэрэгслүүд нь хүмүүсийн амьдрал, амьжиргаанд нэмэр болохуйц байвал тохиромжтой.
3. **Техникийн тусламж:** Өрх толгойлсон эмэгтэйчүүд болон бусад эмзэг бүлгийнхэн барилга барих, засвар хийхэд нь хамаатан садны гишүүн, хөршүүд, хөлсний ажилчдын тусламж хэрэгтэй болдог.

Хавсралт 1**Орогнох байр, суурьшуулах болон хүнсний бус
зүйлсийн анхны хэрэгцээг үнэлэх асуултууд**

Энэхүү асуултын жагсаалтыг гамшигийн дараахь хоргодох байрны асуудлыг шийдвэрлэх зорилгоор хэрэгцээтэй мэдээ, мэдээллийг олж авахад ашиглана. Энэхүү асуултууд нь албан ёсны биш ба тохируулж өөрчилж ашиглах хэрэгтэй. Гамшиг үүссэн шалтгаан, дүрвэгсдийн байдал, уугуул хү амын болон шаардлагатай хүмүүсийн нэрс, холбоо барих утас, хаяг г.м.тус тусад нь цуглуулж авдаг. (29-р

хуудсан дээрх эхний хэрэгцээт дүгнэлтийг хар).

1. Орогнох байр ба нүүлгэн сууришуулах

Хүн амын талаар мэдээлэл

- Жирийн нэг өрх хэдэн хүнтэй байдаг вэ?
- Үндэсний цөөнх, дагахдах хүнгүй хүүхдүүд зэрэг жирийн өрхөөс ялгаатай бүлэг хүмүүст тус гамшигт нэрвэгдсэн нийгэмд байгаа эсэх?
- Хэдэн өрхөд хоргодох байр хүрэлцэхгүй байна вэ? Тэд хаана байна?
- Хэдэн хүн бие даасан өрхөд хамрагдахгүй хоргодох байранд ороогүй байна? Тэд хаана байна?

Эрсдлүүд

- Хоргодох байр хангалтгүй болон хоргодох байрны хомсдолтой амьдарч байгаа хүмүүсд хамгийн тэргүүнд тохиолдох эрсдлүүд юу вэ? Хэдэн хүн энэ эрсдэлд байна вэ?
- Хоргодох байргүй гамшигт өртсөн хүмүүсийн амь нас, аюулгүй байдал, эрүүл мэндэд заналхийлж буй ямар эрсдлүүд байна вэ?

- Дүрвэгсэд шилжин ирснээр уугуул хүн амд тохиолдож болох ямар эрсдлүүд юу вэ? Ямар нөлөө үзүүлэх вэ?
- Гамшиг үргэлжилсээр байгаа үед хоргодох байрны хангамжийн хувьд гамшигт нэрвэгдсэн хүн амын амь нас, аюулгүй байдал, эрүүл мэндэд цаашид тохиолдож болох эрсдлүүд юу вэ?
- Хүн амын дунд ХДХВ/ДОХ-г тээж буй хүүмүүс зэрэг эмзэг бүлгийн хүмүүс хэн хэн бэ?
- Эмзэг бүлгийн хүмүүст тохиолдох онцгой эрдэл юу вэ? Яагаад?

Өрхийн амьдрал

- Гамшигт нэрвэгдсэн хүн амын хоргодох байранд амьдрах нөхцөл хэр хангагдсан байна вэ? Мөн тухайн байрны орон зай, талбайн загвар дизайн нь амьдрах нөхцөл байдалд тохирч байна уу?
- Гамшигт нэрвэгдсэн хүн амын хоргодох байрны гаднах орчинг хэрхэн тохижуулсан байна вэ? Мөн талбайн зохион байгуулалт нь хүмүүсийг байрны гадаа гарахад тохиромжтой байна уу?

Материал ба дизайн

- Өнөөдрийн байдлаар гамшигт өртсөн өрхүүд болон бусад хүмүүсд ямар хоргодох байр, засварын болон барилгын материалаар хангасан байна вэ?
- Хоргодох байрыг засварлахад гамшгийн дараа үлдсэн, ашиглаж болохуйц ямар материалууд байна вэ?
- Дүрвэгсэд болон угуул нутгийн хүн амын байраа барих ерөнхий туршлага нь юу вэ? Барилгын рам, дээвэр, гадаа ханыг хийхэд ямар ямар өөр төрлийн материалууд ашигладаг вэ?
- Ямар загварын, ямар материалууд гамшигт өртсөн хүн амын сонголтод нийцэх вэ?
- Ганц эсвэл олон удаагийн гамшгаас сэргийлэх ба уршгийг багасгахад тохиромжтой хоргодох байрны шийдлийг хэрхэн хийх вэ?
- Хоргодох байр хэрхэн ба хэнээр бариулах вэ?

239

- Барилгын материалыг хэрхэн олж авдаг вэ? Хэнээр хийлгэх вэ?
- Эмэгтэйчүүд, залуучууд, хөгшдийг хоргодох байраа барихад нь сургаж тусалж хэрхэн оролцуулж болох вэ? Шахалт тулгалт юу байж болох вэ?

Орон нутгийн нөөц ба саад бэрхшээлүүд

- Гамшигт өртсөн өрхийн хүний, санхүүгийн болон материалын нөөц нь юу вэ? Хоргодох байрны хэрэгцээг яаралтай даруй хангахад ямар бэрхшээл саадүүд байна вэ?

- Хоргодох байрыг барихад шаардлагатай Газрын эзэмшлийн эрх, газрын ашиглалт ба сул чөлөөтэй газрын боломж ба саад бэрхшээлүүд юу вэ?
- Уугуул нутгийн хүн ам дүрвэсэн хүмүүсийг өөрсдийнхөө орон сууцанд эсвэл ойролцоох газарт байрлуулах боломж ба саадууд юу вэ?
- Гамшигт өртөөгүй барилга байгууламжид түр хугацаагаар дүрвэсэн өрхүүдийг байршуулах, ашиглах боломж ба саадууд юу вэ?
- Түр зуурын суурин байршуулж болох хоосон чөлөөтэй газрын тогтвортой хүрээлэн буй орчны болон газар зүйн нөхцөл ямар вэ?
- Хоргодох байрны шийдлийн талаар нутгийн захиргааны зохицуулалт, шаардлага ба болзошгүй саадууд юу вэ?

Үндсэн үйлчилгээ ба Үйлчилгээний газрууд

- Хувийн эрүүл ахуй болон болон ундны усны одоогийн боломж ямар байна, гарах ариун цэврийн хэрэгцээг хангах боломж ба саадууд юу вэ?
- Нийгмийн үйлчилгээ (эрүүл мэндийн төв, сургууль, мөргөлийн газар зэрэг) газрын боломж юу вэ?эдгээр газруудаар үйлчлүүлэх боломж ба бэрхшээлүүд юу байх вэ?

Уугуул нутгийн хүмүүс ба хүрээлэн буй орчны нөлөө

- Тухайн орон нутгийн иргэдийн санаа зовж буй асуудлууд юу вэ?
- Дүрвэгч өрхийг уугуул нутгийн хүмүүстэй хамт буюу түр зуурын хуаранд байршуулхыг төлөвлөх ба зохион байгуулах асуудал юу байна вэ?
- Дүрвэгсдэд тусламж дэмжлэг (үүнд түлээ, ариун цэврийн байдал, хаягдал зайлуулах, малын тэжээлээр хангах г.м.) үзүүлэх ба орогнох байраар хангахад (барилгын материал ба хүрэлцээ). хүрээлэн буй орчны зүгээс учирч болзошгүй асуудлууд юу вэ?

- Орон нутагт хоргодох байр барихад, нүүлгэн шилжүүлэх боломж, менежментийн ямар боломжууд байна вэ?
- Материалын нөөц, хоргодох байрын байгууламж, нүүлгэн сууришуулах шийдлүүдээр амьдралыг тэтгэх ямар боломжууд гарах вэ?

Хүнсний бус зүйлс: Хувцас, Ор дэр ба цааган хэрэгсэл, ахуйн зүйлс

Хувцас, ор дэр ба цааган хэрэгсэл

- Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, нялхас, хүүхдүүд, жирэмсэн эхчүүд, хөхүүл эмэгтэйчүүд болон өндөр настнуудад ор дэр, хөнжил, хувцасны хэрэгцээний онцлог юу байна, нийгмийн болон соёлын онцлогт тохирч байна уу?
- Эрүүл мэнд, нэр хүнд, хангалуун амьдрахад хэрэгцээтэй хувцас хунар, цаг агаарын тааламжгүй байдлаас хамгаалах хөнжил, ор дэр, бусад зүйлсээр хэдэн хүн дутмаг амьдарч байна вэ? Тэр дундаа бүх насны хэр олон эрэгтэй, эмэгтэйчүүд, хүүхдүүд, нялхас байна вэ? Яагаад?
- Хувцас, ор дэр, хөнжилийн хомсдол нь амь насанд ямар шууд эрсдэл учруулж болох вэ? Хэдэн хүн ийм эрсдэлд байна вэ?
- Хангалттай хувцас, ор дэр, хөнжилийн хэрэгцээгээс улбаадан гарч болзошгүй гамшигт нэрвэгдсэн хүний амь нас, хувийн аюулгүй байдал, эрүүл мэндэд аюул учруулах ямар эрсдлүүд байна вэ?

241

- Нийгмийн аль бүлэг илүү их эрсдэлд байна? Яагаад? Тэдгээр бүлгийн хүмүүсийг хэрхэн яаж дэмжиж тусалж болох вэ?

Хувийн эрүүл ахуй

- Хувийн эрүүл ахуйд хамаарах үндсэн ямар асуудлууд байна вэ? Гамшигт өртөхөөс өмнө өрхийн хувийн эрүүл ахуйд юу хэрэглэгдэж байсан вэ?
- Гамшигт нэрвэгдсэн өрхүүд гамшигийн дараа ямар үндсэн хэрэглээний зүйлс олдохгүй байна вэ?
- Эмэгтэйчүүд, охидууд, хүүхдүүд, нялхасд тусгай хэрэгцээ юу вэ?

- Гамшигт өртсөн өрхүүдийн нэр төр, эрүүл мэндийг хамгаалах соёл болон нийгмийн хувьд чухал нэмэлт зүйлс юу вэ?

Хоол хийх, хоол идэх, зуух болон түлш

- Гамшигт өртөхөөс өмнө хоол хийх, хоол идэхэд хэрэглэдэг ямар хэрэгслүүд өрхөд байсан бэ?
- Хэдэн өрхөд хоол хийх болон хоол идэх хэрэгсэл хангалтгүй байна вэ? яагаад?
- Өрхүүд ямар төрлийн зуухыг хоол хийх, дулааны зорилгоор ашиглаж байсан бэ? Хоол хийх газар нь хаана байсан бэ? Байшингийн дотор ба гадаа нь хаана байралдаг байсан бэ? Ямар төрлийн түлш хэрэглэдэг байсан бэ?
- Хэдэн өрхөд хоол хийх, халаалтын зорилгоор ашиглах зуух байхгүй байна вэ? яагаад?
- Хэдэн өрхөд хоол хийх, халаалтын зорилгоор ашиглах түлш хангалтгүй байна вэ? яагаад?
- Уугуул нутгийн хүмүүс болон дүрвэгсдэд хүрэлцэхүйц түлшний нөөц болон хүрээлэн буй орчны хувьд ямар боломж, саад бэрхшээлүүд байна вэ?
- Дүрвэгч эмэгтэйчүүдэд түлшээ нөөцөлхөд нь ямар нөлөө байна вэ?
- Соёлын болон тогтсон хэрэглээний мөн аюулгүй байдлын нөхцлүүдийг авч үзсэн үү?

Топог төхөөрөмж ба хэрэгслүүд

- Хоргодох байраа барих, засварлах өрхүүдэд байх хэрэгтэй үндсэн хэрэгслүүд юу вэ?
- Хоргодох байраа барьж байгуулах, засч засварлахад үндсэн хэрэгслүүдийг өөр ямар зүйлд ашиглах боломжтой вэ?
- цаг агаар болон хүрээлэн буй орчноос хамаарч шалыг бүрэх хэрэгтэй эсэх? Ямар материалаар хийх шаардлагатай вэ?
- Хортон шавьж болон халдвар тээгчээс өрхүүдийн аюулгүй байдлыг хэрхэн хамгаалах вэ? (шумуулнаас хамгаалах тор г.м)

Хавсралт 2**Ном зүй**

Оксфордын их сургуулийн Дүрвэгсдийн судалгааны төвийн Албадлагын цагаачлалын цахим хөтөлбөрийн ачаар эдгээр баримт бичгийн дийлэнхи нь зохиогчийн эрхийн зөвшөөрөл авч <http://www.forcedmigration.org> цахим сүлжээний тусгай холбогчид тавигдсан.

Олон улсын эрх зүйн баримт бичгүүд

Шаардлага хангасан орон сууцаар хангагдсан эрх /Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын хэлэлцээрийн 11 дүгээр зүйл 1, CECSR-ийн ерөнхий санал 4, 1991/12/12. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо/

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенци /1981/, 14 дүгээр зүйлийн 2 /h/

Хүүхдийн эрхийн конвенци /1990/, 27 дугаар зүйлийн 3

Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенци /1969/, 5 дугаар зүйлийн /e/ /iii/

Дүрвэгсдийн статусын тухай олон улсын конвенци /1951/, 21 дүгээр зүйл

Хүний эрхийн түгээмэл тунхаглал /1948/, 25 дугаар зүйл

Ерөнхий баримт бичгүүд

Chalinder, A /1998/, Сайн туршлагын тойм 6: Онцгой байдлын үед оршин суудаг газраасаа шилжүүлэгдсэн хүн амын түр зуурын суурьшилтын төлөвлөлт. Лондон, Хилийн чанадын хөгжлийн хүрээлэн/Туслах, нөхөн сэргээн сүлжээ

Davis, I /1978/, Гамшгийн дараахь оромж. Оксфордын политехникийн хэвлэл

Davis, J, Lambert, R /1995/, Онцгой байдлын үеийн барьж байгуулах ажил: Тусламжийн ажилчдад зориулсан практикийн гарын авлал. Лондон, RedR/IT-ийн хэвлэл

244

Hamdi, N /1995/, Байшингүй орон сууц: Оролцоо, уян хатан байдал, бололцоо. Лондон, МТ-ийн хэвлэл

ICRC /2002/, Онцгой байдлын зүйлийн каталог. Женев, ICRC

Kelly, C /2002/, Гамшгийн үеийн байгаль орчны хурдацтай нөлөөний судалгааны тухай гарын авлага. Лондон, Их Сургуулийн коллеж, Бенфилдийн хор уршгийн эрдэм шинжилгээний төв,

MSF /1997/, Багц ба онцгой байдлын зүйлийн удирдамж. Шийдвэр гаргагчийн удирдамж. Англи хэлний 4 дэх хэвлэл. Бельги, Medecins Sans Frontieres

Shelterproject.org /2004/, Оршин суудаг газраасаа шилжүүлэгдсэн хүн амын шилжилтийн үеийн суурьшилтын гарын авлага. Камбриж

НҮБ /1995/, Онцгой байдлын тусламжийн зүйл, Ерөнхий тайлбарын ном. Боть 1: Утсан харилцаа, оромж ба орон сууц, усны хангамж, хүнс, ариун цэвэр, эрүүл ахуй, материалын арилжаа, эрчим хүчний хангамж. Копенгаген. НҮБ, Агентлаг хоорондын бараа, үйлчилгээ худалдан авах үйлчилгээний газар

UNDRO /1982/, Гамшгийн дараахь оромж: Тусламжийн гарын авлага. Женев. UNDRO

UNDRO /1996/, Байгаль орчны гарын авлага. Женев. UNHCR

UNHCR /2002/, Дүрвэгсдийн лагерийн амьдралын мөчлөгийг байгаль орчны талаас нь авч үзэх нь. Женев, UNHCR

UNHCR /1993/, Сайжруулсан оромжоор хангах хариу арга хэмжээ, дүрвэгсдийн орчин сэдэвт олон улсын анхдугаар семинар. Женев. UNHCR

UNHCR /1991/, Дүрвэгч эмэгтэйчүүдийг хамгаалах тухай гарын авлага. Женев. UNHCR

UNHCR /1999/, Онцгой байдлын тухай гарын авлага. Женев. UNHCR

UNHCR /2001/, Настай дүрвэгсдийн талаарх бодлого: Дүрвэгсдэд зориулсан хөрөнгө нөөц. Женев. UNHCR

UNHCR /1998/, Дүрвэгсдийн үйл ажиллагаа ба байгаль орчны менежмент: Шийдвэр гаргах үндсэн зарчмууд. Женев. UNHCR

UNHCR /1995/, Дүрвэгсдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл. Женев. UNHCR

USAID /1994/, Гамшгийн судалгаа, хариу арга хэмжээний тухай газар дээр нь хэрэгжүүлэх үйл ажиллагааны гарын авлага. USAID, Гадаадын гамшгийн тусламжийн газар

Zetter, R /1995/, Оромжоор хангах ба дүрвэгсдийг суурьшуулах бодлого. Онцгой байдал, гамшгийн тусламжийн 2 дахь судлагаа. Швед, Норисагийн Африкийн хүрээлэн

Zetter, R, Hamdi, N, Ferretti, S /2003/, Дээврээс эхлээд дахин нэгдэх хүртэл. Женев, Шведийн хөгжил, хамтын ажиллагааны агентлаг SDC

246

247-248 Тэмдэглэл

**5 дугаар бүлэг: Эрүүл мэндийн үйлчилгээний
минимум стандартууд**

249

Энэхүү бүлгийг хэрхэн ашиглах тухай

Энэхүү бүлэг нь Эрүүл мэндийн систем ба дэд бүтэц, Халдварт өвчний хяналт, Халдварт бус өвчний хяналт гэсэн 3 үндсэн хэсэгт хуваагдсан. Тус бүлгийн зохион байгуулалт нь гамшгийн үеийн эрүүл мэндийн үйлчилгээний боловсруулалт, хэрэгжилт, мониторинг, үнэлгээний системийн аргыг дэмжсэн. Энэ бол эн тэргүүний эрүүл мэндийн хэрэгцээг үр ашигтай, үр дүнтэй тодорхойлж хангах нөхцлийг бүрдүүлэх хамгийн найдвартай арга юм. Энэхүү бүлэгт үндэсний ба орон нутгийн эрүүл мэндийн систем, зохицуулалт, стандартчилал зэрэг зарчмуудыг онцолж авч үзсэн.

Хэсэг бүр дараахь зүйлийг агуулсан. Үүнд:

- Минимум стандартууд: эдгээр нь шинж чанарын хувьд чанарын стандартууд бөгөөд эрүүл мэндийн үйлчилгээг хангахад хүрэх наад захын түвшинг тусгасан.
- Үндсэн үзүүлэлтүүд: эдгээр нь тухайн стандартад хүрсэн эсэхийг харуулах “дохио” юм. Тэдгээр нь хөтөлбөрийн нөлөө буюу үр дүн, мөн үйл явц буюу хэрэглэж буй аргыг хэмжих, дамжуулах аргаар хангадаг.
- Заавар тэмдэглэл: эдгээрт янз бүрийн нөхцөл байдалд тухайн стандарт, үзүүлэлтүүдийг хэрэглэх явцад харгалзан үзэх тодорхой зүйл, практикийн хүндрэл бэрхшээлүүдийг шийдвэрлэх талаарх удирдамж, тэргүүлэх чиглэлийн асуудлаарх зөвлөгөө багтана. Тэдгээр нь мөн тухайн стандарт буюу үзүүлэлттэй холбоотой чухал асуудлуудыг хамарч яах аргагүй байдал, санал зөрөлдөөн, одоогийн мэдлэгт гарч буй цоорхой тайлбарлаж болно.

Тус бүлгийн төгсгөл дэх хавсралтууд судалгааг шалгах хуудас, мэдээлэл цуглуулах маягтийн загвар, нас баралт, өвчлөлтийг тооцож томъёо, энэхүү бүлэгтэй холбоотой ерөнхий асуудал ба тодорхой техникийн асуудлуудын мэдээллийн эх сурвалжийг заасан ашиглах материалын жагсаалтыг багтаасан.

Агуулга

Оршил	252
1. Эрүүл мэндийн систем ба дэд бүтэц	258
2. Халдварт өвчний хяналт	273
3. Халдварт бус өвчний хяналт	285
Хавсралт 1: Эрүүл мэндийн үйлчилгээг үнэлэх асуултууд	295
Хавсралт 2: Долоо хоног тутмын хяналтын тайлангийн маягтын загвар	298

Хавсралт 3: Нас баралт, өвчлөлтийг тооцох томъёо	301
Хавсралт 4: Ном зүй	304

Эрүүл мэндийн үйчилгээ		
Эрүүл мэндийн систем ба дэд бүтэц	Халдварт өвчний хяналт	Халдварт бус өвчний хяналт
Стандарт 1 Эрүүл мэндийн үйлчилгээний тэргүүлэх чиглэлийг тогтоох	Стандарт 1 Урьдчилан сэргийлэх	Стандарт 1 Гэмтэл

Стандарт 2 Үндэсний ба орон нутгийн эрүүл мэндийг төвийг дэмжих	Стандарт 2 Улаан бурхнаас урьдчилан сэргийлэх	Стандарт 2 Нөхөн үржихүйн эрүүл мэнд
Стандарт 3 Зохицуулалт	Стандарт 3 Оношлол, тохиолдлын менежмент	Стандарт 3 Эрүүл мэндийн сэтгэхүй, нийгмийн асуудал
Стандарт 4 Анхан шатны эрүүл мэндийн халамж	Стандарт 4 Өвчин гарахад бэлтгэлтэй байх	Стандарт 4 Архаг өвчин
Стандарт 5 Эмнэлгийн үйлчилгээ	Стандарт 5 Өвчний гаралтыг илрүүлэх, шалгах, хариу арга хэмжээ авах	
Стандарт 6 Эрүүл мэндийн мэдээллийн систем	Стандарт 6 ХДХВ/ДОХ	
Хавсралт 1: Эрүүл мэндийн үйлчилгээг үнэлэх асуултууд		
Хавсралт 2: Долоо хоног тутмын хяналтын тайлангийн маягтын загвар		
Хавсралт 3: Нас баралт, өвчлөлтийг тооцох томъёо		
Хавсралт 4: Ном зүй		

Оршил

Олон улсын эрх баримт бичгүүдтэй холбогдох нь

Эрүүл мэндийн үйлчилгээний минимум стандартууд нь Хүмүүнлэгийн дүрэмд заасан зарчим, эрхийн практикийн илрэл юм. Хүмүүнлэгийн хууль нь олон улсын хүний эрх, хүмүүнлэг, дүрвэгсдийн хуульд гол хэсэгт заасны дагуу гамшиг буюу мөргөлдөөнд нэрвэгдсэн хүмүүсийн амь нас, нэр төрийг хадгалахад тавигдах хамгийн анхан шатны шаардлагуудтай холбоотой.

Хүн бүр хэд хэдэн олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд хүлээн зөвшөөрсний дагуу эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй. Энэ нь эрүүл мэндийн халамж төдийгүй баталгаатай ус, хангалттай ариун цэврийн арга хэрэгслийг хүртэх боломж, баталгаатай хүнс, тэжээл, орон сууцаар хангалттай хангагдах, эрүүл орчин нөхцөл, эрүүл мэндтэй холбоотой боловсрол, мэдээлэл хүртэх боломж, ялгаварлан гадуурхагдахгүй байх, хүний нэр төр, хувь хүний үнэ цэнийг бататгах зэрэг бусад хүний эрхийг хангах асуудлыг хамарсан эрүүл мэндийн гол тодорхойлогчдыг тэгш хүртэх боломжтой байх эрхийг хамаардаг.

Гагцхүү хүн амыг хамгаалсан, эрүүл мэндийн халамжийн системийг хариуцсан мэргэжилтнүүд

сайтар дадлагажсан, түгээмэл ёс зүйн зарчим, мэргэжлийн стандартад тууштай, тэдний ажилладаг систем нь хэрэгцээний наад захын стандартыг хангахад зориулагдсан, төр нь аюулгүй байдал, тогтвортой байдлын эдгээр нөхцлийг бий болгож хангах хүсэл эрмэлзлэлтэй тохиолдолд л эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангаж болно. Нэр төр, шударга ёс, хувь хүний эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах төр, төрийн бус оролцогчдын хүлээх үүргийн асуудал нь энэхүү хүний эрхийн төлөв байдалд зайлшгүй хэрэгтэй. Зэвсэгт мөргөлдөөний үед иргэний эмнэлэг, эмнэлгийн байгууламжууд ямар ч тохиолдолд дайралтын талбар болж болохгүй бөгөөд эрүүл мэнд, эмнэлгийн ажилтнууд хүндлүүлэх, хамгаалуулах эрхтэй.

Энэхүү бүлэгт заасан наад захын стандартууд нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн бүрэн илэрхийлэл биш юм. Гэхдээ тухайн хүрээний стандарт нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн гол агуулгыг илэрхийлж энэхүү эрхийн дэлхийн хэмжээнд дэвшилттэй хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.

Гамшгийн үеийн эрүүл мэндийн үйлчилгээний ач холбогдол

Эрүүл мэндийн халамж нь гамшгийн эхний шатуудад амьд үлдэх явдлын чухал тодорхойлогч юм. Гамшиг нь бараг цаг үргэлж хүн амын эрүүл мэнд, нэрвэгдсэн хүн амын эрүүл мэндэд ихээхэн нөлөө үзүүлдэг. Хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг шууд /жишээлбэл, гэмтэл, сэтгэхүйн гэмтэл согог/ буюу шууд бус /жишээлбэл, халдварт өвчин нэмэгдэх, тэжээлийн дутагдал, архаг өвчний хүндрэл/ гэж дүрсэлж болно. Эдгээр шууд бус эрүүл мэндийн нөлөө нь ер нь усны хангалтгүй тоо хэмжээ, чанар, ариун цэврийн нөхцлийн доройтол, хүнсний хангамжийн тасалдал, эрүүл мэндийн үйлчилгээний тасалдал, хүн амын хэт бөөгнөрөл, хүн амыг шилжүүлэх зэрэг хүчин зүйлүүдтэй холбоотой байдаг.

Гамшгийн эсрэг хүмүүнлэгийн хариу арга хэмжээний үндсэн зорилго нь 1/ хэт нас баралт, өвчлөлтөөс урьчилан сэргийлэх, бууруулах, 2/ хэвийн байдалд нь оруулах явдал юм. Төрөл бүрийн гамшиг нь нас баралт, өвчлөлт /257 дугаар хуудасны хүснэгтийг үзнэ үү/-ийн янз бүрийн хэмжээ, хэв маягтай нөхцөлдөж байдаг бөгөөд тиймээс гамшигт нэрвэгдсэн хүн амын эрүүл мэнд, эмнэлгийн хэрэгцээ гамшгийн төрөл, хамрах хүрээний дагуу хэлбэлзэж байдаг.

Эрүүл мэндийн үйлчилгээний тэргүүлэх чиглэлийг тогтоохын тулд гамшигт нэрвэгдсэн хүн амын өмнөх эрүүл мэндийн байдал, хэрэгцээ, эрүүл мэндийн эрсдэл, хөрөнгө нөөц, чадварын талаар тодорхой ойлголттой болох шаардлагатай. Гамшгийн эхний үе шатуудад мэдээлэл бүрэн биш байж болох бөгөөд хүн амын эрүүл мэндийн талаарх чухал шийдвэрийг олдоцтой буюу задлан шинжилсэн бүх холбогдох мэдээлэлгүй хийх хэрэгтэй болж болох юм. Тиймээс гамшгийн хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, хүн амын эрүүл мэндийн эн тэргүүний хэрэгцээ, орон нутгийн хөрөнгө нөөцийн хүрэлцээ, гадны тусламжийн талаар тавигдах шаардлагыг тодорхойлохын тулд хүн амын төлөөлөгчдийг хамруулсан төрөл бүрийн салбарын судалгааг аль болох хурдан хийх хэрэгтэй /анхан шатны судалгааны стандартыг 29 дүгээр хуудас, хавсралт 1-ээс үзнэ үү/.

Ер нь хүн амын эрүүл мэндийн эн тэргүүний арга хэмжээ нь эрүүл мэндийн хамгийн их хэмжээний үр нөлөөг хамгийн олон хүнд үзүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэнэ. Боломжтой бол эрүүл мэндийн арга хэмжээ нотлох баримтад тулгуурласан практикийн зарчимд тулгуурлах хэрэгтэй: хүн амын эрүүл мэндэд мэдэгдэхүйц үр нөлөөтэй арга хэмжээг илүүд үздэг. Ийм арга хэмжээнд гол төлөв хангалттай хэмжээтэй баталгаатай ус, ариун цэврийн нөхцөл, тэжээлийн үйлчилгээ, хүнсний тусламж/хүнсний аюулгүй байдал, оромж, анхан шатны эмнэлгийн халамж багтдаг. Урьдчилан сэргийлэх ба эмнэлгийн үйлчилгээ нь гол төлөв халдварлаж болох өвчинд хяналт тавихад чиглэх ёстой.

254

Нийтийг хамарсан улаан бурхны кампанит ажил нь улаан бурхан гарах эрсдэлтэй хүн ам, ялангуяа дүрвэгсэд, хүнд онцгой байдалд нэрвэгдсэн дүрвэгсдийн хувьд гол эн тэргүүний арга хэмжээ байх болно. Ихэнх гамшигтай газруудад хүргэх үйлчилгээ, эмнэлэгт үзүүлэх халамж чухал хэдий боловч хүн амын эрүүл мэндэд анхан шатны эрүүл мэндийн халамжийн арга хэмжээнээс бага нөлөө үзүүлдэг.

Гамшигт нэрвэгдсэн хүн ам эрүүл мэндийн үйлчилгээг боловсруулах, хэрэгжүүлэх, мониторинг хийх, үнэлгээ өгөхөд оролцох зайлшгүй хэрэгтэй юм. Энэ үед эрүүл мэндийн салбарын одоогийн чадавхийг тодорхойлох, бий болгох талаар хүчин чармайлт хэрэгтэй. Орон нутгийн чадавхийг гамшигт нэрвэгдсэн хүн амтай хамтран бий болгох нь хүн амд гамшгаас гарах, өөрсдийгөө цаашдын гамшигт бэлтгэхэд туслах хамгийн үр дүнтэй арга байж болно. Дүрвэгсэд, дотоодод оршин суудаг газраасаа шилжүүлэгдсэн хүмүүс /ДОСГШХ/ хүлээн авч буй хүн амын эрүүл мэндийн үйлчилгээнд нэмэлт ачаалал өгөх төлөвтэй байдаг. Тиймээс хүмүүнлэгийн хүчин чармайлт аль болох хүлээн авч буй хүн амын эрүүл мэндийн үйлчилгээтэй нэгдэх, дэмжлэг үзүүлэхэд чиглэх хэрэгтэй.

Ихэнх гамшгийн нөхцөлд эмэгтэйчүүд, хүүхдүүд эрүүл мэндийн халамжийн үйлчилгээний гол хэрэглэгчид байдаг бөгөөд эмэгтэйчүүдийн саналыг үйлчилгээг гамшигт нэрвэгдсэн нийт хүн амын хувьд шударга, тохиромжтой, хүртээмжтэй байх нөхцлийг бүрдүүлэх хэрэгсэл болгохыг эрмэлзэх нь чухал юм.

Эмэгтэйчүүд эрүүл мэндэд нөлөөлөх соёлын хүчин зүйл, зан заншил, мөн гамшигт нэрвэгдсэн хүн амын доторх эмзэг хүмүүсийн онцлог хэрэгцээг ойлгоход хувь нэмрээ оруулж чадна. Тиймээс тэд эрүүл мэндийн халамжийн үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд анхнаас нь идэвхтэй оролцох хэрэгтэй юм.

Бусад бүлгүүдтэй холбогдох нь

Бусад салбарын бүлгүүдэд байгаа ихэнх стандарт энэхүү бүлэгтэй холбоотой юм. Нэг салбар дахь стандартад хүрсэн ахиц дэвшил нь байнга нөгөө салбарууд дахь ахиц дэвшилд нөлөөлж бүр тодорхойлж байдаг. Хариу арга хэмжээг үр дүнтэй болгохын тулд бусад салбаруудтай ойр дотно зохицуулалт хийж хамтран ажиллах шаардлагатай. Орон нутгийн байгууллагууд, бусад хариу арга хэмжээ авч буй агентлагуудтай зохицуулалт хийх нь мөн хэрэгцээг хангах, хүчин чармайлтыг давхардуулахгүй байх, эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг боловсронгуй болгох нөхцлийг бүрдүүлэхэд зайлшгүй хэрэгтэй юм. Бусад мэргэжлийн бүлгүүдэд холбогдох газар нь тодорхой стандарт буюу удирдамжийн тэмдэглэлийг оруулсан болно.

255

Бүх салбарт түгээмэл стандартуудтай холбогдох холбоо

Хариу арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлж буй үйл явц түүнийг үр дүнтэй болгоход чухал юм. Энэхүү бүлгийг оролцоо, эхний судалгаа, хариу арга хэмжээ, чиглэл, мониторинг, үнэлгээ, тусламжийн ажилчдын ур чадвар, үүрэг хариуцлага, удирдлага, менежмент, боловсон хүчний дэмжлэгийг /1 дүгээр бүлгийн 21 дүгээр хуудсыг үзнэ үү/ хамарч буй бүх салбарт түгээмэл стандартуудтай хослуулан хэрэглэх хэрэгтэй. Ялангуяа, аливаа хариу арга хэмжээний тухайд тохиромж, чанарыг хангах үүднээс түүний дээр дурьдсан эмзэг хүмүүсийг оролцуулан гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй.

Гамшигт нэрвэгдсэн хүн амын эмзэг байдал ба чадавхи

Онцгой байдлын үед хамгийн их эрсдэлд ордог хэсэг бол эмэгтэйчүүд, хүүхдүүд, настай хүмүүс, тахир дутуу хүмүүс, ХДХВ/ДОХ-той хүмүүс байдаг. Зарим тохиолдолд хүмүүс мөн үндэс угсаа, шашны буюу улс төрийн харьяалал эсвэл оршин суудаг газраасаа шилжүүлэгдсэн зэрэг шалтгаанаар эмзэг болж болно. Энэ нь ийм жагсаалт дуусч буй хэрэг бус мөн хамгийн их тодорхойлогдож байдаг хүмүүс багтдаг. Тодорхой эмзэг байдал нь хүмүүсийн гамшгийн үед аргаа олох, амьд гарах чадварт нөлөөлдөг бөгөөд хамгийн их эрсдэлд орсон хүмүүсийг нөхцөл бүрд нь тодорхойлох хэрэгтэй.

Гарын авлагын туршид “эмзэг хэсэг” гэсэн нэр томъёо нь эдгээр бүх хэсгийг хэлнэ. Аль нэг хэсэг

эрсдэлд орж байхад бусад нь мөн аюул заналд орох төлөвтэй байдаг. Тиймээс эмзэг бүлэг дурьдагдах бүрд хэрэглэгчид энд жагсаасан бүх хүмүүсийг авч үзэхийг хичээнгүйлэн хүсч байна. Тусгай халамжийг ялгаварлан гадуурхалгүй, тэдний онцлог хэрэгцээний дагуу гамшигт нэрвэгдсэн бүх хэсгийг хамгаалах, хангах зорилгоор үзүүлэх ёстой. Гэхдээ гамшигт нэрвэгдсэн хүн ам аргаа олох өөрийн чадвар, чадавхитай байх, олж авах ба тийм чадвар, чадавхийг хүлээн зөвшөөрч дэмжих ёстой гэдгийг мөн сануулах хэрэгтэй юм.

256

Сонгож авсан гамшгийн хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөө					
Нөлөө	Хүнд онцгой байдал	Газар хөдлөлт	Өндөр хурдтай салхи /үергүй/	Үер	Давалгаат үер/цунами
Нас баралт	Их	Их	Цөөн	Цөөн	Их
Хүнд гэмтэл	Янз бүр	Их	Багавтар	Цөөн	Цөөн
Халдварт өвчний өндөр эрсдэл	Өндөр	Бага	Бага	Янз бүр	Бага
Хүнсний хомсдол	Хэвийн	Ховор	Ховор	Янз бүр	Түгээмэл
Хүн амыг олноор оршин суугаа газраас нь шилжүүлэх	Хэвийн /хүнд хохирол үзсэн хот суурин газруудад гарч болно/	Ховор	Ховор	Түгээмэл	Янз бүр

Эх сурвалж: Пан Америкийн эрүүл мэндийн байгууллага, Байгалийн гамшгийн дараахь онцгой

байдлын эрүүл мэндийн менежмент. Онцгой байдлын бэлэн байдал, гамшгийн тусламжийн зохицуулалтын газар: Вашингтон, Пан Америкийн эрүүл мэндийн байгууллага, шинжлэх ухааны хэвлэл 47, 1981.

NB: Гамшгийн тодорхой төрлүүдийн хувьд ч нас баралт, өвчлөлтийн хэв маяг нөхцөл бүрд үлэмж хэлбэлзэж байдаг. Жишээлбэл, барилгын код хэрэгжүүлэх нь газар хөдлөлттэй холбоотой нас баралт, хүнд гэмтлийн тоог эрс бууруулах боломжтой. Зарим хүнд онцгой байдалд халдварт өвчин, тэжээлийн дутагдал нас баралт, өвчлөлтийн үндсэн шалтгаан болж байхад бусад тохиолдолд аюултай гэмтэл нас баралт, өвчлөлтийн өсөлтийн үндсэн шалтгаан болдог архаг өвчний хүндрэл нь үндсэн шалтгаан болж байдаг.

257

Минимум стандартууд

1. Эрүүл мэндийн систем ба дэд бүтэц

Нас баралт байнга нэмэгдэх буюу даруй ийм болж болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээний үед эн тэргүүний хүмүүнлэгийн хариу арга хэмжээ нь анхан шатны эмнэлгийн халамжийг оролцуулан яаралтай амьд гарах хэрэгцээнд анхаарах ёстой. Амьд гарах хэрэгцээ хангагдсан тохиолдолд эрүүл мэндийн илүү өргөн хүрээтэй үйлчилгээг боловсруулах хэрэгтэй. Хариу арга хэмжээний бүх үе шатанд эрүүл мэндийн үйлчилгээг боловсруулах, хэрэгжүүлэх, мониторинг хийх, үнэлгээ өгөх эрүүл мэндийн системийн аргууд нь хамгийн чухал хэрэгцээг хангах, хамарч буй үйлчилгээ тохиромжтой байх, үйлчилгээ авах боломж тохиромжтой байх, чанарыг дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

Цаашид авч үзэх стандартууд нь бүх гамшгийн нөхцөлд хэрэглэгдэх хэдий боловч хөрөнгө нөөц муутай нөхцөлд ялангуяа хамааралтай. Тэдгээр нь ер нь гамшгийн хариу арга хэмжээний үед гамшигт нэрвэгдсэн хүн ам сайн чанарын эрүүл мэндийн үйлчилгээ авах боломжтой байх нөхцлийг бүрдүүлэхэд чиглэдэг. Эрүүл мэндийн дэд бүтэц, үйлчилгээ ихээхэн тасалдсан үед гамшгийн дараахь эрүүл мэндийн үйлчилгээний тогтвортой байдлыг дээшлүүлэх нь нэн чухал юм. Гэхдээ тогтвортой байдлыг хангах нь улс төр, менежмент, байгууллага, санхүү, техникийн зэрэг олон төрлийн хүчин зүйлийг авч үзэхийг шаарддаг тул энэ нь энэхүү баримт бичгийн хамрах хүрээнээс давж гарсан юм. Эрүүл мэндийн агентлагууд, ажилтнууд гамшгийн хариу арга хэмжээний үед гаргасан шийдвэрүүд үйлчилгээний урт хугацааны

тогтвортой байдлыг дээшлүүлэх эсвэл бууруулахад тус дөхөм үзүүлж болно гэдгийг санаж байх ёстой.

258

Эрүүл мэндийн систем ба дэд бүтцийн стандарт 1: Эрүүл мэндийн үйлчилгээний тэргүүлэх чиглэлийг тогтоох

Бүх хүн их хэмжээний нас баралт, өвчлөлтийн гол шалтгааныг авч үзэх зорилгоор эн тэргүүнд тавьсан эрүүл мэндийн үйлчилгээг авах боломжтой.

Үндсэн үзүүлэлтүүд /заавар тэмдэглэлтэй холбож унших/

- Нас баралт, өвчлөлтийн гол шалтгааныг тодорхойлж, баримтжуулж, мониторинг хийдэг.
- Тэргүүлэх чиглэлийн эрүүл мэндийн үйлчилгээнд их хэмжээний нас баралт, өвчлөлтийг бууруулах хамгийн тохиромжтой, үр дүнтэй арга хэмжээ хамаардаг / заавар тэмдэглэл 1/.
- Эмзэг хэсэг зэрэг хүн амын бүх гишүүд тэргүүлэх чиглэлийн эрүүл мэндийн үйлчилгээг авах боломжтой / заавар тэмдэглэл 2/.
- Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд, хүн амын гишүүд тэргүүлэх чиглэлийн эрүүл мэндийн арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцдог.
- Ус, ариун цэвэр, хүнсний аюулгүй байдал, тэжээл, оромж, хамгаалалт зэрэг тэргүүлэх чиглэлийн эрүүл мэндийн арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд бусад салбаруудтай идэвхтэй хамтран ажилладаг.
- Барагцаалсан нас баралт /БНБ/-ыг гамшгийн өмнөх хүн амд баримтжуулсан үндсэн хэмжээнээс 2 дахин байхаас доогуур байлгах буюу тийм хэмжээнд бууруулдаг / заавар тэмдэглэл 3/.

- 5-аас доош насны нас баралт /5-ДННБ/-ыг гамшгийн өмнөх хүн амд баримтжуулсан үндсэн хэмжээнээс 2 дахин байхаас доогуур байлгах буюу тийм хэмжээнд бууруулдаг / заавар тэмдэглэл 3/.

Заавар тэмдэглэл

1. Тэргүүлэх чиглэлийн эрүүл мэндийн арга хэмжээ нь гамшгийн төрөл, нөлөөг оролцуулан тухайн нөхцлөөс хамааран хэлбэлзэж байдаг. Эдгээр арга хэмжээг боловсруулах асуудлыг хүн амын эрүүл мэндийн зарчимд тулгуурлах нь эрүүл мэндийн хамгийн их хэмжээний үр нөлөөг хамгийн олон хүнд үзүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

259

Тэргүүлэх чиглэлийн хүн амын эрүүл мэндийн арга хэмжээнд баталгаатай ус, ариун цэврийн нөхцөл, хүнс, оромжийн хүрэлцээтэй хангамж, халдварт өвчний хяналт /жишээлбэл, улаан бурханы вакцин/, анхан шатны эмнэлгийн халамж, өвчний хяналт багтдаг. Газар хөдлөлт зэрэг их хэмжээний гэмтэлтэй холбоотой гамшгийн дараахь гэмтлийн халамж үйлчилгээ зэрэг өргөжүүлсэн эмнэлгийн үйлчилгээнд нэн тэргүүний ач холбогдол өгдөг.

2. Эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж: ийм боломж нь аливаа байдлаар ялгаварлан гадуурхалгүй хэрэгцээний дагуу тэнцүү боломж олгох нөхцлийг бүрдүүлж тодорхой хэсгийг хамрагдахгүй байх байдалд хүргэж болох шударга ёсны зарчимд үндэслэгдсэн байх хэрэгтэй. Практик дээр эрүүл мэндийн үйлчилгээний байршуулах, ажилтнуудаар хангах ажлыг сайн боломж, хамралтыг хангах байдлаар зохион байгуулах хэрэгтэй. Эрүүл мэндийн үйлчилгээг боловсруулах явцад бэлэн боломжоор хангагдаагүй байж болох эмзэг бүлгийн тодорхой хэрэгцээг авч үзэх хэрэгтэй. Хэрэглэгчийн хураамж авч буй тохиолдолд ийм хураамжийг төлөх чадваргүй хэсэг тухайлбал, хураамжаас чөлөөлөх, тасалбар олгох зэрэг арга хэмжээний үр дүнд боломжоор хангагдсан байх нөхцлийг бүрдүүлэхийн тулд зохицуулалт хийх хэрэгтэй.

3. Барагцаалсан нас баралт ба 5-аас доош насны нас баралт: өдөр тутмын барагцаалсан нас баралт /БНБ/ нь гамшгийн нөхцөл байдалд мониторинг хийх хамгийн тодорхой, ач тустай эрүүл мэндийн үзүүлэлт юм. Үндсэн БНБ 2 дахин нэмэгдэх нь яаралтай хариу арга хэмжээг авахыг шаардсан хүн амын

эрүүл мэнд онцгой байдлыг харуулдаг. Буурай хөгжилтэй улс орнуудын хувьд дундаж үндсэн БНБ нь Дэд Сахарын Африкт 0.44 байхад барагцаагаар 0.38 нас баралт/өдөрт 10,000 хүн байдаг. Аж үйлдвэржсэн улс орнуудын хувьд дундаж үндсэн БНБ нь барагцаагаар 0.25 нас баралт/өдөрт 10,000 байдаг. Үндсэн нас баралт тодорхой бус байх үед эрүүл мэндийн агентлагууд БНБ-ыг 1.0/өдөрт 10,000-аас доогуур байлгахыг зорих хэрэгтэй. Буурай хөгжилтэй улс орнуудын хувьд 5-аас доош насны нас баралт /5-ДННБ/ Дэд Сахарын Африкт 1.14 байхад барагцаагаар 1.03 нас баралт/өдөрт 10,000 5-аас доош нас/хүн байдаг. Аж үйлдвэржсэн улс орнуудын хувьд ийм нас баралт барагцаагаар 0.04/өдөрт 10,000 5-аас доош нас/хүн байдаг. 5-ДННБ тодорхой бус байх үед агентлагууд ийм нас баралтыг 2.0/өдөрт 10,000 5-аас доош нас-аас доогуур байлгахыг зорих хэрэгтэй /хавсралт 2, 3, эсрэг талын хүснэгтийг үзнэ үү/.

Үндсэн лавлах нас баралтын мэдээлэл бүс нутгаар				
Бүс нутаг	БНБ	БНБ	5-ДННБ	5-ДННБ
Дэд Сахарын Африк	0.44	0.9	1.14	2.3
Ойрхи Дорнод, хойд Африк	0.16	0.3	0.36	0.7
Өмнөд Ази	0.25	0.5	0.59	1.2
Зүүн Ази ба Номхон далай	0.19	0.4	0.24	0.5
Латин Америк, Карибын тэнгис	0.16	0.3	0.19	0.4
Төв, зүүн Европын бүс нутаг/ТТҮОХН ба Балтийн улс орнууд	0.30	0.6	0.20	0.4
Аж үйлдвэржсэн улс орнууд	0.25	0.5	0.04	0.1
Хөгжиж буй улс орнууд	0.25	0.5	0.53	1.1
Буурай хөгжилтэй улс орнууд	0.38	0.8	1.03	2.1
Дэлхий	0.25	0.5	0.48	1.0

Эх үүсвэр: НҮБ-ын Хүүхдийн сан, 2003 он, Дэлхийн хүүхдүүдийн төлөв байдал /2001 оны мэдээллээс/.

Эрүүл мэндийн систем ба дэд бүтцийн стандарт 2: Үндэсний ба орон нутгийн эрүүл мэндийг төвийг дэмжих

Эрүүл мэндийн үйлчилгээ одоогийн эрүүл мэндийн систем, бүтэц, үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжихэд чиглэдэг.

Үндсэн үзүүлэлтүүд / заавар тэмдэглэлтэй холбож унших/

- Эрүүл мэндийн яамны төлөөлөгчид боломжтой л бол эрүүл мэндийн хариу арга хэмжээг удирдаж байдаг.
- Эрүүл мэндийн яаманд шаардлагатай чадавхи дутагдаж байвал шаардлагатай чадвартай адилтгах агентлагийг эрүүл мэндийн салбарыг удирдуулахаар тодорхойлдог / заавар тэмдэглэл 1-2/.

261

- Орон нутгийн эрүүл мэндийн байгууламжуудыг хариу арга хэмжээ авч буй агентлагууд дэмжиж бэхжүүлж байдаг /заавар тэмдэглэл 12/.
- Орон нутгийн эрүүл мэндийн ажилтнуудыг дэмжиж хүйс, үндэс угсааны тэнцвэрийг нь харгалзан эрүүл мэндийн үйлчилгээнд оруулдаг /заавар тэмдэглэл 3/.
- Эрүүл мэндийн үйлчилгээ нь гамшигт нэрвэгдсэн эсвэл хүлээн авч буй улс орны одоогийн үндэсний стандарт, удирдамжийг тусгах буюу хүлээн авдаг /заавар тэмдэглэл 4/.
- Орон нутгийн чадавхийг нэмэгдүүлээгүй буюу хүн ам нь одоогийн үйлчилгээ боломжгүй болоогүй тохиолдолд гадаадын салбар эмнэлэг зэрэг адилтгах эрүүл мэндийн байгууламж, үйлчилгээ гаргадаггүй /заавар тэмдэглэл 5/.

Заавар тэмдэглэл

1. Эрүүл мэндийн голлогч байгууллага: Эрүүл мэндийн яам /ЭМЯ/ эрүүл мэндийн удирдах байгууллагын үүргийг хэрэгжүүлэх чадваргүй тохиолдолд ер нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

/ДЭМБ/, НҮБ-ийн Дүрвэгсдийн Дээд комиссар /НҮБДДК/, НҮБ-ын Хүүхдийн сан зэрэг НҮБ-ын агентлаг энэ үүрэг хариуцлагыг авч ажиллана. ЭМЯ, НҮБ-ын агентлагууд бүс нутаг, дүүрэг буюу орон нутгийн түвшинд чадавхи дутагдах тохиолдолд өөр нэг оролцогч агентлаг түр ч атугай үйл ажиллагааг зохицуулах шаардлагатай болно. Эрүүл мэндийн удирдах байгууллага хариу арга хэмжээ авч эрүүл мэндийн байгууллагууд орон нутгийн эрүүл мэндийн системийн чадавхийг дэмжиж бэхжүүлэх нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй. Түүнээс гадна эрүүл мэндийн удирдах байгууллага нь эрүүл мэндийн агентлагуудын үйл ажиллагаа зохицуулагдаж нөхөгдсөн байх нөхцлийг бүрдүүлэх асуудлыг хариуцна.

2. Эрүүл мэндийн салбарын стратеги ба бодлого: Эрүүл мэндийн удирдах байгууллагын нэг чухал үүрэг хариуцлага бол эрүүл мэндийн салбарын онцгой байдлын хариу арга хэмжээний стратеги, бодлогыг боловсруулах явдал юм. Бодлогын баримт бичгийг эрүүл мэндийн салбарын тэргүүлэх чиглэл, зорилтыг тусгаж тэдгээрт хүрэх цар хүрээг харуулсан байх байдлаар хийх хэрэгтэй. Энэхүү баримт бичгийг холбогдох агентлаг, хүн амын төлөөлөгчидтэй зөвлөлдсөний дараа боловсруулах хэрэгтэй.

3. Орон нутгийн эрүүл мэндийн ажилчид: Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд, дадлагажсан/уламжлалт төрөх газрын ажилтнууд зэрэг гамшигт нэрвэгдсэн хүн амын бусад эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг боломжтой үед нь эрүүл мэндийн үйлчилгээнд нэгтгэж байх хэрэгтэй. Хүйсний тэгш байдлыг байнга илүүтэйд үздэг хэдий боловч эрүүл мэндийн халамжийг үзүүлэгчдийн дотор нэг хүйс давамгайлдаг газар зөрүүтэй байж болох юм.

4. Үндэсний стандарт ба удирдамж: Ерөнхийдөө агентлагууд эмчилгээний протокол, хэрэгцээт эмийн жагсаалт зэрэг гамшгийн эсрэг хариу арга хэмжээг хэрэгжүүлж буй улс орны эрүүл мэндийн стандарт, удирдамжийг мөрдөж ажиллах хэрэгтэй /эрүүл мэндийн систем, дэд бүтцийн стандарт 5-ыг үзнэ үү/. Эдгээр стандарт, гарын авлагыг тэдгээрийн тохиромжтой эсэхийг тодорхойлохын тулд гамшгийн хариу арга хэмжээний өмнө ЭМЯ буюу эрүүл мэндийн удирдах байгууллагатай зөвлөлдөж нягталж үзэх хэрэгтэй. Тэдгээр нь хуучирсан эсвэл нотлох баримтад тулгуурласан практикийг тусгаагүй бол шинэчлэх хэрэгтэй.

5. Гадаадын талбарын эмнэлэг: Талбарын эмнэлэг нь тухайн орон нутгийн эмнэлэг нь зохих ёсоор ажиллахгүй байгаа үед эрүүл мэндийн халамжийг үзүүлэх цорын ганц арга байж болох юм. Гэхдээ одоогийн эмнэлгийг дахин ажиллах эхлэх буюу нэмэлт ачааллыг авч явах боломжтой болгох үүднээс тэдэнд хөрөнгө нөөц олгох нь ер нь илүү үр дүнтэй байдаг. Талбарын эмнэлгийг ослын гэмтлийн яаралтай тусламж /эхний 48 цагт/, ослын гэмтэл, энгийн онцгой байдалд хоёр дахь тусламж /3-15 өдөр/ эсвэл орон нутгийн эвдэрсэн эмнэлгийг сэргээн засварлах /хэдэн өдөрт/ хүртэл түүнийг орлох түр зуурын байгууламж байдлаар ажиллуулах нь тохиромжтой байж болно. Талбарын эмнэлгийг ажиллуулах нь

тохиромжтой эсэхийг тодорхойлохын тулд сайтар тодорхойлсон хэрэгцээ байх ёстой. Тухайн талбарын эмнэлэг нь тохирох үйлчилгээг үзүүлэх чадвартай байх ёстой. Энэ нь орон нутгийн хөрөнгө нөөцийг үрэх явдал байж болохгүй. Энэ нь зардлын хувьд үр дүнтэй байх ёстой.

Эрүүл мэндийн систем ба дэд бүтцийн стандарт 3: зохицуулалт

Хүмүүс дээд зэргийн үр дүнд хүрэхийн тулд агентлаг, салбаруудын хэмжээнд зохицуулагдаж байдаг эрүүл мэндийн үйлчилгээг авах боломжтой.

Үндсэн үзүүлэлтүүд: /заавар тэмдэглэлтэй холбож унших/

- Зохицуулалтын механизмыг эрүүл мэндийн салбарын хүрээнд төв /үндэсний ба бүс нутгийн/ ба салбарын түвшинд мөн эрүүл мэнд ба бусад салбаруудын хооронд бий болгосон.

- Эрүүл мэндийн байгууллага хэсэг бүрийн онцгой хариуцлагыг эрүүл мэндийн гол байгууллагатай зөвлөлдсөний үндсэн дээр тодруулж баримтжуулах ба ингэхдээ хүн амыг дээд хэмжээгээр хамруулахаас гадна үйлчилгээнүүдийн харилцан нөхсөн байдлыг баталгаажуулах ёстой (заавар тэмдэглэл 1).
- Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг зохицуулах тогтмол хурал цуглааныг орон нутгийн ба гадны түншүүдэд зориулан төвийн болон хээрийн/талбарын ажиллагааны түвшинд зохион байгуулдаг.

Заавар тэмдэглэл

1. Эрүүл мэндийн байгууллагуудын хоорондох зохицуулалт: эрүүл мэндийн гол байгууллага нь Эрүүл мэндийн яам юм уу өөр байгууллага байна уу гэдгээс үл хамааран эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа бүх байгууллагууд үйл ажиллагаагаа үндэсний болон орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээтэй зохицуулах ёстой. Дүрвэгсдийн

нөхцөлд эрүүл мэндийн байгууллагууд нь хүлээн авагч орны эрүүл мэндийн системд үйл ажиллагаагаа зохицуулах ёстой. Хэд хэдэн эрүүл мэндийн байгууллагууд талбарын нөхцөлд ажиллаж байгаа тохиолдолд тэдгээрийн үүрэг хариуцлагыг зохицуулан хуваарилснаар эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны цоорхой ба давхардлыг арилгах боломжтой болно.

2. Зохицуулах хурал цуглаан: эдгээр үйл мэдээллийг солилцох, гол асуудлуудыг тодорхойлж хянах, эрүүл мэндийн ерөнхий стратегиудыг боловсруулж хэрэгжүүлэх, тусгай үүргүүдийг хуваарилах, стандартчилсан гэрээ ба хөндлөнгийн оролцооны талаар тохиролцох форум хэлбэрээр зохион байгуулах ёстой. Эхэн үедээ хурал цуглааныг дор хаяж долоо хоног бүр явуулах нь зүйтэй.

Эрүүл мэндийн системүүд ба дэд бүтцийн стандарт: эрүүл мэндийн анхны тусламж
Эрүүл мэндийн үйлчилгээг зохих эрүүл мэндийн анхны тусламжийн зарчим дээр үндэслэнэ.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлтэй хамт уншина уу)

- Бүх хүмүүс өөрсдийн эрүүл мэнд ба сайн сайхан байдлыг хамгаалж сайжруулах тус болох эрүүл мэндийн талаархи мэдээллийг авна (заавар тэмдэглэл 1).
- Эрүүл мэндийн үйлчилгээг өрх гэр, хамт олон, алслагдсан газрын эрүүл мэндийн байгууламжууд, төвийн байгууламжууд, зөвлөгөө өгөх эмнэлэг гэх мэт зохих бүх түвшинд хангана (заавар тэмдэглэл 2).

264

- Стандарчлагдсан зөвлөгөө өгөх системийг эрүүл мэндийн гол байгууллага тогтоож эрүүл мэндийн байгууллагууд ашиглана. өвчтөнүүдийг зөвлөгөө өгөх газарт хүргэхэд тохиромжтой тээврийн хэрэгслээр хангана.
- Эрүүл мэндийн үйлчилгээ ба хөндлөнгийн оролцоо нь шинжлэх ухааны үндэслэлтэй арга дээр үндэслэх ба аль болох баримтаар баталгаажуулагдсан байна.
- Эрүүл мэндийн үйлчилгээ ба хөндлөнгийн оролцоонд нийгмийн болон соёлын хувьд хүлээн авч болохуйц зохих технологийг ашиглана.

Заавар тэмдэглэл

1. Эрүүл мэндийн мэдээлэл ба боловсрол: олон нийтийн эрүүл мэндийн боловсрол ба дэмжлэгийг орон нутгийн эрүүл мэндийн эрх бүхий байгууллага ба олон нийтийн төлөөлөгчидтэй зөвлөлдсөний үндсэн дээр хэрэгжүүлнэ. Ингэхдээ хүн амын дундах эрүүл мэндээ хайрлах хандлага эрүүл мэндийн талаархи итгэл үнэмшлийг тооцож үзэх ёстой. Энэ нь тухайн нутгийн онцлог, эрүүл мэндийн томоохон аюулууд, эрүүл мэндийн үйлчилгээг авах боломж, эрүүл мэндээ хамгаалж сайжруулах зан төлөвийн

талаархи мэдээллийг агуулсан байна. Олон нийтэд эрүүл мэндийн талаар мэдээлэл ба материалыг хүргэхдээ тохиромжтой хэл ба мэдээллийн хэрэгслийг ашиглах ба ингэхдээ тухайн соёлын онцлогийг харгалзах ёстой. эрүүл мэндийн талаархи чухал мэдээллүүдийн агуулга нь эрүүл мэндийн байгууллагуудын дунд нийцсэн байх ёстой.

2. **Хөдөлгөөнт эмнэлгүүд:** зарим гамшгийн үед анхаарал халамж хүртэх боломжоор хязгаарлагдмал тусгаарлагдсан юм уу шилжих хөдөлгөөнд байгаа хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг хангахын тулд хөдөлгөөнт эмнэлэг ажиллуулах шаардлагатай болж болно. Туршлагаас харахад ийм эмнэлгийг зохих шаардлагын дагуу ажиллуулвал амин чухал хэрэгцээг хангаж болдог. Зохих шаардлагын дагуу ажиллуулж чадахгүй бол хөдөлгөөнт эмнэлгийн ашиглалт буурч эрүүл мэндийн үйлчилгээг орлосноор хязгаарлагдмал эх үүсвэрүүдийг үр ашиггүй байдлаар зарцуулахад хүргэж болно. Тэдгээрийг эрүүл мэндийн төв байгууллага ба орон нутгийн эрүүл мэндийн салбарын төлөөлөгчидтэй зөвлөлдсөний дараа л ажиллуулах нь зүйтэй.

Эрүүл мэндийн системүүд ба дэд бүтцийн стандарт 5: эмнэлгийн үйлчилгээ

Хүмүүс стандартчилагдсан эмнэлгийн үйлчилгээг авах ба ингэхдээ хүлээн зөвшөөрөгдсөн протокол, зааварчилгааг мөрдөнө.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлийн хамт уншина уу)

- Эрүүл мэндийн байгууламжуудын тоо, түвшин, байрлал нь хүн амын хэрэгцээ шаардлагыг хангахад тохиромжтой байх ёстой (заавар тэмдэглэл 1-2).
- Эрүүл мэндийн байгууламжид ажиллаж байгаа ажилтнуудын тоо, ур чадвар, хүйс болон үндэс угсааны тэнцвэртэй байдал нь хүн амын хэрэгцээ шаардлагыг хангахад тохиромжтой байх ёстой (заавар тэмдэглэл 1-2).
- Ажилтнуудын тоог сонгохдоо нэг эмч өдөрт 50 дээшгүй хүн үзэхээр тохируулна. Хэрвээ энэ босгыг давсан бол шинээр эмч нэмж авна. хүн амын хэрэгцээ шаардлагыг хангахад тохиромжтой байх ёстой (хавсралт 3).
- Эрүүл мэндийн байгууламжуудын ашиглалтын түвшинг хянаж хэт их юм уу бага ачаалалтай бол залруулах арга хэмжээг авна хүн амын хэрэгцээ шаардлагыг хангахад тохиромжтой байх ёстой (заавар тэмдэглэл 3).

- Эрүүл мэндийн төв байгууллага нь тухайн нөхцөлд хамаарах стандартчилсан протоколыг боловсруулах ба үүнийг эрүүл мэндийн байгууллагууд мөрдөнө хүн амын хэрэгцээ шаардлагыг хангахад тохиромжтой байх ёстой (заавар тэмдэглэл 4).
- Эрүүл мэндийн төв байгууллага нь зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг боловсруулах ба үүнийг эрүүл мэндийн байгууллагууд мөрдөнө хүн амын хэрэгцээ шаардлагыг хангахад тохиромжтой байх ёстой (заавар тэмдэглэл 4).
- Протокол болон зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг мөрдөх талаар клиникийн ажилтнуудад сургалт явуулж хяналт тавина (заавар тэмдэглэл 5-6).
- Хүлээн зөвшөөрөгдсөн зааварчилгааны дагуу стандартчилсан эмийн менежментийн системээр дамжуулан хүмүүсийг зайлшгүй шаардлагатай эмийг тасралтгүй хангана (заавар тэмдэглэл 7).
- Эмийн хандивыг зөвхөн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн зааварчилгааны дагуу л өгнө. Эдгээр зааварчилгааг мөрдөхгүйгээр өгсөн эмийн хандивыг хэрэглэхгүй бөгөөд аюулгүй байдлаар устгана.

266

- Нас барсан хүмүүсийн цогцсыг хүндэтгэлтэй бөгөөд соёлын хувьд хүлээн авч болохуйц байдлаар олон нийтийн эрүүл мэндийн журмын дагуу устгана (заавар тэмдэглэл 8).

Заавар тэмдэглэл

1. **Эрүүл мэндийн байгууламжууд ба боловсон хүчин:** эрүүл мэндийн байгууламжийн тоо ба байрлал мөн бүх шатны боловсон хүчний тоо ба ур чадвар нөхцөл байдлаас шалтгаалж өөр өөр байдаг. Боловсон хүчин дунд ганц боловч эмэгтэй ажилтан эсвэл нэг угсаатны цөөнхий төлөөлөгч ороход эмэгтэйчүүд ба цөөнхий бүлгийн гишүүд эрүүл мэндийн үйлчилгээ авахад ихээхэн нөлөө үзүүлж болно. Зэвсэг авч явах гэх мэт эрүүл мэндийн байгууллагын төвийг байдалд аюул учруулах аливаа үйлдэл юм уу үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
2. **Боловсон хүчний түвшин:** дараахь удирдамж нь лавлаж тодруулах зорилгоор хэрэглэхэд тустай боловч нөхцөл байдлаас шалтгаалан зохицуулан өөрчлөх шаардлагатай байж болно. “өндөр мэргэшсэн эрүүл мэндийн ажилтан” гэдэг нэр

томъёо нь албан ёсоор сургалтанд хамрагдсан эмч, сувилагч, клиникийн ажилтан, эмнэлгийн туслах ажилтан гэх мэт клиникийн үйлчилгээ үзүүлдэг ажилтанг хэлнэ.

а. Үйлчлүүлэгчдийн тоо: нэг эрүүл мэндийн ажилтанд 500-1000 хүн, нэг ур чадвар бүхий уламжлалт эх баригчид 2000 хүн, 1 хянагч эмчид 10 гэрээр эмчлүүлэгч, нэг ахлах эмч байна.

б. Алслагдсан эрүүл мэндийн байгууламж нь (ойролцоогоор 10000 хүн) хоёроос таван ажилтан, доод тал нь нэг өндөр мэргэшсэн эрүүл мэндийн ажилтан, өдөрт нэг клиникийн эмч 50 үзлэг, шингэн нөхөх эмчилгээ, боолт, бүртгэл, зохион байгуулалт хариуцсан нарийн мэргэшээгүй ажилтнуудтай байна.

в. Төвлөрсөн газрын эрүүл мэндийн байгууламж нь (ойролцоогоор 50000 хүн) дор хаяж таван ажилтан, доод тал нь нэг их эмч, өдөрт 50 хүнд үзлэг өндөр мэргэшсэн эрүүл мэндийн ажилтан, 20-30 ор тутамд нэг өндөр мэргэшсэн эрүүл мэндийн ажилтан, 24 цагийн үйлчилгээтэй (хэвтэж эмчлүүлж байгаа өвчтөнүүдэд зориулсан) байна. Шингэн нөхөх эмчилгээ хийх нэг нарийн мэргэшээгүй эрүүл мэндийн ажилтан, аптека хариуцсан нэг юм уу хоёр, боолт тарилга ариутгал хариуцсан нэг юм уу хоёр ажилтантай байна. Нэг лаборант болон бүртгэл, хамгаалалт хариуцсан нарийн мэргэшээгүй ажилтнуудтай байна.

г. Зөвлөгөө өгөх эмнэлэг нь янз бүр байна. Дор хаяж хагалгаа хийх чадвартай нэг их эмч ээлжиндээ 20-30 ор тутамд нэг сувилагчтай байна.

3. Эрүүл мэндийн үйлчилгээний ашиглалтын түвшин: эрүүл мэндийн байгууламжид очих нь ашиглалтын түвшинд тодорхойлоход тус болдог. Ашиглалтын түвшин нөхцөл байдал болон улирлаас шалтгаалж өөрчлөгдөж болох учраас тогтсон хязгаар гэж байхгүй. Гэхдээ энэ нь гамшигт өртсөн хүн амын ихэнхдээ хамаагүй өндөр байдаг. Тогтвортой нөхцөлд жилд нэг хүн ойролцоогоор 0.5 – 1.0 удаа эмнэлэгт үзүүлдэг байна. Дүрвэгчдийн дунд нэг хүн жилд 4.0 удаа эмнэлгийн үйлчилгээ авах магадлалтай байдаг. Энэ хэмжээ дундаж хэмжээнээс бага байгаа бол энэ эмнэлгийн байгууллагын олдоц муу жишээ нь эрүүл мэндийн үйлчилгээний аюулгүй байдал хүчин чадал хангалтгүйн нэг үзүүлэлт байж болно. Харин энэ түвшин өндөр байх юм бол олон нийтийн эрүүл мэндийн тодорхой асуудал (жишээ нь халдварт өвчин гарах гэх мэт) юм уу үйлчилгээ хүртэх хүн амыг дутуу тооцсон байдлаас шалтгаалан хэт ачаалал үүссэн байж болно. Эмзэг бүлгийн хүмүүсийн төлөөллийг бүрэн хамруулах тулд ашиглалтын түвшинг тооцохдоо хүйс, нас, гарал үүсэл, хөдөлмөрийн чадваргүй байдлыг бодолцох ёстой (Хавсралт 3-г үзнэ үү).

4. Эмчилгээний стандартчилсан протокол ба зайлиггүй шаардлагатай эмийн

жагсаалт: ихэнх улсууд өөрсдийн зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт юм уу жорын жагсаалтыг гаргасан байдаг ба олон улс түгээмэл өвчнүүд болон гэмтлүүдийг эмчлэх эмчилгээний менежментийн протоколтой байдаг. Эдгээр протоколууд ба эмийн жагсаалтуудын тохиромжтой байдлыг тогтоохын тулд тэдгээрийг гамшгийн эсрэг арга хэмжээ эхний шатанд Эрүүл мэндийн яамтай зөвлөлдсөний үндсэн дээр хянах ёстой. Зарим тохиолдолд тогтсон үндэсний протокол юм уу эмийн жагсаалтанд жишээ нь зөвлөсөн антибиотик юм уу хижгийн эсрэг хариу үйлдэл гарч байгаа шинж тэмдэг илэрсэн тохиолдолд өөрчлөлт оруулах шаардлага гарч болно. Хэрвээ протокол ба зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт байхгүй бол Дэлхийн эрүүл мэндийн байгууллага UNHCR-ээс гаргасан Онцгой үеийн эрүүл мэндийн шинэ хэрэгсэл гэх мэт зааварчилгааг мөрдөх ёстой.

5. Боловсон хүчний сургалт ба хяналт: эрүүл мэндийн салбарын ажилтнууд нь зохих сургалтад хамрагдаж өөрсдийн хариуцлагын түвшинд тохирох ур чадварыг эзэмшсэн байх ёстой. Эрүүл мэндийн байгууллагууд нь боловсон хүчнийхээ мэдлэгийг орчин үеийн түвшинд байлгахын тулд тэднийг сургалтанд хамруулах ёстой. Ялангуяа боловсон хүчин мэргэшил дээшлүүлэх сургалтанд хамрагдаагүй юм уу шинэ эрүүл мэндийн систем эсвэл протокол хэрэгжүүлж байгаа үед онцгой чухал шаардлагатай. Сургалтын хөтөлбөрүүдийг аль болохоор стандартчилж үндэсний хөтөлбөрүүдтэй холбож өгөх шаардлагатай.

268

6. Өвчтөний эрхүүд: гамшигтай холбоотой олон хүчин зүйлүүд нь өвчтөний хувийн нууцаа хадгалах, шийдвэр гаргахдаа мэдээллээр хангагдсан байдал зэрэг эрхүүдийг тасралтгүй хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болгодог. Гэхдээ эрүүл мэндийн ажилтнууд нь аль болохоор эдгээр эрхүүдийг хамгаалж хүндэтгэхийг хичээж ажиллах ёстой. Эрүүл мэндийн байгууламжууд ба үйлчилгээ нь хувийн нууцыг хадгалах байдлаар зохион байгуулагдсан байх ёстой (эрүүл мэндийн системүүд ба дэд бүтцийн стандарт, удирдамжийн тайлбар 3 гэсэн хэсгийг уншина уу). Зөвшөөрөл өгөхдөө мэдээллээр хангагдсан байх эрхийг эмчилгээний юм уу мэс заслын ажиллагааны өмнө хэрэгжүүлэх шаардлагатай. Өвчтөнүүд эмчилгээний ажиллагаа болгон ямар хэсгээс бүрддэг, тэдгээрийн үр дүн, боломжит эрсдэл, зардал, үргэлжлэх хугацаан талаар мэдэх эрхтэй.

7. Эмийн менежмент: зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг ашиглахаас гадна эрүүл мэндийн байгууллагууд нь эминий менежментийн үр дүнтэй системийг нэвтрүүлэх ёстой. Ийм системийн зорилго нь эмийг үр ашигтай, зардал багатай, оновчтой байдлаар хэрэглэхэд оршино. Энэ систем нь сонголт, хангалт, түгээлт, хэрэглээ гэсэн эмийн менежментийн циклийн хамгийн чухал дөрвөн хэсэг дээр үндэслэх ёстой (эрүүл мэндийн менежментийн шинжлэх ухаан, 1997, *Эмийн ханган*

нийлүүлтийг зохион байгуулах, хоёрдох хэвлэлийг үзнэ үү)

8. Нас барагсдын цогцостой харьцах: гамшгийн улмаас нас баралтын түвшин өндөр байгаа үед олон тооны цогцостой харьцах шаардлагатай болдог. Цогцсуудыг эрээ цээргүйгээр бөөнд нь оршуулах ёсгүй. Учир нь энэ нь олон нийтийн мэндэд тохиромжгүй бөгөөд нийгмийн хэм хэмжээг зөрчиж байгаагаас гадна ховор нөөц бололцоог үр дүнгүйгээр үрэгдүүлэхэд хүргэж болно. Хүний цогцсыг олноор оршуулах нь тэдгээрийг түргэн булах юм уу шатаахгүй бол халдварт өвчин үүсгэж болно гэсэн буруу ойлголт дээр үндэслэсэн байдаг. Үнэн хэрэгтээ цогцос нь эрүүл мэндийн эрсдэл үүсгэх магадлал голдуу маш бага байдаг. Холер юм уу халуунаар нас барсан зэрэг зөвхөн цөөхөн хэдэн тохиолдолд л хүний цогцос нь эрүүл мэндийн хувьд эрсдэл үүсгэх ба энэ үед урьдчилсан арга хэмжээ авах шаардлагатай болдог. Нас барагсдын гэр бүлийнхэнд нь соёлын хувьд хүлээн авч болохуйц оршуулга хийх боломж олгох ёстой. Оршуулж байгаа нас барагсад нь хүчирхийллийн золиос болсон үед шүүх эмнэлгийн асуудлыг авч үзэх ёстой (217-р хуудаснаас байр сууц ба амьдрах газрын стандарт 2, удирдамжийн тайлбар 3 гэсэн хэсгийг үзнэ үү)

Эрүүл мэндийн системүүд ба дэд бүтцийн стандарт 6:

Эрүүл мэндийн мэдээллийн систем

Эрүүл мэндийн үйлчилгээг төлөвлөж хэрэгжүүлэхдээ олон нийтийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг тасралтгүй цуглуулах, дүн шинжлгээ хийх, ашиглах ажиллагааг зохион байгуулалттай явуулах ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлийн хамт уншина уу).

- Хүн амын хөдөлгөөн, нас баралт, өвчлөлт, эрүүл мэндийн үйлчилгээний талаархи мэдээллийг тогтмол цуглуулахын тулд эрүүл мэндийн байгууллагууд нь стандартчилсан эрүүл мэндийн мэдээллийн системийг ашигладаг (заавар тэмдэглэл 1-2, хавсралт 1-2).
- Эрүүл мэндийн мэдээллийн системийг зохион байгуулж хянах зорилгоор зохицуулах үүрэгтэй байгууллагыг томилно.
- Эрүүл мэндийн байгууламжууд ба байгууллагууд тогтмол хугацаанд зохицуулах үүрэгтэй байгууллагад ажиглалтын мэдээлэл өгнө. Эдгээр мэдээллийг өгөх давтамж нь нөхцөл байдлаас шалтгаалж өдөр бүр, долоо хоног бүр эсвэр сар бүр байж болно.

- Халдварлалтын талаар өгөх тогтмол мэдээлэл тэр дундаа мэдээллийн дүн шинжилгээ ба тайлбарыг эрүүл мэндийн мэдээллийн хөтөлбөрийг зохицуулах үүрэгтэй байгууллага гаргах ба бусад холбогдох байгууллагууд, шийдвэр гаргагчид, үйлчлүүлэгчидтэй хуваалцана. Эдгээр мэдээллийг өгөх давтамж нь нөхцөл байдлаас шалтгаалж өдөр бүр, долоо хоног бүр эсвэр сар бүр байж болно.
- Хувь хүмүүс болон хүн амын эрх ба аюулгүй байдлыг хамгаалахын тулд байгууллагууд нь мэдээллийг хамгаалах урьдчилсан арга хэмжээг авах ёстой (заавар тэмдэглэл 3).
- Халдварт өвчин гарсныг илрүүлж цаг тухайд нь хариу арга хэмжээ авах боломж олгохын тулд эрүүл мэндийн мэдээллийн системд цаг алдалгүй анхааруулга өгөх механизм багтах ёстой (281-р хуудсан дээр байгаа халдварт өвчнийг хянах стандарт 5).
- Ажиглалтын мэдээллийг тайлбарлах ба шийдвэр гаргах явцыг чиглүүлэхийн тулд бусад зохих эх үүсвэрүүдээс авсан мэдээллийг тасралтгүй ашиглана (заавар тэмдэглэл 4).

270

Заавар тэмдэглэл

1. Эрүүл мэндийн мэдээллийн систем: эрүүл мэндийн мэдээллийн системийг аль болох урьдчилан байгуулсан ажиглалтын систем дээр үндэслэх ёстой. Зарим онцгой тохиолдолд шинэ юм уу зэрэгцээ систем шаардлагатай болж болох ба үүнийг эрүүл мэндийн төв байгууллагатай зөвлөлдсөний үндсэн дээр шийднэ. Эрүүл мэндийн мэдээллийн систем нь уян хатан байх ёстой бөгөөд цаг хугацааны явцад хөгжиж байх ёстой. Гамшгийн үед хариу арга хэмжээ авахдаа дараахи эрүүл мэндийн мэдээллийг оруулах ёстой бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- а. Нас баралтын баримжаалсан түвшин
- б. 5-аас доош насныхны нас баралтын түвшин
- в. Нас баралтын пропорциональ түвшин
- г. Тодорхой шалтгааны улмаас үүссэн нас баралтын түвшин
- д. Хамгийн түгээмэл өвчнүүдийн тохиолдлын түвшин
- е. Эрүүл мэндийн байгууламжийн ашиглалтын түвшин
- ё. Клиник эмчийн нэг өдөрт өгөх зөвлөгөөний тоо

2. мэдээллийн задаргаа: шийдвэр гаргах чиглэл өгөхийн тулд мэдээллийг боломжтой хэмжээгээр нас ба хүйсээр нь задлах ёстой. Гамшгийн эхэн үед мэдээллийг нарийвчлан

задлах нь түвэгтэй байж болно. Гэхдээ 5 наснаас доош хүүхдүүд хамгийн их эрсдэлд өртдөг учраас энэ насны бүлгийн хүүхдүүдийн нас баралт ба өвчлөлийн талаархи мэдээллийг эхнээс нь баримтжуулах шаардлагатай. Үүнээс гадна нас баралт ба өвчлөлийн мэдээллийг хүйсээр нь ангилах нь хүйсний хоорондох ялгааг олж харахад тустай байдаг. Цаг хугацаа ба нөхцөл байдал боломжтой бол улам илүү нарийвчилсан насны ба хүйсийн задаргааг хийхийг хичээх шаардлагатай (0-11 сар, 1-4 нас, 5-14 нас, 15-49 нас, 50-59 нас, 60-аас дээш нас гэх мэт).

3. Мэдээллийн нууцлал: эмнэлгийн тэмдэглэл ба мэдээллийн нууцыг батлагаажуулах ёстой. хувь хүн болон мэдээллийн өөрийнх нь аюулгүй байдлыг хангахын тулд урьдчилсан арга хэмжээнүүдийг авах шаардлагатай. Эмнэлгийн ажилтнууд өвчтөний талаархи мэдээллийг тухайн өвчтөнийг асрах ажиллагаанд шууд оролцоогүй хэнд ч өвчтөний зөвшөөрөлгүйгээр мэдээллийг өгөх ёсгүй. Тамлалт ба бусад хүний эрхийн зөрчлийн улмаас учирсан гэмтэлтэй шууд холбоотой мэдээлэлтэй маш болгоомжтой харьцах ёстой. Өвчтөн зөвшөөрсөн нөхцөлд энэ мэдээллийг холбогдох байгууллага юм уу оролцогч талд өгөх талаар бодолцож болно.

4. Бусад мэдээллийн эх үүсвэрүүд: Холбогдох эрүүл мэндийн мэдээллийн эх үүсвэрт лабораторийн тайлан, санал асуулга, тухайн тохиолдлын судалгаа, үйлчилгээний чанарын хэмжилтүүд болон бусад хөтөлбөрийн мэдээллүүд орно.

Хавсралт 2-оос долоо хоног тутмын нас баралт ба өвчлөлтийн мэдээллийн маягтын загвар ба Хавсралт 3-аас нас баралт ба өвчлөлтийн түвшинг тооцох томъёог үзнэ үү.

2 Халдварт өвчний хяналт

Бусад гамшгийг бодвол хавсарсан гамшгийн үед илүү тохиолддог халдварт өвчний улмаас үүдсэн өвчлөлт болон нас баралтын хувь хэмжээ өндөр байдаг. Ийнхүү байдал ихэнхдээ хөгжиж буй орнуудад нас баралтын 60-90% эзэлдэг ба түгээмэл тохиолддог 4 халдвар өвчний аль нэгнээс болдог байна. Үүнд: улаан бурхан, суулгалт, цочмог амьсгалын замын халдвар, хумхаа г.м. Хүнсний тэжээлийн хурц хомсдол нь ихэнхи тохиолдолд дээрхи өвчнүүдтэй хавсарч байдаг бөгөөд үүнд ялангуяа бага насны хүүхдүүд өртдөг. Зарим нөхцөлд өөр төрлийн халдварт өвчин тархдаг. Жишээ нь: цахилгаан минингит, шар халуун, гипатит, гэдэсний хижиг г.м.

Халдварт өвчний талхалт нь гэнэтийн гамшигтай хавсарч давхар гарч ирдэггүй. Усны чанар болон ариун цэврийн хомсдолоос болж ихэвчлэн үүсдэг. Цэргийн хүчнийхэн болон алан хядагчид биологийн зэвсэг хэрэглэх болсон нь гамшгийн хариу үйлдэл үзүүлэгч болон хүмүүнлэгийн байгууллагуудыг санааг зовоож эхэлсэн. Хэрэв зээ биологийн зэвсэг хэрэглэсэн тохиолдолд энэхүү стандартуудыг мөрдөх боломжгүй боловч зарим нэг нь тохирч болох юм.

Халдварт өвчний хяналтын стандарт 1: урьдчилан сэргийлэх

Нас баралт ба өвчлөлтийг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөө үзүүлдэг халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл ба үйлчилгээг хүмүүс авах эрхтэй.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлийн хамт уншина)

- Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээнүүдийг бусад холбогдох салбаруудтай харилцан уялдаатайгаар боловсруулж хэрэгжүүлдэг (заавар тэмдэглэл 1).
- Олон нийтэд зориулсан эрүүл мэндийн мэдээлэл хувь хүмүүст түгээмэл тархсан халдварт өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлж холбогдох үйлчилгээг авах талаар мэдлэг олгодог (264-р хуудсанд байгаа эрүүл мэндийн системүүд ба дэд бүтцийн стандарт 4)
- Улаан бурхны эсрэг олон нийтэд вакцин хийх дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөр гэх мэт тодорхой урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг заасны дагуу хэрэгжүүлдэг (заавар тэмдэглэл 2 ба халдварт өвчнийг стандарт 2).

Заавар тэмдэглэл

- 1. Урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ:* эдгээр хөндлөнгийн оролцооны ихэнхийг бусад салбаруудтай уялдаатайгаар зохион байгуулдаг. Үүнд:

- ус ба ариун цэвэр: хангалттай хэмжээ ба чанар бүхий усны хангамж, ариун цэврийн шаардлага хангасан нөхцөл, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөл, векторын хяналт гэх мэт (51-р хуудсанд байгаа ус, ариун цэвэр, эрүүл ахуйг сайжруулах гэсэн хэсгийг үзнэ үү).
- Хүнсний аюулгүй байдал, тэжээл, хүнсний тусламж: шаардлага хангасан хүнс хэрэглэх боломж ба хүнсний хомсдолын менежмент (103-р хуудсанд байгаа Хүнсний аюулгүй байдал, тэжээл ба хүнсний тусламж гэсэн хэсгийг үзнэ үү).
- Байр оромж: хангалттай бөгөөд тохирох байр сууц (203-р хуудсанд байгаа байр сууц, оршин суух газар, хүнсний бус зүйлүүд)

274

2. **Улаан бурхнаас урьдчилан сэргийлэх ба дархлаажуулалтын өргөтгөсөн хөтөлбөр:** улаан бурхан нь гарах өндөр магадлалтай бөгөөд нас баралтын хувь өндөр байдаг учраас энэ өвчний урьдчилан сэргийлэхийн тулд хүүхдүүдийг нийтээр вакцинжуулалтанд хамруулах нь гамшигт нэрвэгдсэн хүн ам, ялангуяа дүрвэсэн юм уу зөрчил тэмцлийн золиос болсон хүн амын дунд маш чухал асуудал байх нь олонтоо. Дархлаажуулалтын өргөтгөсөн хөтөлбөрөөр дамжуулан бусад хүүхдийн өвчний эсрэг вакцин хэрэглэх нь үүнээс илүү ач холбогдол багатай. Учир нь эдгээр өвчнүүд гарах нь илүү цөөн бөгөөд тэдгээрээс үүсэх эрүүл мэндийн эрсдэлийн хэмжээ бага байдаг. Ийм учраас дархлаажуулалтын хөтөлбөрийн бусад вакцинууд нь хүн амын шууд хэрэгцээг хангасны дараа л голдуу хэрэглэдэг. Энэ удирдамжид pertussis буюу хоолойн сахуу зэрэг өвчин тасралтгүй гарснаар тэдгээрээс урьдчилан сэргийлэх вакцин хэрэглэх нь маш чухал болсон тохиолдол хамаарахгүй.

Халдварт өвчний хяналтын стандарт 2: улаан бурхнаас урьдчилан сэргийлэх

6 сараас 15 настай бүх хүүхдүүд энэ өвчний эсрэг дархлаатай байдаг.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлийн хамт уншина)

- 9 сараас 15 хүртэлх насны хүүхдүүд улаан бурхны эсрэг вакцинд хамрагдаж байгаа байдлыг үнэлэх үнэлгээг улаан бурханд өртөмтгий байдлыг тогтоохын тулд шуурхай арга хэмжээний эхэнд явуулдаг (заавар тэмдэглэл 1-г үзнэ үү).

- Хэрвээ вакцинжуулалтын хамрах хүрээ 90%-иас бага байвал 6 сараас 15 насны хүүхдүүдийг (үүний дотор 6-59 сартай хүүхдүүдийг А витаминаар хангах) нийтээр вакцинжуулах кампанит ажлыг эхлүүлдэг. Вакцинжуулах кампанит ажил тэр дундаа дархлаажуулалтын өргөтгөсөн хөтөлбөр үндэсний болон орон нутгийн эрүүл мэндийн удирдах байгууллагууд зохион байгуулдаг (заавар тэмдэглэл 2-г үзнэ үү).
- Кампанит ажлыг гүйцэтгэж дууссанаар дараахи шаардлагуудыг хангасан байх ёстой. Үүнд:
 - 6 сараас 15 насны хүүхдүүдийн дор хаяж 95% нь улаан бурхны вакцинд хамрагдсан байх ёстой.
 - дотор 6-59 сартай хүүхдүүдийн дор хаяж 95% нь А витамины зохих тунг хэрэглэсэн байх ёстой.

275

- Вакцинд хамрагдсан 6-9 сартай хүүхдүүд нь 9 сар хүрэнгүүт улаан бурхны вакциныг өөр тунгаар хэрэглэх ёстой (удирдамжийн тайлбар 2-г үзнэ үү).
- 9 сартай хүүхдийн тогтмол хийгддэг ваикцины хамрах хүрээг хамгийн бага нь 95%-тай байлгах ёстой. Үүнийг дархлаажуулалтын өргөтгөсөн хөтөлбөртэй холбоотой явуулдаг.
- Шилжих хөдөлгөөнд байгаа болон дүрвэсэн хүн амын хувьд 6 сараас 15 нас хүртэлх насны шинээр ирсэн бүх хүүхдүүдийн дор хаяж 95% нь улаан бурхны вакинцд хамрагдсан байх системийг байгуулах ёстой.

Заавар тэмдэглэл

1. **Улаан бурхнаас урьдчилан сэргийлэх:** улаан бурхан нь бидний мэдэх хамгийн өндөр халдвартай вирусүүдийн нэг бөгөөд нас баралтын маш өндөр хувьтай байдаг. Онцгой нөхцөл байдал үүсч хүмүүс олноороо дүрвэх юм уу хүнсний хомсдолын түвшин өндөр байгаа нөхцөлд улаан бурхан гарах магадлал маш өндөр байдаг. Ийм учраас нийтээр вакцинжуулах кампанит ажил нь дээрхи нөхцөл байдал үүссэн үед хамгийн түрүүнд хэрэгжүүлэх хамгийн чухал ажил болдог. Нийтээр вакцинжуулах ажиллагаанд шаардлагатай боловсон хүчин, вакцин, тоног төхөөрөмж болон бусад хангамжийн материалуудыг аль болох түргэн цуглуулах шаардлагатай. Вакцины хамрах хүрээ тодорхой бус байгаа бол кампанит ажлыг хамрах хүрээ хангалтгүй гэж үзэж явуулах ёстой.

2. **Улаан бурхны вакцинжуулалтын насны ангилал:** Зарим арай ахмад хүүхдүүд нь өмнөх улаан бурхны вакцинжуулалтанд хамрагдаагүй бөгөөд улаан бурхан тусаагүй байж болно. Ийм хүүхдүүд нь улаан бурхан тусах өндөр эрсдэлтэй бөгөөд бусад хүүхдүүд тэр дундаа энэ өвчнөөр нас барах хамгийн өндөр эрсдэлтэй илүү бага насны хүүхдүүдэд халдаах эх үүсвэр болж болно. Ийм учраас улаан бурхны вакцинжуулалтанд хамруулах тохиромжтой насыг 15 хүртэл үздэг. Гэхдээ нөөц муутай нөхцөлд 6 сараас 15 нас хүртэлх насны бүх хүүдүүдийг вакцинжуулалтанд хамруулах боломжгүй байж болно. Ийм тохиолдолд 6-59 сартай хүүхдүүдэд эхэлж вакцинд хамруулах ёстой.
3. **6-9 сартай хүүхдүүдийн улаан бурхны давтан вакцинжуулалт:** хүүхэд 8 сараас хойш анхны тунгаа хэрэглэснээс бусад тохиолдолд улаан бурхны давтан вакцинжуулалтыг 9 сар хүрэх үед аль болох түргэн хийх ёстой. Энэ тохиолдолд хүүхдүүд нь хоёрдох тунгаа дор хаяж сарын дараа хийлгэх ёстой.

276

Халдварт өвчнийг хянах стандарт 3: оношлогоо ба тухайн нөхцлийн менежмент

Хүмүүс урьдчилан сэргийлэх болох нас баралт ба өвчлөлтөд ихээхэн хувь нэмэр оруулж байгаа халдварт өвчнүүдийн үр дүнтэй оношлогоо ба эмчилгээг хүртэх боломжтой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлийн хамт уншина)

- Хамгийн түгээмэл халдварт өвчнүүдийн оношлогоо ба эмчилгээнд зориулсан стандартчилсан менежментийн протоколыг тогтмол хэрэглэнэ (заавар тэмдэглэл 1 ба эрүүл мэндийн систем ба дэд бүтцийн стандарт 5-г үзнэ үү).
- Олон нийтэд зориулсан эрүүл мэндийн мэдээлэл хүмүүс, ялангуяа хүүхдүүд, жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настай хүмүүст халууралт, ханиалга, гүйлгэлт зэрэгт эртнээс санаа тавихыг хичээх ойлголтыг төрүүлэх зорилготой.
- Хумхаа өвчний голомттой газар халуурсан оношыг эрт тогтоож (24 цаг) өндөр үр дүнтэй анхан шатны эмүүдээр эмчлэх зорилготой протокол боловсруулсан байдаг (заавар тэмдэглэл 2-г үзнэ үү).
- Заасан үед лаборатрийн үйлчилгээг авч ашиглах боломжтой (заавар тэмдэглэл 3-г үзнэ үү).
- Сүрьеэ өвчнийг хянах хөтөлбөрийг зөвхөн хүлээн зөвшөөрөгдсөн хэмжүүрүүдийг авч үзсэний дараа хэрэгжүүлнэ (заавар тэмдэглэл 4-г үзнэ үү).

Заавар тэмдэглэл

1. **Хүүхдийн өвчний нэгтгэсэн менежмент:** аливаа улс хүүхдийн өвчний нэгтгэсэн менежментийг хөгжлж клиникийн удирдамжийг хэрэглэдэг бол эдгээр удирдамжуудыг стандартчилсан протоколд нэгтгэх нь зүйтэй байдаг. Хүүхдийн өвчний нэгтгэсэн менежмент нь 5-аас доош настай хүүхдэд тавих анхаарал халамжийг сайжруулахад нөлөөлдөг нь батлагддаг.
2. **Хумхаа:** хумхаа нь халдварын голомттой газар хүмүүс олноороо шилжин хөдөлж байгаа тохиолдолд хэдхэн өдөр юм уу долоо хоногийн турхах магадлалтай.

277

Лорокин ба сульфадоксин-пириметаминь эсрэг үйлчилгээ улам бүр нэмэгдэж байгаа учраас илүү үр дүнтэй эм шаардлагатай байж болно. Энэ нь ялангуяа *falciparum* хумхаанд нэрвэгдсэн дархлаагүй бөгөөд эмзэг хүн амд онцгой ач холбогдолтой. Артемизинээс гаралтай хавсарсан эмчилгээний арга илүү үр дүнтэй байдаг. Эмийг сонгохдоо эмчийн үр дүнгийн мэдээлэл дээр үндэслэж эрүүл мэндийн төв байгууллагатай зөвлөлдөх шаардлагатай. Эмийн үйлчилгээг үнэлэхийн тулд ДЭМБ-аас гаргасан стандартчилсан протоколыг ашиглах ёстой.

3. **Лабораторийн үйлчилгээ:** ихэнх гамшгийн эхэн үед клиникийн лаборатори байгуулах нь хамгийн чухал асуудал биш байдаг. Хамгийн түгээмэл халдварт өвчнүүдийг голдуу клиник аргаар оношлох боломжтой бөгөөд эмчилгээг таамаглал дээр үндэслэн хийдэг. Нийтээр вакцинжуулах шаардлага гарч болох өвчин гарсан байх магадлалтай үед тавьсан оношийг баталгаажуулах юм уу соёлын ба антибиотикийн эмзэг байдлын шинжилгээ нь менежментийн шийдвэрт нөлөөлж болох (жишээ нь, дизентери) тохиолдолд лабораторийн шинжилгээ хамгийн тустай байдаг. Тийм учраас зохих микробиологийн шинжилгээ явуулах чадвартай тогтмол лабораторийг өөрийн оронд юм уу өөр аль нэг улсад байгуулах нь зүйтэй. Ингэхдээ дээж авах ба тээвэрлэх зохих зааварчилгааг гаргах ёстой.
4. **Сүрьеэгийн хяналт:** дүрвэгсэд болон дайны хөлд нэрвэгдсэн хүн амын дунда сүрьеэгийн тархалт өндөр байдаг нь баримтаар батлагдсан зүйл юм. Гэхдээ зохих шаардлагын дагуу хэрэгжүүлээгүй сүрьеэгийн хөтөлбөр нь халдварын үргэлжлэх хугацааг сунгах ба олон эмийг тэсвэрлэх чадвартай нян бий болгох замаар сайн үр дүнээс илүү муу үр дагавар авчирч болох талтай. Онцгой байдлын үед сүрьеэгээр өвдсөн хувь өвчтөнүүдийн менежментийг хийж болох боловч сүрьеэгийн хяналтын

өргөн хүрээний хөтөлбөрийг зөвхөн хүлээн зөвшөөрөгдсөн хэмжүүрүүдийг авч үзсэний дараа л хэрэгжүүлэх ёстой (*Дүрвэгсдийн нөхцөлд сүрьцэг хянах: байгууллага хоорондын хээрийн гарын авлагыг үзнэ үү*) Сүрьеэгийн хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлсний дараа тэдгээрийг өөрийн юм уу хүлээн авагч улсын хөтөлбөртэй нэгтгэж хэвшиж тогтсон шууд ажиглагдах эмчилгээний стратегийг мөрдөх ёстой.

Халдварт өвчнийг хянах стандарт 4: өвчин гарахад бэлэн байдалд байх

Халдварт өвчин гарах үед бэлэн байдалд байж хариу арга хэмжээ авах шаардлагатай.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлийн хамт уншина)

- Өвчний тархалтыг судалж хянах төлөвлөгөө боловсруулсан байна . (заавар тэмдэглэл 1-г үзнэ үү).
- Түгээмэл өвчний тархалтыг судалж хянах протокол гаргаж холбогдох ажилтнуудад өгсөн байна.
- Ажилтнууд нь өвчний тархалтыг судалж хянах тэр дундаа эмчилгээний протоколын зарчмын талаар сургалтанд хамрагдана.
- Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хангамж, вакцин, анхны хамгаалалтын материалуудыг бэлэн нөөцөнд байлгаж түргэн шуурхай нийлүүлнэ (заавар тэмдэглэл 2-г үзнэ үү).
- Өвчин (улаан бурхан, менингит, чичрэг гэх мэт) гарсан үед вакцины эх үүсвэрийг түргэн шуурхай олж тогтоон хэрэглэнэ. Түргэн шуурхай хугацаанд эм материалыг нийлүүлэх механизмыг бий болгоно. (заавар тэмдэглэл 2-г үзнэ үү).
- Халдварт өвчин туссан өвчтөнүүдийг тусгаарлаж эмчилгээ хийх газрыг урьдчилан олж тогтооно. Жишээ холер эмчлэх төв гэх мэт.
- Оношийг баталгажуулах лабораторийг орон нутаг, бүс нутаг, улсын хэмжээнд өөр улсад олж тогтооно (заавар тэмдэглэл 3-г үзнэ үү)..
- Өвчин гэнэт үүсгэх хамгийн магадлалтай халдвартай халдвар тараагчуудыг дээжлэх ба тээвэрлэх хэрэгслийг газар дээр нь бэлэн байлгаж дээжийг зохих лаборатори луу

шилжүүлэхийг зөвшөөрнө. Үүнээс гадна хэд хэдэн шуурхай шинжилгээг газар дээр нь хийж болно (заавар тэмдэглэл 4-г үзнэ үү).

279

Заавар тэмдэглэл

1. Өвчний тархалтыг судлах ба хянах төлөвлөгөө: төлөвлөгөөнд дараахи асуудлуудыг тусгах ёстой. Үүнд:

А. өвчний гарлыг хянах баг хуралдах нөхцөл байдал.

Б. өвчний гарлыг хянах багийн бүрэлдхүүн тэр дундаа эрүүл мэнд, ус ба ариун цэврийн гэх мэт холбогдох салбаруудын төлөөлөгчид.

В. Багийн бүрэлдхүүнд орж байгаа байгууллагууд ба албан тушаалтнуудын тусгай үүрэг хариуцлага.

Г. Орон нутгийн ба үндэсний хэмжээнд эрх бүхий байгууллагуудтай зөвлөдөх ба мэдээлэл өгөх зохион байгуулалт.

Д. Өвчний гаралтыг судалж хариу арга хэмжээ эх үүсвэрүүд ба байгууламжууд.

2. Нөөц бараа материал: газар дээр нөөцлөх материалд өвчин гарах үед хэрэглэх материал орно. Үүнд шингэн нөхөн олгох давс, дусал, антибиотик, вакцин болон эмнэлгийн хэрэглээний материал зэрэг орно. Вируст гепатит ба ДОХ-ын халдвараас урьдчилан сэргийлэхийн тулд иэг удаагийн хэрэглээний тариур ба зүүний найдвартай сав бэлэн байдалд байх ёстой. Зарим тохиолдолд урьдчилсан савлагаа холерын хэрэгсэл шаардлагатай байж болно. Менингококийн вакцин зэрэг зарим бараа материалыг голомтын газар дээр нь хадгалах тохиромжгүй байж болно. Эдгээрийг бэлэн байдалд байлгахын тулд нийлүүлэх, тээвэрлэх, хадгалах газрыг урьдчилан тогтоосон байх шаардлагатай.

3. Зөвлөх лаборатори: антибиотикийн хэт мэдрэмж, цус алдалтын ийлдсэн оношлогоо зэрэг илүү нарийн шинжилгээ хийхэд туслах бүс нутгийн юм уу олон улсын лаборатори байгуулах шаардлагатай.

4. Тээвэрлэх орчин ба шуурхай шинжилгээ: дээжний материал (хөвөн) ба тээвэрлэх орчин нь газар дээр бэлэн байх ёстой юм уу түргэн олох боломжтой байх ёстой. Үүнээс гадна хээрийн халдварт өвчин тэр дундаа хумхаа ба менингитийн оношийг баталгаажуулах хэд хэдэн шуурхай шинжилгээ хийх боломжтой байх ёстой.

Халдварт өвчний хяналтын стандарт 5: өвчний тархалтыг илрүүлэх, судлах, хариу арга хэмжээ авах

Халдварт өвчний тархалтыг шуурхай бөгөөд үр дүнтэй байдлаар илрүүлэх, судлах, хянах шаардлагатай.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлийн хамт уншина)

- Эрүүл мэндийн мэдээллийн системд цаг алдалгүй сануулах зориулалттай механизм багтах ёстой (заавар тэмдэглэл 4-г үзнэ үү).
 - Өвчний тархалтыг мэдэгдэл хүлээн авснаас хойш 24 цагийн дотор эхлүүлнэ.
 - Өндөр эрсдэлтэй бүлгийг тодорхойлохын тулд өвчний гаралтыг холбогдох цаг хугацаа, байрлал, хүний талаархи мэдээллийн хамт мэдэгдэнэ. Хувь хүмүүс ба мэдээллийг хамгаалахын тулд шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.
 - Тухайн өвчин ба нөхцөл байдалд тохирох зохих хяналтын арга хэмжээг аль болох шуурхай авна (заавар тэмдэглэл 3-4-г үзнэ үү).
 - Нас баралтын хэмжээг хүлээн авч болохуйц түвшинд байлгана (заавар тэмдэглэл 5-г үзнэ үү).
- холер: 1% ба түүнээс бага
 - шигелла дизентери: 1% ба түүнээс бага
 - гэдэсний хижиг: 1% ба түүнээс бага
 - менингокок менингит: янз бүр (заавар тэмдэглэл 6-г үзнэ үү).

Заавар тэмдэглэл

- 1. халдварт өвчний гаралтыг цаг алдалгүй мэдээлэх систем:** Энэ систем нь дараахь үндсэн хэсгүүдээс тогтоно. Үүнд:

- тохиолдлын тодорхойлолт ба босго хэмжүүрийг тогтоож бүх эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ.
- нийтийн эрүүл мэндийн ажилтнууд хүмүүсийн дунд гарсан боломжит тохиолдлыг илрүүлж мэдээлэхэд сургагдсан байна.

281

- өвчний гаралтыг илрүүлснээс хойш 24 цагийн дотор эрүүл мэндийн системийн дараагийн шатанд мэдээлнэ.
- Холбогдох эрүүл мэндийн байгууллага түргэн шуурхай мэдээлэх харилцаа холбооны системтэй байна, жишээ нь радио ба телефон гэх мэт.

2. Өвчний тархалтыг баталгаажуулах: Өвчин гарсан эсэхийг шууд тодорхойлох нь үргэлж амар байдаггүй бөгөөд бүх өвчинд зориулсан босго хэмжүүр гэж байдаггүй.

А. Холер, улаан бурхан, чичрэг, шигелла, цус алдалтын вирус гэх мэт нэг удаагийн тохиолдлоор өвчин гарсан нь батлагдаж болох өвчнүүд.

Б. Менингокок менингит: 30,000-аас дээш хүн амын хувьд нэг долоо хоногийн дотор 15 тохиолдол буюу 100,000 хүн өвдсөн тохиолдолд өвчин гарсан тодорхой болох боловч өвчин гарах эрсдэл өндөртэй нөхцөлд (3-аас дээш жилийн хугацаанд гараагүй ба вакцинд хамрагдсан байдал 80%-иас бага) энэ босго хэмжээг долоо хоногт 10 тохиолдол буюу 100,000 хүн гэж бууруулж болно. 30,000-аас бага хүн амтай нөхцөлд долоо хоногт таван тохиолдол ба гурван долоо хоногийн хугацаанд арван тохиолдол гарахад өвчин гарсан гэж тооцно.

В. Хумхаа: өвчний тодорхой илүү тодорхой бус. Гэхдээ тодорхой газар нутагт тодорхой хүмүүсийн дунд жилийн хугацаанд гардаг хэмжээнээс илүү олон тохиолдол илэрсэн тохиолдолд өвчин гарсан гэж үзнэ.

3. Өвчний тархалтын хяналт: хяналтын арга хэмжээ нь өвчин гарахад нөлөөлж байгаа халдвар тараагчын дамжих хөдөлгөөнийг зогсооход тухайлан чиглэгдэх ёстой. Дамжуулж байгаа халдвар тараагчын талаархи урьдчилсан мэдлэг нь тодорхой нөхцлүүдэд таарсан хяналтын арга хэмжээг төлөвлөхөд тустай. Ерөнхийдөө хариу арга хэмжээнүүд дараахь байдалтай байдаг. Үүнд:

- эх үүсвэрийг хянах. Усны чанар ба хэмжээг сайжруулах (жишээ нь, холер), оношлогоо ба эмчилгээг түргэвчлүүлэх (жишээ нь, хумхаа), тусгаарлах (дизентери), амьтны нөөцийг хянах (жишээ нь, тахал)
- эмзэг бүлгүүдийг хамгаалах. Хөндлөнгийн оролцоонд дархлаажуулалт (улаан

бурхан, менингит, чичрэг), кемопротексис (жишээ нь, жирэмсэн эхчүүдийг хумхаанаас урьдчилан сэргийлэх), хоол тэжээлийн чанарыг сайжруулах (жишээ нь, амьсгалын замын хурц үрэвсэл)

- дамжих хөдөлгөөнийг таслан зогсоох. Хөндлөнгийн оролцоонд эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах (бохир гараар дамждаг бүх өвчнүүд), векторын хяналт (жишээ нь, хумхаа)

282

(51-р хуудсанд байгаа Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах гэсэн хэсгийг үзнэ үү)

4. Халдвар тараагчийн хяналт ба хумхаа: хумхаа өвчин гарсан үед шавьж судлалын үнэлгээ ба мэдлэг дээр үндэслэн байран дотор шавьж устгагч цацах, шавьж устгалын халдвар тараагч цацсан орны тор тараах зэрэг векторын хяналтын арга хэмжээнүүдийг авна. Эдгээр арга хэмжээнүүд нь ихээхэн хэмжээний хангамж ба үргэлжлүүлэн авах ажиллагаа шаарддаг учраас гамшгийн эхэн үед хэрэгжүүлэх боломжгүй байж болно. Шавьж устгалын халдвар тараагч цацсан орны тор ихээхэн хэмжээгээр (80%-иас дээш) хэрэглэдэг хүн амын торонд түргэн шуурхай пиретроид уусгах арга хэмжээ авснаар өвчний халдварыг зогсоож болно (77-81-р хуудсан дээр байгаа векторын хяналт 1-2-ыг үзнэ үү).

5. Нас баралтын түвшин: нас баралтын түвшин заасан хэмжээнээс хэтэрч байвал хяналтын арга хэмжээнүүдийг нэн даруй нягтлан үзэж нас баралтын түвшинг зохих хэмжээнд байлгахын тулд залруулгын арга хэмжээ авна.

6. Менингокок менингитийн нас баралтын түвшин: Менингокок менингитийн нас баралтын хүлээн зөвшөөрөхүйц түвшин нь ерөнхий нөхцөл байдал ба эрүүл мэндийн үйлчилгээний олдцотой байдлаас хамаарч хэлбэлзэнэ. Өвчин гарсан үед нас баралтын түвшин 20% хүртэл хэмжээнд хүрч болох ерөнхийдөө эрүүл мэндийн байгууллагууд нь нас баралтын түвшинг аль болох бага хэмжээнд байлгах зорилго тавих ёстой.

Халдварт өвчний хяналтын стандарт 6: ХДХВ/ДОХ

Хүмүүс ХДХВ/ДОХ-ын халдараас сэргийлэхийн тулд хамгийн бага багц үйлчилгээг авах ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлийн хамт уншина)

- Хүмүүс гамшгийн үед дараахь зайлшгүй багц үйлчилгээг авах боломжтой. Үүнд:
- Эрэгтэй хүний үнэгүй бэлгэвч ба бэлгэвчийг зөв ашиглах зааварчилгаа
- Онцгой байдлын болон эрүүлийг хамгаалах орчинд халдвараас сэргийлэх түгээмэл урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
- Аюулгүй цус

283

- Хүмүүс өөрсдийгөө ХДХВ/ДОХ-ын халдвараас хамгаалахын тулд авах шаардлагатай арга хэмжээний талаархи мэдээлэл ба боловсрол
- Бэлгийн замаар халдвар авсан нөхцөлд тухайн тохиодлын менежмент
- Бэлгийн хүчирхийллийн үр дагаврын урьдчилан сэргийлэлт ба менежмент
- ХДХВ/ДОХ-ын халдвар авсан хүмүүс эрүүл мэндийн үндсэн халамж
- Гамшгийн дараахи үед ХДХВ/ДОХ-ын хяналтын үйлчилгээний хүрээг өргөжүүлэхийн тулд төлөвлөгөө хэрэгжүүлнэ.

Заавар тэмдэглэл

1. **ХДХВ/ДОХ-ын хяналт:** онцгой байдлын дараахи ба гамшгийг нөхөн сэргээх үе шатанд ХДХВ/ДОХ-ын хяналтын үйл ажиллагааг өргөжүүлэх ажиллагааг орон нутгийн хэрэгцээ шаардлага ба нөхцөл байдал дээр үндэслэн явуулах ёстой. Оршин суугчид ялангуяа ХДХВ/ДОХ-ын халдвартай хүмүүс ба тэдгээрийн асран хамгаалагчдыг хөтөлбөрийг боловсруулах, хянах, дүгнэх ажиллагаанд оролцуулах нь маш чухал юм. Эхний үе шатанд аль хэдийн хэрэгжүүлсэн үйлчилгээнүүдээс гадна илүү өргөн хүрээний ажиглах ба урьдчилан сэргийлэх, эмчлэх болон бусад дагалдах үйлчилгээнүүдийг үзүүлнэ. Ихэнх гамшгийн дараахи нөхцөл байдалд ДОХ-ын эмчилгээнд антиретровирал эмүүдийг хэрэглэх нь одоогийн нөхцөлд боломжгүй боловч ирээдүйд санхүүгийн болон бусад саад тотгор байхгүй болсон үед боломжтой болж болно. Хүмүүсийг гутамшиг болон ялгаварлан гадуурхах хандлагаас хамгаалах ба боловсролын хөтөлбөрүүдийг аль болох түргэн хугацаанд хэрэгжүүлэх ёстой.

Тайлбар: Каритас Интернационалис байгууллагын гишүүд бэлгэвчийн хэрэглээг сурталчилж байгаа учраас Халдварт өвчний хяналт гэсэн хэсгийн 6-р стандартыг болон Хамгийн бага хэмжээний үйлчилгээний багцийн тухай Халдваргүй өвчний хяналт гэсэн хэсгийн 2-р стандартыг дэмжихгүй байгаа. Үүнтэй нэг адилаар Каритас Интернационалис байгууллагын гишүүд энэхүү гарын авлагын аливаа хэсэгт гарах бэлгэвчийн хэрэглээ ба хамгийн бага үйлчилгээний багцтай холбоотой бусад хэсгүүдийг ч дэмжихгүй болно.

3. Халдварт бус өвчний хяналт

Халдварт өвчнөөс үүсэлтэй өвчлөлт, нас баралтын өсөлт нь олон тооны гамшгийн нийтлэг онцлог юм. Ер нь гэмтэл нь газар хөдлөлт, хүчтэй салхи зэрэг эхэн үеийн хатуу ширүүн байгалийн гамшгийн үндсэн шалтгаан юм. Биеийн хүчирхийллээс үүсэлтэй гэмтэл нь мөн бүх хүнд хэцүү онцгой байдалтай холбоотой бөгөөд ийм хямралын үеэр их хэмжээний нас баралтын үндсэн шалтгаан болж болно. Гамшигт нэрвэгдсэн хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээ нь сүүлийн жилүүдэд, ялангуяа, ХДХВ/ДОХ, хүйсийн хүчирхийлэл, жирэмслэлт, төрөлтийн үеийн онцгой халамж, олон тооны хүн ам дахь бүр наад захын анхан шатны нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжгүй байдлын тухайд улам бүр анхаарал татаж ирсэн. Нөхөн үржихүйн хөтөлбөрийг сайжруулах хэрэгцээг ялангуяа хүнд хэцүү онцгой байдалтай холбогдуулан хүлээн зөвшөөрсөн хэдий боловч мөн гамшгийн бусад олон төрөлтэй холбоотой юм.

Тоо хэмжээг гаргахад бэрхшээлтэй хэдий боловч мэдрэлийн эрүүл мэнд, сэтгэл зүйн асуудал нь гамшгийн аливаа төрөл, гамшгийн дараахь нөхцөл байдалтай холбоотой байж болно. Гамшигтай холбоотой аймшиг, гарз хохирол, тодорхойгүй байдал, бусад хямрал үүсгэх хүчин зүйлүүд нь хүмүүсийг янз бүрийн сэтгэхүй, сэтгэл санаа, нийгмийн асуудал ихсэх эрсдэлд оруулж болно. Эцэст нь, гамшигтай холбоотой архаг өвчний хүнд бэрх хүндрэл тохиолдлын өсөлтийг нотлох баримт бий. Ер нь ийм хүндрэл нь одоогийн эмчилгээний дэглэм алдагдсантай холбоотой байдаг. Гэхдээ бусад хямрал үүсгэх төрөл бүрийн хүчин зүйлүүд нь мөн архаг өвчний нөхцөл байдал ихээхэн муудах явдлыг хурдасгаж болно.

Халдварт бус өвчний стандарт 1: гэмтэл

Хүмүүс гэмтлийн менежментийн талаар тохирох үйлчилгээг авах боломжтой.

Үндсэн үзүүлэлтүүд: /заавар тэмдэглэлтэй холбож унших/

- Олон тоогоор гэмтсэн өвчтнүүдтэй байгаа нөхцөл байдалд эмчлүүлэх шаардлагатай өвчнүүдийг эн тэргүүнд эмчлэх стандартчилагдсан системийг үнэлгээ хийх, тэргүүлэх чиглэл гаргах, ухаан оруулах, хүргэх чиглэлээр эрүүл мэндийн халамж тавих байгууллагуудыг удирдан чиглүүлэхээр бий болгодог /заавар тэмдэглэл 1-2-ыг үзнэ үү/.
- Анхны тусламж үзүүлэх, анхан шатанд ухаан оруулах стандартчилагдсан гарын авлагыг бий болгодог /заавар тэмдэглэл 3-ыг үзнэ үү/.
- Гэмтсэн өвчтнүүдийг мэс засал зэрэг дээд шатны халамж үйлчилгээ үзүүлэхээр хүргэх стандартчилагдсан журмыг бий болгодог. Өвчтнүүдийг хүргэгдэх газар нь хүргэхэд тохиромжтой тээврийн хэрэгслийг зохион байгуулдаг.
- Эцсийн гэмтэл, мэс заслын үйлчилгээг зөвхөн тохирох мэдлэг, туршлага, хөрөнгө нөөцтэй агентлагууд тогтоодог /заавар тэмдэглэл 4-ийг үзнэ үү/.
- Олон тоогоор гэмтсэн өвчтнүүдтэй нөхцөл байдалд үй олноороо гэмтсэн хүмүүсийн менежментийн гарч болох асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөөг холбогдох эрүүл мэндийн халамжийн газруудад боловсруулж өгдөг. Эдгээр төлөвлөгөө нь дүүрэг, бүс нутгийн төлөвлөгөөтэй холбоотой байдаг.

Заавар тэмдэглэл

1. **Гэмтлийн үйлчилгээг эн тэргүүнд үзүүлэх:** дийлэнх гамшгийн үед эмнэлгийн халамж шаардах гэмтсэн хүмүүсийг тоог тогтоох боломжгүй байдаг. Ер нь газар хөдлөлт зэрэг эхэн үеийн хатуу ширүүн байгалийн гамшгийн дараа аврагдаж амь гарсан хүмүүсийн 85-90 хувийг 72 цагийн дотор орон нутгийн онцгой байдлын ажилтнууд эсвэл тэдний хөршүүд, гэр бүлийнхэн гаргаж авдаг. Тиймээс гамшигт нэрвэгдэж болзошгүй бүс нутаг дахь авралын үйл ажиллагааг төлөвлөхдөө орон нутгийн хүн амыг анхны халамж үйлчилгээ үзүүлэхэд бэлтгэхэд голлон анхаарах хэрэгтэй. Эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлийн арга хэмжээ урьдчилан сэргийлж болох их хэмжээний нас баралтыг бууруулахад чиглэгдэж байдгийг онцлон тэмдэглэх нь чухал юм.

Зэвсэгт мөргөлдөөний үед гэмтлээс үүдсэн нас баралт эрүүл мэндийн байгууламжаас зайдуу аюултай нутагт гардаг бөгөөд эрүүл мэндийн халамж тавьж урьдчилан сэргийлэх боломжгүй байдаг. Эдгээр нас баралтаас урьдчилан сэргийлэхэд иргэдийг хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай байдаг. Мөргөлдөөний үед эрүүл мэндийг хамгаалах оролцоо нь аймшигт гэмтлийн тохиолдол өндөр байгаа нөхцөлд нийгэмд тулгуурласан эрүүл мэндийн анхан шатны халамжийг дэмжих хэрэгтэй.

2. **Эмчлүүлэх шаардлагатай өвчтнүүдийг эн тэргүүнд эмчлэх:** Өвчтнүүдийг тэдний гэмтэл буюу өвчлөлөөр нь ангилах, хөрөнгө нөөц болон өвчтөнүүдийн амьд гарах магадлалыг үндэслэн эн тэргүүнд эмчилгээ үзүүлнэ. Эмчлүүлэх шаардлагатай өвчтнүүдийг эн тэргүүнд эмчлэх гол зарчим нь хязгаарлагдмал хөрөнгө нөөцийг хамгийн их эрүүл мэндийн үр дүнг хамгийн олон хүнд хүргэх замаар хуваарилах явдал юм. Эмчлүүлэх шаардлагатай өвчтнүүдийг эн тэргүүнд эмчлэх нь заавал хамгийн ноцтой гэмтэлтэй хувь хүмүүсийг эн тэргүүнд авч үзнэ гэсэн үг биш юм. Хязгаарлагдмал хөрөнгө нөөцтэй олон тооны гэмтсэн хүмүүстэй нөхцөлд бодит байдал дээр ноцтой, амь насанд аюултай гэмтэлтэй хүмүүсийг илүү амьд гарч болох гэмтэлтэй хүмүүсээс доогуур тэргүүлэх чиглэл өгдөг. Эмчлүүлэх шаардлагатай өвчтнүүдийг эн тэргүүнд эмчлэх стандартчилагдсан систем байдаггүй бөгөөд олон улсын хэмжээнд хэд хэдэн системийг ашигладаг. Ихэнх систем нь гэмтлийн 2-5 ангилалтай байдаг бөгөөд 4 нь хамгийн түгээмэл байдаг.
3. **Эрүүл мэндийн анхны тусламж ба анхан шатны эмнэлгийн үйлчилгээ:** ялангуяа хөрөнгө нөөц хомс нөхцөл байдалд гэмтэл гарсан үед мэс заслын үйлчилгээ нь хүртээмжтгүй байдаг. Гэвч эрүүл мэндийн анхны тусламж, анхан шатанд сэхээн амьдруулах арга хэмжээ, мэс заслын бус арга нь онц ноцтой гэмтэлтэй хүний амь насыг аврах боломжтой юм. Амьсгалыг замыг чөлөөлөх, цус алдалтад хянах, хураагуурын судасны цус алдалтыг зогсоох буюу багасгах арга хэмжээ авснаар нарийн мэргэжлийн эмчид хүргүүлэн шилжүүлэх хүртэл их гэмтэлтэй хүмүүсийн амь насыг аварч болно. Тиймээс анхан шатны эмнэлгийн үйлчилгээний менежментийн чанар нь өвчтөний амь гарах боломжид их хэмжээгээр нөлөөлж чадна. Шархыг цэвэрлэх, боох, антибиотоккийн хэрэглээ болон таталтаас урьдчилан сэргийлэх зэрэг бусад мэс заслын бус арга нь мөн чухал ач холбогдолтой юм. Сайн үзүүлсэн эрүүл мэндийн анхны тусламж, эмчилгээ ба асрагаа үзүүлсэн тохиолдолд ноцтой гэмтсэн өвчтөнүүд мэс заслын ажилбаргүйгээр олон өдөр, олон долоо хоногоор амьд байж чаддаг.
4. **Гэмтэл ба мэс засал:** эрүүл мэндийн халамж үзүүлэгч бүр гэмтсэн өвчтөнүүдэд анхны тусламж үзүүлэх ба анхан шатны сэхээн амьдруулах арга хэрэглэх чадвартай байх ёстой. Түүнээс гадна стратегийн хувьд шилжүүлэх системтэй холбоотой эмчлүүлэх шаардлагатай өвчтнүүдийг эн тэргүүнд эмчилж амь насыг аврах чадавхи чухал байдаг. Гэхдээ, гарсан гэмтлийн халамж, байлдааны талбар дахь мэс засал нь маш нарийн салбар тул тодорхой сургалт, хөрөнгө нөөцтэй мэргэжлийн цөнд тооны агентлагууд ажилладаг юм. Тохиромжгүй буюу шаардлага хангахгүй мэс засал нь юу ч хийхгүй байснаас ч илүү хор хохирол учруулж болно. Тиймээс

зөвхөн холбогдох мэдлэг, туршлагатай байгууллага, мэргэжлийн хүмүүс ийм нарийн үйлчилгээг бий болгох ёстой.

Халдварт бус өвчний стандарт 2: Нөхөн үржихүйн эрүүл мэнд

Хүмүүс өөрсдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээний наад захын анхан шатны үйлчилгээний багц /НЗАШҮБ/-ийг авах эрхтэй.

Үндсэн үзүүлэлтүүд: /заавар тэмдэглэлтэй холбож унших/

- Эрүүл мэндийн удирдах байгууллагатай зөвлөлдөж НЗАШҮБ-ийг зохицуулах, хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх байгууллага буюу хувь хүнийг тодорхойлно /заавар тэмдэглэл 1-ийг үзнэ үү/.
- Эрүүл мэндийн агентлагууд нь бусад холбогдох салбарууд, ялангуяа, нийгмийн үйлчилгээний бусад байгууллагуудтай хамтарч хүйсийн хүчирхийлэл /ХХ/-ийн үр дагавраас урьдчилан сэргийлэх, зохион байгуулах арга хэмжээ авч байна уу? /заавар тэмдэглэл 2-ыг үзнэ үү/.
- Эрүүл мэндийн байгууллага, хамгаалалт, аюулгүй байдлын ажилтнуудад мэдээлсэн ХХ-ийн бэлгийн ба бусад хэлбэрийн тохиолдлын тоог хянаж харьяа ХХ-ийн удирдах агентлагт мэдээлдэг. Нууцлалын дүрэм нь мэдээлэл цуглуулаж хянахад мөрдөгддөг эсэх.
- ХДХВ/ДОХ-ын тархалтаас урьдчилан сэргийлэх наад захын үйлчилгээний багцийг хэрэгжүүлдэг /халдварт өвчний хяналтын стандарт 6-г үзнэ үү/.
- Тодорхой хугацаанд төрөлтийн тооцоолсон тоонд үндэслэсэн хангалттай тоо хэмжээтэй эрүүл төрөлтийн үед хэрэглэгддэг иж бүрдэл нь хүртээмжтэй байдаг бөгөөд мэдэгдэхүйц жирэмсэн эмэгтэйчүүд ба гэрийн нөхцөлд эрүүл төрүүлэхэд туслах чадвартай төрөхийн сувилагч нарт тараадаг.
- Эх баригчдад зориулсан хангалттай тоо хэмжээтэй төрөлтийн үед хэрэглэгддэг иж бүрдэл /НҮБ-ын Хүүхдийн сангийн буюу түүнтэй адилтгах/-ийг эрүүл, аюулгүй төрөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор эрүүл мэндийн газруудад тараадаг.

- Эх баригч, чадвартай төрөхийн сувилагчдыг хамруулсан стандартчилагдсан шилжүүлэх системийг жирэмслэлт, төрөлтийн онцгой байдлыг удирдах зорилгоор хүн амын дунд бий болгож дэмжлэг үзүүлдэг /заавар тэмдэглэл 3-ыг үзнэ үү/.
- Анхан шатны эрүүл мэндийн халамжид нэгдсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн иж бүрэн үйлчилгээг аль болох хурдан хэрэгжүүлэх төлөвлөгөөг санаачилдаг /заавар тэмдэглэл 4-ийг үзнэ үү/.

Заавар тэмдэглэл

- 1. Наад захын анхан шатны үйлчилгээний багц:** НЗАШҮБ нь гамшгийн эхний шатанд гамшигт нэрвэгдсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээнд хариу өгөх зорилготой. НЗАШҮБ нь тоног төхөөрөмж, хангамжийн иж бүрдэл төдийгүй тодорхой эрүүл мэндийн үйл ажиллагааны цогц юм. Түүний зорилтууд нь тус үйлчилгээг зохицуулах, хэрэгжүүлэх, хүйсийн хүчирхийллийн үр дагавраас урьдчилан сэргийлэх, зохион байгуулах, ХДХВ/ДОХ-ын тархалтыг бууруулах, эх ба нялхсын эндэгдэл ба өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн үржихүйн иж бүрэн үйлчилгээг үзүүлэх ажлыг төлөвлөх байгууллага буюу хувь хүмүүсийг тодорхойлоход оршино. НҮБ-ын Хүн амын сангийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн иж бүрдэл нь ялангуяа НЗАШҮБ-ийн хэрэгжилтийг хөнгөвчлөх зорилготой юм. Энэ нь эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн төв, нарийн мэргэжлийн эмнэлэг г.м. халамжийн мөчлөгт түвшин бүрт хэрэглэж болох 12 дэд иж бүрдлээс бүрддэг.
- 2. Хүйсийн хүчирхийлэл /ХХ/** нь ихэнхи онцгой байдал, ихэнхи байгалийн гамшгийн үеэр түгээмэл тохиолддог юм. Үүнд хүчин, гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүсээгүй гэрлэлт, хүчээр биеийг нь үнэлүүлэх, хүний худалдаа, хүнийг хүч хэрэглэн авч явах зэрэг хүчирхийлэл багтдаг. ХХ-ээс урьдчилан сэргийлэх, удирдах ажил нь хүн амыг төлөөлж буй гишүүд, мөн агентлагуудын хоорондын хамтын ажиллагаа, зохицуулалтыг шаарддаг. Эрүүл мэндийн үйлчилгээ нь бэлгийн хүчирхийллээс амь гарагсдад зориулж эрүүл мэндийн үйлчилгээг удирдах, нууцлалыг хадгалж зөвлөгөө өгөх, бусад тохирох халамжид шилжүүлэх ажлыг багтаах ёстой. Шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөх, шаардлагатай зүйлийг тараах, эрүүл мэндийн үйлчилгээ, бусад хөтөлбөрт хамрагдах боломжтой байх нь ХХ-ийн боломжийг бууруулахад чиглэх ёстой. Тусламжийн агентлагийн ажилтан, цэргийн албаны хүмүүс, нөлөөлөх боломжтой бусад хүмүүс гамшигт нэрвэгдсэн хүн ам, ялангуяа, хүүхэд залуусыг бэлгийн хувьд мөлжихөөс урьдчилан сэргийлж удирдах хэрэгтэй. Бие авч явах дүрмийг боловсруулж аливаа зөрчилд сахилгын арга хэмжээг бий болгох хэрэгтэй /тусламжийн ажилтнуудын ур чадвар, үүрэг хариуцлагын талаар 40-р хуудаснаас үзнэ үү/.

3. **Жирэмслэлт, төрөлтийн үеийн онцгой халамж:** жирэмсэн эмэгтэйчүүдийн барагцаалбал 15 хувь зайлшгүй шаардлагатай жирэмслэлт, төрөлтийн халамж шаардах хүндрэлийг бий болгодог бөгөөд жирэмсэн эмэгтэйчүүдийн 5 хүртэл хувь нь хийсвэрийн хэсгийг оролцуулан зарим төрлийн мэс заслыг шаардана. Анхан шатны зайлшгүй шаардлагатай жирэмслэлт, төрөлтийн халамжийн үйчилгээг эрүүл мэндийн төвийн түвшинд аль болох хурдан байгуулах хэрэгтэй бөгөөд түүнд анхан шатны үзлэг, төрөөгүй хүүхдийн үзлэг, хийсвэрийн мэс засал, цус алдалтын менежмент, халдварын менежмент, хожуу төрөлтийн үеийн цусны даралтын ихсэлт, чичрэлтийн менежмент, олон төрөлт, хүүхдийг бөгсөн биеэр нь төрүүлэх, хөндий орон зайтай багаж хэрэглэх, бэлэг эрхтний гэмтэл авсан эмэгтэйчүүдэд тусгай халамж тавих зэргийг хамаарагдах ёстой. Зайлшгүй шаардлагатай жирэмслэлт, төрөлтийн халамжийг шилжүүлэх эмнэлэгт аль болох хурдан бий болгох хэрэгтэй бөгөөд түүнд хийсвэрийн хэсэг, хэвлийн зүсэлт, савны хүзүү, гуравдугаар зэргийн үтрээний нулимсыг засах, аюултай үр хөндөлтийн хүндрэлийн үеийн халамж, аюулгүй цус сэлбэлт хамаарагдах ёстой.
4. **Нөхөн үржихүйн эрүүл мэндийн иж бүрэн үйлчилгээ:** эрүүл мэндийн агентлагууд нь нөхөн үржихүйн иж бүрэн үйлчилгээг анхан шатны эрүүл мэндийн халамжид шат дараалан оруулах ажлыг төлөвлөх хэрэгтэй. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг салангид дээш чиглэсэн хөтөлбөр болгож бий болгох хэрэгтэй. НЗАШҮБ-д авсан арга хэмжээнээс гадна нөхөн үржихүйн иж бүрэн, нэгдсэн үйлчилгээний бусад чухал бүрэлдэхүүн хэсгүүдэд аюулгүй эх болох, гэр бүл төлөвлөлт ба зөвлөгөө, ХХ-ийн иж бүрэн үйлчилгээ, бэлгийн замаар дамждаг халдвар, ХДХВ/ДОХ-ын иж бүрэн менежмент, залуусын нөхөн үржихүйн тодорхой хэрэгцээ, хяналт, шалгалт зэргийг хамаардаг.

Халдварт бус өвчний стандарт 3: сэтгэл мэдрэлийн ба нийгмийн эрүүл мэндийн асуудал

Хүмүүс сэтгэл мэдрэлийн эмгэг, тахир дутуу болох, нийгмийн асуудлыг бууруулах нийгмийн ба сэтгэл мэдрэлийн эрүүл мэндийн үйлчилгээг авах эрхтэй.

Нийгмийн арга хэмжээний үндсэн үзүүлэлтүүд:¹ /заавар тэмдэглэлтэй холбож унших/

Гамшгийн үед нийгмийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээнд анхаарах хэрэгтэй.

- Хүмүүс гамшиг болон холбогдох тусламжийн хүчин чармайлтын талаар найдвартай мэдээллийг байнга авах боломжтой /заавар тэмдэглэл 1-ийг үзнэ үү/.
- Соёл, шашны хэвшсэн үйл ажиллагааг хадгалах буюу сэргээн бий болгох /холбогдох шашны төлөөлөгчдийн явуулдаг гашуудах зан үйлүүд багтана/. Хүмүүс оршуулгын ёслол хийх боломжтой /заавар тэмдэглэл 2-ыг үзнэ үү/.
- Хөрөнгө нөөц олдоцтой болмогч хүүхдүүд, өсвөр үеийнхэн албан ба албан бус хичээлд суух, чөлөөт цагаа өнгөрүүлэх хэвийн үйл ажиллагаанд оролцох боломжтой.
- Насанд хүрэгсэд, өсвөр үеийнхэн онцгой байдлын тусламжийн үйл ажиллагаанд тодорхой, зорилготой, нийтийн сонирхолд тохирох үйл ажиллагаанд оролцох боломжтой.
- Тусгаарлагдсан буюу өнчирсэн хүүхдүүд, байлдаанд оролцож буй хүүхдүүд, бэлэвсэрсэн хүмүүс, настай хүмүүс буюу гэр бүлгүй болсон бусад хүмүүс зэрэг нь нийгмийн сүлжээний нэгээхэн хэсэг мөн гэдгийг мэдрүүлэх тийм үйл ажиллагаанд оролцуулах хэрэгтэй.

¹ Нийгэм, сэтгэл зүйн үзүүлэлтүүдийг тусад нь авч үзэв. “Нийгмийн оролцоо” хэмээх нэр томъёог нийгмийн нөлөөг үзүүлэх үндсэн зорилготой үйл ажиллагаанд хэрэглэдэг. “Сэтгэл зүйн оролцоо” нь хүмүүс бие биедээ туслах, дэмжих, зорилготой үйл ажиллагаанд оролцох боломжтой. “Сэтгэл зүйн” хэмээх нэр томъёо харуулж байдаг тул “нийгэм сэтгэл зүйн” гэсэн нэр томъёог ашиглаж байна.

- Шаардлагатай үед хүмүүс, гэр бүлийг дахин уулзуулахын тулд эрж хайх үйлчилгээг бий болгох хэрэгтэй.
- Хүмүүсийг оршин суугаа газраас нь шилжүүлсэн бол гэр бүлийн гишүүд, хүн амыг хамтад нь байлгах зорилгоор оромжийг бий болгодог.
- Шашны газар, сургууль, усны цэг, ариун цэврийн байгууламжийг хаана байрлуулах шийдвэрийн талаар хүн амтай зөвлөлддөг. Оршин суугаа газраасаа шилжсэн хүмүүсийн суурьшилтын төлөвлөгөөнд чөлөөт цагаа өнгөрүүлэх ба соёлын газрыг багтаадаг /Оромж, суурьшилтын стандарт 1-2, хуудас 211-218/.

Сэтгэл зүй, сэтгэхүйн арга хэмжээний үзүүлэлтүүд: /заавар тэмдэглэлтэй холбож унших/

- Сэтгэл санаанд нөлөөлөх хүчин зүйлд өртсөний дараа сэтгэлийн хүнд зовлон амсаж буй хувь хүмүүс эрүүл мэндийн үйлчилгээний байгууламж, хүн амын дотор сэтгэл зүйн анхны тусламж авах боломжтой /заавар тэмдэглэл 3-ыг үзнэ үү/.
- Сэтгэхүйн онцгой нөхцөл байдлын талаарх халамж нь анхан шатны эрүүл мэндийн халамжийн системийн дамжин хүртээмжтэй болдог. Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад нийцсэн хэрэгцээ шаардлагатай сэтгэхүйн эмчилгээ нь анхан шатны халамжийн байгууламжид хүртээмжтэй байдаг /заавар тэмдэглэл 4-ийг үзнэ үү/.
- Өмнө нь сэтгэхүйн эмгэгтэй байсан хувь хүмүүс холбогдох эмчилгээг үргэлжлүүлэн авдаг бөгөөд эмчилгээг хор уршиггүй, тасалдахгүй байх хэрэгтэй. Сэтгэхүйн эмнэлгийн өвчтнүүдийн наад захын хэрэгцээг хангах хэрэгтэй.
- Гамшгийн хугацаа сунжрах үед гамшгийн дараахь үе шатны илүү иж бүрэн хүн амд чиглэсэн сэтгэл зүйн арга хэмжээг авах төлөвлөгөөг санаачилдаг /заавар тэмдэглэл 5-ыг үзнэ үү/.

Заавар тэмдэглэл

1. **Мэдээлэл:** мэдээлэл авах боломж нь хүний эрх төдийгүй нийтийн шаардлагагүй айдас, гай зовлонгоос зайлсхийж болдог. Гамшгийн мөн чанар, цар хүрээ, хүн амын хувьд бие мах бодийн аюулгүй байдлыг бий болгох хүчин чармайлтын талаар мэдээлэл өгөх хэрэгтэй. Цаашилбал, хүн амд засгийн газар, орон нутгийн засаг захиргаа, тусламжийн байгууллагуудаас хэрэгжүүлж буй тусламжийн үйл ажиллагааны тодорхой төрөл, тэдгээрийн байршлын талаар мэдээлэх хэрэгтэй.

Мэдээллийг мэдээллийн эрсдлийн зарчмаар дамжуулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ ойлгоход хүндрэлгүй байх /орон нутгийн 12 настай хүүхдүүдэд ойлгогдохоор байх/, чухал хэрэгцээтэй байх /гамшгаас амь гарсан хүний байдлыг ойлгож буйгаа харуулах/ хэрэгтэй.

2. **Оршуулга:** соёлын хувьд тохирч байх үед гэр бүл нь салах ёс гүйцэтгэхээр хайр хүнийхээ цогцсыг харах боломжтой байх ёстой. Талийгаачийн цогцсыг ёслол үзүүлэхгүй зайлуулахаас зайлсхийх хэрэгтэй /Эрүүл мэндийн систем ба дэд бүтцийн стандарт 5, удирдамжийн тэмдэглэлийн 8-ыг үзнэ үү. Хуудас 269/.
3. **Сэтгэл зүйн анхны тусламж:** сэтгэл санаанд нөлөөлөх хүчин зүйлд өртсөний дараа нийт хүн ам буюу тусламжийн ажилтнууд дунд үүссэн сэтгэлийн хүнд зовлонг сэтгэл зүйн анхны тусламжийн зарчмыг баримтлан хамгийн сайн зохицуулна. Үүнд хүчээр яриулахгүй, сонсох, хэрэгцээг хангасан эсэх, бусад олон хүмүүстэй албын хүчээр байлгах гэлгүй харин дэмжих, урамшуулах, цаашдын хор уршгаас хамгаалах зэрэг хамаарна. Ийм төрлийн анхны тусламжийг сайн дурынхан ба мэргэжлийн хүмүүст хурдан зааж сургаж болно. Эрүүл мэндийн ажилтнуудад хараат байдлын эрсдлээс сэргийлж бензодиазипиний их хэмжээгээр хэрэглэхээс зайлсхийхийг сануулдаг.
4. **Сэтгэхүйн онцгой нөхцөл байдлын талаарх халамж:** яаралтай халамж шаардах сэтгэхүйн нөхцөл байдалд өөрт буюу бусдад үзүүлэх аюултай байдал, сэтгэцийн өөрчлөлт, хүнд сэтгэлийн дарамт, солио зэрэг хамаардаг.
5. **Хүн амд тулгуурласан сэтгэл зүйн оролцоо:** Арга хэмжээ нь эдүгээ үзүүлж буй үйлчилгээний судалгаа, нийгэм, соёлын нөхцөл байдлын онцлогт тулгуурласан байх хэрэгтэй. Эдгээрт хувь хүмүүс, хүн амд нөхцөл байдлыг хяналтандаа авахад туслах соёлын асуудлыг зохицуулдаг механизмыг тэд хэрэглэх асуудал хамаарах ёстой. Боломжтой үед хүн амыг төлөөлж буй удирдагч, нутгийн эмч домч нарыг хамтран ажиллахыг зөвлөмж болгодог. Нийгэмд тулгуурласан тусч бүлгүүдийг дэмжих хэрэгтэй. Олон өвчтөнд үйлчилж буй эрүүл мэндийн ажилтнуудад туслах, эмзэг, цөөнхийн бүлгүүдэд үзүүлэх халамжийг хөнгөвчлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нийгмийн ажилтнуудыг сургаж удирдах хэрэгтэй.

Халдваргүй өвчний хяналтын стандарт 4: хууч өвчнүүд

Хууч өвчин нь нас баралтын ихээхэн хэсгийн шалтгаан болж байгаа хүн амын хувьд хүмүүс нь үхлээс урьдчилан сэргийлэх үндсэн эмчилгээнүүдийг хүртэх ёстой.

Үндсэн үзүүлэлтүүд (заавар тэмдэглэлийн хамт уншина)

- Эмчилгээг гэнэт зогсоосны улмаас үхэлд хүрэх боломжтой хууч өвчтэй хүмүүст зориулсан хөтөлбөрүүдийг зохицуулах тусгай байгууллага байх ёстой (заавар тэмдэглэл 1-г үзнэ үү).
- Хууч өвчтэй хүмүүсийг идэвхтэйгээр олж тогтоон бүртгэх ёстой.
- Хууч өвчнийг эмчлэхэд тогтмол хэрэглэдэг эм тариа нь зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон бол тэдгээрийг эмнэлгийн анхны тусламжийн системээр дамжуулж олж авч болно.

Заавар тэмдэглэл

1. Хууч өвчин: гамшгийн үед хууч өвчний менежментийг явуулах нийтээр хүлээн зөвшөөрсөн зааварчилгаа өмнө нь байгаагүй. Урьд нь өвчтөнүүд нь хууч өвчнөө тасралтгүй эмчлүүлэх боломжтой байсан улс орнуудад гэнэт гарсан гамшгийн нөхцөл байдлын үед эмчилгээг гэнэт зогсооноор үхэлд хүргэх боломжтой нөхцөл байдлууд тэр дундаа диализ шүүлтээс хамааралтай архаг бөөрний дутагдалтай, инсулиний хамааралтай диабет буюу чихрийн шижин, зарим төрөлхийн хавдартай хүмүүсд нэн тэргүүнд тусламж үзүүлнэ. Энэ нь шинэ хөтөлбөр биш бөгөөд амь нас аврах үйл ажиллагааны үргэлжлэл буюу нэг хэсэг нь юм. Ирээдүйд гамшиг гарвал бусад хууч өвчний хөтөлбөрүүдийг ашиглах боломжтой байх хэрэгтэй. Хэрэв гамшгаас өмнө тухайн хүн амд хууч өвчний эмчилгээнд шаардлагатай зүйл байгаагүй бол тэдгээр эмчилгээний хөтөлбөр болон журмыг шинээр нэвтрүүлж хэрэгжүүлэх гэсний шаардлага байхгүй. Хэвшсэн эм тариаг ашиглан эрүүл мэндийн анхан шатны байгууллагаар дамжуулан хууч өвчний байнгын тасралтгүй менежментийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хавсралт 1

Эрүүл мэндийн үйлчилгээг үнэлэх асуултууд

Бэлтгэл ажил

- Гамшигт нэрвэгдсэн хүн амын талаархи холбогдох мэдээллийг олж авч хүлээн авч буй улсын болон олон улсын тусламжийн эх үүсвэрүүдийг олж тогтооно.
- Олж авч болох бүх газрын зураг ба агаарын зураглалыг олж цуглуулах.
- Хүлээн авч буй улс ба олон улсын эх сурвалжаас хүн амын болон эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах.

Аюулгүй байдал ба хүртээмж

- Байгалийн болон хүний хүчин зүйлээс шалтгаалсан аюул эрсдэл байгаа эсэхийг тогтооно.
- Ерөнхийдөө аюулгүй байдал ямар байна? Тэр дундаа зэвсэгт хүчин юм уу байлдагчид байгаа эсэхийг тогтооно.
- Хүмүүнлэгийн байгууллагууд гамшигт нэрвэгдсэн хүн амд хүрч очих боломжийг тогтооно.

Хүн амын үзүүлэлтүүд ба нийшмийн бүтэц

- Гамшигт нэрвэгдсэн нийт хүн амын тоо, түүн дотор 5-аас доош насны хүүхдүүдийн эзлэх хувийг тогтооно.
- Хүн амыг насны ба хүйсийн байдлаар ангилсан ангилна.
- Өндөр эрсдэлтэй бүлгүүдийг тодорхойлох, жишээ нь эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ХДХВ/ДОХ-ын халдвартай амьдарч буй хүмүүс, зарим нэг ястны юм уу нийгмийн бүлгийн гишүүд.
- Өрхийн гишүүдийн дундаж тоог, эмэгтэйчүүд буюу хүүхдүүдээр толгойлуулсан өрхийн тоог гаргана
- Оршин байгаа нийгмийн бүтэц тэр дундаа эрх бүхий хүмүүсийн эрх мэдэл/нөлөө ба эмэгтэйчүүдийн гүйцэтгэх үүргийг тодорхойлно.

Эрүүл мэндийн суурь мэдээлэл

- Гамшиг гарахаас өмнө урьд нь байсан эрүүд мэндийн асуудлууд ба гамшигт нэрвэгдсэн газрын хамгийн чухал асуудлуудыг олж тогтооно. Ямар нэг халдварт өвчний тахал гардаг эсэхийг тогтоох.
- Дүрвэгсэдийг оролцуулан урьд нь байсан эрүүл мэндийн асуудлууд ба тухайн улсад хувьд хамгийн чухал асуудлуудыг олж тогтооно. Дүрвэгсдийн ирсэн улсад ямар ямар халдварт өвчний тахал гарч байсныг тогтоох.
- Эрүүл мэндэд учирч байгаа эрсдэл тэр дундаа тахлын боломжийг судална.
- Эрүүл мэндийн халамжийн өмнөх эх үүсвэрүүдийг олж тогтооно.
- Дүрвэгсдийн төрөлх улсад хэрэгжиж байгаа нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хамрах хүрээг тогтооно.

Нас баралтын зэрэг

- Нийт нас баралтын барагцаалсан тоог тооцно.
- 5-аас доош насны хүүхдийн нас баралтын зэргийг тооцно. (5-аас доош насны хүүхдүүдэд хамаарах нас баралт)
- Тодорхой шалтгаанаас үүдсэн нас баралтын зэргийг тооцно.

Өвчлөлтийн зэрэг

- Нийгмийн эрүүл мэндэд нөлөөлдөг томоохон өвчнүүд гарах тохиолдлын зэргийг тооцно.
- Боломжтой бол томоохон өвчнүүд гарах тохиолдлын зэргийг нас ба хүйсээр тооцно.

Ашиглах эх үүсвэр

- Гамшигт өртсөн улс орнуудын Эрүүл мэндийн яамны хүчин чадал ба хариу арга хэмжээг тогтооно.
- Үндэсний эрүүл мэндийн байгууламжууд тэр дундаа тэдгээрийн нийт тоо, ангилал, үзүүлж байгаа халамжийн түвшин, биет байдал, үйл ажиллагааны статус болон хүртээмжийг тодорхойлно.
- Ажиллуулах боломжтой эрүүл мэндийн ажилтнуудын тоо ба ур чадварыг тодорхойлно.
- Дархлаажуулалт ба эрх үрөийн эрүүл мэндийн үйлчилгээний өргөжүүлсэн хөтөлбөр хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн хүчин чадал ба үйл ажиллагааны статусыг тогтооно.

- Стандартчилсан протоколууд, зайлшгүй шаардлагатай эм, хангамжийн материал, тоног төхөөрөмжийн олдцыг тогтооно.
- Оршин байгаа нарийн мэргэжлийн эмчилгээний системийг тодорхойлох.
- Оршин байгаа эрүүл мэндийн мэдээллийн системийн байр суурийг тогтооно.
- Оршин байгаа хангамжийн систем ялангуяа зайлшгүй шаардлагатай эм, вакцин болон эмнэлгийн материалын хангамж, түгээлт ба хадгалалттай холбоотой хүчин чадлыг тодорхойлно.

Бусад мэддээллийн эх үүсвэрүүд

- Хүнс тэжээлийн байдал
- Хүрээлэн байгаа орчны байдал
- Хүнс ба хүнсний аюулгүй байдал

Хавсралт 2

Долоо хоног тутмын ажиглалтын мэдээний маягт

Нас баралтын ажиглалт, маягт 1

Газар нутаг

Даваа гаригаас Ням гариг хүртэлх огноо

Долоо хоногийн эхэнд байсан хүн амын тоо

Долоо хоногийн төрөлтийн тоо

Долоо хоногт шинээр ирсэн хүний тоо

Долоо хоногийн эцсийн хүн амын тоо

Долоо хоногийн нас баралтын тоо

Явсан хүний тоо

5-аас доош насны хүүхдийн тоо

	0-4 нас		5-аас дээш нас		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	
Шууд шалтгаан					
Амьсгалын замын хурц үрэвсэл					
Холер/сэжиг бүхий					
Гүйлгэлт/цусархаг					
Гүйлгэлт/усархаг					
Гэмтэл/ослын бус					
Хумхаа					
Эхийн эндэгдэл/шууд					
Улаан бурхан					
Менингит/сэжиг бүхий					
Төрсөн хүүхэд/0-28 өдөртэй					
Бусад					
Мэдэгдэхгүй					
<i>Нийт, нас ба хүйсээр</i>					
Цаад шалтгаан					
ХДХВ/ДОХ					
Тэжээлийн хомсдол					
Эхийн эндэгдэл/шууд					
Бусад					
<i>Нийт, нас ба хүйсээр</i>					

- Энэ маягтыг олон хүн нас барсан тохиолдолд хэрэглэддэг учраас цаг хугацааны хомсдолтой байдлаас шалтгаалж хувь хүний үхлийн талаархи мэдээллийг цуглуулах боломжгүй.
- Тайлан мэдээний давтамж нь нас баралтын тооноос хамаарна.
- Нас баралтын бусад шалтгааныг нөхцөл байдал ба халдварын зүй тогтлоос хамааран нэмж болно.
- Насны ангиллыг улам нарийвчлан хувааж болно.
- Нас баралтыг зөвхөн эрүүл мэндийн байгууламжуудаас мэдээлэхгүй бөгөөд орон нутгийн ба шашны удирдагчид, орон нутгийн ажилчид, эмэгтэйчүүдийн ба шилжүүлгийн эмнэлэгүүдээс авч олно.
- Боломжтой үед тухайн тохиолдлын тодорхойлолтыг маягтын ар талд бичнэ.

Нас баралтын ажиглалтын маягт 1

Газар нутаг

Даваа гаригаас Ням гариг хүртэлх огноо

Долоо хоногийн эхэнд байсан хүн амын тоо

Долоо хоногийн төрөлтийн тоо

Долоо хоногт шинээр ирсэн хүний тоо

Долоо хоногийн эцсийн хүн амын тоо

Долоо хоногийн нас баралтын тоо

Явсан хүний тоо

5-аас доош насны хүүхдийн тоо

			Үхлийн шууд шалтгаан											Цаад шалтгаан							
	Хүйс /эр,эм/	Нас /өдөр, сар, он/	Амьсгалын замын	Холерийн сэжиг	Гүйлгэлт цусархаг	Гүйлгэлт усархаг	Гэмтэл ослын бус	Хумхаа	Эхийн шууд эндэгдэл	Улаан бурхан	Менингит сэжиг	Шинээр төрсөд 0-28 хоногтой	Бусад /тодруул/	Мэдэгдэхгү	ХДХВ/ДОХ/ сэжигтэй	Тэжээлийн хомсдол	Эхийн шууд бус эндэгдэл	Бусад /тодруул/	Огноо	Байрлал, хаяг	Гэртээ эсвэл эмнэлэгт нас барсан
1																					
2																					
3																					
4																					
5																					
6																					
7																					
8																					
9																					
10																					

- Энэ маягтыг хувь хүний нас баралтын талаархи мэдээллийг бүртгэхэд хангалттай хугацаа байгаа нөхцөлд хэрэглэнэ. Энэ нь насны дагуу шинжилгээ хийж байрлал ба байгууламжийн ашиглалын зэргийн дагуу ашиглана.
- Тайлангийн давтамж нь нас баралтын зэргээс шалтгаална.
- Нас баралтын буад шалтгааныг энд нэмж болно.
- Нас баралтын талаархи мэдээллийг зөвхөн эрүүл мэндийн байгууламжууд өгөх боловч үүнд орон нутгийн ба шашны удирдагчдын өгсөн мэдээллийг тооцох ёстой.
- Боломжтой бүх тохиолдолд тухайн өвчний тохиолдлын талаархи мэдээллийг маягтын арын нүүрэнд бичнэ.

Долоо хоног тутмын ажиглалтын мэдээний маягт

Газар нутаг

Даваа гаригаас Ням гариг хүртэлх огноо

Долоо хоногийн эхэнд байсан хүн амын тоо

Долоо хоногийн төрөлтийн тоо

Долоо хоногт шинээр ирсэн хүний тоо

Долоо хоногийн эцсийн хүн амын тоо

Долоо хоногийн нас баралтын тоо

Явсан хүний тоо

5-аас доош насны хүүхдийн тоо

Өвчлөлт	5-аас доош насны			5-аас дээш насны			Нийт	Давталт
Оношлогоо								
Амьсгалын замын хурц үрэвсэл								
ХДХВ/ДОХ/сэжигтэй								
Цус багадалт								
Холер/сэжиг бүхий								
Гүйлгэлт/цусархаг								
Гүйлгэлт/усархаг								
Нүдний өвчин								
Хумхаа								
Тэжээлийн хомсдол								
Менингит/сэжигтэй								
Гэмтэл/ослын								
Гэмтэл/ослын бус								
Бэлгийн замын халдварт өвчин								
Бэлэг эрхтний шарх								
Эрэгтэйчүүдийн тавилт								
Эмэгтэйчүүдийн тавилт								
ХДХВ/ДОХ								
Гэдэсний доод хэсгийн өвдөлт								
Тууралт								
Арьсны өвчнүүд/үлд хамаарахгүй								
Хорхой								
Бусад								
Мэдэгдэхгүй								
Нийт								

- Нэгээс илүүонош тавих боломжтой. Тухайн нөхцөл байдлаас хамаарч өвчин нэмж болно.
- Амьсгалын замын хурц үрэвсэл нь зарим улсoronд дээд ба доод замын рэвсэл гэж ангилагддаг.
- Тухайн нөхцөл байдал ба халдварын зүй тогтлоос шалтгаалж өвчлөлтийн шалтгааныг нэмэх юм уу хасч болно.
- Насны ангиллыг илүү нарийвчлан задалж болно.

	5-аас доош Насны			5-аас дээш насны			Нийт	
Эрүүл мэндийн байгууллагад очих тоо	Эр	Эм	Нийт	Эр	Эм	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
Нийт тоо								

Ашиглалтын зэрэг: Нэг хүн өдөрт эмнэлгийн байгууллагад очих тоо ш 1 долоо хоногт эмнэлэг очих тоо / нийт хүн ам х 52 долоо хоног

- Насны ангиллыг улам нарийвчилж болно.

Нэг эмчид үзэх өвчтөний тоо=Нийт үзлэгийн тоо/эмчийн тоо/эмнэлгийн ажилладаг өдрийн тоо

Нас баралт, өвчлөлтийн тоо хэмжээг тооцоолох томъёо

- Тодорхойлолт: хүйс, нас харгалзахгүй бүх хүн амын нас баралтын тоо хэмжээ. БӨХ нь сар тутамд 1,000 хүн тутамд ногдох нас баралт буюу жил тутамд 1,000 хүн тутамд ногдох нас баралт гэх мэт янз бүрийн хугацаанд хүн амын янз бүрийн хэсгээр илэрхийлэгдэж боно.
- Гамшгийн үед хамгийн түгээмэл хэрэглэгддэг томъёо:
 Тодорхой хугацаан дахь нас баралтын тоо 10,000 хүн

5-аас доош настай хүүхдийн нас баралтын тоо хэмжээ /5НБТХ/

- Тодорхойлолт: хүн ам дахь 5-аас доош настай хүүхдийн нас баралтын тоо хэмжээ
- Гамшгийн үед хамгийн түгээмэл хэрэглэгддэг томъёо: /5-аас доош настай хүүхдийн насны онцлогтой нас баралтын тоо хэмжээ/

Тодорхой хугацаан дахь 5-аас доош настай
хүүхдийн нас баралтын нийт тоо 10,000хүн

5-аас доош настай хүн амын нийт тоо * тодорхой хугацаан дахь өдрийн тоо
= нас баралт /10,000/ өдөр

Тохиолдлын тоо хэмжээ

- Тодорхойлолт: өвчин бий болгох эрсдэлтэй хүн амын дунд тодорхой хугацаанд гардаг өвчний шинэ тохиолдлын тоо
- Гамшгийн үед хамгийн түгээмэл хэрэглэгддэг томъёо:
Тодорхой хугацаанд гарсан өвчний шинэ тохиолдлын тоо 1,000 хүн

Өвчин бий болгох эрсдэлтэй хүн ам * тодорхой хугацаан дахь сарын тоо
= тодорхой өвчний шинэ тохиолдол /1,000/ сар

Өвчний тохиолдлоор нас баралтын тоо

- Тодорхойлолт: өвчнөөр нас барсан хүний тоог өвчтэй байсан хүмүүсийн тоонд хуваасан тоо.
- Томъёо:
Тодорхой хугацаанд өвчнөөр нас барсан хүний тоо 1,000 хүн

Тодорхой хугацаанд өвчтэй байсан хүмүүсийн тоо * 100/өдөр = x%

Эрүүл мэндийн байгууламжийн ашиглалтын хэмжээ

- Тодорхойлолт: жил тутамд хүн тутамд ногдох гадуур эмчлүүлэгчдийн эмчид үзүүлсэн тоо. Боломжтой л бол анх ба урьд нь эмчид үзүүлсэн тооны алгааг гаргах хэрэгтэй бөгөөд энэ хэмжээг гаргахын тулд анх эмчид үзүүлсэн тоог ашиглах хэрэгтэй. Гэхдээ анх ба урьд нь эмчид үзүүлсэн тооны ялгааг гахгах гол төлөв хэцүү байдаг бөгөөд тиймээс тэдгээрийг цаг ямагт гамшгийн үед эмчид үзүүлсэн нийт тоо болгож нэгтгэдэг.
- Томъёо:
Нэг долоо хоногт эмчид үзүүлсэн нийт тоо

Нийт хүн ам * 52 долоо хоног = эмчид үзүүлсэн тоо/хүн/жил

Өдөр тутам эмч бүрт ногдох зөвлөгөөний тоо

- Тодорхойлолт: өдөр тутамд эмч бүрт ногдох нийт зөвлөгөө /анхны ба давтагдсан/-ийн дундаж тоо
- Томъёо:
Зөвлөгөөний нийт тоо /анхны ба давтагдсан/ : долоо хоног тутамд эрүүл эрүүл
мэндийн байгууламжийн орон тооны мэндийн байгууламжийн ажиллах
адилтгах эмч* нарын тоо өдрийн тоо

* “Орон тооны адилтгах” гэж эрүүл мэндийн байгууламжид ажиллаж буй эмч нарын адилтгах тоог хэлнэ. Жишээлбэл, хэрэв гадуур эмчлүүлэгчдэд үйлчилдэг тасагт 6 эмч ажилладаг боловч тэдний 2 нь орон тооны бус байвал орон тооны адилтгах эмч нарын тоо = 4 орон тооны ажилтан + 2 орон тооны бус ажилтан = 5 орон тооны адилтгах эмч

Хавсралт 4

Ном зүй

Оксфордын их сургуулийн Дүрвэгсдийн судалгааны төвийн Албадлагын цагаачлалын цахим хөтөлбөрийн ачаар эдгээр баримт бичгийн дийлэнхи нь зохиогчийн эрхийн зөвшөөрөл авч <http://www.forcedmigration.org> цахим сүлжээний тусгай холбогчид тавигдсан.

Олон улсын эрх зүйн баримт бичгүүд

Шаардлага хангасан орон сууцаар хангагдсан эрх /Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын хэлэлцээрийн 11 дүгээр зүйл 1, ЭЗНСЭОУХ-ийн ерөнхий санал 14, 2000/08/11. НҮБ-ын баримт бичиг E/C.12/2000/4. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо/

Baccino-Astrada, A /1982/, Зэвсэгт мөргөлдөөний үеийн эмнэлгийн ажилтнуудын эрх, үүргийн тухай гарын авлага. Женев. ICRC

Mann, J, Gruskin, S, Grodin, M, Annas, G /1999/, Эрүүл мэнд ба хүний эрх: сургалтын ном. Rouledge

ДЭМБ /2002/, Эрүүл мэнд, хүний эрхийн тухай 25 асуулт, хариулт. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. <http://www.who.int/hhr>

Эрүүл мэндийн систем ба дэд бүтэц

Beaglehole, R, Bonita, R, Kjellstrom, T /ред/ /1993/, Анхан шатны өвчний тархалт судлал. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага.

Эрүүл мэндийн менежментийн ухаан /1997/, Эмийн хангамжийн менежмент /2 дахь хэвлэл/. Кумариан хэвлэл. СТ, Блүмфилд

Медесин санс frontier /1993/, Эмнэлгийн гарын авлага. Оношлогоо, эмчилгээний гарын авлага. Парис, Медесин санс frontier

Медесин санс frontier /1997/, Дүрвэгчийн эрүүл мэнд. Онцгой байдалтай харилцах арга. Лондон, Макмиллан

Noji, E /ред/ /1997/, Гамшгийн хүн амын эрүүл мэндэд үзүүлэх үр дагавар. Нью-Йорк, Окфордын их сургуулийн хэвлэл

Perrin, AP /1996/, Дайн, хүн эрүүл мэндийн тухай гарын авлага. Женев, Улаан загалмайн олон улсын хороо ICRC

НҮБДДК/ДЭМБ /1996/, Эм хандивлах тухай гарын авлага. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Дүрвэгсдийн Дээд комиссар

НҮБДДК /2001/, Эрүүл мэнд, хүнс, тэжээлийн багц: эрүүл мэнд, хүнс, тэжээлийн хөтөлбөрийг удирдах үнэлэх хэрэгсэл, лавлагааны материал /СД-РОМ/. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Пан-Америкийн эрүүл мэндийн байгууллага

ДЭМБ/ПАЭМБ /2001/, Гамшгийн эрүүл мэндийн номын сан, /СД-РОМ/. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Пан-Америкийн эрүүл мэндийн байгууллага

ДЭМБ /1998/, Шинэ онцгой байдлын эрүүл мэндийн багц 1998. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

ДЭМБ /1999/, Онцгой байдлын эрүүл мэндийн хурдацтай судалгааны протокол. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

ДЭМБ /1994/, Онцгой байдал, гамшгийн байдлын үеийн эрүүл мэндийн лабораторын байгууламж. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Халдварт өвчний хяналт

Chin, J /2000/, Халдварт өвчний хяналтын гарын авлага /17 дугаар хэвлэл/. Вашингтон, Америкийн хүн амын эрүүл мэндийн холбоо

Cook, GC, Zumla, AI, Weir, J /2003/, Мансоны халуун орны өвчин. ВБ Саундерз

Агентлаг хоорондын байнгын хорооны онцгой байдлын үеийн ДХХВ/ДХОШ-ийн лавлагааны хэсэг /2003/, Онцгой байдлын үед ХДХВ/ДОХ-ын талаар авах арга хэмжээний гарын авлага. UNAIDS. Женев /хэвлэлтэд/. /Энэхүү баримт бичиг нь UNAIDS, 1998, Онцгой байдлын үед ХДХВ/ДОХ-ын талаар авах арга хэмжээний гарын авлагыг орлох болно/

Олон улсын аврах хороо /2003/, Ирээдүйг хамгаалах нь: Оршин суудаг газраасаа шилжүүлэгдсэн, дайнд нэрвэгдсэн хүн амын дундах ДХХВ-ын урьдчилан сэргийлэлт, халамж, дэмжлэг. Блүмфилд. СТ, Кумариан хэвлэл.

Пастерийн хүрээлэн: <http://www.pasteur.fr>

UNAIDS: <http://www.unaids.org>

ДЭМБ /1993/, Хлорын хяналтын гарын авлага. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

ДЭМБ /2002/, Өвчний тархалтын газар дээрх судалгааны үед эмнэлгийн дээж цуглуулах гарын авлага. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

ДЭМБ /1997/, Дархлаажуулалт практикт: Вакцин өгдөг эмнэлгийн ажилтнуудын гарын авлага. Лондон, Макмиллан

ДЭМБ /2003/, Хүнд онцгой байдлын үеийн маларийн хяналт. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /хэвлэлд/

ДЭМБ /1993/, Суулгалтын менежмент, урьдчилан сэргийлэлт. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Халдварт бус өвчний хяналт

Гэмтэл

Hayward-Karlsson, J, Jeffrey, S, Kerr, A нар /1998/, Дайн шархагдагсдын эмнэлэг: Зэвсэгт мөргөлдөөний газар мэс заслын эмнэлэг байгуулж ажиллуулах нь. Женев, Улаан загалмайн олон улсын хороо

Медесин санс фронттиер /1989/, Алслагдсан газар жижиг мэс засал хийх дүрэм. Парис, Медесин санс фронттиер

РАНО-OPS /1995/, Нийтийг хамарсан ослын менежментийн систем. Женев, Пан-Америкийн эрүүл мэндийн байгууллага

ДЭМБ /1991/, Дүүргийн эмнэлгийн мэс засал: эх барихуй, эмэгтэйчүүдийн өвчин судлал, ортопед, гэмтэг согог судлал. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Нөхөн үржихүйн эрүүл мэнд

Дүрвэгсдийн хэсгийн нөхөн үржихүйн эрүүл мэнд /1997/, Дүрвэгсдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээний судалгааны газар дээр нь хэрэглэх арга хэрэгсэл. ДХНҮЭМ

Агентлаг хоорондын ажлын хэсэг /1999/, Дүрвэгсдийн нөхцөл дэх нөхөн үржихүйн эрүүл мэндийн агентлаг хоорондын газар дээр нь хэрэглэх гарын авлага. Женев, НҮБ-ын Дүрвэгсдийн Дээд комиссар

НҮБ-ын Хүн амын сан: <http://www.unfpa.org>

НҮБ-ын Хүн амын сан /2001/, Онцгой байдлын нөхөн үржихүйн эрүүл мэндийн багц /2 дахь хэвлэл/. НҮБХХС

НҮБДДК /2003/, Дүрвэгсэд, буцаж ирэгсэд, дотоодод оршин суудаг газраасаа шилжүүлэгдсэн хүмүүсийн эсрэг бэлгийн ба хүйсийн хүчирхийлэл: Урьдчилан сэргийлэлт, хариу арга хэмжээний гарын авлага. Газар дээр нь туршиж буй төсөл, 2002/07/08. /Энэхүү баримт бичиг нь НҮБДДК-ын 1995 оны Дүрвэгсдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл: Урьдчилан сэргийлэлт, хариу арга хэмжээний гарын авлагыг орлох болно/

ДЭМБ /2001/, Хүчиндүүлэлтээс амьд гарагсдын эмнэлгийн менежмент. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Эрүүл мэндийн сэтгэхүй, нийгмийн асуудал

Сэтгэхүйн эрүүл мэндийн үндэсний хүрээлэн /2002/, Сэтгэхүйн эрүүл мэнд ба нийтийн хүчирхийлэл: Нийтийн хүчирхийлэлд хэлмэгдэгсэд/амьд гарагсдын нотлох баримтад түшиглэсэн сэтгэхүйн анхны арга хэмжээ. Шилдэг туршлагын талаар зөвшилцөлд хүрэх семинар /ЭМҮХ-ийн хэвлэлийн дугаар 02-5138/. Вашингтон, АНУ-ын Засгийн газрын хэвлэлийн газар. <http://www.nimh.nih.gov>

ДЭМБ /2003/, Онцгой байдлын сэтгэхүйн эрүүл мэнд: Туйлын стресст оруулах хүчин зүйлд өртсөн хүн амын сэтгэхүй, нийгмийн асуудал. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

ДЭМБ/НҮБДДК /1996/, Дүрвэгсдийн мэдрэлийн эрүүл мэнд. Женев, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. <http://whqlibdoc.who.int>

Архаг өвчин

Ahya, SH, Flood, K, Paranjothi, S нар /ред/, Вашингтоны эмчилгээний гарын авлага /30 дахь хэвлэл/. Липпинкотт Виллиамз энд Вилкинз Паблишерс

Braunwald, E, Fauci, AS, Kasper, DL нар /ред/ /2001/, Дотоодын анагаах ухааны Харрисоны зарчмууд /15 дахь хэвлэл/. Нью-Йорк, МкГро Хилл Профешнел

Tierny, LM, McPhee, SJ, Papadakis, MA /ред/, Өнөө үеийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээ 2003 /42 дахь хэвлэл/. Нью-Йорк, McGraw-Hill/Appleton and Lange

Вебсайт

Өвчний хяналт, урьдчилан сэргийлэлтийнтөвүүд. <http://www.cdc.gov>

Гамшгийн эмчилгээний судалгаа шинжилгээний төв. <http://www.cred.be>

Улаан загалмайн олон улсын хороо. <http://icrc.org>

Улаан загалмай, улаан хавирган сар нийгэмлэгийн олон улсын холбоо. <http://ifrc.org>

Пан-Америкийн эрүүл мэндийн байгууллага. <http://www.paho.org>

НҮБ-ын Дүрвэгсдийн дээд комиссар. <http://www.unhcr.ch>

НҮБ-ын Хүүхдийн сан. <http://www.unicef.org>

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. <http://www.who.org>

Хавсралтууд

page311

1 Үйл ажиллагааны цар хүрээний тухай гарын авлагыг суурь эрх зүйн баримт бичгүүд

Дараахь баримт бичгүүд Хүмүүнлэгийн дүрэм, Гамшгийн хариу арга хэмжээний наад захын стандартын суурь болсон. Үүнд:

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948

Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын конвенци, 1966

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын конвенци, 1966

Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдлын бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенци, 1969

1949 оны Женевийн Дөрвөн конвенци, тэдгээрийн 1977 оны 2 нэмэлт протоколууд

Дүрвэгсдийн статустай холбоотой конвенци, 1967 оны Дүрвэгсдийн статустай холбоотой протокол, 1951

Эрүүдэн шүүх ба бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусад буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенци, 1984

Аймаглан устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, шийтгэх тухай конвенци, 1984

Хүүхдийн эрхийн тухай конвенци, 1989

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенци, 1979

Харьяалалгүй хүмүүсийн статустай холбоотой конвенци, 1960

Дотоодын шилжүүлэлтийн удирдах зарчмууд, 1998

Улаан загалмай, улаан хавирган сар нийгэмлэгийн олон улсын холбоо, УЗОУХ-той хамтран бэлтгэв.²

Энэхүү ёс зүйн дүрэм нь бидний биеэ авч явах стандартыг удирдан чиглүүлэхийг зорино. Энэ бол аливаа хүн хүнсний хэмжээг хэрхэн тооцох буюу дүрвэгсдийн хуаранг байгуулах зэрэг үйл ажиллагааны дэлгэрэнгүй зүйлийн тухай биш юм. Энэ нь илүү гамшгийн эсрэг хариу арга хэмжээ авдаг ТББ, Олон улсын улаан загалмай, улаан хавирган сар хөдөлгөөний чиглэж буй бие даасан байдал, үр дүн, үр нөлөөний өндөр стандартуудыг дэмжихийг зорино. Энэ нь дүрэмд заасан стандартыг дэмжихийг зөвшөөрсөн хүсэл зоригоор хэрэгждэг сайн дурын дүрэм юм.

Зэвсэгт мөргөлдөөний үед энэхүү ёс зүйн дүрмийг олон улсын хүмүүнлэгийн хуулийн тайлбарлаж хэрэглэнэ.

Ёс зүйн дүрмийг эхлээд танилцуулна. Түүнд хүмүүнлэгийн тусламжийг үр дүнтэй хүргэх ажлыг хөнгөвчлөх зорилгоор бидний хүлээн авч буй засгийн газар, хандивлагч засгийн газар, засгийн газар хоорондын байгууллагууд бий болгохыг харахыг хүсдэг ажиллах орчныг тайлбарласан 3 хавсралтыг хавсаргасан.

Тодорхойлолт

ТББ-ууд: ТББ /төрийн бус байгууллага/ гэж энд тэдний байгуулагдсан улс орны засгийн газраас ангид байгуулагдсан үндэсний ба олон улсын байгууллагыг хэлнэ.

ТБХА: энэ бичвэрийн зорилгод ТБХА /төрийн бус хүмүүнлэгийн агентлаг/ хэмээх нэр томъёог Олон улсын улаан загалмай, улаан хавирган сар хөдөлгөөн – Олон улсын улаан загалмайн хороо, Улаан загалмай, улаан хавирган сар нийгэмлэгийн олон улсын холбоо, түүний гишүүн үндэсний нийгэмлэгүүд, дээр тодорхойлсон ТББ-ын бүрэлдэхүүн хэсгүүдийг хамруулахаар бий болгосон. Энэхүү дүрэм нь ялангуяа гамшигын хариу арга хэмжээнд хамрагдсан ТБХА-уудыг заасан.

ЗГХБ: ЗГХБ /засгийн газар хоорондын байгууллага/ гэж 2 буюу түүнээс дээш засгийн газрын байгуулсан байгууллагуудыг хэлнэ. Тиймээс түүнд бүх НҮБ-ын агентлагууд, бүх нутгийн байгууллагууд хамаарна.

Гамшиг: гамшиг нь амь нас, их хэмжээтэй хүмүүсийн зовлон, шаналал, үлэмж хэмжээний материаллаг хохиролд хүргэсэн гамшигт үйл явдлыг хэлнэ.

Ёс зүйн дүрэм

Гамшгийн хариу арга хэмжээний хөтөлбөрт оролцож буй Олон улсын улаан загалмай, улаан хавирган сар хөдөлгөөн, ТББ-уудын ёс зүйн зарчмууд

1 Хүмүүнлэгийн шаардлага эхэлж ирдэг

Хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах буюу санал болгох эрх нь бүх улс орны бүх иргэдийн эдлэх ёстой хүмүүнлэгийн суурь зарчим юм. Бид олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүдийн хувьд шаардлагатай үед хүмүүнлэгийн тусламж үзүүлэх үүргээ хүлээн зөвшөөрдөг. Тиймээс гамшигт нэрвэгдсэн хүн амд саадгүй хүрэх хэрэгцээ нь уг үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхэд үндсэн ач холбогдолтой. Бидний гамшгийн эсрэг хариу арга хэмжээ авах үндсэн шалтгаан нь гамшгаар бий болсон стрессийг хамгийн бага тэвчих чадвартай хүн амын зовлонг арилгахад оршино. Бид хүмүүнлэгийн тусламж үзүүлж байхад энэ намын буюу улс төрийн үйл ажиллагаа бус ба ийм байдлаар ойлгох ёсгүй.

2 Тусламжийг хүлээн авагчийн арьс өнгө, итгэл үнэмшил эсвэл яс үндэс үл харгалзан аливаа байдлаар ялгаварлахгүй үзүүлдэг. Тусламжийн тэргүүлэх чиглэлийг зөвхөн хэрэгцээнд тулгуурлан тооцдог.

Боломжтой бол бид тусламж үзүүлэх ажлыг гамшигт хэлмэгдэгсдийн хэрэгцээг хангахын тулд тийм хэрэгцээ, нэгэнт байгаа орон нутгийн чадавхийн талаар сайтар судалгаанд тулгуурлана. Бид өөрсдийн хөтөлбөрийн хүрээнд хувь тэнцүүлэх байдлын саналыг харуулах болно. Хүний зовлон гарч ирэх бүрд арилгаж байх ёстой. Амь нас бол улс орны нэг хэсэгт үнэтэй байдаг шиг нөгөө хэсэгт ч үнэтэй юм. Тиймээс бидний тусламж үзүүлэх арга хэмжээ уг тусламжийн арилгахыг зорьж буй хүний зовлонгийн хэм хэмжээг харуулна. Бид энэ аргыг хэрэгжүүлэхдээ гамшиг амсаж болох хүн амын дотор эмэгтэйчүүдийн гүйцэтгэдэг чухал үүргийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд бидний тусламжийн хөтөлбөр энэ үүргийг бууруулах бус дэмжих нөхцлийг бүрдүүлэх болно. Ийм түгээмэл, шударга, бие даасан бодлогын хэрэгжилт нь гагцхүү бид, бидний түншүүд ийм шударга тусламж үзүүлэхэд шаардлагатай хөрөнгө нөөцийг авах, гамшгийн бүх хэлмэгдэгсдэд адил тэнцүү хүрэх боломжтой байвал үр дүнтэй болж чадна.

3 Тусламжийг тодорхой улс төрийн буюу шашны байр суурийг дэмжихэд ашиглахгүй

Хүмүүнлэгийн тусламжийг хувь хүн, гэр бүл, хүн амын хэрэгцээг харгалзан олгоно. ТБХА тодорхой улс төрийн буюу шашны байр суурийг дэмжих эрхтэй хэдий боловч бид тусламж нь ийм санал бодлыг хүлээн авагчид дагаж мөрдөх эсэхээс хамааралгүй болохыг нотолж байна. Бид тусламж амлах, хүргэх буюу түгээх асуудлыг тодорхой улс төрийн буюу шашны үзэл санааг хэрэглэх буюу хүлээн авах явдалтай холбож үзэхгүй.

4 Бид засгийн газрын гадаад бодлогын хэрэгсэл болж ажиллахгүй байхыг чармайна

ТБХА-ууд нь засгийн газраас хараат бус байдлаар ажилладаг агентлаг юм. Тиймээс бид өөрсдийн бодлого, хэрэгжүүлэх стратегийг боловсруулах бөгөөд аливаа засгийн газар бидний бие даасан бодлоготой тохирч байгаагаас бусад тохиолдолд тийм бодлогыг хэрэгжүүлэхийн эрмэлзэхгүй. Бид хэзээ ч санаатай буюу хайнга байдлаар өөрсдийгөө буюу ажилтнуудаа цэвэр хүмүүнлэгийн зорилгоос бусад зорилгод үйлчилж болох засгийн газар буюу бусад байгууллагуудын тухайд улс төр, цэрэг буюу эдийн засгийн хувьд эмзэг шинжтэй мэдээлэл цуглуулахад оролцох боломж олгохгүй бөгөөд хандивлагч засгийн газрын гадаад бодлогын хэрэгсэл болж ажиллахгүй. Бид хүлээн авч буй тусламжаа хэрэгцээнд хариу өгөхөд хэрэглэх бөгөөд энэхүү тусламж нь хандивлагчийн илүүдэл барааг зарцуулах, ямар нэгэн тодорхой хандивлагчийн улс төрийн сонирхлын хэрэгцээнд хөтлөгдөхгүй болно. Бид бидний ажлыг дэмжих холбогдох хувь хүмүүсийн сайн дураар өгч буй ажиллах хүч, санхүүжилтийг үнэлж хөхүүлэн дэмждэг бөгөөд ийм сайн дурын санаачлагаар дэмжигдсэн үйл ажиллагааны бие даасан байдлыг хүлээн зөвшөөрдөг.

5 Бид соёл, зан заншлыг хүндлэх болно

Бид өөрсдийн ажиллаж буй газрын хүн ам, улс орнуудын соёл, бүтэц, зан заншлыг хүндэтгэхийг чармайх болно.

6 Бид орон нутгийн чадавхид түшиглэн гамшгийн хариу үйлдлийг бий болгохыг хичээнэ

Бүх хүмүүс, хүн ам бүр гамшгийн үед ч чадавхи ба эмзэг талтай байдаг. Боломжтой үед нь бид орон нутгийн ажилтнуудыг ажиллуулах, орон нутгийн материал худалдаж авах, орон нутгийн компаниудтай худалдаа хийх замаар эдгээр чадавхийг бэхжүүлнэ. Боломжтой үед нь бид төлөвлөх, хэрэгжүүлэх чиглэлээр орон нутгийн ТБХА-уудтай түнш болж ажиллах бөгөөд тохиромжтой үед нь орон нутгийн засгийн газрын бүтэцтэй хамтран ажиллана. Бид өөрсдийн онцгой байдлын хариу үйлдлийн зохистой зохицуулалтад тэргүүлэх чиглэл өгнө. Тухайн улс орнуудад үүнийг тусламжийн үйл ажиллагаанд шууд хамрагдсан байгууллага, хүмүүс хамгийн сайн хэрэгжүүлдэг бөгөөд НҮБ-ын холбогдох байгууллагуудын төлөөлөгчид багтдаг.

7 Тусламжийн менежментэд хөтөлбөрт хамрагдагсдыг оролцуулах арга замыг хайж олно

Гамшгийн хариу үйлдлийн тусламжийг хүлээн авагсад хэзээ ч тулгаж болохгүй. Тухайн хүлээн авагсад тусламжийн хөтөлбөрийг боловсруулалт, менежмент, хэрэгжилтэд хамрагдсан үед тусламжийг үр дүнтэй хүргэж тасралтгүй нөхөн сэргээлт хамгийн сайн хийж болно. Бид өөрсдийн тусламж, нөхөн сэргээлтийн хөтөлбөрт хүн амын бүрэн оролцуулахыг чармайна.

8 Гамшгийн тусламж нь наад захын хэрэгцээг хангахагаас гадна цаашдын гамшгийн эмзэг байдлыг бууруулах, ирээдүйд гамшигт нэрвэгдэх түвшинг бууруулахад чиглэгдэнэ

Бүх тусламжийн үйл ажиллагаа урт хугацааны хөгжлийн хэтийн төлөвт эерэг буюу сөрөг байдлаар нөлөөлдөг. Бид үүнийг хүлээн зөвшөөрч хүлээн авагчдын цаашдын гамшгт өртөх байдлыг бууруулах, тогтвортой аж төрөх ёсыг бий болгоход туслах тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг чармайна. Бид тусламжийн хөтөлбөрийг боловсруулж удирдах явцад байгаль орчны талаар санаа зовоосон асуудалд тодорхой анхаарал хандуулна. Бид мөн тусламж хүлээн авагчдын гадаадын тусламжаас урт хугацаанд хараат байх байдлаас зайлхийхийг хичээж хүмүүнлэгийн тусламжийн сөрөг нөлөөг бууруулахыг эрмэлзэх болно.

9 Бид тусламж хүлээн авч буй хүмүүс болон тусламжийн нөөцийг хандивлаж буй хүмүүсийн өмнө хариуцлага хүлээнэ

Бид байнга туслахыг хүссэн байгууллага, хүмүүс, гамшгийн үед тусламж хэрэгтэй байгаа хүн амын хооронд түншлэлийг холбох байгууллага болж ажилладаг. Тиймээс бид эдгээр талуудын өмнө хариуцлагатай ажилладаг. Хандивлагч, хүлээн авагчидтай явуулж бидний бүх үйл ажиллагаа нээлттэй, ил тод байдлын хандлагыг илэрхийлэх болно. Бид өөрсдийн үйл ажиллагааг санхүү, үр ашгийн талаас нь тайлагнах хэрэгцээг хүлээн зөвшөөрдөг. Бид тусламжийн хуваарилалтын тохиромжтой хяналт хийх, гамшгийн тусламжийн нөлөөний талаар тогтмол судалгаа хийх үүргийг хүлээн зөвшөөрдөг. Бид мөн өөрсдийн ажлын үр нөлөө, ийм үр нөлөөг хязгаарлаж эсвэл нэмэгдүүлж буй хүчин зүйлүүдийн талаар ил тол байдлаар тайлагнахыг хичээх болно. Үнэтэй хөрөнгө нөөцийн үр ашиггүй зарцуулалтыг бууруулахын тулд манай хөтөлбөрүүд нь мэргэжил, дадлага, туршлагын өндөр стандартад үндэслэгдэнэ.

10 Бид өөрсдийн хэвлэл мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагаанд гамшигт нэрвэгдэгсдийг итгэл найдваргүй болсон объект бус нэр төртэй хүмүүс хэмээн хүлээн зөвшөөрнө

Гамшгийн хэлмэгдэгчийг үйл ажиллагааны тэгш эрхтэй оролцож буй түншийн хувьд гамшигт нэрвэгсдийг хүндлэх хүндлэлээ хэзээ ч алдаж болохгүй. Бид өөрсдийн нийтэд зориулсан мэдээлэлд гамшгийн нэрвэгсдийн зөвхөн эмзэг байдал, айдасыг төдийгүй тэдний чадавхи, хүсэл эрмэлзлэлийг онцолж харуулсан гамшгийн байдлын бодит дүр зургийг харуулна. Бид олон нийтийн хариу арга хэмжээг нэмэгдүүлэхийн тулд мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах хэдий боловч нийт тусламжийг нэмэгдүүлэх зарчмаас дээгүүр эрхтэй байх зорилготой сурталчилгааны гадаадын буюу дотоодын шаардлагыг хүлээн авахгүй. Бид мэдээллийн хэрэгслэлийн сурвалжлага хүлээн авагчдад үзүүлсэн үйлчилгээ эсвэл манай ажилтнууд буюу хүлээн авагчдын аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болох нөхцөлд бусад гамшгийн хариу арга хэмжээ авч буй агентлагуудтай ийм сурвалжлагын төлөө өрсөлдөхөөс зайлсхийнэ.

Ажиллах орчин

Бид дээр дурьдсан дүрмийг дагаж мөрдөхийг чармайхыг санал нэгтэй хүлээн зөвшөөрч бид гамшгийн хариу арга хэмжээнд оролцох ТБХА-уудын үр дүнтэй оролцоог хөнгөвчлөхийн тулд хандивлагч засгийн газар, хүлээн авч буй засгийн газар, засгийн газар хоорондын байгууллага – ялангуяа, НҮБ-ын агентлагуудын зүгээс бүрдүүлэхийн хүсч буй ажиллах орчныг тайлбарласан зарим тодорхой гарын авлагыг дор танилцуулж байна. Үүнд:

Эдгээр гарын авлагыг удирдамж болгохоор толилуулж байна. Тэдгээр нь хуулийн адил хүчин төгөлдөр биш бөгөөд энэ нь цаашид түүнд шилжих зорилго болж болох хэдий боловч бид засгийн газар, ЗГХБ-уудыг аливаа баримт бичигт гарын үсэг зурах замаар эдгээр гарын авлагыг хүлээн зөвшөөрч буйгаа харуулна гэж хүлээхгүй. Тэдгээрийг манай түншүүд бидний тэдэнтэй хөгжүүлэхийг эрэлхийлэх бүрэн төгс харилцааны талаар мэддэг байх зорилгоор ил тод байдал, хамтын ажиллагааны үзэл санаан дор толилуулж байна.

Хавсралт I: Гамшигт нэрвэгдсэн орнуудын засгийн газруудад зориулсан зөвлөмж

1 Засгийн газрууд ТБХА-уудын бие даасан, хүмүүнлэгийн шударга үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч хүндлэх хэрэгтэй

ТБХА-ууд нь бие даасан байгууллага юм. Хүлээн авч буй засгийн газрууд ийм бие даасан, шударга байдлыг хүндэтгэх хэрэгтэй.

2 Хүлээн авч буй засгийн газрууд нь ТБХА-уудад гамшигт нэрвэгсдэд хурдан хүрэх боломжийг хөнгөвчилж өгөх хэрэгтэй

Хэрэв ТБХА-ууд өөрсдийн хүмүүнлэгийн зарчмыг бүрэн баримталж ажиллаж байвал хүмүүнлэгийн тусламжийг хүргэх зорилгоор тэдэнд гамшигт нэрвэгсдэд хурдан, нэг талыг дэмжсэн бус боломжийг олгох хэрэгтэй. Ийм тусламжийг саатуулахгүй байх, ТБХА-уудын шударга, улс төрийн бус үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх нь бие даасан үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхэд оролцогчийн хувьд хүлээн авч буй засгийн газрын үүрэг юм. Хүлээн авч буй засгийн газрууд тусламжийн ажилтнуудыг ялангуяа, шилжих, нэвтрэх, нэвтрэх визэд тавигдах шаардлагаас чөлөөлөх эсвэл тэдгээрийг шуурхай олгох арга хэмжээ авах замаар хурдан нэвтрэх асуудлыг хөнгөвчлөх хэрэгтэй. Засгийн газрууд нь онцгой байдлын тусламжийн үе шатанд олон улсын тусламжийн бараа, ажилтнуудыг тээвэрлэж буй нисэх онгоцыг дамжин нисэх зөвшөөрөл, газардах эрх олгох хэрэгтэй.

3 Засгийн газрууд гамшгийн үед тусламжийн бараа, мэдээллийг цаг хугацаанд хүргэх ажлыг хөнгөвчилж өгөх хэрэгтэй

Тусламжийн бараа, тоног төхөөрөмжийг арилжааны ашиг буюу олз олох зорилгоор бус гагцхүү хүн амын зовлон зүдгүүрийг арилгах зорилгоор улс оронд оруулж ирдэг. Ийм барааг ер нь чөлөөтэй, хязгаарлалтгүй оруулах хэрэгтэй бөгөөд консулын гарал үүслийн гэрчилгээ буюу нэхэмжлэл, экспорт буюу импортын тусгай зөвшөөрөл буюу бусад хязгаарлалтад тавигдах шаардлага эсвэл импортын татвар, нэвтрэх хураамж буюу боомтын хураамжид хамаарахгүй байх хэрэгтэй.

Хүлээн авч буй засгийн газар нь тусгай зөвшөөрөл буюу бүртгэлийн хязгаарлалтаас түр зуур чөлөөлөх замаар тээврийн хэрэгсэл, хөнгөн нисэх онгоц, холбоо харилцааны тоног төхөөрөмж зэрэг шаардлагатай тусламжийн тоног төхөөрөмжийг түр зуур импорлох асуудлыг хөнгөвчлөх хэрэгтэй. Үүний нэгэн адил засгийн газрууд тусламжийн үйл ажиллагааны төгсгөлд тусламжийн тоног төхөөрөмжийг дахин экспортлоход хязгаарлалт тавихгүй байх хэрэгтэй.

Гамшгийн харилцаа холбоо хөнгөвчлөхийн тулд хүлээн авч буй засгийн газрууд тусламжийн байгууллагууд гамшгийн харилцаа холбооны зорилгоор улс оронд ба олон улсын харилцаа холбоонд ашиглаж болох тодорхой радио давтамжийг бий болгох, тэдгээр давтамжийг гамшгийн өмнө гамшгийн хариу арга хэмжээ авах байгууллага, хүмүүст танилцуулах хэрэгтэй. Тэд тусламжийн ажилтнуудад өөрсдийн тусламжийн үйл ажиллагаанд шаардлагатай харилцаа холбооны бүх хэрэгслийг ашиглах зөвшөөрөл олгох хэрэгтэй.

4 Засгийн газрууд нь зохицуулалт бүхий гамшгийн мэдээлэл, төлөвлөлтийн үйлчилгээг хүргэхийг эрмэлзэх хэрэгтэй

Тусламжийн хүчин чармайлтыг бүхэлд нь төлөвлөж зохицуулах нь эцсийн бүлэгт хүлээн авч буй засгийн газрын үүрэг хариуцлага юм. Хэрэв БТХА-ууд тусламжийн хэрэгцээ, тусламжийн хүчин чармайлтыг төлөвлөх, хэрэгжүүлэх засгийн газрын системийн талаарх мэдээлэл, мөн тэдэнд тохиолдож болзошгүй аюулгүй байдлын эрсдлийн талаарх мэдээллээр хангагдвал төлөвлөлт, зохицуулалтын ихээхэн нэмэгдүүлж болно. Засгийн газрууд ТБХА-уудыг ийм мэдээллээр хангах хэрэгтэй.

Тусламжийн хүчин чармайлтыг үр дүнтэй зохицуулах, үр ашигтай зарцуулах ажлыг хөнгөвчлөхийн тулд хүлээн авч буй засгийн газрууд нь гамшгийн өмнө орж ирж буй ТБХА-уудын хувьд үндэсний төрийн байгууллагуудтай харилцах нэг цэгийн холбоо барих хүнийг томилж өгөх хэрэгтэй.

5. Зэвсэгт мөргөлдөөний үеийн гамшгийн тусламж

Зэвсэгт мөргөлдөөний үеийн тусламжийн арга хэмжээг олон улсын хүмүүнлэгийн хуулийн холбогдох заалтуудын дагуу зохицуулдаг.

Хавсралт II: Хандивлагч засгийн газруудад зориулсан зөвлөмж

1 Хандивлагч засгийн газрууд ТБХА-уудын бие даасан, хүмүүнлэгийн шударга үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч хүндлэх хэрэгтэй

ТБХА-ууд нь хандивлагч засгийн газрууд бие даасан байдал, шударга байдлыг хүндэтгэх ёстой бие даасан байгууллага юм. Хандивлагч засгийн газрууд ТБХА-уудыг аливаа улс төрийн буюу үзэл суртлын зорилгыг хэрэгжүүлэхэд ашиглаж болохгүй.

2 Хандивлагч засгийн газрууд үйл ажиллагааны бие даасан байдлын баталгааны хамт санхүүжилт өгөх хэрэгтэй

ТБХА-ууд гамшгийн хэлмэгдэгсдэд тусламж үзүүлдэг үзэл санаа буюу хүмүүнлэг, бие даасан үйл ажиллагааны үзэл санаагаар хандивлагч засгийн газруудаас санхүүжилт, материалын тусламжийг хүлээн авдаг. Тусламжийн арга хэмжээг хэрэгжүүлэх нь эцсийн бүлэгт ТБХА-ын үүрэг хариуцлага бөгөөд тухайн ТБХА-ын бодлогын дагуу хэрэгжинэ.

3 Хандивлагч засгийн газрууд өөрсдийн байгууллагуудыг ТБХА-уудад гамшгийн хэлмэгдэгсдэд хүрэх боломжтой болоход туслахад анхиглах хэрэгтэй

Хандивлагч засгийн газрууд ТБХА-ын ажилтнуудын аюулгүй байдал, гамшгийн газруудад хүрэх боломжтой байх эрх чөлөөг хангах үүрэг хариуцлагын түвшинг хүлээн авах ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тэд хэрэв шаардлагатай бол ийм асуудлын талаар хүлээн авч буй засгийн газартай дипломат үйл ажиллагаа явуулахад бэлэн байх хэрэгтэй.

Хавсралт III: Засгийн газар хоорондын байгууллагуудад зориулсан зөвлөмж

1 ЗГХБ-ууд орон нутгийн ба гадаадын ТБХА-уудыг чухал түншээ гэж хүлээн зөвшөөрөх хэрэгтэй

ТБХА-ууд нь илүү сайн гамшгийн хариу арга хэмжээ авахын тулд НҮБ, бусад засгийн газар хоорондын агентлагуудтай хамтран ажиллах хүсэлтэй байдаг. Тэд бүх түншүүдийн шударга, бие даасан байдлыг хүндэтгэсэн түншлэлийн үзэл санаагаар ийнхүү хамтран ажилладаг. Засгийн газар хоорондын агентлагууд нь ТБХА-уудын бие даасан, шударга байдлыг хүндэтгэх ёстой. НҮБ-ын агентлагууд тусламжийн төлөвлөгөөг бэлтгэхдээ ТБХА-уудтай зөвлөлдөх хэрэгтэй.

2 ЗГХБ-ууд хүлээн авч буй засгийн газруудад олон улсын ба орон нутгийн гамшгийн тусламжийг хүргэх ерөнхий зохицуулалтын орчныг бүрдүүлэхэд туслах хэрэгтэй

ТБХА-ууд олон улсын хариу арга хэмжээ шаардсан гамшгийн ерөнхий зохицуулалтын орчныг хангах бүрэн эрхтэй байдаггүй. Энэ үүрэг хариуцлага нь хүлээн авч буй засгийн газар, холбогдох НҮБ-ын байгууллагуудад хамаардаг. Гамшигт нэрвэгдсэн улс орон, гамшгийн хариу арга хэмжээ авах үндэсний ба олон улсын байгууллага, хүмүүст үйлчлэхийн тулд тэднээс энэ үйлчилгээг цаг хугацаанд нь үр дүнтэй үзүүлэхийг шаарддаг. Ямар ч тохиолдолд ТБХА-ууд нь өөрсдийн үйлчилгээний үр дүнтэй зохицуулалтыг хангахын тулд бүхий л хүчин чармайлтаа гаргах ёстой.

3 ЗГХБ-ууд НҮБ-уудад үзүүлдэг аюулгүй байдлын хамгаалалтыг ТБХА-уудад хүргэх хэрэгтэй

Аюулгүй байдлын үйлчилгээг засгийн газар хоорондын байгууллагуудад үзүүлж буй үед энэ үйлчилгээг шаардлагатай үед нь тэдний үйл ажиллагааг явуулж буй ТБХА-ын түншүүдэд хүргэх хэрэгтэй.

4 ЗГХБ-ууд ТБХА-уудыг НҮБ-ын байгууллагуудад үзүүлсэн шиг холбогдох мэдээлэл авах боломжоор хангах хэрэгтэй

ЗГХБ-уудыг гамшгийн үр дүнтэй хариу арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой бүх мэдээллийг тэдний үйл ажиллагааг явуулж буй ТБХА-ын түншүүдтэй хуваалцахыг шаарддаг.

3. Талархал

Төслийн ажилтнуудын баг

Төслийн менежер: Нан Бузард

Сургалтын менежер: Сеан Лоури
Төслийн ажилтан: Вероника Фуберт
Төслийн ахлах туслах ажилтан: Элли Прудлок

Төслийн менежментийн хороо

InterAction * Save the Children Alliance * CARE International * The Lutheran World Federation (LWF/ACT) * Voluntary Organisations in Cooperation in Emergencies (VOICE) * Mercy Corps * Action by Churches Together (ACT) * Oxfam GB * Steering Committee for Humanitarian Response * International Committee of the Red Cross (ICRC) * International Federation of Red Cross and Red Crescent Societies (IFRCRC) * International Council of Voluntary Agencies (ICVA) * Caritas Internationalis

Хандивлагч нар

Дээр дурьдсан гишүүн байгууллагуудын оруулсан хувь нэмрээс гадна дараахь байгууллагууд санхүүжилт гаргасан. Үүнд:

The Australian Agency for International Development (AusAID) * The Belgian Ministry of Development * The Canadian International Development Agency (CIDA) * Caritas Spain * Danish International Development Assistance (DANIDA) * The Disaster Emergency Committee (DEC) * The Finnish Government Development Agency (FINIDA) * The European Community Humanitarian Office (ECHO) * The Ford Foundation * Development Cooperation Ireland (DCI) * The Netherlands Ministry of Foreign Affairs Humanitarian Aid Division * The New Zealand Ministry of Foreign Affairs and Trade * The Foreign Ministry of Norway * The Swedish International Development Cooperation Agency (Sida) * The Swiss Agency for Development and Cooperation (SDC) * The United Nations Children's Fund (UNICEF) * The United Kingdom Department for International Development (DFID) *

The United States Department of State Bureau of Refugees and Migration (US-PRM) * The United States Agency for International Development Office for Foreign Disaster Assistance (US-OFDA)

Мэргэжлийн туслалцаа үзүүлсэн:

Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байдлыг дээшлүүлэх: Andy Bastable, Oxfam GB

Хүнсний аюулгүй байдал: Helen Young, Tufts University

Хүнс тэжээл: Anna Taylor, Save the Children UK

Хүнсний тусламж: John Solomon, CARE USA and NM Prusty, CARE India

Орогнох байр, суурьшилт, хүнсний бус зүйлс: Graham Saunders, Catholic Relief Services

Эрүүл мэндийн үйлчилгээ: Richard J Brennam⁸ International Rescue Committee

Түгээмэл стандартууд: үндсэн гол мэргэжилтнүүд болон бусад салбартай холбоотой асуудал дээр ажилласан ажилтнуудаас гадна Jock Baker, Nan Buzard, Jim Good, Maurice Henderson, Susanne Jaspars, Charles Kelly, Ron Ockwell, Sylvie Robert

Бусад салбаруудтай холбоотой асуудлууд дээр ажилласан:

Хүүхэд: Jane Gibreel, Save the Children UK

Өндөр настан: Nadia Saim, HelpAge International

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс: Beverly Ashton, Action on Disability and Development

Хүйс: Rosemarie McNairn, Oxfam GB

Хамгаалалт: Ed Schenkenberg, ICVA

ХДХВ/ДОХ: Paul Spiegel, UNHCR/CDC

Байгаль орчин: Mario Pareja, CARE/UNHCR

Гарын авлагыг хянан засварлах уулзалтыг зохицуулагч: Isobel McConnan

Хянан тохиолдуулагч: David Wilson

Гүн талархал

Цар хүрээний стандарт, үзүүлэлт-ийг хүмүүнлэгийн ажлын янз бүрийн салбарт

идэвхитэй ажилладаг хүмүүс, агентлагуудын хамтын туршлага, сайн практикт тулгуурлан бэлтгэсэн болно. Дэлхий дээрхи олон хүмүүстэй хамтран ажиллахгүйгээр гарын авлагын анхны хэвлэлээр энэхүү хянан засварлах ажлыг хийх боломжгүй байсан билээ. Нийт 400 гаруй агентлагийг төлөөлсөн 80 улс орны мянга мянган хувь хүмүүс, урт удаан цаг хугацаа, мэргэжлийн ур чадвараа сайн дураар зориулж энэхүү үйл ажиллагаанд оролцлоо.

Гарын авлагыг боловсруулах явцад энэхүү үйл ажиллагааны бүх үе шатанд хамрагдсан нарийн нягталж шалгах бүлгийн сүлжээний зөвлөгөөнд голлон анхаарч ажилласан. Ялангуяа, гамшиг байнга тохиолддог улс орнуудад байгаа, тухайн салбарт уг гарын авлагыг хэрэглэдэг тусламжийн ажилтнууд дэлгэрэнгүй санал гаргаж өгсөн билээ. Үр дүн нь ямар нэгэн агентлагийн санал бодлыг илэрхийлээгүй бөгөөд харин хүмүүнлэгийн үйл ажиллагааны чанар, хариуцлагыг сайжруулах хүчин чармайлт гаргахын тулд өргөн хэмжээнд мэдлэг, туршлага солилцохоор нэгдэх хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцож буй хүн амын идэвхитэй, төлөвлөсөн хүсэл зоригийг илэрхийлж байна. үүнийг бодит зүйл болгоход тусласан бүх хүмүүс, байгууллагад талархлаа илэрхийлье.

Энэхүү гарын авлагын эх хувь ба энэхүү хянан засварлах ажилд оролцсон бүх хүмүүсийн хувь нэмрийг хүлээн зөвшөөрч байгаа хэдийн боловч хувь хүмүүсийн нэрсийг жагсаавал 40 гаруй хуудас болох бөгөөд жагсааж гаргах зай хүрэлцэхгүй юм. Гэхдээ өөрсдийн хувь нэмрийг оруулсан агентлаг, хувь хүмүүсийн бүрэн жагсаалтыг дараахь вебсайтаас үзэж болно. <http://www.shpereproject.org>

4 Товчилсон үгс

ACC/SCN:

United Nations Administrative Committee on Coordination/Subcommittee on Nutrition/НҮБ-ийн Зохицуулалт Захиргааны Хороо/Хүнс Тэжээлийн Дэд Хороо

ACT: Action by churches together/Сүмүүдийн хамтын ажиллагаа

ALNAP:

Active Learning Network for Accountability in Practice/Практик дээрхи хариуцлагын талаар идэвхитэй суралцах

CDC: Centers for Disease Control and Prevention/Халдварт өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх ба төвүүд

DAC: Development Assistance Committee (OECD)/ ЭЗХАХБ-ын Хөгжлийн Тусламжийн Хороо

FAO: Food and Agriculture Organisation/Дэлхийн Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага

IAPSO:

Inter-Agency Procurement Services Office (UNDP)/НҮБХХ-ийн Агентлаг хоорондын бараа, үйлчилгээ худалдан авах үйлчилгээний байгууллага

ICRC: International Committee of the Red Cross/Олон Улсын Улаан Загалмайн Хороо

INFCD:

International Nutrition Foundation for Developing Countries/Хөгжиж буй Улс Орнуудын Хүнс Тэжээлийн Олон Улсын Сан

LWF: The Lutheran World Federation/Лутерний Дэлхийн Холбоо

MISP: Minimum Initial Service Package/Минимум Үндсэн Үйлчилгээний Багц

MSF: Medecins Sans Frontieres/Медсан Сан Фронтиер

NCHS: National Centre for Health Statistics/Эрүүл мэндийн Статистикийн Мэдээллийн Үндэсний Төв

NGO: Non-governmental organization/Төрийн бус байгууллага

OCHA: UN Office for the Coordination of Humanitarian Affairs/НҮБ-ын Хүмүүнлэгийн Хэргийг Зохицуулах Газар

OECD: Organisation for Economic Cooperation and Development/Эдийн засгийн Хамтын

Ажиллагаа, Хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)

OFDA: Office of Foreign Disaster Assistance (USAID)/АНУ-ын Олон улсын Хөгжлийн Агентлагийн Гамшгийн Гадаадын Тусламжийн газар

PTSS: Programme and Technical Support Section (UNHCR)/НҮБДДКГ-ын Хөтөлбөр ба Техникийн дэмжлэгийн хэсэг

SCHR: Steering Committee of Humanitarian Response/Хүмүүнлэгийн Тусламжийг Удирдах Хороо

UNDP: United Nations Development programme/НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр

UNDRO:
United Nations Disaster Relief Organisation/НҮБ-ын Гамшгийн Тусламжийн Байгууллага

UNEP: United Nations Environment Programme/НҮБ-ын Байгалт Орчны Хөтөлбөр

UNHCR:
United Nations High Commissioner for Refugees/НҮБ-ын Дүрвэгсдийн Дээд Комиссариатын Газар (НҮБДДКГ)

UNICEF:
United Nations Children's Fund/НҮБ-ын Хүүхдийн Сан

USAID: United States Agency for International Development/АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг

WCRWC:
Women's Commission for Refugee Women and Children/Дүрвэгч Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн Эмэгтэйчүүдийн Холбоо

WFP: World Food Programme/Дэлхийн Хүнсний Хөтөлбөр

WHO: World Health Organisation/Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

WMO: World Meteorological Organisation/Дэлхийн Цаг Уурын Байгууллага

330 Тэмдэглэл

Индекс

331

Индекс

- удирдлагын газрууд 217
тусламжийн ажилтнуудын
 ажил үүргийн хуваарь 41
 менежмент 41
 мэргэшил 40, 41
антропометрийн судалгаанууд, хүнс тэжээлийн дутагдал 115, 116-17, 183
тусламжийн хөтөлбөрүүд
 олон нийтийн оролцоо 28
 удаан хугацааны ашиг тус 29
- усанд орохыг угаалга-аас *харна уу*
ор дэвсгэр
 эхний олголт 208-9, 241
 хэрэглэх минимум хугацаа 228, 231
 халаалтын асуудал 231
 угаалга 77, 78
бери-бери 140
ном зүй
 антропометрийн үнэлгээ дүгнэлтүүд 195-6
 хоол хүнсний тусламж 199
 хүнсний аюулгүй байдал 194-5, 196
 эрүүл мэндийн үйлчилгээнүүд 304-8
 хүний эрх 20, 44-8
 тэжээлийн микроэлемент 198
 орогнох байр ба суурьшилт 244-6
 халдвар тээгчийн хяналт 98-9
 нэн эмзэг бүлгүүд 197-8
 хог зайлуулах 98-9
 усны хангамж 96-8
биологийн зэвсгүүд 273
бисийн бөөс 77, 78
хөвгүүд
 цэрэгт татах 40
 бэлгийн албадлага 37, 220
хөхөөр хооллох
 ХДХВ/ДОХ 142
 хүнс тэжээлийн дутагдал 152
 Сурталчилгаа 141, 234
барилга байшин, эвдэрсэн 214, 221, 222
оршуулга
 хувцас 230
 орон нутгийн соёл 217, 236, 269, 291, 293
 байршил 84, 215, 269
хуарангууд-ыг орогнох байр, хуарангаас *харна уу*
асрагчид
 өлсгөлөн хүмүүсийн 152, 163
 хоол тэжээлийн шаардлагууд 144
 өндөр настай хүмүүс 11
- үхэл, золгүй явдлын хувь хэмжээ (CFR) 283, 302
борлуулах тариа, ургац 126
ажиллах бэлэн мөнгө (CFW) 129-30, 178
химийн бодисууд
 стандартууд 81
 халдвар тээгчээс үүсэлтэй өвчиний хяналт 81-2
хүүхдүүд
 нэн эмзэг бүлгүүд -с *бас харна уу*
 мөлжлөг 40-1
 ялгас зайлуулах 71, 73, 84
 хоол, сүү 160
 эрүүл мэндийн үйлчилгээнүүд 255
 өвчлөлт 277
 өлсгөлөн хүүмүүс, зорилго тодорхойлох 36
 хүнс тэжээлийн дутагдал
 дунд зэрэг 183-5
 ноцтой 183-5
 5-с доош настай хүүхдийн өвчлөлтийн мэдээлэл 33
 5-с доош настай хүүхдийн нас баралтын мэдээлэл 33, 259, 260
 хоол тэжээлийн шаардлагууд 141, 143-4
 хэрэглэгдэх салбарууд 217
 хамгаалалт 10-11
 сургуулиуд 216, 217
архаг өвчин 294
омог бүлгийн системүүд 37
цаг агаар, орон байрны дутагдал 223
клиникийн эмч нар 266, 268, 271, 303
клиникийн, зөөврийн 265
хувцлах
 эхний олголт 208, 241-2
 угаалгын газрууд 70-1, 232
 хэрэглэх минимум хугацаа 230, 231
 халаалтын асуудал 231
багц төлөвлөлт, орогнох байрууд 215, 216
CMR - үхэлийн ерөнхий коэффициент -с *харна уу*
ёс журам 315-24
халдвартай өвчин
 үхэл, золгүй явдлын хувь хэмжээ 283, 302
 оношилгоо 277, 278
 лабораторын үйлчилгээнүүд 277, 278, 279, 280
 сорьц тээвэрлэлт 279, 280
 эрүүл мэндийн боловсрол 274-5
 ХДХВ/ДОХ 283-4
 хумхаа өвчин 78, 79, 80, 95, 138, 277-8, 282
 улаан бурхан 138, 180, 255, 274-6
 халдварт өвчин гарах
 хяналтын арга хэмжээнүүд 281, 282-3
 урьчилан сэргийлэлт 281-2
 бэлтгэгдсэн байдал 279-80
 өвчин зөвхөн нэг газар илэрсэн шинж баримт 282

сүрьеэ 277, 278
 нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд 267, 281
 гамшгийн онцгой нөхцөл байдал, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө үйлчлэл 257
 зөрчилдөөн тэмцлийн нөхцөл байдлууд
 тусламжийн хуваарилалт 35
 хүнсний аюулгүй байдал 107, 119, 156, 167-8
 осол гэмтэл 287
 байлдаанд үл оролцогчид 17
 барилга
 материалууд
 хариуцлага 225, 226
 орон нутгийн 224, 225, 226, 239-40 дулаалах шинж чанар 221, 223
 ур чадвар 224, 226
 хоол бэлдэх
 түлшний хангамж 158, 159, 234, 235-6
 орчин тойрны нөлөө үйлчлэл 123, 159
 зуухнууд 234, 235
 сав суулга
 авах боломж 163, 164
 эхний шаардлагууд 233, 242
 ус хангамж 64
 зохицуулалт
 хоолны туслалцаа 109, 113-14
 эрүүл мэндийн үйлчилгээнүүд 255, 261-3, 263-4
 мэдээлэл солилцоо 30, 33-4, 35
 орогнох байрны хөтөлбөрүүд 209-10 үхэлийн
 ерөнхий коэффициент (CMR)
 суурь үзүүлэлт 260-1
 тооцоолол 301
 баримт бичиг 32-3, 259, 271
 хэмжээнд нь барих 259, 260
 соёлын практик
 мэдээлэл цуглуулалт 38
 орон сууц 207, 219, 220, 221, 222, 240
 хэвийн байдал 291, 293
 мэдээлэл
 хянан шалгалт -с *бас харна уу*
 нууц хадгалалт 270, 271
 хэсэглэн хуваалт 30, 32-3, 271
 хувийн 36
 ач холбогдол 37
 үхэл, зайлуулах 217, 267, 269
 шийдвэр гаргалт 28
 гүйлгэх эпидеми 67, 79
 хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс
 нэн эмзэг бүлгүүд -с *бас харна уу*
 хоол, авах боломж 144
 хүнс тэжээлийн дутагдал 186
 хамгаалалт 11
 гамшигт нэрвэгдсэн хүмүүс
 хоорондын зөрчилдөөн тэмцэл 40
 эрүүл мэндийн нөлөө үйлчлэлүүд 254-5
 оролцоо 26, 28-9

гамшиг, эхний үнэлгээ дүгнэлтүүд 25, 29-33
 өвчин

халдвартай өвчин -с *бас харна уу*
 архаг 294
 дусал дамжуулалт 224
 тархалтын хувь хэмжээ 302
 тэжээлийн бичил элементийн хомсдол 139
 жорлон, хэмжээнд нь барих 75
 халдвар тээгчээс үүсэлтэй 76-9
 уснаас үүсэлтэй 65, 79

хуваарилалт системүүд

үр бүтээмж 37
 хянан шалгалт 36, 38

бохир ус

эхний үнэлгээ дүгнэлтүүд 92
 ажлын талбар дахь шингээх нүх 87-8
 төлөвлөлт 86, 87
 налуу газар 88, 218
 гадаргуйн топографи 216, 218
 гадаргуйн ус 86

эм

хандивласан 266
 зайлшгүй шаардлагатай жагсаалтууд 266, 268
 менежмент 269
 нөөцлөлт 280

газар хөдлөлт, гэмтэл бэртэл 257, 286

хоолны сав суулга 233-4

ажил эрхлэлт

хүнсний үйлдвэрлэлт 128-30
 цалин хөлс 128, 129-30, 131

хүрээлэн буй орчин

элэгдэл 228
 нөлөө үйлчлэл
 түлшний хангамж 123, 234, 235, 242
 суурьшилт 227-9, 241
 хамгаалалт 13, 227-8

хүнсний аюулгүй байдал 120, 123

EPI (Дархлаажуулах өргөтгөсөн хөтөлбөр) 274, 275

эпидемиологийн тайлангууд 270

тэгш байдал, хүний эрх 11-12

элэгдэл 228

үнэлгээ хийх

минимум стандартуудын шалгуур 39
 хэрэглээ 39

ялгас, өтгөн

амьтан 67, 80, 95
 хүүхдүүд 71, 73
 зайлуулах 71-5, 80

эхний шаардлагууд 90-1

гарах стратегиуд, хүнсний аюулгүй байдал 120, 123

Дархлаажуулах өргөтгөсөн хөтөлбөр (EPI) 274, 275

ялгасын бохирдол, ус хангамж 66-8, 95

гэр бүлүүд, дахин нийлэх 292

FFR (нөхөн сэргээлтийн хоол) 178

FFW (ажлын хоол) 129, 130, 178, 225

ажлын талбарын эмнэлэгүүд 263

анхны туслалцаа 287

ялаа 79, 80

үер, эрүүл мэндийн нөлөө үйлчлэл 257

хоол

хоол бэлдэх; хүнс тэжээлийн дутагдал; тэжээлийн микроэлемент -с бас харна уу зайлшгүй шаардлагатай 133

үр тариа, тээрэмдэх 158, 160-1, 164

эрүүл ахуйг сахих 163-4

импортууд, түүний үйлчлэл 132, 155

мэдээлэл түгээн тараах 170-1

орон нутгийн үйлдвэрлэл 112, 124, 125-7

борлуулах тариа, ургац 126

тэнцвэргүй байдал үүсгэх 121, 122, 124-5, 127

орон нутгийн бараа, бүтээгдэхүүн авах 127, 165, 166

зах зээлүүд 113, 131-4

хянан шалгалт 127

үнийн өөрчлөлт 131, 134

хөдөө нутагууд 113, 124-5, 127

үр тариа 126-7

сүү 160

хүнс

үнэлгээ дүгнэлтүүд 116

өдөр тутмын шаардлагууд 138

хадгалалт 161

зориулалт 167

зохихгүй байх, зайлуулах 167

халдвар тээгчээс үүсэлтэй бохирдол 77

хоолны туслалцаа

хуваарилалт

хоолны порц 155, 156

шударга 123-4, 162, 166, 168, 169

чөлөөтэй 121, 155, 156

аргууд 168, 170-1

хянан шалгалт 168, 171

хуваарилах цэгүүд 170

зорилго тодорхойлох 168, 169

эмэгтэйчүүд 169

ойр дотно байдал 158, 160

эхний үнэлгээ дүгнэлтүүд 157-8

менежмент 162

чанарын хяналт 160, 161, 167

хүчинтэй байх хугацаа 160, 161

хангамжийн шугам 162, 165-6

баримт бичиг 165, 167

логистик 192-3

солилцооны үнэлэмж 158

хүнсний аюулгүй байдал

агентлаг хоорондын зохицуулалт 113-14

шалгах жагсаалтууд 174-6

тайлангууд 112, 113-14, 173

багууд 114

зөрчилдөөн тэмцлийн нөхцөл байдлууд 107, 119, 156, 167-8

тодорхойлолт 108, 119

хуваарилалт 170

орон нутгийн асуудлыг давж гарах стратегиуд 122

ажил эрхлэлт 128-30

орчин тойрны нөлөө үйлчлэл 120, 123

гарах стратегиуд 120, 123

ирээдүйн 113

хянан шалгалт 121, 124

анхан шатны үйлдвэрлэл

хариу үйлдлүүд 177-8

хэрэгжүүлэх боломж 124-6

стандартууд 119-20

ерөнхий 120-4

нөхөн сэргээлтийн хоол (FFR) 178

ажлын хоол (FFW) 129, 130, 178, 225

түлшний хангамж

орчин тойрны нөлөө үйлчлэл 123, 234, 235, 242

найдвартай цуглуулалт 235-6, 242

хүйсний ялгаанд тулгуурласан хүчирхийлэл (GBV) 288, 289-90

генетикийн хувьд өөрчлөгдсөн (GMO) үр тариа 127

Генева хотын Конвенци, байлданд үл оролцогчид 17

охидууд

эмэгтэйчүүд -с бас харна уу

өсвөр насны хүүхэд, хүнс 142

бахуу өвчин 187-8

үр тариа, тээрэмдэх 158, 160-1, 164

гүний ус 64

оршуулгын газар 217, 269

жорлонгийн сорох нүх суваг 74, 75, 87

гар угаах 74, 75

эрүүл мэндийн төвүүд

эмнэлэгүүд -с бас харна уу

төв газар, ажилчид 267

хүнс тэжээлийн дутагдал, ажилчид 149, 150-1

салбарууд, ажилчид 267

хөл хориотой бүс 217

ус хангамж 69, 93

эрүүл мэндийн боловсрол 264-5

халдвартай өвчин 274-5

эрүүл мэндийн нөлөө үйлчлэл, гай гамшиг 257 эрүүл

мэндийн мэдээллийн системүүд (HIS)

мэдээлэл 270, 271

урьчилан сэргийлэлт 281-2

эрүүл мэнд ба аюулгүй байдал

хоол бэлтгэл 163

ажиллах орчин 128, 130

эрүүл мэндийн үйлчилгээнүүд

авах боломж 215, 216-17, 259-60

- хэрэг менежментийн протоколууд 266, 268
хүүхдүүд 255
олон нийт оролцоо 255
олон нийтийн ажилтнууд 267
зохицуулалт 255, 259, 263-4
гай гамшгийн нөлөө үйлчлэл 254-5
эм
хандивласан 268
жагсаалтууд 266, 268
менежмент 269
нөөцлөлт 280
эпидемиологийн тайлангууд 270, 271
хүлээн авч буй нутаг хүмүүс 255
хүний эрх 253
эхний үнэлгээ дүгнэлтүүд 254-5, 295-7
эхний минимум багц үйлчилгээ 289, 290
ба үндэсний/орон нутгийн хангамж 261-3
өвчтнүүдийн эрх 268-9
анхны асрамж 264-5
ач холбогдлыг тогтоох 254, 259-60
ажилчид
хүйсийн тэнцвэр 262-3
ур чадвар 266, 267
хэрэгжүүлэлтийн хувь хэмжээ 268, 302
эмэгтэйчүүд 255
халаалт, зуухнууд 234, 235
хүчтэй салхи, эрүүл мэнд нөлөө үйлчлэл 257
HIS - эрүүл мэнд мэдээлэл системүүд *-с харна уу*
ХДХВ/ДОХ (PLWH/A)
өртөмтгий эмзэг бүлгүүд *-с бас харна уу*
тэвэрч хөхүүлэх 142
хяналт 283-4, 288
асуудлыг давж гарах стратегиуд 13
хүнс тэжээлийн дутагдал 151
хүнс 143
доромжлох 37
жорлон 73
усны хэрэгцээ 65
эмнэлэгүүд
эрүүл мэндийн төвүүд *-с бас харна уу*
клиникийн эмч нар 266, 268, 271, 303
ажлын талбарын 263
ажилчдын хангамжийн түвшин 267
ус хангамж 69, 93
хүлээн авч буй нийгэм
ба дүрвэгсэд 32, 211-12, 213, 241
upgrading 213
гэр ахуйн хог, зайлуулсан 83, 84
орон сууц - орогнох байр *-с харна уу*
хүний эрх
хүүхдүүд 11
эрх тэгш байдал 11-12
хоол 107
эрүүл мэндийн үйлчилгээнүүд 253
орон сууц 207
амь нас ба нэр төр 17
өвчтөнүүд 268-9
ус 55
хүмүүнлэгийн тусламж, чанар 26
Хүмүүнлэгийн тунхаг бичиг 5-6
хүний эрх 17
минимум стандартууд 19
зарчмууд 16-17
үүргүүд ба хариуцлагууд 18
эрүүл ахуйг сахих 59
харилцаа холбоо 61
олон нийтийн оролцоо 60, 61
шударга авах боломж 60, 61
нөөцүүд 60-1
өртөмтгий эмзэг бүлгүүд 61
ус хангамж 64
ажилтнууд 61
IDP - дотоод дүрвэгсэд *-с харна уу*
IMCI (хүүхэд насны өвчлөлтийн нэгтгэсэн менежмент)
277
импортууд, түүний үйлчлэл 132, 155
нярай хүүхдүүд
тэвэрч хөхүүлэх 141
сүүний шил 234
инфекцийн өвчин - халдвартай өвчин *-с харна уу*
мэдээлэл солилцоо
эхний үнэлгээ дүгнэлтүүд 30, 33-4, 35
хянан шалгалт 38
хариу үйлдлүүд 33-4, 35
эхний үнэлгээ дүгнэлтүүд
эрх бүхий байгууллагууд 30
ор дэвсгэр 241-2
хувцлах 241-2
хоол бэлдэх 242
бохир ус 92
ялгас, өтгөн зайлуулах 90-1
хүнсний аюулгүй байдал 111-13, 114, 120, 121, 172-3
шалгах жагсаалтууд 174-6
тайлангууд 112, 113-14, 173
багууд 114
эрүүл мэндийн үйлчилгээнүүд 254-5, 295-7
мэдээлэл солилцоо 30, 33-4, 35
мэдээллийн эх сурвалж 30, 31
хувийн ариун цэвэр 242
хүн амын тоо 30
ач холбогдлыг тогтоох 30-1
хариу үйлдэл 33-4
суурьшилт 238-9
орогнох байр 208-9, 238-9
амьд үлдэх шаардлагууд 258
багийн бүтэц 31

- жорлонгийн хангамж 72
халдвар тээгчээс үүсэлтэй өвчин 91-2
хогны менежмент 92
усны хэрэгцээ 89-90
- гэмтэл бэртэл
хэрэг гарах 285, 286-7
мэс заслын эмчилгээ 286, 287-8
шарх гэмтлийн эмчилгээ 260, 286-8
эмчилгээний протоколууд 286, 287
эмчлэгдэх байдлаар нь хуваах 287
- хүүхэд насны өвчлөлтийн нэгтгэсэн менежмент (IMCI) 277
- интеграцлалт, хариу үйлдлүүд 25-6
- дотоод дүрвэгсэд (IDP)
ба хүлээн авч буй олон нийт 32, 211-12, 213, 241
эрүүл мэндийн хангамж 255
буцаж гэртээ харих 211, 212-13
- түлхүүр индикаторууд, тодорхойлолт 8-9
- лабораторын үйлчилгээнүүд, тайлбар 277, 278, 279, 280
- газар эзэмшигч, орогнох байраа авах 212, 214
- хог хаях газар 84, 85
- бие засах газар - жорлон -с харна уу
- угаалгын газрууд 70-1
саван 232
- амь зуулга
өөр сонгох боломж 120, 123
тодорхойлолтууд 108
уян хатан чанар 119
дэмжлэг 212, 215, 237, 243
- орон нутгийн эрх бүхий байгууллагууд 30
эрүүл мэндийн хангамж 261-3
- хумхаа өвчин 95, 139, 277-8, 282-3
шумуулын хяналт 77-81
шумуулын тор 236, 283
- хүнс тэжээлийн дутагдал
тэжээлийн микроэлемент -с бас харна уу
антропометрийн судалгаанууд 115, 116-17, 183
үнэлгээ дүгнэлтүүд 145, 147
насанд хүрсэн хүмүүс 185-6
хүүхдүүд 184-5
5 наснаас доош хүүхдүүд 183
тэвэрч хөхүүлэх 152
асрагчид 152, 163
учир шалтгаанууд 115, 116, 180-2
хүүхдүүд
дунд зэрэг 183
ноцтой 183
тодорхойлолтууд 108
хоолны найдваргүй байдал 114
- дундаж жингийн өсөлт 151
- дунд зэрэг
хүүхдүүд 183
засвар хийх 145-8
хамруулалт 145, 147
эрүүл мэндийн үйлчилгээ авах боломж 145, 147
- хянан шалгалт 139
олон нийтийн оролцоо 146, 148
гарах индикаторууд 146, 147, 149, 150
- урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд 137-8
- протоколууд 151-2
- сэтгэл санааны дэмжлэг 152
- ба олон нийтийн эрүүл мэнд 180-1
- ноцтой
хүүхдүүд 183
засвар хийх 145, 149-2
хамруулалт 149, 150
намжруулах шалгуур 149, 150-1
нэмэлт тэжээл 146, 149
- зах зээлүүд
үргэлжлэл 215
гаднах нөлөө үйлчлэл 132
хүнсний аюулгүй байдал 113
хөндлөнгийн оролцооны хариу реакци 131, 133
холбосон 132
хамгаалалт 131, 132-3, 178-9
хог 85
- дундаж жингийн өсөлт 151
- улаан бурхан 139
вакцинжуулалт 180, 255, 274-6
давталт 276
витамин А нэмэлтүүд 275
- эмнэлэгийн хог, зайлуулах 84, 85
- менингококковын менингит 282, 283
- сарын тэмдэг 75, 232, 233
- оюун ухааны эрүүл мэнд 285, 291, 292-3
- тэжээлийн микроэлемент
авах боломж 139
хомсдол 114, 115, 116-17, 139
оношилгоо 152-3
эндемик 140
сэргийлэлт 153
- минерал бодисууд
хомсдол 187-8
шаардлагууд 189
нэмэлтүүд 152-3
витамиинууд
хомсдол 138, 187
шаардлагууд 137-8, 189
- эх баригчийн тусламжийн хайрцаг 288, 290
- сүү
хуваарилалт 160
нунтаг 160

минерал бодисууд
 өдөр тутмын шаардлагууд 189
 иодын дутагдал 187-8
 эхний минимум багц үйлчилгээнүүд (MISP) 289, 290
 Минимум стандартууд
 зарчмууд 6, 13-14
 ач холбогдлыг тогтоох 14
 хариу үйлдлүүд 33-5
 хамрах цаг хугацааны хүрээнүүд 7
 хянан шалгалт
 мэдээлэл -с *бас харна уу*
 консультац 38
 хоолны туслалцаа 121, 124
 хоолны туслалцааны хуваарилалт 168, 171
 чухал ач холбогдол of 26, 37
 мэдээлэл солилцоо 38
 анхан шатны хүнсний үйлдвэрлэлт 127-8
 зорилго тодорхойлох 38
 шинэчлэх 38
 өвчлөлтийн тухай мэдээлэл
 хүүхдүүд, 5 -аас доош настай 33
 баримт бичиг 259, 271
 ажиглалтын хэлбэр 300
 үхлийн тухай мэдээлэл
 хүүхдүүд, 5 -аас доош настай 33, 271
 боловсруулагдаагүй 259, 260, 301
 баримт бичиг 259, 271
 ажиглалт хэлбэрүүд 298-9
 шумуул
 хяналт 77-81
 хумхаа өвчин 95, 139, 277-8, 282-3
 тор 236, 283
 хөнжил даавуу угаах 73
 үндэсний эрх бүхий байгууллагууд
 эрүүл мэндийн хангамж 261-3
 хүн амын хамгаалалт 30
 байгалийн аюул 212, 214, 226
 аюултай тулгарах улс орон руу албадан буцаахгүй байх
 17
 хүнс
 хүнс тэжээлийн дутагдал -с *бас харна уу*
 үнэлгээ дүгнэлтүүд 116
 асрагчид 144
 хүүхдүүд 142, 142-3
 өдөр тутмын шаардлагууд 139, 157-8, 189-91
 мэдээлэл 180
 ба хүн ам зүйн бүтэц 190-1
 оксидууд 142
 Хүний дархлал хомсдолын нян/ДОХ өвчинтэй
 өвчтөнүүд 143
 нярай хүүхдүүд 141
 өндөр настай хүмүүс 143
 өмнө нь гарсан хөндлөнгийн оролцоонууд 182
 эмэгтэйчүүд
 тэвэрч хөхүүлэх 142
 жирэмсэн 142

өндөр настай хүмүүс
 өртөмтгий эмзэг бүлгүүд -с *бас харна уу*
 асрагчид 11
 хоол, авах боломж 143
 хүнс тэжээлийн дутагдал 186
 хүнс 143
 хамгаалалт 11
 эцэг эхчүүд
 хөнжил даавуу угаах 73
 тусгаарлалт 122
 оролцоо
 олон нийт 26
 мэдээлэл 28
 төлөөлөл 29
 пеллагра өвчин 140
 хувийн мэдээлэл цуглуулалт 36
 хувийн ариун цэвэр, эхний үнэлгээ тооцоолол 242
 хувийн орон зай 216, 217, 219-20
 цаг агаар 219
 хуванцар, хоолны хувь хэмжээ 234
 тоглох газар 217
 PLHW/A - Хүний дархлал хомсдолын нян/ДОХ өвчин
 (PLWH/A) -с *харна уу*
 хүн амын тоо, үнэлгээ дүгнэлтүүд 30
 хамгаалалт, зарчмууд 12, 48
 сэтгэл санааны дэмжлэг
 хүнс тэжээлийн дутагдал 152
 хангамж 221, 285, 291-3
 хөл хориотой бүс 217
 нөхөн сэргээлтийн үе, төлөвлөлт 33, 41
 цалин хөлс 128, 129-30, 131
 ажиллах бэлэн мөнгө 129-30, 178
 нөхөн сэргээлтийн хоол 178
 ажлын хоол 129, 130, 178, 225
 төлөөлөл, тэнцвэртэй 29
 нөхөн сэргээгдэх эрүүл мэнд 285, 288-9
 илгээх сав хайрцаг 288, 290
 нөөцүүд, хуваарилалт 41
 хариу үйлдлүүд
 үнэлгээ тооцоолол хийх реакци 34-5
 хоолны туслалцаа 121, 124
 хүнсний аюулгүй байдал 177-9
 мэдээлэл солилцоо 34, 35
 Минимум стандартууд, биелүүлэх 33-4
 зорилго тодорхойлох 35-7
 рибофлавины дутагдал 140
 мэрэгч амьтад 80
 дээвэрлэх материалууд 220
 дулаалах шинж чанар 221, 223

давс, иоджуулсан 140
эрүүл ахуйн эмчилгээ
авах боломж 212, 214, 215, 216-17
комиссууд 62
хөтөлбөрүүд
зорилт ба зорилго 56, 59
эмэгтэйчүүд 56
сургуулиуд 216, 217
SCM - хангамжийн шугамын менежмент -с харна уу
бам өвчин 140
үр тариа
хуваарилалт 126-7
генетикийн хувьд өөрчлөгдсөн 127
бэлгийн хүчирхийлэл 12
бэлгийн албадлага
хөвгүүд 37
эмэгтэйчүүд 37, 41
SFP - нэмэлт тэжээлийн хөтөлбөрүүд -с харна уу
орогнох байр
баазууд
онцгой нөхцөл байдалд нүүлгэн шилжүүлэх
216, 218
дамжуулах 229
эхний үнэлгээ дүгнэлтүүд 238-9
түр зуурын 212, 213, 218
халдвар тээгчээс үүсэлтэй өвчин 216, 218
багцалсан төлөвлөлт 215, 216
барилга 224-6
зохицуулалт 209-10
соёлын хувьд хүлээн зөвшөөрөгдөх 207, 219, 220,
221, 222, 240
орчин тойрны нөлөө үйлчлэл 227-9
хэрэглээний уян хатан байдал 221
дамжуулалт 227, 229
гэр ахуйн ажилгаанууд 219, 220-1, 239
эхний үнэлгээ дүгнэлтүүд 238-41
газар эзэмшигч 212, 214
олон тооны 218
материалууд
өөр сонгох боломж 221, 222-3
орон нутгийн 224, 225, 239-40
дулаалах шинж чанар 221, 223
хувийн орон зай 216, 217, 219-20
хувийн эрх 219, 220
хөтөлбөрүүд, эмэгтэйчүүд 209
засч засварлах 221, 222
эрсдэлийн үнэлгээ дүгнэлтүүд 212, 213-14
дээвэрлэх материалууд 220
халдвар тээгчээс үүсэлтэй өвчин 77, 224
агааржуулалт 224, 235
газар талбай
бохир ус 87, 88
сонголт 87
сорох нүх суваг, гүний ус 74, 75
саван 70, 232

орлох зүйл 71
нийгмийн эрүүл мэнд 291-2
онцгой шаардлагууд - өртөмтгий эмзэг бүлгүүд -с харна
уу
ширүүн борооны ус 88
зуухнууд 234, 235, 242
нэмэлт тэжээлийн хөтөлбөрүүд (SFP)
хоолны порц 155, 156
хүнс тэжээлийн дутагдал 146, 149
хангамжийн шугамын менежмент (SCM)
тээвэрлэлт -с бас харна уу
гэрээ хэлэлцээр 165, 166
баримт бичиг 165, 167
хоолны туслалцаа 162, 165-6
орон нутгийн эх сурвалж 165-6
логистикийн шалгах жагсаалтууд 192-3
аюул занал 165, 167-8
амьд үлдэх шаардлагууд, үнэлэх 258
зорилго тодорхойлох
шалгуур 35, 36-7
хуваарилалтын системүүд 36, 37
хоолны туслалцаа 168-9
механизмууд 35-6
хянан шалгалт 38
ялгаварлан үзэхгүй байх 35-6
технологийн гай гамшигууд 6-7
жорлон
авах боломж 71, 72-3
дизайн 73, 74
гар угаах 74, 75
хэмжээнд нь барих 71, 72-3, 74, 87
минимум тоо ширхэг 94
жорлонгийн хогийг ухаж гаргах 216, 218
олон нийтийн/нийтийн, тоо ширхэг 71, 72-3
аюулгүй байдал, эмэгтэйчүүд 73, 75
ус хангамж 93
багаж хэрэгсэл
авах боломж 236, 243
оршуулга 236
жорлон барих 74, 75
сургуулилалт 236
тээвэрлэлт
хангамжийн шугам -с бас харна уу
дэд бүтэц 212, 215
эмнэлэгийн сорьцууд 279, 280
суурьшилт 216, 218
шарх гэмтлийн эмчилгээ 260, 286-8
сүрьеэ 277, 278
5 -аас доош настай хүүхдийн үхэлийн хувь хэмжээ
(U5MR) 33, 271
суурь 260-1
тооцоолол 301
хэмжээнд нь барих 259, 260

вакцинжуулалт, улаан бурхан 180, 255, 274-6
халдвар тээгч үүсэлтэй өвчин 76

хяналтууд 78, 79, 81-2, 87

химийн 81-2

эхний үнэлгээ дүгнэлтүүд 91-2

суурьшилт 216, 218

орогнох байрууд 77, 224

дамжуулалт 76, 77-9

витамиинууд

А

хомсдол 187

улаан бурхан вакцинжуулалт 275

өдөр тутмын шаардлагууд 189

хомсдол 137-8, 140

хангамж 137

нэн эмзэг бүлгүүд

хувцлах шаардлагууд 231

барилгын ажил 237

тодорхойлолтууд 9-10, 57-8, 110, 210

эдийн засгийн шаардлагууд 215

түлшний хангамж 235-6

эрүүл ахуйг сахих 61

хоол тэжээлийн дэмжлэг 142-6, 164

хувийн ариун цэвэр 232

хамгаалалт 10-13

нийгмийн шаардлагууд 215

угаалгын тоног төхөөрөмжүүд 70, 71

ус хангамж 57-8, 66

дайн байлдаан - зөрчилдөөн тэмцлийн нөхцөл
байдлууд -с харна уу

угаалга

тоног төхөөрөмжүүд 70, 220

саван 70, 232

орлох зүйл 70-1

хогны менежмент

оршуулга, байршил 84, 215

гэр бүл 83, 84

эхний үнэлгээ дүгнэлтүүд 92

зах зээлүүд 85

эмнэлэгийн 84, 85

ажилчдын хамгаалалт 85

усны эх үүсвэр

бохирдол

химийн 65, 67

ялгадасын 66-8, 84, 95

хөхтөн амьтны шээс 79

дахин ашиглалтын 67, 68

цацраг туяаны 65, 67

гүний ус 64

жорлонгийн сорох нүх суваг 74, 75, 87

хэмжээнд нь барих 63

усны хангамж

авах боломж 63, 66, 212, 214, 215, 216-17

зорилт ба зорилго 56, 59

цуглуулалт ба хадгалалт 68, 69, 233, 234

комиссууд 62

ариутгал 67, 68

эрүүл мэндийн төвүүд 69

хүний эрх 55

эхний үнэлгээ дүгнэлтүүд 89-90

минимум шаардлагууд 93

цэнгэг амт 68

нэг гаралт дахь хүмүүсийн тоо 65-6

тоо ширхэг 63, 64

оорчирлох хугацаа 63, 66

өртөмтгий эмзэг бүлгүүд 57-8, 66

эмэгтэйчүүд

өртөмтгий эмзэг бүлгүүд -с бас харна уу

төрөлтийн туслагчид 262

тэгш эрх 12

хүйсний ялгаанд тулгуурласан

хүчирхийлэл 288, 289-90

эрүүл мэндийн үйлчилгээнүүд 255

угаалгын тоног төхөөрөмжүүд, хувийн эрх 70

сарын тэмдэг 75, 232, 233

жирэмслэлт, хүнс 142

нөхөн сэргээгдэх эрүүл мэнд 285, 288-9

аюулгүй байдал

мөлжлөг 40-1

орогнох байр 220

жорлон 73, 75

бэлгийн албадлага 37, 41, 225

хоол хангамж 113

орогнох байрны хөтөлбөрүүд 209, 225

ус хуримтлах 56, 66

ксерофтальми 187

